

МОНТЕ-КРИСТО ГҮН

1-р боть

Өмнөх үг

Францын зохиолч А.Дюмагийн (1802-1870) уран бүтээлийн хамгийн эрчимтэй үе нь 1840-1848 он байсныг судлаачид тэмдэглэсэн байдаг. Үнэхээр ч энэ хугацаанд «Монте кристо гүн», «Шадар гурван цэрэг», «Хорин жилийн хойно», «Бражелоны бэйс буюу арван жилийн хойно» роман болон бусад олон туурь, жүжиг, замын тэмдэглэл зэрэг дэлхийн улс гүрэнд үе үеийг дамжин алдар нь түгсэн бүтээлүүдээ туурвисан байдаг.

Манай ахмад үеийн орчуулагч нарын чамлалтгүй хөлсөө гоожуулж сэтгэл гаргасны ачаар уншигчид маань дээрх романуудаас нь эх хэлээрээ уншин, амтанд нь орж, олж аваагүй нэгэндээ дамжуулан гялайлгаж явсан цаг саяхан шиг билээ. Яагаад ч юм одоогоос хориод жилийн өмнө уншигчид, ялангуяа залуучууд маань өөрийн зохиолчдын ч бай, орчуулгын ч бай гарсан ном болгоныг алгасалгүй шимтэн сонирхдог байгаа юу даа гэсэн бодол төрөх юм.

Энэ бүгдийг эс өгүүлэн зохиолын тухай хэдэн үг хэлсү. «Монте кристо гүн» романыг бичих санаа 1892 онд Эльба арлаас холгүй байдаг Плонез арал дээр ан хийж явахад нь төрсөн юм гэдэг. Хажууханд нь Уайсан «Монте кристо» гэдэг арлын нэр зохиолчийн санаанаас гаралгүй явсаар Парист буцаж ирэнгээ, чухам юуны тухай бичихээ товлоогүй мөртөө хэвлэлийн газартаа ийм нэртэй зохиол бичнэ гэсэн гэрээ хийчихжээ. Ингэж байтал, Парисын цагдаагийн газрын хуучин данс бичгийн захирагч Жак Пешегийн «Дурсамжаас» нөгөө бичих романыхаа гол санаа, зангилааг санамсаргүй олоод авсан байна.

1807 онд Парист гуталчин залуу Франсуа Пико гэдэг даржин эр амьдарч байж. Амь зуулгаар тааруухан тэр эрд, аз болоход сүйлсэн бүсгүйнх нь инжинд зуун мянган франк ирэх болжээ. Нэгэн удаа Пико ам алдан энэ тухайгаа гурван танилдаа болон цуг сууж байсан гуанзны эзэн Лупианд ярьчихжээ. Пиког явангуут, угийн жетөөч, өөдгүй санаатай Лупиан, Пиког цагдаагийн газар гүтгэж, хуримы нь хийлгэхгүй болгочихъё гэдэг санааг цаадуулдаа хэлжээ. Тэгээд цагдаагийн комиссарт «Пико бол английн тандуул» гэсэн ховын бичиг хүргүүлжээ. Хөөрүү комиссар хуурамч ховыг сохроор итгэж, тэр дор нь эзэнт улсын цагдаагийн яамны сайдад дамжуулан илтгэснээр Франсуа Пико долоон жилийн турш сураггүй алга болсон байна.

Тэр нь тагнуул туршуул гэгдэн тулгагдаж Фенестрел цайзад ял эдэлж байхдаа үхлүүт өвчтэй нэгэн итали гэлэнг сэтгэл гарган тойлж байсны хариуд цаадах нь Милан хотод нуусан алт, үнэт чулуун эрдэнэсээ түүнд гэрээслэн өв болгожээ. Напелеоны эзэнт улсыг унасны дараа Франсуа тэр эрдэнэсийн сангий нь эрж олоод, Парист өөр нэрээр эгэн ирсэн ба©на. Гэтэл сүйлсэн бүсгүй нь хоё° жил хүлээж байгаад гуанзны эзэн Лупиантай гэрлэснийг дуулжээ. Өөртэй нь хэн ингэж, хатуугаар «тоглосныг» хар аван гадарласан Пико итали ламын дүрд хувилан Нимд очиж, Лупианы гуанзанд сууж байсан гурвын нэг байсан боловч булай «тоглоомд» оролцохгүй гэж татгалзсан Антуан Аллютой уулзаж, ховор сайхан очир эрдэнэ бэлэглэн байж, бусад хүний нь нэрийг хэлүүлжээ. Энэ үеэс эхлэн Пико өшөөгөө авахаар хатуу шийдсэн байна.

Удалгүй Парис хотын «Урлагийн гүүрэн» дээрээс Шамбарал Лупианы хамсаа гэгчийн хүүр олдоход, түүнийг алсан чинжаалын бариул дээр «Анхных нь» гэж сийлсэн байжээ. Тэгтэл ч Лупианд гай түйтгэр нүүрлэж, гуанз нь шатан, хүү нь шоронгийн хадаас болж, охин нь цөллөгөөс оргосон ялантай гэр бүл болсон нь илэрчээ. Дараа нь Лупианы хоёр дахь хамсаа Солари хорлогдон амь тавихад, авсан дээрээс нь «Хоёр дахь нь» гэсэн бичиг олдсон байна. Эцэст нь, нэгэн үдэш, нүүрэндээ багтай хүн Лупианыг гудамжинд зогсоож, нүгэл нь нүдээрээ гарч байгааг сануулжээ. Гуанзны эзэн «Бурхан намайг гэсгээн цээрлүүлсэн» гэж хэлэхэд нь нөгөө танихгүй хүн ч чухам хэн болохоо хэлжээ. Хайр найргүй өшөө авахаа тангарагласан Пико ч санасандаа хүрч, Лупиан «Гурав дахь нь» болсон байна.

Хэрэг явдал үүгээр дууссангүй. Нөгөө долоон булчирхай, найман найлзуурхайгаа Пикод тоочсон Антуан Аллю, түүний мөрийг мөшгөн, анаж яўсаар эцэст нь өшөөг өшөөгөөр авч, түүний аминд хүрчээ. Энэ бүгдийн тухай Аллю амьсгаа хураахынхаа өмнө нүглээ наманчлан ламд ярьснаар сайхь түүхийг цагдаагийн газар дансандаа тэмдэглэн авчээ.

Ургуулан бодож үгээр урлахдаа гарамгай Дюма зохиолч дээрх явдлаас санаа авч түүхэн үйл явдалтай холбоод, амьдралд үнэхээр байсан мэт санагдах дахин дахин уншсан ч уйдамгүй энэхүү гайхамшигт зохиолыг бүтээсэн түүх ийм ажгуу.

Манай хэвлэлийн газарт, хорь гучин жилийн өмнө гарсан орчуулгын сайхан сайхан зохиолуудыг амтархан уншиж байсан ном нь одоо нүдний гэм болсныг тэмдэглээд дахин хэвлэж өгөөч гэсэн хүсэлт тэр байтугай ийм ийм зохиолыг орчуулаач гэсэн санал уншигчдаас маань чамлалтгүй ирдэг. Бид ч үүнийг хирээрээ бодолцъё хэмээх боломжийн гэж үзсэн орчуулгыг заавал дахин орчуулж цаг алдалгүйгээр уг эхтэй нь дахин тулгаж, нягтлан шүүгээд гаргаж байхаар шийдээд байна. Үүний өмнө М.Ридийн «Морь унасан толгойгүй хүн»-ийг дахин хэвлэснийг та бүхэн бэлхнээ мэдэх билээ.

Энэ удаа Д.Даш агсны орос хэлнээс орчуулсан «Монте кристо гүн»-г франц эхий нь барин дахин засварлав. Алдаж энддэггүй орчуулагч бараг байдаггүй болохоор, гол нь утгын алдаа мэдгийг эхийнх нь дагуу засч залруулан, монгол уншигчийнхаа чихэнд эвтэй сонстохыг нь бодолцон орос орчуулгаас хэвээр нь буулгасан амьтан ургамал, цол хэргэм зэргийн нэр томъёог аль болохоор дүйх монгол үгээр орлуулан, гээгдэж орхигдсон зарим үг өгүүлбэрийг нэмж нэгэн мөр болгов.

Иймээс эрхэм уншигч авгай та уншихын зэрэгцээ өмнөх номтой нь харьцуулан, алдаж оносныг нь, зөвдөж буруудсаныг нь, дутуу дулимаг болсныг нь шүүн тунгааж санал онолоо Улсын хэвлэлийн газар ирүүлбэл манай цаашдын ажилд ихээхэн тус болмоор байна санж.

Б. Пүрэвбаатар

Нэгдүгээр бүлэг

1. Марсельд ирсэн нь

1815 оны хоёрдугаар сарын хорин долооны өдөр Норт Дам де-ла Гард зогсоолын харуул, Смирна, Приест, Неаполь ороод ирж яваа гурван шурагт «Фараон» гэдэг хөлөг онгоц айсуу явааг дохио өгч мэдэгдэв.

Буудлын лоцман¹ ердийн заншлаараа онгоц татах газраасаа гарч Иф цайзыг өнгөрөн Моржион хошуу, Риаон арал хоёрын хооронд яваа хөлөг онгоцонд тулж очив.

Марсельд хөлөг онгоц ирэхэд ихээхэн хөл хөдөлгөөнтэй болдог бөгөөд ялангуяа тэр онгоцыг нь «Фараон» шиг эртний Фокея хотын хөлөг онгоц үйлдвэрлэх газар босгож тоноглон, усанд анх тавиад, бас эзэн нь нутгийн хүн бол бүр ч их хөл болдог учир, зогсоолын гэгээн Ионна гэдэг талбайд олон мянган сониуч хүн заншсан ёсоороо төдхөн цугларан ирэв.

Энэ завсар хөлөг онгоц улам ойртсоор, галт уулын дэлбэрэлтээс болж дээр цагт Каласарень Жарос хоёр арлын хооронд тогтсон хоолойгоор амар мэнд өнгөрч, Помегийг тойрон гараад, шулуун гурван дарвуулаа татаж, хошуун дээрх гурвалжин далбаагаа дэлгэсэн мөртөө алгуурхан ирж явахад цугларсан олон хүн, азгүй явдал тохиолджээ гэдгийг аргагүй тааварлан чухамхүү юу болсон байдаг билээ гэж бодоцгооно. Гэвч учрыг мэдэх хүмүүс хөлөг хэвийнхээ байдлаар сайн явж байгааг хараад хэрвээ ямар нэгэн явдал болсон байлаа гэхэд онгоцонд биш юм гэдэг нь тодорхой байв. Зангуу буулгахад бэлхэн, ватер-бакштагаа өгчихсөн бөгөөд «Фараон»-ыг Марселийн онгоц зогсоолын нарийхан хаалгаар оруулах гэж байгаа лоцманы хажууд гавшгай байрын залуу эр зогсож хөлгийн хөдөлгөөн бүрийг нарийн ажиглаж, лоцманы тушаал бүхнийг давтан дамжуулж байв.

Энэ тодорхой биш түгшүүр нь цугларсан олны дундаас нэгэн хүнд сүрхий хүчтэй нөлөөлж, хөлөг онгоц буудалд орж ирэхээс өмнө, яаран завинд сууж «Фараон»-ы өөдөөс явахыг тушааж удалгүй нөөц булангийн тушаа хөлөг онгоцтой зэрэгцэж очив.

Залуу далайчин энэ хүнийг хараад лоцманы дэргэдээс холдон, онгоцны хөвөөнд очиж, бүрх малгайгаа авч зогсов.

Энэ бол арван найм, хорин насны, өндөр нуруутай, тэгшхэн биетэй, сайхан хар нүд, гялтганасан хар үстэй залуу хүү байв. Төрх байдалд нь бага наснаасаа эхлэн аюул гамшигтай тэмцэж сурсан хүмүүст байдаг тайван, шийдмэг янз илрэх ажээ.

- Өө! Дантес та юу? гэж завинд сууж ирсэн хүн хашхираад, - Юу болчоо вэ? Яагаад хөлгийнхөн чинь цөмөөрөө уруу царайтай явна вэ? гэж асуув.

- Эрхэм Моррель гуай, их золгүй явдал тохиолдлоо. Ялангуяа надад их золгүй явдал тохиолдож Чивита-ВекӨийн дэргэд алдарт ахмад Леклерээсээ хагацав гэж хүү хариулахад,

- Аа ачаа чинь? Гэж хөлгийн эзэн яаран асуув.

- Эрхэм Моррель, бүрэн бүтэн ирсэн, энэ талаар та санаа зовохгүй байх гэж би бодож байна... Харин хөөрхий ахмад Леклер... гэхэд, хөлгийн эзэн илтэд сэтгэл амарсан байдалтай,

- Юу болоо вэ? Манай алдарт ахмадад ямар явдал тохиолдов? гэж асуув.

- Нас барсаан.

- Онгоцноос ойчоо юу?

- Үгүй ээ мэдрэлийн чичрэг тусаад, жигтэйхэн зүдэрч үхсэн гэж Дантес хэлээд, хөлгийнхөн өөдөө эргэж, - Алийв? Байр байрандаа! Зангуугаа буулгаарай! гэж хашхирав.

Хөлгийнхөн нийтдээ арваад хүн тушаалыг дагаж хүн бүр өөр өөрийн үүрэгт ажлыг хийхээр далбаа, шураг уруу аргамж хөндлөвч уруу ухасхийлдлээ.

Залуу далайчин тэднийг зэрвэсхэн харж тушаал нь ёсоор биелэгдэж байгааг мэдээд, ярьж байсан хүн уруугаа дахин эргэхэд хөлгийн эзэн тасарсан яриагаа үргэлжлүүлэн:

- Тэр золгүй явдал чухам яаж тохиолдов? гэж асуув.

- Ёстой санамсаргүй явдал болсон. Ахмад Леклер боомтын коменданттай ярьж ярьж Неаполиос ихэд сэтгэл хөдөлсөн шинжтэй гарч яваад, маргааш нь байдгаараа халуурч, гурав хоноод өөд болчихсон... Бид зохих ёсоор нь оршуулсан. Одоо хөл толгойдоо хүнд юм зүүлттэй, зотонгоор ороолттой Дель Джильо арлын дэргэд тайван нойрсож байгаа. Бэлэвсэрсэн авгайд нь загалмай, сэлэм хоёры нь авчирсан. Бусдын л адил, мөрөөрөө нүд анихын тулд англичуудтай арван жил байлдаж явах ч гэж дээ хэмээн залуу хүү гунигтай янзаар инээмсэглэн хэлэв.

- Одоо яая гэх вэ. Эдмон минь! гэж улам улам тайвширч байгаа хөлгийн эзэн хэлээд,- Бид цөмөөрөө л үхэх үйлтэй улс хойно, хөгшин нь залуудаа байраа тавьж өгөх хэрэгтэй. Тэгэхгүй бол хамаг юм байрандаа үлдэнэ. Ингэхэд та ачаа яасан гэнээ? гэхэд нь

- Эрхэм Моррель гуай, бүрэн бүтэн ирсэн, би түүнийг батлан хариуцна. Тэр бүү хэл, хямдаар өглөө гэхэд та хорин таван мянган франкийн цэвэр ашиг олох

байх гэж бодож байна гэж хэлснээ «Фараон» дугараг цамхгийг өнгөрч явааг мэдээд: - Дарвуулаа хумь! уурвалжин далбааг буулга! Бизань-шкот! Зангуугаа буулгахад бэлтгэ! гэж хашхирав.

Энэ тушаал цэргийн хөлөг онгоц дээрх лүгээ адил түргэн биелэгдэв.

- Дарвуулын аргамжийг тат! Далбаагаа буулга!

Сүүлчийн тушаал өгөхөд бүх далбаа хураагдаад хөлөг онгоц зөвхөн эрчээрээ урагш гулсан явж байв.

Хөлгийн эзэн тэсэж ядан яарч байгааг хараад Дантес,

- Эрхэм Моррель, та одоо наашаа гараад ирээч дээ. Таны нягтлан бодогч эрхэм Данглар өрөөнөөсөө гарч ирж явна. Танд хэрэгтэй бүх мэдээг дуулгана биз. Би зангуун дээр очиж, уй гашуудлынхаа тэмдгийг тавих ажил хийе гэж хэлэв.

Хоёр дахь удаа давтан урих хэрэг байсангүй. Хөлгийн эзэн Дантесын шидсэн олсноос барьж, ямар ч далайчин атаархмаар шалмаг гавшгайгаар хөлгийн хажуугийн төмөр дамнуургаар авиран гарч ирэхэд Дантес Морреллийг угтан ирж яваа Дангларт байраа тавьж өгөөд хуучин байрандаа очихоор явав.

Данглар бол хорин тав орчим насны нилээд зэвүүн царайтай, дарга даамалд долигонуур, доод хүмүүстээ шигүүн догшин хүн юм. Нягтлан бодогч гэдэг хэргэм зэргээс нь илүүгээр энэ байдалд нь далайчид хэдийчинээ дургүйцэх тусмаа Дантесыг төдийчинээ хайрлан үзнэ.

- Тэгэхээр бидэнд тохиолдсон золгүй явдлыг эрхэм Моррель та хэдийнэ дуулаа шив дээ? гэж Данглар хэлэв.

- Тэглээ, тэглээ! Хөөрхий ахмад Леклер! Их сайн, шударга хүн байсан юм сан!

- Хамгийн гол нь тэнгэр, далай хоёрын хооронд насаа хөгширтөл явсан гайхамшигт сайн далайчин. Ийм хүнд л «Моррель ба түүний хүү» мэтийн ийм том фирмийн сонирхлыг итгэн хүлээлгэж болно гэж Данглар хариу хэлэв.

Тэгэхэд аятайхан зогсох газар хайж байгаа Дантесыг ажиглан харж байсан хөлгийн эзэн:

- Таны хэлж байгаа шиг ажлаа сайн мэддэг болохын тулд заавал хөгшрөх хэрэгтэй биш юм шиг санагдаж байна. Тэр, манай найз Эдмоныг хараач, хэнээс ч зөвлөлгөө заавар авалгүйгээр ажлаа айхавтар амжуулж байна шүү гэж хэлэхэд Данглар Дантес руу үзэн ядсан маягтай хялайн харснаа:

- Тийм ээ, тийм, нас залуу, хэтэрхий бие тоосон хүн дээ. Ахмадыг амьсгаа хураагаагүй байхад хэнтэй ч зөвлөн ярилцалгүйгээр командлалыг өөрөө авчхаад шууд наашаа хөдлөхийн оронд, Эльба арлын дэргэд биднийг бүтэн хагас өдөр дэмий хүлээлгэж цаг алдсан даа гэж хэлэв.

- Командлалыг авсан нь ахмадын туслахынхаа үүргийг гүйцэтгэсэн хэрэг, харин онгоцонд засва^о хийх хэрэг байгаагүй л бол Эльба арлын дэргэд бүтэн хагас өдөр болдог нь буруу гэж хөлгийн эзэн хэлэв.

- ХөлөJ онгоц эвдрээгүй, бүрэн бүтэн байсан эрхэм Моррель. Харин бүтэн хагас өдрийг алдсан нь зөвхөн эрэг дээр бууж зугаацах л гэснээс болсон юм гэхэд хөлгийн эзэн залуу хүү өөд хандан:

- Дантес аа нааш ир! гэж дуудав.

- Уучлаарай эзэн минь, би нэг минутын дараа тан дээр очъё гэж Дантес хариулав.

Тэгээд онгоцныхоо багт хандаж:

- Зангуу буулга! гэж тушаав.

Тэр дор зангуу бууж, гинж нь тарчигнан гүйв. Хэдийгээр лоцман байсан боловч Дантес энэхүү сүүлчийн ажиллагаа дуустал байрандаа байсаар байв.

Дараа нь:

- Дарцгаа хагаст нь хүртэл буулгаж, далбаагаа зангидаад, хөндлөө зөрүүл гэж хашхирав.

-Та харж байгаа биз дээ, одоо бүр өөрийгөө ахмад гэж хэдийнэ бодчихоод байна, нээрээ шүү гэж Данглар хэлэв.

- Тийм ээ, энэ чинь ахмад шүү дээ гэж хөлгийн эзэн хариулав.

- Тийм л дээ тэгэхдээ л та бодоод таны хоршоо нөхдөөр батлагдаагүй байгаа биз дээ, эрхэм Моррель гэж Данглар хэлэхэд:

- Түүнийг ахмад болгож болохгүй юм юу байна? Үнэндээ насаар залуу боловч ажил хэрэгт үнэнч шудрага, их туршлагатай хүн шиг байна гэв.

Дангларын царай барайв. Дантес ойртож ирээд:

- Уучлаарай, эрхэм Моррель гуай, зангуу буулгачихлаа, би одоо таны мэдэлд ирлээ. Та намайг дуудсан байх аа? гэж хэлэв.

Данглар алхам ухрав.

- Би танаас яах гэж Эльба арал дээр буусан бэ? Гэж асуух гэсэн юм

- Би өөрөө ч мэдэхгүй. Би зөвхөн ахмад Леклерийн сүүлчийн тушаалыг л биелүүлсэн. Амьсгаа хурааж байхдаа надад нэгэн дугтуйтай бичиг өгч маршал Берtrand өгөөрэй гэсэн.

- Эдмон та түүнтэй уулзаа юу?

- Хэнтэй?

- Маршалтай.

- Тэгсэн.

Моррель эргэн тойрноо хараад, Дантесыг хажуу тийш нь аваачиж:

- Аа, император ямар байна? Гэж адган асуув.

- Миний л харснаар бол энх тунх байх шиг байна билээ.

- Та бүр, императорыг түүнийг хараа юу?

- Намайг маршал дээр байхад орж ирсэн,

- Та тэгээд түүнтэй юм яриа юу?

- Үгүй, тэр надтай ярьсан гэж Дантес инээмсэглэн хариулав.

- Тэр юу гэж байна?

- Хөлгийн тухай, Марсель өөд хөдлөх цагийн тухай, манай аяны зам, ачаа барааны тухай асууж байна билээ. Хэрвээ хөлөг онгоц ачаагүй, тэгээд миний мэдэлд байсан сан бол лав худалдаж авах байсан байх гэж бодож байна. Тэгээд би өөрийгөө зөвхөн ахмадыг орлож яваа, хөлөг онгоц «Моррель ба түүний хүү» гэдэг худалдааны газрынх гэж хэлэхэд тэр « Өө, мэднээ. Үе залгамжилсан хөлгийн эзэд байгаа юм. Нэг Моррель нь намайг Валансид байхад манай хороонд алба хааж байсан юм » гэж байна лээ.

- Тиймээ үнэн! гэж хөлгийн эзэн баярлан дуугараад

- Тэр бол миний авга ах Поликар Моррель байгаа юм. Ахмад цолтой болтлоо цэргийн алба хаасан хүн. Дантес та авга ахад, эзэн хаан түүнийг дурсаж

байна лээ гэж хэлээрэй, тэгэхэд чинь хөгшин үглээ амьтан уйлна даа гээд залуу далайчны мөрийг нөхөрсгөөр алгадаж

- Хэрвээ таныг маршалд бичиг аваачиж өгч, императортой ярилцсаныг мэдвэл танд муу юм болж болох боловч та ахмад Леклерийн тушаалыг биелүүлж, Эльба арал дээр зогссон тань сайн байна гэв.

- Энэ надад юугаараа муу болох юм бэ? Гэж Дантес асуугаад

- Би дугтуй дотор чухам юу байсныг мэдэхгүй, эзэн хаан хэнээс ч асууж болох тийм зүйлүүдийг надаас асуусан. Одоо явж болох болов уу. Хорио цээрийн ба гаалийн түшмэд ирж явна гэв.

- Яв, яв хайрт нөхөр минь.

Залуу хүүг холдон явмагц Данглар хүрч ирээд:

- За яав? Порто-Феррайод зогссон тухайгаа танд тайлбарлаж өгөө шив дээ гэж асуув.

- Бүрэн дүүрэн хэлсэн, эрхэм Данглар минь.

- Өө! Тэгвэл бүр сайн юм болж. Хүн үүргээ биелүүлэхгүй байхыг харахад хэцүү байдаг юм гэв.

- Дантес өөрийнхөө үүргийг биелүүлж, энэ талаар хэлэх юм алга. Ахмад Леклерийн тушаалаар Эльба арлын дэргэд зогссон хэрэг байна гэж хөлгийн эзэн зөрж хэлэв.

- Мартсанаас танд ахмад Леклерийн захидлыг өгөв үү?

- Хэн?

- Дантес

- Надад уу? Үгүй. Түүнд захидал байсан юм гэж үү?

- Ахмад түүнд дугтуйтай битүүмжээс гадна бас нэг захидал өгөх шиг болсон юм сан.

- Данглар та ямар дугтуйтай юм яриад байна вэ?

- Порто-Феррайод, Дантесын аваачиж өгсөн.

- Дантес Порто-Феррайод дугтуйтай битүүмж аваачиж өгсөн гэж та хаанаас мэдээ вэ?

Дангларын царай улайж:

- Би ахмадын өрөөний хажуугаар явж байгаад түүнийг Дантест дугтуйтай юм, захидал хоёр өгч байхы нь харсан юм гэж хариу хэлэв.

- Үгүй, тэр надад юу ч хэлээгүй, хэрвээ түүнд захидал байгаа бол надад өгнө л дөө гэхэд Данглар бодлого болж:

- Хэрвээ тийм бол эрхэм Моррель та Дантест энэ тухай юм битгий хэлээрэй. Би андуурсан юм байлгүй дээ гэв.

Энэ үед залуу далайчин буцаж ирлээ. Данглар бас л холдлоо.

- За яав эрхэм Дантес, чөлөөтэй болов уу? Гэж хөлгийн эзэн асуухад

- Тэглээ, эрхэм Моррель гэж хариулав.

- Та ажлаа яасан түргэн амжуулчихав аа?

- Би гаалийнханд авчирсан таваарынхаа нэрсийн жагсаалыг өгчихсөн, харин боомтоос манай бичиг цаасыг дамжуулсан хүнийг лоцмантай хамт буцаагаад явуулчихаж.

- Танд энд өөр хийх юм байхгүй юу? Гэхэд Дантес тэр дороо эргэцүүлэн хараад:

- Алгаа бүх юм номоороо байна гэж хэлэв.

- Тэгвэл манайд очиж хоол идье.

- Уучлаарай эрхэм Моррель гуай, би юуны өмнө аавтайгаа уулзах ёстой. Таны урьсан явдалд тун их баярлалаа...

- Зүйтэй, Дантес, зүйтэй! Таныг сайн хүү гэдгийг би мэднэ гэхэд Дантес төдий л шийдмэг бишээр:

- Аав минь ямар байгаа бол, та мэдээгүй биз? Гэж асуув.

- Хайрт Эдмон минь, би түүнтэй уулзаагүй боловч лав эрүүл энх байгаа байх гэж бодож байна.

- Тийм ээ, аав минь муу өрөөндөө гарахгүй суугаад л байгаа байх.

- Таныг байхгүйд ямар нэг юмаар дутагдаж гачигдаагүйг энэ чинь нотолж байгаа хэрэг.

Дантес инээмсэглэн:

- Манай аав нэрэлхүү зантай хүн, юмаар дутагдаж гачиггалаа гэхэд бурхнаас өөр хэнээс ч тусламж гуйхгүй хүн байгаа юм гэв.

- Аавтайгаа уулзчихаад мана©хаар ирнэ биз дээ?

- Бас л ууч«ал гуйя, эрхэм Моррель, надад бас өөр нэг тун чухал үүрэг бий.

- Тийм ээ! Каталанд бас нэг хүн, гоо үзэсгэлэнт Мерседес, аавтай чинь адил тэсэж ядан хүлээж байгаа гэдгийг би мартчихаж.

Дантес инээмсэглэв.

- Өө тийм байж шүү! Тэр охин гурван удаа ирж, «Фараон» хэзээ ирэх вэ? гэж асуусны учрыг одоо л ойлголоо. Чөтгөр ав. Эдмон та ямар их азтай хүн бэ, ямар сайхан найзтай юм бэ!

- Мерседес миний найз биш гэж далайчин ноцтойхон хэлээд, - Миний болзоот хүүхэн байгаа юм гэхэд, хөлгийн эзэн инээд алдаж

- Энэ чинь заримдаа адилхан байдаг гэвэл

- Тэгвэл бидэнд тийм биш гэж Дантес хариулав.

- За за, Эдмон таныг би саатуулахаа больё. Та миний ажлыг сайн амжуулсан болохоор, өөрийнхөө ажлыг бүтээхэд тань зав өгөх ёстой. танд мөнгө хэрэггүй гэж үү?

- Үгүй, хэрэггүй. Аяллын үед авсан мөнгө, өөрөөр хэлбэл гурван сарын цалин хэвээрээ үлдэж ирсэн.

- Эдмон та, их нямбай хүн юм.

- Эрхэм Моррель, аавыг минь ядуу хүн гэдгийг бүү мартаарай.

- Тийм ээ, тийм, би таныг сайн хүү гэдгийг сайн мэднэ. Аавдаа оч. Би ч бас хүүтэй. Хэрвээ түүнийг минь гурван сар эзгүй явж байгаад ирээд надтай уулзах гэхэд нь хүн саад хийвэл би бас учиргүй уурлана.

- Та тэгвэл зөвшөөрч байх шив дээ? гээд залуу хүү бөхөсхийн асуув.

- Хэрвээ танд өөр хэлэх юмгүй бол яв даа.
- Өөр юу ч үгүй.
- Ахмад Леклер амьсгал хураахдаа надад захидал өгсөнгүй юу?
- Леклер юм бичиж чадахгүй байсан, харин би танаас хоёр долоо хоногийн чөлөө гуйх ёстойг таны асуулт надад санууллаа.
- Хурим хийхэд үү?
- Хурим хийх, Парис орох хоёрт.
- Тэг тэг. Бид бараг зургаан долоо хоног ачаа бараагаа буулгана, тэгээд гурван сарын дараа дахин далайд гарна даа гээд хөлгийн эзэн залуу далайчны мөрийг алгдан - Харин та гурван сар болоод энд байх ёстой. «Фараон» ахмадгүйгээр аянд гарч чадахгүй гэв.
- Ахмадгүйгээр гэнэ ээ? Гэж Дантес дуу алдаад, нүд нь баяртай гялалзан, - Эрхэм Моррель минь болгоомжтой яриарай, таны хэлсэн үг миний сэтгэлийн гүн дэх сэм горьдолд хариулж байна шүү. Та намайг «Фараон»-ы ахмадаар томилох гэж байна уу? гэж асуув.
- Хайрт нөхөр минь, хэрвээ би ганцаараа мэддэгсэн бол «Шийдсэн!» гэж хэлээд л гар барихсан. Гэвч надад хоршоо нөхөр байдаг болохоор тэгэж болохгүй байна. Та Италийн зүйр үг: «chi ha compagno ha padrone!» гэдгийг мэднэ биз. Гэвч хоёр саналын нэг нь таны талд байгаа болохоор хэрэг ажлын хагас нь бүтсэн. Хоёр дахь саналыг бас таны талд гаргуулахыг би хариуцъя.
- Ай эрхэм Моррель! гэж залуу хүү нүднийхээ нулимсыг гүйлгэнүүлэн түүний гарыг атгаж - Танд эцэг Мерседес хоёрын нэрийн өмнөөс баяр хүргэе гэв.
- Зүгээр зүгээр, Эдмон минь үнэнч хүмүүсийн бурхан, тэнгэрт байдаг юм, чөтгөр ав! Аав Мерседес хоёртойгоо уулзчихаад дараа нь манайд очоорой.
- Би таныг эрэг дээр гаргаж өгөх үү?
- Үгүй, баярлалаа. Би эндээ хоцорч Данглартай тооцоо бодож үзье. Аялалын үеэ тэр танд ямар санагдав?
- Наанатай цаанатай. Нөхрийн хувьд тааруухан. Нэгэн удаа бид хоёр муудаж маргалдсан. Тэгэхэд би энэ маргаанаа шийдвэрлэхийн тулд Монте Кристо арлын дэргэд 10-хан минут зогсёе гэж тэнэг юм хэлчихсэн

юм. Түүнээс хойш надад муу болчихсон хүн дээ. Уг нь би тэгэж хэлэх хэрэггүй байж, түүний татгалзсан ч зөв болжээ. Нягтлан бодохын хувьд ямар ч муу юм хэлэх арга алга, та ч гэсэн сэтгэл ханамжтай байх болно гэхэд, хөлгийн эзэн

- Хэрвээ та «Фараон»-ы ахмад байсан бол Дангларыг өөрийнхөө дэргэд дуртайяа байлгаж ажиллуулах уу? Гэж асуув.
- Би ахмад ч юм уу, эсвэл туслах нь ч байлаа гэсэн эздийнхээ итгэлийг хүлээсэн хүнийг бүрэн хүндэтгэж байх болно, эрхэм Моррель гуай.
- Зүйтэй, Дантес. Та ер нь бүх талаараа сайн хүн юм. Одоо яв даа, зүүн дээр сууж байгаа юм шиг л байна.
- Тэгээд би чөлөөтэй болчихов уу?
- Яв яв гэж хэлж байна шүү.
- Та завиар явж болох уу?
- Ав ав.
- Баяртай. Эрхэм Моррель танд маш их баярлалаа.
- Баяртай, Эдмон. Амжилт хүсье!

Залуу далайчин завинд харайн орж, залуурын дэргэд суугаад Канньбьер гудамж чиглэн явахыг тушаав. Хоёр далайчин сэлүүр барьж, буудлаас Орлеаны эрэг хүртэл хоёр эгнүүлэн зогсоосон онгоцнуудын хоорондох нарийхан зайгаар бусад олон завийн дундуур чадах чинээгээрээ хурдан сэлүүрдэн явав.

Хөлгийн эзэн түүнийг эрэг хүрч, завинаас үсрэн буугаад өглөөний таван цагаас оройн есөн цаг болтол хөл үймээн дүүрэн байдаг Каннебьер гудамжинд орж, бужигнасан олон хүний дунд алга болтол нь хойноос нь инээмсэглэн харж зогссон бөгөөд орчин үеийн фокейчууд энэ гудамжаараа бардамнан бахархаж «Парист Каннебьер гудамж байдаг сан бол Парис бяцхан Марсель байх сан » гэж өөрсдийн онцлог аялгуугаар үнэн голоосоо ярилцдаг ажээ.

Хөлгийн эзэн эргэж, өөрийн нь тушаалыг хүлээж байгаа мэт боловч үнэн хэрэг дээрээ өөртэй нь адил, залуу далайчныг үдэн харж байгаа Дангларыг харав. Гэвч холдон явж байгаа хүнийг харсан, энэ хоёр хүний харц шал ондоо байлаа.

2. Эцэг хүү хоёр

Үзэн ядах сэтгэлдээ автагдсан Данглар өөрийн нөхрийг хөлгийн эзний нүүрэн дээр муутгах гэж хичнээн оролдож байх зуур Дантес хаана юу хийж явааг сонирхон дагая. Тэрээр Каннебьер гудамжийг тууш явж Нойаль гудамжийг өнгөрөн Мельяны модот гудамжны зүүн гар талд байгаа багавтархан байшинд орж бүдэг гэрэлтэй шатаар тавдугаар давхар өөд яаран гарахдаа, нэг гараараа шатны бариулаас барьж, нөгөө гараараа догдлон цохилж буй зүрхээ дарж явснаа дутуу онгойсон хаалганы дэргэд очиж зогсов. Тэр хаалгаар тэр муу жижигхэн өрөөн доторх бүх зүйлийг үзэж болох ажээ.

Тэр муу жижигхэн өрөөнд түүний эцэг суудаг байж.

Сандал дээр гарч зогсоод салганасан гараараа цонхон дээр ургасан алтан лицэх, чөдөр ороомог цэцгүүдийг засаж байгаа өвгөнд «Фараоны» ирсэн тухай мэдээ хүрч арай л амжаагүй байжээ. Гэтэл араас нь нэгэн хүн тэврэн авч:

- Аав аа! гэх танил дуу сонстов.

Өвгөн дуу алдаж гэдрэг эргэн хүүгээ хараад тэврэн авахад царай нь цонхийж дагжин чичирч байв.

- Аав аа, та яагаа вэ? Бие чинь муу байна уу? гэж залуу хүү сэтгэл зовонгуй асуув.

- Үгүй, үгүй, хайрт Эдмон минь, хүү минь, үр минь, үгүй! Би чамайг хүрээд ирнэ гэж санасангүй...Гэтэл ороод ирлээ... Би баярлаад л ингэж байна. Бурхан минь! Үхэх гэж байгаа юм шиг санагдаж байна!

- Тайвшир аав минь, би байна. Хүн баярласнаасаа болоод үхдэггүй гэдэг болохоор би ингэж гэнэт ороод ирсэн юм. Аав минь битгий гөлрөн ширтээд байгаач, инээгээч. Би хүрээд ирлээ. Одоо юм бүхэн сайх сайхан болно гэхэд өвгөн:

- Тэгвэл сайн хүү минь. Гэсэн ч яаж юм бүхэн сайн сайхан болох юм бэ? Бид хоёр одоо хэзээ ч салахгүй юу? Аз жаргалынхаа тухай яриач? Гэж хэлэв.

- Бүхэл бүтэн гэр бүлийн уй гашуудал дээр бүтэж боссон аз жаргалыг минь бурхан өршөөг, гэвч би аз жаргалыг ингэж олох гэж хүсээгүйг минь бурхан харж байгаа. Энэ аз жаргал аяндаа өөрөө ирсэн болохоор уйтгарлаж гуниглахын арга алга. Ахмад Леклер нас барсан, би Моррелийн буянгаар түүний орыг эзлэх нь шиг байна. Ойлгож байна уу, аав аа? Би хорьхон настайдаа ахмад болох нь! Зуун луидорын цалин авч бас орлогоосоо хуваалцна! Ядуу далайчин би ийм юм болно гэж яаж санах вэ?

- Тийм ээ, хүү минь, чиний хэлдэг зөв, энэ бол үнэхээрийн азтай явдал гэж өвгөн хэлэв.
- Та миний цалин авахад л өөрийн цэцэг ногоог тарьж ургуулах цэцэрлэгтэй байшин худалдаж аваарай... Аав аа, та яагаад байнаа? Бие чинь муу байна уу?
- Зүгээр, зүгээр... одоо гайгүй зүгээр болчихно! гэснээ өвгөн тамир тасарч ар тийшээ суун тусав.
- Одоохон, аав аа! Аяга дарс уучих, тэгвэл бие чинь засарна. Дарс чинь хаана байна?
- Хэрэггүй, баярлалаа, битгий эр, хэрэггүй гэж өвгөн хүүгээ зогсоохыг оролдон хэлэв.
- Яагаад хэрэггүй гэж! . Дарс чинь хаана байгааг хэлээч гээд Дантес шүүгээн дотор эрж эхлэхэд, өвгөн:
- Эрэх хэрэггүй...Дарс байхгүй... гэж хэлэв.
- Байхгүй гэнээ? гээд Дантес өвгөний цонхигор хацар, хоосон шүүгээ хоёрыг ээлжлэн харж - Яагаад байхгүй гэж? Таны мөнгө хүрэхгүй гэж үү? Гэж асуухад:
- Чи л ирсэн хойно боллоо гэж өвгөн хэлэхэд, Дантес хөлсөө арчиж:
- Гэсэн ч дээ, би гурван сарын өмнө явахдаа танд хоёр зуун франк орхисон шүү дээ гэж аяархан дуугарав.
- Тэгсэн, тэгсэн, Эдмон, харин чи явахдаа айлынхаа Кадруст өгөх өрөө өгөлгүй мартаад явчихсан байна лээ. Тэр хүн энэ тухай надад хэлж, хэрэв чиний орноос өрөө төлөхгүй юм бол Моррель гуайд хэлнэ гэхээр нь би чамд муу юм болж магадгүй гэж айгаад... гэхэд,
- Тэгээд яав? Гэж Эдмон асуув.
- Тэгээд би төлчихсөн.
- Би Кадруст зуун дөчин франкийн өртэй байсан! гэж Дантес хашхирахад өвгөн:
- Тийм ээ гэж дотроо бувтнав.

- Тэгээд та түүнийг миний үлдээсэн хоёр зуун франкаас төлчихөө юу? Гэхэд өвгөн толгой дохив.
- Бүтэн гурван сард жархан франкаар байгаа юу?
- Би тэрнээс ихээр юу хийх вэ гэж өвгөн хариулав.
- Бурхан минь! гэж Дантес эцгийнхээ өмнө өвдөг дээрээ сөхрөн суухад:
- Юу болов? Гэж өвгөн асуув.
- Би үүнийг хэзээ ч уучлахгүй.
- Боль доо, зүгээр хүү минь гэж өвгөн инээмсэглэн хэлээд- чи л ирсэн хойно бүх юм гүйцлээ. Одоо юм бүхэн сайхан байна шүү дээ гэв.
- Тийм ээ, би ирсэн, тэгэхдээ илүү сайхан горьдлоготой,бага зэрэг мөнгөтэй ирсэн... Май аав аа, үүнийг ав, одоохон хүн явуулж юм хум авчруул гэж залуу хүү хэлэв.

Тэгээд арав гаран алтан зоос, тав, зургаан ширхэг таван фракийн зоос, задгай мөнгө гаргаж ширээн дээр асгав.

Өвгөн Дантесийн царай гэрэлтэж,

- Энэ хэний юм бэ? Гэж асуув.
- Минийх...таных... манайх! Идэж уух юм ав, битгий мөнгө хайрлаарай, маргааш бас мөнгө авчирна гэхэд өвгөн инээмсэглэн:
- Байз, байз авчирсан мөнгөнөөс чинь бага багаар зарахгүй бол хүмүүс намайг хүүгээ ирэхийг хүлээж ядаж байж дээ гэж бодож магадгүй гэж хэлэв.
- Дураараа л бол, харин юуны өмнө зарц хөлсөлж аваарай. Би таныг ганцаараа битгий суугаасай гэж байна. Онгоцон дээрх миний өрөөнд контрбандын кофе цай, гайхамшигт сайхан тамхи бий, маргааш танд авчирч өгнө. Чишш! Хүн ирж явна.
- Кадрусс л байх даа. Чиний ирснийг дуулаад сайн сайхан явж ирсэнд чинь баяр хүргэх гэж байгаа байх.
- Могойн эрээн гаднаа, хүний эрээн дотроо гэж Эдмон шивэгнээд- гэсэн ч яах вэ манай айлын хүн, урьд бидэнд тус болж байсан юм! Аятайхан л угтаж уулзъя гэж хэлэв.

Эдмоныг үгсэ хэлж дуусаагүй байтал Кадроссын хар сахалтай толгой хаалгаар цухуйв. Энэ бол хорин тав зургаан настай хүн юм. Оёдолчин мэргэжлийнхээ дагуу хувцас хийх хэсэг цэмбэ барьжээ.

Өө, Эдмон, хүрээд ирээ юу? Гэж их л марсель аялгуугаар хэлээд, зааны яс шиг цагаан шүдээ цөмий нь ил гартал арзайн инээмсэглэв.

- Херш Кадросс, хүрээд ирлээ. Танд хэрэгтэй бол туслахад бэлэн байна гэж Дантес хүйтэн царайгаа эелдэг зөөлөн аялгуугаар далдлан хэлэхэд,

- Гүнээ баярлалаа. Аз болоход надад юу ч хэрэггүй. Харин заримдаа би хүнд хэрэг болдог юм (Дантес татвасхийв) Эдмон. Би чиний тухай яриагүй шүү. Би чамд мөнгө зээлүүлсэн, чи надад түүнийг минь буцааж өгсөн, сайн сэтгэлт хөрш нар ийм байдаг юм, бид хоёр одоо өр ширгүй.
- Бид өөрсдөдөө тусалсан хүнд хэзээ ч өртэй байдаг. Мөнгөний өр төлөгдчихсөн ч гэсэн, баяр талархлын өр хэвээрээ үлддэг юм гэж Дантес хэлэв.
- Үүнийг яриад яах юм бэ? Өнгөрсөн хэрэг. Харин чиний сайн сайхан буцаж ирсэн тухай ярилцъя. Би буудал дээр очиж, хүрэн цэмбэ олох гэж яваад өөрийн танил Данглартай уулзлаа л даа.

«Чи чинь Марсельд ирчихээ юу?» гэж би асуулаа.

«Ирчихсэн байгааг харж байгаа биз дээ» гэж байна. «Чамайг Смирнад байгаа л гэж бодож байлаа».

«Тэндээс шууд ирсэн болохоор, тэнд байсан ч байж болно».

«Манай Эдмон хаана байна?»

«А в дээрээ очсон байх» гэж Данглер надад хэллээ.

Тэгээд л би, найздаа баяр хүргэе гэж ирлээ л дээ гэв.

-Кадросс сайн хүн, бидэнд тун хайртай шүү! гэж өвгөн хэлэв.

- Мэдээж хайртай байлгүй яах вэ. Тэгээд бас үнэнч шударга хүн ховор болохоор хүндэтгэж байдаг юм... гээд оёдолчин Дантесийн ширээн дээр гаргаж тавьсан овоолгоотой алт, мөнгийг хяламхийн хараад - Найз минь чи бүр баяжаа шив дээ? гэж хэлэв.

Хөршийнхөө хар нүдэнд гялалзах шуналыг залуу хүү ажиглав.

- Энэ миний мөнгө биш гэж хайхрамжгүйхэн дуугараад- Би аавыг мөнгөгүй болчихсон байх бий гэж айж явснаа хэлсэн юм, тэгэхээр миний сэтгэлийг амруулах гэж хэтэвчиндээ байсан мөнгөө ширээн дээр асгачихаад байгаа нь энэ. Аав аа хөршид минь мөнгө хэрэггүй бол наадуулаа далд хий, хэрэгтэй бол өг л дөө гэв.
- Үгүй найз минь. Надад юу ч хэрэггүй. Бурхан минь, оёдлын ажил минь намайг тэжээж байна, мөнгө хэзээч илүүдэхгүй, хайрлаж хадгалж бай, мөнгө авахаасаа илүү мөнгө ав гэж хэлсэнд чинь их баярлалаа гэж Кадрусс хэлэв.
- Би үнэн зүрхнээсээ хэлсэн юм шүү гэж Дантес хэлэхэд,
- Эргэлзэхгүй байна. Чи Моррельтэй их түнш юм аа, сэргэлэн эр байна шүү! гэв.
- Эрхэм Моррель надад үргэлж сайн байдаг юм гэж Дантес хариулахад,
- Тэгвэл чи хоол ид гэж урихад нь дэмий татгалзаж дээ гэв.
- Хоол ид гэж урихад нь татгалзлаа гэж үү? Тэр чамайг хоол ид гэж урьсан юм уу? гэж өвгөн Дантес асуув.
- Тийм ээ, аав аа гэж Дантес хариулаад, хүүгий минь урьсан яудалд хязгааргүй их баярлаж байгаа өвгөнийг харж инээмсэглэв.
- Хүү минь чи юунд тэгж татгалзаа вэ? гэж өвгөн асуухад залуу хүү,
- 'ан дээр бушуухан ирэх гэж тэгсэн юм. Тантай уулзах гэж тэсэж ядаад гэж хариулбал.
- Моррель гомдсон байх. Ахмад болохоор санаархаж байгаа хүн эзэнтэйгээ зөрөх хэрэггүй дээ гэж Кадросс хэлэв.
- Би түүнд татгалзсан учраа тайлбарлан хэлж өгсөн, тэр ч миний хэлснийг ойлгосон.
- Ахмад болохын тулд эздэдээ жаахан долигонож байх хэрэгтэй.
- Ингэхгүйгээр ахмад болж болно гэж би найдаж байна гэж Дантес хариулав.
- Тэгвэл сайн, тэгвэл сайн! Энэ чинь чиний хуучин бүх найз нөхрийг баярлуулж байна. Тэгээд гэгээн Николай цайзын цаад талд хүлээж байгаа нэг хүн улам ч их баярлах байх.

- Мерседес үү? Гэж өвгөн асуув.
- Тийм ээ, аав аа гэж Дантес хариулаад- Одоо би тантай уулзаж, таны эрүүл энх, хэрэгтэй юм бүхэн чинь байгааг үзэж мэдсэн хойно, намайг Каталан руу явахыг зөвшөөрнө гэв.
- Яв, яв, хүү минь яв. Бурхан надад хүү заяасан шиг чамд бас эхнэр заяаг гэж өвгөн Дантес хэлэв.
- Эхнэр гэнэ ээ? Та яасан их яарч байх юм бэ, Мерседес одоохондоо эхнэр нь болчихоогүй байна! гэж Кадросс хэлэв.
- Одоогоор үгүй, тэгэхдээ удахгүй болох байх гэж Эдмон хариулав.
- Тэр ч яах вэ, харин чиний яаран ирсэн чинь сайн болж хэмээн Кадрусс хэлэв.
- Яагаад тэр билээ?
- Яах юу байх вэ, Мерседес чинь гоо үзэсгэлэнтэй охин, тэгэхээр гоо сайхан охиод сэтгэлтэй хүн олон байдаг. Ялангуяа Мерседесийн хойноос өдий төдийгөөрөө л хөөцөлдөж байна.
- Нээрэн үү? Гэж Дантес асуугаад инээмсэглэхэд баJa зэрэг сэтгэл зовсон шинж харагдаж байв. Кадрусс үргэлжлүүлэн,
- Тийм ээ, тийм тэгээд бас атаархмаар хүмүүс. Гэвч чи удахгүй ахмад болохоор чамд татгалзах нь юу л бол гэж хэлэхэд Дантес тосож аваад сэтгэл зовсноо арай гэж нууж инээмсэглэн:
- Тэгвэл, тэгвэл би ахмад болохгүй бол... гэж хэлэхэд Кадрусс,
- Хай л даа гэж аман дотроо бувтнав.
- Ингэхэд би ер нь эмэгтэйчүүдийн тухай, ялангуяа Мерседесийн тухайд танаас арай дээр бодолтой шүү. Намайг ахмад болсон ч болоогүй ч тэр охин надад үнэнч хэвээрээ байна гэдэгт би итгэлтэй байна.
- Тэгвэл л сайн, тэгвэл л сайн! Эхнэр авахдаа түүндээ итгэж чаддаг байх хэрэгтэй, гэхдээ найз минь, цаг алдалгүй очиж ирсэн тухайгаа, өөрийнхөө санаж бодож явдгаа хуваалц гэж би хэлэх байна гэж Кадруссыг хэлэхэд
- Явлаа гэж Эдмон хариулав.

Эцгээ үнэсчихээд, Кадрусс өөд толгойгоо дохиод гарч одов.

Кадрусс өвгөнтэй хамт жаахан сууж байгаад түүнтэй салах ёс гүйцэтгэн гарч, Сенак гудамжны буланд өөрийг нь хүлээж байгаа Данглар дээр очив.

- За яав? Чи түүнтэй уулзав уу? гэж Данглар асуухад,
- Уулзлаа гэж Кадрусс хариулав.
- Ахмад болно гэж горьдож байгаагаа чамд ярьж байна уу?
- Бүр ахмад болчихсон юм шиг л ярьж байна.
- Үгүй ер! Дэндүү яарч байна! гэж Данглар хэлэв.
- Гэхдээ Моррель түүнд ам өгч...
- Тэр их баяртай байна уу?
- Хэтэрхий их баяртай байна. Тэр ч байтугай дээд зиндааны хүн шиг загнаж, банкны эзэн хүн шиг мөнжө өгөх гэсний нь яана.
- Тэгээд и авсангүй юу?
- Авсангүй. Уг нь амьдралдаа анх удаа үзсэн мөнгө гээчийг зээлдүүлсэн хүн нь би байсан болохоор авч болох л байлаа. Харин одоо эрхэм Дантес юугаар ч дутахгүй, удахгүй ахмад болох нь ээ!
- Гэхдээ одоохондоо ахмад болчихоогүй л байна! гэхэд Кадрусс
- Үнэнийг хэлэхэд тэр ахмад болчихгүй бол сайн сан. Тэгвэл тэрүүнтэй ярьж ч болохгүй болчихно гэв.
- Хэрвээ бид хүсвэл тэр одоогийнхоо байгаа хэвээр, магадгүй тэрнээс ч дор байж болно шүү гэж Данглар хэлэв.
- Чи юу ярина вэ?
- Зүгээр би өөрөө өөртөө хэлж байна. Тэр одоо хүртэл гоо үзэсгэлэнт Каталан охинд хайртай хэвээрээ байна уу?
- Ухаангүй хайртай. Аль хэдийн тийшээ гүйгээд явчихсан. Чухам энэ талаас л түүнд эвгүй явдал болж магадгүй гэж санагдах юм, эсвэл би андуурч байж ч болох юм.
- Тодорхой ярь.

- Яах юм бэ?
- Энэ бол чиний бодож байгаагаас илүү чухал юм. Чи Дантест дургүй шүү дээ.
- Би бардам зантангуудад дургүй.
- Тэгтэл чи каталан охины тухай мэдэж байгаа бүхнээ хэл.
- Лавтайяа мэдэх юм алга. Гэхдээ хуучин эмнэлгийн хажуу зам дээр ирээдүйн ахмадад эвгүй явдал тохиолдож магадгүй гэж бодож болохоор юм харсан.
- Чи юу харсан юм бэ? За алив, хэл.
- Мерседесийг хот орж ирэх бүрд нь бие бялдар томтой хар нүдтэй улаан хацартай, хар үстэй, ууртай байрын каталан залуу дандаа дагаж ирдгийг би харсан. Мерседес түүнийг үеэл ах аа гэж байна лээ.
- Нээрээ юү? Тэгээд үеэл ах нь түүнийг эргүүлээд явдаг байх гэж чи бодож байна уу?
- Тэгж л бодож байна. Хорин настай залуу арван долоотой гоо үзэсгэлэнт охин хоёрын хооронд түүнээс өөр юу байж болох билээ?
- Чи Дантесийг Каталан уруу явчихлаа гэв үү?
- Намайг байхад явчихсан.
- Хэрвээ чи бид хоёр тийшээ явбал «Нөөц»-өд орж аяга мальгийн дарс уух зуураа сонин юм үзэж болох нь ээ.
- Хэн тэр тухай бидэнд хэлэх юм бэ?
- Бид Дантесийн зам дээр байж байгаад чухам юу болсныг нь царайгаар нь мэдчихнэ.
- За тэгвэл явъя. Харин чи мөнгийг нь төлнө шүү гэж Кадрусс хэлэхэд,
- Тэгэлгүй яахав гэж Данглар хариулав.

Тэгээд тэр хоёр очих газар өөдөө яаран явав. Гуанзанд орж нэг шил дарс, хоёр аяганы хамт өг гэв.

Арваад миний өмнө Дантес гуанзны хажуугаар өнгөрч гарсан гэдгийг өвгөн Памфилаас сонсчээ.

Дантесын Каталанд байгаа гэдгийг мэдэж аваад, хаврын урин орж мөчир дээр нь шувууд жиргэн донгодож байгаа залуу моддын навчисын дор сууцгаав.

2. Каталанчууд

Хоёр найз чих тавин чагнаж зам ширтэн малыгийн хатуу дарс ууж суугаа тэр газраас зуугаадхан алхам зайтай газар нар салхинд идэгдсэн нүцгэн довцгийн цаад талд Каталан гэдэг суурин оршино.

Эрт дээр цагт Испани орноос гарсан хэсэг нүүдэлчин одоогийнхоо оршин сууж байгаа энэ бяцхан газар ирж нутагласан ажээ. Тэд чухам хаанаас ирсэн нь мэдэгдэхгүй бөгөөд үл ойлгогдох хэлээр ярилцана. Дарга нарын нь дотроос провансаль хэл мэдэх нэгэн хүн эртний далайчдын заншлаар хөлөг онгоцнууд а татан гаргасан, хүн амьтангүй эзгүй хошууг эзэмшин сууя гэж Марсел хотын даргаас зөвшөөрөл гуйжээ. Тэдний хүсэлтийг хүндэтгэн хүлээн авч удалгүй гуравхан сарын дараа эдгээр тэнгисийн цыгануудын авчирсан арваад хөлөг онгоцыг тойрон багахан суурин үүсчээ. Хагас мавритан, хагас испани маягийн энэ өвөрмөц байдалтай үзэсгэлэнт сайхан сууринд эдүгээ хүртэл эцэг өвгөдийнхөө хэлээр ярьдаг, тэдгээр хүмүүсийн удам угсаа оршин амьдарсаар байна. Тэд гурав буюу дөрвөн эрингийн туршид, далайн шувуу шиг сүрэглэн ирж суурьшсан тэрхүү хошуундаа үнэнч шудрага хэвээр урвалт хөрвөлтгүй амьдарч марселынхантай огтхон ч хутгалдахгүй зөвхөн өөр хоорондоо гэрлэж хэл яриагаа хадгалан хоцорсон шигээ зан заншил, хувцас, хунараа хэвээр нь хадгалан байгаа ажээ.

Уншигч авгайг бидний хойноос дагаж, суурины ганцхан гудамжаар явж, нэгэн бяцхан байшинд орохыг урья. Энэ хязгаарын эртний барилга бүхэнд байдаг зэвхий шаргал ханатай байшинг гаднаас наран гийгүүлэх бөгөөд дотор талыг будагчин хүн испанийн *posadas*-ын ганцхан гоёл чимэг болох цагаан өнгөөр будаж гоёжээ.

Давирхай шиг гялтганасан хар үстэй, уян зөөлөн нүдтэй гоо үзэсгэлэнт охин хайс налан зогсож, эрт цагийн уран барималч урлан хийсэн юм шиг нарийхан хуруугаараа ямар ч гэм хоргүй байсан далийн мөчрийг базлан имрэхэд унасан цэцэг навч нь шалан дээр хөглөрнө. Бага зэрэг борлосон боловч, Арлийн Венерагийн гараас хуулбарлан бүтээсэн юм шиг тохойдоо хүртэл ханцуйгаа шамласан гоолиг гар нь сэтгэлийн хөдөлгөөнөөс болж үл мэдэг чичирхийлэн, өндөр өсгийтэй шаахай өмссөн хөнгөн хөлөөрөө байж ядсан байдалтай шал товшиход саарал, хөх судалтай улаан оймс шав хийтэл өмссөн шулуухан хөлийн булчинг харж болохоор байв. Тэр охиноос гуравхан алхмын зайтай газар хорин нэг хоёр насны биелэг сайхан залуу эр сандал дээр ганхан, ширээ тохойлдож тэвдэж эгцүүдсэн байдалтай харж сууна. Залуугийн нүдэнд юм асуумаар шинж илэрхий

боловч охины шийдвэртэй ширүүн харц түүний нь номхотгон барьж байх ажээ. Залуу хүү

- Мерседес минь сонсооч, удахгүй улаан өндөгний баяр, хурим хийхэд хамгийн тохиромжтой үе болно... хариу хэлээч дээ! гэж гуйна.
- Фернан, би чамд мянга түмэн удаа хариу хэлсэн, харин чи дахиад надаас асуувал өөрөө өөртөө дайсан болно шүү.
- Чи дахиад хэлээч, гуйя чамаас, намайг итгэхээр дахиад хэлээч. Ээж чинь зөвшөөрөн адисласан миний дурлалыг няцаан буцааж байгаагаа зуу дахь удаагаа хэлээч. Аз жаргалаар минь тоглож, миний үхэх амьдрах хоёр чамд юу ч биш гэж боддог болтол минь ойлгуулаач. Бурхан минь! Чиний нөхөр болох юм сан гэж арван жил хүсэн мөрөөдөөд, эцэс сүүлд нь амьдралын минь ганцхан зорилго болж байсан горьдлого алдагдана гэдэг яасан хэцүү хэрэг вэ?
- Би л лав чамд ийм горьдлого төрүүлээгүй дэг. Би чамд хэзээ цагт горьдохоор юм хэлсэн гэж чи намайг зэмлэж чадахгүй. Би чамд ах шигээ хайртай, харин Энэ ах дүү ёсны нөхөрлөлөөс илүү өөр юм бүү шаард, би зүрх сэтгэлээ өөр хүнд өгсөн гэж дандаа хэлдэг байсан шүү дээ. Би чамд үүнийг хэлээгүй гэж үү? Гэхэд залуу хүү түүний үгийг тасалж,
- Хэлсээн хэлсэн, Мерседес чи надад дандаа эрс тэс, хатуу ширүүн хариу өгдөг байсан. Гэхдээ чи каталанчууд зөвхөн өөр хоорондоо гэрлэн суух ариун хуулийг мартаж байна гэж хэлэв.
- Чи ташаарч байна, Фернан, энэ бол хууль биш заншсан заншил л байгаа юм. Энэ заншлыг урдаа барих хэрэггүй гэж хэлсэн шүү. Чи одоохондоо чөлөөтэй сул яваа бол энэ чинь зөвхөн азын хэрэг. Өнөөдөр биш ч гэсэн маргааш чамайг цэрэгт татна. Тэгээд чи цэрэг болчихоороо эцэг минь ээжид, ээж минь надад үлдээж өгсөн хуучирч өгөршсөн муу урхи торноос өөр юу ч дотор нь байхгүй, нурж унаж байгаа муу оромтой мөнгө ч үгүй, гаслан зовлонтой өнчин ядуу хүүхнийг яах болж байна? Эхийгээ өнгөрсөнөөс хойш би, жил шахам бараг гуйлгаар амь зууж байсан шүү дээ! Чи бодооч Фернан! Чи заримдаа намайг өөртөө тусалж байна хэмээх дүр үзүүлдэг чинь барьсан загаснаасаа намайг аваг гэсэндээ л тэр. Чиний өгсөн загасыг авдгийн учир бол чиний эцэг миний аавын ах байсан учраас, чи бид хоёр хамт нэг дор өссөн, ялангуяа би татгалзвал чи гомдож болох учраас тэгэж авдаг байсан юм. Чиний загасаар олж, юм нэхэх олс худалдан авч байсан тэр мөнгө бол зүгээр л гуйж олсонтой адил гэж би боддог.
- Мерседес минь, надад бас адилдаа адил! ганцаардмал ядуу зүдүү чи надад Марселийн ямар ч баян хөлгийн эзэн, банкны эзний охиноос илүү

үнэтэй! Ядуу хоосон бидэнд юу хэрэгтэй вэ? Үнэнч гэргий, сайн аж ахуйч эзэгтэй хэрэгтэй. Тэгэхээр чамаас илүү хүнийг хаанаас олох вэ?

- Фернан минь гэж Мерседес толгойгоо сэгсрээд - Муу эзэгтэй ч болж мэднэ. Бас тэгээд нөхөртөө дургүй өөр хүнд сэтгэлтэй бол үнэнч эхнэр байна гэхийн баталгаа байхгүй. Чи надтай нөхөрсөг харьцаатай байгаадаа ханавал болно. Үүнийг л чамд амлан хэлж чадна, би лав биелүүлж чадах юмаа л амладаг гэдгийг давтан хэлье гэхэд Фернан:
- Ойлгож байна, чи өөрийнхөө ядуу хоосон байдлыг тэсвэртэй хүлээн өнгөрүүлж, харин минийхээс айж байх шив дээ. Мерседес ээ, хэрвээ чи надад сэтгэлээ өгвөл би аз жаргал олохыг оролдоод үзье. Чи надад аз авчирч, би баяжина. Би загасчин хэвээрээ байхгүй, конторын албанд хөлсөөр орж сүүлдээ өөрөө ч худалдаа наймааны ажил хийдэг болж болох юм гэж хэлэв.
- Үгүй, Фернан чи ийм юм хийж чадахгүй, чи хэзээ ч цэрэг хүн, одоо дайн дажин байхгүй болохоор л энэ Каталанд байж байна. Загасчин хэвээрээ бай, гандирсийн балгас битгий босгоод бай, сүүлд нь жинхэнэ үнэн байдалд ороод ирэхээр улам хэцүү бэрх болно, чамтай үерхэн нөхөрлөж байгааг минь л их юм гэж бодож яв. Би чамд үүнээс өөр юм хэлж чадахгүй.
- Тийм ээ чиний хэлдэг зөв. Мерседес минь би далайчин болно. Харин тСгэхдээ чиний дургүйцдэг эцэг өвJөдийн хувцасны оронд чийдсэн бүрх малгай, судалтай цамц, товчин дээрээ зангууны дүрстэй богино цамц өмсөнө. Чамд аятайхан харагдах гэсэн хүн бол ийм хувцас өмсөх ёстой биз дээ?
- Чи юу гэх гээ вэ? гээд Мерседес түүний өөдөөс бардам, эрс харж - Чи тэгээд юу гэх гээ вэ? Би чиний хэлж байгааг ойлгохгүй байна гэж хэлэв.
- Мерседес, чи миний дүрслэн хэлсэн шиг тийм хувцас өмссөн хүн ирэхийг хүлээж байгаа учраас надад ингэж их хатуу ширүүн байх юм. Тэр хүн чинь тийм тогтвортой туйлбартай байгаад байхгүй байж мэднэ. Тэр тогтвортой байгаад байлаа гэхэд далай гэдэг маань дөлгөөн тогтвортой биш шүү дээ гэж хэлэх гэсэн юм гэхэд Мерседес:
- Фернан гэж хашхираад - Би чамайг сайхан сэтгэлтэй хүн гэж боддог юм сан, гэвч андуурсан юм байж. Хэрвээ хардаж сэрдэхдээ бурхны хилэнг дуудаж байгаа юм бол чи хорт амьтан! Чиний тэр ярьж байгаа хүнийг хүлээж байгаа, түүнд дуртай хайртай гэдгээ би нуухгүй. Хэрвээ тэр минь эргэж ирэхгүй бол би түүнийг тогтвор суурьшилгүй гэж зэмлэхгүй, харин надад хайртай, дуртай байсаар байгаад л үхсэн гэж хэлнэ гэж хэлэв.

Каталан залуу хилэнтэйгээр нударга зангидав.

- Намайг өөртөө дурласангүй гэж түүнд хонзон санаж байгааг чинь би ойлголоо. Чи каталанд хутгаа түүний чинжаалтай зөрүүлэх санаатай байна уу? Өөрөө л мэд! Хэрвээ чи дийлдвэл би чамтай үерхэмээ болино. Хэрвээ чи дийлчихвэл би чамайг үзэн ядах болно. Хүүхэнд тоогдох гээд тэр хүүхний дурласан хүнтэй маргах гэдэг бол буруу арга гэдгийг мэдэж ав. Үгүй, Фернан чи дэмий муу санаа бүү агуул. Би чиний эхнэр болохгүй болохоор намайг зүгээр л сайн найз, дүүгээ шигээ л бодож сурчихна. Түүнээс гадна гээд хүүхний нүдэнд нулимс гүйлгэнэн - Фернан чи битгий яар, тэнгис далай хэцүү гэж чи өөрөө хэлсэн биз дээ, тэр минь яваад дөрвөн сар болж байна, энэ хооронд би өчнөөн олон шуурга болсныг тоолж суусан! гэж хэлэв.

Фернан хүйтэн царай гаргаж, Мерседесийн хацар дээгүүр урссан нулимсыг арчих ч гэсэнгүй. Уг нь бол түүний дусал нулимс бүрийн төлөө аяга цус гаргахаа хайрлахгүй байсан сан. Гэвч энэ нулимс өөр хүний төлөө гарч байгааг сайн мэдэж байв!

Фернан босож гэр дотуур урагш хойш явснаа Мерседесийн өмнө ирж зогсоход нүд гялалзуулан гар зангидсан байв.

- Мерседесээ, ингэж бүр шийдэв үү, хэлээч? Гэж хэлэв.
- Би Эдмон Дантест хайртай. Эдмоноос өөр хэн ч миний нөхөр болохгүй гэж охин тайван хариулав.
- Чи түүндээ үргэлж хайртай дуртай байх уу?
- Амьсгаа тасартлаа хайртай байна

Фернан сүүлчийнхээ найдлагыг алдсан хүн шиг гиншин толгойгоо бөхийлгөснөө дараа нь гэнэт өргөж шүдээ зуугаад:

- Аа хэрвээ цаадах чинь үхчихвэл яах вэ? гэж асуув.
- Тэгвэл би бас үхнэ.
- Хэрвээ чамайг мартчихсан байвал яахав?

Гэтэл хаалганы цаад талаас,

- Мерседес гэж хөгжилтэй цовоо дуу гарснаа дахин - Мерседес! Жэж дуудав.

Хайр дурлал аз жаргалдаа автсан бүсгүй,

- Өө! гэж дуу алдаад - Харж байна уу, намайг мартаагүй хүрээд ирж! гэж хэлэв.

Тэгээд хаалга руу гүйж очоод онгойлгох зуураа

- Наашаа ор, Эдмон минь! Би энд байна гэж хашхирч байв.

Фернан зам дээр нь могой дайралдсан хүн шиг огло үсрэн ухарч царай нь зэвхийн хамаг бие нь чичирч сандалаа тулаад аяндаа суучихав.

Эдмон Мерседес хоёр ухасхийлдэн тэврэлдэхэд онгорхой хаалгаар туссан марселийн шатаам халуун наран тэр хоёрыг гийгүүлэв. Тэд эхлээд орчин тойрондоо юу байгааг ч огт анхаарсангүй. Хэмжээлшгүй жаргал тэднийг орчноос нь тусгаарлаж, огцом цөөн үгээр баярласан сэтгэлийнхээ хөдөлгөөнийг илчилж тэврэлдэнэ.

Гэнэт бүдэг харанхуй дундаас Фернанийн зэвхий цайвар, хорсож заналхийлсэн царай тодорч, каталан залуу бүсэндээ зүүсэн хутган дээрээ өөрийн мэдэлгүй гэлтэй гараа тавьсан байхыг Эдмон олж хараад, хөмсөг зангидан:

- Уучлаарай, бид гурвуулаа байгаа юм гэдгийг мэдсэнгүй шүү гэж хэлэв.

Дараа нь Мерседес өөд харж ийн асууруун:

- Энэ эрхэм хэн бэ?
- Энэ бол миний найз, миний ах Фернан болох учраас мөдхөн таны сайн нөхөр болно. Дантес аа, энэ хүнийг би таны дараад оруулан хайрладаг юм. Та таньсангүй гэж үү? Гэхэд,
- Таньж байна гэж Эдмон Мерседесээс гараа салгалгүйгээр нөгөө гараа каталан залуу өөд найрсгаар сарвайв.

Гэвч Фернан түүнийг нөхөр ёсоор гар сарвайхад үг дуу ч гаралгүй баримал хөшөө шиг зогсов.

Тэгэхэд нь Эдмон чичрэн дагжиж байгаа Мерседес, аймаар баргар царайлан зогсож байгаа Фернан хоёрыг шинжин харав.

Ганц хараад л бүгдийг ойлгожээ. Дантесийн уур хилэн бадрав.

- Мерседес ээ, би чам дээр ирэх гэж яаран гүйж явахдаа дайсантай учирна гэж огт мэдсэнгүй гэхэд Мерседес:

- Дайсан гэнэ ээ? Гэж хашхираад үеэл ах өөдөө хорсолтойгоор харж, - манайд, миний гэрт дайсан байна гэнэ ээ? Би хэрвээ тэгж бодсонсон бол энэ гэрийг үүрд орхиж чамтай сугадалцаад Марсель орчихсон байх байсан юм гэж өгүүлэв.

Тэгэхэд Фернанийн нүд гялалзаж байлаа.

- Эдмон минь, хэрвээ чамд ямар нэгэн муу явдал тохиолдвол гээд Мерседес, Фернаний хар санааны гүнд шингэн орсон тэр тайван байдлаараа үргэлжлүүлэн- Би Моржион хошуун дээр гарч хаднаас толгойгоороо үсрэх байсан гэж хэлэв.

Фернан үхээрийн зэвхий царай гаргав.

- Гэвч чи ташаарч байна Эдмон оо, энд чамд нэгч дайсан байхгүй, харин миний ах Фернан л байна. одоо тэр чамтай үнэнч нөхрийн ёсоор гар барина гэж Мерседес хэлэв.

Хөшсөн юм шиг Эдмон руу аяархан дөхөж очоод гараа сунгаж байгаа каталан залууг Мерседес захирангуй маягтай харав.

Хүчит долгион адил түүний үзэн ядах сэтгэл нь эрх дураараа энэ охины өмнө арга буюу задран бутрав.

Гэвч Эдмоны гарт дөнгөн данган хүрч, гүйцэтгэх ёстой үүргээ гүйцэтгэлээ гэж бодмогцоо гэрээс гүйн гарч одов.

- Надад зовлон учруулагч! гээд гараа базлан гиншиж, - хэн намайг энэ хүнээс ангижруулдаг бол? Яасан гаслантай хэрэг вэ! гэнэ.
- Хүүе, каталан залуу! Хүүе, Фернан! Чи хаачих ь вэ? гэж нэг хүн дуугарав.

Феран зог тусаж ийш тийшээ харахад Кадрусс Данглартай хамт модны цаад талын ширээнд сууж байв.

- Чи наашаа ирэхгүй яагаа вэ? Эсвэл чи найз нөхөдтэйгээ ч мэндлэх завгүй явна уу? гэж Кадрусс асуув.
- Ялангуяа өмнө нь бараг бүтэн шил архи байхад уу ! гэж Данглар нэмж хэлэв.

Фернан тэднийг алмайран харж, нэг ч үг дуугарсангүй.

- Энэ бүр алмайрч орхиж гэж Данглар хэлээд Кадрусст хөлөө хүргэж- Бид эндүүрч, бидний бодсоны эсрэг Дантес ялж орхивол яана? гэв.

- Тэгвэл одоохон мэдээд орхиё гэж Кадрусс хэлээд, залуу хүү өөд эргэж-За яав, каталан хүү чи шийдэж байна уу, үгүй юу? гэв.

Фернан нүүрнийхээ хөлсийг арчаад, сэхээвчинд ороход түүний сүүдэр сэтгэлийг нь бага зэрэг тайвшруулж, сэнгэнэсэн сэрүүн агаар алжаасан биеийг нь амраах шиг болов.

- Сайн байцгаана уу? Та нар намайг дуудав уу даа янз нь? гэж хэлээд нэгэн сандал дээр суух гэж унаад өгөв.
- Би чамайг галзуу юм шиг гүйж явахыг хараад, тэнгист ороод живж үхчих вий гэж айгаад дуудсан юм гэж Кадрусс инээж хэлээд -Чөтгөр аваг! Нөхдийгөө зөвхөн дарсаар зочлон дайлдаг биш, бас заримдаа тэднийгээ ус балгахад нь саад болдог ч явдал байдаг гэнэ

Фернан санаа алдах ч биш, эхэр татах ч биш хачин жигтэйхэн болоод гар дээрээ толгой унжуулан бөхийв.

- Фернан, чи миний хэлэхийг сонс доо гэж Кадрусс сониучхан зангаасаа болоод зүй зохистой харьцааг алддаг жирийн хүмүүсийн бүдүүлэг, илэ далангүй байдлаа хэлээд - Чи чинь ёстой л аргаа барсан амьтан ёиг байх юм! гээд учир зүггүй инээв.
- Үгүй ээ ийм сайхан эр дурлалд хаанаас азгүй төрөх вэ. Кадрусс чи битгий тоглоом хий гэж Данглар өөдөөс нь хэлэв.
- Би ер тоглоом хийгээгүй байна шүү дээ. Чи үүний санаа алдаж байгааг дуулж байгаа биз дээ? Алийв, Фернан наад хамраа өргөөд асуусан юманд хариулаадах эрүүл мэндий чинь тухай найз нөхөд чинь асууж байхад хариулахгүй байна гэдэг бүдүүлэг хэрэг шүү дээ Фернан гэхэд цаадах нь нударгаа зангидаж:
- Би зүгээр гэж хариулсан боловч толгойгоо өндийлгөсөнгүй.

Тэгэхэд Кадрусс найз өөдөө нүд ирмээд:

- Өө! Данглар, ийм явдал болжээ, чиний энэ харж байгаа марселийн шилдэг сайн загасчны нэг, сайн санаат каталан залуу Фернан бол Мерседес гэдэг гоо үзэсгэлэнт бүсгүйд дурлачихжээ. Гэтэл гай болж тэр гоо хүүхэн нь «Фараоны» ахмадын туслахад сэтгэлтэй юмсанжээ. Тэгээд өнөөдөр «Фараон» буудалдаа эргэж ирсэн учир ...ойлгож байна уу? гэж хэлэхэд Данглар:
- Үгүй, ойлгохгүй байна гэж хариулав.

- Хөөрхий Фернан огцрох нь тэр гэж Кадруссын үргэлжлүүлэн ярихад,
- Тэгээд яагаа вэ? гэж хэлээд Фернан толгойгоо өндийлгөж хорслоо хэнд гаргах билээ гэж хүн эрэх шиг Кадруссыг хараад-Мерседес хэний ч өмч биш, тийм биз дээ? Хэнд дурлахаа өөрөө мэднэ гэв.
- Чи үүнийг ингэж үзэж байгаа бол өөр хэрэг л дээ! Би чамайг каталан хүн гэж боддог байсан юм, каталанчууд бол хайртай хүүхнээ булаалгадаг улс биш гэж надад ярьсан юм л даа. Тэр ч байтугай Фернан өшөөгөө аймшигтай сүрхий авдаг хүн байгаа юм гэж нэмж хэлсэн гэж Кадрус хэлэхэд Фернан жигших мэт инээмсэглээд,
- Дурлачихсан хүн хэзээ ч аймшигтай биш гэж хэлэв.

Тэгэхэд Данглар түүнийг үнэн зүрхнээсээ өрөвдөж байгаа юм шиг,

- Хөөрхий амьтан! Одоо яадаг билээ дээ? Дантесыг ийм түргэн яваад ирнэ гэж бодогүй байх даа. Дантесыг үхчихсэн ч юм уу эсвэл Мерседест дурлахдаа больчихсон байж магадгүй гэж бодож байсан байх даа, яаж мэдэх вэ? Иймэрхүү явдал гэнэт тохиолддог болохоор хүнд илүү их дарамттай байдаг юм гэж хэлэв.

Байн байн ууж байгаа малыгийн дарс толгойд нь гарсан Кадрусс,

- Ямар ч л гэсэн Дантес эсэн мэнд яваад ирсэн нь ганцхан Фернаны хорыг хөдөлгөөд зогсоогүй байх аа, тийм үү Данглар аа? гэж асуув.
- Тийм ээ, энэ явдлыг муугаар төгсөнө гэж батлахнаач би бэлэн байна гэж Дангларыг хэлэхэд, Кдарусс Фернанд дарс хийж өгөөд өөрийнхөө хундагыг найм буюу арав дахь удаагаа дүүргэж:

Хэдий тийм боловч... Хэдий тийм боловчтэр хүн гоо үзэсгэлэнт Мерседестэй сууна. Тэгэх л гэж эргэж ирсэн байлгүй гэв. Энэ завсар Данглар дарсанд зөвхөн уруулаа хүргэх төдий суув.

Данграл энэ хооронд Фернаныг гайгүй сайн шинжин харж Кадруссын үг түүний зүрхэнд халуун тугалга шиг нэвтрэн орж байхыг мэдэв.

- Хурим хэзээ болох вэ? гэж Дангларыг асуухад,
- Өө! Хуримд ч арай хүрээгүй гэж Фернан шивэгнэн хэлэв.
- Тэглээ ч гэсэн хуримандаа ч хүрнэ дээ. -Энэ бол Дантес «Фараон»ы ахмад болно гэдэг шиг мадаггүй зүйл дээ, тийм биз дээ? Данглар гэж Кадрусс хэлэв.

Данглар гэнэт ингэж хэлэхэд нь татвасхийгээд санаатайгаар хэлэв үү, эсвэл үгүй юу гэдгийг мэдэх гэж Кадрүүс өөд ширтэн харахад, цаадах нь хөлчүүрэн элий балай болсон царайд нь атаархлаас өөр юм харагдахгүй байв.

- Тэгэхээр гээд шилэн аягануудыг дүүргэж - Үзэсгэлэнт каталан хүүхний нөхөр ахмад Эдмон Дантесын төлөө ууя! гэж хэлэв.

Кадрүүс хүндэрсэн гараараа аягаа өргөж, нэг амьсгаагаар уучхав. Фернан өөрийн аягыг шүүрэн авч, хага цохин хаяв.

- Байз! Каталанаас ирдэг замын довцог дээр юу болж байна? Фернан чи хараач, чиний нүд сайн шүү дээ. Миний нүд ч одддхоёр хараад байна. Дарс бол урвамтгай эд гэдгийг чи мэднэ биз дээ. Сэтгэлтэй хоёр гараасаа хөтлөлцөн явах шив. Ай бурхан минь! Биднийг эндээс харж байна гэж сэжиг ч авахгүй үнсэлцэж байна шүү! гэж Кадрүүс хэлэв.

Фернаны хөдлөх бүрийг Данглар ажиглаж байсан тул царай нь эвгүй болохыг харав.

- Фернан та, тэр хоёрыг таньж байна уу? гэж асуухад Фернан:
- Таньж байна. Эдмон Мерседес хоёр байна гэж аяархан хариулав.
- Ай хөөрхий! Тийм байж л дээ. Би тэднийг таньсангүй. Хөөе Дантес! Хөөе үзэсгэлэнт хүүхэн! Нааш ир, хурим чинь хэзээ болох вэ, бидэнд хэлж өгөөч, энэ зөрүүд Фернан хэлэхгүй байна гэхэд Данглар хөлчүүрхсэн хүний зөрүүд зан гаргаж сэхээвчнээс ооччих гэж байгаа Кадрүүсыг хойш татан зогсоож байгаа дүр үзүүлэн, үгийг нь тасалж:
- Чи дуугүй байна уу, үгүй юу? Хөл дээрээ төвшин зогс, хайртай улсыг зүгээр байлгаач. Фернанаас жишээ аваач, үгүй дээ л ухаалаг байна гэв.

Дангларт тухируулан биеэ барьж чадахгүй болсон Фернан босон харайж өрсөлдөгчийнхөө өөдөөс үсрэн очихыг шахсан боловч хөгжилтэй тэнэгэр явсан Мерседес сайхан тэргүүнээ өргөж жавхаатай нүдээр бүхнийг харахад «Эдмон үхвэл би үхнэ» гэж заналхийлснийг нь санаад сандал дээрээ буцаж суув.

Данглар архинд мансуурч дурлалд автсан хоёр нөхрөө харж

- Энэ тэнэгүүд надад ямар ч нэмэр болохгүй нь Архичин, хулчгар хоёртой л хоршчих шиг боллоо гэж айж байна. Энэ нь хорсож заныхын оронд дарсаар гүзээгээ дүүргэсэн атаархагч амьтан, нөгөөдөх нь дурласан хүүхнээ хамар доороо алдчихаад хүүхэд шииг уйлж, гомдож яваа балай амьтан. Гэхдээ энэ хүнд өшөөгөө нарийн авч чаддаг испани, сицили, калабри хүмүүсийнх шиг гал цогтой нүд,бухын толгой шиг хага

базчихмаар нударга байна. Аз жаргал Эдмонд инээмсэглэж, гоо сайхан хүүхэнтэй сууж, ахмад болоод биднийг шоолон доромжлох болох нь ээ, харин зөвхөн... гээд Данглар ёжтойхон инээмсэглээд - Харин би л дундуур нь орж саад болохгүй бол гэж битүүхэн шивгэнэн үглэв.

Кадрусс өндийж нударгаараа ширээ тулж зогсоод:

- Хүүе Эдмон! Чи найз нөхдөө харахгүй байна уу, эсвэл тэгж биеэ их тоочихоод бидэнтэй ярихыг хүсэхгүй байна уу? гэж хашхирахад Дантес,
- Үгүй шүү эрхэм Кадрусс. Надад бардсан юм алJa. Би их аз жаргалтай байна, аз жаргал хүнийг бардам зангаас илүү сохор балай юм шиг болгодог юм гэв.
- Тийм ээ зөв! Энэ ч ёстой тайлбар даа! Сайн байна уу, Дантес хатагтай? Гэж Кадрусс хэлэв.

Тэгэхэд нь Мерседес ёсорхгоор мэхийн ёсолж,

- Намайг одоохондоо тэгж нэрлэх болоогүй. Нөхөр нь арай болчхоогүй байгаа болзоот хүний нь нэрээр хүүхнийг нь нэрлэвэл, манай ёсонд муу ёр гэдэг юм, тийм болохоор намайг Мерсеес л гэж дуудаж байхыг танаас хүсье гэв.
- Манай хөрш Кадрусс төдий л буруутай биш, ялимгүй л алдлаа шүүдээ гэж Дантес хэлэв.

Тэгэхэд Данглар хоёр залуу тийш мэхийн ёслоод,

- Тэгэхээр хурим тань удахгүй болох нь шив дээ? гэж асуув.
- Аль болохуйц түргэн хийх санаатай байна. Өнөөдөр аавтайгаа ярилцана, маргааш эсвэл нөгөөдөр ураг болохоор тохиролцсоны баярыг энэ «Нөөц»-өд хийнэ. Найз нөхөд минь бүгдээрээ ирнэ гэж бодож байна. Энэ бол эрхэм Данглар та уригдлаа гэсэн үг. Энэ бол Кадрусс чиний ирэхийг бид хүлээнэ гэсэн үн гэхэд Кадрусс согтуу инээдээр инээж,
- Аа, Фернан яах вэ? Фернан бас ирэх үү? Гэж асуув.
- Миний эхнэрийн ах бол миний ах. Ийм үед түүнийг бидэнтэй хамт байхгүй бол Мерседес бид хоёр үнэнээсээ гомдоно доо гэж Эдмон хэлэв.

Фернан үг хэлэх гэсэн боловч хоолой дээр нь юм тээглэхчээд үг дуугарч чадсангүй.

- Өнөөдөр сүйлчхээд эсвэл маргааш эсвэл нөгөөдөр нь хуримаа хийх гэнэ ээ... Ахмад та их яарч байа даа! гэхэд Эдмон инээмсэглэж,
- Эрхэм Данглар, би саяхан Мерседесийн Кадруст хСлсэн үгийг танд хэлмээр байна. Одоогоор хүртээгүй байгаа цолоор намайг бүү дуудаарай, энэ бас надад аюул даллаж мэднэ гэв.
- Уучлалыг гуйя. Би зөвхөн таныг дэндүү яарч байна л гэж хэлсэн юм. Бидэнд амжих цаг их байна. «Фараон»гурван сарын дараа л аян замд гарна шүү дээ гэж Данглар хариулав.
- Жаргалтай байх гэж яарах хэрэгтэй,эрхэм Данглар. Удаан зовж зүдэрсэн хүн аз жаргалаа олсонд арай ядан итгэдэг юм. Энэ бол зөвхөн биеэ тоосон хэрэг биш, би бас Парис явах хэрэгтэй байгаа юм.
- Өө тийм бий! Парис орох гэнэ ээ! Та тийшээ анх удаа явах гэж байгаа тань энэ үү?
- Тийм ээ.
- Та тэнд ажилтай юу?
- Надад ажил байхгүй ээ. Манай хөөрхий ахмад Леклерийн сүүлчийн даалгаврыг биелүүлэх хэрэгтэй байна. Энэ бол буяны үйл гэдгийг Данглар та ойлгож байгаа биз дээ. Санаа зовох хэрэггүй, би оччихоод л хүрээд ирнэ.
- Тийм ээ тийм, ойлгож байна гэж Данглар хэлээд дотроо маршалын өгсөн захидлыг эзэнд нь хүргэж өгөх нь. Чөтгөр ав! Харин энэ захидал чинь надад нэг санаа төрүүлэв, тэгэхдээ бүр гайхалтай сайхан санаа гээч, Дантес найз минь! Чи одоогоор «Фараон» дээр тэргүүн дугаарт бичигдэх хүн нь болчихоогүй л байна шүү гэж бодов.

Тэгээд тэр холдон яваа Эдмоны хойноос,

- Замдаа сайн яваарай! гэж хашхирав.

Тэгэхэд Дантес толгойгоо эргүүлэн гяарэг харж эелдгээр дохин:

Баярлалаа гэж хариулав.

Дурласан хоёр залуу тэнгэрээс заяасан гэлтэй жаргалтай тайван одоцгоов.

2. Хуйвалдаан

Эдмон Мерседес хоёрыг гэгээн Николай цайзны цаагуур далд ортол Данглар хойноос нь ажиглан харж байгаад дараа нь лонхны найз нар өөдөө эргэж харав. Фернаны царай цонхийн бие нь чичрэн хөдлөхгүй суух бөгөөд Кадрусс нь ямар нэгэн шалиг дуу бувтнав.

- Энэ хурим хүн болгонд жаргал авчрахгүй байх гэж надад санагдаж байна хэмээн Данглар Фернанд хэлэв.
- Энэ хурим намайг гуниг гасланд учруулна гэж Фернан хариулав.
- Та Мерседест сэтгэлтэй юу?
- Би түүнийг хайрлан дээдэлдэг юм.
- Эртнээс тэр үү?
- Бие биеэ мэдэх болсон цагаас л хойш тэр. Би амьдралынхаа туршид түүнийг хайрлаж дурлаж яваа минь энэ.
- Та тэгээд уйтгар гунигаа арилгачихаар арга сүвэгчлэхийн оронд толгойтой үсээ зулгаан зүгээр сууж байгаа хэрэг үү? Чөтгөр ав! Каталанчуудын хооронд ийм явдал болдоггүй гэж боддог.
- Тэгээд би таныхаар бол юу хийх вэ? гэж Фернан асуув.
- Би яаж мэдэх вэ? Ямар надад хамаатай юм биш. Би Мерседес авхайд дурласан биш, харин та яахаа хөлгөн сударт хэлсэнчлэн хайвал дээр дээ.
- Би ч яахаа шийдсэн байгаа л даа.
- Чухам яаж шийдээ вэ?
- Би түүнийг хутгалчих гэж бодсон чинь Мерседес Дантесыг үхвэл амиа хорлоно шүү гэсэн юм.
- Боль доо! Тэгж аман дээрээ ярьдаг болохоос, үнэн хэрэг дээрээ хийчихдэггүй юм.
- Та Мерседесийг мэдэхгүй байна. Хэлсэн үгэндээ хүрдэг хүн байгаа юм.
- Балай амьтан! Тэр үхвэл үхэж л байг, надад ямар хамаа байх вэ, харин Дантес ахмад болохгүй л байвал боллоо гэж Данглар шивэгнэв.

- Мерседесийг үхэхээс өмнө би үхнэ гэж Фернан шийдвэртэй хэлэв. Кадрусс согтуу дуугаар:
- Дурлал гэдэг чинь л энэ байна даа! Энэ чинь л дурлал байна, эсвэл би энэ тухай юу ч мэддэггүй амьтан юм уу? гэв.
- Хөөш та надад их сайн хүн шиг санагдлаа, чөтгөр ав гэж, би таны зовлонг нимгэлж тусалмаар л байна. Гэхдээ... хэмээн Дангларыг хэлтэл Кадрусс хөндлөнгөөс нь шүүрэн авч,
- Тийм бол яриач гэв.

Тэгэхэд нь Данглар үгий нь тасалж,

- Эрхэм минь, чи одоо бүр согтчихож наад шилтэйгээ уучихвал бүр ч болох нь тэр. За, за наадхаа уу, тэгээд бидний ажилд бүү оролц. Бидний ажилд саруул толгой хэрэгтэй гэж хэлэв.
- Би согтчихлоо гэнэ ээ? Гэж Кадрусс хашхираад
- Би дөрвөн шилийг ч уучихна. Энэ нь сүрчигийн хөөс л гэсэн үн. Памфил гуай дарс өгөөдөх! гээд шилэн аягаараа ширээ дэлдэв.

Фернан тасарсан өгүүлбэрийн төгсгөлийг дуулах гэж байдгаараа шимтэн Дангларт,

- Та юу гэнээ яриач... гэж хэлэв.
- Би юу ярьж байснаа санахгүй байна. Энэ муу архичин хамаг ухаан санаа самууруулчихлаа.
- Яах вэ дээ архичин л байгаа биз. Харин дарснаас айдаг улс өөрсдийн муу санааг согтуудаа гаргачих бий гэж айгаад дарс уудаггүй байх гэж Кадрусс хэлээд тэр үед ихэд түгээмэл байсан дууг уянгалуулан,

Хар усан ундатны мууг

Харь эртнээс цөм мэднэ гэж дуулав.

- Та, миний зовлонг нимгэлж тусалмаар байна. Гэхдээ... гэж хэлээд зогссон шүү дээ гэж Фернан үргэлжлүүлэн хэлэв.
- Тийм ээ, Танд туслахын тулд таны дурласан хүүхэнтэй Дантесын суух явдалд саад хийх хэрэгтэй. Дантесыг алахгүйгээр хуримыг нь хийлгэхгүй байж болно.

- Зөвхөн үхэх л тэр хоёрыг хагацуулж чадна гэж Фернаныг хэлэхэд Кадрусс үгийг нь тасалж
- Та чинь хонь шиг л амьтан юм, найз минь. Манай Данглар бол ухаантай, зальтай, эрдэмтэй хүн. Таны ташаарч байгаа нотлоод өгнө. Хэлээд өг Данглар. Би чамайг даана. Дантес үхэх хэрэггүй, тэр ч байтугай хайртай байдаг юм. Дантес чиний төлөө уучихъя! гэж хэлэв.

Фернан эгдүү нь хүрч гараараа савчаад ширээний цаанаас босоход Данглар каталан залууг зогсоож

- Энэ маань согтуу боловч, сохор ухаантай байна. Салгаж хагацаана гэдэг бол үхлээс доргүй зүйл. Дантес, Мерседес хоёрын хооронд шоронгийн хана байна гэж бодоод үз л дээ. Шорон тэр хоёрыг булшны чулуу шиг л салган тусгаарлаж чадна гэж хэлэв.

Тэгэхэд Кадрусс үлдсэн үл ялих ухаанаа зарцуулж, ярианд дөнгөн данган оролцоод,

- Тийм нь ч тийм, тэгэхдээ шоронгоос гараад ирнэ шүү дээ. Шоронгоос гарч ирээд Эдмон Дантес гэж дахин нэрлэгдэх болохоороо заавал ч үгүй өшөөгөө авна гэж хэлэв.
- Яах вэ тэгэг! гэж Фернан шивгэнэв.
- Үгүй тэгээд, Дантесыг яалаа гэж шоронд суулгах хэрэг вэ? Тэр хулгай хийгээгүй, хүрээ талаагүй... хүн алаагүй... гэж Кадруссыг хэлэхэд,
- Дуугүй бай гэж Данглар үгийг нь таслав.
- Дуугүй байхгүй! Дантесыг яалаа гэж шоронд хийх гэж байгаагаа надад хэлээч. Би Дантест хайртай. Дантес чиний эрүүл мэндийн төлөө ууя! гэж Кадрусс хэлээд дахин нэг аяга дарс хоослов.

Данглар сайвангийн суларч гүйцсэн нүдийг хараад эргэж Фернанд:

- Одоо та түүнийг алах шаардлагагүй гэдгийг ойлгож байна уу? гэж хэлэв.
- Хэрвээ Дантесыг шоронд хатаачих арга байгаа бол алах хэрэггүй нь мэдээж хэрэг. Гэвч ямар арга байна даа?
- Сайн эрвэл олдоно доо гэж Данглар хэлснээ- Би ер яах гэж энэ хэрэгт орооцолдож байнаа? Надад хамаагүй хэрэг шүү дээ гэхэд Фернан гарыг нь шүүрэн авч:

- -Танд хамаатай эсэхийг мэдэхгүй харин танд Дантесыг үзэн ядах шалтгаан байна гэдгийг би мэдэж байна. Өөрөө үзэн ядаж байгаа хүн л өөр хүний тийм сэтгэлийг алдалгүй мэдэрдэг юм даа гэв.
- Дантесыг үзэн ядах шалтгаан надад байна гэнэ ээ? Ямарч шалтгаан байхгүй, үүнийг танд батлан хэлье. Би таны зовлонтой явааг хараад тус болох юм сан даа гэдэг бодол төрсөн юм. Тэгээд л тэр харин эрхэм нөхөр минь, та намайг өөрийнхөө тусын тулд ингэж байна гэж бодвол би байртай гэж хэлээд явахаас ч биш яах вэ. Та өөрөө л энэ явдлаасаа яаж ийгээд мултарч үзнэ биз дээ гээд Данглар босох гэж байгаа дүр үзүүлэв.
- Үгүй та байж байгаач! гэж Фернан түүнийг зогсоон хэлээд - Та Дантесыг үзэн ядаж байгаа эсэх нь надад ямар хамаа байх вэ. Би түүнийг үзэн яддаг, тэрнийгээ нуугаагүй. Аргы нь хэлээд аль би бүгдий нь гүйцэтгэе. Харён алж л болохгүй шүү. Дантесыг үхвэл Мерседес ч бас үхнэ гэж хэлсэн болохоор тийм арга тус болохгүй гэв.

Кадруус ширээн дээр дэрлэсэн толгойгоо өндийлгөж ухаангүй хөлчүү нүдээр Фернан Данглар хоёрыг гөлрөн хараад,

- Дантесыг ална гэнэ ээ! Хэн Дантесыг алах гэж байна? Түүнийг алахад би дургүй байна тэр бол миний найз, өнөө өглөөхөн хүртэл намайг мөнгө авахгүй юу гэж байсан юм. Би ч бас түүнд мөнгөнөөсөө өгдөг байсан шиг л хуваах гэсэн юм. Би Дантесыг үхээсэй гэж хүсэхгүй байна! гэхэд Данглар түүний үгийг тасалж,
- Түүнийг алах гэж байна гэж чамд хэн хэлсэн юм, тэнэг хог! Бид зүгээр л тэгж тоглоом хийсэн. Түүнийхээ эрүүл энхийн төлөө уу гэж Кадруссын аягыг дүүргэж - Бидэнд бүү саад болооч гэж хэлэв. Кадрусс дарс шимэх зуураа:
- Тэгье, тэгье. Дантесын эрүүл мэндийн төлөө ууя! Түүний эрүүл мэндийн төлөө ууя! Түүний эрүүл мэндийн төлөө!...За энэ гэж хэлэв.
- Харин... Ямар арга?... Ямар арга байна? гэж Фернан давтан асуув.
- Та арга олоогүй байна уу?
- Үгүй, та олно гэсэн шүү дээ.
- Нээрээ тийм. Франц хүмүүс испаничуудаас нэг давуу талтай байдаг. Испаничууд эрэгцүүлэн боддог, францчууд бодож олдог юм гэж Данглар хэлэв.
- За тэгээд бодож олооч дээ! гэж Фернан тэсэж ядан хашхирав.

- Хүүе! Үзэг, бэх, цаас! гэж Данглар хашхирав.
- Үзэг, бэх, цаас ий? Гэж Фернан бувтнахад,
- Тийм ээ, Би нягтлан бодох хүн болохоор үзэг, цаас, бэх бол миний зэвсэг, эдгээргүйгээр би юу ч хийж чадахгүй гэв.
- Үзэг, бэх,цаас аваад ир! гэж Фернан бас хашхирав.
- Тэр ширээн дээр бий Жэж мухлагийн зарц, гараараа заав.
- Аль вэ нааш нь өгөөдөх

Зарц үзэг, бэх,цаас авчирч тэдэнд өгөв. Кадрусс гараараа цаасан дээр цохиж,

- Энэ чинь л ёстой модон дотор отож сууснаас илүүгээр хүнийг ална даа. Би буу сэлмээс илүүгээр үзэг, бэх, цааснаас айж явдаг минь дэмий хэрэг биш гэж хэлэв.
- Энэ мал санасанчлан их согтоогүй байна. Фернан чи аяганд нь архи хийгээд өгөөч гэж Данглар хэлэв.

Фернан Кадруссын аягыг дүүргэхэд цаадах нь ёстой согтуу хүний ёсоор цаасан дээрээс гараа авч аяга уруу сарвайв.

Кадрусс аягатайг дугтарч орхиод аягаа ширээн дээр тавихыг нь, чухамдаа унагачихы нь Фернан хүлээж байв. Тэгээд Кадрусст үлдсэн өчүүхэн ухаан энэ аяганд шингэн орсныг хараад:

- За тэгээд? Гэж каталан залуу асуув.
- Тэгэхээр Дантесыг Неополь ба Эльба арлаар ороод ирсэн энэ аяллын дараа түүнийг Бонапартын төлөөлөгч гэж вангийн прокурорт хов хүргэвэл ямар вэ гэж Данглар үргэлжлүүлэн хэлэхэд,
- Би хов хүргэе! гэж каталан хүү угтан авав.
- Болно оо, та тэр бичигт гарын үсэг зурах болно. Тэгэхээр таныг түүнтэй нүүр учруулна. Би түүнийг шийтгүүлэх бүх материалаар хангаж өгнө. Гэвч Дантес үүрд шоронд суухгүй шүү дээ. Хэзээ нэгэн цагт гараад ирнэ, тэгэхээр түүнийг шоронд хийлгэсэн хүнд гай болно доо!
- Тэр надтай маргалдвал л хэрэгтэй байна.

- Өө, Мерседес үү? Хайртай дуртай Эдмонд нь гар хүрлээ гэж Мерседес таныг үзэн ядна шүү дээ!
- Энэ ч бас үнэн шүү гэж Фернан хэлэв.
- Болохгүй нь дээ гэж Данглар үргэлжлүүлэн хэлээд - Нэгэнт ийм хэрэг хийе гэж байгаа болохоор зүгээр л үзгээ барьж бэхэнд дүрээд дараах агуулгатай бяцхан мэдээг бичгээ танигдахгүйн тул солгой гараараа биччихье гэв.

Тэгээд Данглар солгой гараараа ердийн бичгийн хэвээсээ шал ондоогоор ташуу бичиж Фернанд өгөв.

Түүнийг Фернан авч аман дотроо уншсан нь:

«Эзэн ширээ ба шашныг сүслэн дагагч би, Неаполь, Порто-Феррайо ороод өнөөдөр Смирнаас хүрэлцэн ирсэн «Фараон» гэдэг хөлөг онгоцны ахмадын туслах Эдмон Дантес, Мюратаас узурпаторт захидал аваачиж өгөөд узурпатороос Парист төвлөрөн байгаа Бонапартын хороонд явуулсан захидал авч явааг ангийн прокурор таны сонорт хүргэе.

Хэрвээ түүнийг баривчлан авбал хэргийн баримт болох тэрхүү захидал түүний биеэс эсвэл эцгийнхээс нь эсвэл «Фараон» онгоц дээрх түүний тасалгаанаас олдоно» гэв.

- За энэ л боллоо, ийм мэдээлэл эргээд танд хор хүргэхгүй, аяндаа бүх зүйлийг бүтээчихнэ. Харин зөвхөн захидлаа ингэж нугалаад «Вангийн эрхэм прокурорт» гэж хаяглаж орхивол гүйцэх нь тэр гэж Данглар хэлээд инээмсэглэн хаягий нь бичив.

Захидал уншихад Кадрусс сүүлчийнхээ үлдсэн өчүүхэн эрүүл ухааныг зарцуулан байж чагнаад, энэ нь ямар их муухай үр уршиг тарихыг аяндаа мэдрэв.

- Гүйцээ нь ч гүйцээ л дээ, тэгэхдээ энэ бол бузар хэрэг! гэж Кадрусс хашхирав.

Тэгээд захидлыг авах гэж гараа сарвайв. Тэгэхэд Данглар түүнээс захидлыг холдуулж,

- Би зөвхөн тоглоомоор ингэж ярьж, хийж байгаа юм. Хэрэв манай алдарт Дантест ямар нэгэн явдал тохиолдвол би хамгийн түрүүн гомдох болно. Хараач! гээд захидлыг хумхиад мухлагийн булан руу чулуудчихав.
- Энэ чинь зүйтэй хэрэг! гэж Кадрусс - Дантес бол миний найз, тэгэхээр би түүнд хор хүргэхэд дургүй байна гэв.

- За боль доо, хэн түүнийг хорлох гээвэ? Фернан бид хоёр л лав үгүй дэг гэж Данглар хэлээд босож буланд хаясан цаас руу хяламхийж харж суугаа каталан залуу өөд харав.
- Тэгвэл дахиад дарс аль! Би Эдмон, гоо үзэсгэлэнт Мерседес хоёрын төлөө ууна гэж Кадрусс хэлэв.
- Хар архичин минь чи зөндөө их уулаа шүү дээ. Одоо нэмж увал хөл дээрээ ч зогсож чадахгүй болж эндээхонох хэрэг болно гэж Данглар хэлэв.

Тэгэхэд Кадрусс хөлчүү хүний бардам зангаар,

- Би юу? Би хөл дээрээ зогсож чадахгүй гэнэ ээ? Аккульский сүмийн хонх өөд гуйвах ч үгүй гаръя гэж мөрий тавья л даа! гэхэд Данглар үгий нь тасалж,
- За тэлье. Маргааш мөрий тавья. Харин өнөөдөр гэртээ харъя. Алив гараа аль, явъя гэж хариулав.
- Явъя, харин тэгэхдээ чиний гар надад хэрэггүй. Аа Фернан чи явах уу? Бидэнтэй хамт Марсель орохгүй юу? гэж Кадрусс хариу хэлэв.
- Үгүй, би каталан руу гэртээ харина гэж Фернан хэлэв.
- Дэмий, бидэнтэй хамт Марсель оръё, явъя.
- Надад Марсель орох хэрэг алга, би тийшээ явахгүй.
- Юу гэнэ ээ? Явахгүй гэнэ ээ? За яах вэ, өөрөө л мэд. Дураараа л бол... явъя Данглар энэ эрхэм Каталан орох дуртай юм бол тийшээгээ яваг.

Данглар Кадруссыг найрсаг занг ашиглаж түүнийг марселийн замаар дагуулан явав. Гэвч, Фернанд дөт тохиромжтой зам үлдээхийн тулд Рив-Невийн эргээр явсангүй, Сен Викторын хаалга чиглэн явав. Кадрусс түүнийг дагаж, гараас нь зүүгдэн гуйвж ганхан явна. Данглар хориод алхам хиртэй яваад эргэж харвал Фернан хумхиж хаясан бичгийг шүүрэн авч, хот уруу гүйх нь харагдав.

- Тэр юу хийж байна? гэж Кадрусс асуугаад - Каталан руу явна гэж худлаа хэлчихээд хот уруу явж байгаагий нь. Эй, Фернан! Найз минь чи буруу тийшээ явчихлаа! гэж хэлэхэд Данглар үгий нь тасалж:
- Чиний нүд чинь эрээлжлээд тэгж харагдаж байгаа юм. Тэр хуучин эмнэлэг өөд шууд явж байна шү дээ гэж хэлэв.

- Нээрэн үү? Гэж Кадрусс асуугаад - Би түүнийг баруун тийшээ эргээд явчихлаа гэж хэлмээр байна. Гэвч дарс бол хортон гэж ярилцдаг нь үнэн юм даа гэв.

Одоо ч ажил хэрэг санасанчлан аяндаа бүтэж орхино доо гэж Данглар аман дотроо шивгэнэн хэлэв.

2. Гэрлэх ёслол

Маргааш өглөө нь тэнгэр цэлмэг дулаахан байлаа. Хурц наран мандаж улбар туяа нь далайн долгионоо солонгорон харагдана.

Найр хийх газар нь бидний мэдэх болсон өнөөх «Нөөц»-ийн хоёрдугаар давхарт байлаа. Энэ бол зургаан цонхтой том танхим бөгөөд цонх бүрий нь дээр (Яагаад тэгснийг нь бурхан л мэдэх байх) Францын нэгэн том хотын нэр бичээстэй байв.

Энэ цонхнуудын дагуу мөн л байшин шигээ модон ханатай гудам бий ажээ.

Үд дунд найр хийхээр бэлтгэсэн боловч, тэвчээргүй зочид бүр арван цагт ирчихээд сэлгүүцэн байв. Тэнд «Фараон» хөлөг онгоцны далайчид ба Дантесын найз хэдэн цэрэг байв. Тэд цөмөөрөө хуримаа хийх гэж байгаа хоёр залууг хүндэтгэн гоёлынхоо хувцсаа өмсжээ.

Найран дээр «Фараон» онгоцны эзэд өөрснөө ирнэ гэдэг цуу үг зочид гийчдийн дотор дэлгэрэв. Гэвч энэ нь Дантест арай л ахдах хүндэтгэл мэт байсан тул хэн ч түүнд итгэж зүрхэлсэнгүй.

Гэтэл Данглар Кадрустай хамт ирж энэхүү мэдээ үнэн болохыг батлав. Өглөө нь Дангларыг эрхэм Моррельтой уулзахад, Моррель үдийнхээ хоолыг «Нөөц»-өд иднэ гэж түүнд хэлсэн ажээ.

Үнэхээр ч хэдэн минутын дараа Моррель тасалгаанд орж ирэв. Далайчид түүнд найр тавьж, баяр хүргэж алга ташив. Хөлгийн эзэн хүрэлцэн ирсэн явдал нь Дантес ахмадаар томилогдох гэнэ ээ гэдэг цуу үгийн баталгаа болов. Тэд Дантест их л хайртай байдаг учир хөлгийн эзэн ганц удаа ч болов өөрсдий нь хүсэлтэй нийцсэн хүн сонгож олсон явдалд талархлаа илэрхийлжээ. Эрхэм Моррелийг дөнгөж орж ирмэгц бүгдийн шаардлагаар Данглар Кадрусс хоёрыг болзоот хоёр залуу дээр очиж олы баяр хөөрийг хөдөлгөсөн хөлгийн эзэн хүрэлцэн ирснийг мэдэгдэж, тэднийг шалавхан ирээч гэж хэлүүлэв.

Данглар Кадрусс хоёр га^оч гүйсэн боловч зуун алхам яваагүй байтал нь болзоот хоёр залуу өөдөөс нь гарч ирэв.

Эдмон болзоот хүүхнээ сугадаж, Мерседесийн найз дөрвөн каталан хүүхэн дагаж явав. Мерседесийн хажууд өвгөн Дантес дагаж явах бөгөөд хойноос нь Фернан дагаж, хорсолтойгоор мушилзан явна.

Мерседес, Эдмон хоёрын хэн нь ч энэ инээмсэглэлийг ажигласангүй. Тэр хоёр тэтгэж тусалсан мэт санагдах цэлмэг тэнгэр ба өөрсдөөсөө өөр юу ч харахгүй тийм жаргалтай сайхан явж байв.

Данглас Кадрусс хоёр өөрсдөдөө ногдсон үүргийг гүйцэтгээд, тэдэнтэй найзархагаар гар барьж, тус тусын байрыг эзлэн Данглар Фернантай, Кадрусс бүх олны анхаарлын төв болсон өвгөн Дантестай зэрэгцэн алхав.

Өвгөн, ган товчтой торгон дээл өмсөж, туранхай боловч, шөрмөслөг хөлдөө английн хил зөрчин наймаалагчид авчирдаг гоёмсог цоохор хээтэй цаасан оймс өмсжээ. Гурвалжин бүрх малгай дээр нь цэнхэр, цагаан бүч санжигнана. Өвгөн махир бариултай таяг барьсан нь Люксембург ба Тюильрийн ордны дахин нээгдсэн цэцэрлэг дотуур сэлгүүцэн явдаг байсан 1796 оны үеийн гангацуулаас юугаараа ч ялгагдахгүй байв.

Кадрусс өвгөнтэй зэрэгцэн явна. Сайхан хоол идэх завшаан олдсон нь түүнийг Дантестай бүрэн эвлэрүүлжээ гэдгийг бид дээр хэлсэн билээ. Өчигдрийн болсон явдал нь түүний санаанд зүүдэлсэн зүүд мэт бүүр түүр орно.

Данглар Фернанд дөхөж очоод, бүтэ«гүй дурлалаасаа болж гунихарч гомдсон залууг ширтэн харав. Эдмоноосоо өөр юу ч харахгүй яваа Мерседест мартагдаж орхигдсон Фернан ирээдүйн гэргий нөхөр хоёрын хойноос дагаж, заримдаа царай нь зэвхийрч, заримдаа улайж явна. Тэрээр Марселийн зүг байн байн харж харах бүрдээ өөрийн эрхгүй чичрэн дагжина. Үүний нь харвал Фернан ямар нэг чухал хэрэг явдал болохыг хүлээсэн буюу үгүй дээ л тийм хэрэг явдал болох байх гэж тааварлаж байсан мэт байлаа.

Дантес өөрийн байдлаараа хувцаслажээ. Худалдааны хөлөг онгоцонд алба хаадаг болохоор цэргийн ба энгийн хольсон хувцас өмссөн бөгөөд аз жаргалаар гэрэлтсэн тавиун царай нь тун ч үзэсгэлэнтэй сайхан байв.

Мерседес нь кипр ба хиосын грег охин шиг хар нүдтэй, улаахан уруултай гоо цэвэрхэн бөгөөд арлезиан, андалуз хүүхнүүд шиг тайван чөлөөтэй алхална. Хот газрын охин бол баяр хөөрөө нүүрний гивлүүр ч юм уу үгүй ядахдаа сормуусаа буулган нуухыг оролдож болох байсан атал Мерседес тойрон байгаа бүхэн өөд харж инээмсэглэх бөгөөд түүний инээмсэглэл, харц нь «Хэрвээ та нар миний найз нөхөд мөн юм бол жаргалыг минь хуваалцаж, надтай хамт баярлацгаа» гэж хэлэх мэт тодорхой байв.

Болзоот хоёр тэднийг дагалдагсад «Нөөц»-өд хүрэлцэн ирэхэд усан цэрэг ба цэргүүдээр хүрээлэгдсэн Моррель угтан очиж талийгаач болсон Леклерийн

оронд ахмад болгоно гэж Дантест хэлсэн үгээ тэдэнд давтан хэлэв. Дантес түүнийг хармагц Мерседесийн гарыг тавьж эрхэ- Моррельд байраа тавьж өгөв. Хөгийн эзэн Дантесын болзоот хүүхэн хоёр бусдыг үлгэрлэн ширээ зассан өрөө өөд шатаар өгсөхөд модон шат бүтэн таван минут хэртэй зочдын хөл доор нажигнан хяхнав.

Мерседес ширээний төв дунд очиж зогсоод:

- Эцэг минь, миний баруун гар талд суухыг хүсье, зүүн гар талдаа ахын минь оронд ах болсон хүнээ суулгая гэв. Энэ үгийг эелдэг зөөлөн дуугаар хэлсэн боловч Фернаны зүрхэнд хутга шаах шиг болж уруул нь зэвхийрэн борлосон арьсан доорх бүх цус нь зүрхэндээ хуралдаж царай нь цайв.
- Дантес баруун гартаа Моррелийг, зүүн гар талдаа Дангларыг суулгаад, дараа нь бусад хүмүүсийг дуртай газартаа суухыг урьж гараар дохив.

Хүмүүсийг бараг сууж амжаагүй байхад шахам гялалзсан тавиур дээр тавьсан арьлийн сайхан үнэртэй улаан хиам, улбар ягаан хавч, туулайн бөөрийг санагдуулам өргөстэй тэнгисийн зараа, умар зүгийн амтат хавчны оронд дажгүй хэрэглэж болох кловисс, ер нь сайн сэтгэлт загасчид «тэнгисийн үр шим» гэж нэрлэдэг долгион давалгаагаар элст эрэг дээр гарч ирдэг амттан шимттэн цөм бүрнээ ширээ дүүрч байв.

Өвгөн Дантес, эзэн өөрөө Мерседесийн өмнө авчирч тавьсан молор эрдэнэ шиг тунгалаг шар дарсыг балгаж:

- Ямар чимээ аниргүй юм бэ, шуугилдан наргих гэж байгаа гучин хүн байна гэж хэн ч хэлмээргүй байна аа? гэв.
- Эхнэр авч хуримаа хийж Үайгаа хүн бүр хөгжилтэй байдаггүй гэж Кадрусс хэлэв. Тэгэхэд Эдмон түүний үгийг угтан авч:
- Тийм ээ, би баяр хөөрөө гаргаж чадахгүйгээр тийм их жаргалтай байна. Хэрвээ хөрш минь үүнийг хэлж байгаа бол таны ёстой зөв өө. Баяр хөөр бол заримдаа хачин нөлөө үзүүлж, уйтгар гуниг шиг хүнийг дарчихдаг юм гэв.

Сэтгэлийн нь хөдөлгөөн бүр нүүрэнд нь илрэн гарч суугаа Фернан өөд Данглар зэрвэсхийн харав.

- Болиоч дээ! Эсвэл та ямар нэг юмнаас айгаад байна уу? Харин ч таны хүссэн бүхэн биелэгдэж байх шиг санагдаж байна шүү гэв.
- Чухамхүү энэ л намайг айлгаад байна гэж Дантес хариулаад - Хүн ийм амар хялбархнаар аз жаргал олчихын тулд төрдөггүй гэж санагдах юм.

Аз жаргал бол үүдий нь догшин луу манаж байдаг үлгэрийн ордонтой адил юм. Үүнийг эзэмшин авахын тулд тэмцэх хэрэгтэй. Гэтэл би үнэндээ Мерседесийн нөхөр болох ямар гавьяатайгаа мэдэхгүй байна гэв.

- Нөхөр ий!... гээд Кадрусс инээд алдаж - Болоогүй шүү, ахмад та нөхөр болоод үз л дээ, яаж хүлээж авахы нь үзье! гэв.

Мерседесийн царай улайв.

Фернан сандал дээрээ хавчигнаж, өчүүхэн чимээ гарах бүрд цочин мөндөрт борооны түрүүчийн дусал мэт дух уруу нь урсах хөлсөө байн байн арчина.

- Ийм ялихгүй юмны төлөө маргаад яах вэ, хөрш минь гэж Эдмон Кадруст хэлээд - Мерседес одоохондоо миний эхнэр болчихоогүй байна, энэ үнэн, тэгэхдээ л... гээд цагаа харж - Цаг хагасын дараа болно доо! гэв.

Бөх хэвээрээ байгаа шүдээ гарган нүүр дүүрэн инээж суугаа өвгөн Дантесаас бусад бүх хүн гайхан дуу алдав. Харин Мерседес царай нь улайсангүй инСэмсэглэв. Фернан хутганыхаа ишнээс аяндаа шүүрч авав.

Данглар мөн л царай нь зэвхийрч,

- Цаг хагасын дараа гэнэ ээ! Яагаад тэр вэ? гэж хэлэв.
- Тийм ээ, найз нар минь гэж Дантес хариулаад - Энэ ертөнц дээр эцгийнхээ дараад оруулж ачий нь санаж явах эрхэм Моррелийн ачаар бүх саад тотгор арилж, зарлан тунхаглахгүйгээр болгож бүтээхээр мөнгө оруулсан. Одоо хоёр цаг хагасад Марсель хотын дарга биднийг албаныхаа өрөөнд хүлээн авна. Тэгэхээр одоо нэг цаг арван таван минут цохиж байгаа болохоор, цаг хагасын дараа Мерседес, хатагтай Дантес гэж нэрлэгдэх болно гэж хэлбэл би төдий л их буруудахгүй байх гэв.

Фернан зовхий нь галаар төөнөх мэт болж нүдээ анив. Тэгээд тэр ойчихгүйн тулд ширээ тохойлдож хэдийвээр биеэ барьж байсан боловч тэсэхгүй гиншихэд энэ нь зочдын шуугиан инээдэмд замхран дуулдсангүй.

- Ёстой л амжуулж байна даа! Цаг алдахгүй байх гэдэг чинь энэ дээ! Өчигдөр өглөө ирээд, өнөөдөр гурван цагт эхнэртэй болчихлоо! Далайчид л ингэж амжуулдаг юм! гэж өвгөн Дантес хэлэв.
- Гэвч янз бүрийн гүйцэтгэх ёс, гэрээ бичиг, яасан бэ? гэж Данглар төдий л эрс биш асуув.

- Гэрээ бичиг гэнэ ээ? Гээд Дантес инээн - Тэр ч бэлэн. Мерседест юу ч байхгүй, надад бас юу ч байхгүй! Бид хоёрт чиний миний гэх хувь хөрөнгө байхгүй... Үүнийг бичихэд удахгүй, тэгээд баг хямдхан гэж хэлэв.

Энэ үгэнд хүмүүс дахин инээлдэж алга ташив.

- Тэгвэл бид чинг гэрлэх ёслол дээр байгаа биш, зүгээр л хурим дээр байгаа юм шив дээ гэж Данглар хэлэхэд Эдмон татгалзаж:
- Үгүй, та нар ямар ч юмаар хохирохгүй, тайван байцгаа. Би маргааш өглөө Парис явна. Тийшээ дөрөв хоног наашаа дөрөв хоног, даалгасан үүргийг биелүүлэхэд нэг хоног ингээд би гуравдугаар сарын есөнд буцаж ирнэ, тэгээд арванд ёстой хурим найр болно гэж хэлэв.

Дахин найр болно гэдэг үг бүхний сэтгэлийг хөгжөөв. Анхандаа чимээ аниргүй байна гэж гомдол гаргаж байсан өвгөн Дантес олны шуугиан дотор ирээдүйн эхнэр, нөхөр хоёрын төлөө хундага өргөх гэж дэмий оролдоно.

Дантес эцгийнхээ санааг мэдэж өөдөөс нь хайр энхрийллээр дүүрэн харцаар харна. Мерседес ханын цаг уруу хараад, Эдмон руу толгой дохив.

Тэр үед жирийн хүмүүсийн хоолны үеэр гарч ирдэг эрээ цээргүй яриа шуугиан болж байв. Суудлаа голсон зарим нэг нь өөр тааламжтай хүн дээр очиж сууна. Хүн бүр ам амандаа шуугилдан, хүний асуусанд хариулна ч гэж байхгүй өөр өөрийн бодолд автан завгүй байв.

Данглар Фернан шиг зэвхий царайлан байв. Фернан гал дөл дотор орчихсон нүгэлтэн шиг амьсгал нь давхацна. Тэр хамгийн түрүүнд босож, хүмүүсийн яриа хөөрөө ба аяга тавагны чимээн дунд ямар нэг юм чих тавин чагнаж танхим дундуур холхино.

Кадрусс Фернаны дэргэд очиход, Данглар тэр доороо тэдэн дээр очив. Фернан Данглараас зайлсхийгээд л байх шиг байжээ.

Дантесын гэнэтийн жаргалыг харааг атаархсан сэтгэл нь Эдмоны баяр цэнгэл, өвгөн Памфилын сайхан дарсанд бүрэн даагдсан Кадрусс,

- Үнэн юм үнэнээрээ, Дантес сайн хүн. Болзоот хүүхэнтэйгээ хамт сууж байхы нь хараад өчигдрийн та нарын хийх гэж байсан тэр муухай юмыг хийвэл муу хэрэг болох байсан гэж бодож байна гэв.
- Бид тэр бичгээ явуулаагүйг чи харсан шүү дээ гэж Данглар хэлээд - Хөөрхий Фернан анхандаа өрөвдмөөр гунигтай байсан. Гэвч өөрөө өөрийнхөө гунигтай эвлэрч, тэр байтугай өрсөлдөгчийгөө гэрлэлтийн ёс

гүйцэтгэхэд нь дагуул болохыг зөвшөөрсөн болохоор өөр ярих юмгүй болсон шүү дээ гэв.

Кадрусс Фернаныг харахад цаадах нь үхээрийн цонхигор царайтай болчихсон байв.

- Ийм сайхан охиныг алдана гэдэг чинь үнэндээ их гарз шүү. Чөтгөр ав! Миний ирээдүйн ахмад азтай хүн юм! Би ганц өдөр ч болов Дантес болох юмсан гэж Данглар үргэлжлүүлэн ярив.
- Явах уу? гэж Мерседесийн эелдэг дуу гарч - Одоо хоёр цаг боллоо. Биднийг хоёр цаг арван таван минутанд хүлээн авна гэсэн шүү дээ гэж хэлэв.

Дантес түргэн босох зуураа,

- Тийм, тийм явъя гэж хэлэхэд,
- Явцгаая гэж зочид нэг зэрэг дуугарав.

Тэр минутад цонхон дээр сууж байсан Фернаныг алдалгүй ажиглаж байсан Данглар, түүнийг нүд нь орой дээрээ гарав уу гэлтэй болсноо цонхон дээрээс үсрэн буугад дахин буцаж суухыг харав. Гадна үл ойлгогдох чимээ гарч, хүнд хөлийн чимээ ойлгомжгүй яриа, зэүсэг хавиралдах нь сонстон зочдын хөгжилтэй яриаг таслан, хүмүүс сэтгэл түгшин дуугүй зогсоцгоов.

Дуу чимээ ойртон, хаалга гурван удаа цохиход зочид бие бие өөдөө гайхан харав.

- Хуулийн өмнөөс! гэж чанга дуу гарахад хэн ч хариу дуугарсангүй.

Тэр дороо үүд нээгдэж, өргөн ноосон бүс бүсэлсэн цагдаагийн комиссар дөрвөн цэрэг нэг бага дарга дагуулж орж ирэв.

Сэтгэл түгшин байсан хүмүүс айн сандарцгаана.

Хөлгийн эзэн, таних комиссар өөдөө очоод,

- Юу болов? Лав андуурсан байх аа гэж хэлэв.
- Эрхэм Моррель, хэрвээ андуурсан байвал учир нь даруй олдоно гэж комиссар хэлээд - Харин одоо надад баривчлах тухай тушаал өгсөн болохоор, би харамсаж байгаа боловч энэ үүргээ гүйцэтгэх ёстой. Та нарын хэн чинь Эдмон Дантес гэдэг вэ, эрхмүүд ээ? Гэж асуув.

Хүмүүс цөмөөрөө Эдмон өөд харахад сэтгэл нь ихэд хөдөлсөн Дантес толгой дээгүүр урагшаа гараад:

- Би байна. Танд юу хэрэгтэй вэ? гэж асуув.
- Эдмон Дантес, таныг би хуулийн нэрийн өмнөөс баривчилж байна! гэж комиссар хэлэхэд Дантесын царай бага зэрэг зэвхийрч,
- Баривчлах ий? Яалаа гэж намайг баривчилж байгаа юм бэ? Гэж өөдөөс нь асуув.
- Мэдэхгүй, гэвч эхний байцаалт дээр та бүгдийг мэдэж болно.

Яах ч аргагүй гэдгийг Моррель ойлгов. Өргөн ноосон бүс бүсэлсэн комиссар бол хүн биш, дуу аниргүй, хуулийн биелэл болсон дүлий хүйтэн хөшөө юм.

Харин өвгөн Дантес комиссар өөд үсрэн очив. Эцэг эхийн зүрх ойлгон мэдэж чаддаггүй зүйлүүд байдаг юм. Тэр гуйж мөргөв. Нус нулимсаа гоожуулан гуйсан боловч нэмэр болсонгүй. Гэвч энэ гаслан гунигийг комиссар ч хүртэл мэдрэхээр тийм их байлаа.

- Эрхэм та тайвшир! Таны хүү хорио гаалийн ямар нэг зааврыг биелүүлээгүй байж болох юм, хэрэгтэй юмы нь тайлбарлан хэлж өгчихөөд л дороо суллагдаад ирнэ гэв.

Кадрусс хөмсгөө зангидан, гайхсан дүр үзүүлэн зогсож байгаа Данглараас:

- Юу болж байгаа нь энэ вэ? гэж асуув.

Тэгэхэд Данглар,

- Би яаж мэдэх юм бэ гэж хариулаад -Би бас чамтай адилхан юу болж байгааг нь хараад гайхаж зогсоно гэв.

Кадрусс Фернаныг нүдээрээ эрсэн боловч цаадах нь алга болчихсон байв.

Тэгэхэд өчигдрийн болсон явдал түүнд аймшигтай тодорхой харагдаж, болж байгаа эмгэнэлт явдал сэтгэл мэдрэлий нь бүрхэж байсан өчигдрийн согтуурлын бүрхэвчий нь хуу татан авч хаях шиг болов.

- Энэ чинь өчигдөр та хоёрын ярьж байсан зүйлийн үр уршиг биш биз? Тэр сөөнгө дуугаар хэлээд - Тэгвэл энэ явдлыг санаачилсан хүмүүст гаслан болно доо. Үүнд ямар ч шохоорхмоор юм алга гэв.

- За, үгүй дээ! Намайг тэр бичгийг ураад хаячихыг чи өөрөө үзсэн шүү дээ гэж Данглар хэлэхэд, Кадрусс,
- Чи түүнийг ураагүй, зөвхөн булан руу хаячихсан, тэгээд л гүйцсэн шүү дээ гэж хэлэв.
- Дуугүй бай, чи юу ч хараагүй, согтуу байсан.
- Фернан хаана байна? гэж Кадрусс асуухад,
- Би яаж мэдэх юм? Өөрт нь хэрэг болоод л явчихсан байлгүй. За яршиг, дэмий юмаар яах вэ, золгүй өвгөн дээр очиж тусалъя гэж Данглар хариулав.

Дантес энэ завсар найз нөхөдтэйгээ инээмсэглэн гар барьж амжаад, цэргүүд дээр оччихсон байв.

- Тайван байцгаа, учир нь олдоно, би шоронд ч орохгүй байх гэж хэлэв.
Тэгэхэд түүн өөд дөхөж ирж явсан Данглар үгий нь тос ч аваад,
- Тэгэлгүй яах вэ, тэгнэ гэдгийг би батлахад ч бэлэн байна? гэж хэлэв.

Дантес шатаар буухад өмнө нь комиссар, хоёр талд нь цэргүүд явав. Хаалга онгойлгосон сүйх тэрэг босгоны дэргэд хүлээж байв. Дантес сүйх тэргэнд ороход араас нь комиссар ба хоёр цэрэг суув. Хаалга хаагдаж сүйх Марселийг чиглэн давхив.

- Баяртай Дантес! Баяртай, Эдмон! гэж Мерседес үүд уруу гүйн хашхирав.

Баригдсан залуу, болзоот хүүхний шаналсан зүрхнээс гарсан энэ цорхирон уйлах мэт сүүлчийн дууг сонсоод сүйх тэрэгний цонхоор шагайж: «Баяртай Мерседес» гэж хашхираад гэгээн Николай цайзны булан тойрч алга болов.

-Та нар намайг эндээ хүлээж байгаарай. Би хамгийн түрүүнд дайралдсан тэргэнд сууж Марсель ороод, мэдээ авч ирье гэж хөлгийн эзэн хэлэхэд цөм нэг дуугаар,

- Яв, яв бушуухан яваад бушуухан эргэж ир! гэж хашхирцгаав.

Хоёр дахь хүнийг явсны дараа цугларсан олон хэдэн минут гунихран чимээгүй байцгаав.

Эдмоны аав Мерседес хоёр тус тусдаа гашуудалд автагдан байснаа сүүлд нь бие биенийгээ харж, адилхан нэг цохилтод нэрвэгдсэн хоёр болохоо мэдэрч өөд өөдөөсөө гүйж тэврэлдэв.

Энэ үед Фернан танхимд орж ирээд аяга ус хийж уугаад сандал дээр суув.

Хажуугий нь сандал дээр Мерседес санамсаргүй суув Тэгэхэд Фернан өөрийн эрхгүй аундаа сандлаа түүнээс холдуулав.

Тэр үү! гэж каталан залуугаас нүд салгалгүй ширтэж байсан Кадрусс Дангларт хэлэв. Тэгэхэд Данглар,

- Үгүй байх. Тэгж чадахааргүй тэнэг амьтан. Гэвч тийм юм хийсэн хүнд нүгэл болог гэж Данглар хариу хэлэв.

- Чи түүнд зөвлөгөө өгөөд байсан хүнийг мартчихаа шив гэж Кадрусс хэлэхэд Данглар,

- Үгүй ер! Зүгээр л дэмий ярьж байсны төлөө хариуцах хэрэг болох нь ээ! гэж хариулав.

- Хариуцах л ёстой тэр дэмий ярьсан юм чинь хэзээ нэгэн цагт хүний толгой дээр ойчно доо!

Түүний зэрэгцээгээр зочид Дантесын баривчлагдсан тухай дур дураараа тайлбарлан ярьж байв.

- Ингээд Данглар та энэ тухай юу гэж бодож байна? гэж нэгэн хүн асуув.

- Би түүнийг ямар нэгэн хориотой бараа авчирчхаагүй байгаа даа гэж бодож байна гэж Данглар хариу хэлэв.

-Гэхдээ Данглар та нягтлан бодохын хувьд энэ тухай заавал мэдэх ёстой шүү дээ.

-Тийм ээ, тэгэлгүй яах вэ, гэвч нягтлан бодох хүн зөвхөн өөрт нь мэдэгдсэн юмыг л мэдэж суудаг юм шүү дээ. Бид хөвөн цаас авчирсан гэдгийг мэдэж байна. Бид Александрийд Пастреас, Смирнад Паскаляас ачаа авсан. Үүнээс өөр мэдэх юм алга.

- Өө! Одоо би саналаа гэж горьдлого тасраагүй байсан золгүй өвгөн шивгэнээд - Өчигдөр надад хайрцаг кофе цай, авдар тамхи авчирсан гэж ярьж байсан шүү гэв.

- Харж байна уу? Тийм л байх ёстой! Биднийг эзгүй хоорондуур гаалийнхан и°ж «Фараон»-ыг нэгжиж үзээд, хориултай бараа олж л дээ гэж Данглар хэлэв.

Мерседес үүнд итгэсэнгүй. Удаан тэсвэрлэн барьж байсан гаслан нь гадагшлан учир зүггүй цорхирон уйлав.

- Зүгээр, зүгээр, итгэж хүлээж сууя гэж өвгөн чухам юу ярьж байгаагаа ч мэдэхгүй хэлэв.
- Хүлээж сууя! гэж Данглар давтан хэлэв.

«Хүлээж сууя» гэж Фернан хэлэх гэсэн боловч хоолойн дээр нь тээглэхээд, зөвхөн уруул нь хоосон хөдлөв.

Моррелийн ирэхийг харуулдаж байсан нэгэн хүн,

- Эрхмүүд ээ! Эрхмүүд ээ, сүйх тэрэг! Моррель! Тэр лав сайхан мэдээ авчирч яваа байх! гэж хашхирав.

Мерседес, өвгөн эцэг хоёр, хөлгийн эзнийг угтан гүйв. Тэд үүдэн дээр дайралдахад Моррелын царай тун цонхигор байв.

- За юу гэнэ вэ? гэж тэр хоёр нэг зэрэг асуув.
- Найз нөхөд минь гээд хөлгийн эзэн толгойгоо сэгсэрч - Бидний бодсоноос үлэмж сүрхий хэрэг болжээ гэв.
- Ай, эрхэм Моррель! Түүнд ямарч буруу байхгүй! гэж Мерседес дуу алдав.

- Би бас үүнд итгэж байна гэхдээ түүнийг буруутгаж байна... гэж Моррелийн хариулахад,

- Юунд тэр вэ? гэж өвгөн Дантес асуув.
- Түүнийг Бонапартын төлөөлөгч гэж байна.

Миний өгүүлж байгаад холбогдох тэр үед амьдарч байсан уншигч бол энэ ямар аймшигтай ял байсныг мэднэ.

Мерседес орь дуу тавьж, өвгөн сандал дээр унан тусав.

- Та нар намайг хуурчихаж дээ, Данглар. Тэрхүү тоглоомоо хэрэгжүүлчихжээ. Гэвч би хөөрхий өвгөн, болзоот охин хоёр уй гаёуугаар үхээсэй гэж хүсэхгүй байна. Би одоохон тэдэнд бүгдий нь хэлнэ гэж Кадрусс хэлэв.

- Дуугүй бай, азгүй золиг! гэж Данглар хашхираад, гарыг нь шүүрэн авч - Хэрвээ чи аминдаа хайртай бол дуугүй бай. Дантес гэм буруугүй хүн гэж хэн чамд хэлсэн юм бэ? Хөлөг онгоц Эльба арлын дэргэд зогсож, Дантес эрэг дээр гарч Порто-Феррайод бүтэн өдөр байсан. Хэрвээ түүнээс эд мөрийн баримт болох ямар нэг захидал олдвол яана? Тэгвэл түүнийг хамгаалсан хүн бүрийг түүнтэй хоршоо хуйвалдагч гэж шийтгэнэ шүү дээ гэв.

Хувиа хичээхийн авъяасаар дутна гэж байхгүй Кадрусс энэ бүхний үнэнтэй болохыг ойлгож, Данглар өөд арга ядарсан байдлаар хараад, Урагш алхахын оронд хоёр алхам хойш ухрав.

- Хэрвээ тийм юм бол хүлээзнэе гэж аман дотроо шивгэнэв.

- Тийм ээ, хүлээзнэе. Хэрвээ гэм буруугүй бол түүнийг суллан тавина. Буруутай байх юм бол өөрсдийгөө хуйвалдагчдын төлөөнөө хэрэгт барьж өгөөд яах вэ гэж Данглар хэлэв.

- Тэгвэл явъя, би энд байж чадахгүй нь.

Тэгэхэд хамт гарах хань олсондоо баярласан Данглар,

- Тэгье, явсан нь дээр байх. Эд яана, дураараа болцгоог... гэв.

Хүмүүс цөм тархаж одов. Фернан бас л Мерседесийн ганц түшиг болж үлдээд, түүнийг сугадан Каталаны зүг явав. Дантесын нөхөд эцэж туйлдсан өвгөнийг Мельяны модот гудамжийн тэнд байдаг гэр өөд нь аваачив.

- Дантесыг бонапартын төлөөлөгч гэж баривчилсан тухай мэдээ тэр даруй хот даяар тархав.

- Моррель өөрийн нягтлан бодох, Кадрусс хоёрыг гүйцэж ирээд,

- Хэн тэгнэ гэж бодох вэ дээ, Данглар! Хэн тэгнэ гэж бодох билээ? Гэж хэлэв. Моррель хот орж, хааны прокурорын туслах эрхэмде Вильфортой танилын хувьд Дантесын тухай шинэ мэдээ олж сонсохоор яаран явж байжээ.

- Эрхэмсэг та юу гээ вэ? Дантес ямар ч шалтгаангүйгээр Эльба арлын дэргэд зогссон гэж би танд хэлсэн шүү дээ. Энэ зогсолт надад сэжиглэлтэй санагдсан юм гэж Данглар хэлэв.

- Та өөрийнхөө энэ сэжиглэлийн тухай надаас өөр хүнд ярьсан уу?

- Яаж болох билээ гэж Данглар намдуухан дуугаар хэлээд - Түүний дэргэд алба хааж байсан таны авга ах Поликар Моррелийг мэдэх учраас би танаас санасан бодсоноо нуудаггүй гэдгийг та мэднэ шүү дээ. Бас таныг Наполеоныг

өрөвдөн харамсдаг гэж сэжиглэцгээдэг... Би Эдмон та хоёрт хор болох бий гэж айлгүй яах вэ. Захирсан эзэндээ хэлээд өөр бусад хүнээс үхтлээ нуух зүйл байдаг юм шүү дээ гэж хэлэв.

- Зүйтэй Данглар, зүйтэй, та үнэнч хүн юм. Хөөрхий Дантес «Фараон»-ы ахмад болчихвол таныг юу гэж үзэх бол гэдэг тухай би аль түрүүн санаа тавьчихсан шүү.

- Яаж тэр вэ?

- Би Дантесаас таны тухай юу гэж бодож байгаа хуучин ажилд нь хэвээр байлгахыг зөвшөөрөх үү гэж асуусан. Яагаад ч юм бүү мэд, та хоёрын дунд хүйтэн харьцаатай юм шиг надад санагдсан.

- Тэгээд тэр танд юу гэж хариулав?

- Чухам ямар явдал болсноо надад хэлээгүй. Харин нэгэн цагт танд үнэхээр буруутсанаа хэлээд, хөлгийн эзний итгэсэн хүнд хэзээ ч итгэж явна гэж байна лээ.

- Хуурамч дүр үзүүлэгч! гэж Данглар шивгэнэү.

- Хөөрхий Дантес! Сайн хүн байсан сан! гэж Кадрусс хэлэв.

Тийм ээ, гэхдээ одоохондоо «Фараон» ахмадгүй болчихлоо гэж Моррель хэлэхэд,

Бид гурван сарын дараа аян замд гарах болохоор, тэр хооронд Эдмоныг суллагчид ч мэдэх юм гэж Данглар хэлэв.

- Тийм ээ, гэвч тэр хүртэл?

- Тэр хүртэл би танд зүтгэж болно гэж Данглар хариулаад - Би алсын аяллын ямарч ахмадаас дутахгүйгээр хөлөг онгоц жолоодож чадна гэдгийг та мэднэ шүү дээ. Тэгээд ч бас намайг авбал Эдмоныг шоронгоос гарч ирэхэд баяр хүргэх хүнтэй байх нь танд ашигтай. Тэгээд тэр өөрийн байрыг би өөрийн байрыг эзлээд л гүйцээ гэв.

- Танд баярлалаа Данглар. Үнэхээр зөв арга байна. Тэгэхээр командлалыг хүлээж ав, би танд онц эрх олгож байна. Зарим нэгэн хүнд ямарч азгүй явдал тохиолдлоо гээд ажил хэрэг хохирох ёсгүй. Ачаа буулгах явдлыг сайн харж байгаарай гэв.

- Эрхэм Моррель санаа бүү зов. Харин хөөрхий Эдмонтой уулзаж болох болов уу?

- Би одоо үүнийг мэдье. Эрхэм де Вильфортой уулзаж баригдсан хүний төлөө хэдэн үг хэлэхийг оролдъё. Тэр бол нэрд гарсан роялист хүн, гэхдээ роялист ч бай хааны прокурор ч бай хүн л юм хойно доо. Тэгээд бас тийм ч муу санаатай хүн биш дэгээ.

- Үгүй, муу санаатай хүн биш, гэвч нэр төрд дуртай хүн гэж би дуулсан, энэ чинь л бараг адилхан юм даа.
- За яах вэ, харан байж больё гэж Моррель санаа алдаж хэлээд - Онгоцон дээр очиж бай, би удахгүй ирнэ гээд тэр шүүхийн байшин өөд явлаа.
- Ажил хэрэг ямраар эргэж байгааг харж байна уу? гэж Данлар Кадруст хэлээд - Чи бас л Дантесыг өмөөрөх санаатай хэвээрээ байна уу? гэж асуув.
- Үгүй, үгүй гэсэн ч тийм тоглоом ийм уршигт хүргэнэ гэдэг аймшигтай байна.
- Хэн тоглоом хийсэн гэж? Чи биш, би биш, харин Фернан л байна. Чи намайг тэр зурвасыг хаячихсан гэдгийг мэднэ шүү дээ. Тэрч байтугай ураад хаячихсан шиг санагдаж байна.
- Үгүй! үгүй! Мухлагийн буланд хумхиад хаячихсаны нь би одоо харж байна. Зурвасыг тэр буландаа л байгаад байгаасай гэж хүсэж байна!
- Одоо яая гэх вэ? Фернан түүнийг аваад хуулж бичсэн буюу эсвэл хуулж бичүүлээд, эсвэл ингэж ажил болголгүйгээр ашиглачихсан байж мэднэ... Бурхан минь! Миний бичсэнийг явуулчихсан байвал яана! Бичгийн хэвийг өөрчилж бичсэн минь сайн болж.
- Тэгээд, чи Дантесыг хуйвалдагч гэж мэдэж байсан уу?
- Би юу ч мэдээгүй. Зүгээр л тоглоом хийж байсан юм гэдгээ хэлсэн шүү дээ. гэтэл тоглоом хийж байгаад үнэн юм хэлчихэж:
- Тэглээ яалаа ч энэ бүх явдал болохгүй байх буюу үгүй дээ л би энэ хэрэгт оролцохгүй байхын тулд юу ч хайрлахгүй сан. Энэ хэрэг бидэнд золгүй явдлаар төгсөхийг чи үзнэ дээ, Данглар.
- Хэрвээ энэ хэрэг хэн нэг хүнд муу явдал авчрах юм бол хийсэн жинхэнэ буруутанд нь авчирна биз. Тэр буруутан нь Фернан болохоос, бид биш шүү дээ. Бидэнд ямар золгүй явдал тохиолдох гэж? Бид зөвхөн тайван сууж, нэг ч үг дуугаралгүй байх хэрэгтэй, тэгвэл аянга цахилгаа хажуугаар өнгөрөн гарах болно.

- Тэгэх л болтугай гэж Кадрусс хэлээд Данглар өөд толгой дохиж, Мальяны таримал модот гудамжийг чиглэн юманд ихэд санааширсан хүнд байдаг шигээр толгойгоо санжигнуулан хамар дороо юм бувтнан явав.

«За ингээд хэрэг явдал миний бодсоноор болдог байж. Би түр зуур боловч ингээд ахмад болчихлоо. Харин энэ муу тэнэг Кадрусс элдвийн юм ярихгүй дуугүй байгаад байж чадвал үүрд ахмад байх болно. Харин үнэнч шударгын шүүх Дантесыг өөрийн савраас тавьчихвал... Гэвч үнэн шударгын шүүх бол үнэн шударгын шүүх дээ. би түүнд бүрэн найдаж болно» гэж Данглар инээмсэглэн бодож явав.

Тэгээд завинд үсрэн сууж, хөлгийн эзэн уулзахаар болзсон «Фараон» онгоц өөд явахыг тушаав.

2. Вангийн прокурорын туслах

Мөн тэр өдөр, тэр цагт Медуз оргилолт булгийн өөдөөс харсан Гран Кур гудамжинд уран барилгач Пюжегийн барьсан нэгэн язгууртны байшинд бас л гэрлэх ёслол хийж байв.

Гэвч энэ баяр ёслолд оролцогчид бол жирийн хүмүүс, усан цэргүүд биш, харин марселийн дээд язгууртны хүрээлэнгийн хүмүүс байлаа. Эд бол засгийн эрхийг хууль бусаар булаагчийн үед халагдсан хуучин хэргэм зэрэгтэн, францын армиас Кондегийн армид урваж ирсэн цэргийн хүмүүс, бас залуучууд байв. Хэдийгээр хүүхдүүдийнхээ оронд дөрөв, таван хүнийг цэрэгт хөлслөн явуулсан боловч бас л тэднийгээ цэрэгт татчихаж магадгүй гэж айсаар байгаа тэдний эцэг эх хүүхдүүдээ, таван жил цөллөгт явуулж зовлонт амьтан болгоод, дахин сэргэн тогтсоны арван таван жилийн дотор бурхан болгож хувиргах ёстой тэр нэгэн хүнийг үзэн ядах үзлээр хүмүүжиж байв.

Францын өмнөд хэсэгт таван зуун жилийн туршид улс төрийн дайсагнал шашны дайсагнал болон, гүнзгийрч байсан учир, энэ баярт оролцож байгаа хүмүүсийн яриа нь тэр үедээ л хамгийн их хэмжээгээр тачаадсан байдалтай байв.

Зуун хорин сая албат харьяат нар нь арваад хэл дээр түүнд: «Наполеон мандтугай» гэж хашхирч байсан үе өнгөрч, бүхэл бүтэн эх газрыг захирч байсан эзэн хаан, тав зургаан мянган хүнтэй Эльба арлын хаан болсны дараа энэ найрт оролцогчид тэр хүнийг францаас үүрд зайлуулагдаж хаан ширээнээс үүрд мөнх огцрогдсон мэт бодож байжээ. Хуучин хэргэм зэрэгтэнгүүд түүний улс төрийн алдааг дурсан ярилцаж, цэргийн хүмүүс Москва, Лейпцигийн тухай шүүмжлэн хэлэлцэж, хүүхнүүд Жозефинагаас салсан тухай нь ярьцгааж байв. Ганц хүний уналт биш харин бүхэл бүтэн журам зарчим устгагдаж байгаа явдалд баярласан энэ роялист бүлэг өөрсдөд нь шинэ амьдрал эхэлж, хар дарсан аймшигт зүүднээс сэрсэн мэт санагдаж байжээ.

Энгэр дээрээ гэгээн Людовикийн одон зүүсэн жавхаатай нэгэн өвгөн XVIII Людовик вангийн төлөө уух санал гаргав. Энэ бол бейл де Сен-Меран байлаа.

Гартелийн хөөгдмөл, францын ван бөгөөд тохинуулагчийн төлөө өргөсөн энэ хундагыг баяртай хүлээн авцгааж, англичуудын заншлаар цөмөөрөө хундага өргөж, хүүхнүүд барьж явсан цэцгээ ширээн дээгүүр тараан тавив. Ийнхүү нэгэн сэтгэлээр хөөрөх нь бараг л утга уянга гэлтэй байлаа.

Хүйтэн харцтай, нимгэн уруултай, биеэ авч явах нь язгууртны байдалтай хэдийгээр тавин настай боловч бас л үзэмжтэй хэвээрээ байгаа Сен-Меран хатагтай,

- Харгислалын үед манай эртний орд харшийг зүсэм талхаар худалдан авч, биднийг хөөн зайлуулаад, бидний эсрэг дур зоргоороо аашлахад бид тайван сууж байсан тэрхүү хувьсгалчид өнөөдөр энд байгаасан бол бид нуран унаж байсан хэмжээлшгүй эрхт ёсонд үнэнч хэвээрээ үлдсэн болохоор үнэхээрийн амь бие хайрлахгүй явдал нь манай талд байсан гэдгийг хүлээн зөвшөөрөх байсан даа. Биднийг хоосорч байхад тэд мандаж байгаа наранд баяр хүргэж, хөрөнгө хогшил цуглуулж, баяжиж байсан юм. Тэд бас манай ванг үнэхээрийн Ивгээлт Людовик байсан гэдэгт харин засгийн эрх булаан авагчаа хэзээд Хараал идсэн Наполеон хэвээрээ үлдэх юм гэдгийг хүлээн зөвшөөрөх байсан сан. Тийм биз дээ, де Вильфор? Гэж хэлэв.
- Хатагтай та юу гэж айлдав? Уучлаарай би дуулсангүй гэхэд түрүүнд хундага өргөсөн өвгөн,
- Хүүхдүүдийг зүгээр байлга хөгшөөн, Өнөөдөр тэд сүйлж байгаа болохоор улс төрийн бодлогод оролцох завгүй байна гэж хэлэв.
- Уучлаарай, ээж ээ гэж хонгор шар үстэй, эелдэг зөөлөн нүдтэй, залуухан гоо охин хэлээд - Эрхэм де Вильфорыг би саатуулчихлаа. Эрхэм де Вильфор, ээж тантай ярья гэнэ гэж хэлэв.
- Миний дуулаагүй асуултыг хатагтай дахин хэлэхээ дургүйцэхгүй бол бид хариулахад бэлхэн байна гэж эрхэм де Вильфор хэлэв.
- Рене би чамайг уучилъя гэж хатагтай эевэргүү инээмсэглэн хэлэхэд, түүний хүйтэн царайд тийм инээмсэглэл тодрох нь хачин жигтэй байв. Эмэгтэй хүний зүрх заншил болсон үзэл, хэвийн байдалд автагдсан байлаа ч гэсэн түүн дотор нь бурхан эх хүний хайр сэтгэлийг хийж өгдөг ажээ. - Би ярьж байна аа Вильфор, бонапартчууд бидэн шиг итгэлтэй, бидэн шиг үнэнч шударга, бидэн шиг амь биеэ хайрлахгүй байж чадахгүй юм гэв.

- Хатагтай минь, тэдэнд бидний тэр бүх чанарыг орлох нэг чанар бий. Энэ бол улайран итгэх явдал юм. Наполеон бол өрнөдийн Магомет байгаа юм. Эдгээр доод гаралтай боловч нэр төрд дуртай хүмүүст бол, тэр хүн хууль тогтоогч, захиран тушаагч биш, бас бэлэг тэмдэг, тэгш ёсны бэлэг тэмдэг нь юм.
- Тэгш ёс! гэж хатагтай дуу алдаад - Наполеон тэгш ёсны бэлэг тэмдэг гэнэ ээ? Тэгвэл де Робеспьер юу болох вэ? Тэгэхээр та түүний байрыг авч корсик хүнд өгөх гэж байх шиг надад санагдаж байна. Засгийн эрхийг хууль бусаар авсан нь л хангалттай юм шүү гэв.
- Үгүй хатагтай минь гэж Вильфор татгалзаад - Би тэр хоёрыг өөр өөрсдийн байранд хэвээр үлдээж байна. Робеспьерыг арван тавдугаар Людовикийн талбай дахь цаазны индэр дээр, Наполеоныг Вандомын талбай дахь багана дээр нэ тавина. Тэр хоёрын нэгний нь гарсан тэгш ёс басамжлан бууруулж нөгөөдөхий нь тэгш ёс өргөмжлөө мандуулсан юм. Нэг нь ванг цаазны заазуурт аваачих хэмжээнд хүртэл бууруулж, нөгөөх нь ард түмнийг вангийн ширээнд хүртэл өргөмжилсэн юм гэснээ Вильфор инээмсэглэн- Гэхдээ энэ нь тэр хоёрыг хоёулаа бузар хувьсгалчид, болоход нь францын хувьд аз завшаантай хоёр өдөр болох термидор сарын есөн, мянга найман зуун арван дөрвөн оны дөрөвдүгээг сарын дөрөвнийг ёс журам ба хэмжээлшгүй эрхт ёсны талынхан заавал тэмдэглэвэл зохих баяр болгоход саад болохгүй юм. Наполеон нэгмөсөн унагаагдсан мөртлөө талдаа хичээнгүйлэн зүтгэх хүнийг байлгаж чадаж байгаа нь бас үүгээр тайлбарлагдана. Хатагтай та юу гэх гээ вэ? Кронвель бол Наполеоны талд ч хүрэхгүй шахам байсан боловч бас л өөрийн талын хүмүүстэй байсан гэж хэлэв.
- Энэ бүгд нь хувьсгалаар өгөгддөг гэдгийг Вильфор та мэднэ шүү дээ. Гэхдээ би таныг уучилж байна. Хувьсгалд сэтгэлгүй байж, жирондичийн хүү байж болохгүй шүү дээ гэхэд Вильфорын царай улайж,
- Миний эцэг жирондич байсан нь үнэн. Гэхдээ миний эцэг ванг цаазлахын төлөө саналаа өгөөгүй юм. Эцэг минь харгислалын өдрүүдэд бас л та нар шиг хөөгдөн зүдэрч, таны эцгийн толгой өнхрөн ойчсон тэр цаазны индэр дээр арай л толгойгоо тавьчихаагүй юм гэв.
- Тийм ээ гэж энэ цуст дуртгалын ямар ч тэмдэг царайд нь илрээгүй хатагтай хариулаад - Харин тэд эрс тэс хоёр зарчмын төлөө цаазын индэр дээр гарах байсан юм. Би нотолгоог нь хэлээд өгье л дээ. Манай бүх гэр бүл хөөгдсөн бурбончуудод үнэнч шударга хэвээрээ байхад, харин танай эцэг шинэ засгийн газарт нийлж, иргэн Нуартье жирондич байсан бол, харин гүн Нуартье сенатч болсон юм гэв.

- Ээж ээ, та бид энэ муухай цагийг дурсан ярихгүй гэж тохиролцсон шүү дээ гэж Рена хэлэв.
- Эрхэм хатагтай гэж Вильфор хэлээд - Би де Сен-Меран авхайтай санал нийлж байна. Өнгөрсөн явдлыг мартахыг бид хоёр танаас хүсэн гуйя. Бурхан ч түүний өмнө хүчгүй тийм зүйлийг шүүмжлэн хэлэлцээд яах вэ? Бурхан ирээдүйг өөрчлөн байгуулах чадалтайгаас биш, өнгөрсөн юмыг яаж ч өөрчилж чадахгүй, Бид өнгөрснөөс зайлан салж чадахгүй ч гэсэн түүнийг халхавчилж чадна. Жишээлбэл би эцгийнхээ үзэл бодлоос татгалзаад зогсоогүй, нэрий нь ч зүүхээсээ татгалзсан. Миний эцэг бонапартч Нуартье гэдэг байсан ба одоо ч хэвээрээ байгаа байж болох юм. Гэтэл би роялист, намайг де Вильфор гэдэг. Хөгшин царсны хувьсгалч шүүс нь хатаж байг, харин та бол зөвхөн түүнээс салбарлан гарсан боловч түүнээс бүрэн салчихыг хүсэхгүй байгаа мөчрий нь харж байна гэв.
- Сайн байна. Вильфор! Сайн байна! гэж бэйл хашхираад - Зүйтэй хэллээ, Би түүнийг өнгөрсөн явдлыг мартаач гэж үргэлж ятгадаг юм. Гэвч ямар ч амжилт олддоггүй. Та бол бүр илүү аз жаргалтай болно гэж найдаж байна гэхэд хатагтай Сен-Ме°ан,
- За яах вэ, өнгөрсөн явдлыг мартацгаая, би ч бас мартмаар байна. Гэвч Вильфор ирээдүйд гуйвшгүй байх ёстой. Гид таныг эрхэмсэг эзний өмнө хариуцна гэж ам өгсөн ба эрхэмсэг эзэн таны өнгөрсөн явдлыг одоо би мартаж байгаа шиг бас мартахыг зөвшөөрсөн болохыг Вильфор та бүү мартаарай гэснээ түүнд гараа өгөөд - Харин таны гарт ямар нэгэн хуйвалдагч этгээд орж ирвэл таныг хуйвалдагчидтай холбоотой байж мэдэх гэр бүлээс гаралтай гэдгийг мэдэх учир өөрийг тань улам хатуу чанга мөшгөж байх болно гэдгийг санаж байгаарай гэж хэлэхэд Вильфор,
- Эрхэм хатагтай минь, миний эрхэлж байгаа үүрэгтажил, ялангуяа бидний амьдарч байгаа энэ цаг үе намайг хатуу ширүүн байхыг шаардаж байна. Би ч өөрөө хатуу ширүүн байх болно. Би улс төрийн хэрэг хэдэн удаа шүүсэн, энэ талаар би өөрийгөө хэн болохоо үзүүлсэн. Гэхдээ нэн маань сүүлчийнх биш нь харамсалтай гэж хэлэв.
- Та тэгж бодож байна уу? гэж хатагтай асуув.
- Би үүнээс болгоомжилж байна Эльба арал, Францад дэндүү ойрхон байдаг. Манай нутгийн эрэгт Наполеон бараг харагдаж байгаа явдал нь түүнийг талархагчдад горьдлого төрүүлсээр байна. Марсельд хагас цалинтай цэргийн хүмүүс бужигнаж, цаг ямагт роялистуудай маргалдах шалтаг хайж байна. Ийм учраас дээд язгуурын хүмүүсийн дотор халз тулалдах жирийн ардын дотор хутгалалцах явдал их гарч байна.

- Тийм ээ, биднийг Парисаас явахад тэгж ярьцгааж байсан. Үгүй тэгээд хаашаа шилжүүлэх юм бол? Гэж бэйл асуув.
- Гэгээ Елена руу
- Гэгээн Елена руу гэнэ ээ! Юу гэсэн үн вэ? гэж хатагтай асуув.
- Эндээс хоёр мянган бээрт байгаа экваторын цаадах нэг а°ал гэж гүн хариулав.
- Санасан ёсоор бүтэх болтугай! Тийм хүнийг өөрийн төрсөн корсик хүргэн хүү нь захирч байгаа Неополь, хүүдээ хаант улс болгож өгөхөөр завдаж байсан итали гурвын дунд байлгана гэдэг бол тэнэг хэрэг гэж Вильфорын хэлдэг зөв байна.
- Мянга найман зуун арван дөрвөн оны гэрээ байгаа болохоор тэр гэрээг зөрчихгүйгээр Наполеонд хүрч чадахгүй нь харамсалтай юм гэж Вильфор хэлэхэд, де Сальвьё гүн,
- Тэр гэрээг аяндаа зөрчинө. Хөөрхий Энгиенский бэйлийг буудах тушаал өгөөд төдийлөн ёсорхоогүй хүн дээ гэж хэлэхэд бэйлийн хатан,
- За одоо шийдлээ. Ариун холбоо Европыг Наполеоноос салгаж Вильфор Марселийг түүний талынхнаас салгаж өгнө. Эсвэл ван хаанчилна, эсвэл үгүй. Хэрвээ тэр хаанчилж байх юм бол төр нь хүчтэй байх ёстой бөгөөд албан ажлыг гүйцэтгэгчид нь гуйвшүй байх ёстой. Зөвхөн ийм баймааж нь хорт муу явдлаас урьдаас сэргийлж болно гэв.
- Хатагтай минь гээд Вильфор инээмсэглэн-вангийн прокурорын туслах бол хорт муу явдлыг болж өнгөрсөн хойно нь олж үздэг нь харамсалтай гэж хэлэв.
- Тэгвэл түүнийг засаж залруулах ёстой.
- Бид хорт муу явдлыг засаж залруулдаггүй түүний төлөө өшөө л авдаг юм. Тэгээд л тэр гэж хэлмээр байна.
- Ай, эрхэм де Вильфор. Биднийг Марсельд байх хугацаанд нэг сонин хэрэг таслахыг хичээгээч, би тийм шүүх таслах ажиллагаа ердөө үзээгүй, улсууд их сонин байдаг юм гэж ярьцгаадаг юм гэж де Сен-Меран авхайн найз де Сальвьё гүнгийн @хин залуу сайхан бүсгүй хэлэхэд вангийн прокурорын туслах,
- Тийм ээ, нээрээ ч сонин шүү гэж хариулаад - Энэ бол зохиомол дууриамал эмгэнэлт явдал биш үнэхээрийн үнэн явдал, зовж зүдэрч

байгаа хүний дүр үзүүлж байгаа биш, жинхэнэ зовлон зүдүүр байдаг юм. Таслан шийтгэх хурлын төгсгөлд таны харах хүн бол жүжиг тараад гэртээ харьж, гэр орныхонтойгоо оройн хоолоо идээд маргааш бас дахин тоглохоор тайван хэвтэхгүй, харин алуурч хүлээж байгаа шорон уруу хүргэгдэн очно. Тэгэхээр сэтгэл ихэд хөдөлгөх юм үзэхийг хүсдэг авгай нарт бол тэрнээс илүү сонин зүйл гэж байхгүй байх. Хэрвээ тийм учрал тохиолдвол би түүнийг ашиглахгүй өнгөрөхгүй гэдэгт сэтгэл бүү зов гэв.

- Бид үгийг нь сонсоод дагжин чичирч байдаг... Гэтэл энэ хүн инээж байна шүү гэж Рене хэлээд царай нь зөвхийрэв.
- Та юу гэж айлдаж байна? Энэ бол өрсөлдөөн... Би улс төрийн ба бусад хэрэгтэнд тав зургаан удаа алах ял оноохыг шаардсан... Харанхуйн дунд хичнээн хутга билүүдэгдэж эсвэл миний өөдөөс хэдийг нь зангачихсан байгааг хэн мэдэх вэ?
- Бурхан минь! Та нээрэнгээсээ ярьж байна уу, эрхэм де Вильфор? Гэж Рене хашхирахад Вильфор? гэж Рене хашхирахад Вильфор инээмсэглэн,
- Огт үнэнээсээ ярьж байна. Гүнгийн хатны сонирхон хүсэж байгаа миний нэр төрөө бодож хийдэг тэр сонирхолтой ажиллагаа бол надад зөвхөн аюул заналыг л ихэсгэдэг юм. Дайсан өөдөө сохроор давшилдаг энэ наполеоны цэргүүд, хэзээ буудах буюу жадаар шаахаа боддог гэж үү? Урьд өмнө нүдэндээ ч хараагүй орос, австри, унгар хүнийг зүгээр алчихдаг тэр цэргүүд өөрсдийн дайсан гэж үзсэн хүнийг алахдаа гар нь чичирнэ гэж үү? Тэгэхдээ аюул занал зайлшгүй тохиолдоно. Тэгэхгүй бол манай ажил зөвтгөх юмгүй болно. Шийтгүүлж байгаа хүний нүдэнд хорсол занал гялалзахыг харахдаа би өөрөө дүрэлзэн шатдаг. Энэ минь надад хүч чадал өгдөг юм. Энэ бол зарга заальхай биш харин тулалдаан юм. Би түүнтэй тулалдахад тэр биеэ хамгаалдаг, тэгэхэд нь би шинэ цохилт хийдэг, тэгээд тулалдаан маань ямар ч тулалдааны адил ялалт эсвэл ялагдлаар төгсдөг. Шүүх таслах хурал дээр үг хэлнэ гэдэг чинь энэ дээ! Аюултай явдал хүнийг хэлэмгий болгодог юм. Хэрвээ намайг үг хэлсний дараа хэрэгтэн хүн инээмсэглэвэл би тодорхой бус хийсвэр муухан ярьжээ гэж мэддэг. Хэрэгтнийхээ үнэнхүү буруутайд итгэсэн эд мөрийн баримт гарган, уран сайхан ярьсан үгийнх нь цохилтод хэрэгтэн хүн толгойгоо бөхийлгөж уруу царайлан суухыг харахад прокурор хүний сэтгэл ямар их ид хаваар дүүрэн гэж санана! Хэрэгтний толгой бөхийн бөхийсөөр унадаг юм!

Рене аяархан дуу алдав.

- Ёстой ярьж байна даа! гэж зочдын нэг хэлэв.

- Манай үед ийм л хүмүүс хэрэгтэй дээ гэж өөр нэг хүн дуугарахад гурав дахь нь шүүрэн авч,
- Вильфор та, сүүлчийн нэг хэрэг ласлах хурал дээр сайхан байсан. Эцгээ алсан новшийг санаж байгаа биз дээ? Тэгэмэд та түүнийг алуурчийн гарт хүрэхээс өмнө бараг л алж орхисон гэв.
- Өө, эцгээ алагчдыг би харамсан өрөвдөхгүй. ийм хүмүүсийг шийтгэх хангалттай хүнд шийтгэл алга гэж Рене хэлээд - Харин золгүй улс төрийн хэрэгтнүүд... гэхэд,
- Тэд ард түмний эцэг болсон ванг унагах ч юм уу эсвэл алахыг хүсдэг учраас гучин хоёр сая хүний эцгийг алахыг хүссэн хэрэг, тэгэхээр улам ч муухай хортой хэрэг хийж байгаа улс гэв.
- Ялгаагүй, эрхэм де Вильфор. Би танаас хүссэн хүний ялыг хөнгөвчлөн үзэж байхыг надад амлах уу... гэж Рене хэлэхэд Вильфор их л эелдэг инээмсэглэн,
- Бүү сэтгэл зов, ялын төлөвлөгөөг хоёулаа бичиж баймц гэж хэлэв.
- Хайрт охин минь гэж хатагтай хэлээд - Өөрийнхөө нохой, шувуу, алчуур зэргээр оролдож, хожмынхоо нөхрийг ажил хэргээ явуулахад нь бүү саад бол. Одоо чинь зэвсгийн оронд үг хэл хүндтэй болсон цаг, Энэ тухай латины цэцэн үг байдаг гэхэд,
- Cedant arma loque гэж Вильфор хэлэв.
- Би латинаар нь хэлэх зүрх хүрсэнгүй гэж хатагтай хариулав.
- Та эмч байсан бол надад таатайхан байх мэт санагдах юм гэж Рене үргэлжлүүлэн хэлээд - Цээрлүүлж залхаадаг бол надад сахиулсан тэнгэр байлаа ч гэсэн аймшигтай байдаг гэв.

Вильфор хайр дурлалаар дүүрэн нүдээр харж,

- Энэрэнгүй сэтгэлт Рене минь гэж шивгэнэн дуугарав.
- Эрхэмсэг де Вильфор манай мужийн зан суртахуун ба улс төрийн Смч байх болно. Охин минь, энэ бол хүндэт үүрэг гэдэгт итгээрэй гэж бэйл хэлэхэд,
- Энэ нь ч эцгийн нь гүйцэтгэсэн үүргийг мартахад тус болно гэж чигээрээ зүтгэдэг хатагтай хэлэв.

- Хатагтай минь гээд Вильфор уйтгартайхан инээмсэглээд - Миний аав, үгүй ядахдаа миний бодоход өнгөрсөн үеийн төөрөгдлөөсөө салж, шашин ба ёс журмын талын үнэнч хүн, намайг бодвол шилдэг роялист хүн болсон. Юу гэвэл тэр бол гэм буруугаа хүлээсэн роялист, би бол зөвхөн үнэн сэтгэлээсээ роялист болсон гэж найдах юм гэж Вильфор хэлээд шүүхийн хурал дээр гоц сайхан ярьчихаад тэр нь цугларсан олонд ямар нөлөө үзүүлж байгааг шалгах мэт тэнд цугларсан бүхнийг эрэгцүүлэн харав.
- Зүйтэй, Вильфор. Би энэ үгийг уржигдар Тюильрид жирондичийн хүү, Кондегийн армид албан хааж байсан офицерын охин хоёр гэр бүл болох гэж буйд гайхсан ордны сайдад хэлсэн юм. Сайд ч миний хэлснийг сайн ойлгосон. Ван ч өөрөө ингэж нэгдэх аргыг дэмжиж байна лээ. Бид хоёрын яриаг ван чагнаж байгааг бид мэдээгүй байтал, тэр өөрөө ярианд оролцож «Вильфор (ван Нуартье гэж хэлээгүй, харин Вильфор гэж хэлснийг харж байгаа биз) Вильфор хол явах хүн дээ. Энэ чигээ олсон залуу хүн миний талд байгаа юм. Де Сен-Мераных охиноо түүнтэй суулгах гэж байгааг дуулаад би талархсан, түүгээр ч барахгүй өөрсдөө над дээр ирж зөвшөөрөл гуйгаагүй байсан бол би ингэ гэж тэдэнд зөвлөх байсан юм» гэж хэлсэн шүү гэж де Салвьёгийн ярихад баярласан Вильфор
- Ван тэгж хэлээ юу, гүнтэн? Гэж асуув.
- Би танд вангийн өөрийн нь хэлсэн үгийг дамжиулан хэлж байна. Хэрвээ бэйл илэн далангүй байя гэж бодвол хагс жилийн өмнө, охиноо танд өгөх гэж бодож байгаа тухайгаа ванд хэлэхэд ван түүнд бас энэ үгийг хэлж байсныг хэлэх байх даа.
- Энэ үнээн гэж бэйл батлан хэлэв.
- Тэгвэл би вангийн ачийг хариулах ёстой! Вангийн төлөө бүхнийг хийнэ!
- Таны ийм байх чинь надад таалагдаж байна. Одоо хуйвалдагч гараад ирэг л дээ тавтай морилог! гэж хатагтай хэлэв.
- Миний хувьд ээж минь таны хэлснийг бурхан бүү сонсоосой, харин эрхэмсэг де Вильфор зөвхөн хармааны хулгай, багахан дампуурал, аймхай луйварчингуудыг л ирүүлж байгаасай гэж бурханд мөргөнө. Тэгвэл л би тайван унтаж чадна гэж Рене хэлэхэд Вильфор инээж,
- Энэ бол эмч хүнийг толгой өвдөх, сэвх татах, зөгийд хатгуулах зэргийг эмнэж бай гэсэнтэй адил юм. Хэрвээ та намайг вангийн прокурор байлгахыг хүсэх юм бол эмчийн алдар нэрийг мандуулах аймаар өвчнийг анагаахыг хүсэж байгаарай гэж хэлэв.

Гэтэл яг энэ үед хувь тавилан Вильфорын хүслийг хүлээж байв уу гэлтэй зарц орж ирээд хэдэн үг чихэнд нь хэлэв.

Вильфор уучлал гуйгаад, ширээний цаанаас босон явснаа хэдхэн минут болоод их л сэтгэл хангалуун байдалтай инээмсэглэн буцаж ирэв.

Рене болзоот хүн өөдөө бахархсан байдалтай харахад, түүний цэнхэр нүд нь хууз сахлаар хүрээлэгдсэн цайвар цагаан царай дээр нь гялтганаж, энэхэн зуур үнэхээр ч сайхан харагдаж байв. Түүнийг гэнэт гарсныхаа учрыг тайлбарлан хэлж өгөхийг Рене тэсэж ядан хүлээж байв.

- Та тун саяхан эмч нөхөртэй байх юм сан гэж хүсэж байсан гэж Вильфор хэлээд - Эскулапын шавь нартай (мянга найман зуун арван таван онд ч ингэж ярьдаг байсан юм) адил төстэй юм надад байна. Би олдсон цагаа ашиглаж чадахгүй нь. Намайг энд, таны дэргэд байхад ч хүртэл бидний гэрлэх ёслол дээр ч олоод ирэх юм гэхэд залуу бүсгүй бага зэрэг сэтгэл зовсон байдалтай,
- Таныг юу гэж дуудаа вэ? гэж асуув.
- Надад хэлсэн нь үнэн бол, их л хүнд өвчтэй хүнээс болоод дууджээ. Үлэмж сүрхий тохиолдол бөгөөд тэр өвчин нь аягүй бол цаазны индэрт ч хүргэж мэднэ.
- Бурхан минь! гэж Рене царай нь зэвхийрэн хэлэв.
- Та юу гэнэ ээ! Зочид нэгэн дуугаар хэлэв.
- Бонапартчуудын хуйвалдаанаас илүү ч үгүй, дутуу ч үгүй явдлын тухай болж байх шиг байна.
- Нээрээ гэж үү дээ! гэж хатагтай дуу алдав.
- Ирүүлсэн нууц мэдээнд бичсэн нь гээд Вильфор уншруун:

«Эзэн ширээ ба шашныг сүслэн дагагч би, Неаполь, Порто-Феррайо ороод өнөөдөр хүрэлцэн ирсэн «Фараон» гэдэг хөлөг онгоцны ахмадын туслах Эдмон Дантес, Мюратаас засгийн эрхийг хууль бусаар булаагчид бонапартын хооронд явуулсан захидал авч явааг вангийн эрхэм прокурор таны сонорт хүргэе.

Хэрвээ түүнийг баривчлан авбал хэргийн баримт болох захидал түүний биеэс эсвэл эцгийнхээс нь эсвэл «Фараон» онгоц дээрх түүний тасалгаанаас олдоно.»

- Үнэ захидалд гарын үсэг зураагүй тэгээд бас танд гээгүй вангийн прокурорт гэсэн байна шүү дээ гэж Рене хэлэв.
- Тийм ээ, гэвч вангийн прокурор байхгүй байгаа. Энэ захидлыг нарийн бичгийн даргад нь авчирч өгчээ. Тэр хүн захидлыг задлан үзэх эрхтэй хоцорсон болохоор задалж үзээд миний хойноос хүн явуулжээ. Тэгээд намайг гэртээ байхгүй болохоор өөрөө баривчлах тушаал өгчихөж.
- Тэгвэл хэрэгтнийг бариад аваа юу? гэж хатагтай асуухад,
- Өөрөөр хэлбэл хэрэгт татагдаж байгаа хүнийг гэж Рене засан хэлэв.
- Тийм ээ, баривчлагдсан гэж Вильфор хариулаад - Би Рене авхайд хэлснээр хэрвээ тэр хүнээс захидал олдвол эмчлүүлэх хүн маань их л хүнд өвчтэй байж таарах нь гэв.
- Тэр азгүй амьтан чинь хаана байна? гэж Рене асуув.
- Миний албан дээр хүлээж байгаа.
- Яв яв найз минь. Албан үүрэгтээ хайхрамжгүй байж болохгүй. Вангийн алба таныг биеэр оролцохыг шаардаж байна. Тэгэхээр вангийн алба шаардсан тэр газар уруу яв яв гэж бэйл хэлэв.

Вильфор ширээ тойрч очоод болзоот хүүхнийхээ сууж байгаа сандлын арыг түшиж,

- Таны сэтгэлийг зовоохгүйн тулд чадах л бүх зүйлээ хийхийг амлая. Хэрвээ эд мөрийн баримт нь гарцаагүй болж тулгаж буй ял нь үнэн байвал бонапартынхны хог өвсийг хадаж хаяхаас биш яах вэ гэж хэлэв.

Рене «хадаж хаях» гэдэг үгийг сонсоод сочин татвасхийсний учир юу гэвэл Вильфорын хэлж байгаагаар тэр хог өвс нь толгойтой ажээ.

- Энүүний үгэнд битгий ор Вильфор. Энэ бол хүүхдэд зан, тэгж байгаад дасах болно гэж хатагтай хэлээд туранхай хорчгор гараа Вильфор өөд сунгахад Вильфор түүний нь үнсэх зуураа Рене өөд харав. Энэ харц нь «Би таны гарыг үнсэж байна гэсэн буюу үгүй дээ л үнсэхийг хүсэж байна» гэж хэлэх мэт байв.
- Гунигтай ёр байна даа! гэж Рене шивгэнэв.
- Болиорой Рене гэж хатагтай хэлээд - Чиний энэ хүүхэд занг хараад тэсэж чадахгүй нь. Улсын хувь заяа, чиний хувийн бодол хоёрын аль нь илүү чухал болохыг мэдэх юм сан гэв.

- Ээ дээ ээж минь гээд Рене санаа алдав.
- Хатагтай минь, манай муу роялист эмэгтэйг уучлаарай. Вангийн прокурорын туслахын үүргийг хичээнгүйлэн биелүүлнэ. Өөрөөр хэлбэл хайр найргүй байна гэдгийг танд амлая гэж де Вильфор хэлэв.

Гэвч прокурорын туслахын ёсоор энэ үгийг хэлж байх зуураа болзоот охин өөд харснаа «Битгий зовоорой Рене, би таны төлөө энэрэнгүй сэтгэл гаргана» гэж хэлэх мэт байв.

Рене ээврүү инээмсэглэлээр хариулахад Вильфор их л хангалуун гарч одов.

2. Байцаалт

Вильфор зочдын өрөөнөөс гараад, хөгжилтэй дүрээ тэр дороо өөрчилж, өөрийн ойрхны хүний хувь заяаг шийдвэрлэх дээд зэргийн үүрэг ноогдсон хүний баяр ёслолын байдалтай боллоо. Гэвч хэдийгээр чадвартай жүжигчин шиг толины өмнө олонт сургуулилж нүүр царайгаа өөрчилж чаддаг болсон боловч энэ удаа хөмсгөө зангидаж баргар царай гаргахад хэцүү байв. Үнэхээр ч, хэрвээ эрс тусгаарлахгүй бол хор хүргэж болох аавын нь өнгөрсөн үеийн улс төрийн үзэл байдлыг тооцохгүй бол Жерар де Вильфор энэ үед азтай хүнд л байж бо«ох тийм их баяр жаргалтай байв. Ихээхэн хөрөнгөлэйн дээр хорин долоон насандаа хууль цаазныхны дотор өндөр тушаал эзлэн залуу сайхан охины болзоот хүн нь болжээ. Вильфор энэ охинд тачаадан дурласан биш харин вангийн прокурорын туслахын ёсоор ухаалаг дурласан ажээ. Сен-Меран охин бол зөвхөн гоо үзэсгэлэнтэй төдийгүй бас ч вангийн оронд их нэр хүндтэй гэр бүлээс гаралтай хүн юм. Эцэг эх нь өөр хүүхэдгүй учир бүх хөрөнгөө хүргэндээ ашиглуулж болох эцэг эхтэй болзоот хүүхэн нь тавин мянган экюгийн инжтэй ирэх бөгөөд бас ч хагас саяын хөрөнгө нэмэгдэж болох горьдлоготой байв. Хэрвээ энэ бүгдийг хамтатган бодох юм бол Вильфор наран дээрээс ч хар толбо олж харахаар тийм аз завшаантай байв.

Хаалган дээр түүнийг цагдаагийн комиссар хүлээж байв. Тэр бараан дүр нь түүнийг диваажингаас хилэнцэт газар дээр бууж ирэхэд хүргэв. Тэгээд царайгаа зохих ёсоор өөрчилж, цагдаагийн комиссарт дөхөж орогчоод,

- Би бэлхэн! Захидлыг уншлаа, та тэр хүнийг барьсан чинь сайн байна. Одоо та түүний тухай, хуйвалдааны тухай бүх л мэдэж авсан юмаа хэлж өгнө үү гэв.
- Хуйвалдааны тухай бид одоогоор юу ч мэдэхгүй. Түүнд байсан бүх бичиг цаасыг боогоод таны ширээн дээр тавьчихсан. Харин хэрэгт татгдаж байгаа хүний тухайд гэвэл, нууц мэдээлэл дотор таны уншиж мэдсэнээр Эдмон Дантес гэдэг. Тэр бол Александр ба Смирнээс хөвөн зөөдөг, марселийн «Моррель ба түүний хүү» гэдэг худалдааны газарт

харъяалагдан «Фараон» гэдэг гирван шурагт хөлөг онгоцны ахмадын туслахаар албан хаадаг юм байна.

- Худалдааны онгоцонд ажилд орохын өмнө усан цэрэг байсан юм уу?
- Өө, үгүй! Тэр чинь ив идэрхэн хүн.
- Хэдэн настай юм бэ?
- Арван ес, хориос хэтрээгүй байх.
- Вильфор, Гранрю гудамжийг өнгөрөн гэртээ ойртон ирж явахад түүнийг хүлээж байсан бололтой нэг хүн өөдөөс нь гарч ирэв. Энэ бол эрхэм Моррель байв.
- Эрхэм де Вильфор! гэж хашхираад - Би тантай дайралдсан минь сайн боллоо! Хачин эндүүрэл болж, миний ахмадын туслах Эдмон Дантесыг баривчлан авлаа гэж хэлэв.
- Мэднэ, би түүнийг байцаах гэж явна гэж Вильфор хариулав.
- Эрхэм де Вильфор, та хэрэгт татагдсан тэр хүнийг мэдэхгүй, би бол сайн мэднэ. Хамгийн үнэнч томоотой хүн гэж бодоорой, түүгээр ч барахгүй худалдааны бүх флотод түүн шиг ажлаа сайн мэддэг хүн байхгүй гэж хэлж болно...Эрхэм де Вильфор! Та түүнийг харж үзэхийг гуйя гэж Моррель гал дөлтэй хэлэв.

Вильфор бол бидний мэдэж авсанчлан язгууртны хүрээлэнд хамаарагдах бөгөөд харин Моррель плебейнхэнд хамаарагдана. Вильфор бол яахын аргагүй роялист байсан болохоор Моррелийг бонапартизмыг талархагч байж мэднэ гэж сэжиглэнэ. Вильфор Моррельд ихэмсэг зан гаргаж хүйтнээр,

- Гэр орондоо төвшин төлөв, худалдаа арилжааныхаа ажилд үнэнч, өөрийнхөө ажлыг зайн мэддэг байлаа ч гэсэн улс төрийн талаар хэрэгтэн гэмтэн байж болох юм. Эрхэм та үүнийг мэднэ шүү дээ? гэж хариулав.

Тэгэхдээ үгийн төгсгөлийг Моррельд өөрт нь хамааруулав уу гэлтэй нухацтай өнгөөр хэлэв. Янзыг нь үзсэн маягтай харц нь өөрт нь өршөөл мэдсээр атлаа хэрэгтэйг өрөөлийн төлөө энэрэл гуйж зүрхэлсэн тэр хүний зүрхэнд нэвтрэхийг хичээх адил байв.

Моррелийн улс төрийн үзэл тийм ч айхтар цэвэр биш болохоор царай нь улайгаад явчихав. Маршалтай уулзсан болон эзэн хааны хэлсэн үгийн тухай Дантесын итгэж хэлсэн нууц зүйл сэтгэлийг нь зовооно. Гэвч сэтгэлийн угаас,

- Эрхэм де Вильфор та үүргийнхээ ёсоор үргэлж шударга байдаг шигээ энэрэнгүй байж хөөрхий Дантесыг минь бидэнд эргүүлж өгөхийг гуйя! гэж хэлэв.

Энэ «бидэнд эргүүлж» гэдэг үгэнд хувьсгалт шинж байна гэж вангийн прокурорын туслахад санагдав.

«Тийм бий! «Бидэнд эргүүлж» гэнэ ээ. Өмгөөлөн гүйж яваа хүн нь болгоомжгүйгээр олон тоон дээр ярьж байхыг бодоход энэ Дантес ямар нэгэн бүлэгт хамаарагддаг юм биш байгаа? Түүнийг архины мухлагт тэгэхдээ олон хүнтэй хамт байхад нь барьсан гэж комиссар хэлж байсан шүү. Ямар нэг нууц байр байж магадгүй» гэж дотроо бодсоноо,

- Эрхэм та огтын тайван байж болно. Хэрвээ хэрэгт татагдаж байгаа хүн гэм буруугүй байвал таны энэ гүйлт дэмий өнгөрөхгүй. Харин буруутай байх юм бол бид хүнд бэрх цаг үед амьдарч байгаа болохоор, ял цээрлэлгүй өнгөрүүлчихнэ гэдэг чинь хорлонтой жишээ болж мэднэ. Ийм болохоор би өөрийнхөө үүргийг гүйцэтгэх хэрэгтэй болно гэж мэлэв.

Тэгээд их л хүйтнээр ёс бэлгэн бөхийж ёслоод шүүхийн байшинтай залгаа орших өөрийнхөө гэрт ороход хөөрхий хөлгийн эзэн хөшсөн мэт гудамжинд зогсож хоцров.

Үүдний өрөөнд цагдаа цэргүүд дүүрэн бөгөөд баригдсан залуу тэдний дунд, үзэн ядах харцаар хүрээлэгдэн хөдлөлгүй тайван зогсож байв.

Вильфор үүдний өрөөг өнгөрөн гарахдаа Дантесыг хяламхийж хараад, цагдаагийн гараас боодолтой бичиг цаас авя,

- Баригдсан хүнийг оруулаад ир гэж хэлэв.

Вильфор баригдсан хүнийг хэдийгээр агшин зуурын дотор харсан боловч байцаах гэж байгаа хүнийхээ тухай өөрийн бодлыг тогтоож амжив. Түүний өргөн магнайн цаадах ухаан, шаргуу харц ба зангидсан хөмсөгнөө илрэх зориг, зааны яс шиг хоёр эгнээ цагаан шүд нь харагдах хагас хамхисан уруул дээрх шулуун шударга зангий нь ажиглан харж чадав.

Төрсөн анхны сэтгэгдэл нь аятайхан байв. Гэвч Вильфорт улс төрийн мэргэн ухаан анхны сэтгэгдэлд бүү бууж өг, энэ бол ямагт сэтгэлийн догдлол байдаг юм гэж сургадаг юм шүү гэж хэлдэг байжээ. Вильфор анхныхаа сэтгэгдлийг энэ байдалд захируулав.

Зүрхэнд нь нэвтрэн сэтгэлийг нь эзлэн авах гэж оргилон байгаа сайн сэтгэгдлээ дарж орхиод, толины өмнө орогчиж сүртэй дүр гаргаад, бичгийн ширээний ард баргар ширүүн царайлан суув.

Минутын дараа Дантес орж ирэв.

Тэр, өнөөх л янзаараа зэвхий цагаан царайтай байсан боловч тайван талархуу байв. Дантес шүүгчид чөлөөтэй бөхөсхийн ёслоод, дараа нь хөлгийн эзэн Моррелийнд орсон юм шЕг суух сандал нүдээрээ хайв.

Тэгээд зөвхөн Вильфорын харцтай дайралдав. Энэ бол бодол саналаа хэнд ч харуулж мэдүүлэхгүйн тул харцаа бүдэх ший шиг болгочихдог зөвхөн үнэ шударгын шүүхийн ёс дэглэмийг сахиулагчид байдаг харц байв. Энэ харц нь Дантесыг шүүхийн өмнө байгаа болохыг мэдрүүлэв.

- Та ямар ажилтай хэн гэдэг хүн бэ? Гэж Вильфор үүдний өрөөнд түүнд өгсөн бичиг баримтуудыг эргүүлэн үзэх зуураа асуув. Ганц нэгэн цагийн дотор хэргийн баримт бичгүүд нилээд зузаан болжээ. Хэрэгтэн гэж нэрлэгдсэн золгүй амьтныг тагнуулын бузар яр ийм хурдан иддэг ажээ.
- Намайг Эдмон Дантес гэдэг гэж залуу эр төвшин тод хоолойгоор хариулаад - «Моррель ба түүний хүү» гэдэг фирмийн «Фараон» онгоцны ахмадын туслах гэж хэлэв.
- Та хэдэн настай вэ? гэж Вильфор үргэлжлүүлэн асуухад Дантес,
- Арван естэй гэж хариулав.
- Таныг баривчлах үед та юу хийж байсан бэ?
- Би гэрлэх ёсоо гүйцэтгэж нөхөдтэйгээ цайлж байсан гэж Дантес үл мэдэг чичигнэсэн хоолойгоор хариулав. Энэ үед болж байгаа хүйтэн ёсорхог байдал ба түрүүчийн баяр цэнгэл, Вильфорын баргар царай ба Мерседесийн туяа татсан тунгалаг царай хоёрын хооронд даанч ялгаатай хачин их зовиуртай байлаа.

Прокурорын туслах өөрийн эрхгүй татвасхийн,

- Таны гэрлэх ёс гүйцэтгэж байсан үеэр гэнэ ээ? Гэж асуув.
- Тийм ээ, би гурван жилийн турш дурлаж явсан хүүхэнтэйгээ сууж байг а юм.

Вильфор ердийн хайхрамжгүй байдлаасаа гадуур ингэж тэр х@ёрын гэрлэх ёс зэрэгцсэн явдлыг гайхаж, залуу хүүгийн догдолсон дуу түүнд өрөвдөх сэтгэл төрүүлэв. Тэр өөрийн болзоот хүүхэнд дуртай, бас л жаргалтай байв. Тэгтэл өөртэй нь адилхан жаргал эдлэх гэж байсан тэр хүний аз жаргалыг эвдэн бусниулахаар дууджээ.

«Ингэж гүн ухааны маягаар зэрэгцүүлэх нь де Сен Меран бэйлийн зочдын өрөөнд тун сайхан сэтгэгдэл төрүүлэх байх» гэж дотроо бодлоо. Тэгээд Дантесыг дараачий нь асуултыг хүлээж суух зуур Вильфор сонсогчдыг алга ташуулах тийм өгүүлбэр бодож олох гэж ухаанаа зарцуулдаг илтгэгч шиг оюунаа хөвчлөн суув.

Тэгээд дотроо уран сайхан өгүүлбэр бодож олоод Дантест хандаж:

- Цааш нь яриарай гэв.
- Цааш нь юугаа ярих вэ?
- Үнэн шударгын шүүхэд өчгөө өг.
- Тэгвэл үнэн шударгын шүүх юу мэдэх хүсэлтэй байгаагаа хэлэг. Би мэдэх л бүх юмаа хэлж өгье. Тэгэхдээ гээд Дантес инээмсэглэн - Би их л бага юм мэднэ шүү дээ гэж хэлэв.
- Та засгийн эрхийг булаан авагчийн үед албан хааж байсан уу?
- Түүнийг унахад намайг цэргийн флотод авах гэж байсан юм.
- Таныг улс төрийн бодллогод дэндүү оролцдог гэж хүмүүс ярих юм гэж Вильфор хэнээс ч юу ч дуулаагүй боловч юу ч гэсэн энэ асуудлыг ял тулгах маягаар тавиад үзье гэж бодоод асуув.
- Миний улс төрийн үзэл! Надад хэзээ ч тэр үзэл гэдэг юм чинь байгаагүй, би танд хэлсэнчлэн одоо арван есөн настай, би юу ч мэдэхгүй, би ямарч дээгүүр тушаал эзэлж чадахгүй, хэрвэS миний хүсэж байгаа тэр албаныг надад өгвөл би ганцхан эрхэм Мо°рельд л ачийг нь хариулах болно. Тэгэхээр миний улс төрийн биш харин хувийн үзэл бол гурван сэтгэгдэлд оршино. Би өөрийн эцэгтээ хайртай, эрхэм Моррелийг хүндэтгэдэг ба Мерседесийг хайрлан дурладаг. Өршөөлт эрхэм минь үнэн шударгын шүүхэд хэлж чадах, мэдэх юм маань энэ л байна даа. Тэгтэл энэ маань шүүхэд бага сонирхогдож байгаа нь үзтэл илэрхий байна.
- Дантесыг ярьж байх зуур Вильфор түүний үнэнч шударга царайг хараад Рене энэ хүнийг танихгүй боловч өршөөн энэрч үзээрэй гэж байсныг өөрийн эрхгүй санав. Прокурорын туслах гэмт хэрэг ба гэмт хэрэг өдүүлэгчидтэй ярилцаж сурсан болохоор Дантесын үг бүр нь түүний гэм буруугүйг шинээр нотолж байгааг харж байв. Эрлээ гэхэд олдох нь ховор, сэтгэл зүрх ер нь байгаагаараа ч энгийн цагаан сэтгэлтэй, бараг хүүхэд шиг энэ залуу хүү яллан шүүж байгаа хүндээ ч гэсэн эеврүү сайхан сэтгэлээ илчлэн гаргав. Аз жаргалтай байсан учир юм бүхнийг хайрлан үзэх бөгөөд баяр жаргал бол хамгийн хортой санаатныг ч болов хувирган сайхан сэтгэлтэй болгодог юм. Вильфор түүнтэй хатуу ширүүн байсан

бөгөөд харин Эдмоны харц, дууны өнгө, хөдөлгөөнд нь байцааж байгаа хүндээ дотно, сайн байгаагаас өөр юм байхгүй байв.

«Үнэхээр ч сайн хүү байна. Ренегийн хамгийн анхны хүслийг биелүүлэхэд төвөггүй боллоо. Үүний төлөө Рене минь олны өмнө гарыг минь атгаж харин хүнгүй буланд бол сэм эелдэгхэнээр үнсэх байх» гэж Вильфор бодов.

Энэ амтат сайхан найдлагаас болж Вильфорын царай гэгээ тусаж, бодлоосоо салж Дантес өөд харахад Вильфорын царайны өөрчлөгдөх бүрийг ажиглан харж байсан Дантес инээмсэглэв.

- Танд дайсан бий юу? гэж Вильфор асуув.
- Дайсан уу? Аз болоход би өөртөө дайсантай болчихоор хэмжээнд арай хүрчихээгүй байна. Би бага зэрэг түргэн зантай хүн, гэвч доод хүмүүстэй харьцахдаа биеэ барьж байхыг үргэлж хичээдэг юм. Миний удирдлага доор арав, арван хоёр усан цэрэг байдаг. Өршөөлт эрхэм минь та тэднээс асуу л даа, би дэндүү залуу байгаа болохоор тэд намайг эцэг шигээ биш ах шигээ хайрлан хүндэтгэдэг болохоо хэлж өгөх байх гэж Дантес хэлэв.
- Хэрвээ танд дайсан байхгүй юм бол атаархагч хүмүүс байж мэдэх юм. Та дөнгөж арван есөн настай, тэгтэл таныг ахмадаар томилж байна. Энэ бол таны насанд их өндөр тушаал, бас тэгээд өөртөө хайртай сайхан охинтой суух гэж байна. Энэ бол маш ховор тохиолдох явдал юм. Тэгэхээр хүн атаархаж болох хоёр эмзэг шалтгаан байна.
- Тийм ээ, таны хэлдэг зөв. Та хүмүүсийг мэдээж надаас илүү сайн мэддэг л дээ. Нээрэн тийм л байх. Гэвч эдгээр атаархагчид миний нөхдийн дотор байвал би тэднийг хожим үзэн ядаж явахгүйн тулд мэдэхгүй байхыг илүүд үзэж байна.
- Энэ чинь буруу. Хүрээлэн байгаа хүмүүсээ аль болохоор сайн мэдэж байм хэрэгтэй. Үнэнийг хэлэхэд та надад сайн залуу шиг санагдлаа., тэгэхээр би шударга үнэний шүүхийн ердийн заншла с ухарч, үнэн учрыг илрүүлэн ол@ход танд тусалъя... Таныг хэрэгт татуулсан ховын мэдээ энэ байна. Бичгийг нь таньж байна уу? хэмээгээд Вильфор хармаанаасаа захидлыг гаргаж Дантест өгөв. Дантес авч үзээд, уншсанаа духаа атируулан хэлсэн нь:
- Үгүй, би энэ бичгийн танихгүй байна. Хэлбэрийг нь өөрчилж бичжээ. Тэгэхдээ нэлээн тогтуун бичигтэй хүн юм гээд Вильфор өөд баярласан байдлаар харж - Тантай тохиолдсон явдалдаа би их баярлаж байна. Энэ атаархагч бол ёстой дайсан юм! гэж үргэлжлүүлэн хэлэв.

Эдгээр үгийг хэлэхдээ залуу хүүгийн нүдэнд гялалзах гал дөлийг хараад Вильфор энэ гадна талын энгийн номхон байдлын цаана сэтгэл оюуны ямар их хүч байгааг ойлгов.

- За тэгвэл одоо хэрэгтэн хүн шүүгчдээ хэлж байгаа шигээр биш, харин азгүй явдал тохиолдсон хүн өөртөө тус болох гэж байгаа хүнд хэлж байгаа ёсоор хэлж өгөөрэй. Энэ нэргүй ховын дотор бичсэн зүйл үнэн үү? Гэж Вильфор асуугаад Дантесын үзээд өгсөн захидлыг зэвүүцсэн байдалтай ширээн дээр шидэв.
- Бүгдээрээ үнэн тэгэхдээ бас нэг ч үнэн үг алга. Би танд яг үнэнийг нь хэлье. Хэлж байгаа маань үнэн гэдгийг далайчны нэр төрөөр, Мерседест дурладаг дурлалаараа, өвгөн эцгийнхээ амьдралаар тангараглая!
- Цааш нь ярь даа гэж Вильфор хэлээд дотроо «Хэрвээ намайг Рене хардаг сан бол сэтгэл нь тайвширч, намайг яргачин гэж хэлэхгүй байсан даа» гэж бодов.
- Тэгэхээр ийм байна. Биднийг Неаполиос гарах үед ахмад Леклер мэдрэлийн халуун хумхаагаар өвдсөн юм. Хөлөг онгоцон дээр эмч байхгүй байсан. Эльба арал өөд яарч явсан болохоор эрэг дээр гарахыг өөрөө дургүйцсэн, тэгтэл ч биеий нь байдал доройтож гурав дахь өдрөө амьсгаа хураах дөхөж байгаагаа гадарлаад намайг дуудуулсан юм.

«Дантес минь, миний чамд өгөх гэж байгаа даалгаврыг биелүүлнэ гэж надад нэр төрөөрөө тангарагла. Маш чухал хэрэг юм шүү» гэж хэлэхэд нь би:

«Тангараглая ахмад аа» гэж хариулсан.

«Намайг үхсэн хойно ахмадын туслахын хувьд командлал танд шилжин очно, тэгэхээр та командлалыг аваад Эльба арлыг чиглэн явж, Порто-Ферранд зогсож, маршал дээр очиж энэ захидлыг өгөөрэй, танд тэнд өөр захидал эсвэл ямар нэг даалгавар өгч магадгүй. Энэ даалгаврыг би авах ёстой байсан юм, харин одоо Дантес та миний орноос гүйцэтгээрэй. Тэгээд бүх гавъяа нь таных болно»

«Биелүүлье ахмад, харин маршал дээр орох тийм амаргүй байх болов уу даа?»

«Май энэ бөгжийг, түүнд дамжуулж өгөөрэй гэж хүсээрэй. Үүгээр бүхий л саад тотгорыг арилгана.» гэж ахмад хэлээд надад бөгж өгсөн. Түүнээс хойш хоёр цагийн дараа ухаан алдаж ойчоод, маргааш нь нас барсан даа.

- Тэгээд та яасан бэ?

- Миний хийх ёстой байсан тэр зүйлийг миний оронд хэн ч байсан бас хийх байсан байх. Нас барж байгаа хүний хүсэлт бол үргэлж ариун зүйл байдаг. Ялангуяа бидэнд, далайчдад, даргын хүсэлт бол биелүүлэхгүй байж болохгүй тушаал байдаг юм. Тэгээд би Эльба арлыг чиглэн явж маргааш нь хүч ирэв. Хүрч ирээд бусад хүмүүсээ онгоцон дээрээ орхиод ганцаараа эрэг дээр гарсан. Миний бодож байснаар намайг маршал дээр оруулахгүй гэсэн, тэгэхээр нь би таних тэмдэг болгож өгсөн өнөөх бөгжийг түүнд явуулсан, тэгтэл бүх зам нээлттэй болох нь тэр. Маршал намайг хүлээн аваад хөөрхий Леклерийн нас барсан тухай асууж ярилцаад, Леклерийн хэлснээр надад захидал өгч, түүнийг биеэрээ Парист хүргэж өгөөрэй гэж тушаасан. Энэ зүйл ахмадын маань эцсийн гуйлтад байсан болохоор би хүргэж өгнө гэж ам өгсөн. Тэгээд наашаа хүрч ирээд хөлөг онгоцон дээрх хамаг ажлаа эмхлэн цэгцлээд болзоот хүүхэн дээрээ гүйж хүрсэн. Тэр минь улам ч хонгор сайхан болчихсон юм шиг санагдлаа. Эрхэм Моррелийн дэмээр бид хоёр гүйцэтгэвэл зохих шашны бүх ёслолыг гүйцэтгэчихээд ширээний цаана сууж, нэг цагийн дараа гэр бүл болно, маргааш нь Парис явна гэж байтал миний адил та ч бас жигшин үзэж байгаа энэ ховын бичгээр намайг баривчлан аваад байгаа нь энэ.
- Аа, тийм байж гэж Вильфор дуугараад - Энэ бүхэн надад үнэн юм шиг санагдаж байна. Хэрвээ та ямар нэгэн юманд буруутай бол болгоомжгүйдээ л тэр, гэвч таны болгоомжгүй явдал чинь ахмадын тушаалаар зөвтгөгдөж байна. Эльба арал дээрээс авсан захидлаа бидэнд аль, тэгээд бидний дуудсан цагт хожимдолгүй ирнэ гэсэн м өгөөд нөхөд дээрээ очиж болно гэв.
- Тэгвэл би чөлөөтэй болов оо! гэж Дантес баярлан хашхирав.
- Тийм ээ, харин тэр захидлыг надад өгөөрэй.
- Тэр захидал танд байх ёстой, түүнийг миний бусад бичиг цаасуудын хамтаар хурааж авсан, тэр боодолтой юман дотор зарим нь байх шиг байна.
- Байзнаарай гээд Вильфор малгай бээлийгээ авах гэж байсан Дантесыг зогсоогоод - Байзаарай! Хэнд гэж хаягласан захидал вэ? гэж асуув.
- Эрхэм Нуартъед, Кок-Эрон гудамж, Парис хотонд гэж хаягласан байсан.

Вильфорын дээрээс цахилгаан буудаг юм гэхэд ийм хурдан, нам цохихгүй байсан байх. Зөөлөн сандал дээр суун туссанаа, Дантесаас хурааж авсан боодолтой бичиг цаасыг авах гэж өндийгөөд, галзуурсан мэт онгичин өнөөх гайтай захидлыг гарган ирж өгүүлж баршгүй айсан харцаар түүнийг ширтэв.

Түүний царай улам их зэвхийрэн,

- Эрхэм Нуартъед, Кок Эрон гудамж, гучдугаар байшин гэж шивгэнэн уншихад гайхсан Дантес,
- Яг тийм, та түүнийг таньдаг юм уу? гэж хэлэв.
- Үгүй, вангийн үнэнч зарц, хуйвалдагчидтай танил байдаггүй юм гэж Вильфор яаран хариулав.
- Тэгвэл хуйвалдааны тухай хэрэг болж байх шив? Гэж Дантес асуув. Тэр өөрийгөө эрх чөлөөтэй боллоо гэж үзэж байснаа хэрэг явдал өөрөөр эргэж байхыг мэдэрч - Би энэ захидлын дотор бичсэн зүйлийн утгыг мэдэхгүй гэж танд хэлсэн билээ гэв.
- Тийм ээ гэж Вильфор бүдэгхэн дуугаар хэлээд
- Гэвч та тэр захидал хаягласан хүний нэрийг мэднэ шүү дээ! гэлээ.
- Би захидлыг эзэнд нь биеэрээ өгөх байсан тул нэрийг нь мэдэх ёстой байсан юм.
- Тэгээд та, үүнийг өөр хэнд ч үзүүлээгүй юу? гэж уг захидлыг унших зуур Вильфор улам улам царай нь зэвхийрэн асуулаа.
- Хэнд ч үгүй, нэр төрөө барьж тангараглая!
- Таныг Эльба арал дээрээс эрхэм Нуартъед хүргэж өгөхөөр захидал авсныг хэнч мэдээгүй юу?
- Надад өгсөн хүнээс өөр хэн ч мэдэхгүй.
- Энэ чинь бас л олон хүн мэдэж байгаа хэрэг! гэж Вильфор дотроо шивгэнэнэ.

Захидлыг цааш унших тусам царай нь улам улам барайж зэвхий уруул, чичирсэн гар, гялалзаж байгаа нүд нь Дантест хамгийн муухай совин төрүүлнэ.

Вильфор захидлаа уншиж дуусаад толгойгоо барьж дуугүй суув.

- Эрхэм та яав? Гэж Дантес хулгасхийн асуув.

Вильфор хариу дуугарсангүй, зэвхийрсэн эвгүй царай гаргаж захидлыг дахин уншив.

- Та захидлын утгыг огт мэдэхгүй гэдэг чинь бүр үнэн үү? Гэж Вильфор хэлэв.
- Юу ч мэдэхгүй гэдгээ дахин нэр төрөө барьж тангараглая. Та юу болов оо? Танд эвгүй оргиж байна уу? Би хүн дуудах уу?
- Үгүй гэж Вильфор түргэн хэлээд босож - Байрандаа зогсоод дуугүй байж бай, энд чинь та захирдаг юм биш, би захирдаг юм гэж хэлэв.

Дантес гоморхсон байдалтайгаар,

- Уучлаарай, би зөвхөн танд туслах л гэсэн юм гэхэд,
- Надад юу ч хэрэггүй. Түр зуурын ядрал, өөр юм байхгүй. Харин миний тухай бодохоос өөрийнхөө тухай бод. Хариулаад бай гэв

Дантес асуултыг хүлээсэн боловч дэмий болжээ. Вильфор зөөлөн сандалдаа шигдэн суугаад, сульдсан гараар нүүрнийхээ хөлсийг арчиж, өнөөх захидлыг гурав дахь удаагаа уншив.

- Хэрэв энэ хүн захидал дотор юу бичсэнийг мэдэж байгаа бол яана. Хэрвээ Нуартье гэдэг чинь Вильфорын эцэг юм гэдгийг хэзээ нэгэн цагт мэдвэл, би эргэлт буцалтгүй өнгөрөх нь тэр! гэж шивгэнэнэ.

Тэгээд Вильфор, амаараа дуугарч хэлээгүй боловч зүрхэн дотроо хадгалж байж мэдэх нууцыг нь шинжин мэдэх гэсэн шиг Дантес өөд байн байн ширтэн харна.

- Эргэлзэх юмгүй! гэж тэрээр гэнэт дуу алдав.
- Бурхан тэнгэрийг бодож хэрвээ та надад эргэлзэж байгаа бол, хэрвээ та намайг сэжиглэж байгаа бол асууж байцаа л даа. Би танд хариулахад бэлхэн байна гэж хөөрхий залуу хэллээ.

Вильфор биеэ барин байж албаар итгэлтэй маяг үзүүлсэн дуугаар,

- Таны өчиг мэдүүлгээс үзэхэд танд хамгийн хүнд ял ногдож байна. Ийм учраас анх бодож байсан шигээ таныг дор нь суллаад явуулчих эрх алга. Ийм алхам хийхийн тулд би юуны уоёд мөрдөн байцаагчтай уулзах ёстой. Харин одоохондоо би танд ямар байсныг та өөрөө харсан шүү гэж хэлэв.
- Өө, тэгэлгүй яахав би танд баярлаж байна! гэж Дантес дуу алдаад - Надтай та шүүгчийн ёсоор биш, харин сайн нөхрийн ёсоор харьцсан шүү дээ гэв.

- За тэгэхээр таныг энд жаахан байлгах болно, удахгүй байх гэж бодож байна. Таны эсрэг гол эд мөрийн баримт бол энэ захидал байна. Тэгэхээр та харж бай л даа... гээд Вильфор задгай зуухандаа өнөөх захидлыг хаяж орхиод шатаж дуустал нь харж байв.
- Та харж байгаа биз дээ, би үүнийг устгачихлаа гэж үргэлжлүүлэн хэлэв.
- Та бол үнэн шударгын шүүхээс ч илүү ачтай хүн юм. Та тэр чигээрээ хайр биеэрээ байна! гэж Дантес дуу алдав.
- Гэхдээ та миний хэлэхийг дуулж бай гэж Вильфор хэлээд- Намайг ингэснээс хойш та надад итгэж болно биз дээ гэв.
- Тушаах л юм байвал тушаагаарай, би таны тушаалыг биелүүлнэ гэхэд Вильфор Дантест дөхөж очоод,
- Үгүй, би танд тушаал өгөх гээгүй, харин зөвлөлгөө өгөх гэсэн юм, ойлгож байгаа биз? Гэж хэлэв.
- Хэл л дээ, би таны зөвлөн хэлсэн зүйлийг тушаал шиг л биелүүлнэ.
- Би таныг энэ шүүхийн байшинд үдэш болтол байхаар орхиё. Таныг өөр хүн ирж байцааж ч магадгүй. Тэгвэл надад ярьсан бүх зүйлээ хэлээрэй харин захидлын тухай нэг ч үг бүү дуугараарай!
- Ам тангараг өгье, эрхэм минь.

Одоо бол Вильфор гуйж, хэрэгтэн нь шүүгчээ

тайтгаруулж байгаа юм шиг байв. Вильфор захидал дүрстэй хэвээрээ байгаа үнсийг харж,

- Захидал устаж алга болсныг та ойлгож байгаа биз. Ийм захидал байсан гэдгийг та бид хоёр л мэднэ. Үүнийг танд хэн ч хэзээ ч үзүүлж тулгаж чадахгүй, хэрвээ захидлын тухай танаас хүн асуувал, үгүй л гээд байгаарай, зоригтойхон шийг үгүйсгээд байвал та аврагдана гэж хэлэв.
- Би үгүйсгэн, та сэтгэлээ бүү зов гэж Дантес хэлэхэд, Вильфор
- Сайн байна гээд хонхоо дарах гэснээ больж - Танд ганцх н энэ л захидал байсан уу? гэж асуув.
- Ганцхан энэ.
- Тангарагла!

Дантес гараа өргөж,

- Тангараглая гэж хэлэв.

Вильфор хонх дуугаргахад цагдаагийн комиссар орж ирэв.

Вильфор түүний чихэнд хэдэн үг шивгэнэн хэлэхэд цаадах нь хариу толгой дохив. Тэгээд Вильфор Дантест,

- Комиссарыг дагаад яв гэж хэлэв.

Дантес мэхэсхийх ёслоод Вильфор өөд баярласан нүдээр дахин нэг харчихаад гарч одов.

Дөнгөж хаалга хаагдмагц Вильфор тамир нь гэнэт тасарсан юм шиг зөөлөн сандал дээрээ бараг ухаангүй унав.

Тэгээд нэг минутын дараа,

- Бурхан минь! Амьдрал, аз жаргал гэдэг чинь ийм л юмнаас шалтгаалдаг байна шүү дээ! Хэрвээ вангийн прокурор Марсельд байсан бол яана... Тэгвэл энэ бузар захидал намайг газрын агваар тонилгочих байсан! Ай, эцэг минь, эцэг минь! Чи газар дэлхий дээрх миний жаргалд үргэлж саад болж байх юм гэж үү? Би таны өнгөрсөн үеийн явдалтай цаг үргэлжид тэмцэж байх гэж үү? Гэв.

Гэвч түүний ухаан гэнэт сэргэж ярвайсан уруул дээр нь инээмсэглэл тодорч, төөрөлдөн мэдэрсэн харц нь төвлөрөн, ямар нэгэн юм бодож олсон мэт болов.

- Тийм, тийм намайг алах гэж байсан энэ захидал миний жаргалын эх булаг болж болно... За, Вильфор минь ажилд ор! гэж хашхирав.

Тэгээд үүдний өрөөнд хэрэгтнийг алга байхыг мэдээд вангийн прокурорын туслах тэр даруй гарч болзоот хүүхнийхээ гэр өөд яаран алхлав.

2. Иф цайз

Цагдаагийн комиссар үүдний өрөөнд оронгуутаа хоёр цагдаад дохио өгөв. Тэ° хоёрын нэг нь Дантесын баруун талд, нөгөөх нь зүүн талд нь зогсов. Шүүхийн байшин уруу ордог үүд нээгдэж чичрэн дагжих ямарч шалтгаангүй хүн ч гэсэн чичрэн дагжмаар болдог урт баргар гудмуудын нэгээр баригдсан хүнийг туулаа. Вильфорын гэр шүүхийн байшинтай залгаа байдгийн адил шүүхийн

байшин баргар муухай шоронтой залгаа байдаг ажээ. Түүний өмнө сүндэрлэн байдаг Аккульскийн хонхот гонхон өөдөөс нь харж гялалзан байна.

Дантес гудмаар хэдэн булан тойрон явснаа сараалжин цонхтой хаалга байхыг харав. Комиссар төмөр алхаар цохиж байх шиг болов. Хаалга онгойж, орж зүрхлэхгүй гайхан зогсож байгаа баригдсан хүнийг цагдаа нар аяархан түлхэж оруулав. Дантесыг босго алхмагц ард нь хаалга түрхийн хаагдав. Тэр өөр чийгтэй хүнд агаараар амьсгалж, ингээд шоронд оржээ.

Овоо цэвэрхэн өрөө боловч том түгжээтэй, цонхондоо тортой ажээ. Шинэ байр нь түүнийг төдий л их айлгасангүй, түүний хамт вангийн прокурорын туслахын илэрхий сэтгэл зовон халамжилсан байдалтай хэлсэн үг нь найдлага төрүүлэн сэтгэлийг нь уужруулан чихэнд нь сонстоно.

Дантесыг шоронгийн өрөөнд авчрахад өдрийн дөрвөн цаг болж байв. Энэ явдал бидний дээр бичсэн ёсоор хоёрдугаар сарын 28-нд болсон учир төдий л удалгүй бүрэнхий болов.

Тэр даруй чих нь улам илүү сайн сонсох боллоо. Өчүүхэн чимээ сонсох бүр эрх чөлөө олгох гэж ирж байна уу гэж босон харайж ухасхийнэ. Гэвч иг чимээ нь өөр зүгт алга болоход Дантес дахин сандал дээрээ сууна.

Эцсийн эцэст, үдшийн арван цагийн үед Дантесын горьдлого тасарч байтал дахин чимээ гарч, энэ удаа түүний өрөө уруу мадаггүй ойртон ирэв. Дараа нь гудамд хөлийн чимээ гарч, үүдэнд хүмүүс ирж зогсоод, цоож түлхэж, түгжээ хиханан зузаан царсан хаалга нээгдэж, харанхуй тасалгаан дотор хоёр бамбарын хурц гэрэл нүд гялбуулан тусав.

Бамбарын гэрэлд дөрвөн цагдаагийн зэвсэг ба урт сэлэм гялалзан харагдав.

Дантес урагшаа ухасхийсэн боловч ингэж хүч нэмэгдүүлсэн хамгаалал ирсэн байхыг хараад тэр дороо зогсов.

- Та нар намайг авах гэж ирэв үү? Гэж Дантес асуухад нэгэн цагдаа,
- Тийм ээ гэж хариулав.
- Вангийн прокурорын туслахын тушаалаар уу?
- Мэдээж хэрэг.
- За тэгвэл сайн, би та нарыг дагаж явахад бэлхэн байна гэж Дантес хэлэв.

Вильфорын нэрийн өмнөөс ирлээ гэж итгэсэн явдал хөөрхий залуугийн эргэлзээг арилгаж, өөрөө ухасхийн гарч цагдаа нарын дунд орж зогсов.

Шоронгийн үүдэнд сүйх тэрэг зогсож, дэлбэгчийн суудал дээр хөтөч, хөтчийн хажууд харгалзагч сууж байв.

- Надад ирсэн сүйх үү? Гэж Дантес асуухад цагдаагийн нэг,
- Танд ирүүлсэн юм. Суугтун гэж хариулав.

Дантес юм хэлэх гэтэл хаалга нь нээгдэж түүнийг сүйх тэрэг уруу хүчээр түлхэн оруулав. Эсэргүүцэж чадсангүй, эсэргүүцэхийг ч хүрсэнгүй, эгшин зуурын яотор арын суудал дээр хоёр цагдаагийн дунд орчхов. Өөр хоёр цагдаа өөдөөс нь харж суугаад, хүнд тэрэг зэвүүн муухайгаар түчигнэн дуугарч өнхрөв.

Хоригдол цонх өөд нь харахад төмөр тороор торлочихсон байв. Зөвхөн шоронгоо өөрчилж, шинэ шорон нь дугуйтай бөгөөд үл мэдэх нэгэн чигийг барин давхина. Дөнгөж гар орж болохоор ойрхон хадсан төмөр торны завсраар Дантес харахад Кессари гудамжаар, дараа нь Сен Лоран, Тарамис гудамжаар орж далайн эрэг уруу буув.

Түүнээс хойш бага зэрэг хугацаа өнгөрсний дараа цонхны сараалж ба дэргэдүүр нь гарсан дурсгалын хөшөөний хаалтын завсраар буудлын захиргааны гэрлийг харав.

Сүйх тэрэг зогсож харгалзагч үсрэн буугаад харуулын байшинд хүрч очиход, тэндээс арваад цэрэг гарч хоёр эгнээ болон зогсов. Тэдний зэр зэвсэг, тэнгисийн эрэг дээрх дэнлүүний гэрэлд гялалзана.

«Энэ бүгд намайг л гэж ингэж байгаа хэрэг үү?» гэж Дантес дотроо бодов.

Харгалзагч хаалгы нь түлхүүрээр онгойлгоод энэ асуултад нь хариулсан мэт дуугүй зогсоход сүйх тэрэгнээс эрэг хүртэл хоёр эгнэн жагссан цэргүүдийн хооронд түүнд зориулсан нарийхан зурвас зай үлдсэн байхыг Дантес харав.

Урд талын сандал дээр сууж байсан хоёр цагдаа сүйх тэрэгнээс түрүүлэн гарахад Эдмон тэдний хойноос түүний хоёр талд сууж байсан хоёр нь дагаж гарав. Тэд цөмөөрөө гаалийн үйлчлэгч гинжнээс нь барин зогсож байсан завь уруу очив. Цэргүүд Дантесыг сонирхон сэм харцгаана. Түүнийг тэр дор нь дөрвөн цагдаагийн дунд жолоон дээр суулгаад харгалзагч өөрөө завийн хошуун дээр суув. Завийг хүчтэй түлхэж эргээс холдуулан дөрвөн сэлүүрч Пилоныг чиглэн түргэн сэлүүрдэж гарав. Завь дээрээс хашхирсан дуугаар, буудлыг хааж байсан гинж доош унаж, Дантес, Фриул буюу өөрөөр хэлбэл усан буудлын гадна талд гарчхав.

Баригдсан хүн цэвэр агаарт гараад анх мэдэрсэн зүйл нь бол баяр хөөрийн сэтгэгдэл байв. Агаар гэдэг бол бараг л эрх чөлөө гэсэн үг. Дантес шөнийн тэнгисийн сайхан үнэрийг шингээсэн амьдруулагч агаарыг цээж дүүрэн амьсгалав. Гэвч удалгүй гунигтайгаар санаа алдав. Удсан ч үгүй өглөөхөн нь тийм их аз жаргалтай сууж байсан «Нөөц»-ийн хажуугаар өнгөрөв. Хурц гэрэлтэй цонхоор нь хөгжилтэй бүжгийн дуу сонстоно.

Дантес гараа зөрүүлэн тэнгэр өөд харан залбирч эхлэв.

Завь цаашаа явсаар Амьгүй толгой гэдгийг өнгөрөн Фаро хэмээх булантай зэрэгцэн даланг тойрон гарахад, Дантес ямарч учрыг олохгүй явав. Тэгээд нэг цагдаагаас,

- Намайг хааш нь аваачиж яваа юм бэ? Гэж асуув.
- Одоохон та мэднэ.
- Гэлээ ч гэсэн...
- Тантай ярихыг бидэнд хориглосон.

Дантес хагас цэрэгжсэн хүн байсан учир өөртэй нь ярихыг цагдаа нарт хориглосон гэхээр юм асууж шалгаах нь тэнэг хэрэг гээд дуугүй болов.

Тэгэхэд түүний толгойд хамгийн хачин бодол төрөв. Найдваргүй муу завиар хаана ч хүрэх юм билээ, зангуугаа өргөж аянд гарахаар бэлтгэсэн нэг ч хөлөг онгоц ойр хавь байхгүй байв. Тэгэхэд өөрийг нь алслагдсан нэг эрэг дээр гаргаж одоо чөлөөтэй боллоо гСж суллах юм байлгүй гэж бодож явч. Түүнийг хүлсэн ч үгүй, гарт нь гав зүүх ч гэсэнгүй. Энэ бүхэн нь түүнд сайны ёр шиг санагдав. Түүний зэрэгцээгээр прокурорын туслах, Нуартъегийн гайтай нэрийг хэлэхгүй л явбал айх юм байхгүй гэж хэлсэн биш билүү? Түүний эсрэг эд мөрийн ганц баримт болох захидлыг Вильфор нүдний нь өмнө шатаачихсан шүү дээ.

Тэр энэ бүхнийг юугаар төгсөх бол гэж чимээгүй хүлээн, харанхуйн дотор газрын баримжаа олж сурсан далайчийн нүдээр орчин тойрноо ажиглахыг хичээж явна.

Гэрэлт цамхаг асаж байсан Ратонно арал баруун талд нь хоцорч, завь эргийг дагаж явсаар Каталаны буланд хүрч ирэв. Баригдсан хүний харц улам хурц болж, энд Мерседес суудаг байсан учир харанхуй эрэг дээр эмэгтэй хүний бараан дүрс шиг үзэгдэх шиг болно.

Хайртай хар хүү нь өөрөөс нь гуравхан зуун алхмын зайтай байгааг Мерседест совин нь хэлэхгүй байж яахан чадах билээ.

Бүх Каталанд ганцхан цонх гэрэлтэй байв. Дантес сайн ажиглан харвал тэр нь болзоот хүүхнийх нь өрөө мөн болохыг танив. Энэ сууринд ганцхан Мерседес л унтсангүй. Хэрвээ чангахан шиг хашхирчихвал дуу нь Мерседест сонстох байсан биз. Гэвч нэрэлхээд тэгж чадсангүй. Хэрвээ галзуурсан юм шиг хашхирвал цагдаа нар юу гэх билээ? .Ийм учраас амаа ч ангайсангүй, харин тэртээ тэндэх гэрлээс нүд салгалгүй ширтэн х рсаар өнгөрөв.

Тэр завсар завь урагшлан явж байсан боловч, баригдсан хүн завийн тухай болсонгүй, Мерседесийн тухай л бодож яваа. Тэгтэл гэрэлтэй цонх гозгор том хадны цаагуур далд орж харагдахгүй болов. Дантес эргэн харж завь эргээс холдон явж байгааг мэдэв.

Түүнийг бодолдоо автан байх зуур сэлүүрээ дарвуулаар сольж, завь нь салхины эрчээр явж байв.

Дантес хэдийгээр цагдаагаас асууж шалгаах гээгүй боловч,түүн уруу дөхөж суугаад гараас нь барьж,

- Нөхдөө! Та нар ба та нарын цэрэг нэрийг барьж гуйя. Та нар намайг өрөвдөн хайрлаж надад хариу хэлж өгөөч. Би бол ахмад Дантес, хэдийгээр намайг ямар наган урвасан хэрэгт сэрдсэн боловч би сайн сэтгэлтэй, үнэнч франц хүн. Та нар намайг хааш нь аваачих гэж байгаа юм бэ? Үүргээ биелүүлж, хувь заяаныхаа аяыг дагана гэдгээ далайчны ёсоор амлая. Надад хэлээд өгөөч дээ! гэв.

Цагдаа шилээ маажгаад нөхөр өөдөө харав. Цаадах нь «Одоо ч хэлж болох болсон байх» гэсэн мэт хөдөлгөөн үзүүлэхэд цагдаа Дантес өөд эргэж,

- Та Марьсельд төрсөн далайчин хүн байж, бид хаашаа явж байна гэж асууна гэнэ ээ? Гэв.
- Тийм ээ, би үнэндээ мэдэхгүй байна.
- Та тааварлаж чадахгүй байна уу?
- Үгүй.
- Арай ч дээ.
- Энэ дэлхий дээрх ариун бүхнийг барьж тангараглая. Бурхныг бодож хэлж өгөөч!
- Аа, тушаал яах вэ?

- Арван минут, хагас цаг магадгүй цагийн дараа мэдэх тэр зүйлийг надад хэлж болохгүй гэж та нар харж байгаа биз дээ. Тэгээд энэ ч бүр бололцоогүй хэрэг. Бид хаашаа явж байна вэ?

- Та эсвэл сохорчихсон байх, эсвэл Марселийн усан буудлаас огт гарч үзээгүй байх, тэрнээс хаашаа явж байгаагаа тааварлан мэдэхгүй байж яаж болох вэ.

- Мэдэхгүй байна.

- Тэгвэл эргэн тойрноо хар л даа.

Дантес босож завины чиглэн явж байгаа тэр зүг өөд харахад өмнө нь зуун сажны газарт цохион дээр Иф цайз бараантан харагдаж байлаа.

Хачин гайхалтай энэ дүр, хязгааргүй их аймшгийг төрүүлэх энэ шорон, гурван зуун жилийн туршид марселийнханд хачин жигтэй үлгэр домог шиг дуртгал үлдээсэн энэ цайз Дантесын өмнө босож ирэхэд түүний тухай бодоо ч үгүй явсан Эдмонд цаазлагдах ял оноогдсон хүнд цаазны индрийн өмнө очиход нь төрдөг тэр аймшигт сэтгэл төрлөө.

- Бурхан минь! гэж дуу алдаад-Иф цайз уу? Бид яах гэж тийшээ явж байгаа юм бэ? Гэв.

Цагдаа инээмсэглэв.

- Үгүй намайг тэнд хорьж болохгүй шүү дээ! Иф цайз гэдэг чинь зөвхөн улс төрийн том хэрэгтнүүдэд зориулсан улсын шорон. Би ямар ч гэмт хэрэг хийгээгүй. Иф цайзан дотор ямар нэгэн мөрдөн байцаагч, шүүгч нар байдаг гэж үү? Гэж хэлэв.

- Миний мэдэж байгаагаар бол тэнд зөвхөн комендант, хуягууд, харуулын цэрэг, бас бат зузаан хана хэрэм байдаг юм. За боль, боль найз минь, гайхсан дүр бүү үзүүл, би таныг миний сайн сэтгэлийг инээн доромжилж байна гэж бодно шүү гэж цагдаа хэлэв.

Дантес цагдаагийн гарыг маш чанга атгасан нь гары нь золтой л бяцалчихсангүй.

- Та тэгээд намайг, Иф цайзад аваачиж тэнд нь орхих гэж байгаа юм уу?

- Тийм л болж байна. Гэвч та миний гарыг ийм чанга атгаад яах вэ гэж цагдаа хэлэв.

- Ямар ч мөрдөн байцаалтгүйгээр үү? Ямар ч ёс журам гүйцэтгэхгүйгээр үү?
- Эрхэм де Вильфор танд юу гэж амласан болохыг би мэдэхгүй юм гэж цагдаа хэлээд - Би зөвхөн Иф цайз өөд явж байгаага л мэдэж байна. Хүүе та яаж байна? Нөхдөө нааш ирээрэй бариад аваарай! гэв.

Дантес цахилгаан шиг хурдан хөдөлж тэнгис уруу үсрэн орох гэсэн боловч цагдаагийн туршлагатай нүднээс мултран гарч чадсангүй, хөл нь завины ёроолоос хөндийрөх тэрхэн үед хүчит дөрвөн гар түүнийг барьж авав.

Завин дотор унаж уурласандаа архирна.

- Ээ, дүү минь! гээд цагдаа түүнийг цээжин дээр өвдөглөн, - Далайчныхаа үгэнд хүрч байгаа чинь энэ үү! Тэгвэл ингээд тайван байж бай! За одоо эрхэм минь, хөдөлбөл чинь л духанд чинь сум зооно шүү! Би тушаалын нэгдүгээр зүйлд захирагдсангүй, гэвч бүү зов хоёрдугаархы нь яг биелүүлнэ гэж хэлэв.

Тэгээд үнэхээр бууны амаа Дантесын чамархайд тулгав. Дантес анхандаа үйлийн үргүй хөдөлж, өөрийг нь савардан авсан тэр азгүй явдлыг төгсгөл болгох гэж бодсон боловч энэ азгүй явдал нь гэнэт тохиолдсон болохоор төдий л удаан үргэлжлэхгүй байх гэж бодов. Дараа нь Вильфорын амласан үгийг санаж, бас завины ёроолд цагдаагийн гарт үхнэ гэдэг бол дэмий балай хэрэг гэж боджээ. Банзан дээгүүр унаж, арга нь барагдахдаа гараа хазав.

З вь юм хүчтэй мөргөж давилзав. Сэлүүрчдийн нэг нь завь хошуугаар а мөргөж зогссон хадан дээр үсрэн бууж, олсны эвхээс задрах нь сонстоход тэд завиа татаж байна гэдгийг Дантес ойлгов.

Түүний гараас нь барьж, заамдаж байсан цагдаа нар хүчээр босгож, эрэг дээр гаргаад цайзын хаалга уруу явсан шат өөд аваачив. Ар талд нь жадтай буугаар зэвсэглэсэн харгалзагч дагав.

Гэвч Дантес дэмий эсэргүүцсэнгүй. удаан хөдлөж байгаа нь эсэргүүцсэнээсээ болсон биш, харин санаанд ороогүйгээс болжээ. Толгой нь эргэж, согтуу хүн шиг гуйвна. Бас л эгц эрэг дээр хоёр эгнэн зогссон цэргүүдийг харсан бөгөөд шат нь албаар хөлөө өргөх болгож байгааг мэдэрч, хаалгаар хашаанд оронгуут нь араас нь хаагдахыг ажиглана. Энэ бүхэн нь юу ч ялган харж болшгүй манан дотор байгаа юм шиг бүүр түүр санагдана. Тэр бүү хэл хоригдлуудын зовлон зүдүүрийн эх булаг болсон тэнгисийг ч харсангүй. хоригдлууд түүний уудам төвшинг харж даван туулж гарах аргагүй гэдгээ аймшигтайгаар ухамсарч байдаг ажээ.

Минут хэртэй зогсох үед Дантес бага зэрэг ухаан орж орчин тойрныг харав. Тэр дөрвөн өндөр ханын дундах дөрвөлжин хашаан дотор зогсож байв. Манааны хүний нэгэн хэвийн жигд алхаа сонстож, хоёр гуравхан гэрэлтэй цонхны дэргэдүүр өнгөрөх бүрд зэвсэг нь гялалзана.

Тэд арваад минут хэртэй зогсов. Цагдаа нар Дантесыг зугтааж чадахгүй болсныг ойлгоод сул тавив. Тэд ямар нэгэн тушаал хүлээж байсан бололтой. Тэгтэл нэгэн хүний дуу гарч,

- Ба^оигдсан хүн хаана байна? гэж асуув.
- Энд байна гэж цагдаа нар хариулав.
- Намайг дагаад яваг, би өрөөнд нь оруулчихъя.
- Яваарай гэж хэлээд цагдаа нар Дантесыг түлхэв.

Эдмон өөрийг нь хагас газар доорх шоронгийн өрөөнд үнэхээр хүргэж өгсөн өнөөх замчийг дагаж явав. Цулгуй нойтон хананаас нь нулимс гоожих мэт санагдана. Өмхий тосон дотор гол нь хөвсөн, дөрвөлжин сандал дээрх дэнлүү энэ аймшигт урцын гөлгөр хана ба дагуулж ирсэн хүнийг гэрэлтүүлнэ. Энэ бол муу хувцастай, муухай царайтай хүн байв. Бодвол шоронгийн доод үйлчлэгчдийн нэг бололтой.

- Таны өнөө шөнөдөө хонох газар энэ гэж хэлээд
- Одоо орой болчихсон болохоор ноён комендант унтаад өгсөн. Маргааш өглөө босоод, таны тухай ирүүлсэн тушаалыг уншиж үзээд, танд өөр тасалгаа өгч магадгүй. Май, одоохондоо энэ талх ав, энэ аяган дотор ус бий, тэр буланд сүрэл байгаа. Хоригдолд өгч болох зүйл бол энэ. Сайхан нойрсоорой гэв.

Дантесыг түүнд хариу хэлэхээс өмнө, хуяг хаана талх тавьсныг ажиглаж авахаас өмнө, аягатай ус хаана байгааг харж авахаас өмнө, түүний дэвсгэр болох сүрэл хаясан булан өөд эргэж харахаас өмнө хуяг дэнлүүгээ авч, хаалга хааж, шоронгий нь нойтон ханыг харуулж өгсөн бүлэг гэрлээс хоригдлыг хагацаав.

Чимээ аниргүй харанхуйн дунд ганцаараа үлдэж, хэлгүй юм шиг үг дуугүй, уруу царайлан зогсоход халуу шатаж байгаа духан дээр нь үхээрийн муухай хүйтэн мэдрэгдэж байв.

Өглөөний нарны гэрэл энэ бузар ормыг гэрэлтүүлж эхлэх үед хуяг хоригдлыг энд нь байлгар тушаал авч ирэв. Дантес мөн л тэр газраа зогсож байлаа. Гагцхүү нүд нь уйлж ухилаагүй нулимснаас болж хавдсан байв. Тэр хөдөлсөн ч үгүй газар ширтэнэ.

Бүхэл шөнийг зогсоогоороо өнгөрүүлж, нэг минут ч дуг хийсэнгүй.

Хуяг орж ирээд, түүнд ойртож, тойрон харахад, Дантес түүнийг хараагүй юм шиг зогсож байв.

Хуяг мөрөнд нь хүрэхэд Дантес цочиж толгойгоо сэгсрэв.

- Та унтсангүй юу? гэж асуухад
- Мэдэхгүй гэж Дантес хариулав.

Хуяг түүн өөд гайхан харж,

- Та өлсөж байна уу? гэж үргэлжлүүлэн асуухад,
- Мэдэхгүй гэж Дантес давтан хэлэв.
- Танд юу ч хэрэггүй юу?
- Би коменданттай уулзахыг хүсэж байна.

Хуяг мөрөө хавчаад гарч одов.

Дантес түүний хойноос харж хагас онгорхой байгаа хаалга уруу гараа сарвайсан боловч хаалга хаагдчихлаа.

Тэгэхэд чангаар цохирон уйлав. Хураагдаад цугларч байсан нулимс сад тавин урсав. Сөхрөн суугаад, толгойгоороо шаланд наалдаж, өөрийнхөө бүх амьдралыг ухаан дотроо эрэгцүүлэн санаж, ийм хүнд хатуу цээрлэл хүлээхээр ямар гэмт хэргийг энэ бага залуу насандаа хийчхэв гэж өөрөөсөө асуун мөргөв.

Ингэж нэг өдөр өнгөрөв. Дантес хэдэн үмх талх арай ядан идээд, хэдэн балга ус уув. Заримдаа бодлого болон суух ба заримдаа төмөр торон доторх зэрлэг адгуус шиг ханаа даган тойрно.

Ялангуяа нэгэн бодол түүнийг байж ядтал зовооно. Хааш нь авч явааг ч мэдэхгүй, арчаагүй тайван сууж байсандорохноо арван удаа ч усанд үсрэн орж, Марсельд бараг толгой цохидог гарамгай сэлж шумбаж чаддаг чадвараа ашиглан усан доор нуугдаж хамгаалж явсан цагдаа нарыг хуураад, эрэг хүрч ямар нэгэн хоосон хүнгүй буланд нуугдаж, Генуэгийн буюу Каталаны хөлөг онгоц ирэхийг хүлээж байгаад, Итали эсвэл Испанид очиж, тэндээсээ Мерседесийгээ хүрч ир гэж захидал бичдэг байж гэж бодно. Гэдсээ тэжээх тухайд санаа зовсонгүй, хувь заяа түүнийг ямарч оронд аваачиж хаялаа гэсэн сайн далайчин хүн гэдэг ховор байдаг, тэр бол италиар тоскан хүн шиг, испаниар бол ёстой Кастилийн хүү шиг торолгүй ярина. Мерседес аав хоёртойгоо чөлөө жаргалтай амьдарч болох байжээ. Эцгээ

бас дуудаж аваачилгүй яахав. Гэтэл ингэхийнхээ оронд Иф цайзад түгжээстэй хоригдол, энэ гарч болшгүй шорон дотор, эцэг нь яасан, Мерседес нь ч яасныг мэдэхгүй сууж байдаг. Энэ бүхэн бол ганцхан Вильфорт итгэснээс болжээ. Галзуурч болох шалтгаан байсан учир Дантес хуягийн авчирч өгсөн шинэ сүрэл дээгүүр туучин харайлгав.

Маргааш нь мөн тэр цагт хуяг хүрч ирэв.

- За яав, бага зэрэг ухаан оров уу? гэж асуув.

Дантес хариу дуугарсангүй.

- За гунихрахаа боль! Та юу хүсэж байгаагаа хэлээрэй. За алив, хэлээч!

- Би коменданттай уулзахыг хүсэж байна.

- Энэ бололцоогүй хэрэг гэж би танд хэлсэн шүү дээ гэж хуяг арга ядсан байдалтай хэлэв.

- Яагаад бололцоогүй юм бэ?

- Яагаад гэвэл шоронгийн дотоод дүрэм ёсоор хоригдол хүн түүнтэй уулзаж болдоггүй юм.

- Тэгвэл энд юу зөвшөөрдөг юм бэ? Гэж Дантес асуув.

- Мөнгөөр нь арай дээр хоол унд олж өгч болно, зугаалга заримдаа ном шаардахыг зөвшөөрнө.

- Надад ном хэрэггүй зугаалахыг хүсэхгүй, хоол унд надад хангалттай санагдаж байна. Харин би ганцхан коменданттай уулзахыг л хүсэж байна.

- Хэрвээ таныг ингэж шалаад амрахгүй бол би танд хоол унд авчирч өгөхөө болино шүү.

- За яая гэхэв. Хэрвээ чи надад хоол унд авчирч өгөхөө больчихвол би өлсөөд л үхчихнэ, тэгээд л гүйцээ!

Дантесын энэ үгийг хэлсэн байдал нь, хуягт түүний хоригдол үхэх дуртай байгааг харуулав. Тэгэхээр хоригдол бүр хуягт өдөрт арван су-гийн орлого оруулдаг болохоор Дантесын хуяг түүнийг үхчихвэл гарч болох алдагдлаа бодож үзээд, нэлээд эелдгээр,

- Дуулж бай, таны хүсээд байгаа тэр зүйл чинь бололцоогүй юм. Тэгэхээр дахин гуйх хэрэггүй. Ер нь хоригдлын хүссэн ёсоор комендант өрөөнд нь ирж уулзаж байсан жишээ байхгүй. Ийм учраас та номхон бай, харин танд зугаалахыг зөвшөөрнө, тэгэхэд л ямар нэг аргаар коменданттай уулзахыг бод. Тэгээд л хэлэх юмаа хэл, харин таны асуултад хариулах эсэх нь тэр хүний хэрэг гэв.
- Ингэж уулзана гэж би хэдий болтол хүлээх вэ?
- Хэн мэдэх вэ? Сар, гурван сар, хагас жил, магадгүй жил ч болж байж мэднэ гэж хуяг хэлэв.
- Энэ ч дэндүү удаан байна. Би одоо л түүнтэй уулзах юмсан!
- Болохгүй юманд битгий зүтгээд бай, аягүй бол хоёр долоо хоногийн дараа галзуурч мэднэ шүү.
- Чи тэгж бодож байна уу? гэж Дантес асуув.
- Тийм ээ, галзуурна, ингэж л галзуурч эхэллээг юм. Манайд ийм нэг явдал тохиолдсон. Танаас өмнө энд нэг гэлэн сууж байсан юм. Өөрийгөө суллаж өгвөл сая франк өгнө гэж комендантаас шалаад байдаг байсан юм. Тэгээд л тэрүүгээрээ галзуурсан даа.
- Эндээс гараад удаж байна уу?
- Хоёр жил болж байна.
- Та нар түүнийг суллан тавьсан уу?
- Үгүй, чангаланд хорьчихсон.
- Хөөе, би гэлэн ч биш, галзуу хүн ч биш, би галзуурч болох л юм, харин одоохондоо эрүүл ухаантай байна, би чамд өөр юм өгье гэж Дантес хэлэв.
- Юу тэр вэ?
- Би чамд саяыг өгнө гэж хэлж чадахгүй, учир нь надад байхгүй, харин хэрвээ чамайг Марсель явахдаа Каталанд очиж, Мерседес гэдэг охинд захидал аваачиж өгөхийг зөвшөөрвөл би чамд зуун эко өгье... бүр захидлаа ч байг, хоёрхон мөр юм.
- Хэрвээ би тэр хоёр мөр юмыг чинь дамжуулан өгвөл намайг барьж авна, тэгэхээр би орлого ба хоолоо тооцохгүйгээр жилд мянган ливр авдаг

ажлаа алдана. Гурван зуун ливр авахын төлөө мянган ливрээ алдах юманд зориглоно гэвэл би тэнэг хүн болно биз дээ.

- За яах вэ! гэж Дантес хэлээд - За чи дуулж бай, сайн тогтоож аваарай, хэрвээ чи Мерседест зурвас аваачиж өгөхгүй буюу үгүй дээ л намайг энд байгааг түүнд мэдэгдэхгүй бол би чамайг хэзээ нэгэн цагт отож байгаад орж ирэхээр чинь энэ дөрвөлжин сандлаар тархийг чинь хага цохино доо! гэв.
- Өө, заналхийлж байна аа! гэж хуяг хашхираад алхам ухарч, хамгаалахад бэлтгэн, - Таны толгойд бас ч явдал байна, гэлэн тан шиг л ингэж эхэлсэн юм, гурав хоногийн дараа бас л түүн шиг сүйдэлж эхэлнэ дээ! Иф цайзад чангалан байдаг нь сайн хэрэг юм гэв.

Дантес мухар сандал авч толгой дээгүүрээ эргэлдүүлэв.

- За, за яах вэ, таныг тэгтлээ хүсээд байвал би комендантад хэлж өгье гэж хуяг хэлэв.

Хуяг гараад хэдэн минутын дараа дөрвөн цэрэг нэг бага даргатай хамт орж ирэв.

- Комендантын тушаал ёсоор, хоригдлыг доод давхарт оруул гэж хуяг хэлэв.
- Харанхуйд уу гэж бага дарга асуухад,
- Тийм ээ, харанхуйд, галзуу хүнийг галзуу хүнтэй нь хамт суулгах хэрэгтэй гэв.

Дөрвөн Дантесыг барьж авав, тэр нь алмайран, ямар ч эсэргүүцэлгүй тэднийг дагаж явав.

Тэд арван таван шат доошилж, харанхуй өрөөний үүд онгойход Дантес аман дотроо,

- Түүний зөв, галзуу хүнийг галзуу хүнтэй нь хамт суулгах хэрэгтэй юм гэж үглэсээр түүн уруу оров. Хаалга хаагдахад Дантес хананд хүрэн хүртэл гараа сунган урагш явав. Тэгээд буланд хөдлөлгүй удаан сууж тэр завсар нүд нь харанхуйд дасаж юм бага зэрэг ялган таних боллоо.

Хуяг эндүүрсэнгүй, Дантес галзуурдгийн даваан дээр байжээ.

9. Гэрлэх ёс гүйцэтгэсний орой

Бидний дээр хэлснээр Вильфор, Гран-Кур гудамж өөд дахин явж де Сен-Меран хатагтайн гэрт орвол зочид хоолны өрөөнд биш, харин зочдын өрөөнд кофе ууцгааж байв.

Рене ба бусад зочид түүнийг тэсэж ядан хүлээж байв. Тийм учраас тэд түүнийг баяр хөөртэй угтан авав. Зочдын нэг нь,

- За, толгой авагч, төрийн түшиг, роялист Брут! Юу болов? Яриад байгаарай! гэж машхирав.
- Шинэ харгислал бэлтгэгдэж байгаа юм биш биз дээ? гэж нөгөө нь асуув.
- Корсикийн махчин үүрнээсээ гараад ирсэн юм биш биз? Гэж гурав дахь нь асуув.

Вильфор өөрийн ирээдүйн хадам эхэд,

- Хатагтай, уучлаарай намайг, би танаас гарах зөвшөөрөл гуйх хэрэгтэй боллоо... Бэйлтэн танд хоёр үг аминчлан хэлэхийг зөвшөөрнө үү? Гэж Тэгвэл энэ чинь үнэхээрийн ноцтой хэрэг болж байна аа? гэж хэлэв.
- Маш ноцтой хэрэг, би та нарыг хэдэн өдөр орхиж явах ёстой боллоо. Үүнийг сонсоод та нар гэснээ Вильфор Рене руу хандаж - Маш чухал юм гэж мэдэж байгаа байх гэв.

Рене гомдсоноо нууж чадалгүй,

- Та явах нь уу? гэж дуу алдав.
- Тэгэхээс өөр аргагүй боллоо гэж Вильфор хариулахад, хатагтай,
- Хаашаа тэр вэ? гэж асуув.
- Энэ бол шүүхийн нууц. Гэвч та нарын хэн нэгэнд Парист захих юм байвал өнөөдөр миний сайн нөхөр тийшээ явна. Тэр та нарын захих зүйлийг дуртай хүлээн авна.

Хүмүүс гайхан бие бие өөдөө харцгаана.

- Та надтай ярих гэв үү? Гэж бэйл асуув.
- Тийм ээ, таныг зөвшөөрвөл тасалгаанд тань орьё. Бэйл, Вильфорыг сугадан хоёулаа гадагш гарав.

Бэйл өрөөндөө оронгоо,

- За юу болов? Ярь даа гэв.
- Намайг Парист явахыг шаардсан нэгэн чухал хэрэг гарлаа. Бэйл та намайг даруу биш, эв дүйгүй асуулт асуухад минь уулаарай. Танд улсын зээллэгийн тэмдэгтүүд бий юу?
- Миний бүх хөрөнгө л тэр дээ, зургаа долоон зуун мянган франкийнх бий.
- Тэгвэл түүнийгээ худалд, бэйл худалд. Тэгэхгүй бол та хоосорно шүү.
- Би түүнийг эндээс яаж худалдах билээ?
- Танд Парист гарын төлөөлөгч бий юу?
- Бий.
- Тэгвэл түүндээ надаар захидал явуул, нэгч минут, нэг ч хором алдалгүй худалдаг. Би дэндүү хожимдож очиж ч магадгүй.
- Чөтгөр ав! Цаг алдаад яах вэ! гэж бэйл хэлээд ширээндээ сууж, өөрийн төлөөлөгчид зээллэгийн бүх тэмдэгтүүдийг ямар ч үнээр хамаагүй худалд гэсэн захирамж бичив.
- Нэг захидал бэлхэн боллоо гэж хэлээд Вильфор захидлыг түрийвчиндээ нямбайлан хийгээд - Одоо надад өөр нэг захидал хэрэгтэй байна гэв.
- Хэнд?
- Ванд?
- Ванд ий?
- Тийм ээ. Би эрхэм дээд вантанд шууд бичиж чадахгүй шүү дээ.
- Тийм ээ, би таныг өөрөө бичиж өгөөч гэж байгаа юм биш, харин таныг де Сальвьё гүнгээр захидал бичүүлж өгөөч гэж хүсэж байгаа юм. Үнэт цагийг алдахгүйн тулд, надад шууд л ванд ямар ч элдвийн саад тотгоргүйгээр орж болох тийм захидал хэрэгтэй байна.
- Аа шүүх яамны сайд яагаа вэ? Тэр Тюильрид орох эрхтэй, тэгэхээр та түүгээр дамжуулан дуртай цагтаа ван дээр шууд орох зөвшөөрөл авч болно шүү дээ.
- Тийм л дээ. Гэсэн ч авч яваа тэр чухал үнэт мэдээгээ өөр хүнтэй хуваалцах хэрэг юу байна, та ойлгож байгаа биз дээ? Шүүх яамны сайд

намайг хойш нь түлхчихээд миний гавъяаг өөрөө сэм ашиглачих болно. Хэрвээ би Тюи«ьрид хамгийн түрүүнд очвол ванд хэзээ ч мартаггүйгээр тус хүргэж, үүгээр миний эрх тушаал хангагдах болно гэдэг ганц зүйлийг танд хэлье, бэйл минь,

- Хэрвээ тийм бол найз минь явж, замынхаа юмыг төхөөр, би Сальвьёг дуудъя, тэр танд нэвтрэх үнэмлэх болох захидал бичиж өгнө.
- За тэгвэл сайн байна, харин цаг бүү алдаарай, би арван таван минутын дараа шуудангийн сүйх тэргэнд суусан байх ёстой.
- Манай гэрийн гадаа тэргээ зогсоогоорой л доо.
- Та Сен-Меран хатагтай, охин хоёртоо миний өмнөөс ийм сайхан өдөр гүн харамсалтайгаар салж явахад хүрсэн явдалд минь уучлалт гуйна биз.
- Тэр хоёр таныг миний тасалгаанд хүлээх болно. Тэгэхээр та тэдэнтэй салах ёс гүйцэтгээрэй л дээ.
- Туйлын их баярлалаа. Тэгвэл та захидлаа бэлтгэж байгаарай.

Бэйл хонх дуугаргавал зарц орж ирэв.

- Гүн де Сальвьёг наашаа ирнэ үү гэж хэлээч... гээд бэйл Вильфорт - Харин та яв даа гэв.
- Би одоохон буцаад ирнэ.

Тэгээд Вильфор яаран гарснаа үүдэн дээр очоод, вангийн прокурорын туслах, яаран гүйж явбал бүхэл бүтэн хотын амгалан тайван байдлыг алдагдуулж болох юм гэж бодоод өөрийн ердийн ихэмсэг алхаагаар цааш явав.

Гэртээ хүрч ирэхэд нь харанхуй дотор ямар нэгэн цагаан дүрс түүнийг хүлээн хөдлөхгүй зогсож байхыг харав.

Тэр бол Мерседес байлаа. Эдмоныхоо тухай сураг чимээ сонстохгүй болохоор болзоот хар хүүг нь ямар учраас баривчилсныг мэдэхээр шийдэж иржээ.

Мерседес Ви«ьфорыг таниад зогсож байсан хананаасаа холдож замы нь боон тосов. Дантес болзоо! хүүхнийхээ тухай Вильфорт ярьс н болохоор Мерседес нэрээ хэлэх хэрэггүй байв. Тэгсэн тэгээгүй Вильфор танив. Охины үзэсгэлэн гоо түвшин сайхан байдал нь түүнийг гайхуулж охин болзоот хар хүүгийнхээ тухай асуухад, яллагч нь тэр охин, яллагдагч нь Вильфор өөрөө мэт түүнд санагджээ.

- Таны асууж байгаа тэр хүн бол хүнд хэрэгтэй, би түүний төлөө юу ч хийж чадахгүй гэж Вильфор хариулав.

Мерседес цорхирон уйлав. Вильфор хажуугаар нь өнгөрөх гэтэл түүнийг зогсоож,

- Үгүй, ядахдаа хаана байгаагий нь хэлж өгөөч, би түүний үхсэн, амьды нь мэдэх юм сан гэж хэлэхэд Вильфор,
- Мэдэхгүй. Тэр миний мэдлээс гарсан гэж хариулав.

Түүний нэвт шувт ширтэн харах харц, гуйн хүсэх хөдөлгөөн нь Вильфорт тээртэй санагдахад нь Мерседесийг хойш нь түлхээд байшиндаа орж энэ бүсгүйн гашуун зовлонгоос нь аль болох түргэн ангижрах гэсэн юм шиг хаалгаа түргэн гэгч хаачхав.

Гэвч гашуун зовлонг хөөн зайлуулах нь тийм ч амаргүй. Гашуун зовлонд нэрвэгдсэн хүн бол түүнийгээ үхлийн сум шиг авч явдаг. Вильфор хаалгаа түгжээд зочдынхоо өрөө өөд гарсан боловч хөл нь гуйвлан, эхэр татан уйлах адил чимээ цээжнээс нь гарч зөөлөн сандал дээр унав.

Тэгэхэд л үхлийн эмгэгийн анхны үүсвэр илрэн гарав. Хувийн нэр төрийн төлөө золиосонд гаргасан тэр залуу зөвхөн эцгийнх нь гэм буруугийн төлөө хохирсон юм. Цонхигор аймшигтай царайтай тэр залуу, мөн тийм цонхигор царайтай болзоот хүүхнээ сугадан өмнө нь гарч ирэх шиг болж, түүнд сэтгэлийн зовлон авчирна. Тэгэхдээ энэхүү сэтгэлийн зовлон нь гэнэт оволзон гардаг тэр зовлон биш, харин аажим алгуураар, үе үеэр авсанд ортол нь улам улам гүнзгий иддэг тийм зовиуртай үл ажиглагдам зовлон юм.

Вильфор дахин нэг эргэлзэх, сүүлийн минутыг үзэж өнгөрөв. Тэмцэлд догдлохоос өөр юу ч саналгүйгээр хэрэгтэн хүнд алах ял ногдуулахыг нэг биш удаа шаардаж байв. Түүний ниргэх адил уран гоё үгийн ачаар гүйцэтгэгдэж байсан энэ цааз нь түүний сэтгэлд өчүүхэн төдий ч сүүдэр тусгаагүй бөгөөд эдгээр хэрэгтнүүд нь үнэхээр буруу хэрэг хийсэн хүмүүс ч юмуу үгүйдээ л Вильфор тэднийг тийм буруутай хүмүүс гэж үздэг байв.

Гэвч энэ удаа шал өөр хэрэг боллоо. Жаргал эдлэх цаг нь ирж байсан гэмгүй залуу хүүг бүх насаар нь хорих ял ногдуулан шийтгэв. Вильфор түүнээс зөвхөн эрх чөлөөг нь булаан аваад зогсоогүй бас аз жаргалыг нь хамтад нь авчихлаа. Вильфор энэ удаа шүүгч биш, харин алуурч болжээ.

Энэ тухайгаа бодсоор урьд өмнө огт үзээгүй зовиурт цохилтыг амсав. Энэ нь түүний цээжинд дарамт болж, хэлж баршгүй аймшгаар зүрхий нь дүүргэнэ. Шархадсан хүн, шархаа аньтал цочин дагжихгүйгээр, цус нь шүүрэн, мах нь ил гарсан шархандаа хуруу хүргэж чаддаггүй билээ.

Гэвч Вильфорын шарх бол аньдаггүй анилаа гэхэд урьдынхаасаа улам их өвчин орж задрахаар эдгэрдэг тийм шарх юм.

Хэрвээ энэ үед Ренегийн зөөлөн дуу өршөөл энэрэл үзүүлээч гэж гуйн, Мерседес хойноос нь орж ирээд «Та биднийг харж байгаа бурхны нэрийн өмнөөс зүхэн тарнидъя. Миний хар хүүг минь буцаан өгөөч» гэж хэлсэн бол аргагүй болсон Вильфор бүрэн захирагдаж, өөрт нь ямарч аюул занал тохиолдохыг хайхрахгүйгээр Дантесыг суллах тухай тушаалд гарын үсэг зурах байсан биз. Гэвч энэ чимээ аниргүйн дундаас хэний ч дуу гарсангүй, харин хаалга онгойж үйлчлэгч орж ирж сүйх тэрэг аян замд гарахад бэлхэн болсныг мэдэгдэв.

Вильфор сэтгэл доторх тэмцлээ ялсан хүн шиг босож, үнэнээр нь хэлбэл босон харайж, мөнгөнийхөө авдраас бүх алтан зоосоо авч хармаандаа хийгээд, тасалгаан дотуураа нэг удаа тойрч, духныхаа хөлсийг гараараа арчаад аман дотроо эх захгүй олон юм буйтнан байснаа үйлчлэгч нь цув нөмрүүлснийг мэдээд гарч, сүйх тэргэндээ суугаад Гран Кур гудамж өөд, Сен Меран бэйлийнд орогч гэж огцомхон тушаав.

Хөөрхий Дантес эргэлт буцалтгүйгээр шийтгэгдэн ял эдлэх болжээ.

Де Сен-Меран амласан ёсоороо эхнэр охин хоёроо тасалгаандаа байлгаж байв. Залуу, Ренег хараад цочин дахиад л Дантесийн төлөө өршөөл гуйх бий гэж айв. Гэвч ашгүй тэгсэнгүй. Залуу охин болзоот хар хүүгийнхээ явах болсонд сэтгэл нь хөдлөн, үүнээс өөр юм бодсонгүй.

Тэр Вильфорт хайртай Вильфор хуримынхаа өмнөхөн хол газар явав. Чухам хэзээ ирэхээ сайн мэдэхгүй байв. Рене, Дантесийг харамсан өрөвдөхийн оронд болзоот хүнээс нь салгах болгосон тэр хэрэгтэнг хараан зүхэж байв.

Мерседес ямар байв аа!

Де-ла-Лож гудамжны буланд лүүнийг Фернан хүлээж байв. Тэгээд Мерседесийн хойноос дагаж ирэв. Мерседес Каталандаа хүрч ирээд дутуу үхсэн юм шиг орон дээрээ ухаангүй унав. Фернан орны нь өмнө сөхрөн суугаад, Мерседесийн хүйтэн гарыг барьж халуунаар үнсэх боловч, бүсгүй түүний нь мэдсэн ч үгүй.

Ингэж шөнийг өнгөрөөлөө. Дэнгийн тос шатаж дуусаад гэрэл унрав. Гэвч Мерседес гэрэл асаж байсныг ажиглан мэдээгүй шигээ, харанхуй болсныг бас мэдсэнгүй. Үүр цайж эхлэхийг ч бас мэдсэнгүй.

Уй гашуу нь түүний нүдийг бүрхэж ганцхан Эдмоноос өөр юу ч үл харагдана.

- Чи энд байгаа юм аа! гэж Мерседес Фернан өөд эргэж хараад хэлэв. Тэгэхэд Фернан гунигтайгаар санаа алдаж,

- Би өчигдрөөс хойш эндээс холдоогүй шүү гэж хариу хэлэв.

Моррель өөрийгөө ялагдсан гэж үзсэнгүй. Дантесыг байцаасны дараа шоронд хийсэн гэдгийг мэджээ. Тэгээд ямар нэгэн нөлөө бүхий өөрийн бүх найз нөхөд дээгүүр очиж уулзсан боловч Дантес бонапартын төлөөлөгч гэж баривчлагдсан гэдэг чимээ тархаж, тэр үед Наполеон ширээндээ эгж суух ямарч оролдлого явуулсан түүнийг нь хамгийн зоригтой хүмүүс ч гэсэн тэнэг хэрэг гэж үзэж байсан учир Моррель газар бүхэнд хүйтэн, аймхай харьцаа эсвэл татгалзах үг сонсож байв. Гайхаш нь барагдан цөхөрсөн амьтан гэртээ хүрч ирсэн бөгөөд хэн ч тусалж чадах чадалгүй юм гэдгийг ойлгожээ.

Кадрусс ч бас хэрэндээ их л сэтгэл зовж байв. Ямар ч ашиггүй боловч, Дантест тус хүргэх гэж Моррелж шиг хотоор гүйхийн оронд, гэртСэ хоёр шил дарс авч тавиад өөрийнхөө түгшин зовсон сэтгэлийг дарсанд далд хийхээр суув. Үймсэн сэтгэлийг нь дарахад хоёр шил дарс багаджээ.Тийм учраас гарч дарс авчирч ч чадахгүй, болсон явдлыг мартаж ч чадахгүй доголлон ширээн дээрх хоёр хоосон лонхны дунд тохойлдон сууж, тортогтож байгаа гэрэлд нүдэнд нь үзэгдэх мэт хий үзэгдлийг харж сууна.

Ганцхан Данглар л сэтгэл зовж, сандарсангүй. тэр ч байтугай баярлаж байжээ. Дайснаасаа өшөөгөө авч халагдчих вий гэж айж явсан «Фараон» дээрх тушаалдаа бат тогтон авчээ. Данглар бол чихнийхээ ард үзэг хавчуулан, зүрхнийхээ оронд бэхийн савтай төрдөг хариг нямбай хүмүүсийн нэг юм. Тэр бол энэ дэлхий дээрх юм бүхнийг өсгөн үржүүлэхийн үүднээс үзэж тооны тэмдгийг хүнээс ч илүү үзэж, тоо л нэмэгдэж байвал хүн хорогдоход сэтгэл зовдоггүй тийм хүн юм.

Ийм учраас Данглар унтдаг цагтаа тайван унтав.

Вильфор де Сальвьё гүнгээс баталгаа бичиг аваад Ренегийн хоёр хацрыг үнсэж, де Сен-Меран хатагтайн гарт уруулаа хүргээд, бээлтэй гар барьж, шуудангийн сүйх тэргэнд сууж Экс орох замаар давхин одов.

Гашуун зовлонд автагдсан өвгөн Дантес байж ядан сэтгэл түгшинэ.

Эдмоны тухайд гэвэл бид юу болсны нь мэднэ.

10. Тюильрийн бага тасалгаа

Гурван давхар хөлс төлөөд, Парисын замаар чинээгээр нь давхийлж яваа Вильфорыг орхиод, хоёр гурван зочдын өрөөг алгасан, хагас дугараг цонхтой, Наполеон ба XVIII Людовик, сүүлд нь Лун-Филипийн дуртай тасалгаа байснаараа нэрд гарсан тюильрийн бага тасалгаанд орёе.

Энэ тасалгаанд Гартвелиас авчирсан нэр алдартай хүмүүст байдагчлан учиргүй хайртай самрын модон ширээнийхээ цаана, XVIII Людовик ван буурал үстэй, язгууртан хүний царайтай гоёмсог хувцасласан тавь орчим насны нэгэн хүний яриаг сонсож суув. Тэгэхийн хамт Грифиусийн хэвлэсэн төдий л нарийн зөв биш Горацийн номын мөр дээгүүр юм тэмдэглэж байв. Тэр номыг эрхэм дээд эзэн уншиж хэлний шинжлэлийн ажиглалт хийхдээ ихээхэн тэжээл олж авдаг ажээ.

- Таны ярьж байгаагаар... гэж ван хэлэхэд,
- Миний сэтгэл их зовж байна, эрхэм дээд эзэн минь гэв.
- Нээрэн үү дээ? Танд долоон тарган, долоон туранхай үнээ зүүдлэгдсэн юм биш биз дээ.
- Үгүй, эрхэм дээд эзэн минь. Хэрэв тэгсэн бол элбэг дэлбэг долоон жил бидэнд тохиолдоно гэсэн үг л дээ. Эрхэм дээд эзэн тан шиг хашир вантай байхад өлсгөлөнгөөс айх юмгүй.
- Тэгвэл таны сэтгэлийг ямар юм зовоогоод байна вэ, хонгор Блакас?
- Эрхэм дээд эзэн минь, өмнөдөд аюулт цахилгаан хуралдаж байна гэж бодох үндэс байх шиг санагдаж байна.
- Энэ тухай ярьж байгаа бол эрхэм хан та тэр зүйлтэй муу танилцсан байна. Би бол тэнд тэнгэр маш сайхан байна гэж мэдэж байна гэж XVIII Людовик хариулав.

XVIII Людовик боловсролтой хүн байсан боловч, төдий л уран биш шог үгэнд дуртай ажээ.

- Өндөр дээд эзэнтэн минь үгүй ядахдаа үнэнч зарцынхаа сэтгэлийг тайвшруулахын тулд Лангедок, Прованс, Дофина гуравт итгэлтэй хүн явуулж, энэ гурван мужийн хүмүүсийн сэтгэл санааны байдалтай танилцахгүй юу гэж де балкас хэлэв.
- *Sanimus surdis* гэж ван Горацийн номон дээрээ юм тэмдэглэх завсар хэлэв.

Ордны түшмэл венузийн яруу найрагчийн хагас шүлэглэлийн учрыг ойлгосон дүр үзүүлэн мушгиад,

- Эрхэм дээд эзэн минь. Эрхэм дээд эзэн минь, таны Францын үнэнч шударгад итгэдэг таны зөв байж болох юм! гэвч ямар нэгэн арга нь барагдсан оролдлого гарахаас болгоомжилж байгаа минь тийм ч их буруугүй юм шиг надад бодогдож байна... гэж хэлэв.

- Хэний талаас тэр вэ?
- Бонапартын талаас эсвэл түүний намын талаас.
- Эрхэм Блакас, таны ингэж айгаад байгаа тань намайг ажил хийлгэхгүй байна.
- Аа таны тайван байдал миний унтахад саад болж байна.
- Байзаарай, эрхэм минь хүлээж байгаарай Pastor guum traheret□ -ын тухай маш сайхан тэмдэглэл миний санаанд орж ирлээ, байзаарай, дараа нь яриарай.

Чимээ аниргүй болж, хаан жижигхэн гээчийн үсгээр Горацийн хуудсан дээр хэдэн мөр юм бичив.

- Цааш нь яриарай, эрхэм хан гэж хэлээд ван хүний ярьсан зүйлд зүг чиг олгож өгсөн хүн шиг бардам байдлаар толгойгоо өндийлгөж- Цааш нь яриарай, би сонсож байна гэв. Тэгэхэд Вильфорын мэдээг ганцаараа ашиглах гэж горьдсон Блакас,
- Эрхэм дээд эзэн минь, хоосон яриа, дэмий болгоомжлол миний сэтгэлийг зовоогоогүй гэдгийг танд хэлэх ёстой. Сайн санаатай миний итгэлийг дүүрэн хүлээж, францын өмнө талд юу болж байгааг ажиглан харж байх үүргийг надаас авсан (хан энэ үгийг хэлэхдээ үл мэдэг түгдрэв.) хүн шуудангийн сүйх тэргээр давхин ирж, ванд аймшигтай аюул занал хийлж байна гэж хэллээ. Эрхэм дээд эзэн тан дээр яаран ирсний учир ийм байна гэж хэлэв.
- Mala ducis avi domum! гэж ван тэмдэглэлээ үргэлжлэн хэлэх зуур хэлэв.
- Би энэ зүйлийг танд орхичихвол, эрхэм дээд эзэн танд хэрэг болох болов уу?
- Үгүй, үгүй эрхэм хан харин гараа сунгаач...
- Алийг нь?
- Аль нь ч яах вэ, тэр зүүнээ...
- Энэ үү эрхэм дээд эзэн минь?
- Би танд зүүнээ гэж байхад, та баруунаа эрээд байх юм. Би миний зүүн гар талд байгааг чинь хэлж байна. Тийм тэнд, тэнд чинь цагдаагийн яамны сайдын өчигдөр ирүүлсэн мэдээлэл байгаа... За, Дандре өөрөө...

Та эрхэм Дандрег ирлээ гэж хэлэв үү? Гэж ван цагдаагийн яамны сайдыг ирснийг мэдэгдэх гэж орж ирсэн үйлчлэгчээс асуув.

- Тийм ээ, түшээ гүн Дандре гэж үйлчлэгч хариулав.
- Өө, түшээ гүн гээд XVIII Людовик үл мэдэг инээмсэглэн - Ор ор гүнтэн минь ноён Бонапартын тухай хамгийн сүүлчийн мэдээг ханд хэлж өгөөч. Байдал ямар ч хэцүү байлаа гэсэн юу ч нуулгүй хэлж өгөөрэй. Эльба арал гэдэг чинь галт уул, тэндээс дайн, bella, horrida, bella оргилж байна гэдэг үнэн үү?

Дандре хоёр гараараа сандлын арыг гангамсаг байдлаар тулж,

- Эрхэм дээд эзэн, та миний өчигдрийн мэдээллийг үзсэн болов уу? гэж асуув.
- Уншсан, уншсан, харин тэнд юу бичсэн байгааг олж харж чадахгүй байгаа ханд Ia өөрөө ярьж өг. Узурпатор, арал дээр юу хийж суугаа тухай тодорхой ярьж өгөөрэй гэхэд түшээ гүн ханд хандаж,
- Эрхэм дээд эзний бүх үнэнч зарц нар Эльба арал дээрээс авсан сүүлчийн мэдээнд баярлах ёстой. Бонапарт ... гэж хэлээд ямар нэгэн тайлбар уншиж сонирхоод толгойгоо ч өндийлгөхгүй байгаа XVIII Людовик өөд харснаа цааш үргэлжлүүлэн - Бонапарт үхтлээ уйдаж байна гэнэ. Тэр Порто-Лангоний минчдийн ажлыг бүхэл өдрийн турш харж зогсдог гэнэ гэхэд ван дээрээмс нь нэмж,
- Бас зугаацахын тул биеэ мааждаг юм байх гэж хэлэв.
- Биеэ мааждаг гэнэ ээ? Эрхэм дээд эзэн та юу хэлж байна вэ? гэж хан хэлэхэд,
- Энэ агуу их хүн, энэ баатар эр, энэ хагас бурхан хамуутай юм гэдгийг та мартчихаа юу? гэв.
- Хан тэр ч бага хэрэг узурпатор ойрын үед галзуурна гэдэгт бид бараг итгэж байна гэж хэлэв.
- Галзуурна ий?
- Гарцаагүй, түүний ухаан балартаж, заримдаа гашуунаар уйлах ба заримдаа хоолой мэдэн инээж байна гэнэ. Заримдаа бүтэн цагаар эрэг дээр сууж ус уруу чулуу шидэж, тэр нь тав зургаа дахин ус долоож үсэрвэл Маренго эсвэл Аустерлицийн дэргэд дахин ялалт хийсэн юм шиг

баярладаг гэнэ. Энэ бол галзуурлын илэрхий шинж тэмдэг мөн гэдгийг та нар зөвшөөрнө байх.

- Эсвэл цэцэн мэргэн ухааны шинж тэмдэг байдаг эрхэм түшээ гүн гэж XVIII Людовик инээж хэлээд - Эрт цагийн гарамгай жанжнууд завтай цагтаа усанд чулуу шидэж зугаацдаг байсан юм гэнэ лээ.

Плутархыг нээж Африкийн Сципионы амьдралыг үзээрэй гэв.

Сайд ван хоёр имй хайхрамжгүй байгааг хараад де Блакас бодлого болов. Вильфор хүнд ашиглуулчихгүйн тулд бүх нууцыг бүгдий нь хэлчхээгүй байж, гэвч түүнд бага биш болгоомжлох сэтгэл төрүүлэхэд хүрэлцээтэй зүйл хэлжээ.

- Дандре цааш нь яриарай гэж ван хэлээд - Блакас бас л итгэхгүй хэвээрээ байна, узурпатор үнэний замд яаж орж байгаа тухай ярьж өгөөч гэв.

Цагдаагийн яамны сайд мэхийн ёслов.

Хан вергилевийн малчид хоорондоо ярьж байгаа юм шиг ээлжлэн ярьж байгаа ван, Дандре хоёр өөд хараад,

- Үнэний зам гэнэ ээ гэж хэлснээ - узурпатор үнэний замд орсон гэнэ ээ? Гэж асуув.
- Эрхэм хан эргэлзэх юмгүй.
- Ямар замд тэр вэ?
- Сайн сайхны замд. Тайлбарлаж өг, түшээ гүн гэхэд, сайд үнэхээр нухацтай байдлаар,
- Ийм байна, хан. Наполеон саяхан үзлэг хийжээ. Тэгсэн чинь хуучин үглээчүүдээс хоёр гурав нь францдаа буцах хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Тэгэхээр нь тэднийг чөлөөлж, сайн сэтгэл ванд үнэнчээр зүтгээрэй гэж их л шаргуу зөвлөж явуулсан байна. Энэ бол түүний өөрийнх нь хэлсэн үг шүү, би баталж байна.
- За, Блакас ямар байна? Та үүнийг юу гэж үзэж байна? гэж ван өнөө дэлгээстэй байгаа том номноосоо салж, дийлсэн байдалтайгаар асуухад,
- Эрхэм дээд эзэн минь, бидний нэг нь л эндүүрч байна, эсвэл цагдаагийн эрхэм сайд, эсвэл би байх. Гэвч цагдаагийн сайд, эрхэм дээд эзэн таны нэр алдар, сайн сайхан баодлыг хамгаалж байгаа болохоор эрхэм сайд андуурч х ёсгүй, тэгэхээр би л андуурч таарлаа. Гэвч эрхэм эзэн таны

оронд би байсан сан бол миний тэр хэлсэн хүнээс асуух байсан даа. Түүгээр ч барахгүй эрхэм дээд эзэн таныг тэр хүнтэй уулзаж хайрлахыг танаас хүсэх байна.

- Хан таны заавраар хэнийг боловч би хүлээж авна. Гэвч би түүнийг гартаа буу барьж байж хүлээж авахыг хүсэж байна. Ноён сайд танд арай шинэ мэдээ байхгүй юу? Энүүн дээр чинь хоёрдугаар сарын хорин гэж бичсэн байна аа, өнөөдөр чинь гуравдугаар сарын гурван шүү дээ.
- Байхгүй, эрхэм дээд эзэн минь, харин одоохон л ирэх ёстой. Би өглөө л гэрээсээ гарсан, тэгэхээр мэдээ хүлээн авчихаад байгаа ч байж магадгүй.
- Яаман дээрээ оч, тэгээд хэрвээ мэдээ ирээгүй байвал... гээд Людовик инээж - Өөрсдөө ямар нэгэн юм зохиочихоод аваад ир, та нар тэгдэг биз дээ? гэв.
- Бурхан өршөөг, эрхэм минь бидэнд юу ч санаагаараа зохиох хэрэггүй гэж сайд хариулаад - Биднийг өдөр бүр янз бүрийн хов живийн бичгээр дараад байдаг юм. Эднийг ямар нэгэн тус хүргэж шагнал авах гэж хүсдэг үнэндээ ямар ч тус болдоггүй хүмүүс ирүүлдэг юм. Тэд аз тохиолдож, зөгнөн хэлсэн зүйлийг нь батлан нотлох болов уу гэж горьдож бичдэг юм.
- Сайн байна, яв яв, гэж ван хэлээд - Харин намайг хүлээж байгааг битгий мартаарай гэв.
- Эрхэм дээд эзэн минь би арван минутын дараа энд байх болно...
- Харин би явж, мэдээ хүргэж ирсэн хүнээ авчиръя, эрхэм дээд эзэн минь гэж Блакас хэлэв.
- Байз арай, байзаарай. Би таны сүлдийг солих болох нь, би танд мултран зайлах гэж дэмий оролдож байгаа олзоо сарвуундаа атгаж, далавчаа дэлгэсэн бүргэд өгье. «Чанга баздаг» гэдэг уриатай байна гэж ван хэлэв.
- Эрхэм дээд эзэн таны хэлснийг би сонсож байна гэж хан тэсэж ядан хумсаа мэрэн байж хариулав.
- Би тантай. Molli fugiens anhelitu гэдэг шүлгийн тухай зөвлөх гэсэн юм. Чононд хөөгдсөн бугын тухрай өгүүлдэг шүү дээ санаж байгаа биз. Та чинь анчин, оберегерментер хүн тэгэхээр энэ танд ямар санагдаж байна вэ?
- Их сайхан, эрхэм дээд эзэн минь. Харин надад мэдэ хүргэж ирсэн тэр хүн бол таны хэлж байгаа тэр бугатай адил юм. Тэр хүн хориод өртөө

газрыг шуудангийн сүйх тэргээр явж иржээ. Тэгэхдээ гурван өдөр ч хүрэлгүй явсан байна шүү.

- Ийм зүйлийг ямарч амьсгаа давхцахгүйгээр гурав дөрвөн цагийн дотор гүйцэтгэж чадах цахилгаан мэдээ байхад энэ бол илүү хөдөлмөр, илүүдээ гарсан сандрал байна даа.
- Эрхэм дээд эзэн таныг урдаас болгоомжлуулах гэж догдлон давхиж ирсэн залуу хүнийг та муу урамшуулж байна даа. Үгүй ядахдаа түүнийг надад явуулсан Сальвьё гүнг бодож тэр хүнийг хүлээж аваач дээ.
- Сальвьё гүн гэнэ ээ? Миний ахын ордны даамал уу?
- Мөн, тэр биеэрээ.
- Тийм тийм, Марсельд байдаг шүү дээ.
- Тэр тэндээс надад бичжээ.
- ТэгСэд энэ хуйвалдааны тухай бичээ юу?
- Үгүй эрхэм де Вильфорыг над руу батлан илгээж, эрхэм дээд эзэн тан дээр оруу«ахыг даалгасан байна.
- Вильфор ий! гэж ван дуугараад - Тэгээд түүнийг Вильфор гэдэг гэнэ ээ? Гэв.
- Тийм ээ, эзэн минь.
- Тэр Марселиас ирээ юу?
- Тийм ээ, биеэрээ ирсэн байна.
- Та тэгээд нэрийг нь шууд хэлэхгүй яав? Гээд вангийн царай дээр бага зэрэг зовсон шинж илрэв.
- Эрхэм дээд эзэн таныг нэрийг нь мэдэхгүй юм байх гэж бодсон юм.
- Үгүй, үгүй Блакас, энэ хүн бол ажил хэрэгч, сайн санаатай хамгийн гол нь нэр төрд дуртай хүн байгаа юм. Та түүний эцгийг мэднэ биз дээ. Үгүй ядахдаа л нэрээр нь...
- Эцгийг нь үү?
- Тийм ээ, Нуартъег.

- Жирондич уу? Сенатын гишүүн үү?
- Чухам яг тийм.
- Тэгээд эрхэм дээд эзэн та улсын чухал үүрэгт ажлыг тийм хүний хүүд итгэн өгсөн хэрэг үү?
- Блакас, найз нөхөр минь, та юу ч ойлгохгүй байна. Вильфор нэр төрд дуртай хүн гэдгийг танд хэлсэн шүү дээ. Нэр төр олж авахын тулд юугаа ч хайрлахгүй, тэр ч байтугай төрсөн эцгээ ч золиосонд нь гаргаж байгаа.
- Тэгвэл түүнийг нааш нь ирүүлэх үү?
- Одоохон ирүүл, тэр хаана байгаа юм бэ?
- Доор, миний сүйх тэргэнд хүлээж байгаа.
- Түүний хойноос яваарай.
- Одоохон гүйе.

Тэгээд хан залуу хүн шиг шалмаг гүйв. Жинхэнэ роялист сэтгэлийн хөдөлгөөн нь түүнд хорин настай хүүгийн хүч чадлыг өгчээ.

XVIII Людовик ганцаараа хоцроод дэлгээтэй байгаа Гораций уруугаа харж аман дотроо: «*Justum et tenacem propositum virum...*» гэж шивнэв.

Де Блакас гарсан шигээ тийм хурдан орж ирэв. Гэвч зочид хүлээх өрөөнд орж ирээд вангийн соёрхсоноор ингэж байгаа юм гэж хэлэхэд хүрэв. Вильфорын шороотой хувцас, хунар нь хааны ордны ёс дэглэмд тохирохгүй байсан учир де Брезе бээлийн дургүйг хүргэж, ийм байдалтайгаар ван дээр орох гэсэн залуу хүний бүдүүлгийг гайхав. Гэвч хан «Эрхэм дээд эзэн вангийн тушаалаар» гэдэг ганцхан үг хэлж бүх саад тотгорыг арилгасан бөгөөд, ёслол гүйцэтгүүлэгч дургүйцэн үглэсээр байсан боловч Вильфор вангийн тасалгаанд оров.

Ван, ханыг гарахад сууж байсан тэр газраа сууж байв. Вильфорыг хаалга онгойлгоход ван яг өмнө нь харагдав. Залуу өөрийн эрхгүй зогсов.

- Ор ор, эрхэм де Вильфор гэж ван хэлэв.

Вильфор мэхийн ёслоод урагш хэд алхаж, ван юу асуух бол хэмээх хүлээж зогсов.

- Эрхэм де Вильфор, бидэнд мэдэгдэх ямар нэгэн чухал зүйл танд бий гэж Блакас хэлсэн хэмээн XVIII Людовик хэлэв.

- Эзэн минь ханы хэлсэн үнэн, эрхэм дээд эзэн та ч гэсэн түүнтэй санал нийлэх байх гэж би найдаж байна.
- Надад итгүүлэх гээд байгаа тэр аюул чинь тийм их сүрхий юм уу?
- Эрхэм дээд эзэн минь, би түүнийг сүрхий ноцтой хэрэг гэж үзэж байна, гэвч яаран ирсний минь ачаар тэр аюулыг урдаас болгоомжлон зогсоож болно.
- Тодорхой яриарай битгий зов гэж ван хэлээд ханы нүүрэн дээрх, Вильфорын дуун дахь догдолсон байдал ванд нөлөөлж - Яриарай, харин тэгэхдээ бүр эхнээс нь яриарай, би юм бүхэн эмх цэгцтэй байхад дуртай гэж хэлэв.
- Эрхэм дээд эзэн танд торохой гарган хэлье. Гэвч сандарч зовсон байдал үгийн утг»г бага зэрэг бүрхэгдүүлэхэд хүрвэл уучлаарай гэж хэлээд Вильфор ван өөд харвал, ван эелдгээр хандаж байгаа нь илэрхий тул цааш үргэлжлүүлэн - Би эрхэм дээд эзэн танд, хүн зон цэргийн доорд хэсэгт өдөр бүр гарч байдаг ердийн хоосон хов живийн тухай биш, харин эрхэм дээд эзэн таны титэмд аюул занал учруулж болох жинхэнэ хуйвалдааны тухай үүргийнхээ дагуу айлтгахаар Парист яаран яаран хүрч ирсэн юм. Узурпатор гурван хөлөг онгоцыг зэвсэглэж ямар нэгэн хэрэг явдал үүсгэж байна. Энэ нь магадгүй, ухаангүй дэмий ч хэрэг байж болно. Хэдий тийм боловч аюултай юм. Яг энэ үеэр Эльба арлыг орхиж хаашаа нь ч мэдэгдэхгүй зүйлд явсан байх. Тэр эсвэл Неапольд, эсвэл Тосканы эрэгт, магадгүй Францад ч юм уу хөлгөө татаж буух гэж бодож байгаа нь эргэлзээгүй хэрэг. Эльба арлын эзэн Итали, Францтай холбоо харьцаатай хэвээр байгаа гэдгийг эрхэм дээд эзэн та мэднэ гэхэд вангийн сэтгэл ихэд догдолж,
- Тийм ээ. Бонапартчууд Сен-Жак гудамжинд цугларцгааж байна гэж бид саяхан мэдсэн. За та цааш нь яриарай. Энэ бүх мэдээг та яаж олж авав? Гэж асуув.
- Би Марселийн нэгэн далайчныг байцааж байж энэ бүхнийг мэдэж авлаа л даа, эрхэм дээд эзэн минь. Би түүнийг эртнээс ажиглан хардаг болсон юм, тэгээд яг явах өдрөө түүнийг баривчлах тушаал өгсөн. Энэ хүн бонапартич болох нь эргэлзээгүй хэрэг, бас Эльба арал руу сэм очиж тэнд маршалтай уулзаж, цаадах нь түүгээр дамжуулан Парист байгаа энэ бонапартичид дам даалгавар өгчээ. Тэр хүнийх нь нэрийг дуулж би тун ч чадсангүй. Тэр даалгаврын утга нь, ойрын өдрүүдэд эргэж ирэх явдалд хүмүүсийг бэлтгэх, (эрхэм дээд эзэн минь би ялтны хэлсэн үгийг хэвээр нь дамжуулж байгаа юм шүү) хэрэгтэй гэсэн юм байна билээ.
- Аа, тэр хүн чинь хаана байна? гэж ван асуув.

- Шоронд эрхэм дээд эзэн минь.
- Энэ хэрэг танд ноцтой санагдав уу?
- Би энэ тухай гэр бүлийн баяр дээр, миний гэрлэх ёс гүйцэтгэж байсан тэр өдөр дуулж мэдээд, бүх ажил хэргээ хойш нь тавьж, өөрийнхөө үнэнч шударгыг танд илэрхийлэхээр яаран хүрч ирлээ.
- Тийм ээ, та чинь Сен-Меран авхайтай суух ёстой байсан байх аа гэж Людовик хэлэв.
- Таны хамгийн үнэнч зарц нарын нэгний охин шүү дээ.
- Тийм, тийм, за бүлэглэлийн чинь тухай ярилцъя, эрхэм де Вильфор.
- Эрхэм дээд эзэн минь, энэ бол ямар нэг бүлэглэл төдий биш, хуйвалдаан л байх бий гэж айж байна.
- Манай үед гээд Людовик инээмсэглэж - Хуйвалдаан хийх нь амархан, харин түүнийг хэрэг болгон биелүүлэх нь хэцүү. Бид саяхан өөрсдийн өвөг дээдсийн ширээнд эргэж ирж суугаад, өнгөрсөн, одоо ирээдүй цагийг бага зэрэг харж байгаа болохоор тэдэнд хэцүү болно. Миний сайдууд Газрын дундад тэнгисийн эргийг хурц соргогоор хамгаалж эхэлснээс хойшарван сар өнгөрч байна. Бонапарт Неапольд буудаг юм гэхэд бүх эвслүүд Пьомбино хүрэхээс нь өмнө түүний эсрэг босно. Хэрвээ Тосканд буувал өөртөө дайсагнасан газар буух нь тэр. Хэрвээ францад ирвэл хүн зон түүнийг үзэн яддаг болохоор өчүүхэн хэдэн хүнтэй түүнийг бид хялбархан учры нь олчихно. Ийм учраас сэтгэл зовох юмгүй, харин вангийн талархалд итгэлтэй байгаарай гэж хэлэв.
- Өө, эрхэм Дандре ирлээ гэж Блакас хан дуу алдав.

Сандарч тэвдсэн зэвхий царайтай, цагдаагийн яамны сайд тасалгааны босгон дээр зогсож байв. Ухаан тавьчихсан юм шиг харц нь мэлэрнэ. Вильфор холдох гэсэн боловч де Блакас түүний гараас татан зогсоов.

11. Корсийн махчин

XVIII Людовик цагдаагийн сайдын тэвдэж сандарсан царайг хараад, сууж байсан ширээгээ хүчтэй түлхэж,

- Та яав, түшээ гүн та яагаад ингэж сандарчихав? Эрхэм де Вильфорын нотолж байгаа, Блакас ханы таавраас болж ингэлээ гэж үү? Гэж асуув.

Хан ч бас түшээ гүний дэргэд түргэн очив. Ордны бараа бологчийн аймхай байдал нь төрийн зүтгэлтний эгдүүцлийг улам ихэсгэжээ. Үнэндээ ч цагдаагийн сайдыг эвгүй байдалд оруулж, шившиг болгосноос өөрөө шившиг болсон нь дээр гэхээр тийм цаг үе байв.

- Эрхэм дээд эзэн минь... гэж түшээ гүн бувтнав.
- Ярь ярь гэж ван хэлэв.

Тэгэхэд цагдаагийн сайд арга нь барагдан XVII Людовикийн өмнө сөхрөн унав. Людовик гэдэргээ ухарч, хөмсгөө зангидаж,

- Та ярина уу үгүй юу? гэж асуув.
- Ай эрхэм дээд эзэн минь! Ямар азгүй явдал вэ? Би яах билээ? Тайтгарахын арга алга!
- _Ерөөлт эрхэм минь, би таныг ярихыг тушааж байна гэж XVIII Людовик хэлэв.
- Эрхэм дээд эзэн минь, узурпатор хоёрдугаар сарын хорин найманд Эльба арлыг орхиж, гуравдугаар сарын нэгэнд эрэгт буужээ.
- Хаана тэр вэ? гэж ван хурдан асуув.
- Францад, эрхэм дээд эзэн минь. Жуан булангийн Антибын ойролцоох жижигхэн онгоц зогсоолд буужээ.
- Узурпатор гуравдугаар сарын нэгэнд Францад Антибын ойролцоох Жуан буланд, Парисаас хоёр зуун таван бээр газарт ирж буучхаад байхад та энэ тухай гуравдугаар сарын гурванд, дөнгөж өнөөдөр мэдэж байх!... Үгүй өршөөлт эрхэм минь ингэсэн байж болохгүй, эсвэл таныг хуурсан байх, эсвэл та галзуурсан байх.
- Үгүй, эрхэм дээд эзэн минь, энэ бол ёстой үнэн!

Людовик айх хорсох зэрэгцэн чичирч, зүрх өөд нь гэнэтхэн хатгуулсан юм шиг ухасхийн босов. Тэгээд тэр,

- Францад шүү! Узурпатор Францад ороод ирж гэнэ! Тэгвэл энэ хүнийг ажиглан харж байгаагүй хэрэг байх нь ээ? Эсвэл түүнтэй эчнээ холбоотой юм уу яаж мэдэх вэ? гэж хашхирав.
- Эзэн минь Дандре түшээ гүн шиг ийм хүнийг урвалаа гэж яаж хэлж болох билээ! гэж Блакас хан дуу алдаад - Эрхэм дээд эзэн минь, бид бүгдээрээ

сохор байж, нийт олны энэ харалган байдалд цагдаагийн сайд ч бас автагдчихаж тэгээд л тэр!

- Гэсэн ч... гээд Вильфор үг хэлэх гэснээ гэнэт зогсож - Эрхэм дээд эзэн минь энэрч уучлаарай гээд бөхийн ёсолсоор - миний зүтгэл намайг хөтөлчихлөө уучлаарай эрхэм дээд эзэн минь гэв.

- Ярь ярь эрхэмээ, зоригтой ярь гэж ван хэлээд - Та л ганцаараа золгүй явдлын тухай бидэнд урьдчилан мэдэгдлээ. Түүний өөдөө хариуцах арга зам олоход тусалж өгөөч гэв.

- Эрхэм дээд эзэн минь, узурпаторыг өмнөд талыхан үзэн яддаг юм. Хэрвээ өмнөд нутгийг дайран гарах гэвэл Прованс, Лангедок хоёр мужийг, түүний эсрэг амархан босгож болох байх гэж бодож байна.

- Зүйтэй, тэгэхдээ Гап Систероныг дайран ирж явна гэж сайдыг хэлэхэд ван үгийг тасалж,

- Ирж явна ий! Тэр чинь Парис өөд ирж яваа байх нь ээ? Гэв.

- Цагдаагийн сайд дуугараагүй байгаа нь хүлээн зөвшөөрсөн гэсэн үг байв.

-Аа, Дофинд ирвэл? Гээд ван Вильфор өөд - Энэ мужийнхныг Прованстай адил түүний эсрэг босгож болох уу? гэж асуув.

- Хатуу ширүүн үнэнийг эрхэм дээд эзэн танд хэлэхэд надад хэцүү байна, гэвч Дофиныхны байдал Прованс, Лангедок хоёрынхоос их л муу байгаа. Уулынхан гэдэг чинь бонапартич нар байгаа юм, эрхэм дээд эзэн минь.

- Тэр сайн мэдэж байжээ гэж ван шивнэн хэлээд - Тэр хичнээн цэрэгтэй вэ? гэж асуухад цагдаагийн сайд,

- Мэдсэнгүй эрхэм дээд эзэн минь гэж хариулав. Тэгэхэд ван зэвүүнээр инээмсэглэж,

- Яагаад мэддэггүй юм бэ? Та энэ тухай асууж мэдэхээ мартчихаа юу? Үнэндээ энэ ч тийм чухал биш дээ гэж ван гайхаш тасран инээмсэглэн нэмж хэлэв.

- Эрхэм дээд эзэн минь, би энэ тухай мэдэж чадсангүй. Мэдээн дотор зөвхөн узурпаторын буусан тухай, түүний явж байгаа замын тухай л мэдээлсэн байна.

- Та яаж мэдэ хүлээж ава? Гэж ван асуухад, сайд толгойгоо унжуулж, хавч шиг улайн,

- Цахилгаан мэдээгээр, эрхэм дээд эзэн минь гэж хариулав.

Тэгэхэд XVIII Людовик урагшаа нэг алхаж Наполеон шиг хоёр гараа элгэндээ зөрүүлэн барьж, хор нь хөдөлж, царай нь зэвхийрэн,

- Холбоотны долоон арми энэ хүнийг унагасан юмсан. Би хорин таван жил хөөгдөн байсныхаа дараа эцэг өвгөдийнхөө суурин дээр ид шидээр ирж суусан юмсан. Би энэ хорин таван жилийн дотор өгнө гэж амласан тэрхүү францын хүмүүс, ажил явдлы нь судлан, эрэгцүүлэн бодож, таних болсон. Гэтэл юуны төлөө ингэв? Хүссэн зорилго минь биелэгдэх тэр үед миний гартаа барьж байгаа хүч аянга цахилгаан мэт эрчлэн, намайг бут ниргэхийн тулд тэр гэж үү? Гэв.

- Эрхэм дээд эзэн минь, энэ бол хувь зохиол гэж сайд хувь тавилангийн дарамт, хүнийг дарж алж чаддаг болохыг мэдэрч бувтнав.

- Манай дасйнууд бидний тухай ярьдаг зүйл үнэн байна. Бид юу ч сураагүй, юу ч мартаагүй байна. Түүнээс урвасан шиг надаас урвасан бол би бас тайвширч болохсон. Гэтэл миний өршөөлт хүндэтгэлийг пологдотлоо хүртсэн, хүмүүсийн дунд байж, тэдний арчаагүйгээс, тэнэг явдлаас нь болж үхэж үрэгдэх ч гэж дээ. Учир нь миний аз жаргал бол тэдний аз жаргал гэсэн үг. Надаас өмнө тэд юу ч биш байсан. Надаас хойш бас л юу ч биш болох хүмүүс. Тийм ээ өршөөлт эрхэм минь таны зөв, энэ бол үйлийн үр!

Сайд толгойгоо өндийлгөж зүрхлэхгүй, энэ аймшигт номлолыг сонсож зогсов. Блакас нүүрнийхээ хөлсийг арчиж, Вильф®р нэр хүнд нь дээшилж байгаад д®троо баярлаж байв.

XVIII Людовик эзэнт төрийн өмнө харлан гарч байгаа ан цавын хэр гүнзгий болохыг шууд ойлгон

- Унах унахдаа түүнээ бас цахилгаан мэдээгээр мэдэж байдаг! Олны өмнө ичгүүр сонжуур болж тюильрийн шатаар буусанд орохноо ах XVIII Людовик шигээ цаазны индэр дээр гарвал надад илүү амар байна... Өршөөлт эрхэм минь та Францад олны элэг доог болно гэдэг юу болохыг мэдэхгүй байх, ер нь та үүнийг мэдвэл зохино гэж хэлэв.

- Эрхэм дээд эзэн минь, уучлан өршөөгөөрэй! гэж сайд бувтнав.

Бүхэл бүтэн улсын хувь заяаны тухай ярьж байгаа яриаг чагнаж, тэднээс зайтайхан хөдлөлгүй зогсож байсан залууд хандаж ван үргэлжлүүлэн,

- Нааш ир, эрхэм де Вильфор. Нааш ир тэгээд үүнд мэдэхгүй байсан юмаа урьдаас мэдэж болох байсныг хэлж өгөөч гэв.

- Эрхэм дээд эзэн минь, бүхнээс нууж байсан узурпаторын санаа бодлыг урьдаас мэдэх ямар ч бололцоогүй байлаа.

- Ямар ч бололцоогүй гэнэ ээ! Ямар их үнэтэй шалтгаан бэ! Үнэтэй шалтгаан гэдэг чинь жинтэй хүмүүс л гэсэн үг дээ. Би тэдний үүнийг мэддэг. Өөртөө бүхэл бүтэн захиргаатай, хэлтэстэй, төлөөлөгчидтэй, тандуул, эрүүлчтэй бас сая хагас франкийн нууц хөрөнгөтэй сайд Францын эргээс жархан бээр газар юу болж байгааг мэдэхгүй байх гэж үү? Ийм хэрэглэлийн аль нь ч байхгүй жирийн нэг шүүхийн түшмэл энэ залуу хүн, таныг цагдаагийн газартайгаа нийлээд мэддэгээс хавьгүй илүү зүйлийг мэдэж байна. Энэ хүн тан шиг цахилгаан мэдээний газрыг захирах эрхтэй байсан бол миний титмийг авраг байсан байх.

Цагдаагийг сайд их л хор нь хөдөлсөн байдалтай Вильфор өөд харахад цаадах нь ялсан хүний даруу зангаар толгойгоо бөхийлгөв.

- Би Блакас таны тухай яриагүй байна гээд ван үргэлжлүүлэн - Та юу ч нээж олоогүй гэсэн, өөрийнхөө сэжиглэлд хатуу зогсож байсан. Өөр хүн байсансан бол эрхэм де Вильфорын мэдээлсэн зүйлийг дэмий хоосон зүйл гэх буюу эсвэл нэр төр хүссэн хэрэг гэж үзэх байсан байх гэв.

Энэ бол нэг цагийн өмнө цагдаагийн сайдын ам бардам хэлж байсан үгийг ёжилсон хэрэг байлаа.

Вильфор вангийн тоглоомыг ойлгожээ. Өөр хүн бол олсон амжилтандаа хөөрөн магтаалд ташуурах байсан биз. Гэвч хэдийвээр эргэлт буцалтгүй унаж байгаа нь илэрхий ч гэлээ цагдаагийн сайдтай дайсан бололцохоос айжээ. Эрхэм дээд эзэн минь мэдэл дүүрэн ч гэлээ Наполеоны санаа бодлыг тааварлан мэдэж чадаагүй сайд үхэхийнхээ өмнө үхэр бугаа тавина гэгчээр Вильфорын нууцыг тайлчихаж болох юм. Тэр мэдээг мэдэхийн тулд Дантесийг зөвхөн байцаах л хэрэгтэй байв. Ийм учраас сайдыг гүйцээн цохихын оронд харин түүнд туслав.

- Эрхэм дээд эзэн минь, хэрэг явдал эрс түргэн болж байгаа нь ганцхан бурхан л салхи шуурга явуулбал түүнийг зогсоож чадахаар ажээ. Миний тэр мэдсэн зүйл бол таны хэлсэнчлэн хурц мэргэн хараатайнх биш, зөвхөн тохиолдлын хэрэг юм. Би тэр тохиолдлыг л үнэнч зарцын хувьд ашигласан юм. Намайг хэтэрхий өндрөөр битгий үнэлээрэй, хожим танд тэгж үнэлэгдсэндээ гунихгүй байх юмсан.

Цагдаагийн сайд, Вильфор өөд баярлаж учиртайхан харахад, Вильфор вангийн талархлыг алдалгүйгээр, хожим хэрэг тохиолдвол найдаж болох найзтай боллоо гэдгээ ойлгов.

- За яах вэ тийм болог. Харин одоо эрхмүүд ээ гээд ван, де Блакас, цагдаагийн сайд хоёр өөд хандаж - Та хоёр одоо надад хэрэггүй, явж болно... Одоо хийх зүйл бол цэргийн сайдад холбогдоно гэж хэлэв.

- Аз болоход бид армидаа найдаж болно. Бүх л ирсэн мэдээнүүд таны титэмд армийн итгэл найдвартайг батлан харуулж байна гэж хан хэллээ.

- Надад тэр мэдээ зэдээ гэж битгий яриад бай, түүнд яаж итгэж болохыг би мэднэ. Өө, харин түшээ гүн минь Сен -Жак гудамжны тухай ямар сонинтой байна вэ?

- Сен-Жак гудамжны тухай гэнэ ээ! гэж Вильфор өөрийн эрхгүй дуу алдсанаа тэр дороо түгдрэн зогсож - уучлаарай, танд үнэнч шударга байя гэдэг тэр бодол минь, миний зүрхэнд гүн шингэсэн таныг хүндэтгэх хүндэтгэлийг биш, харин ордны ёс горимыг мартчихад хүргээд байх юм гэж хэлэхэд ван,

- Болно, болно та өнөөдөр надаас асуух эрхтэй болсон гэж хэлэв.

- Эзэн минь, энэ хэрэгтэй холбогдуулж цуглуулсан шинэ мэдээнүүдийн тухай танд илтгэх гэсэн юм. Гэтэл таны анхаарал Жуан буланд болсон аймшигт явдалд татагдчихлаа. Тэгэхээр одоо энэ мэдээ эрхэм дээд эзэн танд ямарч сонирхолгүй болох байх гэж цагдаагийн сайд хэлэхэд,

- Үгүй шүү, харин ч энэ хэрэг бидний одоо сонирхо@d байгаа явдалтай шууд холбоотой юм шиг санагдаж байна. Генерал Кенелийн үхсэн явдал биднийг дотоодын том хуйвалдааны мөр олоход тус болох байх гэж ван хариу хэлэв.

Кенел гэдэг нэрийг дуулаад Вильфор цочин татвасхийв.

- Эрхэм дээд эзэн минь, энэ бол бидний анх бодож байсан шиг амиа хорлосон явдал биш, үнэндээ аллага байж гэж цагдаагийн сайд үргэлжлүүлэн - Генерал Кенел бонапартичуудын клубээс гараад л алга болчихож. Тэр өглөө нь нэг танихгүй хүн түүн дээр ирээд, Сен-Жак гудамжинд уулзъя гэж хэлжээ. Гай болоход, генералын үсийг засаж самнаж байсан хиа танихгүй хүнийг тасалгаанд оруулж ирээд, түүнийг Жак гудамжинд уулзъя гэж хэлэхийг сонссон авч байшингийн дугаарыг нь тогтоож авч чадсангүй гэв.

Цагдаагийн сайд энэ мэдээг ванд мэдэгдэж байх зуур түүний үгийг сонсож байсан Вильфорын царай заримдаа улайж, заримдаа зэвхийрч байв.

Ван түүн рүү эргэж:

- Эрхэм де Вильфор, узурпаторын талын хүн гэгдэж байсан генерал Кенел үнэн хэрэг дээрээ надад үнэнч шударга явсан тэр хүн бонапартичуудын гарт үхсэн байж болох уу? гэж асуув.

- Тийм байж болно, эрхэм дээд эзэн минь, гэхдээ өөр тодорхой юм юу ч алга гэж үү?

- Уулзах болзоо тогтоосон тэр хүний мөр дээр буусан шүү.
- Мөр дээр буусан? Гэж Вильфор давтан хэлэв.

- Тийм, хиа нь тэр хүний зүс царай, таних тэмдгийг хэлсэн. Энэ бэл тавь, тавин хоёр орчим насны, хар үстэй, хар нүдтэй өтгөн хөмсөгтэй, сахалтай, хоолойндоо хүрэн олон товчтой гадуур хөх цамцай, түүн дээрээ Хүндэт легионы одонгийн туузтай хүн байж. Өчигдөр яг тийм таних тэмдэгтэй хүнийг олж харсан боловч, тэр хүн Ла-Жюсьен ба Кок-Эрон гудамжаар ороод алга болчихож.

Вильфор, сайдын ярьж эхэлмэгц л сандлын түшлэгийг түшиж, хөл нь дайвалзан байснаа үл таних хүн баригдсангүй алга болчихсоныг сонсоод сэтгэл нь амарч санаа алдлаа.

- Тэр хүнийг ол гэж ван сайдад хэлээд - Одоо надад тийм их хэрэгтэй байсан байж мэдэх генерал Кенель хүний гарт үхсэн болохоор тэр хүн нь бонапартич ч байсан түүнийг заавал олж хатуу шийтгэх хэрэгтэй гэв.

Вильфор вангийн сүүлчийн үгийг сонсоод өөрийн айсан байдлыг далдлахын тулд бүх л чадах ядахаараа хайнга байдалтай байхыг хичээв.

- Хачин хэрэг болж байна! гэж ван хорсон хэлээд - Цагдаагийн газар хүн алчихаж гэж хэлснээ бүгдийг тайлбарлачихсан юм шиг бодож, мөрий нь гаргасан гэдгээрээ бүгдийг хийчихсэн гэж үзэх юмдаа гэв.

- Эрхэм дээд эзэн та энэ удаад сэтгэл хангалуун байх болов уу гэж найдаж байна.

- За за, тэгвэл сайн байна, би таныг барихаа байя, бэйс. Эрхэм де Вильфор та аян замд явж ядарч ирсэн байх, явж амар. Та бодвол аавындаа буусан биз?

Вильфорын нүд эрээлжлээд явчихав.

- Үгүй, эрхэм дээд эзэн минь, би Турнон гудамжинд «Мадрид» зочид буудалд буусан.

- Гэвч та түүнтэй уулзсан биз дээ?
- Үгүй, эрхэм дээд эзэн минь, би шууд Блакас ханыд очсон.
- Гэвч та түүнтэй уулзах юу байгаа биз дээ?
- Үгүй байх гэж бодож байна, эрхэм дээд эзэн минь.

- Өө нээрээ тийм л дээ гэж ван хэлэхэд, тэр энэ бүх асуудлуудыг зүгээр асуугаагүй гэдэг нь инээмсэглэлээр нь мэдэгдэж байв. - Би таныг эрхэм Нуартьетай эв түнжинтэй биш гэдгийг, тэгээд энэ нь миний титэмд зориулсан золиос агаад үүний чинь төлөө би таныг шагнах ёстойгоо мартчихаж,

- Эрхэм дээд эзэн таны энэрэл бол миний хүсэж санаж явснаас ч илүү өндөр шагнал юм. Надад өөр хүсэх юм алга.

- Ялгаагүй, бид таныг мартажгүй, бүү санаа зов оо, одоохондоо гээд хаан, хөх фрак дээлэн дээрээ гэгээн Людовикийн хэрээс тэмдгийн дэргэд, Кармилийн дарь эх ба гэгээн Лазарийн од одонгийн дээд талд үргэлж зүүж явдаг Хүндэт легионы одонг авч Вильфорт өгөөд - Энэ хэрээсийг авч бай гэв.

- Эрхэм дээд эзэн та эндүүрч байгаа юм биш байгаа, энэ чинь офицер хүний одон шүү дээ гэж Вильфор хэлэв.

- Хамаагүй, үүнийг ав. Өөрийг авчруулах зав надад алга. Блакас, эрхэм де Вильфорт жуух бичиг хийлгэж өгөөрэй.

Вильфорын нүдэн дээр бахархлын нулимс гүйлгэнэж одонг аваад үнэсэв.

- Та надад өөр ямар тушаал өгөхсөн бол? Гэж Вильфор асуув.

- Одоо амар, харин сүүлд, Парист байхдаа эс чадлаа ч гэсэн Марсельдаам очоод надад их тус хүргээрэй.

- Эрхэм дээд эзэн минь, би нэг цагийн дараа Парисаас явна гэж Вильфор мэхийн ёсолж хариулав.

- Яв даа, хэрвээ би таныг мартчихвал (хаад мартажтай байдаг) өөрийгөө сануулахаас битгий айгаарай... Түшээ гүн над дээр цэргийн сайдыг дуудах тушаал өгөөтхөөч. Блакас үлдээрэй гэж ван хэлэв.

- Тийм ээ, эрхэм та зөв хаалгаа олж таны эрхэм дээд эзэн минь тушаал, хэргэс зэргийн зам нээлттэй боллоо гэж цагдаагийн сайд Тюильригээс гарахдаа Вильфорт хэлэв.

- Удах болов уу даа? Гэж Вильфор эрхэм дээд эзэн минь тушаал нь төгсгөл болсон сайдтай салах ёс гүйцэтгэн шивнээд нүдээрээ сүйх тэрэг хайв.

Голын эргээр явж байсан хөлсний сүйхийг Вильфор дуудаж зогсоогоод хаягаа хэлэн сүйхэнд орж суугаад, нэр төр хүсэн мөрөөдөж бодолд автав. Тэгээд арван минутын дараа байрандаа ирж, хоёр цагийн дараа морь өгөхийг тушаагаад хоол захиалж авчруулав.

Түүнийг хоол идэхээр суутал хэн нэгний их л итгэлтэй, хүчтэй гараар хонх тугтрав. Зарц очиж хаалга онгойлгоход Вильфор өөрийнхөө нэрийг хэлэхийг сонсов.

- Намайг Парист явааг хэн мэдэх билээ? Гэж вангийн прокурорын туслах бодов

Зарцын буцаж ирэхэд,

- Тэнд хэн байна? Хэн хонхдоо вэ? Хэн намайг сураглаж ирэв? Гэж Вильфор асуухад,

- Танихгүй нэгэн эрхэм, нэрээ хэлэхгүй байна гэв.
- Яалаа гэнэ ээ? Нэрээ хэлэхгүй байна гэнэ ээ? Тэр надаар яах гэсэн юм бол?

- 'антай уулзаж ярих гэсэн юм гэнэ.

- Надтай юу?

- Тийм ээ.

- Тэр намайг нэрээр минь хэлж байна уу?

- Тийм ээ.

- Тэр ямаршуухан хүн байна?

- Тавиад орчим насны хүн байна.

- Өндөр юум уу? Намхан юм уу?

- Тантай л адил юм.

- Шаргал үстэй юм уу? Бараан үстэй юм уу?

- Бараан үстэй, хар нүдтэй, хар хөмсөгтэй.

- Аа хувцас нь? Гэж Вильфор шамдан асуугаад - Ямар хувцастай юм бэ? Гэв.

- Захандаа хүртэл товчтой, гадуур хөх цамцтай, Хүндэт легионы одонгийн туузтай хүн байна.

Тэгэнгүүт Вильфорын царай зэвхийрэн,

- Өнөөх чинь байна гэж шивнэв.

- Чөтгөр ав! гэж хэлээд бидний өнөөх таних тэмдгийг нь хоёр удаа тодорхойлон хэлсэн хүн хаалгаар орж ирээд, - Ямар их ёс журам бэ? Эсвэл Марсельд хүүхдүүд нь эцгээ үүднийхээ өрөөнд хүлээлгэдэг заншилтай юм уу? гэж хэлэв.

- Аав гэж Вильфор дуу алдаад - Би андуурсангүй... Би яг таныг гэж бодсон юмаа... гэхэд ирсэн зочин таягаа буланд тавиад, бүрх малгайгаа ширээн дээр тавьж,

- Хэрвээ чи намайг гэж бодсон юм бол, ингэж хүлээлгэх чинь найрсаг биш л байна даа хонгор Жерар гэж чамд хэлэхийг зөвшөөрнө үү гэж хэлэв.

- Жерман явж бай гэж Вильфор хэлэхэд зарц илэрхий гайхсан царайтай гарч одов.

12. Эцэг хүү хоёр

Эрхэм Нуартье (үнэхээр тэр мөн байжээ) зарцыг гарч үүд хаагдтал хойноос нь харж байснаа, дараа нь үүдний өрөөнд зогсоод чагнах бий гэж болгоомжлон дахин хаалга онгойлгож харав. Тэгж болгоомжилсон нь ч илүүдсэнгүй. Жерман манай эцэг дээдэст хор учруулж байса, тэр дутагдлаас ангижран холдож чадаагүй нэгэн ажээ. Тэгэхээр ь Нуартье үүдний өрөөний хаалгыг өөрөө хаагаад дараа нь унтлагын өрөөг түгжээд, эцэст нь гайхан ширтэх Вильфорт гараа өгөв. Тэгээд үнэн учрыг нь олоход хэцүүгээр инээмсэглэж хүүдээ,

- Жерар чамайг надтай уулзсандаа баярлаж байгаа гэж хэлж болмооргүй байх чинь гэв.

- Хаанаас даа аав аа, би их баяртай байна. Гэвч би таныг ирнэ гэж бодоогүй байсан учир намайг бага зэрэг тэвдүүлчихлээ гэхэд эрхэм Нуартье сандал дээр сууж,

- За, найз минь, би ч бас танд тийм үг хэлж болох байна. Таны гэрлэх ёс хоёрдугаар сарын хорин найманд Марсельд болно гэж бичиж байсан шүү дээ. Гэтэл та гуравдугаар сарын гурванд Парист байж байна, энэ чинь юу болж байгаа нь энэ билээ? Гэж асуув.

- Тиймээ, би энд ирлээ гэж Жерар, эрхэм Нуартье өөд дөхөн - Гэвч та надад битгий үг хая, би таны төлөө ирлээ, миний ирсэн явдал таныг аварч магадгүй гэж хэлэв.

- Уухай! гэж сандал дээрээ хайнгадуу шигдэн суусан Нуартье хэлээд - Эрхэм прокурор, юу болоо вэ яриарай, энэ их сонин байна гэж хэлэв.

- Та Сен Жак гудамжинд байдаг нэгэн бонапартич клубын тухай сонссон уу?

- Тавин гуравдугаар байшинд уу? Тийм ээ, би түүний дэд ерөнхийлөгч,

- Аав аа таны хайхрамжгүй байдал намайг айлгаж байна.

- Хонгор минь чи тэгээд юу гэх гээ вэ? Монтань-яруудаас алагдах ял заагдаж байсан хүн, Парисаас тэрэгтэй өвсөн дотроос нуугдаж зугтаад, бордосийн талд Робеспьерий тагнуулчдаас нуугдаж явсан хүн олон юманд дасаж заншжээ. Тэгээд цааш нь яриач. Сен-Жак гудамжин дахь тэр клубт юу болчихоо вэ?

- Тийш нь генерал Кенелийг урьж, тэгээд генерал Кенель оройн есөн цагт гэрээсээ гарч яваад, хоёр хоногийн дараа Сенаас олдсон хэрэг болжээ.

- Энэ сонирхолтой явдлыг танд хэн хэлчихэв?

- Ван өөрөө хэлсэн.

- Аа тэгвэл би таны ярьсан зүйлийн хариуд нэг сонин юм хэлье гэж эрхэм Нуартье хэлэв.

- Би түүнийг чинь мэдчихсэн байхаа даа.

- Тэгвэл та эрхэм дээд эзэн хаан эрэг дээр буусан тухай мэдэж байна уу?

- Дуугүй бай, ааваа танаас гуйя, нэгдүгээрт өөрийнхөө төлөө, дараа нь таны төлөө. Тийм ээ, би тэр сонин зүйлийг чинь мэднэ, тэрч байтугай би танаас түрүүнд мэдэж байсан, би Марселиас Парист хүрч ирэх гэж гурван өдөр давхиж, тархи толгойг минь зовоож байгаа тэр санааг хоёр зуун бээр газрыг давуулан шидчихэж чадахгүйдээ толгойтой үсээ зулгаан явсан юм.

- Гурван өдөр ий? Та галзуурав уу? Гурван өдрийн өмнө император хөлгөө эрэгт татаагүй байсан.

- Тийм ээ, тэгэхдээ би түүний санааг мэдэж байсан юм.

- Яаж тэр вэ?

- Эльба арал дээрээс танд хаяглаж ирүүлсэн захидлаас.
- Надад ий?
- Тийм ээ би түүнийг элчээс нь хурааж авсан. Хэрвээ энэ захидал надаас өөр хүний гарт орсонсон бол та лав хэдийн буудан алагдчихсан байж магадгүй. Вильфорын эцэг инээд алдав.
- Бурбончууд, ямарч саадгүй ажиллахыг императороос сурчихсан бололтой... Буудан алагдах Жэнэ ээ! Найз минь, та яасан их яарч байх юм бэ? Аа тэр захидал чинь хаана байна? Би таныг мэдэх болохоор тэр захидлыг маш нарийвчлан нуусан байх гэж бодож байна.
- Энэ захидал танд алах ялтай адил юм болох учир шатчихсан.
- Тэгээд таны нэр алдар, эрхэм дээд эзэн минь тушаалын төгсгөл болно шүү дээ гэж Нуартье хүйтнээр хариулаад - Тийм ээ та намайг тэтгэн дэмжиж байгаа болохоор надад айх юм алга гэж хэлэв.
- Түүнээс гадна би таныг аварч байна шүү.
- Өө тийм бий? Энэ чинь сонин хэрэг байна даа! Тайлбарлаач. За тэгвэл Сен-Жак гудамжин дахь клубын тухайд эргэж орёё.
- Энэ клуб, эрхэм цагдаа нарыг үнэхээр их түгшүүлж байгаа бололтой. Тэд яагаад түүнийг тийм муу эрээд байгаа юм бол? Аль хэдийн олчихмоор юм аа!
- Та түүнийг олоогүй боловч мөрийг нь олсон.
- Тийм ээ, цагдаагийн газрын хүч хүрэхгүй, аргагүй болохоороо, мөрийг нь олсон гэж ярьдаг юм. Тэгээд өнөө олсон мөрөө алдчихлаа гэж уруу царай гаргаж ирэхийг засгийн газар тайван хүлээж суудаг юм.
- Тийм ээ гэвч хүүр нь олдсон, егнерал Кенель үхсэн байсан, үүнийг орон бүхэнд л аллага гэж нэрлэдэг юм.
- Аллага ий? Гэвч генерал, хүнд алагдсан гэдэг ямарч гэрч баримт алга байгаа шүү дээ. Үхэхээс өөр аргагүй болж цөхрөлд орж үхсэн буюу эсвэл сэлж чадахгүй учраас живж үхсэн хүн Сенээс өдөр бүр олддог биз дээ.
- Генерал Кенель арга тасран усанд харайн орж үхээгүй, бас нэгдүгээр сард Сенэд хүн усанд ордоггүй гэдгийг та сайн мэднэ. Үгүй, үгүй та битгий төөрөгдүүлээд бай, энэ үхлийг чинь хүн амины хэрэг гэдэг юм.
- Хэн үүнийг тэгж нэрлэж байгаа юм бэ?

- Ван өөрөө.

- Ван? Би түүнийг гүн ухаантан хүн болохоор улс итөрийн бодлогод аллага гэж байдаггүй юм гэдгийг мэдэх байх гэж бодож байсан юмсан. Хонгор минь та бид хоёрын хэний нь ч мэдэж байгаагаар улс төрийн бодлогод чинь хүмүүс гэж байдаггүй, харин үзэл суртал байдаг юм. Мэдрэхүй байхгүй, харин сонирхол байдаг юм шүү дээ. Улс төрийн бодлогод бол хүнийг алдаггүй, зөвхөн замын саадыг арилгадаг юм, ингээд л гүйцээ. Энэ бүхэн яаж болсныг та мэдэх юмсан гэж бодож байна уу? Би танд ярьж өгье. Бид генерал Кенельд итгэж болно гэж бодож байсан юм. Түүнийг Эльба арлаас бидэнд зөвлөн зуучилсан юм. Бидний нэг түүн дээр очиж, Сен-Жак гудамжинд болох хуралд урьсан, тэгээд тэр ч хуралд ирсэн. Бид түүнд императорыг Эльба арлаас гарч Францын эрэгт буух гэж байгаа тухай бүх төлөвлөгөөгөө танилцуулсан. Тэгээд энэ бүхнийг сонсож, мэдэж аваад сүүлд нь би роялист хүн гэдгээ хэлж байна. Манайхан бие биенээ харж гайхлаа. Тэгэхээр нь түүнээс ам тангарагийг нь авсан чинь маш их дургүй өглөө. Бурханд л нүгэл бүү болог доо, гэсэн ч генералыг гэр уруу нь чөлөөтэй явуулчихсан. Гэтэл тэр гэртээ харьсангүй. Тэгэхээр та нар яах гээ вэ? Тэр бодвол, манайхаас гараад замаасаа төөрчихсөн байлгүй, тэгээд л тэр. Үүнийг чинь аллага гэдэг юм уу? Вильфор би таныг гайхаж байна. Вангийн прокурорын туслах ийм туйлбаргүй эд мөрий баримтаар яллах гэж яаж болох билээ. Үнэнч шударга роялист та, бид нарын нэгийг нөгөө ертөнцөд тонилгочихлоо гэхэд «Хүү минь чи аллага хийлээ!» гэж хэлэх бодол миний толгойд орж ирнэ гэж бодож байна уу, үгүй шүү би танд «Маш сайн байна, өршөөлтэй эрхэм та дийллээ, дараачийнх нь бидний ээлж боллоо» гэж хэлнэ дээ.

- Аав минь та болгоомжилж байгаарай, бидний ээлж ирэхэд бид хайр найргүй байх болно шүү.

- Би таны хэлж байгааг ойлгохгүй байна.

- Та узурпаторын эргэж ирэхэд найдлага тавьж байна уу?

- Нуухгүй ээ.

- Та ташаарч байна, түүнийг Францын гүн уруу арван бээр ч ороогүй явахад, хойноос нь мөрдөж хөөж гүйцээд, зэрлэг араатан шиг хордуулчихна шүү дээ.

- Хайрт нөхөр минь, эзэн хаан одоо Гренобль орох замд яваа, арван, арван хоёр оны үед Лионд, хорин буюу хорин тавны үед Парист ирнэ.

- Ард түмэн босно доо...

- Тийм ээ. Түүнд баяр хүргэх гэж шүү.

- Тэр цөөхөн хүнтэй, түүний эсрэг бүхэл бүтэн арми явуулна.
- Түүнийг баяр хөөр болон нийслэл хүртэл дагах гэж үү. Жерар та миний хэлсэн үгэнд итгэ! Та хүүхэд хэвээрээ байна. Эзэн хааныг Францын эрэгт бууснаас гурав хоногийн дараа «Узурпатор Каннад цөөн бүлэг хүнтэй буусан, хойноос нь хөөхөөр хүмүүс явуулсан» гэдэг үгтэй утас хүлээж аваад бүгдийг нь мэдчихлээ гэж бодож байна уу. Харин тэр одоо хаана байна. Юу хийж явна? Та нар юу ч мэдэхгүй шүү дээ. Та нар зөвхөн хойноос нь хөөхөөр хүн явуулсныг л мэдэж байгаа. Тэд чинь Парис хүртэл нэг ч буу дуугаргалгүй хөөж явсаар ирснэ дээ.
- Гренобль, Лион хоёр бол роялист хот, тэд түүний өмнө давшгүй бат хэрэм цайз болно.
- Гренобль түүнд хаалгаа баяртайгаар нээж өгч, Лион түүнийг тосож авна. Бид та нараас илүү мэднэ, манай цагдаагийн газар танайхаас дутахгүй. Танд нотолгоо хэрэгтэй бол хэлье л дээ. Та надаас өөрийнхөө ирснийг нуух гэсэн чинь би таныг харуул өнгөрөөд хагас цаг болсны дараа л мэдчихсэн шүү дээ. Та хаягаа зөвхөн шуудангийн сүйх тэрэгний хөтөчид өгсөн, тэгэхэд би түүнийг чинь мэдчихээд таныг хоол идэхээр ширээнд суух үед урьж байгаа нь энэ. Тэгэхээр хонхоо дуугаргаж бас нэг хүний хэрэглэл захиарай, хоёулаа хамт хоол иднэ.
- Үнэндээ ч гээд Вильфор эцэг өөдөө гайхан харж - Та хамгийн нарийн мэдээ хүлээн авчээ гэж хэлэв.
- Тийм ээ, энэ бол хялбархан хэрэг, засгийн эрхэнд сууж байгаа та нар бол зөвхөн мөнгөөр л худалдан авч болох тэр хэрэглүүрүүдийг ашиглаж байна. Харин засгийн эрхэм дээд эзэн минь авахаар хүлээж байгаа бидэнд бол амь бие хайрлахгүй, үнэнч шударга явдлаас гардаг тэр бүх хэрэглэлүүд бий.
- Үнэнч шударга ий! гэж Вильфор давтан хэлээд инээмсэглэв.
- Тийм ээ, үнэнч шударга ёс, ирээдүйдээ найдсан нэр төр олохыг зүй ёсыг даган ингэж нэрлэдэг юм гэж хэлээд Вильфорын эцэг түүнийг зарцаа дуудахгүй байгааг хараад өөрөө хонх уруу гараа сарвайв. Тэгэхэд Вильфор түүний гарыг барьж,
- Байзаарай аав аа, бас нэг үг хэлье гэв.
- Хэл хэл.
- Манай цагдаагийн газар хичнээн муу ч гэсэн нэг аймшигтай нууцыг мэдэж байгаа даа.
- Ямар?

- Генерал Кенелийг алга болсон өдөр нь түүнийг аваачхаар ирсэн хүний шинж тэмдгийг мэдэж байгаа.

- Үгүй ер, мэднэ гэнэ ээ? Нээрээ тийм гэж үү? Тэгээд тэр шинж тэмдэг чинь ямар юм бэ?

- Бор царайтай, хар үстэй, хууз сахалтай, хар нүдтэй, хоолойндoo хүрсэн олон товчтой гадуур хөх цамцтай, захан дээрээ Хүндэт легионы одонгийн туузтай, өргөн хүрээтэй бүрх малгайтай, хулсан таягтай хүн байгаа.

- Үгүй ер! Цагдаагийн газар үүнийг мэдчихээ юу? Тэгээд мэдсэн юм бол түүнийг юунд бариад аваагүй юм бол? Гэж Нуартье хэлэв.

- Тэр хүн өчигдөр юм уу уржигдар Кок-Эрон гудамж тойроод алга болчихсон учраас барьж чадаагүй юм байна.

- Танай цагдаагийн газар гэдэг тэнэгүүд байдаг юм гэж би чамд дэмий хэлээгүй шүү.

- Тийм ээ, гэсэн ч хэзээ ч хамаагүй түүнийг олоод авч магадгүй дээ.

- Тэгэлгүй яахав гэж хэлээд Нуартье эргэн тойрныг хайхрамжгүй харснаа - Хэрвээ тэр хүнийг урьдаас болгоомжлуулаагүй бол шүү. Гэвч тэр хүнийг урьдаас болгоомжлуулчихлаа л даа. Ийм болохоор гэснээ инээмсэглээд - Тэр хүн нүүр царай, хувцас хунараа сольчихно доо гэж хэлээд босож сюртук, галстук хоёроо тайлж, Вильфорын аяны хэрэгсэл дээр нь байгаа ширээнд очиж, сахлын хутгыг нь авч, сахлаа савандаад, цагдаагийн газар маш чухал ач холбогдолтой хууз с хлаа хусаж хаяв.

Вильфор айх бахдах зэрэгцэн харав.

Нуартье хууз сахлаа хусаж хаяад, үсээ өөрчлөн самнаж заса д хар галстукийнхаа оронд өөр өгийн галстук Вильфорын онгорхой чемоданаас авч зүүгээд хоёр энгэртэй хөх сюртукээ тайлж, Вильфорын нугалсан ганц энгэртэй сюртукийг өмсөөд хүрээтэй бүрх малгайг нь өмсөж толины өмнө тааруулж үзээд, сэтгэлд нь тохирсон бодолтой байв. Таягаа задгай зуухны цаад талын буланд тавиад, оронд нь хааны прокурорын туслахын бардам чөлөөтэй алхаанд чимэг болж явдаг нарийнхан хулсан таягийг авч барив... Тэгээд гайхаж ангайсан Вильфорт хандаж,

- За ямар байна? Одоо намайг цагдаа нар таних болов уу? гэж хэлэв.

- Үгүй байх гэж Вильфор бувтнаад - Үгүй байх л гэж бодож байна гэв.

- Чамд орхиж байгаа энэ юмнуудын тухайд гэвэл, чи эдгээрийг болгоомжтойгоор, нуучихаж чадах байх гэж бодож байна.

- Битгий санаа зов! гэж Вильфор хэлэв.

- Чиний хэлдэг ер нь үнэн ч байж мэднэ, чи үнэхээр амийг минь аварсан байж болох юм, гэвч бид удахгүй өгөө аваагүй болно.

Вильфор толгойгоо сэгсрэв.

- Үнэмшихгүй байна уу?

- Таныг ташаарч байна гэж бодож байна.

- Чи вантай дахиж уулзах уу?

- Магадгүй.

- Чи түүнд далдыг мэдэгч мэргэн болохыг хүсэж байна уу?

- Азгүй явдлыг зөгнөн мэддэг мэргэн хүнийг, ордныхон муугаар хүлээн авдаг юм.

- Тийм л дээ, гэхдээ эрт орой хэзээ нэгэн цагт ойлгодог юм, дахин сэргэх үед чи агуу их хүн болон алдаршина шүү дээ.

- Тэгээд би ванд юу гэж хэлэх юм бэ?

- Түүндээ ингэж хэл: «Эрхэм дээд эзэнтэн минь Францын байдал, хотуудын хүн амын зан авир, армийн сэтгэл санааны тухай танд хуурамч мэдээ өгч байна. Парист та нарын корсикийн махчин, Неверт узупа тор гэж нэрлэдэг тэр хүн чинь одоо Лионд Бонапарт, Гренобльд эзэн хаан гэгдэж байна. Та түүнийг хөөж мөрдөж, тэр зугтаж байгаа гэж бодож байгаа бол тэр чинь эргэж ирж яваа бүргэд адил халин дүүлж явна. Та түүний цэргийг өлсөж, ядран, аян замд зүдэрч, тарж сарнихад хүрч байгаа гэж үзэж байна. Гэтэл тэд хуйлран овоорох цас мэт өсөн нэмэгдэж байна. Эрхэм дээд эзэнтэн, та Францыг худалдаж авсан биш, таны эсрэг хүмүүс танд өршөөл үзүүлэхээр хангалттай хүчтэй, харин гэгээн Людовикийн удам угсаа Арколь, Маренго, Аустерлицийн дэргэд ялалт байуулагчид амь хэлтрүүлсний ачийг санаж явахгүйн тулд эндээс зайлж яв» гэж хэлээрэй. Жерар чи энэ бүхнийг ванд хэлээрэй, эсвэл түүнд юу ч ярилгүй, Парист байснаа хэн бүхнээс нууж яах гэж наашаа явсан ба ирээд юу хийснээ хэнд ч битгий хэл, морь хөлслөж аваад, наашаа давхиж ирсэн бол, буцахдаа нис. Марсельд шөнө очиж, гэртээ арынхаа хаалгаар ороод хаана ч харагдалгүй, номхон дөлгөөн суу, хамгийн чухал нь томоотой номхон бай, энэ удаа бид өөрсдийнхөө дайснаа таньдаг хүч чадалтай хүмүүс яаж хөдөлдөг шиг л ажиллах болно. Хүү минь яв түргэн яв, эцгийнхээ

тушаалыг дагасан ч юм уу эсвэл найзынхаа зөвлөлгөөг дагасны чинь хариуд бид таны одоогийн чинь албан тушаалыг хэвээр үлдээнэ. Энэ бол хожим улс төрийн тэнцвэр дээр та хүчтэй болж би хүчгүй болох үе ирвэл та намайг дахин аварч болох боломж олгож байгаа юм. Баяртай. Жерар дараа ирэхдээ манайд буугаарай.

Тэгээд Нуартье энэ бүх ярианы үед тайван байдлаа огт алдалгүй байсан чигээрээ гарч одов.

Айж тэвдээд зэвхийрсэн Вильфор цонх уруу гүйж очоод, хөшгийг нь яран харахад, эцэг нь хар хууз сахалтай, хөх сюртуктэй, өргөн хүрээтэй бүрх малгайтай хүнийг тааралдвал барьж авах санаатай байрын сэжигтэй гурван хүний дэргэдүүр ажигч үгүй өнгөрөн гарав.

Вильфор аавыгаа далд ортол цонхноос холдолгүй, чичрэн зогсов. Дараа нь аавынхаа орхисон хувцас хунарыг шүүрэн авч, хар галстук, хөх сюртук хоёрыг нь чемоданыхаа ёроолд хийж, бүрх малгайгийн нь хумхиж шүүгээний доорд нүдэнд хаяад таягийг нь хугалж задгай зууханд түлж, аяныхаа малгайг өмсөж зарцыг дуудаж ирүүлээд, бүх хөлсийг нь төлж, хүлээж байсан сүйх тэргэнд сууж Лионд очоод тэндээс бонапарт Гренобль уруу явчихсан гэдгийг мэдэж цааш, замын турш бужигнаан үймсэн олны дундуур явсаар нэр төр анхны амжилт олсон хүнд л тохиолдох сэтгэлийн зовлонг амсаад Марсельдаа хүрч ирэв.

13. Зуун өдөр

Нуартье сайн зөнч байжээ. Бүх зүйл түүний зөгнөн хэлснээр боллоо. Эльба арлаас хачин гайхалтайгаар эргэж ирсэн, өнгөрсөн үед ч байгаагүй, ирээдүйд ч дахин гарахааргүй энэ явдал бүхэнд илэрхий Үйлээ. XVIII Людовик хатуу ширүүн цохилтыг няцаах гэж сул дорой оролдлого хийв. 'эр хүмүүст итгэхгүйн адил болж байгаа хэрэг явдалд итгэхгүй байв. Түүний дөнгөж сая сэргээн байгуулсан хаант засаг буюу үнэндээ хэмжээгүй эрхт засаг бэхжиж тогтоогүй хөл дээрээ ганхаж, хуучны үлдэгдэл ба шинэ үзэл сртлын холио хутгаа болсон барилга нь императорын анхны дохиогоор нурж унав. Ийм учраас вангаас авсан шагнал нь Вильфорт ашиггүйгээр барахгүй аюултай байсан учир, хэдийгээр хан Блакас, вангийн тааллыг биелүүлэхийн тулд жуух бичиг ирүүлсэн боловч Хүндэт легионы одонгоо хэнд ч үзүүлсэнгүй.

Зовж зүдрэн, ач тус хүргэснийхээ төлөө эзэн хааны ордонд бүхнийг чадагч эрхтэй болсон Нуартье өмгөөлч хамгаалаагүй бол Наполеон Вильфорыг зайлшгүй хөөн зайлуулах байсан юм. 1793 оноос жирондич 1806 оноос сенатч болсон тэр хүн өөрийнхөө хэлсэн үгэнд хүрч урьд нь тус хүргэсэн хүндээ тус болов.

Вильфор энэхүү эзэн хаант гүрнийг хоёр дахь удаагаа унана гэдгийг сайн мэдэж байсан учир тогтнон байгаа хугацаанд нь Дантесын тараачих шахсан нууцыг чадлынхаа хэрээр нуун далдалж байв.

Вангийн прокурорыг бонапартизмд хангалттай үнэнч биш гэж сэжиглэн огцруулав.

Императорын засаг дөнгөж тогтмогц XVIII Людовикийн дөнгөж орхиж явсан Тюильерын ордонд Наполеон шилжин ирж суумагц, Вильфорийн хойноос манай уншигчид даган орсон тэр тасалгаанаас олон тооны янз бүрийн тушаал зарлигуудыг тал бүр тийш нь илгээв. Эзэн хаан самрын модоор хийсэн ширээн дээрээс XVIII Людовикийн дүүрэн тамхит й хайрцгийг олжээ. Марсельд оро нутгийг эрх баригчид хичнээн хориглосон боловч хүмүүсийн хооронд харилцан маргалдаан үүсэв. Хэрэг явдал зөвхөн гэртээ биеэ оторлон сууж байгаа Роялистуудын орилолдон хашхиралдахаар хязгаарлагдахгүй, гудамжинд зүрхлэн гарсан хүмүүсийг илэрхий доромжлох боллоо.

Цаг үеийн байдал өөрчлөгдсөний үрээр, хөлгийн эзэн хүндэт хүн плебейн лагерьт хамаарагдах Моррель хэрвээ бүхнийг чадагч болчихоогүй ч гэсэн (Моррель худалдааны удаан хүнд хэцүү замаар явж нэр төр, эрх тушаалтай болсон тэр бүх хүмүүсийн адил нэлээд аймхай, болгоомжтой болчихсон хүн юм.) гомдлоо илэрхийлэх дуугаа өндөрсгөх хүрэлцээтэй жин олж авчээ. Энэ гомдол нь Дантесын тухай гэдгийг тааварлахад хялбархан.

Вильфор өөрий нь дарга унасан боловч тэсвэрлэн зогсож хоцров. Түүний хурим хийх явдал нь сарнин замхраагүй хэдий боловч аятай зохистой цаг иртэл хойшлогдов. Хэрвээ эзэн хаан ширээндээ тогтон суугаад байвал Жерар өөр нам эрж олох хэрэгтэй байсан бөгөөд Нуартье түүнд өөр эхнэр олж өгөх байсан юм. Хэрвээ XVIII Людовик хоёр дахь удаагаа эргэж ирвэл бэйл де Сен-Мераны нөлөө Вильфорийн адилаар хоёр дахин нэмэгдэж, хурим хийх нь улам ч тохиромжтой болох байв.

Ийм байдалтайгаар нэгэн өглөө Моррелийг ирснийг мэдэгдэхэд вангийн прокурорын туслах Марселийн шүүхийнхний дунд тэргүүн байр эзлэх болсон ба©в.

Өөр хүн байсан бол хөлгийн эзэн өөд яаран очиж угтан уулзаж өөрийнхөө сул яоройг харуулчих байсан боловч Вильфор ухаантай, туршлагагүй байлаа ч гэсэн сайн сэрэхүйтэй хүн болохоор Моррелийг завгүйдээ биш харин вангийн прокурорын туслах ирсэн хүнийг үүдэндээ хүлээлгэж сурсан ёсоор үүднийхээ өрөөнд хүлээлгэв. Мөчийн дараа, янз бүрийн чиглэлийн хэдэн сонин эргүлж үзээд эрхэм Моррелийг дууд гэж тушаал өгөв.

Моррель Вильфорыг зөөлөн зантай болсон байх гэж бодож байтал харин хоёр сар хагасын өмнө байсан шигээ тайван, бат тогтвортой ёсорхуу хэвээрээ байв. Энэ бол жирийн хүнийг эрх тушаалтай хүнээс тусгаарлах хамгийн давшгүй саад тотгор байдаг. Моррель тасалгаанд ороод түүнийг өөрийгөө хараад сүрдэн чичрэх байх гэж найдаж байсан чинь, харин оронд нь өөрийг нь хүлээж бичгийн ширээний цаана сууж байгаа прокурорын туслахыг хараад өөрөө л айн дагжихад хүрчээ.

Моррель үүдэнд зогсов. Вильфор түүнийг танихгүй байгаа юм шиг харна. Тэгээд хэсэг зур дуугүй байж, Моррелийг малгайгаа эргүүлэн зогсож байхад,

- Хэрвээ би андуураагүй бол та чинь эрхэм Моррель уу? гэв.
- Тийм ээ эрхэм ээ, би байна гэж хөлгийн эзэн хариулав.
- Аль вэ, наашаа орооч гэж Вильфор сайхан зантай хэлээд,
- Таны ирсэн явдлын ачийг би юугаар хариулах ёстой болж байна? гэв.
- Та тааварлахгүй байна гэж үү? Гэж Моррель асуув.
- Үгүй огт тааварлахгүй байна, хэдий тийм боловч чадах юм байвал танд луслахад бэлхэн байна.
- Энэ бол таны бүрэн мэдлийн зүйл гэж Моррель хэлэв.
- Тэгвэ« юун тухай юм бэ, хэл л дээ

Моррель бага зэрэг лайвширч, өөрийнхөө хүсэлтийн шударга ба одоогийн байдлын тодорхойд бат итгэж,

- Эрхэм ээ, эрхэм дээд эзэн хааны буцаж ирэх тухай мэдээ тодорхой болохоос хэдэн хоногийн өмнө би тан дээр нэгэн залуу далайчин, миний онгоцны ахмадын туслахад өршөөл үзүүлнэ үү гэж гуйж ирсний минь санаж байгаа биз. Түүнийг Эльба аралтай харилцаатай гэж шийтгэсэн юм. Тэр үед ялт хэрэг гэж үзэгдэж байсан ийм харьцаа нь одоо шагнал хүртэхээр зүйл боллоо. Тэгэхэд та XVIII Людовикт албан хааж байсан болохоор тэр хүнийг өршөөгөөгүй л дээ, энэ бол таны үүрэг байсан. Одоо бол та Наполеонд үйлчилж, гэм буруугүй хүнийг хамгаалах үүрэгтэй, энэ бол бас л таны үүрэг. Ийм учраас би тан дээр түүний тухай асуух гэж ирлээ.

Вильфор ихэд биеэ барин,

- Түүний нэр хэн билээ? Гэж асуугаад - Нэрий нь хэлж өгөөч гэв.
- Эдмон Дантес

Шууд өөдөөс нь хэлж байгаа энэ нэрийг сонсохоос хорин таван алхмын ирүүл тулаанд дайсныхаа өөдөөс духаа тавьж өгөх нь аятайхан байжээ. Гэвч Вильфор нүдээ ч ирмэсэнгүй.

«Намайг энэ залууг хувийнхаа эрх ашгийн үүднээс барьсан гэж хэн ч хэлж чадахгүй» гэж Вильфор бодож байв.

- Дантес ий? Гэж давтан асуугаад - Эдмон Дантес гэв үү? Гэв.

- Тийм ээ эрхэм ээ.

Вильфор зэргэлдээ байгаа том шүүгээг нээж, дараа нь өөр нэг ширээнд очиж, ширээнээс хавтаст хэргүүд өрсөн дашинга дээр очиж үзсэнээ, эргэж хөлгийн эзэн өөд хараад, хамгийн жирийн дуугаар,

- Өршөөлт эрхэм минь, та андуураагүй биз? Гэж асуув

Хэрвээ Моррель арай авхаалжтай, энэ хэргийн байдлыг илүү сайн мэдэж байсансан бол прокурорын туслах уг хэрэгт огт хамаарагдахгүй зүйлээр хариулж байх нь хачин санагдаж байсан юм. Вильфор, түүнийг хоригдлуудын нэрийг үз гэж шоронгийн дарга нар уруу яагаад явуулахгүй байна гэдэг асуулт өөртөө тавих байсан юм. Айсан шинж байгаа эсэхийг дэмий эрсэн Моррель, түүний эелдэг байгааг л харж байлаа. Вильфор зөв тооцжээ.

- Үгүй шүү би андуураагүй, түүнийг мэддэг болоод арваад жил болж байна манайд дөрвөн жил алба хаасан юм. Сар хагасын өмнө, санаж байна уу? Одооных шиг шударга үнэнийг хүсэж гуйхын адилаар энэрэл өршөөл үзүүлэхийг би танаас гуйж ирсэн шүү дээ. Тэгэхэд та намайг нэлээд хайхрамжгүй хүлээн авч дургүйхэн хариулж билээ. Тэр үед роялистууд бонапартичдэд найрсаг биш байдаг байсан юм! Гэж хэлэв.

- Өршөөлт эрхэм минь гэж Вильфор түүний цохилтыг няцаан ерийн хайнга байдлаараа хариулаад - Бурбончуудыг би эзэн ширээний хууль ёсны эзэн, ард түмний сонгосон хүмүүс гэж үздэг байсан тэр үедээ роялист байсан юм. Гэвч одоо бидний үзэж, гэрч нь болж байгаа тэр гайхамшигт эргэлт .миний ташаарсныг батлан харуулав. Наполеоны суут ухаан ялжээ. Зөвхөн олны дуртай хэмжээгүй эрхт засаг бол хууль ёсны хэмжээгүй эрхт засаг юм гэв.

- Санасан ёсоор боллоо гэж Моррель бүдүүлэгдүүхэн илэн далангүй хэлээд - Таны тСгж ярихыг сонсоход сайхан байна. Энэ бол хөөрхий Эдмонд сайн ёр болох нь гэв. Вильфор шинэ бүртгэлийн хуудас эргүүлэн,

- Байзаарай, би одоо санаж байна, далайчин байх аа? Тэр каталан охинтой суух гэж байсан байх аа? Тийм тийм, би одоо санаж байна. Тэр бол маш ноцтой хэрэг байсан юм гэж хэлэв.

- Тийм гэж үү?

- Шүүхийн байшинд байхад нь түүнийг шууд шорон уруу аваад явсныг та мэдэж байгаа шүү дээ...
- Тийм ээ, тэгээд дараа нь яасан бэ?
- Дараа нь би Парис өөд мэдээ явуулж түүнээс олсон бичиг баримтуудыг хамт явуулсан. Би тэгэх үүрэгтэй. Түүнээс долоо хоногийн дараа хоригдлыг аваад явчихсан.
- Аваад явчихсан гэнэ ээ? Гэж Моррель дуу алдаад - Хөөрхий амьтныг яагаа бол? Гэв.
- Бүү ай. Түүнийг бодвол Фенестрель, Пиньероль юм уу эсвэл гэгээн Маргаритийн арал уруу цөлөх маягаар явуулсан байх. Нэг л сайхан өглөө тан дээр эргэж ирээд хөлөг онгоцны командлалыг хүлээх авна.
- Хэзээ л бол хэзээ ирэг. Түүний байр хадгалаастай байна. Харин одоо болтол яагаад ирэхгүй байна вэ? Наполеоны шүүх роялистуудын шүүхийн шоронд хийсэн хүмүүсийг юуны өмнө суллан тавих ёстой баймаар юм.
- Эрхэм Моррель та зэмлэх гэж битгий яар гэж Вильфор хэлээд -Ажил хэрэг бүхэнд хууль зүй шаардагддаг юм. Шоронд бас суллан тавих тухай тушаалыг мөн л дээд дарга нараас авах болно шүү дээ. Наполеон дөнгөж хоёр долоо хоногийн өмнө буцаж ирсэн. Хоригдлуудыг суллан тавих тухай тушаал одоо л бичигдэж байна гэв.
- Энэ ёс журмыг нь түргэн гүйцэтгэчихэж болдоггүй юм уу? гэж Моррель асуугаад - Бид ялсан улс шүү дээ. Надад найз нөхөд, холбоо харьцаа бий, тэр шийтгэх тогтоолыг хүчингүй болгуулж чадна гэв.
- Тогтоол байхгүй шүү дээ.
- Тэгвэл баривчлах тухай тогтоол.
- Улс төрийн хэрэгт, хоригдлуудын нэрсийн жагсаалт байдаггүй юм. Заримдаа засгийн газар хүнийг ор сураггүй алга болчихыг сонирхдог. Тэгэхээр нэрсийн жагсаалт байж байвал эрж олоход тус хүргэнэ шүү дээ.
- Бурбончуудын үед тийм байсан байж болох юм, харин, одоо...
- Цаг үе бүхэнд тийм байдаг юм, эрхэм Моррель, засгийн газрууд бие биеийгээ сольдог боловч бие биетэйгээ адил байдаг юм. Арван дөрөвдүгээр Людовикийн үед тогтоосон ял цээрлүүлэлтийн машин одоо хүртэл ажиллаж байна.

Зөвхөн Бастили л байхгүй болсон. Эзэн хаан бол шоронгийн дүрмийг биелүүлэх талаараа Людовик арван дөрвөөс ч илүү хатуу чанга бөгөөд, нэрсийн жагсаалтад нэр нь ороогүй хоригдлууд тоолж баршгүй олон байна.

Ийм эелдэг сайхнаар илэн далангүй ярих нь хэнийг ч итгүүлэхэд хүргэнэ. Тэгээд ч Моррель огтхон ч эргэлзэж сэжиглэсэнгүй.

- Хөөрхий Дантесыг түргэн буцааж ирүүлэх талаар яавал зохих тухай эрхэм де Вильфор юу гэж зөвлөхсөн бол?

- Шүүх яамны сайдад өршөөл гуйж өргөдөл оруул гэдэг нэг л зүйлийг зөвлөж чадах байна.

- Ай, эрхэм де Вильфор! Өргөдөл гэдэг чинь юу болохыг би мэднэ, шүүх яамны сайд тэр өргөдөл гэдгийг чинь өдөрт хоёр зууг хүлээн авна, тэгээд тэрнээсээ дөрвий нь ч уншдаггүй.

- Тийм ээ гэж Вильфор хэлээд - Гэвч тэр миний цохолттой буюу надаас шууд явуулсан өргөдлийг заавал уншина гэв.

- Тэгвэл та энэ өргөдлийг түүнд дамжуулж өгөх үү?

- Дуртайяа дамжуулна. Дантес урьд нь хэрэгтэн байсан байж болох юм. Одоо бол хэрэгтэн биш, тэгэхээр би түүнийг шоронд хийсэн шигээ бас шоронгоос суллах үүрэгтэй.

Вильфор ийм байдалтайгаар, хэдийгээр гарах боломжгүй ч гэсэн өөртөө аюултай үр уршиг тарьж өөрийг нь эргэлт буцалтгүй хөнөөл учруулж болох зүйлийг аргалан хаацайлж өнгөрүүлэв.

- Сайдад яаж бичих вэ?

- Эрхэм Моррель наашаа суу гээд Вильфор түүнд суудлаа тавьж өгөөд, - Би танд хэлж өгч бичүүлье гэв.

- Та яасан сайн хүн бэ?

- Тэгж хэлээд хэрэггүй. Харин бид цаг алдаад яах вэ, тэртэй тэргүй зөндөө цаг алдлаа.

- Тийм тийм хөөрхий амьтан хүлээж зовж байгаа, арга нь барагдаж байж ч магадгүй.

Вильфор чимээ аниргүй харанхуйн дунд өөрийг нь хараан зүхэж суугаа хоригдлыг бодоод чичрэн дагжив. Гэвч дэндүү хол гараад явчихсан учир ухарч

болохгүй болчихсон байв. Дантес түүний нэр төрд дуртай сэтгэлд дарагдан алга болох ёстой байв.

Моррель Вильфорын зөөлөн сандал дээр суугаад үзэг авч,

- Би бэлхэн байна гэж хэлэв.

Тэгэхэд Вильфор сайн санааны үүднээс, Дантесын эх оронч үзэл, түүнээс бонапартичдын хэрэгт үзүүлж байсан ач тусыг өсгөн нэмсэн өргөдлийн үгийг хэлж өгөв. Үүнээс үзвэл Наполеоныг буцаж ирэхэд гол үүрэг гүйцэтгэсэн хүний нэгэн нь Дантес болж харагдаж байв. Ийм өргөдлийг сайд үзмэгц тэр дороо шударга үнэний нь дахин олох ёстой болно. Тэгэхдээ энэ нь хийгдээгүй байсан бол шүү дээ.

Өргөдлийг бичиж дуусмагц Вильфор түүнийг чанга уншив.

- Сайн байна, одоо үлдсэний нь надад найдаж болно.

- Та хэзээ үүнийг явуулах вэ?

- Өнөөдөр л явуулна.

- Таны цохолттой явахуу?

- Хэрвээ энэ өргөдөл дотор бичсэн зүйл цөм чин үнэн гэж би батлан бичвэл тэр хамгийн сайн цохолт болно.

Вильфор ширээндээ суугаад өргөдлий нь булан дээр хэрэгтэй цохолтыг нь хийв.

- Одоо би цааш нь юу хийх вэ? гэж Моррель асуухад Вильфор,

- Хүлээж л бай, би бүгдийг өөрөө хариуцъя гэж хариулав.

Ийм итгэлтэй хариулт нь Моррелийг дахин итгэн горьдох болгов. Тэгээд вангийн прокурорын туслах дээрээс баяртай гарч өвгөн Дантест хүүтэйгээ удахгүй уулзана гэж хэлэхээр явав.

Гэтэл Вильфор тэрхүү өргөдлийг Парис уруу явуулахын оронд өөрөө гамтай хадгалав. Одоохондоо бол Дантесыг аврах энэ захидал нь Европт болж магадгүй байгаа тэр хэрэг явдал буюу дахин сэргэлт болох юм бол түүнд үхлийн уршиг учруулж болох ажээ.

Ингэж Дантес хоригдол хэвээрээ үлдэв. Харанхуй нүхэн дотор хаягдаж орхигдсон тэрээр XVIII Людовикийн дуулиантайгаар унасныг дараа нь түүнээс ч илүү хүчтэйгээр эзэнт төрийн задран сүйрснийг дуулж сонссонгүй.

Харин Вильфор бүхнийг нарийн ажиглаж, бүхнийг чих тавин анхаарч байлаа. Зуун өдөр хэмээн нэрлэгдсэн Наполеоны дахин буцаж ирсэн тэр үед Моррель хоёр удаа Дантесыг суллуулах гэж довтолсон болов, удаа бүрд нь Вильфор түүнийг амлалт горьдлогоор тайвшруулан өнгөрөв. Эцсийн эцэст Ватерлоо болов. Моррель Вильфор дээр дахин очсонгүй, тэр залуу найзынхаа төлөө хүний хүч хүрэлцэх л бүхнийг хийлээ. Дахин сэргэлтийн үед шинэ оролдлого хийвэл өөртөө л дэмий хор хүргэхээс хэтрэхгүй байв.

XVIII Людовик ширээндээ буцаж суув. Вильфор, дотоод сэтгэий нь зовоон тарчилгасан олон дуртгал сэтгэлд нь үлдээсэн Марселиас гарч Тулуз хотод вангийн прокурорын үүрэгт хүлээн авч очив. Энэ хотод ирснийхээ дараа хоёр долоо хоноод Рене де Сен-Меран хатагтайтай суув. Одоо хатагтайн эцэг ордонд онцгой хайр хишгийг хүлээсэн хүн болжээ.

Зуун өдөр ба Ватерлоогийн дараа Дантес хүмүүст биш юм гэхэд лав бурханд мартагдаж шоронд хоригдсон хэвээр үлдсэний учир ийм байна.

Наполеоны Францад буцаж ирснийг мэдээд, Данглар Дантест ямар цохилт өгснөө ойлгов. Түүний ховын бичиг зөвсондоо хүрчээ. Гэмт хэрэг хийхдээ овжин өдөр тутмын амьдралд хангалттай авъяастай бүх хүний адилаар энэ хачин тохиолдлыг «тэнгэрийн балаг» хэмээн нэрлэв.

Наполеон Парист ирж, түүний захирах хүчит дуу дахин цуурайтахад Данглар айв.

Бүх зүйлийг мэдэж байгаа өшөө хорслоо ямраар ч авч мэдэх Дантес хүрээд ирэх байх гэж цаг мөч бүрд хүлээн сандарч байў. Тэгээд далайн албанаас гарах хүсэлтэй байгаагаа Моррельд мэдэгдэж испанийн нэгэн томоохон худалдаачид явуулж өгөхгүй юу гэж хүсжээ. Ингээд Данглар гуравдугаар сарын сүүлч буюу Наполеоныг Тюильрд ирснээс арав, арван хоёр хоногийн дараа тэрхүү худалдаачныд конторын албан хаагчаар орж, Мадрид яваад, түүнээс хойш сураг чимээ нь сонстсонгүй.

Фернан ямарч учрыг олсонгүй. Дантес байхгүй байсан нь түүнд хамгийн хэрэгтэй зүйл нь байжээ. Дантес яагаа бол гэдгийг тэр мэдэхийг ч оролдсонгүй. Түүний бүх хүч анхаарал нь Мерседесийг болзоот хүн нь ирэхгүйн тухай янз бүрийн зохиомол юмаар хуурах ба яаж бүсгүйг дагуулан өөр тийшээ явах билээ гэдэг ганцхан зүйлд чиглэгджээ. Заримдаа Фаро хошууны өндөр орой дээр сууж, Марсель Каталан хоёрын зам өөд махчин шувууны нүд шиг хөдөлгөөнгүй харцаар, өшөө өвөрлөсөн гоо сайхан далайчин ирж яваагүй байгаа гэж харж сууна. Фернан Дантесыг буудан алж, дараа нь хүн алснаа далдлах гэж өөрийгөө буудахаар хатуу

шийджээ. Гэвч тэр өөрийгөө хуурчээ. Тэр бас л горьдсоор байгаа учир хэзээ ч өөрөө өөртөө гар хүрэхгүй байжээ.

Тэр завсар, энэ гунигт явдлууд болж байх үед, зэвсэг үүрч л чадах бүх хүнийг император цэрэгт татаж Францын хилийн цаана явуулж байв.

Фернан ч бусад хамт аян дайнд явж овоохой Мерседес хоёрыг орхиод, эзгүй байх хооронд нь өрсөлдөгч залуу ирээд хайртай хүүхэнтэй минь суучих вий гэж бодож тарчлан явав.

Хэрвээ Фернан амиа хорлох зориг чадвартай байсансан бол Мерседесээс хагацах үедээ лав биеэ хорлох байсан биз.

Мерседесийн уй гашууд сэтгэл зовсон дүр үзүүлж, түүний өчүүхэн хүсэл бүрийг хичээнгүйлэн биелүүлж байсан нь сайн санаат зүрхэнд нөлөөлж байлаа. Мерседес түүнд ах шигээ хайртай, энэ нөхөрлөл нь ачийг санан баярлах сэтгэлээр улам бэхэжжээ.

Мерседес, каталан залуугийн мөрөнд аяны нь үүргэвчийг зүүж өгөхдөө,

- Ах минь, ганц найз минь, биеэ мэдэж яв, миний нулимсаа гоожуулж суудаг энэ дэлхий дээр чамаас өөр хүн надад байхгүй шүү дээ, намайгаа битгий ганцаардуулаарай гэж хэллээ.

Салахдаа хэлсэн энэ үг Фернаны горьдлогыг улам сэргээжээ. Дантес эргэж ирэхгүй юм бол, Мерседес түүний эхнэр болох өдөр ирэхийг хэн байг гэх вэ.

Мерседес ганцаараа нүцгэн хадан дээр үлдэв. Энэ хад хэзээ ч түүнд хязгааргүй өргөн далайн өмнө ийм үр шимгүй мэт санагдаж байсангүй. Мерседес энэ хязгаарт домгийг нь ярьдаг галзуу эмийн адилаар нулимсаа гоожуулж Каталаныг тойрон сажилна. Заримдаа өрнөдийн шатаам халуун наранд хөшөө мэт хөдлөлгүй зогсож Марселийн зүг харна. Заримдаа тэнгисийн эрэг дээр сууж долгио давалгаалан шуугихыг чагнан ингэж найдлагагүй хүлээн, зовлон эдэлж сууснаас урагшаа бөхийж далайн гүнд орж алга болбол дээр юм биш үү? Хэмээн бодно. Мерседес аймхай зориггүйдээ амиа хорлож чадахгүй байсан биш харин бурханд сүсэглэж сэтгэлээ тайтгаруулдаг нь түүнийг аварчээ.

Кадруссыл бас Фернаны адил цэрэгт татсан боловч каталан залуугаас найман насаар ах, бас тэгээд эхнэртэй байсан учир түүнийг гуравдугаар §эрэгт, эрэг хавийн газрыг хамгаалахаар үлдэв.

Зөвхөн найдлага, горьдлогоор амьдарч байсан өвгөн Дантес императорыг унамагц сүүлчийнхээ горьдлогыг алдав.

Хүүгээсээ хагацсанаас яг таван сарын дараа, Эдмоныг баривчилж аваад явсан тэр цагт өвгөн Дантес Мерседесийн гар дээр нас барав.

Моррель, оршуулах зардлыг өөрөөсөө гаргаад өвчтэй байхдаа өвгөний зээлсэн бага сага өрийг төлжээ.

Энэ бол зөвхөн хүнч чанар төдийгүй зоригтой хэрэг байв. Өмнөдөд өөр хоорондоо арцалдах явдал өрнөж байсан энэ үед Дантес шиг тийм аюултай бонапартчийн эцэгт үхэх үед нь ч гэсэн туслах гэдэг бол ялт хэрэг байлаа.

14. Нэг нь солиотой нөгөө нь догшин хоёр хоригдол

XVIII Людовик эргэж ирснээс барагцаалбал нэг жилийн дараа ерөнхий байцаагч шоронгуудад шалгалт хийв.

Дантес газар доорх өрөөндөө сууж байгаад, дээд талд юм болж гэм чанга, харин доод талд, шөнийн харанхуйд шүлсээрээ тор сүлжиж байгаа аалзны дууг, бас газар доорх өрөөний таазан дээр хуран цугларахад нь бүтэн цаг шаардагдах усны дуслын унахыг сонсож дассан хоригдол хүнд л дуулдах төдий чимээ, хяхналтыг сонсов.

Амьд хүмүүсийн дотор ямар нэгэн юм болж байгааг ойлгов. Харин өөрөө өөрийгөө үхсэн хүүр гэж бодохоор тийм удаан булшинд суужээ.

Байцаагч шоронгийн өрөө тасалгаа бүрээр дэс дараалан Өров. Зарим хоригдлуудаас юм ч гэлээ асуув. Тэдгээр хоригдол даруу эсвэл аймхайг асаа болоод дарга нартаа гэмгүй харагдах болсон улс байв. Байцаагч тэднээс хоол унд ямар байгаа, эрэлт хүсэлт байна уу гэж асуув. Тэгэхэд тэд цөм дур гутмаар хооллож байна, суллаж өгөөч гэж нэгэн зэрэг хариулав. Тэгэхээр нь байцаагч өөр хүсэх юу байна гэж асуужээ. Тэд толгой сэгсрэв. Хоригдол хүн суллагдахаас өөр юу хүсэх билээ?

Байцаагч инээмсэглээд комендант өөд хандаж,

-Энэ ашиггүй эргэлт шалгалтууд хэнд хэрэгтэй юм, мэдэхгүй байна. Нэг л шорон үзвэл зуун шорон үзсэнтэй адил, нэг хоригдлын хэлэх үг сонсвол мянган хоригдлын хэлсэн үг сонсохтой адил, энд тэндгүй л адилхан муу хооллож байна, ямар ч гэмгүй гэдгээ л хэлэх юм. Өөр хоригдлууд танайд байхгүй юу? гэв.

-Аюултай бөгөөд галзуу солиотой хоригдлуудаа бид газар доорх давхарт авч байдаг гэхэд байцаагч ядарсан байдалтайгаар,

-Яая гэх вэ, үүргээ эцэст нь хүртэл биелүүлэхээс биш, доошоо бууцгаая гэж хэлэв.

-Үгүй дээ л хоёр цэрэг авч оролгүй болохгүй. заримдаа хоригдлууд арга нь тасарч амьдралд уйдаад ирэхээрээ алагдах ял оноолгохын тулд шийдэмгий цөхөрсөн юм хийдэг юм. Таны амь насанд халдаж мэднэ.

-Тийм бол болгоомжлох арга хэмжээ ав гэж байцаагч хэлэв.

Хоёр цэрэг хүрч ирж, тэд цөмөөрөө доош буув. Тэдний бууж яваа шатаар доошлох тутам бүх таван мэдрэхүйд хэцүү тээртэй, муухай үнэр үнэртэнэ. Байцаагч зогсоод,

-Чөтгөр ав! Энд чинь ямар амьтан сууж болдог юм вэ? Жэж хэлэхэд комендант,

-Онц аюултай луйвардагч, энэ хүн юу ч хий! чадах хүн гэж бидэнд сануулан мэдэгдсэн юм.

-Ганцаараа байдаг уу?

-Тэгэлгүй яах вэ.

-Энд удаж байгаа юм уу?

-Жил шахам болж байна.

-Авчраад л шууд газар доорх шоронд хийчихсэн үү?

-Үгүй, хоол зөөж байсан хуягийг алах гэж дайрсны дараа хийсэн

-Хуягаа алах гэсэн гэнэ ээ?

-Тийм ээ, намайг алах гэсэн юм гэж хариулав.

-Галзуу хүн байна шүү дээ!

-Түүнээс ч долоон дор, зүгээр л чөтгөр гэсэн үг гэж манаач хэлэв. Тэгэхэд байцаагч,

-Тэгвэл түүнээс гомдол нэхэж болно шүү дээ гэж хэлэв.

-Хэрэггүй дээ, хангалттай шийтгэгдсэн хүн. Тэгээд ч бас галзуурах дөхөөд байгаа юм. Одоо жил өнгөрөлгүй л бүр галзуурна. Бид туршлагаасаа мэдэж байна.

-Тэгвэл өөрт нь сайн даа гэж байцаагч хэлээд -галзуурчихаараа зовох нь бага болно гэв.

Байцаагч бол хүнч энэрэнгүй сэтгэлтэй энэ нигүүлсэнгүй үүрэгт ажилдаа тохирсон хүн болох нь харагдаж байгаа биз дээ.

-Таны хэлдэг түмэн зөв гэж комендант хариулаад - таны хэлж байгаа үг хоригдлуудыг сайн мэддэгийг харуулж байна. Манайд нөгөө талын шатаар очдог харанхуй шоронд урьд Италид нэгэн намын удирдагч байсан өвгөн ширээт лам бий. Тэр энд мянга найман зуун арван гурван оны эцсээр галзуурсан. Тэрнээс хойш танихын аргагүй болсон. Урьд уйлаад л байдаг байсан бол одоо инээгээд л байдаг, урьд нь тураад л байснаа одоо таргалаад л байна. Энүүний оронд та түүнийг үзэхгүй юу? Тэр бол хөгжилтэй галзуу. Танд уйтгар төрүүлэхгүй шүү гэж хэлэв.

-Би энэ хоёрыг хоёуланг нь үзнэ. Албан үүргийг үнэн сэтгэлээсээ биелүүлэх хэрэгтэй гэж байцаагч хэлэв.

Байцаагч өрөөр анх удаагаа шорон үзэж байгаа учраас дарга нартаа тоогдох гэж хүсжээ.

- Урьдаар энүүн дээр нь орьё гэж хэлэв.
- Болгооно уу гэж комендант хэлээд, хуяг өөд дохив.

Хуяг хаалга онгойлгов.

Хүнд түгжээ хангир жингэр хийж зэвэрсэн нугас хяхнан төмөр сараалжтай нарийхан завсраар орж ирж байгаа нарийхан гэрлийг хэлж баршгүй амтархан харсан Дантес толгойгоо дээш болгов.

Нэг танихгүй хүн, бамбар барьсан хоёр хуяг, хоёр цэрэг, бүрх малгайгаа гартаа барьсан комендант орж ирэхийг хараад Дантес учрыг ойлгож, одоо л дээд даргатай уулзах аз тохиолдлоо гэж урагшаа ухасхийн гараа элгэндээ зөрүүлэн барив.

Тэгмэгц цэргүүд байцаагч өөд муу юм үйлдэхээр ухасхийлээ гэж бодоод жадаа өмнүүр нь зөрүүлэв.

Байцаагч өөрийн эрхгүй алхам хойш ухрав.

Дантес өөрийн нь аюултай хүн болгон ойлгуулсныг мэдэв.

Тэгэхэд нь Дантес хүний л чадах хэмжээгээр номхон даруу байдал гаргаж, ирсэн хүмүүсийг гайхахаар дөлгөөхөн загнаж, өндөр тушаалт тэр хүний зүрхийг хөдөлгөхийг оролдов.

Байцаагч Дантесын хэлж байгааг дуустал сонсоод дараа нь комендант өөд эргэж,

- Зөв тийшээгээ болж байгаа хүн байна. Хэдийнэ номхрон, тогтуун байдалтай болжээ. Айна гэдгийг мэдэж байна. Жад хараад ухарч байгаагийн хараач. Харин галзуу хүн бол юунаас ч айдаггүй. Би энэ асуудлаар Шарантонд маш сонирхолтой ажиглалт хийсэн дээ гэж хэлэв.

Дараа нь хоригдол өөд хандаж,

- Товчоор хэлбэл, та юу хүсэж байгаа юм бэ? Гэж асуув.

- Миний ямар гэмт хэрэг хийснийг л надад хэлж өгөөч, шүүхээр тасалж, мөрдөн байцааж өгөхийг хүсэж байна, тэгээд сүүлд нь хэрвээ намайг буруутай бол буудан алж, гэм буруугүй бол суллан тавиач гэж хүсэж байна.

- Таныг сайн хооллож байна уу?

- Тийм байлгүй, мэдэхгүй. Тэгээд ч энэ бол гол чухал юм биш. Харин гэм буруугүй хүн, хуурамч мэдээнд өөрийгөө алсан яргачдыг хараан зүхсээр хохирон үхэхгүй байх нь азгүй хоригдол надаар зогсохгүй үнэн шудрагын шүүхийг бүтээгч засаг төрд ч, биднийг захиран суудаг ванд ч чухал юм.

- Та өнөөдөр маш номхон байх чинь юу вэ? Та дандаа ийм байдаггүй байсан шүү дээ. Хуягийг алах гэж байхдаа та шал өөр юм ярьж байсан гэж комендант хэлэв.

- Энэ үнэн, харин би надад маш сайн байдаг энэ хүнээс өршөөл уучлалт гуйж байна... Та нар юу хүсээ вэ? Би тэгэхэд галзуу солиотой байж гэж Дантес хэлэв.

- Аа, одоо үгүй юу?

- Үгүй, шорон намайг нуга дарж сөхрүүлжээ. Би энд ийм их удаж байна!

- Удаж байна гэнэ ээ? Таныг хэзээ баривчилсан бэ? Гэж байцаагч асуув.

- Мянга найман зуун арван таван оны хоёрдугаар сарын хорин найманд, өдрийн хоёр цагт гэхэд байцаагч бодож гарав.

- Өнөөдөр чинь мянга найман зуун арван зургаан оны долдугаар сарын гучин. Та мэдэхгүй байна, арван долоон сар шоронд сууж байгаа юм байна шүү дээ.

- Дөнгөж арван долоон сар гэнэ ээ! гэж Дантес давтан хэлээд, - Та мэдэхгүй байна, арван долоон сар шоронд сууна гэдэг чинь, арван долоон жил буюу арван долоон зуун жил гэсэн үг! Ялангуяа жаргахын даваан дээр очиж, гоо сайхан охинтой сууж, хүндэт тушаал хүлээх гэж байсан над шиг хүнд маш хэцүү байна. Гэрэлт өдөр нь харанхуй шөнөөр солигдож, ирээдүй нь алга болж, дурласан хүүхэн нь өөрт нь дуртай хэвээрээ байгаа эсэх, настай эцэг нь амьд мэнд эсэхийг мэдэхгүй сууж байгаа хүнд ямар байх вэ! Далайн цэвэр агаар амьсгалан, нүд алдам хязгааргүй уудамд дассан хүнд арван долоон сар шоронд суух гэдэг чинь юу вэ! Арван долоон сар шоронд суух гэдэг чинь хүмүүс хамгийн муухайгаар нэрлэдэг тэр гэмт хэрэгт ч гэсэн ихдэх хугацаа юм. Намайг энэрэн үзэж, өршөөхийн тулд биш, улам хатуу ширүүн шүүж, шүүх таслахад оруулж хайрлаач. Хэрэгтэн хүнийг шүүхээр таслуулъя гэж гуйж байхад татгалзаж болохгүй шүү дээ гэв.

- За яах вэ, үзэж байж больё гэж байцаагч хэлэв. Тэгээд дараа нь тэр комендант өөд хандаж,

- Энэ хөөрхий амьтан үнэхээр өрөвдөлтэй байна. Дээш гараад хэргийг нь надад үзүүлээрэй гэж хэлэв.

- Тэгье, харин та тэндээс хамгийн бүтэлгүй мэдээнүүд үзэх байх гэж айж байна гэж комендант хариулав. Тэгэхэд Дантес,

- Та намайг суллан тавих эрх байхгүй гэдгийг би мэдэж байна. Харин та миний хүсэлтийг дээд дарга нартаа уламжилж, мөрдөн байцааж, эцэст нь шүүхэд өгч болно шүү дээ. Миний хүсэж байгаа ганц хүсэлт бол шүүх! Н майг ямар хэрэг хийсний минь, ямар ял оноогдсоны минь надад хэлж өгвөл боллоо. Учир явдал тодорхойгүй байх нь энэ ертөнц дээр хамгийн хэцүү ялаас ч дор юм.

- Би учир явдлыг хянан үзье гэж байцаагч хэлэв.

- Таны сэтгэл хөдлөн, анхааран үеэж байгааг би дуугаар чинь мэдэж байна! Би танд найдаж болох нь ээ! гэж Дантес дуу алдав.

- Би тэгж хэлж чадахгүй гэж байцаагч хэлээд - Би зөвхөн таны хэргийг хянан үзье гэж хэлж чадна гэв.

- Тэгвэл л би суллагдаж, аврагдах нь тэр!

- Таныг хэний тушаалаар барьсан бэ? Гэж байцаагч асуув.

- Эрхэм де Вильфорын тушаалаар. Та түүнтэй яриарай гэж хариулав.
- Эрхэм де Вильфор одоо Марсельд байхгүй, тэр Тулузад очоод жил шахам болж байна.
- Тэгвэл гайхах юмгүй гэж Дантес шивнээд - Намайг өмгөөлөгч ганц хүн маань энд алга! Гэв.
- Эрхэм де Вильфор таныг үзэн ядах ямар нэг шалтгаантай юм биш биз? Гэж байцаагч асуув.
- Ямар ч юм байхгүй, харин ч надад ихэд өршөөнгүй байсан шүү.
- Тэгвэл таны тухай түүний үлдээсэн эсвэл надад өөрийн нь өгөх тодорхойлолтуудад итгэж болох уу?
- Бүрэн болно.
- За тэгвэл хүлээж л бай даа.

Дантес өвдөг дээрээ сөгдөн, гараа дээш тэнгэр өөд өргөөд хүний сүнсийг тамаас зайлуулахаар бууж ирсэн харанхуй шоронд нь аврагчийн ёсоор орж ирсэн энэ хүний төлөө мөргөн залбирав.

Байцаагчийг гарч явахад хаалга түгжигдсэн боловч түүний авчирсан горьдлого нь Дантесын өрөөнд хоцров.

- Та хоригдлуудын нэрсийн жагсаалтыг үзнэ үү, эсвэл доошоо бууж өнөөх ширээт ламыг үзэх үү гэж комендант асуухад, байцаагч,
- Юуны өмнө үзлэгээ дуусгая, хэрвээ би одоо дээшээ гарчихвал дахиж бууж ирэх зүрх хүрэхгүй байх гэж хариулав.
- Өө, ширээт лам үүнтэй адилгүй, хөгжилтэй галзуу, хөрштэйгөө адилгүй хүн.
- Тэр юунаас болж галзуурсан бэ?
- Хачин жигтэй юмнаас болсон. Өөрийгөө хэмжээ хязгааргүй их эрдэнэсийн сангийн эзэн гээд л байсан. Анхдугаар жилдээ засгийн газарт хэрвээ өөрийг нь суллавал нэг саяыг өгнө гэдэг байсан хоёрдугаар жилдээ хоёр сая, гуравдугаар жилдээ гурван сая гэх зэргээр нэмэгдсээр байлаа. Тэр одоо тав дахь жилдээ сууж байна. Таныг үзэхээр хоёулхнаа уулзаж ярилцъя гээд танд таван саяыг өгье гэж амлана даа.

- Энэ чинь үнэхээр сонин байна гэж байцаагч хэлээд - Тэр саятны чинь нэр хэн бэ? Гэж асуув.

- Ширээт лам Фариа гэдэг.

- Хорин долоон номертой юм аа! гэж байцаагч хэлэхэд,

- Тийм, энд байдаг юм. Алив Антуан онгойлгооч.

Хуяг хэлснийг нь гүйцэтгэхэд, байцаагч бүгдийн нэрлэдгээр «галзуу ширээт ламын» газар доорх өрөө уруу сонирхон шагайв. Тасалгааны дунд хананаас ховхорсон шохойгоор сараачсан дугараг хүрээний дунд бараг нүцгэн шахам хүн хэвтэж байв. Хувцас хунар нь ноорч гүйцжээ. Энэ хүрээн дотроо геометрийн дүрс тодхон зурж, Архимед ¶эрэг Марцеллад алагдах үедээ байсан шиг анхаарлаа дайчилсан байў. Ийм учраас хаалга онгойлгоход хөдөлсөн ч үгүй, харин ажиллаж байсан чийгтэй шалан дээр бамбарын ердийн биш гэрэл тусахад сая ухаан оров. Тэгээд эргэн харж шатаар бууж орж ирсэн олон хүнийг гайхан ширтлээ.

Ухасхийн босож, муу орныхоо хөл дээр байсан хөнжлийг шүүрэн авч, орж ирсэн гийчдэд арай ч аятай харагдах гэж нөмрөв.

Байцаагч ердийнхөө заншлаар,

- Та юу хүсэж байна гэж асуув.

- Миний хүсэж байгаа юм уу? гэж ширээт лам гайхан асуугаад - Би юу ч хүсэхгүй байна гэв.

- Та миний хэлснийг ойлгосонгүй, намайг засгийн газраас явуулсан, би шорон шалгаж, хоригдлуудын эрэлт хүсэлтийг хүлээн авч байгаа юм гэж байцаагч үргэлжлүүлэн хэлэв.

- Өө! Тэгвэл өөр хэрэг гэж ширээт лам сэргэн хэлээд - Бид хоёр үгээ ойлголцох байх гэж би найдаж байна гэв. Тэгэхэд комендант,

- За харж байна уу, миний хэлснээр л эхэлж байна даа гэв.

- Өршөөлт эрхэм ээ гээд ширээт лам үргэлжлүүлэн - Намайг ширээт лам Фариа гэдэг. Ромд төрсөн, их хамба Роспильозийнд хорин жил нарийн бичгийн дарга хийсэн, намайг мянга найман зуун арван нэгэн оны эхээр баривчлан авсан, чухам яагаад тэгэж баривчилсныг би мэдэхгүй. Үүнээс хойш би Итали, Францын засгийн газруудаас суллан тавихыг дэмий л шаардаж суух болсон юм гэв.

- Яагаад францын засгийн газраас билээ? Гэж комендант асуув.

- Намайг Пьомбинод байхад баривчлан авсан юм. Тийм болохоор Пьомбиног, Милан, Флоренц хотууд шЕг францын аль нэг мужийн гол хот болсон байх гэж бодож байна.

Байцаагч комендант хоёр инээмсэглэн бие бие өөдөө харав.

- За эрхэм минь Италийн тухай таны хэлж байгаа зүйл чинь шинэ сонин зүйл биш байна гэж байцаагч хэлэхэд, ширээт лам Фариа,

- Энэ бол намайг баривчилсан тэр үетэй холбогдоно гэж хариулаад - Эрхэм дээд император бурхнаас заяагдсан хүүдээ Ромын вант улсыг байгуулах гэж байсан болохоор би түүнийг ялалтаа үргэлжлүүлэн Италийг нэгтгэн нэгэн бүхэл нэгдсэн улс болгох гэсэн, Маркиавелли ба Цезарь Боржиагийн хүсэл мөрөөдлийг хэрэгжүүлэн байгаа юм байх гэж бодож байсан юм гэв.

- Аз болоход таны онц талархан үзэж байсан тэр төлөвлөгөөг бурхан бага зэрэг өөрчилчихжээ гэж байцаагч татгалзан хэлэхэд ширээт лам,

- Энэ бол Италийг хүчирхэг, тусгаар тогтносон, жаргалтай улс болгох ганц арга мөн гэж хариулав. Тэгэхэд нь байцаагч,

- Магадгүй юм, тэгэхдээ би тантай Италийн улс төрийн бодлогын чиглэлийг шүүмжлэн хэлэлцэх гэж ирээгүй, таныг орон сууц, хоол ундандаа тааламжтай байгаа эсэхийг асуух гэж ирсэн юм гэж хэлэв.

- Эндхийн хоол бусад бүх шоронгуудын хоолтой адил, өөрөөр хэлбэл маш муу байна гэж ширээт лам хариулаад - Байр минь чийгтэй, эрүүл агааргүй байна, гэвч газар доорх шорон гэхэд ерөнхийдөө овоо л байна. Энэ ч яах вэ, харин засгийн газарт мэдэгдэх гэсэн нэг чухал нууц зүйлд л хамаг учир байна гэв.

- За одоо л эхэллээ гэж комендант байцаагчийн чихэнд хэлэв.

- Хэрвээ амжилттай болвол Ньютоны бүх сЕстемийг ч өөрчилж мэдэх тийм то@цоо хийж байхад минь саад хийсэ боловч, би та нарыг хараад баярлаж байна. Би тантай хоёулхнаа уулзаж ярилцахыг зөвшөөрнө үү? Гэж ширээт лам үргэлжлүүлэн ярихад, комендант байцаагчид,

- Би танд хэлээгүй юү? Гэж шивнэв.

Тэгэхэд байцаагч инээмсэглэж,

- Та өөрийнхөө улсуудыг сайн мэддэг юм байна гэж хариулаад ширээт лам өөд хандаж - Би таны хүсэлтийг биелүүлж чадахгүй юм байна гэж хэлэв.

- Хэрвээ улсад их мөнгө жишээлбэл таван саяын хөрөнгө өгөх тухай яривал яах вэ?

- Гайхалтай байна, та тэр ч байтугай өгөх мөнгөний нь тоог хүртэл урьдчилан мэдчихсэн байна шүү гэж байцаагч комендантад хэлэв. Тэгээд байцаагч явах гэж байгааг хараад, ширээт лам үргэлжлүүлэн,

- За яах вэ, хоёулхнаа ч ярихгүй байж болно. Эрхэм комендант бидний ярианд байлцагч л даа гэж хэлэв.

- Эрхэм минь, бидэнд таны хэлэх байгаа зүйлийг чинь би нэгд нэггүй цээжээр мэдэж байна. Өнөөх л эрдэнэсийн сангийн тухай биз дээ, тийм үү? Гэж комендант түүний үгийг таслан хэлэв.

Тэгэхэд Фариа урьд нь дуулаагүй хүн бол саруул ухаан, үнэн шудрага сэтгэлийн нь олж харахаар тийм харцаар тэрхүү элэг доог хийгчийг ширтэв.

- Тэгэлгүй яах вэ, тэрнээс өөр би юу ярих вэ? гэж ширээт лам хэлэхэд комендант,

- Эрхэм байцаагч аа гэж үргэлжлүүлэн хэлээд - Би үүнийг таван жилийн туршид үргэлж сонсож байгаа болохоор энэ явдлыг ширээт ламаас доргүй ярьж чадна гэв.

- Эрхэм комендант аа, энэ бол таныг түүх сударт бичсэнчлэн нүдтэй мөртлөө юм үздэггүй, чихтэй байтлаа юм сонсдоггүй тэр хүмүүст хамаарагдах хүн юм гэдгийг нотлон харуулж байна гэж ширээт лам хэлэхэд байцаагч,

- Эрхэм минь, улс баян, бурхны ачаар улс таны мөнгөөр дутахгүй, харин та тэр мөнгөө, суллагдаж гарах хүртлээ хадгалж бай гэв.

Ширээт ламын нүд том болж байцаагчийн гараас шүүрэн авч,

- Хэрвээ намайг шоронгоос гаргахгүй бол, хэрвээ шудрага ёсыг зөрчиж намайг энэ зооринд байлгаад байвал, хэрвээ би өөрийнхөө нууцыг нэг ч хүнд гэрээслэн захиж үлдээж чадахгүй үхвэл, энэ бүх эрдэнэсийн сан дэмий хаягдаж өнгөрнө гэсэн үг болох нь ээ? Тэгсэнд орохноо энэ хөрөнгийг улс авч ашиглаад, далимд нь надад бас ашиг болбол дээр юм биш үү? Би зургаан саяыг өгөхийг зөвшөөрнө, би зургаан саяыг найр тавьж өгье. Хэрвээ би суллагдвал бусад нь надад хүрнэ гэж хэлэв.

- Нээрээ үүнийг галзуу хүн гэж мэдэхгүй байсан сан бол үнэн юм хэлж байна гэж итгэмээр ярьж байна шүү гэж байцаагч аман дотроо хэлэв.

Тэгэхэд хоригдол хүний сонор чихээр байцаагчийн ярьсан бүхнийг сонссон Фариа,

- Би галзуу хүн биш, би үнэн үг хэлж байна. Миний ярьж байгаа дармал эрдэнэ үнэхээр байгаа юм. Тэгэхээр надтай хамт миний хэлсэн газар очиж, бидний дэргэд тэр газрыг ухаж үзэх гэрээ надтай байгуул. Хэрвээ би худлаа хэлсэн байвал, хэрвээ юу ч олдохгүй бол, хэрвээ би та нарын хэлдгээр галзуу хүн юм бол намайг буцааж авчраад шоронд нэ хийчих, би эндээ хэнээс ч юу ч гуйж хүсэж шалгааж зовоохгүйгээ° үхье гэв.

Комендант инээд алдаад,

- Аа, таны тэр булмал эрдэнэ эндээс хол уу? гэж асуухад ширээт лам,

- Эндээс зуугаад бээр газар гэж хэлэв.

- Аюулгүй сайн зохиочихож шүү. Хэрвээ бүх хоригдол хуягнуудаа ийм хол зугаалахаар авч явах арга бодож олоод байвал, хэрвээ хуягууд нь тэдний хэлснийг зөвшөөрөөд байвал бололцоо дөнгөж гармагц л оргож алга болоод дүүрэх байх, ингэж хол явахад бололцоо заавал гарна даа гэв.

- Энэ арга бол бүхний мэдэх зүйл тэгэхээр эрхэм ширээт лам анх бодож олсон гэж бардамнахын ч аргагүй гэж байцаагч хэлэв.

Тэгээд дараа нь ширээт ламд,

- Би таныг сайн хооллож байна уу гэж асуусан шүү дээ? гэв.

- Өршөөлт эрхэм минь, хэрвээ намайг үнэнийг хэлж, дармал эрдэнэ байгаа газрыг зааж өгвөл суллан тавина гэж Иисус Христосыг барьж тангарагла гэж Фариа хариулав.

- Таныг сайн хооллож байна уу, үгүй юу? гэж дахин асуув.

- Тэгэхэд танд ямар ч муу юм болохгүй, би оргож зугтах арга эрээгүй байгааг харж байгаа биз. Тэр эрдэнэсийн санг олж, ухаж автал би шорондоо байж байя гэхэд байцаагч тэсэж ядан,

- Та миний асуултад хариулахгүй байна гэж үгийг нь таслан хэлэв.

- Аа, та миний хүсэлтийг! Гэж лам дуу алдаад, - Надад үнэмшээгүй тэр ухаангүй тэнэг улсууд шиг бас л хараал идэж яв! Та миний алтыг авах дургүй байвал алт наддаа үлдэг, надад эрх чөлөө өгөхийг хүсэхгүй байвал бурхан түүнийг надад өгөг. Явцгаа, надад одоо та нарт хэлэх юм алга гэв.

Тэгээд ширээт лам хөнжлөө мөрөн дээрээсээ авч хаяад, хэсэг шохой авч өнөөх дугараг дотроо орж шугам зургаа зурж, элдвийн бодлого бодож эхлэв.

- Энэ юу хийж байгаа юм бэ? Гэж байцаагч гарахдаа асуухад комендант,
- Өөрийнхөө эрдэнэсийг тоолж байгаа юм гэж хариулав.

Тэднийг ингэж дооглон ярилцахад, Фариа ихээхэн жигшсэн харцаар хариулав.

Тэднийг гарч одоход хуяг, хаалга цоожлов.

Байцаагч, шатаар өгсөж явахдаа,

- Нээрээ тийм эрдэнэсийн сан байгаа юм биш биз дээ гэж хэлэхэд комендант тосож аваад,
- Эсвэл зүүдэндээ үзсэн юм байлгүй. Тэгээд өглөө нь босоход галзуураад боссон байх гэж хэлэв.
- Тийм ээ, тэр үнэхээр баян хүн байсан бол шоронд орохгүй байсан байлгүй гэж байцаагч хээл хахууль авдаг хүний энгийн байдлаар хэлэв.

Ширээт лам Фариагийн тухайд гэвэл хэрэг явдал үүгээр төгсөв. Тэр шорондоо хоцорч, түүнээс хойш галзуу ширээт ламын алдар улам нэмэгдэв.

Агуу их дармал эрдэнэ эрэгч Халигуал, Нерон хоёрын аль нэг нь энэ хөөрхий хүний үгийг сонссон бол түүний мөрөөдөл болсон хээр тал, ийм их хөлс төлөх гэж амлаж байсан эрх чөлөөг нь түүнд бэлэглэх байсан даа. Гэтэл одоогийн энэ байгаа зүйлээр хязгаарлагдсан манай үеийн эзэд дээдэс бол хүсэн мөрөөдөх зоригоо алдаж, өөрсдийнхөө тушаалыг сонсож байдаг чихнээс, яаж биелэгдэхийг нь харж байдаг нүднээс айх болсон улс юм. Тэд бурхнаас заяасан өөрсдийн давуутай байдлыг ойлгон мэдрэхгүй, зөвхөн титэм өмссөн хүмүүс болж хувирчээ. Дээр цагт, өөрсдийгөө Юпитерийн хүүхдүүд гэж үздэг, үгүй дээ л тэгэж нэрлэж, үхэшгүй мөнх эцгээ зарим юмаар дуурайж байсан юм. Үүлний цаана юу болж байгааг шалгах тийм ч амархан биш, харин одоо бол дэлхий дээрх эзэд дээдэст хүрч тэднийг танин мэдэж болох болжээ. Хэмжээгүй эрхт засгийн газраас шорон ба тамлалтын үр уршгийг өдрийн гэрэлд гаргаж үзүүлэхийг хэзээ ч хүсдэггүй болохоор харгис шүүхийн олз болсон хүн өөрийн хугарсан яс, цус асгарсан шархыг гадагш гарган харуулдаг жишээ ховор учраас, шорон гяндангийн дотор би болсон ухаан солиорол, сэтгэлийн зовлон нь тэндээ нямбайлан хадгалагддаг юм. Хэрвээ тэндээс гарчихаж гэмээж нь ямар нэгэн зэвүүн эмчлэн сувилах газар оршуулж, оточ нар хуягуудаас авсан тэдгээр сүгнээс хүний дүрс, оюун бодлыг дэмий л эрдэг юм.

Ширээт лам шоронд ухаан самуурч, солиорлоороо өөрийгөө бүх насаараа шоронд хоригдох болгожээ.

Дантесын тухайд гэвэл байцаагч хэлсэн үгэндээ хүрч, комендантын тасалгаанд орж ирсэн хойноо хоригдлуудын хэргийн материалуудыг авчруулж үзэв. Дантесын тухай доорх агуулгатай зүйл бичигдсэн байлаа.

Эдмон Дантес

Засаршгүй бонапартич, узурпаторыг Эльба арлаас эргэж ирэхэд идэвхтэй оролцсон. Маш нууцаар, нарийн хяналтанд байлга.

Энэ тэмдэглэгдсэн зүйл бол бусад бичгийг адил хэүүэр бэхээр бичигдээгүй байв. Энэ нь Дантесыг шоронд хийснээс хойш нэмж бичсэн бөмбөхийг нотлон харуулна.

Шийтгэл нь маргахын аргагүй хатуу чанга байсан учир байцаагч дээр нь:

«Яах ч аргагүй юм» гэж нэмж бичив.

Байцаагч ирсэн явдал нь Дантесын сэтгэлийг сэргээв. Тэр шоронд орсон цагаасаа хойш өдөр сараа мартчихсан байв. Харин байцаагч түүнд өдөр, сар, он хэлж өгсөн учир Дантес түүнийг мартсангүй. Тэгээд тэр, адраас унасан хэсэг шохойгоор ханан дээрээ 1816 оны долдугаар сарын гучин гэж бичив. Түүнээс хойш өдөр сар алдахгүйн тулд өдөр бүр тэмдэглэх болов.

Өдөр, долоо хоног, сар өнгөрсөөр, Дантес хүлээсээр байв. Тэр эхлээд хоёр долоо хоногийн хугацаа тавив. Хэрвээ байцаагч өршөөнгүй сэтгэлийнхээ хагасыг нь ч гаргалаа гэхэд хоёр долоо хоногийн хугацаа хангалттай. Энэ хоёр долоо хоног дуусахад Дантес өөртөө байцаагч Парис орохоос нааш өөрийн нь хэргийг сөхөж үзнэ гэх горьдлого бол тэнэг хэрэг гэж хэлэв. Байцаагч даалгасан шалгалтын хийхэд сар хоёр сар хэрэгтэй байх бодоод Дантес хоёр долоо хоногийнхоо оронд гурван сарын хугацаа тавив. Энэ гурван сарын хугацаа дуусахад түүнд бас өөр нэг бодол төрж, хагас жилийн хугацаа тавив. Энэ хагас жилээ өнгөрөхөд бодоод үзвэл есөн сар хагас хүлээчихсэн байв.

Энэ хугацаанд түүний байдалд ямар ч өөрчлөлт гарсангүй, тайвшруулах ямар ч мэдээ авсангүй, хуяг хуучин янзаараа л хэлгүй юм шиг байв. Дантес өөртөө итгэхээ больж, толгойд нь орж ирсэн тэр бодол бол дэмий бодол, шоронд ирсэн тэр чигээ тэнгэр зүүд нойронд нь орж ирсэн юм байж гэж бодох бөмбөв.

Нэг жилийн дараа комендантыг өөрчилж, түүнд Гам гэдэг цайзыг өгчээ. Явахдаа өөрийн доор захирагдсан хүмүүсээс зарим нэгийг нь авч явсан бөгөөд тэдний тоонд Дантесын хуяг оржээ.

Шинэ комендант ирэв. Хоригдлуудыг нэрээр нь тогтоох түүнд залхуутай санагдсан тул зөвхөн тэдний дугаараар нь хэлж байхыг тушаажээ. Энэ аймшигт газар нь тавин тасалгаатай, тэнд суудаг хүмүүсээ дугаараар нь нэрлэх болж, золгүй хүү Эдмон гэдэг нэр Дантес гэдэг овгоосоо хагацаж, зөвхөн гучин дөрөв дугаартай хүн боллоо.

15. Дугаар 34, дугаар 27

Шоронд мартагдсан хоригдол хүний эдэлдэг бүх л зовлонг Дантес амсаж өнгөрөв.

Дантес анхандаа, итгэл найдвар ба өөрийгөө буруугүй гэж үзсэн сэтгэлээс үүссэн бардам зантай байв. Дараа нь өөрийнхөө гэм буруугүйд эргэлзэж, галзуурлын тухай комендантын онолыг тодорхой хэмжээгээр батлах болов. Эцэс сүүлд нь бардам өндөрт байхаа больж, мөргөж гуйх болов. Тэгэхдээ буханд биш, хүмүүст мөргөнө. Бурхан бол сүүлчийн горьдлого байдаг. Хүн бол зовлонд учрахаараа юуны өмнө бурханд ханддаг, харин Дантес бусад бүх горьдлого тасрахаар бурханд хандана.

Дантес өөрийгөө, улам харанхуй, улам чийгтэй газар доор шилжүүлж өгөхийг гуйв. Улам муутгалаа ч гэсэн өөрчлөлт л хийвэл хэдэн өдөр түүнийг зугаацуулах байв. Тэр гадуур салхинд гарах, юм унших, багаж хэрэглэл өгөхийг гуйв. Гэвч түүнд юу ч үл өгнө, тэгэхэд, Дантес бас л гуйсан хэвээр байв. Дантес хуягтай ярилцаж сурав, лэр нь урьдынхаас улам ч цөөн үгтэй боловч, тийм хүнтэй ч гэсэн үг дуугарна гэдэг Дантест маш их баяр байв. Дантес өөрийнхөө дууг сонсох гэж ярина. Тэр ганцаараа ярих гэж оролдсон боловч энэ нь түүнд хачин аймшигтай санагдав.

Дантес эрх чөлөөтэй байхдаа шорон гянданд байгаа тэнүүлчид дээрэмчид, хүний амь хороогч бузар баяраа хийцгээж хоорондоо хачин аймшигтай нөхөрлөл үүсгэж байдаг гэж жигшин боддог байжээ. Одоо бол тэр ийм дээрэмчдийн бүлгийн нэгд орж, үг дуу ч үгүй, энэрэх сэтгэлгүй гөлийсөн хуягийн царайнаас өөр царай харах юм сан гэж хүсэж, шившгийн муухай хувцас өмсөж, хөлдөө дөнгөтэй, мөрөндөө пайзтай ялт хөдөлмөрийн хэрэгтэн болоогүйдээ харамсана. Ялт хөдөлмөрийнхөн бол өөрсөдтэйгөө адил хүмүүсийн дунд амьдарч, агаараар амьсгалан, тэнгэр газрыг үзэж явна. Ялт хөдөлмөр хийгчид бол аз завшаантай улс юм.

Дантес хуягаасаа хүнтэй хамт суулгаж өгөөч, ядахдаа тэр урьд нь сонссон галзуу ширээт ламыг ч болов хамт суулгаж өгөөч гэж гуйна. Хамгийн хатуу ширүүн хуягийн дотор ч болов, хүнч сэтгэлийн өчүүхэн оч нуугдан хоцорсон байдаг ажээ. Дантесын хуяг гаднаа сэтгэлээ гаргахгүй боловч зовж тарчилж байгаа хөөрхий хүүг дотроо өрөвдөн хайрлана. Тэр 34 дугаартай хүний хүсэлтийг комендантдаа дамжуулан хэлэв. Гэвч комендант улс төрЕйн зүтгэлтэн хүний хашир болгоомжтой байдал гаргаж, Дантесыг хоригдлуудын толгойг эргүүлж, оргох хань олж авах гэж байна гэж бодоод татгалзжээ.

Дантес хүний хийж чадах бүх аргыг дуусгасан учраас, сүүлд нь бурхнаас тусламж гуйв.

Тэгэхэд хувь заяанд захирагдсан азгүй амьтны амьдарч байгаа сайн сайхан санаа бодол түүний сэтгэлийг сэргээв. Ээжийнхээ зааж өгсөн залбирлын үгийг санаж, урьд нь мэдэхгүй байсан утга санааг түүн дотроос олж мэдэв. Аз жаргалтай

хүмүүст бол мөргөл хийнэ гэдэг нэгэн хэвийн хоосон үг мэт санагдах бөгөөд харин зовлонд нэрвэгдсэн хүн бурхантай ярилцахад түүнд гүн санаа бодол төрөх шиг болно. Тэр хичээнгүй сэтгэлээсээ бурханд мөргөсөнгүй, харин догшин ширүүнээр залбирч байв. Чанга дуугарч мөргөхдөө өөрийнхөө дуунаас айхаа байчихжээ. Тэр үг хэлэх бүрдээ сэтгэл нь хачин жигтэй хөдөлж, бурхныг үзнэ. Дантес өөрийн номхорч баларсан амьдралын бүх явцыг бурхны таалал гэж үзэн, тэр явцаас сургамж авч, хамаг мөргөл залбирлаа тогтоон, бидний өрөө төлдгийн адил өгөх авралаа илгээгээч гэж жирийн хүн, бурхантай ярихаасаа хүнд хэлэх нь илүү сонсдог хамгийн харамгүй үгээр мөргөл залбирлыг дуусгадаг байлаа.

Дантес хичнээн их сүсэглэн мөргөсөн боловч шорондоо хэвээр үлдэв.

Тэгэхэд нь ухаан нь харанхуйлж, нүдийг нь манан бүрхэх шиг болжээ. Дантес бол боловсролгүй жирийн хүн байв. Өнгөрсөн үеийг халхлан байдаг хөшгийг шинжлэх ухаан түүнд нээж өгсөнгүй. Тэр өөрийн ганцаардмал шорон, хий бодол дотроо өнгөрсөн үеийг дахин сэргээж, дотоод сэтгэлдээ, Мартины в вилоны зургууд шиг галт туяа татсан тэнгэртэй, яруу тунгалаг их хотуудыг төрүүлэн дүрсэлж чадахгүй ажээ. Дантест ахархан өнгөрсөн үе, зовлонт одоо үе, үл мэдэгдэх ирээдүй л байв. Хязгааргүй ч байж магад харанхуй шөнийн дунд дурсан бодох саруул сайхан амьдралын арван есөн жил байв. Иймээс өөрийгөө юугаар ч зугаацуулж чадахгүй бөгөөд түүний авхаалжтай ухаан нь зуун жилийн цаадхыг ч мэдэхээр баяртай тэмүүлэх байсан болов, торонд орсон бүргэд шиг хавчигдан байх ажээ. Тэгэхэд нь Дантес нөхцөл байдлын гайгаас болж эвдэрсэн өөрийн жаргалын тухай нэгэн бодолтой зууралдана. Энэ санаагаа элдэв янзаар эргүүлэн тойруулан бодож, хэрвээ тэгж хэлж болдог бол Дантесын тамд дээд хамба Руджиерийн гавлыг Уголино хайр найргүй мэрдгийн адил шүдээрээ ч мэртээр санагддаг байв. Дантест, бүхнийг чадагчийн тухай итгэх эгшин зуурын бодол төрөх боловч бусдын адил удалгүй тэр итгэлээ алдаж, амжилт гарах цаг ирэх юуны магад гэж бодож хоцров. Гэвч тэрхүү амжилт нь ирсэнгүй.

Итгэл найдлага нь сандрал тэвдлээр солигдов. Тэр, бурхныг хараан зүхэх болсон учир хуяг нь түүнээс үхтлээ айдаг болов. Ямар нэгэн өчүүхэн төдий юм болоход шоронгийн ханыг толгойгоороо мөргөнө. Өөрий нь үзсэн, Вильфорын үзүүлсэн, өөрөө гартаа барьж үзсэн тэрхүү ховын бичгийн мөр бүр нь Валтарсарын Ёене, Текел, Фаресү гэдэг үг шиг шоронгийн ханан дээр галт үсэг болон харагдана. Намайг бурхан цээрлүүлж шоронд хийгээгүй, харин үзэн ядсан хүмүүс л ингэлээ гэж өөрөө өөртөө хэлнэ. Дантес эдгээр хүмүүсийг санаандаа орж ирснээр цаазаар авах боловч энэ нь хэтэрхий өршөөнгүй шийтгэл мэт бодогдоно. Цаазаар авахад хүн үхнэ. Хүн үхнэ гэдэг бол тайван нойрсол биш юм аа гэхэд үгүйдээ л тайван нойрсол мэт юу ч мэдэхгүй болно.

Тэр өөрийнхөө дайснуудын тухай бодохдоо үхэл гэдэг бол тайван нойрсол гэсэн үг, тэгэхээр хатуу ширүүн шийтгээ гэвэл цаазаар аваачих биш гэж бодохдоо амиа хорлох тухай бодол санаанд нь төрөхөд гунигтайгаар хөшиж мэлэрнэ. Гунихарч гутах тамд орсон хүн амиа хорлоё гэдэг бодолд баригдан зогсвол тэр

хүнд гаслан болно! Энэ бол тунгалаг хөх усны адил үхсэн тэнгис гэсэн үг. Энэ тэнгис дотор хөвж яваа хүн, өөрийнхөө хөлийг давирхай шиг зууралдсан замагт улам улам шигдэж үхэх цаг ойртож байгааг мэдэрнэ. Хэрвээ түүнд тэнгэр туслахгүй бол өнгөрөх нь тэр, тэгээд амиа аврах гэж өчүүхэн төдий оролдвол л түүнийг үхэл руу улам гүн живүүлдэг.

Гэсэн ч зан суртахууны энэ түр амсхийлт түүний өмнө тохиолдох зовлон шиг, магадгүй үүний дараа тохиолдох шийтгэл шиг тийм аймшигтай биш ээ. Энэ бол мансуурмаар тайвшруулах бөгөөд харлаг агч хавцлыг харуулна. Хавцлын ёроолд хов хоосон байна. Эдмон үүнийг бодохдоо тайвширна. Түүний бүх л зовлон зүдгүүр, дагалдан ирдэг хий үзэгдэл нь үхлийн сахиулсан тэнгэр өлмий тавихаар бэлдэж байсан шоронгийн тэр булангаас хийсэн зайлах шиJ болно. Дантес өнгөрсөн амьдралаа тайван харж ирээдүйгээ аймшигтайгаар төсөөлж, аль л амь хоргодож болохы нь сонгон авна.

Тэр өөртөө ярьсан нь:

- Би хүн байхдаа, алсын аянд явж байхад эрх чөлөөтэй, бүхнийг чадагч хүн, бусад хүмүүст тушаал өгч, тэд түүнийг нь дор нь биелүүлж байхад тэнгэрт хар үүл бүрхэж, долгио давлагаалан оволзож, тэнгэрийн хаяанд хар шуурга босож, аварга том бүргэд далавчаа дэвэх адил харагдахад миний хоргодох газар болсон хөлөг онгоц аварга том амьтны гар дээр байгаа ганцхан жаахан өд шиг дайвалзан ганхахыг мэдэрч байж билээ. Аймшигт давлагаан дунд үхлийг санагдуулагч цохио хад харагдаж, би үхэхээсээ айдаг байсан сан, тэгэхэд би түүнийг няцаах гэж бүх хүчээрээ оролдож, хүний бүх л хүчин чадал, далайчны бүх л авъяас чадварыг дайчилж бурхантай халз үздэг байсан сан. Тэгэхэд амьд үлдэнэ гэдэг бол жаргана гэсэн хэрэг байсан, тэр үеийн үхэл надад үл ойлгогдох үхэл байсан учраас би түүнийг сонгож аваагүй. Би хад чулуу, замагт ёроолд үүрд нойрсохыг хүсээгүй, түүгээр ч барахгүй бурхнаас бүтээгдсэн хүн, харцага, цахлай шувууны хоол болно гэж бодохоос дур гутдаг байжээ. Одоо бол өөр хэрэг: намайг амьдралтай холбож байсан бүх зүйлээсээ хагацсан, одоо бол үхэл намайг энхрийлэн бүүвэйлж байна. Би одоо дуртай үхнэ, энэ газар доорх шоронг гурван мянга тойрч, гучин мянга алхаж, арван бээр газар явган явж ядраад унтсан юм шиг л т йван үхнэ!

Дантес ингэж бодохоо° улам хөгжилтэй болж хатуу ор дэр, хар талхтайгаа хялбар амраар эвлэрнэ. Тэр тун бага идэж, бараг унтахгүй бөгөөд энэ амьдралыг хуучирч элэгдсэн хувцас тайлж хаях адил дуртай цагтаа өөрөөсөө авч хаяж болох элэгдсэн зүйл гэж үзэж байв.

Түүнд үхэх хоёр арга байв. Нэг нь бол маш амархан: нусныхаа алчуурыг цонхны сараалж торноос уяад дүүжилж үхэх, нөгөөдөх нь юм идэж байгаа дүр үзүүлсээр байгаад өлбөрч үхэх ийм хоёр арга байв. Нэгдүгээр аргыг Дантес жигшин үзнэ. Тэр бол хөлөг онгоцны шурагт хүн дүүжилж алдаг далайн дээрэмчдийг үзэн ядах үзлээр хүмүүжсэн хүн. Ийм учраас дүүжилж үхнэ гэдгийг

шившгийн үхэл гэж үзнэ. Тэгээд тэр хоёр дахь аргыг хэрэглэхээр шийдвэрлэж тэр өдрөөсөө эхлэн түүнийгээ хэрэгжүүлж эхлэв.

Дантес энэ зовлон зүдүүрийг амсаж эдэлсээр байтал дөрвөн жил орчим өнгөрчээ. Хоёр дахь жилийн сүүлчээр Дантес ханан дээр өдөр сар тэмдэглэхээ больж, байцаагчийн ирэхийн өмнөхтэй адил өдөр сараа мартжээ.

Тэр өөртөө: «Би үхэхийг хүсэж байна» гэж хэлэв. Тэгээд үхэх арга олж, түүнийгээ нарийвчлан бодоод, өөрийнхөө шийдвэрээс ухрахгүйн тулд өлбөрч үхнэ гэж тангараглав. «Надад өдрийн, оройн хоол авчирч өгөхөд цонхоор хаячхаад байя, тэд намайг бүгдийг нь идчихэж гэж бодог» гэж шийдэв.

Тэгээд шийдсэн ёсоороо хийж эхлэв. Авчирч өгсөн хоолы нь өдөрт хоёр удаа хөх тэнгэрийн зурвас хардаг байсан сараалжтай цонхоороо хаяж, анхандаа хөгжилтэй сайхан байснаа дараа нь бодлогошрох болж, эцэс сүүлд нь харамсах болов. Гагцхүү тавьсан тангараг нь тэр аймшигт шийдвэрээ биелүүлэх хүч чадал өгч байв. Урьд нь жигшин үздэг байсан энэ хоол нь одоо хачин сайхан, үнэртэй амттай юм шиг санагдах болов. Заримдаа тэр тавагтай хоолоо гартаа барьж, өлөн ховдог нүдээр ялзарсан үхрийн мах, өмхий загас хөгцөрсөн зүсэм хар талхыг бүтэн цагаар гөлрөн харна. Тэгэхэд амьдрах юм сан гэдэг бодлы нь сүүлчийн өчүүхэн хэсэг сэтгэл дотор нь аяндаа эсэргүүцэн тэмцэлдэж, заримдаа түүний шийдвэрийг ч давдаг байв. Тэгэхэд түүнд шорон нь тийм ч харанхуй гунигтай биш, хувь заяа нь ч тэгтлээ арга барагдсан байдалтай биш санагдана. Тэр залуугаараа, бодвол хорин тав, зургаагаас хэтрээгүй байгаа түүнд бас тавин жил амьдрах хугацаа байна, энэ бол түүний амьдарч өнгөрүүлснээс хоёр дахин их хугацаа гэсэн үн. Энэ барагдашгүй хугацаан дотор ямарч хамаагүй явдал гарч шоронгийн хаалгыг ховх татан. Иф цайдны ханыг цоо цохиж, түүнд эрх чөлөө олгож болох юм. Тэгж бодохоор хоолоо амандаа барих боловч, тэр дороо тавьсан тангаргаа санаж, өөрөө өөртөө дорд үзэгдэхээс айж зориггоо чангалдаг байв. Амьдралаа хайр найргүй, туйлбартайгаар унтрааж, эцэс сүүлд нь орноосоо босож идэх юмаа цонхоор хаяж чадахгүй боллоо.

Маргааш нь нүд нь юм харахаа байж, чих нь арай ядан сонсоно. Хуяг түүнийг хүндээр өвчилжээ гэж бодов. Эдмон одоо л удахгүй үхэх нь гэж горьдов.

Ингэж нэгэн өдөр өнгөрөв. Эдмоны бие хачин жигтэй, тэгсэн мөртөө өөрт нь аятайхан санагдахаар хөшиж эхэлж байхыг мэдрэв. Дотор нь харлан ам нь цангахаа бараг болив. Нүдээ анихад нь намаг дээгүүр хөвөн явж харагддаг тэнэмэл гал шиг цэг харагдах мэт болно. Энэ бол үхэл гэгч үл танигдахын орны туяа тусаж байгаа нь ажээ.

Гэтэл гэнэт оройн есөн цагийн үед ор нь байгаа ханын цаана бүгт чимээ гарах сонстов.

Энэ шорон дотор ой гутмаар бузар амьтад өдий төдий байдаг бөгөөд Дантес аажим аажмаар тэднийг хайхрахгүй унтаж сурчээ. Гэвч энэ удаад өлсөж ядарсан учир сонор нь хурцадсан ч юм уу эсвэл энэ чимээ ердийнхөөс чанга эсвэл амьдралын сүүлчийн эгшин зуурын хугацаа нь ач холбогдолтой болсноос тэр юм уу, алин боловч Эдмон толгойгоо өндийлгөж чагнав.

Энэ чимээ нь аварга том хумсаар маажих, эсвэл шүдээр мэрэх, эсвэл ямар нэгэн багажаар чулуу хусах мэт чимээ байв.

Хоригдол хүнээс үл салдаг эрх чөлөө! Гэдэг бодол Дантесын манарсан тархинд эгшин зуурын дотор орж ирлээ.

Энэ чимээ нь түүнийг дахин хэзээ ч ямар ч дуу чимсэ сонсохгүй болох гэж байсан тэр үед сонстов. Тэгэхэд тэр, эцсийн эцэст бурхан түүнийг энэрэн өрөвдөж авсанд өрөөсөн хөлөө хийчэхээд байж байхад нь үхлээс аврахаар энэ чимээг явуулсан байх гэж өөрийн эрхгүй бодов. Яаж мэдэх вэ, түүний хүсэн мөрөөдөж, бодож санаж суусан найз нөхдийнх нь аль нэг одоо хоорондох зайгаа багасгах гэж оролдож байж болох юмаа даа?

Үгүй байлгүй, энэ бол үхлийн даваан дээр үзэгдэж байгаа зүүд байх гэж түүнд бодогдов.

Гэвч Эдмон энэ чимээг чагнасаар л байв. Энэ маажлах чимээ гурван цаг хэртэй үргэлжлэв. Дараа нь нэг юм бутран асгарах шиг болоод таг чиг болов.

Нөгөө чимээ хэдэн цагийн дараа улам ойр, улам чанга сонстов. Эдмон энэ ажилд сэтгэлээрээ оролцон, өөрийгөө тийм ч ганцаардмал биш гэж санаж хэвттэл гэнэт хуяг орж ирэв.

Дантес үхэх гэж шийдсэнээс хойш долоо хоног өнгөрч, дөрвөн өдөр юу ч идсэнгүй, энэ хугацаанд хуягтайгаа юу ч ярьсангүй, асуусан юманд нь хариу ч дуугарсангүй, түүнийг дэндүү ширтээд байвал хана руу эргэн харж хэвтдэг байв. Харин одоо шал өөр болж хуяг энэ чимээг сонсож, болгоомжлоод амь тавьж байгаа Дантесын сэтгэлийг зогоож байсан ганц горьдлогыг тасалчихаж болох байв.

Хуяг түүнд хоол авчирч өгөв.

Дантес орон дээрээ өндийж, аль санаанд нь орсон юмаа хоол муу, өрөө нь хүйтэн нойтон байгаа тухай чанга чанга ярьж гарав. Тэр чанга ярих шалтаг эрж, өвчтэй түүнд аяга шөл шинэ талх гуйж авчирсан хуягийг гомцохоор харааж зүхэв. Аз болоход хуяг Дантесыг солиорч байна гэж бодоод, хоолоо дөргөлон ширээн дээр нь тавьчихаад гараад явчихав. Тэгэхэд Эдмон чөлөөтэйгээр санаа алдаад өнөөх чимээгээ баярлан чагнав.

Тэр чимээ нь чих тавин чагнахгүйгээр дуулдахуйц тодхон боллоо.

- Эргэлзэх юм алга гэж өөртөө хэлээд - Энэ чимээ өдөр бас үргэлжилж байгаа болохоор бас л над шиг нэг хоригдол өөрийгөө суллахын тулд ажиллаж байгаа биз. Хэрвээ би түүнтэй хамт байсан сан бол яаж туслах байсан болоо! Гэж бодов.

Дараа нь гэнэтийн тааврын хар үүл найдвар горьдлогыг нь туяаг бүрхчихэв. Аз завшаангүй явдалд дасчихсан ухаан хүнийг баяр жаргалд итгүүлэх гэдэг маш хэцүү. Энэ бол зэргэлдээ өрөөнд засвар хийлгэхээр комендантын явуулсан ажилчид юм хийж байгаа юм байна гэдэгт бараг эргэлзсэнгүй.

Үүнийг мэдэхэд амархан байв. Гэвч яаж асууж зүрхлэх билээ? Хуяг орж ирэхийг хүлээж байгаад түүнд энэ чимээг зааж, тэрүүнийг ямар байдалтай сонсохыг харчихвал хамгийн амархан, гэвч эгшин зуур биеэ тайвшруулах гээд аврагдах байсан юмаа алга хийчихвэл яана? ... Эдмоны толгой эргэв. Ухаан санаа нь манан шиг замхрахаар тийм их ядарч, нэгэн зүйл дээр төвлөрүүлэн бодож чадахгүй байв. Эдмон ухаан санаагийн нь сэргээх нэгэн зүйл байгааг харав. Хуягийн ширээн дээр тавьж орхисон хөрч гүйцээгүй байгаа хоолыг хараад босож гуйвалсаар түүнд хүрээд аягатай усан шөлийг авч, хэлж баршгүй сайхнаар амтлан уув.

Зөвхөн шөлөөрөө ханах зориг түүнд хүрэлцээтэй байв. Хөлөг онгоц сүйрсний дараа усан дотроос олдсон далайчид идэх юм уруу улайран дайрч идээд үхсэн байсныг дуулсан байжээ. Эдмон ам уруугаа хийх гэж авсан талхаа ширээн дээр буцааж тавиад дахин хэвтэв. Тэр одоо үхэхийг хүсэхээ больжээ.

Тэр удалгүй ухаан нь сэргэж байхыг мэдэрч, бүүр түүр бараг ухаангүй байсан санаа нь хуучин хэвдээ орж, хүнийг адгууснаас ялгах тэр цэгт хүрэв. Эдмон одоо юмыг зүй зохисоор нь бодож чадах болов.

Тэгээд өөртөө хэлсэн нь:

- Хэнийг ч илрүүлчихгүйгээр мэдэхийг оролдох хэрэгтэй. Хэрвээ энэ малтаад байгаа хүн жирийн ажилчин бол хана цохиход хаанаас хэн цохив гэдгийг мэдэх гэж ажлаа тэр дороо зогсох болно. Тэгээд ажил нь зөвхөн зөвшөөрөгдсөн биш, урьдаас төлөвлөгдсөн ажил бол тэр дороо дахин ажилдаа орох болно. Харин энэ хоиргдол байвал, миний цохилт түүнийг айлгаж, баригдчих байх хэмээн ажлаа зогсоож, бүх хүн унтсан байхаар бодож үдэш дахин үргэлжлүүлэх байх.

Эдмон тэр дороо орноосоо босов. Хөл нь гуйвж, нүд нь эрээлжлэхээ больчихсон байв. Шоронгийнхоо буланд очиж хананаас чулуу суга татаж аваад, түүгээрээ чимээ аль тодхон гарч байгаа хана уруу цохив.

Эхний удаа цохимогц л нөгөө дуу ид шидтэй юм шиг тэр дороо зогсов.

Тэгээд Эдмон чагнаад л байв. Нэг цаг өнгөрөв, хоёр цаг өнгөрлөө. Ямар ч чимээ алга. Эдмоны цохилт нь хананы цаад талд үхсэн юм шиг чимээ аниргүй болгов.

Найдаж горьдсон Эдмон бага зэрэг талх идээд, балга ус ууж, байгалиас заяасан эрүүл чийрэг биеийнхээ ачаар хүч чадал нь дахин бараг сэргэчихлээ.

Бүтэн өдөр өнгөрлөө, бас л чимээ аниргүй хэвээр.

Шөнө болоход бас л цохисонгүй хэвээр.

Эдмон хэлж баршгүйгээр баярлаж «энэ чинь хоригдол байна» гэж бодов. Тэр одоо сул дорой байхаа больж амьдрал нь шинэ хүчээр сэргэж, үйл хөдөлгөөнтэй идэвхтэй болов.

Шөнө нь ямар ч чимээ аниргүй өнгөрөв.

Эдмон энэ шөнийн турш цурам хийсэнгүй.

Өглөө болж, хуяг хоол авчирч өгөв. Дантес өчигдрийнхөө хоолны үлдэгдлийг идэж орхиод, өглөөнийхөө хоолыг ховдоглон идэв. Тэр өнөөх чимээг дахин сонстох болов уу гэж чих тавин чагнаж, үүрд зогсчихсон юм биш байгаа гэж бодохоороо бачимдан шорон дотуураа арав, арван хоёр бээр газар явахын дайтай алхалж, цонхны төмөр торыг бүтэн цагаар дугтарч, хувь заяатай үхэн хатан тэмцэлдэхэд булчин шөрмөсөө чангалан бэлтгэхийн тулд аль хэдийн мартагдсан дасгалуудыг хийж эхлэв. Бөх хүн барилдах талбар дээр гарахдаа биеэ тосолж, гараараа дасгал хийдэг. Заримдаа зогсож, чимээ гарч байна уу, үгүй юу гэж чагнан, өөрийнх нь ажлыг мөн өөр шиг нь чөлөөлөгдөхийн хүслэн болсон хүн зогсоосныг тааварлан мэддэггүй тэр хоригдлын болгоомжилсонд дургүй нь хүрнэ.

Гурван өдөр буюу хувь хувиар тоологдсон зовлонт далан хоёр цаг өнгөрөв.

Тэгж тэгж нэгэн орой хуягийг явснаас хойш, Дантесыг бараг л зуу дахь удаага хананд чихээ нааж чагнахад дүлий юм шиг дүнсийсэн хананд наасан толгойд нь нэгSn юм доргих шиг болов.

Дантес баярласан сэтгэлSэ дахин тэнцүүлэхийн тулд гэдрэгээ ухарч шорон дотуураа хэд тойроод дахин өнөөх газраа чихээ тавьж чагнав.

Эргэлзэх юм алга, ханын цаана ямар нэгэн юм болж байв. Бодвол түрүүчийн арга аюултай санагдсан учир өөр арга сонгон олжээ. Ажлаа тайван үргэлжлүүлэхийн тулд цүүцээ хөшүүргээр сольсон бололтой.

Өөрийнхөө нээлтэд зориг орсон Эдмон эцэж цуцашгүй тэр хөдөлмөрч хүнд туслахаар шийдэв. Чөлөөлөгдөх ажил явагдаж байгаа газар нь орных нь цаана

байсан учир ороо хананаас зайлуулан тавиад, ханыг эвдэлж нойтон шохойг нь хуулан хаяж чулуу гаргаж авах юм хайж эрэв.

Гэвч түүнд хутга ч, хурц үзүүртэй юм юу ч байсангүй. Харин сараалжны төмөр байсан бөгөөд түүнийг хөдөлгөхийн аргагүй бөх батыг аль хэдийний мэдэх ажээ.

Шорон доторх бүх зүйл нь ор, сандал ширээ, хувин ваар сав л байв.

Оронд нь төмөр хөндөл хийж түүнийг нь модонд эргэдэн тогтоосон байв. Түүнийг халбиар эргүүлж авахаас өөр аргагүй.

Ширээ сандалд нь юу ч байхгүй, хувинд нь сэнж байсан боловч түүнийг бас л авчихжээ.

Дантес домбоо хагалж, түүний хагархайн хурц ирмэгээр ажиллахаас өөр юм үлдсэнгүй.

Тэгээд домбоо шалан дээр хаяхад хэдэн хэсэг болон бутрав.

Дантес хурц үзүүртэй хоёр гурван хагархай авч дэвсгэр дороо нуугаад, бусдыг нь шалан дээр орхив. Ваар хагарах гэдэг бол ердийн хэрэг, ямар ч сэжиг төрүүлэхгүй.

Эдмон шөнийн турш ажиллаж чадах байсан боловч, харанхуйд ажил хэрэг бүтэмж муутай, тэмтэрч ажилламд хүрнэ. Удалгүй өнөөх хөөрхий багаж нь хатуу чулуунд мөхөж эхлэв. Тэгэхэд тэр ороо байранд нь буцааж тавиад өдөр болохыг хүлээв. Тэр итгэж найдахын хамт тэвчээртэй боллоо.

Эдмон бүхэл шөнийн туршид хананы цаана болж байгаа ажлын чимээг чагнав. Тэрхүү ажил нь өглөө болтол үргэлжлэв.

Өглөө болж, хуяг орж ирэхэд Дантес түүнд ам цангахаар нь юм уух гэж байгаад ваараа алдаад хагалчихлаа гэж хэлэв. Хуяг аман дотроо нэг юм үглээд, хагархайнуудыг нь ч түүлгүйгээр орхиж шинэ домбо авчрахаар явав.

Удалгүй хүрч ирээд болгоомжтойхон шиг байхыг зөвлөж, гараад явчлав.

Цоож хяхнан дуугарахыг Дантес баяртай сонсов. Урьд бол энэ цоож дуугарах бүрд зүрх нь базлах шиг болдог байв. Хуягийн хөлийн чимээ дөнгөж намдмагц ор уруугаа гүйн очиж зайлуулаад, газар доорх харанхуй шоронд нь орж ирж байгаа нарны гэрэлд шөнийн хугаст дэмий хөдөлмөрснөө харав. Тэр чулууг тойруулан малтахын оронд хэмлэх гэж дэмий нүдсэн байв.

Нойтон чийг шохойг зөөлрүүлжээ.

Шавар шохой унаж байгааг хараад Дантес баярлаж зүрх нь хүчтэй цохилгов. Үнэндээ тэр нь элсний ширхэг шиг өчүүхэн багаар ойчих боловч Дантес мөчийн дотор атга шороо ухчихав. Ийм шиг янзаар ажиллахад, хааш хаашаа тохой хэрийн уртаараа хорин тохой нүхийг хоёр жилийн дотор ухаж болно гэж тоо бодлогы ухаантай хүн хэлж чадах байсан биз.

Дантес хоосон горьдож, мөргөж, арга тасран байсан урьдын жилүүдийг энэ ажилдаа ашиглаагүй хий өнгөрүүлчихсэндээ харамсана.

Харанхуй шоронд сууж өнгөрүүлсэн зургаан жил дотор ямар ч нарийн чимхүүр ажлыг хийж гүйцэтгэж амжихгүй байсан гэж үү дээ!

Энэ бодол түүнийг улам шаргуу ажиллах болгов.

Тэр гурван өдөр хэмжээлшгүй болгоомжтойгоор ажиллаад бүх л шаврыг нь ховхлон хаяж чулууг нь гаргав. Ханыг нь шавартай зуурсан чулуугаар хийсэн бөгөөд улам бат бэх болгохын тулд зарим газруудад нь том хавтгай чулуу тавьжээ. Тэр ийм нэг том хавтгай чулуу ил гаргасан бөгөөд одоо түүнийгээ ганхуулан хөдөлгөх хэрэгтэй боллоо.

Дантес хумсаараа ч болов ухах гэж оролдсон боловч энэ нь ашиг болсонгүй.

Тэгэхээр нь чулууны завсраар ваарныхаа хэлтэрхийг хийж хөшүүрдэх гэсэн чинь хугараад болсонгүй.

Дантес бүтэн цагийн турш дэмийн оролдоод арга нь барагдан ажлаа орхив.

Энэхүү оролдлогоосоо няцаж, хөршийгөө ажлаа дуусгаж өөр дээр нь хүрч ирэхийг хүлээж дэмий суух гэж үү?

Тэгтэл түүнд шинэ санаа төрж, хөлөрсөн духаа арчаад босож инээмсэглэв.

Хуяг өдөр бүр төмөр саванд шөл хийж авчирдаг байв. Мөн энэ саванд бусад хоригдлуудад шөл аваачиж өгдөг бололтой. Энэ сав заримдаа дүүрэн, заримдаа тэхий дундаа хүртэл хоосон байх бөгөөд энэ нь чухам хаанаас эхлэн хоол түгээснээс болно.

Энэ саванд төмөр сэнж байв, энэ төмөр сэнж л Дантест хэрэгтэй байсан тул үүнийг амьдралынхаа арван жилээр ч болов авахдаа баярлах байв.

Хуяг заншсан ёсоороо Дантесын тавагт шөл хийж өгнө. Дантес энэ тавагтай хоолоо модон халбагаар идчихээд өдөр бүр өөрөө угаана.

Орой нь Дантес тавгаа үүднээс ширээ хүртэл замын хооронд шалан дээр тавьчихав, хуяг орж ирээд түүн дээр гишгэж, таваг хагарав.

Энэ удаа Дантесыг зэмлэж болохгүй байв. Тэр шалан дээр тавгаа хамаагүй тавьсан нь үнэн, гэвч хуяг замаа хараагүй явсан буруутай.

Хуяг зөвхөн аман дотроо нэг юм буйтнаад, шөл хийх сав ийш тийшээ харав. Гэвч Дантест энэ тавагнаас өөр сав байсангүй.

- Савтай нь орхичих л доо. Маргааш надад хоол авчирч өгөхдөө авахгүй юу гэж Дантес хэлэв.

Ийм зөвлөгөө хуягийн сэтгэлд тохирч, энэ нь түүнд дахин өөд уруугаа явах төвөг удахгүй болж байгаа хэрэг ажээ.

Тэр савтай хоолыг орхиход Дантес учиргүй баярлав.

Дантес шоронгийн загшлаар махыг нь дотор нь хийсэн шөлийг түргэн идэж орхиод хуягийг дахиад хүрээд ирэх бий гэж бүтэн цаг хүлээж байгаад, ороо наашлуулж, төмөр саваа авч төмөр сэнжийг нь өнөөх чулууныхаа завсраар өөрийн гаргасан нүхэнд шургуулан хөшүүрэгдэн гөнжив. Хана бага зэрэг доргихоор ажил хэрэг бүтэмжтэй болох нь гэж Дантес мэдэв.

Тэгээд ч үнэхээр нэг цагийн дараа уг чулууг авч хаяв. Тэгэхэд ханан дээр тохой илүү хэртэй талбай бүхий хөндий зай гарав.

Дантес унагасан шавраа цуглуулж байшингийнхаа буланд тавиад, ваарынхаа хагархайгаар цайвар шороо малтаж, түүнийгээ булав.

Аз дайралдаж чухамдаа гэвэл өөрийн нь авхаалж санаачлагатайн үрээр олдсон өнөөх үнэт багажаа дүүрэн ашиглахын тулд энэ шөнийн нэг ч минутыг алдахгүйг хичээн улам шаргуу ажиллав.

Дөнгөж үүр гэгээрмэгц, авсан чулуугаа буцааж нүхэнд нь хийж ороо байранд нь тавьчихаад унтаж өгөв. Хуяг орж ирж зүсэм талх ширээн дээр тавьчихаад гарах гэхэд нь Дантес:

- Та надад таваг авчирсангүй юу гэж асуув.

- Үгүй авчраагүй. Та дандаа юм хагалж байх юм, та ваар хагалсан, танаас болж би таны тавгийг хага гишгэчихсэн. Хэрэв хоригдол бүр ингэж хагалаад байвал засгийн газар нөхөж төлж дийлэхгүй шүү дээ. Танд энэ савыг орхиж дотор нь шөл хийж өгч байя, тэгвэл та сав суулга хагалаад байхгүй байх гэхэд Дантес тэнгэр өөд харж, хөнжил дотроо залбирав.

Гарт нь орж ирсэн тэр хэсэгхэн төмөр түүнийг хэзээ ч, тэр ч байтугай жаргалтай явж байх цагтаа ч баярлаж байгаагүйгээр ихэд баярлуулав.

Харин ганцхан зүйл сэтгэлий нь зовооно. Өөрийг нь ажиллаж эхэлснээс хойш өнөө хүн нь ажиллахаа больчихжээ.

Гэвч үүнээс болж өөрийнхөө санасан зүйлээс ухрах ёстой биш, хэрвээ хөрш нь түүн рүү ирэхгүй бол тэр өөрөө хөрш дээрээ очих ажээ.

Бүтэн өдрийн турш зогсолтгүй ажиллав. Үдэш болоход шинэ багажийнхаа ачаар арваад атга шаврын хэлтэрхий унагаж авч чаджээ.

Үдийн хоолны цаг болоход, савныхаа муруйсан сэнжийг чадах чинээгээрээ тэгшлээд байранд нь тавив. Тэр өдөр мацаг барих ёстой өдөр байсан тул хуяг загасны махтай шөл хувинд нь хийж өгөв. Хоригдлууд долоо хоногт гурван удаа мацаг барих ёстой байжээ. Хэрвээ Дантес өдөр хоног тоолохоо больчихоогүй бол энэ нь түүнд хуналы болж болох байв.

Хуяг шөл хийчхээд гараад явчихлаа.

Дантес энэ удаа өөрийнхөө хөршийг үнэхээр ажиллахаа бүр больсон эсэхийг шалгаж үзэхээр шийдэв.

Тэгээд чагнаж гарав.

Тэгэхэд ажил зогссон гурван өдрийнх шиг чив чимээгүй байв.

Дантес санаа алдав. Хөрш нь түүнээс болгоомжилсон бололтой аж.

Гэвч тэр сэтгэлээр унасангүй, харин гурван цаг хэртэй ажиллаад саадтай учрав.

Төмөр сэнж нь ухаж дийлэхээ больж гөлгөр гадаргуу дээгүүр халтиран гулсана.

Тэгэхээр нь Дантес гараараа тэмтрээд үзсэн чинь яс модонд тулсан байв.

Энэ яс мод түүний ухсан бүх нүхийг тагласан учир одоо түүнээсээ дээгүүр эсвэл доогуур нь ухах хэрэгтэй болов.

Золгүй хүү ийм саад тохиолдоно гэж бодсонгүй.

- Бурхан минь, бурхан минь! Гэж хашхираад - Би чамаас гуйсан сан, миний хүсэж мөргөснийг дуулсан байх гэж найдаж байсан юм сан! Бурхан чи миний чөлөөт амьдрал, тайван үхлийг надаас булаан авч, намайг амьдар гэж уриалан дуудсан шүү дээ. Одоо намайг өрөвдөн хайрлаж, арга нь барагдан үхэхээс авраач! Гэж гуйв.

Гэтэл зузаан хананы цаанаас ёстой л булшнаас дуудав уу гэлтэй бүдэг дуу гарч,

- Бурхан тэнгэр ба цөхөрсөн тухай ямар амьтан нэг амьсгаагаар ярьдаг байна? гэх нь газар доороос сонстох шиг болов.

Тэгэхэд Дантесын үс нь бос@х шиг болж, өвдөг дээрээ ч босолгүй хананаас ухарч,

- Би хүний дуу сонсож байна! гэж тэр шивнэв.

Эдмон дөрөв таван жилийн туршид хуягийн дуунаас өөр хүний дуу дуулсангүй. Хуяг гэдэг хоригдолд хүн биш санагддаг юм. Энэ бол царс модон хаалганы нэмэлт давхар хаалга, төмөр сараалжны давхар хаалт юм.

- Таны дуу намайг айлгачихсан боловч та бурхныг бодож дахин яриач. Та хэн бэ? Гэж Дантес хашхирав. Тэгэхэд өөдөөс нь:

- Аа, та хэн бэ? Гэж асуухад Дантес,

- Золгүй хоригдол байна гэж бодолгүй хариулав.

- Ямар үндэстэн бэ?

- Франц

- Нэр чинь хэн бэ?

- Эдмон Дантес

- Ямар ажилтай хүн бэ?

- Далайчин

- Энд удаж байна уу?

- Мянга найман зуун арван таван оны хоёрдугаар сарын хорин наймнаас энд байна.

- Яалаа гэж тэр билээ?

- Надад ямар ч буруу байхгүй,

- Гэвч таныг юу гэж яллаж байгаа юм бэ?

- Эзэн хааныг буцааж авчрах зорилготой хуйвалдаанд оролцсон гэж.
 - Юу! эзэн хааныг буцааж ирүүлэх гэнэ ээ? эзэн хаан хаан ширээндээ байхаа болио юу?
 - Тэр мянга найман зуун арван дөрвөн онд ширээнээсээ бууж, Эльба арал руу хүргэгдсэн. Харин та өөрөө энд удаж байна уу, та үүнийг мэдээгүй юм уу?
 - Мянга найман зуун арван нэгэн оноос.
- Энэ хүн өөрөөс нь дөрвөн жилээр удаан шоронд сууж байгааг дуулаад Дантес цочин татвасхийв.
- За, ухахаа боль гэж өнөөх дуу хэлээд - Таны ухсан нүх чинь аль хир өндөрт байна вэ гэдгийг надад хэлээдхээч? Гэв.
 - Газарт й чацуу.
 - Энүүнийг чинь юу халхалж байна вэ?
 - Миний ор.
 - Таныг шоронд орсноос хойш оры чинь хөдөлгөсөн үү?
 - Нэг ч удаа хөдөлгөөгүй.
 - Таны тасалгаа хаашаа хардаг вэ?
 - Гудам руу.
 - Аа, гудам чинь?
 - Хашаа руу.
 - Ямар азгүй хэрэг вэ! гэж өнөөх дуу дуугарав.
 - Бурхан минь! Юу болчихов? Гэж Дантес асуув.
 - Би андуурчихжээ, төлөвлөгөө маань бүрэн дүүрэн хийгдэж чадаагүй учир намайг төөрөгдүүлчихлээ, гортиг байгаагүй явдал намайг баллачихлаа. Зураг дээрх ганц шугамаар андуурсан нь үнэн байдалд арван таван тохой зөрүүлчихлээ. Би таны өрөөг цайзнаас гадагшаа гарсан хана юм байх гэж бодчихжээ.
 - Хэрвээ тийм байсан бол тэнгис хүртэл ухах байсан уу?

- Би тэгэх л гэж байсан юм.
- Хэрвээ энэ чинь бүтсэн бол...
- Тэгвэл би тэнгис уруу үсрэн орж, Иф цайзыг тойрсон арлуудын аль нэгэн өөд хөвж Дом ба Тибулан арал хүрэх буюу эсвэл эрэг хүртэл сэлж амь аврагдах байсан юм.
- Та тийм зайг нэвт сэлж чадах байсан гэж үү?
- Бурхан надад тийм хүч өгөх байсан юм. Харин одоо өнгөрчээ.
- Гүйцэв үү?
- Гүйцлээ. Нүхээ аль болохуйц болгоомжтой бөглөөрэй, цааш нь ухах хэрэггүй, юу ч битгий хийгээрэй, надаас мэдээ хүлээж бай.
- Үгүй та тэгээд хэн гэгч вэ?.. Ядахнаа нэрээ хэлж өгөөч?
- Би... би хорин долоо дугаартай хүн.
- Та надад итгэхгүй байна уу? гэж Дантес асуухад цаана нь зэвүүн инээх сонстов.

Тэгэхэд өөртэй нь ярилцаж байгаа үл таних хүн өөрий нь орхихоор шийдэж байгааг зөнгөөрөө мэдэрсэн Дантес,

- Би сайн санаат христус шашинтан байна! гэж хашхираад - Би энэ нууцыг өөрийгөө ба таныг алагчдад хэзээ ч илрүүлэн хэлэхгүй гэж бурхны нэрийг барьж тангараглая. Тэнгэрийг бодож та надаас дуугаа бүү холдуулаач, тэгвэл би толгойгоороо хана хага мөргөж үхнэ, миний үхэлд та холбогдоно шүү гэв.
- Та хэдэн настай вэ? Таны дууг сонсвол залуу хүн бололтой.
- Би энд хоног хугацаагаа мартчихсан тул одоо хэдэн настайгаа мэдэхгүй байна. Өдий насандаа хүн урвагч байж болохгүй гэж өнөөх дуу хэлэв.
- Үгүй, үгүй! Би танд тангараглая! Би таныг барьж өгсөнд орвол хэдэн хэсэг болгон огтчин тасдуулсан нь дээр гэдгийг танд хэлж байна шүү дээ гэж Дантес давтан хэлэв.
- Та надтай ярьсан чинь сайн хэрэг боллоо. Би таныг гуйж хүсээгүй бол өөр төлөвлөгөө зохиогоод танаас холдох гэж байсан юм. Харин таны насны байдал миний сэтгэлийг тайвшруулж байна. Би тан дээр очно намайг хүлээж бай.

- Хэзээ ирэх вэ?

- Үүнийг бодох хэрэгтэй, би танд дохио өгнө.

- Та намайг хаяхгүй биз, намайг ганцааранг минь орхихгүй биз, та над дээр ирэх үү, эсвэл би тан дээр очихыг зөвшөөрөх үү? Хоёулаа хамт зугатъя. Хэрвээ зугтаж болохгүй юм бол та өөрийнхөө дуртай хайртай хүмүүсийн тухай, би өөрийнхөө хайртай дуртай хүмүүсийн тухай ярилцаж байя. Танд хайртай дуртай хүн бий биз дээ?

- Би энэ ертөнц дээр ганцаараа хүн.

- Тэгвэл та намайг хайрла, хэрвээ та залуу хүн бол би таны найз нөхөр болъё, хэрвээ өвгөн настай хүн бол хүү чинь болъё. Надад аав бий, тэр минь одоо амьд байгаа бол далан настай хүн байх ёстой, би зөвхөн аавдаа ба Мерседес гэдэг нэгэн охинд хайртай. Аав минь намайг мартаагүй, би үүнийг сайн мэдэж байна, харин тэр охин...намайг дурсан санаж байгаа эсэхийг хэн мэдэх билээ! Би танд эцэг шигээ хайртай байна.

- За, тэгвэл сайн гэж хоригдол хэлээд - Маргааш болтол баяртай гэв.

Энэ үг Дантест итгэлийг нь төрүүлэхээр сонстов. Түүнд үүнээс өөр юу ч хэрэг байсангүй. тэр босож хананаас ухаж гаргасан хогоо нуугаад, ороо хана өөд нь шахав.

Дараа нь жаргалдаа автан чөлөөтэй хэвтэв. Тэр одоо лав ганцаараа байхгүй, бас ч оргож ч магадгүй. Шорондоо хэвээр байлаа ч гэсэн найз нөхөдтэй болно. Дундуураа холбогдсон шорон бол дөнгөж хагас шорон, хоёулаа хамтарч гомдлоо гаргах нь бараг мөргөл гэсэн үг, хоёулаа мөргөсөн мөргөл бол бараг л хишиг буян гэсэн үг.

Дантес бүтэн өдрийн турш газар доорх харанхуй шорон дотроо хойш урагшаа алхалж, баяр хөөрөөр дүүрнэ. Заримдаа гараараа элгээ дараад, орон дээрээ сууна. Гудамд өчүүхэн дуу гарах бүрд үү уруу гүйнэ. Мэдэхгүй танихгүй боловч найз нөхөр шигээ хайртай болсон тэр хүнээс нь хагацаан салгачих бий гэхээс айдас нь хүрнэ. Хэрвээ хуяг орж ирээд оры нь наашлуулж, ухсан нүхий нь харах гэж бөхийвөл устай ваар тавьсан чулуугаар тархий нь хага цохиж алахаар шийджээ.

Ингэвэл түүнд алах ял онооно, түүнийг сайн мэдэж байв. Түүнд амьдралыг эргүүлж авчирсан тэр шидтэй дууг сонсохдоо уйдаж, арга нь барагдан үхэх гэж байсан биш бил үү?

Орой нь хуягийг орж ирэхэд Дантес орон дээрээ хэвтэж байв. Ингэж хэвтэж байвал бөглөж дүүргээгүй байгаа нүхээ сайн хамгаална гэж боджээ. Маш их уйтгар гунигтай нүдээр хуяг өөд хачин жигтэй харсан тул цаадах нь,

- Яав? Дахиад солиорч байна уу? гэв.

Дантес чичирсэн дуугаараа нууцаа илрүүлчих бий гэж айгаад хариу дуугарсангүй. Тэгэхэд нь хуяг толгойгоо сэгсрээд гарч одов.

Шөнө болоход Дантес хөрш нөхрөө харанхуй ба чимээ аниргүй байгааг ашиглаж, эхэлсэн яриагаа үргэлжлүүлэх байх гэж горьдож байв. Гэвч тэр андуурчээ. Гайхаш нь тасран хүлээхийг нь ямар ч дуу чимээ саатуулсангүй. Өглөө хуягийг орж ирээд гарсны дараа ороо хананаас зайлуулахад гурван удаа жигдхэн цохих сонстов. Тэгэхэд өвдөг дээрээ сөхрөн унаж,

- Та юу? гэж асуугаад - Би энд байна гэв.

- Хуяг явчихсан уу? гэж тэр дуу асуув.

- Явчихсан, одоо оройноос нааш ирэхгүй. Бидний мэдэлд бүтэн арван хоёр цаг байна гэж Дантес хариулав.

- Тэгвэл одоо ажиллаж эхэлж болох нь ээ? гэж өнөөх хүн асуув.

- Болно, болно, бушуулаарай, одоохон шиг, танаас гуйя!

Тэгтэл Дантесын хоёр гараараа тулж байсан газар цөмрөхөд нь ар тийшээ ухарвал баахан шороо чулуу асгаран унаж цоорхой гарав. Тэгтэл гүний нь харж хэмжиж амжаагүй нүхэн дотроос толгой, мөр цухуйж дараа нь нэг хүн нэлээд шалмаг байдлаар гарч ирэв.

16. Италийн эрдэмтэн

Дантес аль хэдийнээс эхлэн хүсэж мөрөөдсөн шинэ найзыгаа тэв^оэн авч, түүнийг гэрэлд сайн харах гэж цонхоор орж ирсэн бүдэг туяанд аваачив.

Кнэ бол намхан нуруутай, хөгширснөөс бус зовлон гунигаас болж бууралтсан үстэй, өтгөн буурал хөмсгөн дороо нэвт ширтсэн хурц нүдтэй, цээжиндээ хүрсэн хар сахалтай хүн байв. Гүн үрчлээ суусан туранхай царай, ухаалаг, зоригтой байрын төрх нь түүнийг биеийн хүчний талаар чангарснаасаа оюун ухааныхаа талаар илүү дасгал хийж хөгжсөн хүн болохыг илчилнэ. Түүний духнаас нь хөлс цувна. Харин хувцасны тухайд гэвэл урагдаж ноороод урьдын нь хийцийг танихын аргагүй болсон ноорхой навтас төдий юм байв.

Харахад жаран таваас доошгүй настай бололтой.

Өвгөрч ядарсан нь насных биш, харин он удаан хоригдсоноос болсон болов уу гэж хэлмээр нэлээд шалмаг хөдөлгөөнтэй хүн байв.

Залуу хүү баярлаж хөөрч байгаа нь түүнд аятайхан санагдаж, хөрч хүйтэрсэн сэтгэл нь Дантесын гал дөл бадарсан сэтгэлтэй дайралдмагц бүлээцэн дулаацав бололтой. Эрх чөлөө олох гэж горьдож байсан горьдлогынхоо оронд өөр нэг харанхуй шорон олсондоо ихэд гунихарсан боловч, залуу хүү баяртай хүлээн авсан явдалд баяр талархлаа илэрхийлэв.

- Юуны өмнө, энэ ухсан ул мөрөө харуул манаанаас далдлах арга байгаа эсэхийг үзье. Бидний ирээдүйн тайван байдал үүнээс шалтгаална гэж хэлээд, нүх уруу тонгойж, хүнд чулууг төдий л төвөггүйгээр өргөж хуучин байранд нь тавив.

Тэгээд толгой эгсэрч,

- Та энэ чулууг болгоомжгүй хамаагүй авч гэж хэлээд - Танд багаж байхгүй юм гэж үү? Гэж асуув.
- Аа, танд бий юу? гэж Дантес гайхан асуув.
- Би зарим нэг багаж хийж авсан. Хуурайнаас л бусад, цүүц, бахь, хөшүүрэг бий.
- Би таны тэвчээр, уран чадварын үр болсон тэдгээр багажуудыг чинь үзэх юм сан гэж Дантес хэлэв.
- Хар л даа энэ цүүц байна гэж хурц иртэй, модон иштэй хавтгай төмөр үзүүлэв.
- Та үүнийг юугаар хийв? Гэж Дантес асуув.
- Миний орны хөндөл төмөр. Би энэ зэвсгээр наашаа ирсэн тавин тохой шахам зам ухсан.
- Тавин тохой ий? Гэж Дантес гайхан дуу алдав.
- Аяархан яриарай, залуу хүн, аяархан яриарай, хоригдлуудын үүдэн дээр хүн чагнах нь олон байдаг юм гэж өвгөн хэлэв.
- Намайг ганцаараа байдаг гэдгийг мэднэ шүү дээ.
- Ялгаагүй.
- Та тавин тохой зам ухлаа гэж ярив уу?

- Тийм ээ, та бид хоёрын өрөөний хооронд барагцаалбал ийм зайтай байгаа юм. Надад хураангуйлсан хэмжээг тодорхой тогтоох геометрийн хэрэгсэл байхгүй учраас би муруйгий нь буруу тооцчихож. Зууван нь дөч биш тавин тохой байж л дээ. Би гадаа хананд хүрч, түүнийг цоо цохиод тэнгист үсрэн орох гэж байсан гэж танд хэлсэн шүү дээ. Би танай доогуур ухахын оронд танай өрөөний хаалга гарсан гудамтай чацуу ухчихаж. Гудам нь манаач, хуягуудаар дүүрэн хашаа уруу харсан учир миний хөдөлмөр дэмий өнгөрчээ.
- Энэ үнэн гэж Дантес хэлээд - Харин гудам бол өрөөний ганц ханын дагуу өнгөрдөг, гэхдээ өрөө маань дөрвөн ханатай шүү дээ гэв.
- Мэдээж хэрэг, гэвч энэ ханыг цохио хад хүрээлж байгаа юм. Чухал хэрэгтэй багажаар зэвсэглэсэн нүх малтагч арван сайн эр энэ хадыг арван жил ухлаа ч цоолж чадахгүй байх. Тэр хана нь комендантын байшингийн суурьт тулж байгаа. Бид үүгээр явбал цоожтой зооринд орж зайлшгүй баригдах болно, аа энэ хана...байз байз! Энэ хана чинь хаашаа харж байна вэ?

Энэ хананд гэрэл орох нүх гаргасан бөгөөд, түүгээр гэрэл орж байв. Энэ нүх нь нарийссаар нарийссаар зузаан хана руу улам гүн орно. Тэр завсраар нялх хүүхэд ч багтахгүй, түүнээс гадна гурван давхар төмөр сараалж хадсан учир, ямар ч хартай хуяг ч гэсэн хоригдлыг оргочих байх гэж айн болгоомжлохгүй байж болох ажээ. Зочин асуулт асуугаад ширээгий нь цонх өөд аваачиж,

- Ширээн дээр гар гэж Дантест хэлэв.

Дантес түүний үгэнд орж, ширээн дээр гараад нөхрийнхөө бодлыг тааварлан мэдэж, нуруугаараа хана түшиж, хоёр алгаа тосож зогсов.

Тэгэхэд өөрийнхөө дугаарыг хэлж өгснөөс биш Дантес жинхэнэ нэрийг нь мэдэхгүй байгаа өвгөн, тэгнэ чинээ санахын аргагүйгээр муур шиг ч гэмээр юм уу, гүрвэл шигээр хурдан хөдөлж, эхлээд ширээн дээр гарч, дараа нь Дантесын алган дээр гишгээд, тэндээсээ түүний мөрөн дээр зогсож, намхан дээвэр толгойд нь тулсан учир бөхийгөөд, төмөр сараалжийн хоорондуур толгойгоо хийж, доошоо харав.

Тэгснээ нэг минутын дараа толгойгоо буцааж гаргаад,

-Үгүй ер! Гэж дуугарснаа - Би тэгж бодсон юм гэж хэлэв.

Тэгээд Дантесын мөрөн дээрээс шЁрээн дээр буугаад, ширээн дээрээсээ шал уруу үсрэн буув.

Дантес түүний хойноос үсрэн буугаад, сэтгэл нь зовсон байдалтай,

- За юу болов? Гэж асуухад, өвгөн бодлого болж,
- Тэгнэ ээ тийм л байх ёстой, таны өрөөний дөрөвдүгээр хана чинь эргүүл манаа байнга явдаг тойруу зам руу харсан юм байна гэж хэлэв.
- Та энэ хэлж байгаадаа бүрэн итгэлтэй байна уу?
- Би цэргийн өндөр малгай, бууны үзүүрийг нь харлаа. Тэгээд түүнд харагдчих бий гэж толгойгоо нааш нь болгосон юм.
- Тэгээд яах вэ? гэж Дантес асуув.
- Танай өрөөгөөр дамжиж оргож болохгүй гэдгийг та өөрөө харж байгаа биз.
- Тэгээд юу болох вэ? гэж Дантес үргэлжлэн хэлэв.
- Тэгээд юу болохыг бурхан л мэддэг байх даа! Гэж өвгөн хэлэхдээ үнэхээр сүслэн дагасан нь түүний царайд илэрлээ.

Өчнөөн жил мөрөөдөж ирсэн хүслээсээ ийм амархан тайвнаар буцаж байгаа хүнийг Дантес гайхан бахархаж харав.

- Одоо та хэн болохоо надад хэлж өгөөч! Гэж Дантес асуухад,
- За яах вэ, өөртчинь юугаар ч тус болж чадахгүй болсон хүний нэрийг мэдэхийг хүсэж байвал хэлэхээс биш дээ гэж өвгөн хариулав.
- Та надад хүчтэний дотроос хамгийн хүчтэй нь юм шиг санагдах тул намайг тайвшруулж, дэмжиж чадна.

Хоригдол гашуунаар инээмсэглэв.

- Намайг ширээт лам Фариа гэдэг. Таны мэдэж авсанчлан мянга найман зуун арван нэгэн оноос энэ Иф цайзад сууж байна. Үүнээс өмнө би Финестрельскийн цайзаг гурван жил суусан. Мянга найман зуун арван нэгэн онд намайг Пьемонтоос Францад авчирсан. Тэгэхэд Наполеонд дуу«гавартай байна уу гэлтэй хувь заяа түүнийг хүүтэй болгож, энэ хүүг өлгийтэй байхад нь ромын хаан болгожээ гэдгийг би мэдсэн юм. Тэр цагт би одоогийн таны ярьж байгаа хэрэг явдал болно гэж тааварлан мэдсэнгүй, дөрвөн жилийн дараа тэр их хүн унах юм гэж санасангүй. Одоо Францад хэн хаанчилж байгаа вэ? Хоёрдугаар Наполеон уу? гэж асуув.
- Үгүй, Людовик арван найм.

- Людовик арван зургаагийн дүү, Людовик арван найм уу? Бурхан юу гэж таалахыг мэдэхийн аргагүй юм. Тэр ямар зорилгоор өөрийнхөө өргөж мандуулсан юмаа унагаж, харин унагасан юмаа өөд татах болов?

Өөрийнхөө хувь заяаг мартаж орхиод бүхэл бүтэн ертөнцийн хувь заяаг бодож байгаа тэр хүнийг Дантес нүд салгалгүй ширтэнэ.

- Тийм ээ, тийм. Англи дахь шиг. Нэгдүгээр Карлын дараа Кромвель, Кромвелийн дараа хоёрдугаар Карл бас ч магадгүй хоёрдугаар Яковын дараа ямар нэг эхнэрий нь төрсөн дүү эсвэл хамаатан садангийн нь Оран гүн мэтийн аль нэг хүн болох байх, Эсвэл аль нэг мужийн даамал ч болж болох юм. Тэгвэл дахиад л ард түмэнд буулт хий, үндсэн хууль, эрх чөлөө! Гэх болно гэснээ Дантес уруу эргэж хожмыг мэдэгч мэргэн ухаантны нүд л ийм байдаг байх гэмээр сэргэн догдолсон нүдээр харж - Та залуу хүн, тэгэхээр үүнийг үзнэ дээ. Та залуу хүн байна, үүнийг үзэх болно! Гэж ярив.
- Тийм эс, хэрвээ эндээс гарвал тэгнэ.
- Тийм дээ гэж ширээт лам хариулаад - Бид шоронд харагдсан улс, харин би шоронгийн ханын цаана болж байгаа юмыг харж чаддаг учраас өөрийгөө эрх чөлөөтэй хүн шиг санах цаг тохиолддог юм гэв.
- Тэгээд таныг юуны учир шоронд хийсэн юм бэ?
- Намайг уу? Наполеон, мянга найман зуун арван нэгэн онд хийсэн юмыг би мянга найман зуун долоон онд хүсэж мөрөөдсөн учраас, би Макивеллийн адил Италиар нэг тарсан сул дорой өчүүхэн ванлигуудыг нэгэн том хүчирхэг гүрэн болсон байгаасай гэж хүссэн учраас, би өөрийнхөө Цезарь Борджиаг, надтай санал нийлж байсан тэдгээр титэм өмссөн тэнэгүүдийн дотроос олох мэт болсон учраас шоронд орсон юм. Энэ бол зургадугаар Александр, долдугаар Климентын санаа бодол байсан юм. Энэ санаа бүтэх учиргүй байжээ. Гэвч тэр хоёр түүнийг биелүүлэх гэж тэмцсэн нь дэмий болж, тэр ч байтугай Наполеон үүнийг биелүүлж чадсангүй, Итали ч аргагүй л нэг хараал хүрсэн орон юм даа!

Өвгөн толгойгоо гудайлгав.

Хүн ийм сэтгэл хөдлөлөөс болж амьдралаа үрчихийг зүрхэлнэ гэдгийг Дантес ойлгохгүй байв. Тэр Наполеоныг үзсэн, таньдаг, юм ярилцаж байсан учраас мэддэг байж болох юм. Харин долдугаар Климент ба зургадугаар Александрын тухайд бол түүнд өчүүхэн ч төсөөлөл байхгүй юм.

Дантес Иф цайз даяар боддог нөгөө бодлыг хуваалцаж эхлэн,

- Та нөгөө ... өвчтэй лам гэдэг биз дээ? гэж асуув.
- Та галзуу гэж хэлэх гэж байна уу?
- Тэгж хэлж зүрхэлсэнгүй гэж Дантес инээмсэглэн хариулав.
- Тийм ээ гэж Фариа гашуунаар инээж - Тийм ээ, намайг галзуу гэдэг юм. Би аль хэдийнээс Схлэн энэ цайзынхны элэг доог болж, хэрвээ энд хүүхэд шуухад байдаг сан бол тэдний тоглоом наадам болох байсан.

Дантес үг дуугүй хөдлөлгүй зогсоно.

- Та тэгээд оргохоо больё гэж бодов уу? гэж тэр асуув.
- Оргож болохгүй юм байна гэдгийг би мэдлээ, болохгүй юмыг болгоно гэж оролдоно гэдэг бурхны өөдөөс босох гэсэн хэрэг.
- Аргаа баран гуньхарч суугаад яах вэ? түргэн амжилт олох гэж хүсэх гэдэг бас л бурхнаас дэндүү ихийг шаардаж байгаа хэрэг. Өөр зүг руу ухаж болохгүй юм гэж үү?
- Намайг яаж зүдэрч байж үүнийг ухсан гэж санаж байна? Зөвхөн багаж хийх гэж дөрвөн жил зарцуулсны минь мэдэж байна уу? Боржин чулуу шиг хатуу газрыг хоёр жилийн турш ухсан гэж мэдэж байна уу? урьд нь бол хөдөлгөхөөргүй том чулууг өргөж, өдрийн турш аварга их ажил хийж, чулуу шиг хатуурсан шохойноос ганцхан хавтгай дөрвөлжин ямх авч хаяж чадвал үдэш нь ямар их баяртай байдаг байсныг мэдэхгүй байх аа? Ухсан чулуу шороогоо зайлуулах гэж бас хана цоо цохиж, түүнийгээ шатан доор асгасан, одоо дахиад шороо гаргавал хааш нь хаях вэ? Огт зайгүй болчихсон байгаа юм чинь. Би хөдөлмөр гаргасныхаа зорилгод хүрч, энүүнээс илүү чадал надаас гарахгүй гэдгээ мэдэрч байтал гэнэт бурхан энэ зорилгоос минь зайлуулж хаашааг нь ч мэдэхгүй газар аваачсаныг та мэдэхгүй байх? Үгүй! Би одоо хуруугаа ч хөдөлгөхгүй гэж танд хэлсэн, түүнийг явтан хэлье. Намайг эрх чөлөөгү© бай гэж бурхан таалж байгаа юм байх!

Дантес өөртөө найз нөхөртэй болсондоо баярласан царайгаа, оргож чадаагүйдээ гуньхарсан хоригдолд харуулахгүйн тулд доош тонгойв.

Ширээт лам Фариа орон дээр лаг хийтэл суучхав.

Эдмон оргох тухай хэзээ ч боддоггүй байсан юм. Иймэрхүү юмыг бүтэшгүй юм гэж үзэх учир тийм зүйл толгойд нь орж ирдэггүй байв. Тавин тохой газар доогуур ухах, тэнгис руу гарахын тулд гурван жил зарцуулах, хэрвээ манаач урьтаад буудчихгүй бол тавь, жар магадгүй зуун тохой өндрөөс хаданд тархиа хага

мөргөх гэж үсрэх, тэгээд арай гэж нэг юм оргож чадвал бүтэн бээр газар сэлж гарна гэдэг баршгүй ажил. Энэ гарцаагүй зүйлтэй эвлэрсэн нь Дантесыг үхлийн босгон дээр авчирсныг бид харсан билээ.

Гэвч амьдрахын төлөөнөө үхэн хатан зууралдаж, ганирсан шийдэмгийн байдлын жишээг харуулж байгаа өвгөнийг хараад Дантес эргэцүүлэн бодож эр зориггоо хэмжээлэн тунгааж эхлэв. Өөрийн нь бодоо ч үгүй юмыг өөр хүн хийж, өөрөөс нь залуу биш, өөрөөс нь бяр чадал багатай, авхаалж самбаа муутай тийм хүн хөдөлмөр, тэвчээрээр аварга их ажилдаа хэрэглэх багаж зэвсэг хийж авчээ. Гагцхүү энэ зорилго нь тооцоо буруу хийснээс болж биелэгдсэнгүй. Өөр хүн энэ бүгдийг хийж болчихсон юм, өөрт нь бол ямар ч боломжгүй юм гэж байх ёсгүй. Фариа тавин тохой ухжээ, тэр зiун тохой ч ухаж чаднаа. Тавин настай Фариа гурван жил ажилласан байхад харин түүнээс хоёр дахин дүү тэрээр зургаан жил ажиллах болно. Ширээт лам Фариа, эрдэмтэн хувраг хүн Иф цайзнаас Дом, Ратонно эсвэл Ленер хүртэл усан дотуур сэлж гарах байсан гэнэ. Харин тэгэхэд зоригтой далайчин, шүр сувд авах гэж далайн ёроол руу шумбадаг Дантес ганц бээр газар сэлээд гарчихаж чадахгүй гэж үү? Нэг бээр газар сэлэхэд хэдий хэр хугацаа шаардагдах бол? Нэг цаг? Эрэг дээр гаралгүйгээр бүтэн цагаар долгион дотор хөвдөггүй байсан гэж үү? Үгүй, үгүй түүнд ганцхан л зоригжуулах жишээ хэрэгтэй байв. Өөр хүн хийж чадах байсан буюу хийж чадсан юмыг Дантес хийж чадна.

Тэгээд тэр бодлого болсноо хэлсэн нь:

- Би таны эрсэн зүйлийг оллоо гэхэд Фариа цочиж,
- Та юу? гэж асуугаад толгойгоо өндийлгөхөд, хэрвээ Дантес үнэн юм хэлсэн ч байлаа гэсэн хамт байгаа нөхрийн нь арга тасарсан байдал тийм ч их удаан үргэлжлэхгүй нь илтэд байв. - Та юу олоо вэ?
- Таны нэвтэрч гарч ирсэн гудам, гадаах цагдаа цэрэг зогссон гудамжны дагуу байгаа юм уу?
- Тийм ээ.
- Тэр хоёрын хооронд арван таван алхмын зай байх ёстой биз.
- Хамгийн их дээ л тэр.
- Бид гудмын дундаас эгц хажуу тийш нь зам гаргана. Та энэ удаа арай нарийн тооцоо хийнэ шүү. Тэгээд бид гадаа гудамж руу гарч манаачийг алаад зугтъя. Үүнийг хийхэд зөвхөн зориг хэрэгтэй, ийм зориг танд бий, надад бас хүрэлцэхүйц чадал байна. Тэсвэрийн тухайд би ярихгүй, та үүнийг хэрэг дээр нь үзүүлсэн, харин би өөрийнхөө тэсвэрийг нотлон харуулахыг хичээе.

- Байзаарай, Ia миний эрэлхэг зориг гэж ямар ёүү юм болохыг хүчээ юунд ашиглах гэж байгааг та мэдэхгүй байна. Надад тэсвэр хүрэлцээтэй байна. Би өглөө бүр шөнийнхөө ажлыг сэргээж, шөнө бүр өдрийнхөө ажлыг үргэлжлүүлдэг байсан. Тэгэхэд би, залуу хүү минь миний хэлэхийг дуулж байгаарай, тэгэхэд би бурхны төлөө, гэм зэмгүй учраас чөлөөтэй сул байх ёстой нэгэн бүтээлийг нь чөлөөлөхийн төлөө хичээн оролдож байна гэж санагдаж байсан юм гэж ширээт лам хэлэхэд,
- Аа одоо тиймгүй гэж үү? Гэж Дантес асуугаад - Эсвэл та надтай дайралдсанаас хойш өөрийгөө буруу хэрэг хийчихлээ гэж бодож байна уу? гэв.
- Үгүй, би тэгэхийг хүсэхгүй байна. Би одоо хүртэл эд юмсаар оролдож байсан, тэгэхэд та хүмүүсээр оролдуулах гэж байна. Би хана цөм цохиж, шаты нь устгаж чадна, харин хүний цээжийг цоо цохиж, амьдралыг нь устгаж чадахгүй.

Дантес түүнийг гайхан харав.

- Яагаад тэр билээ? Хэрвээ та зугтааж чадах бололцоотой байсан бол ямар бодол таныг зогсоох байсан юм бэ? Гэж асуухад,
- Аа, та өөрөө гэж Фариа хэлээд - Та яагаад хуягаа сандлынхаа хөлөөр цохиж алаад, хувцсы нь өмсөж оргохыг оролдоогүй юм бэ? Гэж өөдөөс нь асуухад,
- Тэгж миний санаанд орсонгүй шүү гэж Дантес хариулав.
- Та бол хүн алах явдлыг төрөлхийн үзэн яддаг учраас тэр. Таны оноо санаанд ч ороогүй тэр үзэн ядалт л бидний хийж чадах юманд биднийг шулуун замаар хөтөлнө. Цус урсгахаар төрсөн барсад бол ингэх нь түүний хэрэг, түүний үүг байдаг болохоор ганцхан үнэрлээд л олзоо ойрмон байгаа эсэхийг мэдэж байх хэрэгтэй байдаг. Тэгээд олз өөдөө даруй үсрэн хэдэн хэсэг болгож хаяна. Энэ бол түүний төрөлхийн авьяас, тэгэхээр тэр үүндээ захирагддаг юм. Харин хүнд бол цус гаргах явдал бузар муухай, биднийг хүн алах явдлыг хүний нийгмийн хууль хориглодоггүй, харин байгалийн хууль хориглодог юм.

Дантес аягүйрхэж ирэв. Ширээт ламын үг түүний ухаанд, өөрөөр хэлбэл түүний сэтгэлд аяндаа төрдөг тэр зүйлийг тайлбарлаж өгөв. Энэ нь заримдаа тархинд, заримдаа зүрх сэтгэлд төрөх нь бий.

- Түүнээс гадна дээд Фариа үргэлжлүүлэн - Би арван хоёр жил шоронд суухдаа оргож байсан бүх л алдарт туршлагаудыг бодож үзсэн. Тэгээд ихэнх нь бүтэлгүйтэж байсныг мэдэв. Удаан хугацаагаар бодож, бэлтгэж

байж оргосон орголт дүүрэн амжилттай болдог юм. Бофор бээл Венсений цайзнаас, ширээт лам, Дюбюкау Фор-Левекаас, Латюд Бастилиас тэгж оргоцгоосон юм. Бас өөр аз дайралдаад оргочихсон явдлууд бий. Эд л хамгийн сайн нь, чи миний үгэнд итгэ, аятай цаг тохиолдохыг хүлээж байя, хэрвээ тийм нөхцөл тохиолдвол түүнийг л ашиглая гэж ярихад Дантес санаа алдаад, өвгөний үгийг тасалж,

- Та бол хүлээж тэсвэрлэж чадсан. Таны удаан жилийн хөдөлмөр таныг зугаацуулахгүй болох цагт найдлага горьдлого чинь таныг тайвшруулж байсан шүү дээ гэхэд,
- Би зөвхөн тийм юм хийгээд л сууж байгаагүй гэж ширээт л м хэлэв.
- Та юу хийж байсан бэ?
- Юм бичиж хийдэг байсан.
- Тэгвэл цаас, үзэг, бэх өгдөг юм уу?
- Үгүй, гэвч би тэдгээрийг өөрөө хийдэг юм гэж ширээт лам хэлэв.
- Та цаас, үзэг, бэх хийдэг гэнэ ээ? гэж Дантес дуу алдав.
- Тийм ээ.

Дантес өвгөн ширээт лам өөд бишрэн харав. Гэвч тэр түүний үгэнд муу л итгэж байв. Тэгэхэд Фариа түүний эргэлзэж байгааг мэдээд,

- Таныг над дээр очихоор, би танд өөрийнхөө амьдралын туршид хайж бодож олсон санааныхаа үр бүтээлийн бүхэл бүтэн бүтээлийг үзүүлнэ. Би түүнийг Ромын Колизейн сүүдэрт, Венецийн гэгээн Маркийн баганын хажууд, Флоренцийн Арно голын эрэг дээр явж байхдаа хуягууд надад Иф цайзан дотор бичиж дуусгах зав өгнө гэдгийг мэдэлгүй бодож боловсруулсан юм. Энэ бол «Бүгдээрээ нэгдсэн Италийг байгуулах бололцооны тухай номлол» гэдэг зузаан боть ном болно.
- Тэгээд та түүнийгээ биччихсэн үү?
- Бичсэн, хоёр цамцан дээрээ бичсэн. Би зотон даавууг илгэн цаас шиг гөлгөр чигжүү болгодог бодис найруулж олсон.
- Тэгвэл та чинь химийн ухаантан хүн үү?
- Хагас хугас мэднэ. Би Лавуазьетэй танил, Кабанистай найз байсан юм.

- Ийм хөдөлмөр хийхэд танд түүхийн материалууд хэрэгтэй байсан биз дээ. Тэгэхээр танд тийм номууд байсан уу?
- Ромд надад таван мянган номтой номын сан байсан юм. Тэгээд би тэр номуудыг уншиж, заримыг нь дахин уншиж байж, зуун тавин ном л шилж сонгож уншвал, бүрэн биш ч гэхнээ хүний мэдвэл зохих бүх мэдлэгийг олж авч чадах юм гэдгийг мэдэж авсан. Би энэ зуун тавин номыг гурван жил Ейн дотор уншиж, намайг баривчлах үед тэднийг бараг цээжээр мэддэг болсон байсан. Шоронд орсон хойноо тархиа бага зэрэг дайчлан ажиллуулахад тэр бүхэн дахиад санаанд орж ирсэн. Би танд Фукидид, Ксенофонт, Плутарх, Тит Ливий, Тацит, С трада, Иорнанд, Данте, Монтень, Шекспир, Спиноз, Макиавелли, Боссюэ нарын зохиолуудыг цээжээр ч уншиж өгсөн ч чадна. Би танд зөвхөн хамгийн голы нь л нэрлэлээ.
- Та хэд хэдэн улсын хэл мэддэг үү?
- Би таван хэл дээр ярьдаг, герман, франц, итали, англи, испани хэл мэднэ. Эртний грег хэлний тусламжтайгаар одоогийн грег хэлийг ойлгодог. Гэхдээ би энэ хэлээр муу ярьдаг. Харин одоо энэ хэлийг сурч байгаа.
- Та грег хэл судалж байгаа гэнэ ээ? гэж Дантес асуув.
- Тийм ээ би мэддэг үгнүүдийнхээ түүвэр хийсэн, би тэднийг өөрийнхөө санааг ойлгож болохоор аль болохуйц дөхөмтэйгөөр байрлуулан тавьсан. Би мянгаад үг мэднэ, хэдийгээр толь бичигт зуун мянга шахам үг байдаг боловч илүү олон үг надад хэрэггүй. Би уран илтгэгч хүн болохгүй, миний хэлснийг хүн ойлгоно, энүүнээс илүүгээр би яах вэ.

Эдмон улам улмаар гайхан биширсээр, энэ хачин хүний авьяас чадварыг бараг ер бусын юм гэж мэдэв. Тэр түүнээс бас өөр юм дуулах гэж үргэлжлүүлэн,

- Танд өд өгөөгүй юм бол та юугаараа ийм зузаан ном биччих вэ? гэв.
- Би өөртөө маш сайхан үзэг хийж авсан, түүнийг хүмүүс үзвэл галууны өднөөс ч илүү дээр үзэг байна гэж хэлэх Ўайх. Тийм үзгийг мацаг барьдаг өдөр хааяа өгдөг шөлөнд ирдэг том согос загасны толгойн мөгөөрсөөр хийсэн. Би лхагва, баасан, бямба гаригт дуртай үзэг маань олон болно гэж баярладаг аа. Түүхийн зохиол бичих явдал миний дуртай ажил байгаа юм. Би өнгөрсөн үеийн түүхт явдлын тухай бодож суухдаа одоо үеэ мартчихдаг. Өнгөрсөн үеийн тухай чөлөөтэй бодож байхад шоронд байгаа маань мартагддаг юм.
- Аа, бэх? Та юугаар бэх хийдэг вэ? гэж Дантес асуув.

- Урьд нь миний өрөөнд задгай зуух байж, намайг тэнд хорихоос өмнө яндангий нь бөглөсөн боловч олон жилийн турш зууханд гал түлж байсан болохоор хананд нь хөө тортог суусан байв. Би энэ хөөнөөс авч бүтэн сайн өдөрт өгдөг дарсанд уусгаад их сайхан бэх гаргаж авсан. Зарим нэг онцолбол зохих зүйлийг хуруугаа шалбалаад цусаараа биччихдэг гэж Фариа хариулав.
- Би энэ бүгдий чинь хэзээ үзэж болох вэ? гэж Дантес асуухад,
- Дуртай цагтаа л үз гэж Фариа хариулав.
- Одоо л үзье!
- Тэгвэл миний хойноос дагаад яваарай гэж ширээт лам хэлэв.

Тэгээд нүхэн дотор орж алга болоход Дантес хойноос нь дагаж оров.

17. Ширээт ламын өрөө

Дантес хэдийгээр бөхийсөн боловч, төвөггүй явж ширээт ламын ухсан хонгилын цаад үзүүрт хүрэв. Тэнд нүх улам нарийсаж зөвхөн мөлхөж явахаас өөр аргагүй болов. Ширээт ламын өрөөний шал нь дөрвөлжин дөрвөлжин чулуугаар хийсэн агаад хамгийн харанхуй буланд байгаа нэгэн дөрвөлжинг авч, төгсгөлий нь Дантес үзсэн тэр хүнд бэрх ажлыг эхэлсэн ажээ.

Эдмон өрөөнд орж, дээш болон зогсоод ийш тийшээ сонирхон харав. Анх харахад гайхаад баймаар юу ч алга байв.

- Одоо арван хоёр цагаас арван таван минут өнгөрч байна. Тэгэхээр бидэнд хэдэн цагийн зай байна гэж хэлэхэд Дантес ширээт ламын яг таг хэлээд байгаа цагийг эрж эргэн тойрон харав. Тэгэхэд ширээт лам

- Миний цонхоор орж ирж байгаа нарны гэрлийг хар, тэгээд энэ ханан дээр зурсан зураасыг хар. Би энэ зураасаар хэрвээ надад цаг байсан бол түүнээс ч илүү зөвөөр цаг тодорхойлж мэднэ. Яагаад гэвэл цаг эвдэрч болно. Харин нар газар хоёр бол үргэлж зөв ажилладаг юм.

Дантес энэ тайлбарыг ойлгосонгүй. нар уулын цаанаас гараад, газрын дундад тэнгист орчихдогийг хараад газар хөдөлдөг биш, харин нар хөдөлдөг юм байна гэж бодож байжээ. Өөрийн нь оршин байгаа газар дэлхий хөдөлдөг гэхэд үнэмшихийн аргагүй санагджээ. Ярьж байгаа хүний үг бүрд бүр жаахандаа Гузерат, Голкондоор аялан явж байхдаа үзсэн алт, доржпалам чулууны уурхай шиг тийм хачин гайхалтай шинжлэх ухааны гайхамшиг тодорно.

- Би таны баялгийг үзэх юм сан гэхээс тэсэж чадахгүй байна гэж ширээт ламд хэлэв.

Ширээт лам голомт руу очиж, гартаа салгалгүй барьж явсан цүүцний үзүүрээр хэзээ нэгэн цагт сам төмрийн үүрэг гүйцэтгэж нэлээд овоо гүнзгий нүхийг таглаж байсан дөрвөлжин чулууг сөхөв. Түүн дотор Дантест ярьсан өнөөх зүйлүүд нь хадгалагдаж байжээ.

- Танд эхлээд юугий нь үзүүлэх вэ? гэж асуув.

- Та Италийн хаант улсын тухай зохиолоо үзүүлээч.

Фариа нууц дотроосоо хуйлсан муутуу цаас шиг дөрвөн хуйлаас гаргаж ирэв. Энэ нь дөрвөн ямх өргөн, арван найман ямх урт нарийн хуудсууд байв. Энэ хуудсууд дугаарлагдсан байсан тул Дантес хэдэн мөр юм төвөггүй уншив. Энэ зохиол нь ширээт ламын төрөлх хэл буюу итали хэлээр бичигдсэн байсан бөгөөд прованс гаралтай Дантес энэ хэлийг маш сайн ойлгодог байв.

- Харж байгаа биз, энд цөмөөрөө байна. Би долоо хоногийн өмнө жаран наймдугаар хуудсан дээр «төгсөв» гэдэг үг бичсэн. Хоёр цамц, нусны бүх алчуур маань энд зарцуулагдчихсан. Хэрвээ би хэзээ нэгэн цагт эрх чөлөөтэй болбол миний номыг зүрхэлж хэвлэх газар Италид олдвол би алдаршина даа.

- Тийм ээ харж байна. Одоо энэ номыг бичсэн үзгээ үзүүлнэ үү гэж Дантес хэлэхэд Фариа,

- Энэ байна, үз л дээ гэж хэлэв.

Тэгээд зургаан ямх урт, хагас ямх бүдүүн савх гаргаж ирэхэд, түүнд загасны мөгөөрсөөр хийсэн, бэх хатсан үзгийг утсаар ороож тогтоосон байв. Тэр нь ердийн үзэг шиг үзүүрлэгдэж, дундуураа зүсэгдсэн ажээ.

Дантес үзгийг нарийвчлан үзээд, үүнийг ингэж сайхан зассан багаж нь хаана байгаа юм бол гэж нүдээрээ эрэв.

-Та үзэг хийсэн тонгорог эрж байна уу? гэж Фариа асуугаад,-Энэ бол миний бахархаж урьдаа барих зүйл. Энэ тонгоргёйг бас энэ том хутгыг лааны хуучин сууриар хийсэн гэж хэлэв.

Тогорог нь үсний хутга шиг даана, харин том хутга нь өдөр тутмын хэрэгцээ хангахаас гадна бас зэр зэвсэг болж чадах давуу талтай ажээ.

Дантес энэ бүх зүйлүүдийг, холын аяны ахмадууд өмнөдийн арлуудаас авчирсан зэрлэг хүмүүсийн хийсэн зэвсэг, ховор нандин зүйлийг худалдаалах мухлагуудад байхыг үзсэнтэйгээ адилаар ихэд сонирхон үзэв.

- Бэхний тухайд гэвэл юугаар хийдгийг нь мэднэ, би хэрэглээнийхээ хэрээр л хийдэг гэж Фариа хариулав.

-Энэ бүхнийг хийхэд өдөр цаг яаж хүрэлцсэн юм бол гэдэг ганцхан зүйлийг л би гайхаж байна гэж Дантес хэлэхэд Фариа,

- Би шөнө ч бас ажилладаг байсан юм гэж хариулав.

- Шөнө ий? Та чинь шөнө муур шиг сайн хардаг юм уу?

- Үгүй ээ, бурхан хүнийг ухаантай төрүүлсэн учир би өөртөө гэрэл гаргах арга олсон.

- Яаж тэр вэ?

- Надад өгдөг үхрийн махны өөхийг нь огтолж аваад хайлуулж, тосыг нь шахаж авдаг. Ингээд л миний лаа бэлэн болдог юм даа.

Тэгээд ширээт лам баярын өдрүүдэд гудамж чимэглэдэг цөгц шиг тийм цөгц үзүүлэв.

- Аа гал?

- Надад хоёр ширхэг цахиур, цамц үнгэж хийсэн уул бий.

- Аа тэгвэл шүдэнз яах вэ?

- Би арьсны өвчтэй гэж худлаа хэлээд жаахан чихэр гуйж авсан юм.

Дантес тэр бүх зүйлийг ширээн дээр тавиад тонгойн ширтэж, энэ хүний тэсвэртэй, ухаантайг гайхан шагшрав.

- Энэ ч бас цөмөөрөө биш гэж Фариа хэлээд - Бүгдийг нь нэг дор нууж болохгүй. Тэгэхээр энэ нууц байраа хааж орхиё гэв.

Тэр хоёр авсан чулуугаа буцааж тавиад, үнсээр хучиж онгойлгосон гэж мэдсгдүүлэхгүйн тулд хөлөөрөө үрж тсгшлэв. Тэгээд дараа нь ор уруу очиж, нааш нь татав.

Орны толгойн цаад талд чулуугаар маш чигжүү хаасан нүх байв. Энэ нүхэн дотор гучаад тохой олсон шат байв. Дантес түүнийг татаж үзэхэд ямар ч хүнд юм даахаар байв.

- Та шат хийх ийм сайхан олс хаанаас олоо вэ? гэж Дантес асуув.

- Нэгдүгээрт миний цамцнууд, бас Фенестрельд сууж байхдаа гурван жилийн турш орны цагаан даавуунаас танаж авсан юм. Нааш нь шилжүүлэн авчрахад би олсон материалаа аргалж байгаад аваад ирсэн юм. Тэгээд энд ажлаа үргэлжлүүлсэн.

- Таны цагаан даавуу танагдчихсан байхыг хэн ч мэдээгүй юу?
- Би оёчихдог байсан юм чинь.
- Юугаар?
- Энэ зүүгээр.

Тэгээд ширээт лам нооронхой дээлийнхээ дотроос загасны хавиргаар хийсэн зүү, сүвлэсэн утастай гаргаж ирэв.

- Ийм байна л даа гээд ширээт лам үргэлжлүүлэн - Би анхандаа төмөр сараалжийг тас хуурайдаж орхиод цонхоор оргочихъё гэж бодсон юм. Энэ маань таныхаас арай том байгааг харж байгаа биз дээ. Тэгээд ч би түүнийг зугатахынхаа өмнө ихэсгэж болох байлаа. Тэгсэн чинь цонх маань хашаа уруу харсан байхаар нь тэр бодлоосоо ухарлаа. Гэсэн ч бололцоо гарвал гэж ярьсан шүү дээ, хэзээ нэгэн цагт оргож юу магад гэж бодоод энэ олсон шатыг хадгалаад байгаа юм гэж ярив.

Харин Дантес тэр шатыг харж зогсохдоо шал өөр юм бодов. Түүний толгойд шал өөр санаа орж ирлээ. Энэ ухаантай эрдэмтэн, шинийг зохиож олж чаддаг хүн, түүний хувьд ямагт манан буданд бүрхэгдсэн юм шиг санагддаг золгүй явдлынх нь учрыг олж чадна даа гэж бодов.

Ширээт лам Дантесын бодлого болон зогсож байхыг, ихэд бишрэн гайхсаных хэмээн үзэж,

- Та юу бодоо вэ? гэж инээмсэглэн асуув.
- Нэгдүгээрт: Таныг зорьсондоо хүрэх гэж хичнээн их хүч зарцуулсан тухай, бас чөлөөтэй бол та юу гээчийг хийх байсан байсан бол гэж бодож байна.
- Юу ч хийж чадахгүй байж магадгүй. Би өөрийнхөө ухааныг ялахгүй аар саар юманд зарцуулчих байсан биз. Зөвхөн азгүй явдал л хүний ухааны нууц баялагийг нээн гаргадаг юм, дарийг дэлбэлэхийн тулд түүнийг шахах ёстой. Тал тал тийшээ сарнин тархсан ухааныг минь шорон нэгэн дор цугларуулж өгөв. Тэд өчүүхэн зайд мөргөлдөн тулгарав. Мөргөлдөж шүргэцсэнээс цахилгаан гардаг, цахилгаанаас аянга, аянганаас гэрэл гардаг гэдгийг та мэднэ шүү дээ.

- Үгүй, би юу ч мэдэхгүй гэж эрдэм номгүйдээ дарагдсан Дантес хариулаад - Таны хэлж байгаа зарим үг чухам ямар утгатай үг болохыг би ойлгохгүй юм. Ийм их эрдэмтэн болно гэдэг бас сайхан хэргээ! Гэв.

Ширээт лам инээмсэглэж,

- Гэхдээ та өөр бусад юмны тухай бодсон биш үү?
- Тийм ээ.
- Нэрий нь ч та надад хэлсэн, харин хоёр дахий нь хэл дээ?
- Хоёрдугаар нь ийм байна. Та надад өөрийнхөө амьдралыг ярьсан, минийхийг та мэдэхгүй.
- Таны амьдрал одоохондоо тийм чухал үйл явдал үзэж амжих хараахан болоогүй.
- Миний амьдралд маш их азгүй явдал тохиолдсон. Би ингэж гайтахаар юм хийгээгүй юм сан. Би хожим хэзээ ч бурхныг хараахгүйн тул миний зовлонд хүмүүс л буруутай гэдэгт итгэхийг хүсэж байна гэж Дантес хэлэхэд,
- Танд тулгаж байгаа тэр хэргийг та хийгээгүй гэж үзэж байгаа юм уу? гэж ширээт лам асуув.
- Би ямар ч хэрэг хийгээгүй, энэ ертөнц дээр хамгийн хайртай хүмүүс болох аав, Мерседес хоёрынхоо нэрийг барьж тангараглая.
- За тэгвэл сайн гэж ширээт лам хэлээд нууц нүхээ таглаж ороо хуучин байранд нь тавиад - Та өөрийнхөө түүхийг ярьж өгөхгүй юү гэв.

Тэгэхэд Дантес ширээт ламын түүх гэж нэрлэж байгаа тэр юмыг ярьж өгөв. Энэ нь Энэтхэг уруу аялсан ба Дорнод өөд хоёр удаа явсан төдийхнөөр хязгаарлагдана. Сүүлчийн аяны тухай, ахмад Леклерийн нас барсныг, маршалд даалгаж явуулсаныг түүнтэй уулзсанаа Нуартъед захидал өгүүлсэн зэргийг ярив. Бас Марсельд буцаж ирснээ эцэгтэйгээ уулзсанаа, Мерседест хайртайгаа, гэр бүл болох ёс гүйцэтгэсэнээ, баривчлагдаж байцаагдсанаа, шүүхийн байшинд түр хоригдоод дараа нь Иф цайзанд бүрмөсөн хаягдсанаа ярив. Эдмон түүнээс өөр юу ч мэдэхгүй тэр ч байтугай хэдэн жил шоронд сууж байгаагаа ч мэдэхгүй ажээ.

Түүний ярьсныг сонсоод, ширээт лам гүн санаа алдаж бодлого болов.

- Эрхийн тухай шинжлэх ухаанд гэж хэлээд дуугүй болсноо - Нэг мэргэн сургаал байдаг, үүнийг би түрүүнд танд хэлсэн. Хэв ёсоо алдсан хүнээс муу санаа гарах тохиолдлоос бусад үед хүн гэмт хэргээс дөлж явдаг юм. Гэвч бидний сайн

эхлэлийг нуга даран хорон мууд аваачдаг тийм хуурамч шаардлага, дутагдал, хүсэл байдгийг соёл иргэншлээс бид мэддэг. Энэ бүхнээс ийм нэг үндэслэл гарч байна. гэмт хэрэгтнийг олж авъя гэвэл, тэрхүү гэмт хэргээс ашиг олж болох тэр хүнийг эрж ол. Таны алга болох явдал ямар хүнд ашигтай байсан юм бэ?

- Хэнд ч үгүй дээ. Би чинь жижигхэн хүн байсан юм.

- Та битгий хуумгай хариулаарай. Таны хэлж байгаа үгэнд ямар ч учир зүй, гүн ухаан алга. Энэ ертөнц дээр юм бүхэн харьцангуй байдаг юм, хайрт нөхөр минь. Үе залгамжлагчдаа саад болдог хаанаас эхлээд дээд зэргийн бичээчид саад болдог албаны түшмэл хүртэл цөм харьцангуй. Хаан таалал төгсөхөөр үе залгамжлагч нь титэм өмсөнө, албаны түшмэл үхэхээр бичээч нь мянга хоёр зуун ливрийн цалинг өвлөж авна. Энэ цалин нь түүний иргэний эрх болж байгаа юм. Эдгээр нь хаанд арван хоёр сая ливр хэрэгтэй байдаг шиг л түүнд их хэрэгтэй юм. Нийгмийн шатны дээрээс аваад доороо хүртэл хүн бүр, Декартын ертөнцүүдэд байдаг шиг өөрийн хуй салхи, махир тахир эгэл бөөмтэй, сонирхлын ертөнцхөнийг өөрийгөө тойруулаад бий болчихдог юм. Дээшлэх тусам энэ нь улам томордог. Энэ бол тэнцвэрийн цэгийг тойрон дөнгөн данган тогтож байгаа эргүүлэг юм. Ингээд таны ертөнц уруу эргэж очъё. Таныг «Фараоны» ахмадаар томилох гэж байсан гэв үү?

- Тийм ээ.

- Та сайхан охинтой гэрлэх гэж байсан гэв ээ?

- Тийм ээ.

- Тэгвэл таныг «Фараоны» ахмад болгохгүй байх нь хэн нэгэнд хэрэгтэй байсан уу? Мерседестэй суухад чинь дургүйцэх хүн байсан уу? Эхлээд нэгдүгээр асуултыг хариулаарай. Дэс дараалал гэдэг бол зөв тааварлахын түлхүүр юм шүү. Таныг «Фараоны» ахмад болоход дургүйцэх хүн байсан уу?

- Хэн ч байгаагүй онгоцныхон цөм надад сайн байсан юм. Хэрвээ далайчдад ахмадаа сонгох эрх өгвөл, намайг л сонгох байсан гэдэгт би итгэж байна. Харин нэг л хүнд, надад дургүйцэх шалтгаан байсан. Би түүнтэй муудаад, тэгээд ирүүл тулалдаан хийе гэж дуудахад тэр хүн татгалзсан юм.

- Үгүй ер! Хэн гэдэг хүн бэ?

- Данглар.

- Хөлөг онгоцны юу нь байсан юм бэ?

- Нягтлан бодох.

- Та ахмад болсон бол түүнийг хуучин албанд нь үлдээх байсан уу?
- Үгүй ээ, хэрвээ энэ нь миний хэр хэмжээнд багтвал үлдээхгүй байсан. Түүний тооцоонд зарим нэг будлиан байсныг би ажиглан мэдсэн.
- За тийм байж. Таныг ахмад Леклертэй сүүлчийн удаа ярилцахад өөр хүн байсан уу?
- Үгүй, бид хоёулхнаа байсан.
- Та хоёрын яриаг хүн сонсож болох байсан уу?
- Болох байсан, хаалга онгорхой... тэр ч байтугай... үгүй байзаарай... тийм тийм, маршалд өгөх захидлыг ахмад надад өгөх яг тэр үед Данглар хажуугаар гарсан юм байна.
- За их сайн байна, бид мөрий нь гаргалаа. Та Эльба арал өөд явахдаа ямар нэг хүн дагуулж явсан уу?
- Хэнийг ч дагуулж яваагүй.
- Танд, тэнд захидал өгсөн үү?
- Тэгсэн, маршал өгсөн.
- Тэрнийг нь та яасан бэ?
- Түрийвчиндээ хийсэн.
- Тэгэхээр танд түрийвч байжээ дээ? Албан захЁдалтай түрийвч далайчин хүний хармаанд яаж багтдаг байна даа?
- Таны хэлдэг зөв, түрийвч маань өрөөнд байсан юм байна.
- Тэгэхээр та захидлыг өрөөндөө ирсэн хойноо түрийвчиндээ хийсэн байх нь ээ?
- Тэгсэн.
- Порто-Феррайогоос онгоц хүрч иртэл захидал чинь хаана байсан бэ?
- Гарт минь байсан.
- Таныг «Фараон» дээр гарч ирэхэд гарт чинь захидал байгааг хүн бүхэн харж болох байсан уу?

- Болох байсан.
- Бас Данглар ч харж болох байсан уу?
- Тийм. Данглар ч харж болох байсан.
- За одоо та миний хэлэхийг анхааралтай сонсож өнгөрсөн явдлыг сайн санаарай, тэр ховын бичиг яаж бичигдсэн байсныг санаж байна уу?
- Өө, саналгүй яах вэ, би түүнийг гурав дахин уншсан, үг бүр нь миний санаанд байна.
- Түүнийгээ надад хэлж өгөөч.
- Дантес бодов.

Би үг гээлгүй хэлье:

«Эзэн ширээ ба шажинд сүслэн дагагч би Неаполь, Порто-Феррайо ороод Смирнаас өнөөдөр хүрэлцэн ирсэн «Фараон» гэдэг хөлөг онгоцны ахмадын туслах Эдмон Дантес, Мюратаас узурпаторт захидал аваачиж өгөөд узурпатороос Парист төвлөрөнбайгаа бонапартын хороонд явуулсан захидал авч явааг вангийн эрхэм прокурорын туслах таны сонорт хүргэе. Хэрвээ түүнийг баривчлан авбал хэргийн баримт болох тэрхүү захидал түүний биеэс буюу эсвэл эцгийнхээс нь эсвэл «Фараон» онгоц дээрх түүний тасалгаанаас олодоно» гэж хэлэхэд ширээт лам мөрөө хавчиж,

- Өдөр шиг тодорхой Үоллоо гэж хэлээд - Та тэр дор нь тааварлан мэдэхгүй их цайлган хүн юм гэв.
- Та тэгэж бодож байна уу? гэж Дантес хашхираад - Ямар бузар хэрэг вэ! гэв.
- Дангларын бичгийн хэв ямар вэ?
- Маш гоё гаргацтай, баруун тийш нь хазайлгаж бичдэг юм.
- Харин тэр ховын бичгийн хэв ямар байсан бэ?
- Зүүн тийш нь хазайлгаж бичсэн байсан.

Ширээт лам инээмсэглэв.

- Хэвээ өөрчилсөн бичиг байна даа!

- Өөрчилсөн баймааргүй тийм тогтсон хэлбэртэй бичиг байсан.

- Байз, байз гэж ширээт лам хэлээд, үзэг буюу үнэндээ үзэг гэж нэрлэгдсэн тэр зүйлээ авч бэхэндээ дүрээд цаас орлодог зотон дээр ховын бичгийн эхний мөийг солгой гараараа бичив.

Дантес түүнийг хараад гэдрэгээ огло үсэрч, ширээт лам өөд гайхан харав.

- Хачин юм! Энэ бичгийн хэлбэр нөгөөдөхтэй яасан адилхан юм бэ! Гэж дуу алдахад,

- Ховын бичгийг солгой гараараа бичиж. Харин, би сонин зүйлийг ажиглан мэдэв гэж ширээт лам үргэлжлүүлэн хэлэв.

- Ямар зүйл!

- Баруун гарын бичгийн хэв бүр ондоо ондоо, харин солгой гарын бичгийн хэв цөм адилхан байдаг юм байна.

- Та юм бүхнийг судалжээ! Юм бүхнийг мэдэх юм аа!

- За цааш нь ярья.

- Тэгье, тэгье.

- Одоо хоёрдугаар асуултад оръё.

- Таны асуултыг хүлээж байна.

- Таныг Мерседестэй суухад дургүйцэх хүн байсан уу?

- Байсан. Мерседест дурласан нэг залуу байсан.

- Нэр нь хэн гэдэг юм бэ?

- Фернан гэдэг.

- Испани нэртэй юм аа.

- Тэр каталан хүн.

- Та түүнийг ховын бичиг бичсэн гэж үзэж байна уу?

- Үгүй, тэр на-тайг хутгалаад л зогсох байсан.

- Тийм ээ, энэ ч испан хүмүүсийн зан, аллага болохоос өөдгүй муухай юм биш.
- Бас тэгээд ховын бичигт байсан зүйлүүдийг нарийн мэдэхгүй.
- Та түүнийгээ хэнд ч яриагүй биз?
- Хэнд ч үгүй.
- Болзоот хүүхэндээ ч гэсэн хэлээгүй юү?
- Үгүй хэлээгүй.
- Тэгвэл энүүнийг Данглар бичиж дээ.
- Одоо бол үүнд үнэмшиж байна.
- Байзаарай... Данглар Фернаныг таних уу?
- Үгүй... Тийм ээ... Одоо саналаа!
- Юу тэр вэ?
- Миний хурим хийхийн урьд өдөр өвгөн Памфилын мухлагт тэд нар сууцгааж байсан шүү. Данглар их л найрсаг зантай, хөгжилтэй, харин Фернан нь зөвхий цонхигор царайтай байсан.
- Тэд хоёулхнаа байсан уу?
- Үгүй, гурвуулаа сууж байсан, гурав дахь нь миний сайн танил хүн байсан. Бодвол тэр л тэр хоёрыг танилцуулсан байх... Сайван Кадрусс гэдэг хүн. Гэвч тэр шал согтуу байсан... Байзаарай... Байзаарай... Би яагаад үүнийг урьд нь санасангүй вэ? Тэдний архи ууж суусан ширээн дээр бэхийн сав, цаас, үзэг байсан (Дантес гараараа духаа илэв) Өө... бузар амьтад, бузар амьтад!
- Өөр юм мэдэхийг хүсэж байна уу? гэж ширээт лам инээмсэглэн асуув.
- Байна байна, та юм бүхний учрыг мэдэж, юм бүхнийг тодорхойгоор харах юм. Намайг яагаад ганц удаа байцааж, шүүх таслахаар оруулаагүй юм бол, үүнийг мэдэх юм сан?
- Энэ ч харин нарийн асуудал болж байна. Үнэн шудрагын шүүхийн зам харанхуй бүдүүлэг учир түүний учрыг олж мэдэхэд хэцүү. Таны хоёр дайсны байдал төрхийг мөшгөхөд ёстой амархан хүүхдийн тоглоом шиг л байлаа, харин та одоо надад хамгийн зөв, үг таг хариулт өгөх хэрэгтэй дээ.

- Асуугаад байга рай. Та миний амьдралыг надаас өөрөөс минь илүү мэдэх юм.

- Таныг хэн байцаасан бэ? Вангийн прокурор уу, эсвэл туслах нь уу, эсвэл мөрдөн байцаагч уу?

- Туслах нь

- Залуу хүн үү, хөгшин хүн үү?

- Залуу, хорин долоо орчим настай.

- Тэгвэл хүнээ ч байчхаагүй, харин нэр төрд дуртай байж таарна гэж ширээт лам хэлээд - Тэр тантай ямаршуухан харьцсан бэ? Гэж асуув.

- Хатуу ширүүн гэхээсээ эелдэг зөөлөн харьцсан.

- Та түүнд бүгдий нь хэлсэн үү?

- Бүгдий нь

- Түүний зан байдал нь байцаалтын үед өөрчлөгдөв үү?

- Миний эсрэг эд мөрийн баримт болсон захидлыг уншмагц л өөрчлөгдөж, надад тохиолдсон гай зовлонд сэтгэл нь ихэд хөдлөх шиг санагдсан.

- Танд тохиолдсон гай зовлонд ий?

- Тийм ээ.

- Тэр чухамдаа таныг өрөвдөж халаг хоохой болсон гэдэгт та итгэлтэй байна уу?

- Ямар ч л гэсэн намайг өрөвдөн, сэтгэл зовж байгаагаа хэрэг дээр нь харуулсан.

- Чухам яаж?

- Надад хор хүргэж болох ганц эд мөрийн баримтыг шатаачихсан.

- Ямар баримт? Ховын бичгийг үү?

- Үгүй, захидлыг.

- Тэгсэн гэдэгт итгэж байна уу?

- Намайг харсаар байтал шатаачихсан.
- Энд ч нэг жог байна даа. Прокурорын туслах чинь, бодсоноос илүү бузар амьтан шиг санагдаж байна.
- Энэ ертөнц гэдэг чинь барс, матруудаар л дүүрэн юм гэж үү дээ? Яасан аймшигтай юм бэ? Гэж Дантес хэлэв.
- Тийм ээ, тэгэхдээ хоёр хөлтэй барс, матрууд дөрвөн хөлтэйгөөсөө илүү их аюултай байдаг юм.
- Алив, цааш нь үргэлжлүүлье.
- Ингэхэд Ia түүнийг захидал шатаачихсан гэв үү?
- Тэгсэн тэгэхдээ бас «Таны эсрэг ганц эд мөрийн баримт энэ байна, би түүнийг чинь устгачихлаа» гэж нэмж хэлсэн.
- Энэ чинь дэндүү буянтай хэрэг байсан учраас л хуурамч байж дээ.
- Та тэгж бодож байна уу?
- Би бүр итгэлтэй бодож байна. Тэр захидал ямар хүнд очих байсан бэ?
- Парис хотын Кок-Эрон гудамжны арван гуравдугаар байшинд байдаг ноён Нуартъед.
- Энэ захидал устаж алга болох явдал прокурорын туслахад хэрэгтэй байсан гэж та бодохгүй байна уу?
- Магадгүй юм. Хэд хэдэн ч удаа, миний төлөө л гэж байгаа юм шиг, энэ захидлын тухай хэнд ч хэлэхгүй захидлын хаяг дээр бичсэн нэрийг нэг ч хүнд дурсахгүй гэсэн ам тангаргийг минь авсан.
- Нуартъе! Гэж ширээт лам давтан хэлээд - Нуартъе! Этрурийн хатан хааны ордонд нэг Нуартъе байсныг би мэднэ, хувьсгалын үеийн жирондич Нуартъег мэднэ. Харин таны тэр прокурорын туслахыг хэн гэдэг вэ? гэж асуув.
- Де Вильфор гэхэд ширээт лам тачигнатал хөхрөв. Дантес түүнийг гайхан харж,
- Та яав аа? гэж асуув.
- Та энэ нарны гэрэл харж байна уу? гэж ширээт лам асуув.

- Харж байна.
- Одоо таны хэрэг надад энэ гэрлээс ч илүү тодорхой боллоо. Хөөрхий жаал! Тэр танд их эелдэг зөөлөн байсан уу?
- Тийм ээ.
- Энэхүү хүндтэй хүн тэр захидлыг шатаачихлаа гэнэ ээ?
- Тийм ээ.
- Таныг Нуартье гэдэг нэр хэзээ ч битгий хэлээрэй гэж хүндэт яргачны зарц танаас ам тангараг авсан гэж та хэлэв үү?
- Тийм ээ.
- Тэр Нуартье гэдэг чинь, хөөрхий золгүй сохор амьтан минь тэр Нуартье гэдэг чинь хэн байсныг та мэдэж байна уу? Тэр Нуартье чинь түүний эцэг байхгүй юу даа?

Дантесын хөл доор аянга бууж өмнөх газар нь хагаран түүний ёроолд тамын орон байхыг харвал, ширээт ламын хэлсэн үгийг сонссонтой адил тэгж гэнэт айх, гайхах сэтгэл төрүүлэхгүй байх сан биз ээ. Ухасхийн босож толгойгоо барин,

- Түүний эцэг байж! Түүний эцэг! Гэж бархирав.
- Тийм ээ, түүнийг Нуартье де Вильфор гэдэг юм гэж ширээт лам харуулав.

Тэгэхэд л нүд гялбам хурц гэрэлд Дантесийн ухаан санаа саруулжих шиг болов. Урьд нь түүнд ойлгогдохгүй байсан, бүдэг бараг бүх юм хурц тодхон харагдав. Байцаалтын үед Вильфорын зан байдал өөрчлөгдөж байсан нь захидал устгасан нь ам өгөхийг шаардсан нь, шүүгчийн айлган сүрдүүлсэн биш харин гуйж хүссэн шинжтэй дуу энэ бүгд санаанд нь орж ирэв. Тэрээр согтуу хүн шиг гуйвлан хашхичив. Тэгээд дараа нь өрөөгий нь холбодог ухсан нүх уруу ухасхийж,

- Би ганцаараа байх хэрэгтэй байна! Би энэ бүхнийг эргэцүүлэн бодох ёстой! Гэж дуу тавилаа.

Тэгээд Дантес өрөөндөө орж, орон дээрээ унаад өглөө. Үдэш нь хуягийг орж ирэхэд Дантес царай нь хачин болж, нүд нь гөлийн баримал хөшөө шиг дув дуугүй сууж байлаа.

Хоромхон зуур мэт нисэн өнгөрсөн энэ хэдэн цагийн хооронд Дантес аймшигт шийдвэр гаргаж түүнийгээ биелүүлэхээр хатуу тангараглав.

Бодлого болон сууж байсан Дантесыг хүний дуу г рч сэрээв. Энэ нь хуягийг явсны дараа хамт цай уухыг урихаар ирсэн ширээт ламын дуу ажээ. Галзуу, тэр мөртөө зугаатай галзуу гэдэг алдар нь өвгөн хоригдолд бага зэрэг эрх ямба олгож тухайлбал: арай цагаан талх, ням гаригт лонх дарс өгдөг болгожээ. Тэр өдөр нь яг ням гариг байсан тул ширээт лам залуу нөхрөө талх дарсаа хуваалцаж цайлъя гэж урихаар иржээ.

Дантес түүний хойноос дагаж оров. Дантесын царай гэрэлтэж хуучин янзандаа орсон боловч, залуу хүүгийн санаанд ямар нэгэн шийдвэр төрснийг илтгэн, харц нь хатуу ширүүн, хурц болжээ. Ширээт лам түүнийг сайтар ажиглан хараад,

- Би танд үнэн мөнийг олоход тусалж, хэрэггүй үг хэлсэндээ харамсаж байна гэхэд Дантес,

- Яагаад тэр вэ? гэж асуув.

- Яагаад гэвэл танд урьд нь байдаггүй байсан, өшөө авахын хүслэн гээчийг сэтгэлд тань суулгачихжээ.

Дантес инээмсэглэж,

- Өөр юм ярилцъя л даа гэж хэлэв.

Ширээт лам, Дантес өөд дахин нэг хараад, гунигтайгаар толгойгоо сэгсрэв. Гэвч Дантесын гуйснаар өөр зүйлийн тухай яриу. Ширээт ламтай ярих нь зовлон зүдүүр үзсэн хэн нэгэн хүнтэй ярихын адил сургамжтай, сонирхолтой байлаа. Харин ярианд хувиа бодсон шинж огт илрэхгүй бөгөөд зовж зүдэрсэн энэ хүн өөрийн зовлон зүдүүрийн тухай огт ярьдаггүй ажээ.

Дантес түүний үг бүрийг бишрэн гайхаж сонсоно. Ширээт ламын ярьж байгаа зарим үг нь түүний мэддэг зүйлд, далайчин хүний мэдлэгт тохирсон хариу өгнө. Зарим нь далайгаар аялан явахад шөнө дунды үед умардад туяа татдаг лугаа адил түүний мэдэхгүй зүйлд хариу болж, шинэ хачин сонин зүйлийг түүнд нээж өгнө. Зах суртахуун, гүн ухаан, нийгмийн үзэл санааны өндөрлөгт хүрсэн ийм ухаантанг дагалдах гэдэг нь боловсролтой хүнд ямар их аз завшаан болохыг ухааран ойлгов.

- Та өөрийнхөө мэддэг зүйлээс аль нэгийг нь надад зааж өгөөч гэж Дантес хэлээд - Үгүй ядахдаа надтай хамт байхдаа уйдаггүйн тулд зааж өг л дөө, над шиг ийм боловсролгүй дорд хүнтэй байснаас ганцаараа байсан нь дээр гэж таныг бодох бий дээ гэж айж байна. Хэрвээ миний хүсэлтийг зөвшөөрвөл би оргох зайлах тухай дахин ярихгүй гэж ам өгье гэв.

Ширээт лам инээмсэглэж,

- Ай, хүү минь. Хүний мэдлэг гэдэг зэгсэн хязгаарлагдмал юм, би танд тоо бодлого, физик, түүх ба өөрийн мэддэг гурав дөрвөн хэл зааж өгөхөд та миний мэдэж байгаа бүх зүйлийг мэдчих болно. Энэ бүх мэдлэгийг би танд хоёр жилийн дотор зааж сургана гэж хэлэв.

- Хоёр жил ий? Та намайг хоёр жилийн дотор энэ бүх эрдмийг сурчихна гэж бодож байна уу?

- Хавсралт нэмэлттэй нь бол үгүй л дээ, харин үндсэн зүйлүүдийг нь сурчихна. Цээжлэх явдал мэдэж байгаа гэсэн хэрэг биш. Мэддэг хүмүүс, эрдэмтэй хүмүүс гэж хоёр янз байдаг юм. Түрүүчийнхийг нь ухаан санаа, дараачийнхийг нь гүн ухаан төрүүлдэг юм.

- Тэгвэл гүн ухаанд суралцаж болохгүй гэж үү?

- Гүн ухаанд суралцдаггүй, харин гүн ухаан бол олж авсан мэдлэг, түүнийг хэрэглэгчийн ухаан хоёрын хослол юм. Гүн ухаан гэдэг бол Христос бурхан тэнгэрт дээшлэхдээ дамжиж гарсан гэрэлт үүлс юм.

- Та юунаас нь эхэлж зааж өгөх вэ? Би бушуухан л заалгаад эхэлмээр байна, би юм мэддэг болохсон гэж хүсэж байна гэж Дантес асуув.

- Бүгдий нь! Гэж ширээт лам хариулав.

Хоригдлууд тэр оройдоо хичээлийнхээ төлөвлөгөөг зохиогоод, маргаашаас нь түүнийгээ хэрэгжүүлж эхлэв. Дантес гайхмаар ойтой ер бусын ойлгомтгой хүн ажээ. Тоонд авьяастай нь юм бүхнийг тоо бодлогын үүднээс ойлгоход тусална. Далайчин хүний уужим, сайхан сэтгэл нь хоосон тоо, шулуун шугамд аваачигч хэтэрхий жирийн нотолгоонуудыг зөөлрүүлж өгнө. Түүнээс гадна итали хэл мэддэг ба Дорнодын орноор аялж явахдаа шинэ грег хэд гадарладаг болжээ. Энэ хоёр хэлнийхээ ачаар удалгүй бусад хэлний зохион байгуулалтыг ойлгож, хагас жилийн дараа испани, англи, герман хэлээр ярьж чаддаг болжээ.

Шинжлэх ухаан түүнд зугаатай санагдсанаас ч тэр юм уу, эсвэл дээр өгүүлсэнчлэн хэлсэн үгэндээ хүрч чаддагаас тэр юм уу, юу ч л гэсэн ширээт ламд хэлсэн ёсоороо оргох тухай нэг ч удаа ярьсангүй, өдөр хоног ч хурдан, ашигтай өнгөрсөөр байв. Нэг жилийн дараа Дантес өөр хүн болсон байв.

Ширээт ламын тухайд гэвэл хэдийгээр Дантестай хамт зугаатай байх боловч, өдрөөс өдөрт царай нь барайн, ямар нэгэн бодол ухаан санаанаас нь гарч өгөхгүй байгаа юм шиг байв. Тэр өвгөн заримдаа гүн бодолд автан хүндээр санаа алдаж, заримдаа гараа элJэндээ зөрүүлээд бүтэн цагийн турш өрөөн дотуураа хойш урагш алхална.

Нэгэн удаа гэнэт зогссоноо дуу алдан,

- Хэрвээ манаач байдаггүй сэн бол! Гэхэд ширээт ламын санаа бодлыг шууд харав уу гэлтэй мэдсэн Дантес,

- Манаач байх, байхгүй нь танаас л шалтгаална гэж хэлэв.

- Хүн ална гэхээс дур гутдагаа танд хэлсэн шүү дээ.

- Гэхдээ хүний аминд хүрлээ гэхэд, өөрийгөө хамгаалах төрөлх авьяаснаас л болж үйлдэнэ шүү дээ.

- Ялгаагүй, би чадахгүй.

- Гэлээ ч гэсэн та энэ тухай бодож байна уу?

- Үргэлж гэж ширээт лам шивнэхэд, Дантес,

- Тэгээд та арга олоо юу? гэж сонирхон асуув.

- Хэрвээ хоёр байшингийн хоорондох зайнд сохор дүлий цагдаа тавивал арга олсон гэж ширээт ламыг хариулахад Дантес түүнийг айхаар хатуу шийдвэртэйгээр,

- Тэр сохор, дүлий байж болно гэж хариулав.

- Үгүй, үгүй гэж ширээт лам хашхираад - Ингэж болохгүй! гэв.

Дантес энэ яриагаа үргэлжлүүлэх гэсэн боловч ширээт лам толгой сэгсрэн, хариу дуугарсангүй.

Түүнээс хойш гурван сар өнгөрлөө.

Нэгэн өдөр ширээт лам Дантесаас,

- Та бяртай юу? гэж асуув.

Дантес түүнд хариу хэлэхийн оронд дэргэдээ байсан цүүцийг авч морины тах шиг нугалснаа, буцааж тэгшлэв.

- Тун аргагүй хэрэг болбол л манаачийг алахаас биш, наана нь үгүй гэж ам өгөх үү?

- Өгнө.

- Тэгвэл бид бодож байгаагаа биелүүлж чадна гэж ширээт лам хэлэв.

- Түүнийг биелүүлэхэд хэдий хэр хугацаа шаардагдах вэ?
- Жилээс л багагүй.
- Тэгвэл ажилдаа орж болох уу?
- Одоо ч гэсэн болно.
- Харж байна уу та, бид бүтэн жилээ зүгээр алдчихсан байна! гэж Дантес хашхирав.
- Таныхаар бол алдсан байна уу?
- Бурхныг бодож намайг уучлаарай! Гэж Дантесын царай улайн дуу алдав.
- Зүгээр зүгээр! Хүн бол хүн л юм, харин та бол миний мэдэх олигтой хүмүүсийн нэг. За сонсож бай! Миний төлөвлөгөө ийм байна гэж ширээт лам хэлэв.

Тэгээд хийсэн төлөвлөгөөгөө Дантест үзүүлэв. Энэ бол өөрийн нь өрөө, Дантесын өрөө, тэр хоёрын өрөөг холбосон нүхний зураг байв. Энэ нүхнийхээ дунд талд нь уурхай шиг хажуу тийш нь салбарлуулан нүх ухна. Энэ хажуугийн нүх нь манаач зогсдог гудамлагт хүрэх бөгөөд түүний шал хийсэн дөрвөлжин чулуунуудаас нэгийг нь хөндийлөн ухаж орхино. Тэгээд хэрэгтэй цаг болохоор цэрэг дээгүүр нь явахад даалгүй доош нурна, цэрэг сандарч биеэ хамгаалж чадахгүй болоход Дантес түүн уруу ухасхийн барин авч хүлээд, аманд нь алчуур чихчихнэ. Тэгээд хоёр хоригдол гудамлагийн цонхоор гарч гадна талын ханыг олсон шатны тусламжтайгаар давж буугаад оргож зайлна.

Дантес дороо дэвхцэн нүд нь баяртай гялалзлаа. Энэ төлөвлөгөө нь ямар ч байсан гарцаагүй биелэгдэхээр хялбархан байв.

Мань хоёр тэр өдөртөө газраа ухаж эхлэв. Энэ хөдөлмөр нь удаан хугацааны амралтын дараа эхэлж байгаа болохоор их л хичээнгүй ажиллав. Тэр хоёрын хэн хэний нь ганцхан хүсэж явсан юм нь байлаа.

Тэр хоёр эцэж цуцахыг мэдэхгүй ажиллана. Харин хуяг ирэх цаг дөхөхөөр ажлаа орхиж өөр өөрсдийнхөө өрөөнд ирдэг ажээ. Тэд хуягийнхаа алхааг холоос таньдаг болсон учир огтхон ч тэвдэх сандрахгүй байцгаана. Тэр шинэ нүхнээс гарсан шороог нунтаглаад аль нэгнийхээ цонхоор маш болгоомжтойгоор хаяхад нь шөнийн салхи хийсгэн алга болгоно.

Цүүц, хутга, модон хөшүүргээр хийсэн энэ ажилд жил илүү хугацаа зарцуулагдав. Энэ жилийн туршид ширээт лам Дантесыг сургаж, түүнтэй аль нэгэн хэлээр ярилцаж, ард түмэн ба алдар хэмээх гайхамшигт мөрийг өөрийнхөө ард

үлдээсэн их хүмүүсийн түүхийг ярьж өгнө. Түүний хамт ширээт лам дээд зиндааны язгууртны хүрээний хүн болохоор яриандаа уйтгартай боловч хүндэтгэлийн ихэмсэг харьцааг хэрэглэх ажээ. Дантес төрөлхийн авхаалжтай учир, өөрт нь дутагдаж асан язгууртны эелдэг хүндэтгэлийг мөн зөвхөн дээд ангийнхан эсвэл гэгээрч боловсорсон хүмүүсийн дунд баймааж нь сурч болдог сурвалжит язгууртны аяг маягийг өөрийн болгож авч чаджээ.

Тэд арван таван сарын дараа нүхээ ухаж гүйцжээ. Гудмын доод талд хөндийлөн ухсан бөгөөд хойш урагшаа явж байгаа манаачийн хөлийн чимээ сонстоно. Амжилттай оргохын тул моригодлууд саргүй харанхуй шөнө болохыг хүлээж, харин цэргийн доорх газар цагаасаа өмнө нурчих бий гэж айж байв. Энэ аюулыг урьдаас болгоомжлохын тулд байшингийн суурин дороос олдсон модоор тулгуур хийжээ.

Дантес яг үүнийг хийж байхад, олсон шат бэхлэх хадаас үзүүрлэхээр өрөөндөө үлдсэн ширээт лам түүнийг гэнэт айсан дуугаар дуудахыг сонсов. Дантес түүн өөд яаран очиход ширээт лам өрөөний дунд царай нь зэвхийрэн, хөлс нь гоожин, чичигнэсэн гараа атгалан зогсож байв.

- Бурхан минь! Гэж Дантес хашхираад - Юу болчих нь энэ вэ? Яав та? Гэж асуув.

- Бушуул, бушуул! Гэж ширээт лам хэлээд - миний хэлэхийг сонс! Гэв.

Дантес ширээт ламын зэвхийрсэн царай, хөхөрсөн нүд, цагаарсан уруул, сэгсийсэн үсийг хараад гартаа байсан цүүцийг өөрийн эрхгүй алдчихав.

- Юу болчхов? Гэж дуу алдав.

- Би үхлээ! Миний хэлэхийг сонс! Надад нэг хачин, үхэж ч магадгүй өвчин тусаж байх шиг байна, ухаан алдалт эхэлж байна. Би үүнийг мэдэрч байна, шоронд орохоос жилийн өмнө нэг удаа ингэсэн юм. Энэ өвчнийг эмнэдэг ганцхан эм байдаг юм, би түүнийг танд хэлж өгье. Миний өрөөнд гүйж очоод орны хөлийг өргө, тэр хөндий юм, түүн дотор жижигхэн шилтэй улаан эм бий. Түүнийг нааш нь аваад ир... эсвэл, байя байя, байзаарай! Намайг энд байхад ороод ирж магадгүй, одоогоор чадалтай байгаа дээр минь өрөөнд хүргээд аль. Юу болох ба хичнээн хугацаагаар үргэлжлэхийг хэн мэдэх вэ? гэв.

Дантес аймшигт золгүй явдал тохиолдсон боловч тэвдэж сандарсангүй, хөөрхий ширээт ламыг чирэн нүхэн дотор оров. Үйлээ үзэн байж өвчтэй өвгөнийг өрөөнд нь аваачиж, орон дээр нь хэвтүүлэв.

Ширээт лам дөнгөж сая хүйтэн уснаас гарч ирсэн юм шиг, бүх бие нь чичрэн салганаж,

- Баярлалаа, одоо ухаан алдаж эхэлж байна. Дүйнгэтэн ухаангүй болох байх. Нэг ч дуу гаргалгүй ямар ч хөдөлгөөнгүй хэвтэж магадгүй эсвэл амнаас хөөс сахран атиралдаж, хашхирах байх шүү. Тэгвэл миний хашхирахыг дуулдуулалгүй байхыг бодоорой, энэ л хамгийн чухал шүү, тэгэхгүй бол намайг өөр өрөөнд шилжүүлж чи бид хоёрыг үүрд салгачхаж магадгүй. Намайг үхсэн юм шиг хөдлөхгүй хөшиж орхихоор, дуулж байгаа биз, гүйцэд хөшихөөр шүү, та миний шүдийг хутгаар зааж байгаад энэ шингэнээс арван дусал дусаагаарай. Тэгэхд би сэргэж магадгүй гэлээ.

- Магадгүй гэнэ ээ? гэж Дантес гунигтайгаар дуу алдав.

- Туслаарай! Туслаарай! Гэж ширээт лам хашхираад - Би...би...үх... гэв.

Энэ муужралт нь золгүй хоригдлыг үгий нь хэлж дуусгалгүй тийм хурдан хүчтэйгээр эхлэв. Тэнгисийн шуурга шиг хурдан баргар сүүдэр магнай дээгүүр нь татав. Нүд нь бүлтийж, ам нь мурийн, хацар нь хүрэлтээд ирэв. Тонгочиж, хашхиран аманд нь хөөс сахрав. Дантес түүний захисныг биелүүлж амыг нь хөнжлөөр нь дарав. Ингэж хоёр цаг үргэлжлэв. Тэгээд эцэст нь чулуу шиг голгүй, гантиг шиг хүйтэн цагаан, гишгэгдсэн өвс шиг арчаагүй болж, сүүлчийн удаа чичрэн дагжаад орон дээрээ огт хөдлөхгүй хэвтэв.

Энэ хуурмаг үхэл бүх биеийг нь эзлэн авч зүрх нь хөдлөхөө больж эхлэхийг хүлээв. Тэгээд хутгаа вч шүднийх нь завсраар шургуулж, ихээхэн хүч гарган, зуусан шүдийг зай гаргаж улаан эмнээс нь арав дусаагаад хүлээв.

Нэг цаг өнгөрлөө, өвгөн хөдөлсөн ч үгүй. Дантес эм дусаалгүй дэндүү удаачихиав уу даа гэж айн толгойгоо базлан айж мэгдсэн харцаар түүнийг харна. Тэгтэл арай гэж хацар нь улайж, харсан хэвээрээ байсан нүд нь ухаан орж, өвгөн хөнгөнөөр санаа алдаад хөдлөв.

- Аврагдлаа! Аврагдлаа! Гэж Дантес хашхирав

Өвчтэй хүн юм ярьж чадахгүй байсан боловч илэрхий сандарсан байдалтайгаар гараа үүд уруу сунгав. Дантес анхааран чагнавал хуягийн хөлийн чимээ гарав. Долоон цаг болсон байв. Гэвч Дантес хэдэн цаг болж байгааг анзаарах ч сөхөөгүй байжээ.

Эдмон нүх уруу ухасхийн ороод чулуугаар таглаж, өөрийнхөө өрөөнд оров.

Хэсэг хугацца өнгөрсний дараа хаалга онгойж, хуяг орж ирэхэд хоригдол урьдынхаа адилаар орон дээрээ сууж байв.

Хуяг гарч, хөлийн чимээ нь дөнгөж дуудлахаа больмогц сэтгэл нь түгшиж зовсон Дантес хоолоо ч мартаж орхиод буцаж очин чулуугаа өргөөд ширээт ламын өрөөнд оров.

Ширээт лам ухаан орсон боловч огтхон ч тэнхээ тамиргүй хэвтэж байв.

- Би тантай дахиад уулзахгүй юм байх гэж бодож байсан шүү гэж хэлэв.
- Яагаад? Та үхэхээс айж байсан юм уу? гэж цаадах нь асуув.
- Үгүй, оргоход бүх зүйл бэлхэн болсон, би таныг оргочих байх гэж бодсон юм гэхэд Дантесын хацар улайж,
- Таныг орриод уу? Та намайг ингэх амьтан гэж үнэхээр бодлоо гэж үү? Гэж хашхирав.
- Би таша рчээ гэдгээ одоо мэдэж байна. - Би яасан их тамирдаж доройтоо вэ? гэж өвгөн хэлэв.
- Сэтгэлээр бүү уна, тэнхээ тамир орно гэж Дантес хэлээд ширээт ламын орон дээр сууж гараас нь барив.

Ширээт лам толгой сэгсрэв.

- Хамгийн сүүлд хагас цаг хяраатай муужирсан юм сан, дараа нь юм идэх дур хүрч билээ, харин одоо бол хүний тусламжтайгаар босож чадахгүй, баруун хөл, баруун гар хөдөлдөггүй шүү. Тархинд цус харвасан бололтой, толгой их өвдөж байна. Гурав дахь удаагийн ухаан алдалтаар надад саа өвчин тусах ч юм уу эсвэл тэр дорoo үхнэ гэв.
- Үгүй, үгүй, та тайвшир, үхэхгүй. Хэрвээ гурав дахь ухаан алдалт болдог юм гэхэд эрх чөлөөтэй болсон хойно тохиолдоно. Тэгэхэд бид таныг энэ удаагийнх шиг, тэр ч байтугай илүү сайн эмчилнэ. Учир нь бидэнд хэрэгтэй юм бүхэн байх болно шүү дээ.
- Найз минь, өөрийгөө битгий хур, энэ удаагийн ухаан алдалт намайг үүрд энэ шоронд байх болгов, оргоход чинь явж чаддаг байх хэрэгтэй...
- Тэгээд яагаа вэ? Бид долоо хоног, сар, хэрвээ хэрэгтэй бол хоёр сар хүлээнэ, тэр хугацаанд та дахин тэнхээ тамир орно, бидний оргоход юм бүхэн бэлэн, бид өөрсдөө хэзээ хэдэн цагт оргохоо тогтоож чадна. Таныг сэлж чадах болмогц бид оргоно доо.
- Би одоо сэлж чадахаа больсон гэж Фариа хариулаад - Энэ гарт саа тусчихлаа, тэгэхдээ ганц өдөр биш, үүрд тийм боллоо. Та үүнийг өргөөд ямаршуухан хүнд байгаагий нь үзээч гэв.

Дантес өвчтөний гарыг өргөж үзэхэд, тэр нь чулуу шиг доошоо уначихав. Тэгэхэд Дантес санаа алдав.

- Эдмон та одоо үнэмшив үү? Ярьж байгаа юмаа мэдэж байна гэдэгт минь итгэ. Энэ өвчин анх надад туссанаас хойш би үүний тухай зогсолтгүй бодох болсон юм. Би ингэнэ гэж хүлээгээд л байсан юм. Миний энэ өвчин бол үе залгамжилсан өвчин. Миний аав гурав дахь удаагаа ухаан алдаад талийгаач болсон, өвгөн аав бас тэгсэн. Энэ уусмалыг найруулах жор бичиж өгсөн алдарт эмч Кабанис надад ч ийм хувь зохиол тохиолдоно гэж зөгнөн хэлсэн юм гэв.

- Эмч нарын андуурахыг алийг тэр гэх вэ гэж Дантес дуу алдаад - Танд саа өвчин туслаа ч гэсэн бидэнд саад болохгүй, би таныг мөрөн дээрээ үүрээд сэлж хоёулаа хамт явна гэхэд,

- Хүү минь, та чинь далайчин, туршлагатай усчин хүн, тэгэхээр ийм юм үүрсэн хүн төдий л хол газар сэлж чадахгүй гэдгийг мэдэх ёстой. Таны өөрийн чинь сайн санаат сэтгэл ч үнэмшихгүй байгаа хоосон горьдлогоор өөрийгөө бүү тайтгаруул. Миний суллагдах цаг буюу өөрөөр хэлбэл үхэх цагаа болтол би эндээ байх болно. Харин та орго, зугтаа! Та бол залуу, цог золбоотой, хүч чадалтай байна, надад бүү хоргод, би таны ам тангаргийг чинь буцааж өгье гэж ширээт лам хэлэв.

- За тийм байж, тэгвэл би ч эндээ үлдэнэ гэж Дантес хэлэв.

Тэгээд босож өвгөн дээр гараа сунгаад,

- Таныг үхтэл орхихгүй гэж бурхны нэрийг барьж тангараглая гэж хэлэв.

”ариа тэр ариун шудрага сайн сан атай, цагаан цайлган сэтгэлтэй залуу хүүг харж, үнэнч сэтгэлийг нь илчилсэн царай дээр нь өөрт нь хайртай бөгөөд үнэн голоосоо тангараглаж байгааг нь тодхон мэдрэв.

- Тэгвэл сайн байна. Би таныг ингэж хохирч байгааг хүлээн авч, их баярлаж байна гэж өвчтэй өвгөн хэлэв.

Тэгээд Эдмонд гараа өгч,

- Таны харамгүй үнэнч сэтгэлийн хариуд, ачийг чинь хариулж магадгүй. Би оргож чадахгүй болсон, та бас эндээс явахгүй гэж байгаа болохоор бид гудам доорх нүхээ бөглөх хэрэгтэй байна. Манаач хөндий газар байхыг мэдчихээд харгалзагчийг дуудаж ирүүлж магадгүй, тэгвэл бүх юм илэрч, бид хоёрыг хагацуулах болно. Би одоо танд тусалж чадахгүй зөвхөн харамсаад л хэвтэж байх боллоо. Та одоо явж ажилдаа ор, хэрвээ хэрэг болбол бүхэл шөнөдөө ч ажилла, тэгээд өглөөний үзлэг өнгөрсөн хойно хүрээд ирээрэй. Би танд маш чухал нэг зүйлийг хэлэх хэрэгтэй байна гэв.

18. Ширээт лам Фариагийн эрдэнэсийн сан

Дантес маргааш өглөө нь нөхрийнхөө өрөөнд орж ирэхэд ширээт лам орон дээрээ сууж байлаа. Царай нь тайван бөгөөд цонхоор орж ирсэн нарны гэрэл түүний зүүн гартаа барьсан цаасан дээр тусна. Баруун гар нь юм барьж чадахаа больчихсон гэдгийг уншигч авгай мартаагүй байх. Энэ хуудсыг бөөрөнхийлөн хуйлаад удсан бололтой, тийм ч учраас сайн тэнийж өгөхгүй байв.

Ширээт лам Дантест цаасаа зааж харуулахад, Дантес,

- Энэ юу юм бэ? Гэж асуув.
- Сайн хар л даа гэж ширээт лам инээмсэглэн хариулав.
- Би нүдээ бүлтэртэл харавч хачин янзын бэхээр бичсэн готийн үсэгтэй хуйлаастай цааснаас өр юм олж харахгүй байна гэж Дантес хэлэв.
- Хайрт нөхөр минь энэ цаас бол гэж Фариа хэлээд - Одоо би танд нуулгүй хэлье, би таныг туршиж шалгаж үзсэн, энэ цаас бол өнөөдрөөс, энэ минутаас эхлээд хагас нь таных болох эрдэнэсийн сан юм гэв.

Тэгэхэд Дантесын духан дээр хүйтэн хөлс чийхрав. Өвгөнийг солиотой гэж алдаршуулахад хүргэсэн тэр эрдэнэсийн сангийн тухай ширээт ламтай ярихгүй юм сан гэж Дантес хичээж иржээ. Эдмон төрөлхийн юмны учрыг олж чаддаг хүн учир энэ эгзэгтэй зүйлийг хөндөхгүйг хичээх бөгөөд Фариа ч бас л энэ тухай дуугүй байсан ажээ. Эдмон түүний дуугүй байх явдлыг ухаан нь дахин сэргэснийх гэж бодож байв. Харин одоо хүндээр ухаан алдаж унасны дараа ингэж байгааг мэдрэл нь дахин муудаж эхэлж байгаагийн гэрч гэж үзэхээс өөр аргагүй.

- Та эрдэнэсийн сан гэнэ ээ? гэж Дантес шивгэнэн хэлэхэд,

Ширээт лам инээмсэглэн,

- Тийм ээ, Эдмон та бол сайн санаатай хүн, таны царай цонхийж, сандарч байгааг чинь хараад би таны дотор чухам юу болж байгааг ойлгож байна. Битгий санаа зов, би солиотой хүн биш. Энэ эрдэнэсийн сан гэдэг бол байгаа юм. Дантес минь, үүнийг би эзэмших хувьгүй юм бол, та түүнийг эзэмшээрэй. Хүн бүхэн намайг солиотой гэж үзэх учраас хэн ч миний үгийг дуулж, түүнд итгэх дīргүй байдаг юм. Харин та бол намайг ухаан саруул гэж сайн мэднэ. Та юу ч гэсэн миний хэлэхийг сонс, тэгээд сүүлд нь итгэх, итгэмгүйгээ өөрө мэдээрэй гэв.

«Ай хөөрхий! Дахиад солиорчихлоо, энэ золгүй хэрэг болох л дутаад байж дээ» гэж Дантес бодсоноо дуулдахаар,

Найз нөхөр минь, та ухаан алдаад тамирдаж орхиж, амарвал дээр биш үү? Маргааш таны ярих юмыг сонсьё, харин өнөөдөртөө би таныг зүгээр л сувилж өнгөрмөөр

байна, тэгээд бас гээд Дантес инээмсэглэж, - Энэ эрдэнэсийн сангийн тухайд бол тийм их яараад баймаар хэрэг биш гэв.

- Яаралгүй болохгүй Эдмон! Маргааш нөгөөдөргүй гурав дахь удаа ухаан алдахыг хэн мэдэх вэ. Тэгвэл өнгөрөх нь тэр шүү дээ! Арваад гэр бүлийг жаргалтай амьдруулахаар тэр их баялгийн тухай би олонтаа харамсан баярлаж боддог юм. Намайг мөрдөн байгаа хүмүүст тэр баялаг олдохоо больсон. Энэ бодол бол миний өшөө авалт бөгөөд харанхуй шорон дотор үүнийг бодож баярлан байдаг сан. Харин одоо бол би танд хайртай учраас ертөнцийг уучлан үзэж, таны залуу нас ба ирээдүйг харж байна. Миний баялаг танд ямар их жаргал авчирч өгөх бол гэж бодохоос хожимдчих вий гэж айж, тэр баялгийг эзэмшвэл зохих ийм хүнийг баялгаасаа хагацаачих вий гэж эмээж байна.

Эдмон санаа алдаад эргэв.

- Та бас л үнэмшихгүй байна уу Эдмон гэж Фариа үргэлжлүүлэн хэлээд - Миний үгэнд та үнэмшсэнгүй. Танд нотолгоо хэрэгтэй байх шиг байна. Энэ хэдэн мөр юмыг уншина уу, би үүнийг хэзээ ч, хэнд ч үзүүлээгүй байсан юм гэв.

- Найз нөхөр минь маргааш больё гэж Эдмон солиотой өвгөний үгээс зөрж чадалгүй хариулаад - Та бид хоёр энэ тухай маргааш ярихаар тохирсон биш билүү гэв.

- Ярихыг нь маргааш ярья, харин энэ бичгийг өнөөдөр уншчих.

«Өвгөний уурыг хүргээд хэрэггүй» гэж Дантес бодов.

Тэгээд тэр хагас нь шатчихсан хэсэг цаас авч уншсан нь:

Энэ агуй дотор: хамгийн мухарт байгаа булмал эрдэнийг түүнд гэрээслэн өөрийн ганц залгамжлагчид бүхлээр өгнө.

1498 оны

Чез

Дантесыг уншиж дуусахаар Фариа,

- За яав? Гэж асуув.

- Энд зөвхөн мөрний эхний үгс байна шүү дээ гэж Дантес хариулаад - Үгс нь хоорондоо холбоогүй хагас нь шатчихсан, утга нь ойлгогдохгүй юм гэв.

- Та анх удаа уншиж байгаа болохоор тэр, түүнээс биш энэ хэсэг цаасыг олон шөнө шагайж өгүүлбэр бүрийг нь, утга санаа бүрийг нь дахин сэргээсэн надад бол өөр хэрэг.

- Та алга байгаа санаагий нь сэргээсэн гэж бодож байгаа юм биз дээ.
- Би энүүнд итгэлтэй байна. Гэвч юу гэж бодно өөрөө мэдээрэй, харин энэ баримт бичгийн түүхийг сонс л доо.
- Чимээгүй! Хөлийн чимээ! ...Би явлаа! ...Баяртай! гэж Дантес хэлэв.

Дантес найз нөхрийн нь солиотой гэдгийг батлахаас өөр юм болохгүй тэр тайлбараас холдож болох болсонд баярлан, нүхэн дотуур могой шиг мөлхөн алга болов. Харин Фариа бүх хүчээ шавхан, хөлөөрөө дөрвөлжинг чулууг цааш түлхээд, шавраар чигжиж чадаагүй завсрыг нь мэдэгдэхгүйн тул чийрсээр таглав.

Комендант орж ирэв. Ширээт ламыг өвдөж гэж хуягаас дуулаад, түүнийг өөрөө биеэр үзэх гэж орж ирсэн нь энэ байжээ.

Фариа эвгүй хөдөлчих бий гэж бодоод түүнийг орж ирэхэд сууж байв. Тэр ингэж өөрийн биеийн баруун тал саа өвчинд дайрагдаж хөдлөхөө больсныг нууж чадав. Комендант түүнийг өрөвдөөд өөр сайн өрөөнд оруулж, залуу нөхрөөс нь салгачих бий гэж айжээ. Гэвч аз болоход сэтгэлийнхээ гүнд өвгөнд дотно байдаг комендант хөөрхий солиотой амьтны бие жаахан эвгүйтсэн юм байж гэж бүрэн итгээд гарч одов.

Тэр үед Дантес орон дээрээ суугаад, хоёр гараараа толгойгоо тулж тонгойн юм бодож байв. Дантес ширээт ламтай танилцсанаасаа хойш түүний саруул ухаан, гүн бодол, юмыг дэс дараатай нарийнаар ухааран мэддэгийн өчнөөн төчнөөн нотолгоог үзсэн, гэтэл юм бүхэнд ийм мэргэн ухаан ганцхан зүйл дээр очихоор солиотой юм шиг болчихоод байдгийн учрыг ойлгож чадахгүй ажээ. Хэн нь төөрөлдөж байна? Эрдэнэсийн сангийнхаа тухай ярьдаг Фариа юу? Эсвэл Фариаг солиотой гэдэг бусад хүмүүс үү?

Дантес найз дээрээ буцаж очихыг төвдөхгүй өдрийн турш өрөөндөө суув. Тэр Фариаг солиотой юм гэдэгт итгэн үнэмших тэр минутыг аль болохуйц хойшлуулахыг хичээнэ.

Үдэш хуягийг орж ирээд явсны дараа Фариа Эдмоны орж ирэхийг хүлээлгүй өөрөө тэр хоёрыг тусгаарлаж байгаа зайг туулах гэж оролджээ. Эдмон сүржигнэх чимээ гарахыг сонсоод саа өвчинд дайрагдсан өвгөн хичнээн их хүч гаргаж явааг мэдэрмэгц цочин давхийв. Дантесын өрөө уруу орж ирдэг нарийхан нүхээр өвгөн хэрхэвч мөлхөн орж ирж чадахгүй байсан учир Дантес өрөөндөө татаж оруулж ирэхээс өөр аргагүй болов.

- Би таныг ийм их махруу мөрдөн дагаж байгааг харж байгаа биз гэж Фариа хэлээд эелдэгхнээр инээмсэглэж, - Та миний өгөөмөр зангаас мултрах юм бодсон байх, гэвч тэгж чадахгүй байх шүү. За тэгэхээр сонсож бай гэж хэлэв.

Эдмон өөр арга байхгүй болсныг мэдээд өвгөнийг орон дээрээ суулгаж өөрөө түүний дэргэд мухар сандал дээр суув.

- Намайг эртний удамт хүмүүсийн сүүлчийн төлөөлөгч болох их хамба Спадын нарийн бичгийн дарга, итгэлт нөхөр нь байсан гэдгийг та мэднэ шүү дээ. Миний амьдралдаа үзсэн бүх л аз жаргал бол энэ эрхэм хүндтэй хүний ач билээ. Түүнийг өвөг дээдэс нь «Спад шиг баян» хэмээн үлгэр домогт яригдан үлдсэн боловч тэр өөрөө баян хүн биш байсан сан. Тэр болон энэ цуу үг зөвхөн баян гэдэг энэ нэрээрээ л амьдарч байсан юм. Түүний ордон нь надад диваажингийн орон болж байсан юм. Би түүний ач нарыг сургаж байсан бөгөөд тэд нас барж, энэ ертөнц дээр их хамба ганцаараа үлдэхэд би түүний арван жилийн туршид надад үзүүлсэн бүхий л ач тусыг нь хязгааргүй үнэнч сэтгэлээр хариулсан юм.

Их хамбын гэрт надаас нуудаг юм байгаагүй. Би түүнийг эртний ном судар хичээнгүйлэн эргүүлж, гэр бүлийн гар тэмдэглэлүүдийг шимтэн уншиж суухыг нэг биш удаа харс н. Би түүнийг нэг удаа шөнийн турш нойр алдаж дэмий сууж дараа нь сульдаж ядрах юм гэж зэмлэхэд, тэр над өөд гашуунаар инээмсэглээд, Ром хотын лүүхийг миний өмнө дэлгэн тавьсан юм. Энэ номын хорьдугаар бүлгээс хутагт хамба зургадугаар Александрын амьдралын тухай, эгнэгт санаанд минь хадагдсан доорх хэдэн мөрийг уншиж билээ.

Романье өөд довтолсон аялал төгслөө. Цезарь Борджиа байлдан дагуулалтаа төгсгөөд Италийг бүхлээр нь худалдан авах мөнгө олох хэрэгтэй болжээ. Хутагт хамбад ч бас ялагдсан хэдий боловч аюултай хэвээрээ байгаа францын ван Арван хоёрдугаар Людовикыг дуустал цохихын тулд мөнгө хэрэгтэй болжээ. Хоосорч доройтсон Италид тун бэрх зүйл болох тийм ашигтай зүйл бодож олох хэрэгтэй байжээ.

Ариун дээд эзэнтэнд нэгэн сайхан санаа төржээ. Тэр, шинээр хоёр их хамба [□](#) томилохоор шийдвэрлэжээ.

Ромын хоёр ихэс тэр дундаа хоёр баян хүнийг сонгож олох явдал нь ариун эцэгт дараах хоёр ашигтай ажээ. Нэгдүгээрт, орлоготой бөгөөд ирээдүйн хамбуудын эзлэх өндөр тушаалыг худалдаж чадах юм, хоёрдугаарт, хамбын малгай худалдсаныхаа төлөө өгөөмөр их шан хүртэх байх гэж найдаж болох байв.

Ажил хэргийн гурав дахь тал үлдлээ. Энэ тухай бид удахгүй мэдэх болно.

Хутагт хамба Цезарь Борджиа хоёр, их хамба болох хоёр хүнээ төлөвлөн оллоо. Энэ нь ариун ширээний дэргэд дөрвөн чухал тушаал эзэлж байгаа Жованни Роспильози ба Ромын хамгийн баян бөгөөд сайн санаат нэгэн ихэс Чезаре Спада хоёр юм. Тэр хоёр хоёулаа хутагт хамбын энэрэл хайрыг их л өндрөөр үнэлжээ. Тэд бас нэр төрд ч дуртай у«с байжээ. Дараа нь Цезарь Борджиа тэдний эрх тушаалыг худалдан авах хүмүүсийг олжээ.

Ийм байдалтайгаар Роспильози, Спада хоёр их хамбын тушаал худалдан авч, бас найман хүн шинэ хамбуудын эзлэн байсан хуучин тушаалуудыг нь худалдан авчээ. Зальтай аав хүү хоёрын авдарт найман зуун мянган скудо нэмэгджээ.

Энэ хэргийн гуравдугаар талд нь шилжиж орьё. Роспильози, Спада хоёрыг энхрийлэн үзэж тэр хоёрт хамбын тэмдэг өгөөд, энэ мэдэгдэм их ач тусын хариуг төлөх ба Ром хотод суухаар шилжин ирэхдээ өөрийн бүх хөрөнгийг бэлэн мөнгө болгож авчирна гэдгийг хутагт хамбатан мэдээд Цезарь Борджиатай хамт тэр хоёрыг дайлахаар урьж л дээ.

Энэ талаар эцэг хүү хоёрын хооронд маргалдаан гарч Цезарь өөрийнхөө ойрхны нөхдөд хэрэглэхээр үргэлж бэлхэн байлгадаг аргуудын нэгийг хэрэглэвэл болно гэж үзжээ. Энэ нь тухайлбал: хэн нэгэн хүнээр ямар нэгэн шүүгээ онгойлгуулахаар өгч явуулдаг алдарт түлхүүр юм. Энэ түлхүүр дээр дархан хүн ажиглалгүй үлдээчихсэн юм уу даа гэмээр өчүүхэн хурц өргөс байдаг санж. Тэр түлхүүрээр цоож онгойлгох гэж оролдсон хүн бүр өргөсөнд нь гараа хатгуулж маргааш нь үхдэг байжээ. Бас Цезарьт аль нэгэн хүнтэй гар барих хэрэгтэй болохоороо зүүдэг арслангийн толгойтой бөгжтэй байлаа. Арслан нь гар барьсан хүний гарт шигдэж тэр хүн нэг хоноод л үхдэг ажээ.

Ийм учраас Цезарь аавдаа, хоёр хамбыг шүүгээ онгойлгохоор явуулах эсвэл нөхөрлөгөөр гар барья гэж санал гаргаж: Гэтэл зургадугаар Александр хариу өгүүлсэн нь:

«Хүндэтгэвэл зохих их хамба Спада, Роспильози хоёроос хоолоо харамлаад яах вэ. Бид хоолныхоо үнийг буцаагаад авчаж чадах байх гэж надад бодогдож байна. Ходоод нь хоол боловсруулж чадахгүй бол тэр дороо мэдэгдэнэ, харин хатгах юм уу шүтгэхэд нэг хоёр хоног болж байж мэдэгддэг гэдгийг чи мартчихаа юу?» гэв.

Цезарь энэ бодлыг зөвшөөрөв. Хоёр их хамбыг дайлахаар урьсны учир ийм байна.

Үзэсгэлэнт сайхан газар гэж хоёр хамбын сонссон Саны-Пьетроин-Винколийн дэргэдэх хутагт хамба ламын усан үзмийн цэцэрлэг дотор ширээ засаж бэлтгэжээ.

Шинэ тушаалтай болсон, найранд очно гэж баярласан Роспильози ихэд хөгжилтэй царайтай ирж. Харин Спада бол болгоомжтой хашир бөгөөд ирээдүйд их л гялалзсан найдлагатай өөрийн ач хүү цэргийн даргад маш хайртай учир цаас, үзэг авч гэрээсээ бичжээ. Тэгээд ач хүүгээ жимст цэцэрлэгийн үүдэнд хүлээж бай гэж хэлүүлэхээр хүн явуулж, гэвч тэр нь гэртээ байсангүй учир явуулсан хүн түүнийг олж чадсангүй.

Дайлахаар урьдгийн учрыг Спада мэдэж байжээ. Гүн соёлжсон хүчин болох христос шашин Ромд ялан дийлсэн тэр цагаас хойш хэмжээгүй эрхт эзэн хааны нэрийн өмнөөс зуутын дарга «Цезарь, таныг үхсэн байгаасай гэж хүсэж байна» гэж зарлан мэдэгдэхээ больж, харин хутагт хамба ламын нСрийн өмнөөс түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч: «Ариун эзэн тантай хамт хоол зооглохыг хүсэж байна» гэж ирж хэлдэг болжээ.

Спада өөрийн хоёр цагт Сан-Пьетро-Ин Винколин усан үзмийн цэцэрлэг руу явав. Хутагт хамба түүнийг тэнд хүлээж байжээ. Спадагийн хамгийн түрүүнд харсан хүн нь ач хүү нь байлаа. Цезарь Борджиа ач хүүд нь их л эелдэг зөөлөн аашилна. Спадагийн царай зэвхийрэхэд, харин Цезарь юм бүхнийг урьдаас бодож төлөвлөн, занга бэлтгэснээ мэдэгдэх гэсэн шиг эгдүүтэйхэн харав.

Хоол идэхээр сууцгаав. Спада ач хүүгээсээ дөнгөж: «Чи миний явуулсан хүнтэй уулзав уу?» гэж асууж амжив. Тэгэхэд ач хүү нь тэр асуултын учрыг маш сайн ойлгож, үгүй хэмээн хариулав. Гэвч хожимджээ. Ач хүү нь хутагт хамбын аягачийн хийж өгсөн сайхан дарснаас нэг аяга уучихсан байжээ. Тэр минутад бас нэгэн лонх дарс авчирч түүгээр Спадаг их л өгөөмөр баян дайлав. Цагийн дараа тэр хоёрыг хорджээ гэж эмч хэлэв. Спада усан үзмийн цэцэрлэгийн үүдэнд нас барж, ач хүү нь гэрийнхээ үүдэнд эхнэртээ ямар нэгэн юм хэлэх гэж оролдоод чадалгүй үхчихжээ. Эхнэр нь түүний хэлснийг ойлгосонгүй.

Тэгтэл ч Цезарь хутагт хамба хоёр талийгаач нарын бичиг цаасыг хянан үзэх нэрийдлээр өв хөрөнгийг нь булаан авав. Гэвч бүх өв хөрөнгө нь: «Миний авдар ба ном дэвтэр, бас тэдгээрийн завсарт байгаа миний алтан булантай уншлагын ном эдгээрийг өөрийн хайрт ач хүүдээ хайрт өвгийнхөө тухай дурсаж байг гэж гэрээслэн үлдээв» гэж Спадагийн бичсэн нэгэн хуудас цаас байлаа.

Үе залгамжлагчийг бүх зүйлийг нэгжин үзэж гэрийн хэрэгслийг нь барилан, уншлагын судрыг нь сонирхож үзээд Спада баян гэдэг чинь ядуугийн ядуу хүн байсан юм байна гэж гайхацгаав. Хэрвээ номын сан ба лаборатори дотор буй мэдлэгийг тооцохгүй бол эрдэнэсийн сангийн мөр ч алга байв.

Өөр юу ч олдсонгүй. Цезарь түүний эцэг хоёр эрж онгичин, хамаг юмы нь хамсан боловч мянгаадхан скудогийн үнэтэй алтан мөнгөн эдлэл ба мөн төдийчинээ бэлэн мөнгөнөөс өөр юм олсонгүй. Гэвч ач хүү гэртээ эргэж ирээд, эхнэртээ «авга ахын бичиг цаасан дотор жинхэнэ гэрээслэл нь байх ёстой, сайн онгичиж эрээрэй» гэж хэлж амжжээ.

Талийгаачийн авгай гүрний үе залгамжлагчдаас илүү ихээр хичээнгүйлэн эрсэн боловч бас юу ч олсонгүй. Хоёр ордон ба усан үзмийн цэцэрлэг нь хутагт хамба лам, түүний хүү хоёрт дэндүү өчүүхэн хөрөнгө санагдсан тул тэдгээр нь талийгаачийн гэр бүлд үлдэв. Тэр үед үл хөдлөх хөрөнгө үнэгүй байж л дээ.

Сар жилүүд өнгөрч, зургадугаар Александр андуурч хор уугаад насбарсан ба түүнтэй хамт хордон Цезарь могойн арьс гууждаг лугаа адилаар шинэ арьс нөмөрсөн боловч тэр арьс нь хорондоо барын арьс шиг цоохор толботой болчихжээ. Тэгээд Ромоос зайлж явахаас өөр аргагүй болж, нэгэн шөнийн тулалдааны үед золгүйгээр алагдаж түүхэнд бараг мартагдаж хоцорчээ.

Хутагт хамба ламыг нас барж түүний хүүг хөгдсөний дараа хүн бүхэн Спадагийн гэр бүлийнхнийг урьд хамба байсантай нь адил язгуур угсаагаа сэргээн эдбэг дэлбэгээр амьдрах юм байх гэж хүлээж байв. Гэтэл тийм хэрэг болсонгүй. Спадагийнхан хэр тааруухан амьдарч байсан бөгөөд энэ хэрэгт ямар нэгэн нууц үргэлжид байсан ажээ. Эцгээсээ илүү зальтай Цезарь түүнээс хоёр хамбын өв хөрөнгийг хулгайлан авчирсан байх гэж хүмүүс шийджээ. Хамба Роспильози болгоомжлох ямарч арга хэмжээ аваагүй байсан тул модоо тултал дээрэмдэгдсэн болохоор хоёр хамба гэж ярьж байгаа юм.

Фариа яриагаа тасалж инээмсэглэн,

- Та одоо хүртэл ийм учир утгагүй юм сонсоогүй биз. Тийм үү? Гэж асуув.
- Яалаа гэж харин ч сонин байна гэж Дантес хариулаад - Сонирхолтой он дарааллын тэмдэглэл уншиж байгаа юм шиг санагдаж байна. Цааш нь ярина уу, таныг гуйя гэв.
- За цааш нь ярья.

Спадагийнхан мэдээ чимээгүй байдалд дасчээ. Он жил өнгөрсөөр байв. Тэдний удмынхны дунд цэргийн хүмүүс, дипломатуул байсан бөгөөд зарим нь сахил хүртэж, зарим нь банкны эзэн болцгоон, нэг хэсэг нь баяжин нөгөө хэсэг нь бүр хоосорчээ. Тэг тэгсээр би нарийн бичгийн даргаар нь ажиллаж байсан гүн Спадад хүрч иржээ.

Тэр өөрийн эрх тушаалд өв хөрөнгө нь тохирохгүй байгаа тухай дандаа гомдолж байдаг хүн байв. Би түүнд, үлдсэн бага зэрэг хогшлоо үүрдийн түрээсэнд өгчих гэж зөвлөсөн юм. Тэгээд тэр миний үгэнд орж, өөрийнхөө орлогыг хоёр дахин нэмэгдүүлсэн билээ.

Өнөөх алдарт мөргөлийн уншлагын нос эцгээс хүүд дамжин дамжсаар Спада гүнд хүрч ирсэн юм. Энэ нь олдож илэрсэн ганц гэрээслэлийн ачаар нэгэн төрлийн ариун сахиус болж хадгалагджээ. Энэ бол готийн нарийн чимэглэлтэй, уншлагын үед хамбын өмнө зарц нь барьж өгч байхаас өөр аргагүй тийм хүнд алтадсан ном байлаа.

Хорлогдон алагдсан хамбын дараа гэр бүлийн архивт үлдсэн янз бүрийн баримт бичгүүд, акт гэрээ хэлэлцээ зэрэг зүйлүүдийг хараад, би энэ их бичиг цаасыг надаас өмнөх хорин үйлчлэгч, хорин хэрэг хөтлөгч хорин нарийн бичгийн даргын адилаар ялган салгаж учир зүйг нь олох боллоо. Би хичнээн их тэвчээртэй, шаргуу эрсэн боловч юу ч олдсонгүй. Харин тэгэхийн хамт их уншиж, манай Цезарь Спадаг үхсэнээс хойш, тэдний өв хөрөнгө нэмэгдсэн эсэхийг л мэдэхийн тулд Борджиагийн овгийн бараг өдөр тутмын түүхийг бичсэн юм. Тэгээд тэдний хөрөнгө зөвхөн хамба Роспильозийн хөрөнгөөр нэмэгдсэнийг олж мэдлээ.

Спадагийн өв хөрөнгө түүний гэр бүлд ч Борджиад ч үлдээгүй, харин араб үлгэрүүдэд гардаг сүнсээр хамгаалуулсан газар доорх их эрдэнэсийн сан шиг эзэгнэх эзэнгүй байж байгаа юм байна гэдэгт итгэв. Би Спадагийнхны гурван зуун жилийн орлого, зарлагыг бодож шалгаж үзсэн боловч, ямар ч ашиг гарсангүй. Би юу ч олсонгүй, гүн Спада хоосон ядуу хэвээрээ хоцров.

Миний өмөг түшиг болсон хүн үхэв. Тэд эд хогшлоо үүрдийн түрээсэнд өгөөд өөртөө зөвхөн гэр бүлийн архив, таван мянган боть номтой номын сан, өнөөх алдарт уншлагын ном эдгээрийг үлдээж авсан см. Гүн маань, энэ бүхнийгээ дээр бас ромын мянг н скудотой хамт надад гэрээслэн үлдээж, би жил бүр тахил өргөж ном уншуулж байх ба түүний овгийн түүхийг үргэлжлүүлэн бичиж байх болзол тавьсан юм. Би ч түүнийг нь ёсчлон биелүүлсэн билээ...

Эрхэм Эдмон минь, тэсэж л байгаарай, одоо бид төгсгөлдөө ойртож байна.

Мянга найман зуун долоон онд, намайг баригдахаас нэг сарын өмнө, гүнгийн нас барснаас хоёр долоо хоногийн дараа арван хоёрдугаар сарын хорин тавны өдөр (энэ өдөр миний санаанд мартагдалгүй үлдсэнийг та одоохон ойлгох болно) би эмхэлж цэгцэлж байгаа цаас бичгүүдээ мянга дахь удаагаа уншсан юм. Ордон худалдагдсан учир би Ромоос Флоренцид шилжин суухаар өөрийн арван хоёр мянган ливрийн үнэтэй эд хогшил номын сан, өнөөх алдарт мөргөлийн номыг аваад явахаар бэлтгэж байлаа. Ихэд хичээнгүйлэн ажиллаж ядраад, дэндүү цадталаа хоол идсэний дараа залхуу хүрээд байхаар нь гараа дэрлээд унтсан юм. Тэгэхэд өдрийн гурван цаг болж байсан билээ.

Харин намайг сэрэхэд зургаан цаг болж байв.

Тэгээд толгойгоо өндийлгөвөл эргэн тойрон хав харанхуй болчихсон байлаа. Би гэрэл авчруулах гэж хонхоо дуугаргалаа, тэгсэн чинь хэн ч ирсэнгүй. Тэгэхээр нь би өөрөө гэрэл гаргахаар шийдэв. Ер нь ч гүн ухаантан хүний амьдралын хэв маягт сурах хэрэгтэй байсан юм. Би нэг гараараа чүдэнз авч, чүдэнзний хайрцаг дотор чүдэнз байхгүй байсан тул задгай зууханд асаж бйгаа галнаас асаахаар нөгөө гараараа цаас тэмтрэв. Тэгээд харанхуй дотор хэрэггүй цаас олохын оронд үнэт баримт бичгүүдээс шатаачих бий гэж айж байтал, өнөөх үе улиран гамтай хадгалагдаж ирсэн мөргөлийн номын дотор хавчуулгын оронд шарлачихсан сул цаас байсныг гэнэт санав. Би тэр хэрэггүй цаасыг тэмтрэн олж аваад хумхиж гал дээр барив.

Тэгээд илбийн юм шиг өнөөх цаасан дээрх чинь гал дүрэлзэхийн хэрээр шаравтар үсгүүд гарч ирэв. Надад аймаар санагдаж, тэр цаасыг базаж унтраагаад, лаагаа шууд задгай галаас асааж, хэлж баршгүйгээр сэтгэл түгшин байж, тэнийлгэж үзсэн чинь зөвхөн хүчтэй халаавал тодрон гардаг нууц бэхээр бичигдсэн үгс байв. Энэ бичгийн гуравны нэг хувь нь шатчихжээ. Энэ бол өнөө өглөө таны уншсан тэр хэсэг юм. Дантес, та дахиад нэг уншчихаач, тэгсний чинь дараа би орхигдсоныг нь үг ба утгаар нь нөхөж өгье.

Тэгээд Фариа их л хангалуун байдлаар Дантест өнөө хуудсаа өгөхөд цаадах нь энэ удаа зэв шиг өнгөтэй бэхээр бичсэн дараах үгсийг шамдан уншив.

«Энэ 1498 оны дөрөвдүгээр

VI Александр намайг дайлахаар
Шанг амлаж, өөрөө миний өв
Хордогдож үхсэн хамба Капрара,
Лайг надад бэлтгэсэн байх
Гвидо Спадаг миний ганц өв залгамж
Тэр надтай хамт очдог байсан
Гадарлаж байгаа. Чухамдаа гэвэл Монте Кристо
Эрдэнийн чулуу, очир алмас болон
үнэ бүхий зүлийг булсан билээ.
Зүүн талын бага булангаас эгц шу
Хясаан доороос түүнийг олно. Агуйд хоёр
Нүхний хамгийн цаад захын буланд
өвлөх ганц хүнийхээ
өмч болгон өгч байна.

1498 оны

Чез

гэж уншив.

- Аа, одоо энүүнийг унш гэж ширээт лам хэлээд өөр нэг хуудас өгөв.

Сарын 25-нд гэгээн дээдэс

Урихад нь, миний өгсөн хамбын овоодойн

Хөрөнгийг өвлөх гэсэндээ

Бентивольо хоёрын адил үйл

вий гэж болгоомжлон өөрийн ач

Лагч хэмээн мэдэгдэж байна.

Болохоор миний эрдэнэсээ булсан газрыг

Арлын агуй дотор цутгасан алт зоос

Бусад үнэт эрдэнэсийн хоёр сая скудогийн

Үүнийг ганц би л мэднэ...

луун тоолбол хорь дахь хадан

нүх гаргасан. Түүний хоёр дахь

би өөрийн булсан эрдэнэсээ

бүрэн мэдэлд гэрээслэн үлдээж

дөрөвдүгээр сарын 25

аре Спада»

Фариа түүний уншихыг хомхойрон харна.

Тэгээд Дантесыг сүүлийн мөрөнд хүрснийг хараад,

- Одоо хоёр хэсгээ нийлүүлээд өөрөө бодоод үз дээ гэж хэлэв.

Дантес түүний хэлснийг гүйцэтгэхэд хоёр хэсэг нийлж дараах зүйл боллоо.

«Энэ 1498 оны дөрөвдүгээр ... сарын 25-нд гэгээн дээдэс ... VI Александр намайг дайлахаар ... урихад нь, миний өгсөн хамбын овоодойн ... шанг амлаж, өөрөө миний өв ... хөрөнгийг өвлөх гэсэндээ... хордогдож үхсэн хамба Капрара, ... Бентивольо хоёрын адил үйл ... лайг надад бэлтгэсэн байх ... вий гэж болгоомжлон, өөрийн ач ... Гвидо Спадаг миний ганц өв залгамжлагч хэмээн мэдэгдэж байна. Тэр надтай хамт очдог байсан ... болохоор миний эрдэнэсээ булсан газрыг ... гадарлаж байгаа. Чухамдаа гэвэл Монте Кристо ... арлын агуй дотор цутгасан алт зоос эрдэнийн чулуу, очир алмас болон ... Ёусад үнэт эрдэнэсийн хоёр сая сЭудогийн ... үнэ бүхий зүлийг булсан билээ. ... Үүнийг ганц би л мэднэ... Зүүн талын бага булангаас эгц шу ... луун тоолбол хорь дахь хадан ... хясаан доороос түүнийг олно. Агуйд хоёр ... нүх гаргасан. Түүний хоёр дахь ... нүхний хамгийн цаад захын буланд ... би өөрийн булсан эрдэнэсээ ... өвлөх ганц хүнийхээ ... бүрэн мэдэлд гэрээслэн үлдээж ... өмч болгон өгч байна.

1498 оны ... дөрөвдүгээр сарын 25

Чез... аре Спада»

- Одоо ойлгов уу? гэж Фариа асуув.
- Энэ чинь тэгэж их удаан эрүүлээд байсан өнөөх Спадагийн гэрээс үү? Гэж бас л бүрэн итгээгүй Эдмон асуув.
- Тийм ээ, мянга дахин тийм.
- Үүнийг хэн ингэж хуучин янзаар нь сэргээсэн юм бэ?
- Би бүтэн үлдсэн хэсгээр нь мөрийн урт богино, цаасны өргөн нарийн ба илэрхий байгаа үгийн утгын дагуу алга болсон хэсгийн утгыг тааварлан бодож, харанхуй агуй дотор дээрээс тусах бүдэгхэн гэрлийн хүчээр замаа олж яваа хүн шиг эрсээр байж олсон юм.
- Та тэгээд эргэлзэх юмгүй болсон хойноо яасан бэ?
- Би тэр дороо өөрийнхөө эхлэн бичиж байгаа италийн нэгдсэн вант улсын тухай ном зохиолоо аваад замд гарч явсан юм. Гэвч императорын харгис цагдаа нар намайг аль хэдийнээс ажиглан харж байжээ. Тэр үед Наполеон мужуудыг салгаж байсан дараа нь хүү төрсний хойно харамсах явдал болсон юм даа. Намайг яаран явахад, шалтгааныг нь мэдэхгүй хүмүүс сэжиглэж Пьомбино орох хөлөг онгоцонд суутал баривчлан авсан юм.
- Одоо гээд Фариа Дантес өөд эцэг ёсны эелдэг харцаар харж - Одоо найз минь миний л мэдэж байгаагийн хэмжээгээр та мэдэж байна. Хэрвээ бид хоёулаа оргож чадвал миний эрдэнэсийн сангийн тал нь таных болно, хэрвээ би эндээ үхэж, та оргож амь гарч чадвал энэ хөрөнгө цөмөөрөө таных болно гэж хэлэв.
- Ингэхэд энэ эрдэнэсийн санг эзэмших биднээс илүү хууль ёсны эрхтэй эзэн байхгүй юм уу? гэж Дантес шийдвэргүйхэн асуув.
- Үгүй, үгүй санаа зоволтгүй. Гэр бүлийнхэн нь цөмөөрөө талийгаач болсон. Түүгээр ч барахгүй сүүлчийн гүн Спада намайг өөрийн өв залгамжлагчаар томилсон юм. Тэр надад энэ гайхамшигт мөргөлийн номыг гэрээслэн үлдээхдээ энүүн дотор байгаа бүх зүйлийг хамт өгсөн юм. Хэрвээ энэ баялаг бидэнд олдвол бид үүнийг сэтгэл зоволтгүй эдэлж ашиглаж болно.
- Тэгэхээр та энэ эрдэнэсийн санг мөнгөөр бодвол...
- Хоёр сая ромын скудо буюу манай мөнгөөр бол арван гурван сая орчим юм.

- Үгүй байлгүй! гэж их мөнгөний тоо сонсон айсан Дантес хэлэв.

- Яагаад тийм байхгүй байх гэж? Спадагийн удам угсаа бол арван тавдугаар зуундаа л хамгийн эрт дээр үеийн хүчирхэг нь байсан юм. Түүнээс гадна тэр үед мөнгөний том наймаа, аж үйлдвэр байгаагүй учир ингэж их алт мөнгө үнэт эрдэнэс хураах явдал ховор биш байсан юм. Одоо ч гэсэн Ромд, саяар тоологдох очир алмас ба үнэт эрдэнэсийн чулуу эзэмийж байгаа хэр нь хамгийн ахмаддаа үе залгамжлан өвлүүлэх ёсыг эвдэж чадахгүйн учир өлсөж үхдэг гэр бүл олон бий гэв.

Эдмонд зүүдэлж байгаа юм ёиг санагдаж, итгэх итгэхгүй хоёрын хооронд гуйвж байв.

Фариа цааш нь үргэлжлүүлэн,

- Би энэ нууцыг танд хэлэхгүй удаан хадгалсан юм. Учир нь нэгдүгээрт, таныг шалгаж үзэх гэсэн юм, хоёрдугаарт танд гэнэт хэлж гайхуулах гэсэн юм. Хэрвээ бид хоёр намайг ухаан алдаж ойчихоос өмнө оргож чадсан бол би таныг Монте Кристо арал дээр аваачих байсан. Харин одоо гээд тэр санаа алдаж - Та намайг аваачих болж. Дантес та яагаад надад баяр хүргэхгүй байна вэ? гэж асуув.

- Найз нөхөр минь, энэ баялаг бол таных. Таны ганцаарангийн чинь юм, үүнээс авах ямар ч эрх надад байхгүй, би таны төрөл садангийн хүн биш шүү дээ гэж Дантес хэлэв.

- Та чинь миний хүү шүү дээ Дантес? Гэж өвгөн дуу алдаад - Эрх чөлөөгүй хоригдол миний хүү! Би хувраг хүн учир гэр бүлгүй явах тавилантай хүн юм. Эцэг болж чадаагүй хүн, эрх чөлөөгүй хоригдол миний сэтгэлийг зогоох гэж бурхан таныг миний хүү болгож явуулсан юм гэв.

Тэгээд Фариа Эдмонд эрүүл гараа өгөхөд, цаадах нь нулимсаа асгаруулан өвгөнийг тэврэн авав.

19. Гурав дахь удаагаа ухаан алдсан нь

Удаан хугацаанд боддог ганц зүйл нь болж байсан эрдэнэсийн сан нь одоо төрсөн хүү шигээ хайрлаж байгаа зүрхний нь дотно хүнийг баярлуулах болсонд улам ч баярлан хөөрсөн Фариа өдөр бүр энэ хэмжээ хязгааргүй их баялгийнхаа тухай ярьж, орчин үеийн ертөнцөд арван гурав дөрвөн саяын хөрөнгөтэй хүн өөрийн нөхдөдөө хичнээн их тус хүргэж болохыг ярьж гарна. Тэгэхэд Дантес»н царай барайна. Эдмон өөртөө тавьсан тангаргийг санаж, орчин үеийн ертөнцөд арван гурав буюу арван дөрвөн саяын хөрөнгөтэй хүн өөрийн дайсанд ямар шуухан хор хүргэж чадахыг бодож байв.

Ширээт лам Менте Кристо арлыг мэдэхгүй бөгөөд харин Дантес түүнийг мэднэ, Корсик, Эльба арлын хооронд Пианозаас хорин таван бээрийн зайд орших энэ арлын дэргэдүүр олон удаа өнгөрөн явсан бөгөөд нэг удаа буудаллаж ч байжээ. Монте Кристо арал дээр хэзээний хүн амьтан суудаггүй бөгөөд одоо ч гэсэн хүнгүй, хоосон хэвээр ажээ. Энэ цохио хад нь галт уулын дэлбэрэлтээс болж тэнгисийн ёроолоос гарч ирсэн бололтой. Дантес ширээт ламд арлын байдлыг хэлэхэд Фариа түүнд өнөөх эрдэнэсийн санг ямар аргаар олохыг зөвлөж өгнө.

Гэвч Дантес тэр бодолд өвгөн шиг тэгж их автагдчихаагүй байв. Гол нь өвгөний адил тэгтлээ итгэсэнгүй. Одоо бол Эдмон ширээт ламыг солиотой хүн огт биш гэж лавтай мэдсэн ба өвгөн өөрийгөө галзуу хүн гэж алдаршуулахад хүргэсэн авхаалжийнхаа ачаар нээлт хийсэнд нь Дантес улам бахархана. Тэгэхийн хамт Дантес энэ эрдэнэсийн сан байсан, байсан байлаа ч гэсэн одоо байгаа гэдэгт л итгэхгүй байлаа. Эдмон түүнийг санаагаараа зохиосон юм гэж үзэхгүй боловч аль хэдийн алга болчихсон юм гэж үзэж байжээ.

Түүний зэрэгцээгээр хувь заяа хоёр хориодлыг сүүлчийн нь горьдлогоос хагацааж, тэднийг үүрд шоронд хоригдох тавилантай см гэдгийг нь ойлгуулах гэсэн юм шиг шинэ азгүй яўдал тохиолдоно. Нурж унах гээд байсан гадна талын гудамлагийг өөрчлөн засварлав. Суурийг нь засаж, Дантесын хагасыг нь тагласан нүхийг том чулуугаар бөглөжээ. Хэрвээ ширээт лам хэлж, Дантес нүхийг бөглөөгүй байсан бол маш их гарз тохиолдож тэдний оргохоор бэлтгэж байсан нь илэрч, тэр хоёрыг зайлшгүй салгах байлаа. Ийнхүү тэдний араас шинэ, улам бөх бат хаалга хаагдав.

- Харж байгаа биз гэж Дантес намуун уйтгартайгаар хэлээд - Би танд үнэнч шудрага байх явдал минь надад гавьяатай хэрэг гэж бурханд таалагдахгүй байна. Би тантай үүрд хамт байна гэж ам өгсөн, одоо өөрийн эрхгүй хэлсэн үгэндээ хүрэх боллоо. Эрдэнэсийн сан та бид хоёрын хэнд ч хүртэхгүй, та бид хоёр эндээс хэзээ ч гарахгүй. Харин ёстой эрдэнэсийн сан бол Монте Кристо арлын харанхуй хадан доор намайг хүлээж байгаа тэр эрдэнэсийн сан биш, энэ бол та миний дэргэд байгаа явдал, энэ бол бид хоёр өдөрт тав зургаан цаг хамт байж, миний ухаанд хийж өгч байгаа таны эрдэм мэдлэгийн хурц илч таны надад зааж өгч байгаа харь орны хэл яриа энэ бол миний тархи толгойд шингээж өгсөн таны гүн мэдлэг ба тодорхой зарчимт шинжлэх ухаан юм. Миний эрдэнэсийн сан энэ дээ, хайрт нөхөр минь, таны надад өгсөн баялаг, жаргал бол энэ юм. Энэ бол торхтой алт, авдартай очир алмасаас илүүгээр надад ашиг болох юм гэдэгт та надад итгэж тайвшраарай. Алт эрдэнэ нь тэнгисийн мандал дээгүүр хөөрч, хатуу газар ёүргэх үүл мэт тийм тунгалаг биш ч ойртох тутам уур болон алга болдог юм. Таны дэргэд аль болохуйц удаан байж, таны сэтгэл санааны гүнд нэвтрэх дууг сонсон, ухаанаа зузаатган, сэтгэлээ хатуужуулах ямар нэгэн их аймшигт хэргийг хийхийн тулд өөрийгөө бэлтгэх (хэрвээ надад суллагдан эрх чөлөөтэй болох завшаан тохиолдвол, тантай танилцахаас өмнө надад байсан тэр арга барагдан тачаадах ядвлаас үүрд ангижрах болно) энэ бүхэн бол миний баялаг юм. Энэ бол хий үзэгдэл шиг биш юм. Би ийм жинхэнэ

мэдлэгтэй болсондоо таны ачийг хариулах ёстой бөгөөд ертөнцийн бүх л баян эзэд, Цезарь Борджиа нь ч бай надаас энэ баялгийг минь булаан авч чадахгүй.

Ийм шиг байдалтайгаар золгүй хоёр хоригдолд цаг хугацаа жаргалтай сайхан гэж хэлмээргүй ч наад зах нь овоо түргэн өнгөрч байлаа. Ийм удаан хугацаагаар өөрийн эрдэнэсийн сангийн тухай дуу гарахгүй байсан Фариа одоо энэ тухай зогсоо зайгүй ярих болов. Түүний мэдэж байсанчлан баруун гар, хөл хоёр нь саа өвчинд дайрагдсан учир өөрөө эрдэнэсийн сангаа ашиглах найдвар бараг байсангүй. Гэвч өөрийн залуу нөхрийг шоронгоос тавигдах ч юм уу эсвэл оргож чадна хэмээн бодож баярлан мөрөөддөг байв. Өвгөн нөгөө бичгийг ямар нэгэн байдлаар алга болгочих бий гэж болгоомжлоод, Дантест цээжилж авахыг шаардав. Дантес түүнийг эхнээс нь аваад адагт нь хүртэл үг дараалан цээжилжээ. Тэгэхээр нь тэр, хоёрдугаар хэсгий нь устгаж, нэгдүгээр хэсгий нь хүн оллоо ч утга учры нь ойлгохгүй болгов. Фариа заримдаа Дантест хэрвээ суллагдвал түүнд ашиг болох зөвлөгөө сургамжуудыг бүтэн цагаар өгдөг байв. Дантес эрх чөлөөтэй болсон анхныхаа өдрөөс, анхныхаа цагаас эхлэн юу ч болдог байсан Монте Кристо арал хүрч, хүний сэжиг төрүүлэлгүй ямар нэгэн шалтгаанаар тэндээ үлдэж заасан газарт өнөөх шидэт агуйг эрж олох ёстой байв. Заасан газар нь бидний мэдэж байгаа өнөөх хоёрдугаар нүхний хамгийн цаад талын булан юм.

Тэр завсар цаг хугацаа мэдэгдэлгүй өнгөрч байсан боловч гойдын явдал гарсангүй. Фариа бидний дээр мэдсэнчлэн саа өвчинд дайрагдсан боловч ухаан нь хуучин янзаараа сэргэж залуу нөхрөө түрүүчийн ярьсан шинжлэх ухаанаас гадна, юу ч үгүй хоосноос юм хийж сурдаг шоронгийн тэвчээртэй өндөр урлагт сургаж. Тэд үргэлжид ямар нэгэн юмаар оролдоно. Фариа хөгширч байгаагаасаа айж, Дантес шөнийн харанхуйд гялалзах алсын оч шиг сэтгэлий нь гүнд шингэж бүүр түүр санагдах өнгөрсөн үеэ дурсан санахгүйн тулд тэгж үргэлж юмаар оролдоно. Тэр хоёрын амьдрал нь зол жаргалгүй явдлын өмнө тэсвэрлэн зогсож чаддаг хүмүүсийн бурхны зарлигаар тайван жигд явагддаг амьдралтай адил байлаа.

Гэвч энэ гадаад тайван байдлын нь цаана залуу хүүгийн зүрхэнд, магадгүй өвгөний зүрхэнд ч дэгдэлсэн сэтгэлийн хүч дарагдан байлаа. Магадгүй Фариа ганцаараа үлдэхэд Эдмон өрөөндөө эргэж ирээд санаа алдан гиншдэг байж ч мэднэ.

Нэгэн хүн түүнийг дуудах шиг болоход нь Эдмон шөнө гэнэт сэрэв. Тэр шөнийн харанхуйг нэвт харах гэж хүчлэн ширтэв.

Өөрийн нэрийг буюу үнэндээ нэрий нь дуудах гэж оролдож байгаа гомдоллосон дууг сонсов.

Дантес орон дээрээ өндийгөөд, айж бие нь хүйт оргин чих тавин чагнав. Ширээт ламын өрөөнөөс тэр дуу гарч байгаа нь эргэлзэх юмгүй болов.

- Бурхан минь! гэж Дантес шивнээд - Арай ч үгүй баймаар юм аа...? гэж хэлэв.

Тэгээд Дантес ороо зайлуулж, чулуугаа аваад ухсан нүх руу орж, нөгөө үзүүрий нь хүртэл мөлхөж очиход, тэр талын тагийг авчихсан байв.

Бидний мэдэх өнөөх хиймэл дэнгийн бүдэг гэрэлд Дантес, өвгөнийг олж харав. Өвгөн орноосоо бариад, хөл дээрээ арай ядан зогсож, царай нь үхээрийн юм шиг цонхийсон байв. Түүний царай нь Эдмоны мэддэг болсон бөгөөд анх харахад нь ихэд айлгасан тийм муухай дүртэй болчихсон байв.

- Найз минь, та ойлгож байгаа биз дээ. Би танд тайлбарлан хэлэх хэрэггүй байх гэж Фариа товчхон хэлэв.

Эдмон гиншин дуу алдаад, хаалга руу ухасхийн,

- Туслаач! Туслаач! гэж ухаангүй хашхирав.

Гэвч Фариа түүний гараас барьж зогсоох хүч хүрчээ.

- Дуугүй бай! Та өнгөрөөгүй байна шүү дээ. Найз минь, зөвхөн таны тухай, таны хоригдон байх хугацааг зохистой өнгөрүүлэх, таны оргох явдлыг бололцоотой болгох тухай бодъё. Энд миний хийсэн бүх юмыг дахин шинээр хийх гэвэл олон жил шаардагдах бөгөөд хэрвээ хуягууд Үйд хоёрын бие бие дээрээ ирж очиж байгааг мэдчихвэл энэ бүх зүйлийг тэр дор нь устгачихна даа. Гэвч найз минь бүү тэвдэж сандар, миний орхих гэж байгаа өрөө удаан хоосон байхгүй. Бас өөр нэг азгүй хоригдол миний оронд ирнэ. Тэгэхэд энэ хүн дээр та аврагч бурхан болж ирээрэй. Тэр хүн тань шиг залуу, хүч чадалтай, тэвчээр хатуужилтай хүн байж мэднэ, тэгэхээр над шиг саад танд болохгүй харин тусалж ч байж магадгүй. Таны бүх хөдөлгөөнд саад хийгч саа өвчинд баригдсан хагас хүүртэй зууралдаж байхгүй болно. Эцсийн эцэст бурхан таныг дурсан санасан бололтой. Бурхан танаас салган авч байгаа юмнаасаа илүү ихийг танд өгч байна, би ч үхэх цаг аль хэдийн болжээ гэж хэлэв.

Эдмон юу ч хийхээ болиод,

- Найз минь дуугүй байгаач гуйя таныг! гэж дуу алдав.

Дараа нь тэр гэнэтийн явдлаас сэхээ орж, сэтгэлээ чангалаад,

- Би таныг нэг удаа аварсан, хоёр дахь удаагаа бас аварна! гэж дуу алдав.

Орных нь хөлийг өргөж, түүн дотроос шилэн сав гаргаж ирэхэд гуравны нэгд нь улаан ханд байв.

- Хараач, аврагч уусмал байна! юу хийх ёстойг минь надад бушуухан хэлээд өгөөрэй! Заагаад өгөөч! Яриарай, би сонсож байна шүү дээ гэж хэлэхэд Фариа,

- Горьдлого байхгүй гэж толгойгоо сэгсрээд - Гэлээ гэхэд бурхан өөрийн бий болгосон амьдралд дурлах тийм их хүчтэй дурлалыг зүрхэнд нь хийж өгсөн тэр тээртэй боловч үнэтэй хүнээ аврах гэж чадах бүх юмаа хийх эсэх нь түүний хэрэг билээ гэв.

- Тийм ээ тийм гэж Дантес дуу алдаад - Би таныг аварна! гэж хэлэв.

- За тийм болог! Би хөрч эхэллээ. Толгойд минь цус хуралдаж байгаа нь надад мэдэгдэж байна. Эрүү дагжиж яс янгинаж байгаа чичрэлт бүх биеийг минь хамарлаа. Би таван минутын дараа ухаан алдаж, нэгэн мөчийн дараа хүүр болох болно.

- Бурхан минь! гэж сэтгэл нь тарчилсан Дантес дуу алдан хашхирав.

- Түрүүчийнх шигээ хийгээрэй, харин тийм удаан битгий хүлээгээрэй. Миний амьдралын бүх хүч барагдаж байна гэснээ саа өвчинд дайрагдсан гар хөлөө зааж - Үхэлд зөвхөн ажлын хагас нь үлдээд байна. Энэ шингэнээс арав дусаахын оронд арван хоёр дусаагаарай, тэгээд намайг ухаан орохгүй бол үлдсэний нь бүгдийг нь хийчхээрэй. Харин одоо намайг хэвтэхэд тусал, би зогсож байж чадахгүй нь гэв.

Эдмон өвгөнийг гараас нь түшиж орон дээр нь хэвтүүлэв.

- Найз минь, та бол миний энэ баларч байгаа амьдралын баяр баясгалан юм. Тэнгэр хэдийгээр хожимдуу боловч энэ баяр баясгаланг надад илгээжээ. Надад ийм үнэлж баршгүй бэлэг явуулсанд би баярлаж байна, би танаас үүрд хагацан салахдаа, хүртвэл зохих тэр сайн сайхан жаргалдаа хүрэхийг хүсэн ерөөе. Хүү минь бурхан чамайг тэтгэж яваг! гэж Фариа хэлэв.

Дантес сөхрөн сууж өвгөний хөнжилд толгойгоо шигтгэв.

- Юуны өмнө энэ сүүлчийн минутад миний хэлж захих үгийг сайн сонсож бай. Их хамба СҮадагийн эрдэнэсийн сан үнэн хэрэг дээрээ байгаа юм. Бурхны авралаар, миний хувьд орон зай, саад тотгор гэж байхгүй болжээ. Би түүнийг хоёр дахь агуйн ёроолд байгааг эндээс харж байна. Миний нүд газрын гүнийг нэвтэлж гялалзан гялтганаж байгаа баялгийг харж байна. Хэрвээ та эндээс оргож чадвал хүн бүхний галзуу хэмээн үзэж байсан хөөрхий лам огтын солиотой байгаагүй юм гэдгийг санаж яваарай. Монте Кристо арал дээр яаран очиж, манай баялгийг эзэмшин авч түүгээрээ жаргаарай, та хангалттай их зовж зүдэрсэн хүн.

Чичрэн дагжиж, өвгөний яриа таслагдав. Дантес өндийж, ширээт ламын нүд цусаар дүүрсэн байхыг харав. Цус цээжнээс нь түрэн толгой өөд нь цутган орж байна уу гэлтэй санагдана.

- Сайн сууж байгаарай гэж өвгөн шивнээд Эдмоны гараас шүүрэн авч, Хагацъя даа! гэлээ. Тэгэхэд цаадах нь,

- Үгүй үгүй, бурхан минь биднийг харж үзээч, үүнийг минь авраач! Туслаач! Туслаач! гэж дуу тавив.

- Аяархан, аяархан! Дуугүй бай, хэрвээ та намайг аварвал биднийг салгаж хагацаана шүү! Гэж үхэж байгаа хүн дуугарав.

- Таны хэлдэг зөв! Бүү сэтгэл зов, би таныг аварна! Та маш их зүдэрч байгаа байх шиг боловч, түрүүчийнхээсээ арай гайгүй юм шиг санагдаж байна.

- Та эндүүрч байна. Надад зовж зүдрэх хүч бага үлдсэн болохоор тэгж бага зовж зүдэрч байгаа юм. Таны насан дээр хүн амьдралд итгэж найдаж явдаг юм. Энэ бол залуу насанд байдаг зүйл. Харин өвгөн насан дээр үхлийг илүү тодхоноор үздэг юм. За тэр! Энэ ирж явна! ... Одоо өнгөрлөө! ... Нүд минь харанхуйлж байна!... Ухаан санаа мий балартаж байна!... Дантес та гараа өгөөч ... сайн сууж байгаарай! Баяртай! ... гээд байдаг хүчээ шавхан сүүлчийн удаа өндийв.

- Монте Кристо! Санаж яваарай Монте Кристо шүү! гэж дуугараад орон дээрээ ойчлоо.

Энэ муужралт нь маш аймшигтай байлаа. Татганасан үе мөч, хавагнасан зовхи, цусан хөөс, мэдрэлгүй болсон бие, эд бүгд бол ухаант тэр хүнээс үлдсэн бүх л зүйл нь байв.

Дантес дэн авч орны толгойн тус газар хананаас цухуйсан чулуун дээр тавив. Түүний анивалзсан гэрэл нь эвгүй болсон царай, амьсгаагүй хөшсөн бие дээр хачин янзын туяа тусгана.

Дантес түүнийг хөдлөлгүй ширтэн харж аврагч эмээ хэрэглэх цаг болохыг хүлээн сууна.

Цаг нь болмогц Дантес хутга авч, шүдийг нь заахад урьдынхаас амархан хөдөлжээ. Тэгээд арван хоёр дусаагаад хүлээж суув. Шилэн дотор нь дусаасан шиг нь хоёрын дайтай эм үлдсэн байлаа.

Тэр арван минут, нэг мөч, хагас цаг хүлээв. Фариа хөдөлсөнгүй. Дантесын бүх бие нь чичирч, үс нь босох шиг санагдаж, дух нь хөлрөн, зүрхнийхээ цохилтоор эгшин бүрийг тоолж байв.

Тэгэхэд Дантес сүүлчийнхээ аргыг хэрэглэх болж гэж шийдээд өнөөх үлдсэн шингэнгээ ширээт ламын ангайсан ам руу цөмийг нь цутгачихлаа.

Эм хачин жигтэйхэн нөлөө үзүүлж, өвгөний бүх үе мөч татганаж, нүд нь аймшигтайгаар нээгдээд хашхирах мэт санаа алдаад дараа нь бие нь чичрэх нь бага багаар нагдсаар дахин хөдөлгөөнгүй болов.

Зөвхөн нүд нь хараатай хэвээр хоцров.

Хагас цаг, цаг, бүтэн хагас цаг өнгөрөв.

Энэ зовууртай бүтэн хагас цагийн туршид Эдмон найзынхаа дээрээс тонгойж зүрхэн дээр нь гараа тавьж, ширээт ламын бие улам улам хөрч, зүрхний нь цохилт улам бүдгэрсээр байгааг мэдэрч байв.

Эцсийн эцэст бүх зүйл төгсөв. Зүрх нь сүүлчийн удаа чичирснээ царай нь хөхрөв. Нүд нь хараатай хэвээрээ боловч харц нь гөлөрч бүрхэгдэв.

Өглөөний зургаан цаг болж үүр цайж, нарны цайвар туяа шоронгийн цонхоор шурган орж дэнгийн бүдэг гэрэлтэй тэмцэлдэнэ. Нарны туяа үхдэлийн нүүрэн дээр тусахад зарим үе амьд юм шиг харагдана. Гэрэл харанхуй хоёр ингэж тэмцэлдэн байх хооронд Дантес бас л эргэлзсээр байсан боловч харин гэрэл нь бүрэн дийлэхэд өмнө нь хүүр хэвтэж байгааг ойлгов.

Тэгэхэд л түүнд туулж давшгүй айх сэтгэл төрөв. Орон дээрээс унжсан гарыг нь барьж, хөдөлгөөнгүй гөлрөн байгаа цэнхэр нүдийг харж зүрхлэхгүй байв. Дантес түүний зовхийг буулгах гэсэн боловч дэмий боллоо. Дэнгээ унтрааж, сайтар нуугаад, нүхээ аль болохуйц сайн таглаж орхиод зайлж явав.

Удахгүй хуяг ирэх байсан учир алгуурлаж болохгүй байлаа.

Энэ удаа хуяг эргэлтийг Дантесаас эхэлж дараа нь тэндээсээ ширээт ламд өглөөний хоол ба орны даавуу аваачиж өгөх байжээ.

Болсон явдлын тухай юу ч мэдээгүй нь илэрхий агаад хуяг гараад явчлав.

Тэгэхэд Дантес хөөрхий найзынх нь өрөөнд юу болох бол гэдгийг мэдэх хүсэл нь оргиллоо. Өнөөх үхэн дотуураа орж, тусламж гуйн хашхирч байгаа цуягийн дууг сонсов.

Удалгүй хуугууд ирж, тэдний дараа цэргүүдийн жагсаагүй ч гэсэн алхаж заншсан хүнд, жигд алхаа сонстов. Цэргүүдийн араас комендант орж ирэв.

Хүүрийг нааш цааш нь эргүүлж, ор шажигнах нь Эдмонд дуулдав. Комендант үхсэн хүний нүүр өөд ус турги гэж тушаагаад сэргэхгүй болохоор нь эмч авчруулахаар явуулав.

Комендант гарч, элэглэн шоолж инээлдэхтэй нийлсэн харамсах үг Эдмонд сонстов.

- За ингээд нэг галзуу өөрийнхөө эрдэнэсийн санд очихоор явлаа, сайн явж хүрээрэй дээ! гэж нэг хүн хэлэв.

- Тийм олон саяын хөрөнгөтэй мөртлөө хүүрээ ороох цагаан өмсгөл худалдаж авах юмгүй байх шив дээ гэж нөгөөх нь хэлэхэд гурав дахь нь,

- Иф цайзад цагаан өмсгөл хямдхан байдаг юм гэв.

- Хувраг хүн болохоор ямар нэг юмнаас илүү гаргаж өгөх магадгүй юм даа.

- Тэгвэл түүнд шуудай л болох юм биш үү дээ.

Эдмон нэг ч үг алдалгүй чагнасан боловч, энэ бүхнээс багахан юм ойлгов. Удалгүй дуу чимээ үгүй болж бүгдээрээ гараад явчих шиг санагдав.

Гэвч хуяг хүүрийг манаад сууж байж магадгүй гэж бодоод орж зүрхэлсэнгүй.

Ийм учраас байрандаа хоцорч, хөдлөлгүй амьсгаагаа даран чагнана...

Цагийн дараа дахин чимээ гарав.

Өвгөний өрөөнд комендант, эмч, хэдэн цэргийн дарга дагуулсаар орж ирэв.

Нэг минут хэртэй цөм дуугүй болов. Бодвол эмч ор уруу очиж хүүрийг үзэж бйгаа бололтой.

Дараа нь асууж эхлэв. Эмч хоригдлыг үзэж гүйцээд, амьсгал хураажээ гэж мэдэгдэв.

Асуулт хариултуудад Дантесын зэвүүг хүргэхээр майхрамжгүй хайнга байдал илэрнэ. Дантес тэднийг өөр шигээ өвгөнд өчүүхэн боловч зүрхнийхээ эмгэнэлийг илэрхийлэх ёстой юм шиг бодож байжээ.

Өвгөнийг үхэж гэж эмчийн хэлэхэд түүний хариуд комендант,

- Надад их гунигтай байна, номой, гэм хоргүй, өөрийнхөө галзуугаар бүхнийг хөгжөөсөн хоригдол байсан юм, хамгийн гол нь түүнийг харгалзаж байхад амархан хүн байсан юм гэж хэлэхэд хуяг өөдөөс нь,

- Ерөөсөө харгалзах хэрэггүй хүн байсан юм. Тавин жил энд суусан ч нэг ч удаа оргох гэж оролдохгүй байсан гэв.

- Хэдийгээр та энэ тухай итгэлтэй батлан хэлж байгаа боловч, үгэнд нь итгэхгүйдээ бус харин хожим хариуцлага хүлээхгүйн тулд хоригдлыг үнэхээр үхэж үү, үгүй юу гэж магадлах хэрэгтэй гэж комендант хэлэв.

Огт чимээ аниргүй болов. Дантес чагнангаа эмч үхсэн хүнийг дахин үзэж, биеийг нь барьж үзэж байгаа юм байна гэж бодлоо.

Эцэст нь эмч комендантад,

- Та санаа зовохгүй байж болно, энэ хүн бүр үхсэн байна. Би үүнийг хариуцна гэж хэлэхэд,

- Ийм явдал тохиолдоход бид зөвхөн үзлэгээр хангагдахгүй гэдгийг та мэднэ шүү дээ, ийм учраас хэдийгээр илэрхий шинж тэмдэг байж байгаа боловч хуулиар заасан ёсыг гүйцэтгүүлнэ үү гэж комендант татгалзан хэлэв. Тэгэхэд эмч,

- За яах вэ, тэгвэл төмөр улайсгаад ир гэж хэлээд - Энэ ч илүү болгоомжлол юм даа гэв.

Төмөр улайсгах тухай ярихад Дантесын бие чичрэв.

Хүмүүсийн яаруу алхах, хаалга чахрах сонстсоноо бас дахин хүний хөлийн чөмөө гарч, хэдэн минутын дараа хуяг,

- За төмөр, хөвөн хоёр аваад ирлээ гэв.

Дахиад л чимээ аниргүй болсноо дараа нь шарагдаж байгаа биеийн арьс шажигнан, эвгүй муухай үнэр Дантесын сууж байгаа ханын завсраар нэвтрэн орж ирэв. Хүний түлэгдсэн махны хиншүү ханхлахад Дантесын бүх биений хөлс чийхарч, одоо л ухаан алдчих гэж байгаа юм шиг санагджээ.

- Энэ хүн үхсэн байхыг та харж байгаа биз. Өсгийгий нь хайрах гэдэг бол хамгийн үнэмшүүлэх нотолгоо юм. Хөөрхий солиотой амьтан галзуугаа эмчлүүлж шоронгоос гарах нь энэ болж дээ гэж эмч хэлэхэд коменданттай явсан нэгэн офицер,

- Үүнийг чинь Фариа гэдэг билүү? Гэж асуув.

- Тийм ээ эртний удамтай хүн гэж өөрөө ярьдаг байсан юм. Энэ бол их эрдэмтэй, эрдэнэсийн сангийн тухайгаас л бусад юм бүхэнд зэгсэн ухаантай хүн байсан юм. Харин эрдэнэсийн сангийн тухайд болохоороо л тэсвэрлэшгүй хүн дээ.

- Энэ өвчнийг бид нэгэн зүйлийн тухай бодох солиорох өвчин гэж нэрлэдэг юм гэж эмч хэлэхэд, комендант ширээт ламд хоол зөөж байсан хуягаас,

- Та энүүнд гомдох хэрэг хэзээ ч тохиолдож байгаагүй юу? гэж асуув.

- Хэзээ ч үгүй, эрхэм комендант гэж хуяг хариулаад - Ер хэзээ ч үгүй шүү, анхандаа надад янз бүрийн түүх намтар ярьж өгч, хожим нь бүр миний эхнэрийг өвдөхөд эм бичиж өгч түүнийг эдгээсэн юм гэж хуяг хариулав.

- Тийм бий! Би өөрийнхөө зиндааны хүн юм гэж мэдсэнгүй. Эрхэм комендант та үүнийг бодож үзэж аятайхан х рьцаарай гэж эмч инээн хэлэхэд,

- Тэгнэ ээ, тэгнэ, та бүү зов, үүнийг олдох л хамгийн шинэ шуудайнд хийж оёно. Таны сэтгэл үүгээр хангагдах уу?

- Таныг байхад дэргэд чинь үүнийг хийхээр тушааж байна уу? гэж хуяг асуув.

- Мэдээжийн хэрэг. Харин түргэлж үзээрэй, би энэ шорон дотор чинь бүтэн өдөр ёрдойн зогсож чадахгүй.

Дахиад л хойш урагшаа явах хөлийн чимээ сонстож, удалгүй Дантест зотонгийн шаржигнах дуу гарч, ор чахран, хүнд юм өргөсөн хүний хөлийн чимээ дуулдаж, дараа нь ор дахин нажигнав.

- Орой болтол гэж комендант хэлэхэд,

- Хойтохы нь унших уу? гэж офицеруудын нэг нь асуув.

- Ийм бололцоо байхгүй гэж комендант хариулаад - Шоронгийн лам Гьер хот орохоор надаас долоо хоногийн чөлөө аваад өчигдөр явчихсан. Би энэ хугацаанд өөрийнхөө хоригдлуудыг хариуцаж хоцорсон юм. Хэрвээ энэ хөөрхий ширээт лам ингэж их яараагүй сан бол хойтохыг нь ёсоор нь гүйцэтгэх л байсан юм гэв.

- Айхавтар юм алга даа, зүгээр гэж эмч чөлөөтэй сэтгэдэг хүмүүст байдаг хайхрамжгүй зангаар хэлээд - Энэ бол санваартан хүн, бурхан багш түүнийг санваартан болохоор нь хүндэтгэж, лам хүнээ тамд өгч наргиулахгүй байлгүй гэхэд, энэ ёжтой яриаг дагалдан хүмүүс инээлдэв.

Энэ үед хүүрийг шуудай дотор хийв.

- Орой болтол гэж комендант тэднийг дуусахаар давтан хэлэхэд,

- Хэдэн цагт вэ? гэж хуяг асуув.

- Арав, арван нэгэн цагийн үед

- Хүүрийн дэргэд манаач үлдээх үү?

- Яах юм бэ? Амьд хүн шиг л гаднаас нь түгжчих, тэгээд л болоо юм биш үү.

Тэгээд дараа нь хүмүүсийн алхаа холдож, дуу нь бүдгэрэн, хааж байгаа хаалганы огцом чахрах ба түгжээ нь тачигнах сонстов. Ганцаардахын чимээ аниргүй биш харин үхээрийн чимээ аниргүй байдал Эдмоны хөрсөн сэтгэлд хүртэл шингэжээ.

Дантес дөрвөлжин таглааг толгойгоороо өргөж, өрөөг ажиглан харав.

Хоосон байлаа. Дантес газар доогуурх нүхнээсээ гарч ирэв.

20. Иф цайзын хүүр оршуулах газар

Шоронгийн цонхоор орж ирсэн манантай өдрийн бүдэг гэрэлд орон дээр барзгар зотон шуудай харагдаж, түүний нугалаануудын доор хөдөлгөөнгүй урт бие байгаа нь муухан мэдэгдэж байв. Энэ бол өнөөх хуягуудын үгээр маш хямдхан цагаан нөмрөг гээч байжээ.

Ингэж бүх зүйл төгсгөл болжээ. Дантес өөрийн найзаас бие цогцсын талаар бүрэн хагацаж, үхлийн тэртээ талыг харах гэсэн юм шиг зовхи нь нээлттэй байгаа нүдийг нь харж чадахаа больж, ертөнцийн нууцыг халхалж байсан хөшгийг өөрийн нь өмнөөс авч хаясан тэрхүү эцэж цуцашгүй гарыг нь атгаж чадахгүй болжээ. Ихэд дотночлон нөхөрлөсөн туршлага дадлагатай, найз нөхөр Фариа нь зөвхөн түүний санаанд л үлджээ. Тэгэхэд аймшигт орны толгой талд сууж, тайтгаруулшгүй уй гашуудалд автагдав.

Ганцаараа боллоо! Дахиад л ганцаараа! Дахиад л чимээ аниргүйн дунд хүрээлэгдэн, үгүй хоосонтой нүүр тулгаран хоцорлоо!

Ганцаараа үлдлээ! Амьдралтай холбож өгсөн ганц хүнийхээ дууг дуулж, зүсийг нь харж чадахгүй болжээ! Зовлон зүдүүрийн хаалгыг даван туулах хэрэг тохиолдлоо ч гэсэн, Фариа шиг бурхнаас амьдралынхаа нарийн тайлбарыг асуувал дээр юм биш байгаа?

Найз нөхөр нь амьд дэргэд нь байхдаа, хөөж зайлуулсан өнөөх амиа хорлох тухай бодол Фариагийн цогцсын дэргэд, хий үзэгдэл мэт дахин босож ирэв.

- Хэрвээ би үхэж чадах байсан бол хойноос нь очиж түүнтэй уулзах байсан биз. Гэвч яаж үхэх вэ? Үгүй, энүүнээс амар юм байхгүй гэж мушийн хэлээд - Би эндээ байж байгаад хамгийн түрүүнд орж ирсэн хүн өөд довтлон багалзуурдаж алья, тэгээд намайг цаазлан хорооно гэж аман дотроо ярив.

Гэвч хүчтэй уйтгар гунигт бас далайн шуурганы үеэр хоёр давалгааны хооронд зай үлддэг шиг тийм зааг үлдэж хоцордог ажээ. Дантес шившигтэйгээр үхэхээс айж, арга нь барагдан цөхөрснөө больж амьдрал, эрх чөлөөг ханашгүй ихээр хүсэж мөрөөдөв.

- Үхэх ий? Үгүй шүү гэж тэр дуу алдаад - Одоо үхэхийн тул ингэж удаан амьдарч, зовж зүдрэх хэрэггүй байсан юм! Үхэх гэнэ ээ! би олон жилийн өмнө үхье гэж шийдэж

байхдаа үхчихэж болох байсан юм. Харин одоо бол золгүй хувь заяаныхаа гарт тоглоом болохыг хүсэхгүй байна. Үгүй, би амьдрахыг хүсэж байна, эцэстээ хүртэл тэмцэхийг хүсэж байна. Надаас булааж авсан аз жаргалыг буцааж авахыг хүсэж байна. Үхэхээсээ өмнө өөрийнхөө яргачдыг гэсгээн цээрлүүлэх ёстой. Хэдэн цөөн андаа шагнахыг хэн байг гэх вэ? Гэвч намайг шорон дотор мартчихсан, тэгэхээр би эндээс Фариа шиг л гарах байх даа гэв.

Тэр энэ үгийг хэлээд гэнэт ямар нэгэн бодол, гэхдээ аймшигтай бодол санаанд нь орж ирсэн хүн шиг өмнөө байгаа зүйлийг эгц гөлрөн ширтэж таг болов. Тэгснээ ухасхийн босож, толгой нь эргэсэн юм шиг гараараа духаа дараад, шорон дотуур хэд алхсанаа дахин орны дэргэд очиж зогсов.

- Энэ санааг хэн миний толгойд оруулж өгөв! Гэж тэр шивнээд, - Бурхан чи биш биз дээ? Хэрвээ эндээс үхсэн хүн л гардаг юм бол үхсэн хүний оронд оръё гэж шивнэв.

Тэгээд ухаан бодлоо, арга нь барагдсан энэ шийдвэрт саад болчих вий гэхдээ юм бодохгүйг хичээж, урагш бөхийж, аймшигт шуудайг ширээт ламын хутгаар ханзлан, өвгөний хүүрийг шуудай дотроос гаргаж өөрийнхөө өрөөнд оруулж, орон дээр хэвтүүлээд заншсан ёсоороо толгойд нь алчуур зангидаад, өөрийнхөө хөнжлөөр бүтээгээд, хүйтэн магнайг нь сүүлчийн удаа үнэсэж, урьдын аймшигт ухаангүй харцаар ширтэж байгаа нүднийх нь зовхийг буулгах гэж оролдоод, хуяг хоол авчирч өгөхдөө хоригдлыгоо унтаж байгаа юм байна гэж бодохоор хана руу нь харуулж орхив. Тэгээд газар доорх нүх уруугаа орж, ороо хана руугаа тулгаж татаад ширээт ламын өрөөнд орж, нууц дотроос нь утас зүү гарган авч, шуудай дотор нүцгэн бие байгаа юм шиг болгохын тулд хувцсаа тайлж орхиод, ханзалсан нүхээрээ шуудайд орж, дотор талаас нь оёж битүүлээд, хүүр бйгаа юм шиг сунаж хэвтэв.

Хэрвээ гай дайрч, энэ үед хүн орж ирсэн бол зүрхний цохилт нь Дантесыг илчлэх байлаа.

Оройн эргэлт өнгөрснөөс хойш энэ бүгдийг хийж болох байсан боловч комендант шийдвэрээ өөрчилж тогтоосон цагаасаа өмнө хүүрийг аваачиж хая гэж тушаах бий гэж айжээ. Тэгвэл түүний эцсийн найдвар алдагдах байжээ.

Юу ч л болсон шийдэх нь тэр.

Түүний төлөвлөгөө ийм байлаа.

Хэрвээ ясчингууд замдаа амьд хүн авч явна гэж мэдчихвэл Дантес эгшин зуур хутгаараа шуудайг хага яран тэдний сандарч, сэхээ аваагүй байхад нь зугтан алга болох ажээ. Хэрвээ түүнийг барьж авах гэвэл хутгаа хэрэглэнэ.

Хэрэв ясчингууд түүнийг хүүр оршуулах газар аваачиж, булшинд хийвэл, шороогоор дарахыг нь хүлээж байгаад, энэ явдал шөнө болох учраас тэднийг дөнгөж явмагц сэвсгэр шороог малтаж хаяад оргоно. Булсан шороо нь түүний өргөж даахааргүй хүнд байхгүй байх гэж горьдож байжээ. Хэрвээ ташаарч булсан шороо нь дэндүү хүнд байх юм бол тэндээ бүтэж үхнэ, тэгвэл бүх зүйл төгсгөл болж сайн л болно биз.

Дантес өчигдрөөс хойш юу ч идээгүй боловч, өглөө нь өлссөн шинжгүй байсан бөгөөд одоо энэ тухай бодохтой манатай байв. Өөр ямар ч юманд санаа тавьж болохгүйгээр тийм аюултай байдалтай байлаа.

Дантест заналхийлж болох анхны аюул бол оройн долоон цагт хуяг хоол авчирч өгөхдөө ингэж солигдчихсон байхыг мэдчихэж болох байв. Аз болоход Дантес ядарснаасаа ч юм уу эсвэл уйтгар гунигаасаа болж хоолны цагийг хөдлөлгүй хэвтэж өнгөрөөдөг байж. Ийм үед хуяг орж ирээд ширээн дээр шөл, талх тавьчихаад дуугүй гараад явчихдаг байсан ажээ.

Харин энэ удаад хуяг заншлаа өөрчилж, Дантестай ярих гээд, дуугарахгүй болохоор нь ор уруу нь очиж, мэхэлснийг нь илрүүлчихэж мэдэх юм.

Долоон цаг ойртох тусам Дантес улам их айж байв. Зүрхэн дээрээ нэг гараа тавиад цохилтыг нь намдаах гэж оролдон нөгөө гараараа нүүр уруу нь урсан гоожих хөлсөө арчина. Заримдаа бие нь чичрэн, хүйтэн бахиар хавчиж байгаа юм шиг зүрх нь базална. Өөрөө үхэж байгаа юм шиг санагдана. Гэвч шорон дотор чимээ аниргүй бөгөөд нэлээд удсан учир Дантес нэгдүгээр аюул өнгөрсөн болохыг мэдэв. Энэ бол сай ёр байлаа. Комендантын төлөвлөсөн цаг болж шатан дээр хүний хөлийн чимээ гарахад Дантес удаан хүсэн хүлээсэн цаг боллоо гэдгийг ойлгов. Байгаа бүх зүрх зоригоо чангалан, амьсгаагаа дарав. Амьсгаагаа дарсан шигээр түг түг цохилон буй зүрхнийнхээ цохилтыг дарж болохгүйдээ харамсаж байв.

Хөлийн чимээ үүдэнд ирж зогсов. Дантест хоёр хос хөлийн чимээ сонстож, хоёр ясчин түүнийг аваачаар иржээ гэдгийг мэдэв. Шалан дээр дамнуурга авчирч тавихад, хоёр хүн иржээ гэдэг нь лавтай болов.

Хаалга онгойж, түүнийг бүрхсэн зотонгийн завсраар, ор уруу ирж яваа хоёр хүний сүүдэр харагдав. Гурав дахь нь бамбар барьж хаалганы дэргэд зогсов. Ясчингууд шуудайн хоёр үзүүрээс барив.

Нэг нь Дантесын толгой талаас өргөж,

- Ийм туранхай өвгөн байж яасан хүнд юм бэ гэж хэлэв.
- Жи« бүр хүний яс хагас фунтээр нэмсгддэг юм гэж ярьцгаадаг гэж нөгөөдөх нь хөлөөс нь барингаа хэлэв.
- Дүүжин бэлтгэсэн үү? Гэж нэг нь асуув.

- Илүү юм өргөж явахын хэргэ юу байх вэ гэж нөгөөх нь хариулаад - Тэнд очоод хийчихье гэв.

- Нээрээ тийм, за явъя.

«Дүүжин гэдэг нь юу юм бол» гэж Дантес бодов. Хуурамч хүүрийг орноос өргөж, дамнуурга уруу аваачлаа. Эдмон биеэ хөшсөн юм шиг болгох гэж булчин шөрмөсөө чангалав. Түүнийг дамнуурган дээр тавиад манаач гэрэл барьж шатаар өгсөв.

Гэнэт шөнийн цэвэр сэрүүн агаар сэнгэнэхэд, баруун хойд зүгийн салхи үлээж байхыг Дантес мэдэв. Гэнэт ингэж мэдэрсэн нь сэтгэлд таалагдахын цацуу бас зовиуртай түгшүүр төрнө.

Авч явсан хүмүүс хориод алхаад зогсож дамнуургаа газар тавив.

Тэдний нэг нь хажуу тийшээ явахад түүний гутлын ул дөрвөлжин чулуун дээр тог тог хийх сонстоно.

«Би хаана байна вэ?» гэж тэрээр бодов.

Дантесын дэргэд үлдсэн нэг ясчин дамнуургын ирмэг дээр суугаад,

- Ингэхэд энэ чинь нэг л хүнд оргиод байна шүү гэв.

Дантес юуны өмнө шуудайнаас сулран гарах юмсан гэж бодсоноо аз болж биеэ бариад байв.

- Алив нааш нь гэрэлтүүлээч, чалчаа минь гэж хажуу тийшээ явсан ясчин хэлээд - Тэгэхгүй бол эрсэн юмаа олохгүй нь гэв.

Тушаалаа нилээд бүдүүлэг ширүүн хэлсэн боловч нөгөөх нь үгэнд нь оров.

«Энэ юу эрээд байгаа юм бол? Ирмэгтэй хонхор газар л эрээд байгаа юм байх даа» гэж Дантес бодлоо.

Ясчин эрсэн юмаа олж баяртайгаар дуугарав.

- Арай гэж нэг юм болов уу даа? гэж нөгөөдөх нь хэлэхэд,

- Яах вэ дээ, энүүнд яараад байх юу байх вэ гэж түрүүчийн хүн хариулав.

Тэр ингэж хэлээд Эдмон уруу ирж, дэргэд нь нэгэн хүнд, цул юм авчирч тавив. Тэгээд тэр дороо хөлий нь олсоор өвдтөл уяв.

- За яав, уяв уу? гэж хоёр дахь ясчин асуухад,
- Хамгийн сайнаар уячихлаа. Ямарч алдаа мадаг байхгүй гэж нөгөөх нь хариулав.
- За тэгвэл алхаад!

Тэгээд тэд дамнуургаа өргөж цааш хөдлөв. Тэр хоёр тавиад алхам газар яваад, нэг хаалга онгойлгож гараад цааш явав. Өргөж яваа хүмүүсийн урагшлах тутам цайз байгаа хад уруу мөргөх долгионы шуугиан Дантесын чихэнд улам улам тодхон болно.

- Аа бас, тэнгэр мөн муухай байна аа! Ийм шөнө тэнгис ч базаахгүй дээ! гэж өргөж явсан хүний нэг хэлэв.

- Тийм ээ! Ширээт лам маань норчих бий дээ гэж нөгөөдөх нь хэлэв.

Тэгээд хоёул чанга инээлдэхэд Дантес шог ярианы учрыг ойлгоогүй боловч үс нь босох шиг болов.

- За хүрээд ирлээ гэж нэг нь нөгөөдөх нь татгалзаж,
- Цаашаа явъя, цаашаа явъя, түрүүчийн удаа зохих газраа хүрээгүй, хад мөргөж унасан шүү дээ. Тэгээд маргааш нь комендант чи бид хоёрыг залхуунууд гэж хэлснийг мартчихав уу? гэж хэлэв.

Тэд улам дээшээ өгсөн тав зургаан алхам явав. Дараа нь түүний толгой хөл хоёроос барьж савлаж байхыг Дантес мэдрэв.

- Нээг? гэж ясчин хэлэв.
- Хоёр!

- Грав аа! гэхэд Дантес хэмжээлшгүй хоосон уруу хаягдаж, шархадсан шувуу шиг доошоо унан зүрх нь хүйт оргин аймшгаар дүүрнэ. Хөлөөс нь уясан юм доош нь татаж улам хурдан унах боловч их л удах шиг түүнд санагдав. Эцсийн эцэст хүйтэн усанд сум шиг түргэн шуугиан ороход дуугарах гэсэн боловч тэр дороо ус залгив.

Дантест тэнгист хаягдаж хөлд нь уясан гучин зургаан фунтын хүнд цул түүнийг далайн ёроол уруу татна.

Тэнгис бол Иф цайзын хүүр оршуулах газар нь байжээ.

21. Тибулен арал

Бараг бүтэж үхэх шахсан Дантес амьсгаагаа барьж байх хэрэгтэй юм гэж бодлоо. Тэгээд баруун гартаа хутгаа бэлхэн барьж байсан учир шуудайгаа дор нь хагас зүсэн эхлээд гараа, дараа нь толгойгоо гаргав. Хэдийгээр хөлнөөс нь зүүсэн юмыг дээш нь татах гэж оролдсон боловч түүнийг тэнгисийн ёроол уруу чангаасаар байв. Тэгэхээр нь бөхийж хөлий нь уясан олсыг тэмтэрч олоод бүтэж үхдэгийн даваан дээр сүүлчийнхээ хүчийг гарган тас огтлов. Тэгээд хөлөөрөө огцом түлхэж дээшээ гарч ирэхэд, түүний үхлийн нөмрөг болох шахсан борги бүдүүн зотонг хүнд цул далайн ёроол уруу авч алга болов.

Дантес хүнд харагдчих вий гэж айгаад ганцхан удаа амьсгал аваад дахин шумбав.

Хоёр дахь удаагаа дээш хөөрөн гарахад унасан газраасаа хамгийн багаар бодоход тавин алхам холдчихсон байв. Дээшээ харахад толгой дээр нь аймаар бараан тэнгэр харагдаж, үүлс нь хурдлан нүүж, үе үе од гялалзсан цэлмэг хөх тэнгэр харагдана. Өмнө нь пад харанхуй нэлэнхий уудам харагдаж, шуурга болохыг зөгнөн давалгаа бургилж, ар талд нь аварга том хий үзэгдэл мэт боржин чулуу сүглийж, түүний орой нь оргон зайлж байгаа олз уруугаа сарвайсан гар мэт санагдана. Хамгийн өндөр цохио хадан дээр сүүдэгнэж байгаа дэнлүүгийн гэрэлд хоёр сүүдэр харагдана.

Тэр хоёр сэтгэл түгшсэн байдалтай тэнгис уруу бөхийцгөөж байх шиг Дантест санагдав. Энэ нэг ёсны ясчингууд түүний унахдаа хашхирсныг сонссон бололтой. Иймээс Дантес дахин шумбаж, усан доогуур сэлэв. Тэр ингэж шумбахдаа үнэхээр дадлагатай бөгөөд Фаро буланд шумбан усчлахад нь олон хүн сонирхон цугларч Марселийн хамгийн сайн усчин гэж нэрлэх нь олонтоо тохиолдож байсан билээ.

Түүнийг уснаас дахин цухуйхад дэнлүүгийн гэрэл алга болсон байлаа. Дантес эргэн тойрон харав. Иф цайзыг тойрсон арлууд дотроос хамгийн ойрхны арлууд нь Ратонно, Помег хоёр юм. Гэвч Ратонно, Помег хоёр дээр хүн суудаг, бас бяцхан Дом арал дээр ч хүн суудаг ажээ. Тийм учраас Иф цайзнаас нэгэн бээрийн газар орших Тибулен, Летер хоёр арал л хамгийн найдвартай нь байжээ.

Тэр хоёр арал хэдийгээр бээрийн газар орших боловч Дантес тэр хоёрын аль нэгэн өөд хөвж очихоор шийджээ. Гэвч улам улам түнэртэж буй ийм харанхуйд лэр хоёрыг яаж олох билээ?

Энэ үед тэр Планье дээр од мэт гэрэлтэх гэрэлт цамхгийн туяаг харлаа.

Тэр гэрэлт цамхгийг яг чиглэн явбал Тибулен арал зүүхэнтээ нь хоцрох байлаа. Тэгэхээр бага зэрэг зүүнтэйгүүр чигтэй явбал энэ арал зам дээр нь дайралдах ажээ.

Иф цайзнаас энэ арал хүртэл наад зах нь бүтэн бээр газар байх ёстой гэдгийг бид түрүүнд хэлсэн. Фариа шоронд байхдаа Эдмоныг гунихарч гутран суухыг хараад: «Дантес

минь зүгээр суухаас болгоомжил, хэрвээ хүчээ байнга дасгалжуулж байхгүй бол та оргохдоо живж үхнэ шүү» гэж нэг биш удаа хэлдэг байжээ.

Одоо Дантес ус аймаар хүнд дарж байхыг мэдэрч, өвгөний зөвлөгөөг санав. Тэр яаран дээш гарч ирээд, хуучин хүч тамир нь хэвээрээ байна уу үгүй юу гэдгийг шалгахаар давалгааг сөрөн сэлж эхлэв. Юм хийхгүй зүгээр байж байснаас болж хүч чадал, авхаалж самбаа нь өчүүхэн ч саараагүй байгааг мэдээд учиргүй баярлаж бага наснаасаа эхлэн сурсан юм нь хэвээрээ байгааг мэдрэв.

Түүнээс гадна айна гэдэг араас нь буцаж няцашгүйгээр элдэж, Дантесын хүч чадлыг, хоёр дахин нэмэгдүүлнэ. Тэр долгионыг зүсэн явахдаа ямар нэг сэжигтэй чимээ анир гарах вий гэж чих тавин чагнана. Долгио түүнийг хөөргөж өргөх бүрд, гүн харанхуйг нэвт харахыг хичээн өндөр хөөрсөн долгионыг харахдаа өөрийн нь хөөж ирж яваа завь шиг санаж улам хурдлан сэлнэ. Энэ нь түүний замыг хороох боловч хүчий нь барна.

Гэвч улам улам урагшлан сэлсээр бөгөөд аймшигт цайз шөнийн харанхуйд бага багаар ард захран хоцорно. Дантес түүнийг ялган танихаа байсан боловч санаанд нь хэвээр байлаа.

Ингэж нэг бүтэн цаг өнгөрч, тэр завсар Дантес амьдарна, эрх чөлөөтэй болно гэдэг бодлоор жолоодуулан зоригжиж, зорьсон зүг уруугаа чиглэн давлагааг зүсэн хөвнө.

«Сэлж эхэлснээс хойш удахгүй цаг болно. Гэвч өөдөөс салхилж байгаа болохоор хурдынхаа дөрөвний нэгийг алдсан байх. Гэсэн ч замаасаа гажаагүй бол одоо Тибулен арлаас холгүй яваа байх ёстой. Харин төөрчихсөн бол яана!» гэж дотроо бодов.

Ингэж бодохоор усчны бие зарсхийх шиг боллоо. Араараа хэвтэх гэсэн боловч тэнгис улам ширүүн долгиулж хэвтэж амарна гэж бодож байсан нь бүтэхгүй болохыг удахгүй ойлгов.

- За яахав, гараа ядартал сэлээд байна даа, тэгээд татаж яах ч аргагүй болохоороо тэнгисийн ёроол уруу яваад өгнө дөө! гэж хэлэв.

Тэгээд өөр ямар ч аргагүй болж цааш хүчлэн сэлэв.

Тэгтэл угийн хар тэнгэр улам хар болж, өтгөн хүнд хар үүл бүрхэх шиг болов. Тэгтэл ч тэр даруй өвдөг нь хүчтэй өвдөв. Сум тусчихлаа гэж бодоод одоо бууны дуу нь сонстох байх гэж чагнаж байтал буун дуу гарсангүй. Дантес гараа сунгавал хатуу юм гарт нь баригдлаа. Тэгээд хөлөө жийн газарт хүрэв. Тэгэхэд л үүл гэж санаж байсан юм нь юу болохыг ойлголоо.

Түүнээс хорин алхмын зайтай газар, дүрэлзэн асаж байгаад гэнэт чулуу болчихсон гэлтэй аварга том түүдэг галын дөл мэт хачин гайхалтай цохио хад сүндэрлэж байлаа. Энэ бол Тибілен арал байв. Дантес босож, бу^охан тэнгэрт баярласнаа илэрхийлээд, ямар

ч зөөлөн сайхан ор дэвсгэрээс илүү мэт санагдсан боржин чулуун хадан дээр тэрийн хэвтэв.

Дараа нь салхи, шуурга тавьж, бороо орж байгааг хайхралгүйгээр, бие нь хөрч хөшиж байгаа боловч гэнэтийн жаргалд автагдсан хүн шиг сэтгэл тэнүүн нойрсов.

Нэг цагийн дараа чих дүлийрэн тэнгэрийн дуу гарч Эдмоныг сэрээв. Шуурга галзууран хийсэж, хурдан далавчаараа тэнгис далай, тэнгэр огторгуйд нүднэ. Галт могой лугаа адил цахилгаан цахилж, бөөгнөрөн бие биеэ хөөн гүйцэж байгаа тэнгисийн долгио, тэнгэрийн хар үүл хоёрыг гэрэлтүүлнэ.

Далайчин хүний туршлагатай нүд андуурсангүй. Дантес аль түрүүнд дайралдсан арал дээр гарсан нь Тибулен арал байлаа. Энэ бол ямар ч хоргодох газаргүй нүцгэн цохио хад гэдгийг Дантес мэдэж байв. Тэгээд шуурга намдахаар дахин тэнгист орж мөн л ийм зэрлэг зэлүүд боловч нэлээн уудам, хүн байж болмоор Лемер арал хүрэхээр төлөвлөн бодлоо.

Урагшаа бөхийсөн хад Дантест түр зуурын хоргодох газар болж, тэр түүн дор нуугдмагц тэр даруй шуурга чадлынхаа хэрээр галзууран шуурав.

Дор нь хоргодсон хад доргин донсолж байхыг Дантес мэдрэв. Том аварга хадыг мөргөн цацарсан усны дусал түүнд хүрч ирнэ. Тэр хэдийгээр аюулгүй газар байсан боловч аймшигт дуу Үа нүд сохлом гялалзах цахилгаанаас болж, зангууг нь авсан хөлөг онгоц шиг түүнийг аймшигт усны Сргүүлэгт аваачих гэж байгаа юм шиг санагджээ.

Тэр бүтэн хоног юм идээгүйгээ гэнэт санаж, өлсөн цангаж тарчлан байлаа. Дантес гараа сунгаж, хадны хонхор дээр тогтсон борооны ус уруу тонгойн байж уулаа.

Дантесыг толгойгоо өндийлгөсөн тэр минутад тэнгэрийг зүсэх адил хурц цахилгаан гялалзаж орчин тойрныг гийгүүлэв. Энэ цахилгааны гэрэлд Лемер арал, Круавиль хошууны хооронд, Дантесаас дөрөвний нэгэн бээрийн зайтай газарт, салхи долгионд туугдсан загасчны бяцхан онгоц хий үзэгдэл мэт гарч ирлээ. Энэ хий үзэгдэл аймшигтай хурднаар ойртон, өөр нэг давалгаан дээр гарч ирлээ. Дантес тэднийг үхэл уруугаа явж байна гэж хашхиран мэдэгдэж дохио өгөх гэсэн боловч тэртээ тэргүй цаадуул нь үүнийг мэдэж байжээ. Дахин цахилгаан цахихад Дантес дөрвөн хүн шураг модноосоо зууралдаж тав дахь нь эвдэрсэн жолооныхоо ард зогсож байхыг харав.

Салхи исгэрэх шуугиан дунд амь тавин бархирах сонстсоныг бодоход Дантесыг тэдгээр хүмүүс бас үзсэн бололтой. Хулс шиг тахийсан шураг дээр нь урагдаж хэдэн хэсэг болсон дарвуул навсагнана. Тэгтэл түүнийг тогтоож барьж байсан оосор бүч тасрахад салхи түүнийг хаман авч, хар үүлний наагуур нисэж яваа аварга том цагаан шувуу далбаганан алга болов.

Тэрхэн зуур чих дүлийрэм чимээ гарч, живж үхэж байгаа хүмүүсийн хашхиралдахыг Дантес сонсов. Өөрийнхөө сууж байга хаданд, ховдост наалдах адил наалдаж, харанхуйлан харагдах тэнгис уруу харж байтал дахин нэг удаа цахилгаан гя«алзаж эвдэрхий онгоц, түүний хэмхэрхий хэсгүүдийн хооронд тэвдэж сандран гараа тэнгэр өөд өргөсөн хүмүүсийн царай харагдав.

Дараа бүх зүйл шөнийн харанхуйд алга болж аймшигт үзэгдэл цахилгаан цахихаас ч удаан үргэлжилсэнгүй.

Дантес тэнгис уруу хальтран унаж магадгүйгээр гөлгөр хадан дээгүүр доошоо гулсав. Хичнээн хичээсэн авч, юу ч дуулдаж, юу ч харагдахгүй, хүмүүсийн дуу сонстохгүй, өөрсдөө үзэгдэхгүй байлаа. Зөвхөн шуурга үргэлжлэн ганирч тэнгис давалгаалан хөөсөрнө.

Салхи бага багаар намдаж, хүчит тэнгэрийн дуунаас зүс нь хувирсан юм шиг үүлсийг баруун зүг хөөнө. Тэгээд од нь улам ч хурц гялалзсан хөх тэнгэр дахин гарч ирэв. Удалгүй дорнод зүгээс хар хөх тэнгэрийн хаяанд өргөн улаан зураас тодорч эхлэв. Долгио хөөрөхдөө гэрэлтэж түүний хөөсөрсөн нуруу нь алтан дэл мэт харагдах ажээ. Өглөө боллоо.

Дантес энэ гайхамшигт үзэгдлийг анх үзэж байгаа юм шиг үг дуугүй, хөдлөх ч үгүй харж байв. Үнэндээ ч тэр Иф цайзад байсан хугацаанд нар яаж манддагийг мартаж орхижээ. Тэр цайз өөд эргээд газар тэнгис хоёрыг удаан гэгч харав.

Бүхнийг нуга дарагч засгийн хамгаалагч нүдэнд хүйтэн тэр муухай байшин нүдний нь өмнө ихэмсэг байдлаараа босож ирэв.

Өглөөний таван цаг болж тэнгис аажмаар намдав.

«Хоёр гурван цагийн дараа хуяг миний өрөөнд орж, хөөрхий андын минь хүүрийг олж аваад өрөөний хооронд ухсан цооног олж мэдээд намайг баахан дэмий эрж, түгшүүр зарлан, намайг усанд аваачиж хаясан бөгөөд хашхирахыг минь сонссон хүмүүсийг дуудаж асууна. Тэгээд тэр дороо зэвсэгтэй цэргүүд завинд сууж төдий л холдож чадаагүй байгаа золгүй орогдлыг мөрдөн хөөх болно. Их буугаар буудаж, өлсгөлөн, ноорхой тэнэмэлд орох орон битгий өг гэж дохио мэдэгдэх байх даа. Марселийн цагдаа нарт мэдэгдэж, тэд эргийг бүслэн, энэ завсар Иф цайзын комендант тэнгисээр эрэл хийх байх. Тэгвэл яана? усан дээр бүслэгдэж, хуурай газар дээр мөрдөгдсөн би хаашаа зайлах вэ дээ? би өлсөж даарч бээрч байна. Ядахдаа сэлэхэд саад болоод байхаар нь өнөөх аврагч хутгаа хаячихсан, намайг илрүүлж өгөөд хорин франкаар шагнуулах гэсэн хамгийн түрүүчийн хүний эрхэнд орно. Одоо надад хүч чадал, ухаан бодол, зориг хатуужил алга! Бурхан минь! Бурхан минь! Миний ингэж зовж зүдэрч байгааг харж байгаа биз, надад туслаач, би өөрөө өөртөө тусалж чадах чадалгүй боллоо!» гэж Эдмон өөртөө хэлэв.

Эдмон ийнхүү ядарч, тамирдан ухаарах чадваргүй болж хагас солиорох шахуу Иф цайз өөд айж сүрдэн харж саях залбирлыг уншиж байгаа энэхэн үед ус бараг шүргэх шахам нисэж яваа цахлай шувуу шиг жижигхэн хөлөг онгоц Помег арлын үзүүр тойрч явахыг олж харлаа. Бараантсан хэвээр байгаа тэнгисийн зурваст яваа энэ онгоцыг Генуегийн хөнгөн онгоц гэж гагцхүү далайчин хүний нүд л ялган таних ажээ. Тэр онгоц Марселийн усан буудлаас тэнгис уруу гарч яваа бөгөөд нарийхан рошууны нь өмнөх гязалзсан хөөс лүүний цүлхгэр биед зам тавьж өгнө.

- Хэрвээ намайг асууж байцаагаад Марсель уруу буцааж аваачиж өгч магадгүй гэж айгаагүйсэн бол би хагас цагийн дараа энэ онгоцтой дайралдаж болох байсан юм! Гэж Эдмон дуу тавиад - Яавал дээр вэ? тэдэнд юу гэж хэлэх билээ? Тэднийг хуурах ямар үлгэр зохиоё доо байз? Эд хагас далайн дээрэмчин, хил зөрчин худалдаа хийгчид л дээ. Худалдаа хийх гэдэг нэрийдлээр дээрэм хийж явдаг, тэгэхээр намайг бодон сайн үйл үйлдэхээсээ худалдчихаж л мэднэ гэж Эдмон бодов.

Хүлээж байя...

Гэвч хүлээх арга алга, би өлсөж үхэх нь, хэдэн цагийн дараа сүүлчийн хүч минь барагдана. Бас тэгээд өглөөний эргэлт очих цаг дөхөж байна. Одоохондоо түгшүүр зарлаагүй байна. Сэжиглэхгүй байж ч магадгүй. Би өөрийгөө урьд шөнө эвдэрч сүйдсэн хөлгийн далайчин гэж хэлье. Энэ л хамгийн үнэмшмээр зүйл болно, намайг хэн ч няцаахгүй, тэд цөмөөрөө живж үхсэн. Тэгэхээр очъё!...

Дантес бяцхан хөлөг онгоц эвдэрсэн зүг уруу хараад цочин дагжив. Цохио хадны нэгэн ирмэг дээр живж үхсэн далайчдын нэгний нь малгай тээглэсэн байх ба ойролцоо нь хүнд гуалин долгионд дайвалзаж хадны ёроолыг таран шиг нүднэ.

Дантес эргэлзэхээ больчихоод малгай уруу сэлж очоод өмсөнгөө нэг гуалин барьж аваад жижиг цагаан онгоцны замыг хөндлөн огтолж хөвөн,

- Одоо би аврагдлаа гэж шивнэв.

Энэ итгэл түүнд дахин хүч оруулав.

Удалгүй Дантес Иф цайз ба Кланье хоёрын хооронд салхи сөрөн арга зүйг олж яваа өнөөх онгоцыг харав. Гэвч Дантес онгоцыг эрэг дагуу явахынхаа оронд шууд тэнгис уруу гарч Корсик буюу Сардина арал зүглэн яваад өгөх вий гэж айв. Гэвч яваа байдлыг харж байтал Итали орохоор явдаг онгоцуудын адилаар Жарос ба Каласарень арлуудын хоорондуур гарч явах нь гэдгийг мэдэв.

Тэр завсар онгоц усчин хоёр бие биедээ ойртсоор байлаа. Онгоц ганц дарвуулаараа явж байсан ч гэлээ Дантест дөрөвний нэгэн бээр хэртэй ойртож ирэв. Дантес өндийж малгайгаараа даллан гай тохиолдсоны дохио өгөв. Гэвч түүнийг хэн ч

ажигласангүй. Онгоц жолоогоо тавьж жигд хөдөлгөөнөөр явав. Дантес хашхирах гэсэн боловч газрын зайг нүдээрээ хэмжиж үзээд дуу нь салхи ба долгионд хөөгдөөд онгоцонд дуулдахгүй гэж мэдэв.

Тэгэхэд л гуалин авч гарсан нь их аз боллоо гэдгийг ойлгов. Тэр онгоцтой дайралдах хүртэл усан дээр тогтож чадахааргүйгээр их ядарсан бөгөөд гай болж онгоц түүнийг харалгүй өнгөрчих бол лав эрэг уруу буцаж гарч чадахгүй байсан биз.

Дантес онгоцын явах замыг бараг итгэлтэй мэдэж байсан боловч, түүнийг өөр уруугаа чиглэн эргэтэл сэтгэл зовнин харж байв.

Онгоц түүн уруу ирж явснаа, хазайж өөр зүг чиглэж эхэлсэн учир Дантес бүх хүчээ шавхан усан дээр бараг эгц дээшээ босож малгайгаараа даллан живж байгаа хүний гомдолтой дуугаар хашхирсан нь тэнгисийн сүнс орилж байна уу гэлтэй байлаа.

Энэ удаа тэд түүнийг харж дууг нь сонсов. Хөнгөн онгоц чиглэлээ өөрчилж түүний зүг эргэв. Тэр үед завь ус уруу буулгаж байхыг Эдмон харав. Нэг минутын дараа хоёр хүн сэлүүрдсэн завь чиглэн ирэхэд Дантес авч явсан дүнзээ одоо хэрэггүй боллоо гэж хаяад тэднийг хол явуулахгүйн тул өөдөөс нь сэлж ойртов. Гэвч барагдаж байсан хүчээ зөв тооцоолсонгүй. Өөрөөсөө зуугаад алхмын газар долгионд хөвж байгаа хэсэг модоо хараад гашуудан харамсав. Гар хөл нь хөшиж биеийн хөдөлгөөн нь алдагдаж, амьсгаа нь тасалдана.

Хоёр дахь удаагаа хашхирахад сэлүүрчид улам хүчтэй сэлүүрдэж тэдний нэг нь итали хэлээр,

- Тэсэж байж үз! гэж хашхирав.

Энэ үг нь ирж байгаа давлагааг сөрөн дээр нь гарч чадахгүй болж, толгой дээгүүр нь хөөс бүрхээд явах яг тэр үед сонстов. Тэр дахин хөөрөн гарч ирээд, гурав дахь удаагаа хашхирч усан дотор яах ч аргагүй болж эргэлдэн хөрвөн, хөлөөс нь хүнд юм чангаасаар байгаа юм шиг доошоо живж байна гэж санагдлаа.

Ус түүнийг бүрхэн авахад түүний завсраар хар толбо цайвар тэнгэрт харагдав.

Тэр дахин хүний хэрээс хэтэрсэн их хүч гаргаж дээшээ гарч ирэв. Тэгэхэд үснээс нь татах шиг санагдаж, түүнээс хойш юу ч сонссонгүй ухаан алдчихжээ.

Дантес ухаан орж, нүдээ нээн харвал аяллаа үргэлжилсээр яваа онгоцны тавцан дээр хэвтэж байлаа. Тэр энэхүү онгоцыг аль зүг уруу явж байгааг нь харах гэж хөдлөхөд онгоц Иф цайзнаас холдсоор байв.

Дантес баярлан хашхирах нь гинших адил дуулдахаар тийм суларч доройтжээ.

Ийнхүү тавцан дээр тэрийн хэвтсэн Дантесыг нэг далайчин ноосон хөнжлөөр арчина. Түүнд «Тэсэж байж үз!» гэж хашхирсан нөгөөх нь дашмаг аманд нь шургуулж байлаа. Гурав дахь хүн болох хөлгийн эзэн бөгөөд худалдаачин, хөгшин далайчин өчигдөр өөрсдөө өнгөрсөн боловч маргааш тэдэнд тохиолдож болох тэр аюулыг өнгөрчихсөндөө сэтгэл хангалуун явдаг хүмүүсийн хувиа бодсон сэтгэлээр харж зогсоно.

Дашмагаас ууссан ром хэмээх архины хэдэн дусал Дантесыг чадал оруулж, хажууд нь өвдөг дээрээ суугаад биеийг нь үрж арчин байгаа далайчны илэлт хөшсөн булчин шөрмөсийг нь дахин уян хатан болгож өгөв.

- Та хэн гэгч вэ? гэж хөлгийн эзэн муухан франц хэлээр асуухад,
- Би Мальтийн далайчин гэж Дантес бас л муухан итали хэлээр хариулаад
- Бид Сиракузаас дарс, даавуу авч явсан юм. Өчигдрийн шуурга бидэнтэй Моржион хошууны дэргэд дайралдаж, бид тэртээх цохиог мөргөж сүйдлээ гэв.
- Та хаанаас сэлж ирэв
- Би хаднаас барьж авч амжсан, харин манай хөөрхий ахмад толгойгоороо хад мөргөж үхсэн. Бусад гурав маань живж үхсэн. Бодвол би л ганцаараа амьд үлдсэн бололтой. Тэгээд танай онгоцыг хараад, хүн амьтангүй хоосон арал дээр удаан байхаасаа айж, онгоцныхоо хэлтэрхийгээс барьж та нар дээр сэлж ирэх гэж шийдсэн минь энэ. Танд их баярлалаа. Та намайг аварлаа. Танай далайчин намайг үснээс минь татаж авахад би яг л живж байсан.
- Тэр чинь би гэж хар хууз сахалтай хөгжилтэй царайтай далайчин хэлээд - Яг л цагийг нь олсон доо, та доошоо живж байсан шүү гэв. Тэгэхэд Дантес түүн уруу гараа сунгаж,
- Тийм ээ, найз нөхөр минь би танд их баярлалаа гэж хэлэв.
- Би таны ингэж их ургачихсан үсийг хараад далайн дээрэмчин юм байх гэж татаж авахаа эргэлзсэн шүү гэж өнөөх далайчин үргэлжлүүлэн ярихад, Дантес Иф цайзын шоронд байсан бүх хугацаандаа нэг ч удаа үсээ засуулж, сахлаа хусуулаагүйгээ санаж,
- Тийм ээ, урд нэгэн аюул тохиолдоход дель Пье де ла Гротта эх дагинад арван жил үсээ засуулахгүй сахлаа хусуулахгүй гэж тангараг тавьсан юм. Өнөөдөр миний хугацаа минь дуусч байгаа юм, харин яг ой дээрээ золтой л живж үхсэнгүй гэж хэлэв.
- Аа, одоо бид таныг яах вэ гэж эзэн асуухад,
- Аль дуртайгаараа бол гэж Дантес хэлээд - Миний ажиллаж байсан бэсрэг онгоц сөнөж, ахмад маань живж үхсэн. Харин би бүтэн үлдлээ. Гэхдээ эхийн минь төрүүлж гаргасан биеэс өөр юмгүй хоцорч. Харин аз болоход би муу биш далайчин. Тэгэхээр

намайг хамгийн түрүүнд дайралдсан нэгэн буудал дээр орхивол тэнд ямар нэгэн худалдааны хөлөг онгоцон дээр ажил олж хийнэ дээ гэв.

- Та газрын дундад тэнгисийг мэдэх үү?
- Би энд хүүхэд байхаасаа аялсан.
- Та сайн зогсоол мэдэх үү?
- Би нүдээ аниад орж гарч чадахгүй тийм сүрхий усан буудал цөөхөн л дайралдах байх.
- Эзэн минь, яах вэ гэж өнөөх «Тэсэж байж үз» гэж хашхирсан далайчин хэлээд - Хэрвээ энэ нөхөр үнэн хэлж байгаа юм бол мана© онгоцон дээр хоцорч болохгүй юу байсан юм бэ? гэв. Тэгэхэд эзэн итгээгүй янзтайгаар,
- Тийм ээ, үнэн хэлж байгаа бол. Иймэрхүү хөөрхий болсон үед ч ихийг амлавч хийх нь гавьдаггүй л дээ гэв.
- Би амалж байгаагаасаа ажил дээрээ илүү ихийг гүйцэтгэж чадна гэж Дантес хэлэхэд,
- Үгүй ер! гэж эзэн инээж хэлээд - харъя л даа гэв.

Дантес босож,

- Та одоо ч үзэж болно. Та нар хаашаа явж байгаа улс вэ? гэж асуув.
 - Ливорно уруу.
 - Тийм бол та бүхэн салхи өөд мацан, үнэт цагаа алдаж байхын оронд зүгээр л салхиар яваад өгөхгүй яасан юм бэ?
 - Тэгвэл бид Рион уруу орчихно шүү дээ.
 - Үгүй, түүнээс дөчөөд метрийн зайтай өнгөрч гарна.
 - За тийм бол жолоо барь, таны хэрхэн жолоодохыг харъя гэж эзэн хэлэв.
- Эдмон жолоон дээр сууж түүнийг хэр зэрэг зохицсон ажиллагаатай юм гэдгийг шалгаж үзээд, онц нарийн биш боловч санаснаар хөдөлж байхыг нь мэдэж,
- Хөндлөн далбаа ба булиняг татаж яв гэж командлав.

Онгоцны бүх баг болох дөрвөн далайчин байр байр өөдөө гүйлдэж, эзэн тэднийг ажиглан харж зогсоно.

- Чигжүү далбаа шилж аваарай! Булиня бас аваарай гэж Дантес үргэлжлүүлэн тушаав.

Далайчид түүний тушаалыг овоо шалмаг гүйцэтгэв.

- За, одоо эвхэх хэрэгтэй.

Энэ тушаал түрүүчийн хоёр тушаалын адил биелэгдэж, одоо онгоц салхины өөд явалгүйгээр харин Рион арлыг чиглэн явж, Дантесын урьдчилан хСлсэн ёсоор түүнээс дөчин метрийн зайтай өнгөрөн гарав.

- Сайн байна гэж эзэн хэлэхэд

- Сайн байна гэж далайчид давтан хэлэв.

Тэгээд харцанд нь ухаан тодорч биед нь хүч чадал шингэсэн энэ хүнийг гайхан харцгаав. Тэд түүнийг ийн чинээ бодсонгүй. Дантес жолоогоо тавьж,

- Харж байна уу? Би энэ удаагийн аялалд ч гэсэн хэрэг болох нь. Хэрвээ Ливорнод очоод би танд хэрэггүй болбол намайг тэнд нь орхичихоорой. Би анхныхаа цалингаас танд хоолны үнэ ба надад өгөх хувцасны чинь үнийг төлж өгнө гэж хэлэв.

- Тэгвэл сайн, харин та илүү их юм авна гэхгүй бол бид яаж ийгээд учраа ололцож болох байлгүй гэж эзэн хэлэхэд,

- Далайчид далайчинтайгаа адил байх ёстой Нөхдүүдэд өгдөг л юмаа надад өгөөрэй гэж Дантес хэлэв. Тэгэхэд Дантесыг уснаас татаж гаргасан далайчин,

- Тэгж болохгүй энэ бол шударга биш хэрэг. Та бид нараас илүү мэдэж байна гэж хэлэв.

- Жакопо, чамд ямар хамаатай юм бэ? Хүн бүхэн дуртай хөлсөөрөө л ажилд ордог юм гэж эзэн хэлэв.

- Тийм дээ, би зүгээр л тэгж хэлсэн юм гэж Жакопо хэлэв.

- Харин чи илүү өмд цамц байвал зээлдүүлбэл дээр юм биш үү гэхэд,

- Надад илүү хөвөнтэй цамц байхгүй, харин дотуур цамц, өмд бий гэж Жакопо хариулав.

- Надад энүүнээс өөр юм хэрэггүй, найз нөхөр минь, их баярлалаа гэж Дантес хэлэв.

Жакопо доошоо ороод хувцсаа барьж гарч ирэхэд, Дантес түүний нь авч өмсөхдөө хэлж баршгүй ихээр баярлан жаргаж байлаа.

- Танд өөр юм хэрэггүй юу? гэж эзэн асуухад,

- Зүсэм талх, түрүүчийн амты нь авсан сайхан хом архинаасаа балга өгөхгүй юу, би юм идээгүй удаж байна гэв.

Үнэндээ бараг хэер хоног юм идээгүй байжээ.

Дантест зүсэм талх авчирч өгөхөд Жакопо түүнд дашмагаа өгөв.

- Жолоогоо зүүн тийшээ! Гэж ахмад хашхирав.

Дантес дашмагаа уруулдаа аваачих гэтэл гар нь газрын дунд зогсов.

- Хараач, Иф цайзан дээр юу болоод байна вэ? гэж эзэн хэлэв.

Иф цайзны өмнөд талын шүдтэй хэрэм дээрээс цагаан утаа суунаглав.

Түүнээс нэг хормын дараа холын их бууны дуу дуулдав.

Далайчид толгойгоо өндийлгөж, бие бие өөдөө харав.

- Юу болж байгаа нь энэ вэ? гэж эзэн асуухад, Дантес

- Ямар нэг хоригдол урд шөнө оргочихсон юм байлгүй дээ, тэгээд түгшүүр зарлаж байгаа байх гэж хариулав.

Энэ үгийг хэлчихээд, дашмагаа уруулдаа аваачиж байгаа залууг эзэн ажиглан харав. Гэвч Дантес эзний санаанд ямар нэг сэжиг төрсөн бол тэр нь дөнгөж төрөөд тэрхэн дороо алга болчихоор тийм ажигч үгүй тайвнаар ромоо ууж суув.

- Ямар хатуу ром бэ? Гэж Дантес хэлээд цамцныхаа ханцуйгаар духныхаа хөлсийг арчив.

- Тэр нь энэ байлаа ч бүр ч сайн, надад зоримог сай залуу олдож гэж эзэн аман дотроо бувтнав.

Дантес жолооны дэргэд суух зөвшөөрөл авлаа. Жолоо баригч ээлжлэх хүн олдсонд баярлаж, эзэн өөдөө харахад тэр нь өөрийн шинэ нөхөрт жолоогоо өгөхийг зөвшөөрөн дохив.

Дантес жолооны дэргэд сууж, ямарч сэжиг төрүүлэлгүйгээр Марселийн зүг харах бололцоотой боллоо.

- Өнөөдөр хэдэн бэ? Гэж „антес Иф цайз харагдахгүй болоход дэргэдээ суусан Жакопогоос асуухад,

- Хоёрдугаа° сарын хорин найман гэж далайчин хариулав.

- ХэдСн оны? Гэж Дантес асуухад,

- Юу хэдэн оны гэж? Та хэдэн он бэ? Гэж асуув уу?

- Тийм ээ, Би хэдэн он бэ? Гэж асууж байна.

- Бид хэдэн онд амьдран сууж байгаагаа мартчихаа юу?

- Одоо яая гэх вэ! гэж Дантес инээж хэлээд - Би урьд шөнө ухаан алдталаа айсан учир ухаан санаанд юу ч алга болчихож. Тийм учраас өнөөдөр хэдэн оны хоёрдугаар сарын хорин найман бэ? Гэж асууж байгаа юм.

- Мянга найман зуун хорин есөн он гэж Жакопо хэлэв.

Дантес шоронд орсноос хойш яг арван дөрвөн жил болжээ. Дантес арван есөн настай байхдаа Иф цайзын босгыг алхаж орсон бол одоо гучин гуравтайдаа тэндээс гарчээ.

Гунигтай инээвхийлэл түүний уруул дээр үзэгдэн өнгөрөв. Өөрийг нь үхсэн гэж бодох болсон байх ёстой Мерседес энэ хооронд яагаа бол гэж өөрөөсөө асуув.

Дараа нь түүний нүдэнд үзэн ядах гал гялалзаж, өөрийг нь удаан хугацаагаар зовлонд хатаасан өөдгүй гурван амьтан санаанд нь оров.

Тэгээд шоронд байхдаа аймшигтайгаар тангарагласан шиг Данглар, Фернан, Вильфор гурваас хайр найргүй өшөөгөө авахаар дахин тангараглав.

Одоо энэ тангараг бол хоосон заналхийлэл биш байлаа. Газрын дундад тэнгисийн ямарч хурдан онгоц, Ливорно орохоор бүх далбаагаа татаж нисэх мэт хурдлан яваа бяцхан хөлгийг гүйцэхээсээ өнгөрчээ.

Хоёрдугаар бүлэг

1. Хулгайгаар хил давуулан панз хийгчид

Дантес онгоцон дээр бүтэн хоноо ч үгүй байж ямар хүмүүстэй учирснаа ойлгов. «Залуу Ачелий»-н (генуегийн онгоцыг ингэж нэрлэдэг байв) эрхэмсэг эзэн ширээт лам Фариагийн дэргэд суралцаагүй боловч Газрын дундад тэнгис гэж нэрлэгддэг өргөн уудам нуурын эргээр ярилцдаг хэлээр, арабаас нь авахуулаад провансаль хүртэл ярьж чаддаг хүн байв. Энэ нь түүнийг хэлмэрч хэмээх үгэнд дуртай даруу биш зантай хүмүүсээс зайлуулж, дайралдсан онгоцууд ба эрэг хавиар явдаг жижиг онгоцууд, эцэс сүүлд нь нэр ус ч үгүй, эх орон ч үгүй, ямар нэгэн тодорхой мэргэжил үгүй, тэнгисийн буудлуудаар үргэлж сэлгүүцэн бурхан л илгээсэн байх гэхээс өөр энгийн нүдээр хараад учир нь олдохгүй хөрөнгөөр амьдардаг хүмүүстэй ч харилцахад хялбар болгож өгнө. Дантес хориотой бараа зөөж худалдаа хийгчидтэй дайралдчихжээ гэдгийг уншигч авгай тааварлаж байгаа биз ээ.

Эзэн, Дантесыг өөртөө авахдаа нэлээд болгоомжилсон нь зүйн хэрэг. Тэрээр эргийн гаалийн газарт зэгсэн танил болсон болохоор гаалийнхан ба энэ хүн бие биеэ хууран мэхлэх гэж чадах л заль мэхээ гаргадаг байв. Дантесыг өөрийн нь нууцыг мэдэх гэж явуулсан гаалийн хүн гэж эхлээд бодож байжээ. Дантес салхины өөдөөс эгц явж, шалгалтыг амжилттай давахад бүр тайвширчээ. Дараа нь Иф цайзын ханан дээр утаа манарч холын их буун дуу сонстоход, ван шиг орох гарахад нь их бугаар буудаж ёсолдог тэдгээр хүмүүсийн нэгийг олж авсан юм биш байгаа гэж боджээ. Энэ бол түүний зочин гаалийн төлөөлөгч байснаас хамаагүй дээр байв. Гэвч энэ хоёр дахь сэжиг нь Дантесын тайван байдлыг хараад нэгдүгээр шиг нь амархан арилж үгүй болов.

Эдмон өөрийнхөө эзнийг хэн болохыг мэдсэн давуу талтай байхад, эзэн нь шинэ далайчнаа чухам хэн болохыг мэдсэнгүй. Түүнийг хөгшин далайчин түүний нөхөд хичнээн ч асууж шалгаасан Дантес юу ч хэлсэнгүй. Марсель шигээ сайн мэддэг Неаполь, Мальт хоёрын тухай тодорхой ярьж өгөөд, түрүүчийн ярьсан түүхээ нэгд нэгэнгүй хэлж өгөв. Ийм янзтайгаар генуегийн хүн бүх заль мэхээ хэрэглэсэн боловч Эдмоны өмнө хол явахгүйгээ харуулав. Дантес бол номхон дөлгөөн, далайчны туршлагатай, хамгийн гол нь өөрийгөө илчилчихгүйгээр чадвартай хүн байв.

Түүний хамт генуэ хүн маань магадгүй, ухаантай хүний ёсоор мэдэх гэсэн юмаа мэдчихээд, аль ашигтай үнэмших юмаа үнэмшээд л явж байдаг хүн байв.

Ливорнод хүрэлцэн ирэхэд хэрэг явдал ийм байв.

Эдмон энд шинэ шалгалтад орох ёстой боллоо. Арван дөрвөн жил шоронд суусныхаа дараа өөрийгөө таних эсэхийг шалгах хэрэгтэй байлаа. Тэр залуудаа ямар хүн байсныгаа нэлээд тодорхой санаж байв. Одоо тэр өөрийгөө нас гүйцсэн хойно ямар болсон байхыг харна. Тэр нөхрийнхөө өмнө тангарагийнхаа хугацааг дуусгав. Дантес Ливорнод хорь шахам удаа ирж байсан учир Сан-Фернандо

гудамжинд нэгэн үсчин байдгийг мэдэх ажээ. Тэгээд үсээ засуулж сахлаа хусуулахаар түүн уруу явав.

Уран зураач Тицианы зурсан зурагтай адил өтгөн хар хууз сахалтай, урт хар үстэй хүнийг үсчин гайхан харав. Тэр үеэ урт үс, сахал хэрэглэдэггүй байв. Байгалиас заяагдсан ийм сайхан гоёлтой хүн үүнийгээ авахуулах гэж байгаад үсчин гайхлаа. Гэвч Ливорны үсчин үг дуугүй ажилдаа оров.

Ажил дуусч сахлаа гөлийтөл хусуулж үсээ ердийн хэмжээнд нь хүртэл тайруулсны дараа Эдмон толь гуйж нүүрээ харав.

Бидний дээр хэлснээр, тэр одоо гучин гурван настай бөгөөд арван дөрвөн жил шоронд хоригдсон нь түүний нүүр царайг ихэд өөрчилжээ.

Дантес Иф цайзад орохдоо дугараг хөгжилтэй царайтай, аз хийморь нь сэргэсэн хүү байсан бөгөөд амьдралын анхны алхам нь амархан бүтэж, өнгөрсөн үеийнхээсээ үлдээж хийсэн ганцхан дүгнэлт болох ирээдүйдээ итгэсэн хүн байв. Одоо үүнээс нь ул мөр ч үлдсэнгүй.

Нүүрийн нь хэв уртсаж, инээмсэглэж байгаа ам нь бат шийдэмгий байдлыг илэрхийлнэ. Хөмсөг нь нугарч, духан дээгүүр нь шулуухан үрчлээ сууж, нүдэнд нь гүн уйтгар нуугдан үе үе, үзэн ядах галаар гялалзана. Өдрийн гэрэл, нарны илч үзээгүй удсан царай нь умард зүгийн хар үсээр эмжээрлэгдсэн язгууртан хүмүүст л байдаг тийм цайвгар туяатай зөөлөн цагаан өнгөтэй болжээ. Бас түүн дээр сурсан эрдэм нь түүнд ухаан ба итгэмтгий байдлыг шингээжээ. Тэр төрөлхийн өндөр нуруутай боловч, байнга чадал сууж байгаагийн тэмдэг болсон нэлээд махлаг болжээ.

Урин турин бие нь чийрэг булчирхаг болж хувирчээ. Гуйж, цөхөрсөн, зүхэж занасан дуу нь үгүй болж заримдаа ер бишийн зөөлөн заримдаа огцом ширүүн, бага зэрэг сөөнгө маягтай дуугарах болжээ.

Түүнээс гадна бүдэг буюу заримдаа бүр харанхуй дотор сууж байсан болохоор нүд нь ирвэс, цөөвөр чононы нүд шиг шөнө ч ямар нэгэн юмыг ялгаж чадах болжээ.

Эдмон өөрийгөө хараад инээмсэглэв. Хэрвээ энэ ертөнц дээр түүнд сайн нөхөр гэж үлдсэн бол түүнийг танихааргүй болсон байв. Тэр өөрийгөө ч таньсангүй.

«Залуу Амелий»н эзэн Эдмон шиг ийм далайчинг өөртөө үлдээхийг үлэмж хүссэн учир түүнд дараагийн олох орлогоос бага зэрэг мөнгө хувь болгож өгнө гэхэд нь Эдмон зөвшөөрөв. Өөрийг нь хамгийн түрүүнд өөрчилж өгсөн үсчинээс гараад Дантес юуны өмнө дэлгүүрт очиж далайчны бүрэн хувцас худалдаж авав.

Энэ бол цагаан өмд судалтай цамц, усан цэргийн малгайгаас бүрэлдсэн жирийн нэг хувцас юм.

Эдмон хувцсаа өмсөөд Жакопогийн зээлдүүлж өгсөн цамц өмдийг буцааж өгөөд «Залуу Амелий»н ахмад дээр очиж түүнд өөрийнхөө түүхийг давтан ярих болов. Энэ гоёмсог хувцасласан сайхан залууг нүцгэн шалдан үхэж байхад нь онгоцон дээрээ гаргаж авсан өнөөх өтгөн хар үс сахалтай тэнгисийн усанд нэвт норсон хүн мөн гэж таньсан.

Дантесын сайхан төрх байдлыг хараад эзэн түүнд өөрийнхөө албанд орохгүй юу гэж дахин гуйв. Өөр бодлого зорилготой байсан Дантес зөвхөн гурван сар хөлслөгдөхөөр зөвшөөрлөө.

«Залуу Амелий»н баг нь ажилсаг хүмүүсээс бүрэлдэх бөгөөд тэднийг цаг алдах дургүй ахмад захирч байлаа. Нэг долоо хоног ч өнгөрөөгү© байтал онгоцны уужим хөндий өнгө өнгийн нимгэн зөөлөн нэхмэл, зөөхөд хориотой цаасан нэхмэл, англи дарь татвар ногдуулах газраас тамгалахыг мартсан тамхиар дүүрсэн байв. Энэ бүгдийг Ливорноос ачиж, Корсикийн эрэг дээр буулгах ёстой бөгөөд тэндээс энэ барааг хэн нэгэн хүмүүс францад аваачих ажээ.

Ингээд онгоц аян замд гарав. Эдмон шоронд байхдаа олон удаа зүүдэлж байсан өөрийн нь багын өлгий болсон тунгалаг хөх тэнгисийг дахин зүсэж явав. Тэр Горгоныг баруун гар талдаа, Пианозыг зүүн гар талдаа үлдээж Паоль ба Наполеоны эх оронг чиглэн явав.

Маргааш өглөө нь ахмад заншсан ёсоороо онгоцон дээр гарч ирээд хөлгийн хажууг түшиж мандаж байгаа нарны илчинд улайсан боржин чулуун шовх хадыг хачин царайгаар ширтэн харж зогсоо Дантесыг харав. Энэ бол Монте Кристо арал байлаа.

«Залуу Амелий» түүнийг баруун талдаа гурав дөрвөн бээр хиртэй газар орхиод Корсикийг чиглэн цааш явав.

Дантес, өөрт нь амин чухал энэ арлын хажуугаар гарахдаа усанд үсрээд л орчихвол чулуужсан хатуу газар дээр хагас цагийн дараа л гарчихна даа гэж бодож байв. Гэвч тэр эрдэнэсийн санг ухах багаж ч үгүй түүнийгээ хамгаалах зэвсэг ч үгүй байж юу хийж чадах билээ дээ? Далайчид ч юу гэх билээ? Ахмад ч юу гэх билээ? Ийм болохоор хүлээхээс өөр арга алга.

Аз болоход Дантес хүлээж чаддаг байв. Эрх чөлөөтэй болохсон гэж арван дөрвөн жил хүлээсэн юм. Одоо эрх чөлөөтэй болсон хойно энэ баялгийг хагас жил байтугай бүтэн жил ч хүлээх хялбархан байв.

Баялаг байхгүй ч гэлээ эрх чөлөөг түүнд найр тавьсан бол зөвшөөрөхгүй байсан гэж үү.

Энэ баялаг гэдэг маань биелшгүй хоосон бодол юм биш байгаа? Хөөрхий ширээт лам Фариагийн гажигтай толгойд төрсөн энэ баялаг түүнтэйгээ хамт алга болчихсон юм биш биз дээ?

Их хамба Спадагийн захидал гайхмаар яг таг юм шиг байсан.

Тэгээд Дантес эхнээс нь аваад адагт нь хүртэл цээжилсэн захидлыг аман дотроо давтан байв.

Үдэш боллоо. Арал аажмаар харанхуй бүрэнхийд замхран алга болохыг харж байв. Удалгүй арал хүн бүхэнд харагдахаа болив. Гэвч харанхуйд дассан Эдмонд харагдсаар л байсан бололтой бусдаас сүүлд болтол онгоцон дээр байлаа.

Тэд өглөө болоход Алерийг харав. Бүхэл өдөржингөө салхины эсрэг явж үдэш нь эрэг дээр гэрэл үзэв. Энэ гэрлүүдийн байрласан байдлыг харвал бараагаа буулгаж болно гэсэн дохио байсан бололтой. Тэд далбаа босгохын оронд дохионы гал асааж эрэгт буун сум тусахаар ойртож ирэв.

Ахмад энэ баярт үеийг тохиолдуулан төдий л их дуу чимээ гаргахгүйгээр дөрвөн фунтын сум мянган алхмын зайд буудаж чадах хоёр жижигхэн үхэр буу гаргаж онгоцны талбай дээр тавив.

Гэвч энэ удаа ийм болгоомжлол нь илүү ажил болж юм бүхэн нам гүм тайван өнгөрөв. Дөрвөн завь «Залуу Амелий» өөд чимээ аниргүй хүрч ирж, «Амелий» өөрөө тэдэнд хүндэтгэл үзүүлэн нэг завиа өөдөөс нь тавив. Ээ таван завь үлэмж шалмаг ажилл ж, өглөөний хоёр цаг болоход «Залуу Амелий»-н ачааг хуурай газар өөд зөөж дуусгав.

«Залуу Амелий»-н ахмад ёс журамд их дуртай хүн учир олсон олзоо тэр шөнөдөө хөлгийнхөндөө хуваан өгч, далйчин бүр тосканы зуун лувр, өөрөөр хэлбэл ная орчим франц авцгаав.

Гэвч аялал үүгээр зогссонгүй, Сардинийг чиглэн явав. Ачаагүй болсон онгоцондоо дахин ачаа ачих хэрэгтэй байлаа.

Хоёрдугаар аялал нь мөн л нэгдүгээр аялал шигээ амжилттай төгслөө... «Залуу Амелий» азтай л яваа бололтой.

Шинэ ачаа нь Лукксийн гүнлэгт очих ёстой байлаа. Энэ ачаа нь бараг бүгдээрээ гаваны янжуур, улаан цагаан дарс байв.

Гэтэл «Залуу Амелий»-н ахмадын байнгын дайсан гаалийнхантай нэгэн будлиантай явдал тохиолдов. Нэг цагдаа алагдаж, хоёр далайчин шархдав. Энэ

хоёр далайчны нэг нь Дантес бөгөөд сум түүний зүүн мөрөөр яс дайралгүй нэвт цохин гарчээ.

Дантест энэ тулалдаан аятайхан санагдаж, шархадсандаа бараг баярлав. Энэ хүнд хичээл нь түүнийг аюултай хэрхэн учирч хэрхэн давж туулахыг үзүүлэв.

Тэр аюултай инээмсэглэн нүүр тулгарч, шархадсан хойноо грегийн гүн ухаантай шиг «Өвдөнө гэдэг бол хорт муу хэрэг биш» гэж хэлж байв.

Тэгэхийн хамт Дантес үхтлээ шархадсан цагдааг харжээ. Тэр үүнээс болоод ч тэрүү, эсвэл тулалдааны үед улангассанаас ч тэр үү эсвэл ухаан нь балартсанаас ч юм уу, юу боловч энэ явдал түүнийг сандраасангүй. Дантес явах гэсэн замдаа нэгэнт орж тавьсан зорилго өөдөө шууд явжээ. Зүрх нь хад чулуу шиг хатуу болжээ.

Дыг үхэтхийн унахыг Жакопо хараад түүн уруу гүйн очиж өндийлгөөд, дараа нь халамжтайгаар асран сувилж байлаа.

Тэгэхээр, хэрвээ үхвэл орлогоос нь өчүүхэн хувь авахаас өөр юу ч үгүй нөхрийгөө энэ далайчин үхчихлээ гэж бодоод тэгж их харамсан гомдож байгааг харахад энэ орчлон, доктор Панглоссын бодож байсанчлан тийм сайн сайхан биш боловч, Дантест санагдсан шиг тийм муу хор шүглэсэн биш юм байжээ.

Аз болоход Эдмон, бидний дээр хэлсэнчлэн зөвхөн шархадсан байлаа. Сардин арлын авгайчууд зөвхөн өөрсдөө л мэддэг өдөр цагт түүж аваад, хориотой юм зөөн худалдагчдад худалддаг эмийн өвсний хүчээр шарх нь амархан анив. Тэгэхэд Дантес Жакопог шалган туршихаар шийдвэрлэв. Эдмон түүний хичээнгүйлэн тусалсны хариуд орлогоос авдаг хувийг түүнд өгье гэхэд нь Жакопо илт дургүйцэн татгалзав.

Жакопо Эдмоныг анх хараад хүндэтгэн, үнэн шударгаар хандсан нь Эдмоныг бас Жакопод зарим талаар ойртуулав. Гэвч Жакопод үүнээс илүү юм хэрэггүй байжээ. Эдмон өөрийн давуу талыг юугаар ч гаргахгүйг хичээх боловч түүнийг одоогийн байгаагаасаа илүү өндөр хувь заяатай хүн гэж Жакопо зөнгөөрөө мэдэрч байлаа. Эдмон түүнийг тоож үздэг явдалд сайн санаат хүү сэтгэл хангалуун байдаг ажээ.

«Амелий» дарвуул үлээх аясын салхины ачаар удаан цагаар хөх тэнгис дээгүүр тайван хөвж, жолоо баригч хүнээс өөр хэн ч, юу ч хийх шаардлагагүй болсон үед Эдмон тэнгисийн зургийг гартаа барьж хөөрхий ширээт лам өөрийн нь багш болж байсан шиг Жакопогийн багш болж байлаа. Эдмон эргийн байдлыг түүнд харуулан, луужингийн зүүний учрыг тайлбарлаж, бурхан номын өнгөн дээгүүр нь очир алмасан үсгээр бичдэг бидний толгой дээр нээлттэй байдаг тэнгэр хэмээх агуу том номыг хэрхэн унших аргыг зааж өгнө.

- Ядарсан муу далайчинд энэ бүхнийг зааж өгөхийн хэрэг байна уу? гэж Жакопог асуухад Эдмон

- Яаж мэдэх вэ? Чи хөлөг онгоцны ахмад болж магадгүй шүү дээ, чиний нутгийн бонапарт император болчихсон шүү дээ? гэнэ.

Жакопо нь Корсик арлын хүн байсныг бид хэлэхээ мартчихаж.

Хоёр сар хагас зогсолтгүй аялав. Эдмон одоо урьд эрэлхэг далайчин байсан шигээ тийм чадвартайгаар эрэг орчмын газраар ажиллаж чадах болов. Тэр, эрэг орчмын хориотой бараа зөөн худалдагчидтай цөмтэй нь танилцаж, эдгээр хагас далайн дээрэмчдийн бие биеийгээ таньдаг бүх нууц тэмдгүүдийг нь судлан мэджээ.

Эдмон, Монте Кристо арлын дэргэдүүр хориод удаа өнгөрөн гарсан боловч түүн дээр нэг ч удаа гарч үзсэнгүй. Тийм ч учраас тэр доорх зүйлийг хийхээр шийдэв.

«Залуу Амелий» дээр ажиллах хугацаагаа дуусмагц, жижиг завь хөлсөлж аваад, ямар нэг шалтгаан олж, Монте Кристо арал руу явна. Дантес аяллын хугацаанд зуугаад пиастр цуглуулж амжсан байжээ.

Тэгээд тэр тэнд чөлөөтэй хайж эхлэх болно, үнэндээ тийм ч чөлөөтэй биш, түүнийг хүргэж өгсөн хүмүүс хойноос нь мөрдөн харах нь лавтай.

Гэвч заримдаа азаа үзэх явдал амьдралд хэрэгтэй байдаг.

Шорон Эдмоныг болгоомжтой байхад сургасан учир азаа үзэхгүй аргацаахыг урьтал болгоно.

Тэр хичнээн удаа элдвээр эргэцүүлэн бодсон боловч хүсэлт арал дээрээ хүрэх өөр арга олсонгүй.

Дантест ихээхэн итгэж, өөрийнхөө албанд авч хоцрохыг маш их хүсдэг ахмад нэгэн орой түүнийг сугадан, Ливорнын хориотой бараа зөөн худалдагчдын урдаа барьдаг охь манлайнууд нь цуглардаг виа дель Ольо дахь архины гуанзанд дагуулж аваачихад бас л эргэлзсэн хэвээрээ байжээ. Чухам энд л худалдаа наймаагаа ярилцан тохиролцдог байжээ. Дантес энэ тэнгисийн бирж дээр хоёр гурван удаа ирсэн юм. Тэгээд тэр хоёр мянган бээр хол газраас ирж цугларсан эдгээр сайн эрчүүлийг хараад энэ ганц нэгээрээ байдаг хүчийг нэгтгэн захирч гартаа оруулж авсан хүн ямар их хүчтэй байх сан бол гэж боддог байв.

Энэ удаа томоохон хэргийн тухай ярьцгаав. Түрэгийн хивс, дорнодын нэхмэл эд ба кашмир даавуу ачсан хөлөг онгоцноос ачааг нь буулгаад дараа нь түүнийг францын эрэг уруу зөөж аваачих хэрэгтэй байв.

Хэрвээ энэ хэрэг амжилттай болбол ихээхэн шагнал өгч, хүн бүрд тавин пиастр ногдох ажээ.

«Залуу Амелий»-н эзэн ачаа буулгахад Монте Кристо арлыг сонгоё гэсэн санал гаргав. Энэ арал бол Олимпын үед худалдаачин ба хулгайч нарын бурхан Меркурия зориудаар тэнгисийн дунд аваачиж тавьсан юм шиг хүн амьтан суудаггүй гаалийн түшмэл цагдаа нар хайгуулдан харуулдаж байдаггүй зэлүүд газар юм.

Дантес «Монте Кристо» гэдэг нэрийг сонсоод баярласандаа болж бие нь чичрэв. Тэгэхээр нь хөдөлсөн сэтгэлээ нуухын тулд босож ертөнцийн хэл аялгуу бүхэн франц хэлэнд шингэсэн, утаа манарсан гуанзан дотуур хойш урагшаа алхлав.

Тэгээд ярилцаж байгаа хүмүүс дээр буцаж ирэхэд асуудал нэгэнт шийдвэрлэгдэж Монте Кристо арал дээр онгоцоо татах болж, маргааш шөнө нь замд гарахаар болжээ. Эдмонын саналыг асуухад энэхүү арлыг огтын аюулгүй хэмээн хариулж, том ажлыг хойшлуулшгүй гүйцэтгэж эхлэх хэрэгтэй гэв.

Ингээд төлөвлөгөө ямар ч өөрчлөлтгүй хэвээрээ үлдэв. Маргааш орой нь зангуугаа авч, тэнгэр аятай байж аясын салхи дайралдвал нэг хоноод хүн амьтан суудаггүй өнөөх аралдаа хүрэхээр ярилцан тохиров.

2. Монте Кристо арал

Эцсийн эцэст Дантес, удаан жилээр хатуу ширүүн хувь заяа эдэлж явсан тийм хүмүүст л тохиолддог гэнэтийн азаар хэнд ч ямарч сэжиг төрүүлэхгүйгээр ердийн байдлаар өөрийнхөө зорилгод хүрч арал дээр очиж чадах боллоо.

Удаан хугацаагаар хүлээсэн аяллаа хийхэд нь ганцхан шөнө үлдэж байв.

Энэ шөнө бол Дантесын үзэж өнгөрүүлсэн хамгийн түгшүүртэй шөнүүдийн нэг байлаа. Түүнд тохиолдож болох амжилттай, амжилтгүй явдлууд энэ шөнийн туршид түүнд зэрэглээтэн байлаа. Үүдээ анихад ханан дээр галт үсгээр бичсэн хамба Спадагийн захидал харагдаж, хоромхон зуур дугхийхэд хамгийн муухай үзэгдлүүд тархинд нь хуй салхи мэт эргэлдэн орж ирнэ. Эдмон номин эрдэнийн шалтай, бадмаараг чулуун ханатай, очир алмас хэлхэлдэн унжсан таазтай агуйд орж байх шиг санагдана. Газар доорх агуйнаасус шүүрэх лүгээ адилаар, сувд ар араасаа бөнжигнөн дусална.

Хөөрч баярласан Эдмон үнэт чулуугаар халаасаа дүүргээд, гадаа гэрэлд гарвал өнөөх үнэт чулуунууд нь ердийн хар чулуу болон хувирчихлаа. Тэгэхээр нь өнөөх хальт харсан шидэт агуйдаа буцаж орох гэвэл зам нь тахиралдан мухардаж хаалга нь олдохоо больчихов. Али-Бабын гайхамшигт агуйг арабын загасчинд нээж өгсөн шидэт үгийг бодож олох гэж эцэж ядарсан тархиа гашилгав. Хичнээн чармайвч дэмий болж газрын савдгаас Дантесын ухасхийн авах гэж байсан эрдэнэсийн сан дахин түүндээ эргэн оджээ.

Өглөө болсон боловч, мөн л шөнө шигээ сэтгэл үймүүлж зовоосон тийм өглөө боллоо. Гэвч Дантесын бодолд учир зүй тус болж, энэ хүртэл тодорхой биш бүрхэг байсан төлөвлөгөө боловсруулж эхлэв.

Өдөр өнгөрч, үдэш болоход аян замд гарахаар бэлтгэж эхлэв. Энэ нь хөөрсөн сэтгэлээ нуух бололцоог Дантест өгөв. Бага багаар нөхдөө эрхэндээ оруулж тэдэнд ахмад шиг тушаал өгч байлаа. Тушаал нь нарийн тодорхой амархан биелэгдэхүйц байдаг учир нөхөд нь түүний нь тэр дор нь дуртайяа биелүүлнэ.

Өвгөн далайчин ч түүнд саад болсонгүй. Дантес бусдаасаа давуу өөрөөс нь ч илүү болохыг хэдийнэ зөвшөөрөн хүлээжээ. Хөлгийн эзэн, залуу далай-ныг зүй ёсоор залгамжлах хүн гэж үзэж, Эдмоныг өөртөө улам татан ойртуулж наалдуулах охингүйдээ харамсаж байв.

Долоон цаг болоход бүх юм бэлхэн болсон байлаа. Долоон цагаас арван минут өнгөрч, хөлөг онгоц гэрэлт цамхгийг тойрон гарах яг тэр үед гэрэл нь асав.

Тэнгис тайван бөгөөд зүүн өмнөд зүгийн зөөлөн салхи үлээж байлаа. Тэд номин цэнхэр тэнгэрийн доогуур хөвөх агаад энд ч бас тус бүр нь бүхэл бүтэн ертөнцөөс бүтсэн гэрэлт цамхгуудыг бурхан асаажээ. Дантес тэднийг цөмий нь явж унт, би жолоогоо барьж хоцоръё гэж хэлэв.

Мальт залууг (Дантесыг тэгж нэрлэдэг байжээ) ингэж хэлмэгц бүгд үгэнд нь орж, санаа зовох юмгүй унтахаар явлаа.

Ийм явдал олонт тохиолддог байжээ. Дантес ор ганцаараа сууж байсан шоронгоос гэнэт нарт ертөнцөд гарч ирсэн болохоор үе үе ганцаараа байх юм сан гэж тэсэлгүй их хүснэ. Шөнийн гүн харанхуйд элчилгүй тэнгисийн дунд, эцэс төгсгөлгүй нам гүмд бүхнийг захиран баригчийн мэлмий доор хурдлан яваа хөлөг онгоц дээр ганцаараа үлдэж хоцрохоос илүү тийм аятай сайхан байх юм гэж хаана байх билээ?

Тэр шөнийн ганцаардмал байдал нь Дантесын бодол санаагаар дүүрч, харанхуй шөнө нь түүний хүслээр гийгүүлэгдэж нам гүм, чимээ аниргүй байдал нь горьдлогоор сэргэнэ.

Ахмадыг сэрэхэд «Амелий» бүх далбаагаа дэлгэн явж байлаа. Салхинд дэрвэн хийсэхгүй нэг ч ширхэг зотон даавуу байсангүй. Хөлөг онгоц цагт хоёр бэSp хурдлан явна.

Монте Кристо арал тэнгэрийн хаяанд харагдав.

Эдмон байраа ахмаддаа өгөөд унтахаар явав. Гэвч хэдийгээр нойргүй хоносон боловч цурам хийж чадсангүй.

Хоёр цагийн дараа дахин тавцан дээр гарч ирэв. «Амелий» Эльба арлыг ороож, Маречаныг чиглэн, хавтгай ногоон Пианоз арлын ойролцоо явна. Монте Кристо арлын орой номин тэнгэрт гялалзан харагдана.

Дантес Пианоз арлыг баруун гар талдаа орхихын тулд жолоогоо баруун тийш нь зал гэж жолоо баригчид тушаав. Энэ нь замыг хоёр гурван зангилаагаар богиносгоно гэж боджээ.

Оройн таван цаг болоход бүх арал алган дээр байгаа юм шиг тодхон харагдах болов. Шингэж байгаа нарны гэрэл нэвт гийгүүлсэн үдшийн тунгалаг агаарт арлын юм бүгд тодорхой харагдана.

Дантес шингэх нарны гэрэлд хурц улаанаас хар хөх хүртэл янз янзын өнгөөр солонгорсон хадат нүсэр арлыг нүд бэлчээн ширтэнэ. Үе үе цус хөөрч дух нь улайж, нүдэнд нь үүл бүрхэх шиг болно.

Хамаг хөрөнгөө мөрийтэй хөзөрт алдчихсан хүн ч гэсэн биеэ барьж чадахааргүй найдаж горьдон байгаа Дантес шиг сэтгэл нь догдлохгүй байсан биз ээ.

Харанхуй болж ирэв. Шөнийн арван цагт хөлөг онгоцоо эрэгт татав. «Залуу Амелий» болзоот газраа хамгийн түрүүн хүрэлцэн ирэв.

Дантес хэдийгээр биеэ барьж чаддаг ч гэсэн тэсгэлгүй түрүүлэн эрэг өөд үсрэв. Хэрвээ тэр зүрх нь хүрсэн сэн бол Брут шЁг газар үнэсэх байсан биз ээ.

Шөнө харанхуй байсан боловч арван нэгэн цагийн үед сар гийж долгиулсон тэнгисийг мөнгөн өнгөөр гийгүүллээ. Сар дээшлэх тутам цайвгар гэрэл нь энэ хоёрдугаар Пелионы арсайж сэрийсэн цохио хаднуудыг гэрэлтүүлнэ.

«Залуу Амелий»-нхан Монте Кристо арлыг сайн мэднэ. Энэ бол тэдний ердийн нэгэн зогсоол юм. Дантес дорно зүгт явах бүрдээ энэ арлыг хардаг боловч нэг ч удаа буудаллаж байсангүй.

Тэр Жакопод хандаж:

- Бид шөнийг хаана өнгөрүүлэх вэ? гэж асуув.

Тэгэхэд цаадах нь,

- Онгоцон дээрээ л гэж хариулав.
- Агуй дотор очиж унтвал дээр юм биш үү?
- Юун агуй дотор?
- Арал дээрх агуй дотор.

- Би энд агуй байдаг гэдгийг мэдэхгүй гэж Жакопо хариулахад Дантесын духны хүйтэн хөлс чийхрав.

- Монте Кристо дээр агуй байхгүй гэж үү? Гэж Эдмон асуухад

- Байхгүй гэж Жакопо хариулав.

Жакопогийн хариулт Дантесыг тэнгэр ниргэсэн лүгээ адил болгов. Дараа нь гэнэт газар нураад ч юм уу эсвэл хамба Спада сэргэмжилж өөрөө зориудаар таглаж далдалсан байж болох юм гэж бодов.

Хэрвээ ингэсэн байвал бөглөрсөн нүхий нь эрж олох хэрэгтэй боллоо. Үүнийг шөнө эрвэл дэмий эрэл болох байлаа Тийм учраас Дантес маргааш өглөө нь эрэлдээ гарахаар шийдэв. Тэгтэл ч эргээс хагас бээрийн хэртэй газраас ирсэн дохионд «Амелий» мөн адил дохио өгсөнд, ажилдаа орох болсныг мэдэгдэв.

Хожимдсон боловч зам нээлттэй гэдэг дохио авсан онгоц хий үзэгдэл мэт сүүтэгнэн эргээс хоёр зууг ад алхамд зангуугаа хаяж зогсов.

Тэр дороо ажилдаа оров.

Дантес ачаа зөөлцөнгөө сэтгэлээс нь огт гарахгүй, өөрөөс нь салахгүй бодогдож байгаа зүйлээ ганцхан үлээр хэлчихвэл энэ хүмүүс ямар их дуу тавин гайхах бол гэж бодож байлаа. Гэвч нууцаа илрүүлээгүйгээр үл барам өөрийн байдал асууж шалгааж, ширтэн гөлөрч бодолд автагдсан байдлаараа хүмүүст сэжиг төрүүлчих вий гэж болгоомжилно. Аз болоход үзэж өнгөрөөсөн хүнд явдал түүний царайд гуниглалын арилшгүй тэмдэг үлдээсэн болохоор хааяа нэг хөгжилтэй байх нь аяндын үүлийг зүсэн гийгүүлэгч цахилгаан шиг түргэн өнгөрнө.

Ингээд түүнийг нэг л өөр болсныг хэн ч ажигласангүй. Дантес маргааш өглөө нь буу, сум дарь авч арлын хад асган дээгүүр олноороо харайлдах янгир ямаа буудахаар явахад нь хүмүүс түүнийг ганцаараа байх ч юм уу эсвэл анд явах дуртай хүн юм даа гэж бодож хоцров. Ганцхан Жакопо л хамт явмаар байгаагаа хэлэв. Дантес сэжиг төрүүлэхгүйн тул дагаж явахыг нь дургүйцсэнгүй. Тэгээд замдаа нэг янгир буудаж алаад Жакопод өгч, нөхөд дээрээ аваачиж, шарж бай, хоол болохоор буугаар буудаж дохио өгөөрэй гэж хэлээд буцаан явуулав. Шарсан махтайгаа хатаасан жимс, лонх монтепулчаны дарс уух болно.

Дантес үе үе эргэж харсаар цаашаа явав. Тэгээд хадны орой дээр гарч өөрөөс нь мянган футын дор байгаа нөхдөө, тэдэнтэй нийлсэн Жакопо хоолоо бэлтгэцгээж байхыг харав.

Тэгээд давуутайгаа мэддэг хүний янзаар тэднийг хэсэгхэн зуур уйтгартайгаар инээмсэглэн харав.

- Хоёр цагийн дараа хармаандаа тавин пиастртай эдгээр хүмүүс бас дахин тавин пиастрыг нь амь нагандаа халтайгаар олох гэж цааш явах болно. Дараа нь зургаа зургаан ливртэй болоод аль нэгэн хотод Султан хаан шиг бардам зантай учиргүй том баян хүн шиг хайхрамжгүйгээр алхалж явах болно. Өнөөдөр би найдвараар амьдарч, надад л гуйлгачин хоосон юм шиг санагдах тэдний баялгийг үзэн ядаж байна. Гэвч маргааш надад арга барагдан гунихрах явдал тохиолдож, энэ гуйлгачин хоосон байдал гайхамшгийн аз жаргал мэт санагдаж болох юм. Үгүй, ийм байдалд хүрэхгүй. Ариун явдалт мэргэн Фариа андуурч эндүүрэх ёсгүй! Ийм хөөрхийлөлтэй зүдүү амьдарч явснаас үхсэн нь дээр! гэж өөртөө яриу.

Ингэж гуравхан сарын өмнө эрх чөлөөтэй болохыг хүсэн мөрөөдөж байсан Дантес одоо эрх чөлөөндөө ханахаа болиод, эд баялгийг хүсэн мөрөөдөх боллоо. Энэ бол Дантесын буруу биш, харин хүний хүч чадлыг хэмжээ хязгаартай тогтоогоод, хэмжээ хязгааргүй хүсэн мөрөөдөх сэтгэлэгтэй бүтээсэн бурхны буруу юм. Хүний хөл гишгээгүй бололтой хоёр хадны хоорондуур урагшлан явсаар байгаад Дантес өнөөх агуй байх ёстой газартаа хүрч ирэв. Эргийн дагуу байдлыг шинжиж, жижиг сажиг зүйлийг боловч сайтар ажиглаад хүний гараар хийгдсэн бололтой хэрчлээс зарим нэг хадан дээр байхыг олж харжээ.

Оюун санааны бүх юмыг мартахын манангаар бүрдэг шигээ, эд юмсыг хөвдөөр даран хучдаг цаг хугацаа, ямар нэг юманд хүргэх зүгийг заасан бололтой тэмдгийг өрөвдөн үлдээсэн юм шиг санагдана. Заримдаа эдгээр тэмдэг нь цэцэглэсэн жанхуу гүйлс хаганд дарагдан алга болжээ. Тэгэхээр нь Эдмон ногоон хөвдийг авч бутны мөчрийг ярж найдлага горьдлоор хөтөлсөн шинэ замаараа цааш явна. Гэр бүлдээ тохиолдох азгүй явдлыг урьдчилан харж чадаагүй хамба лам ачдаа зориулж энэ тэмдгүүдийг татсан ч юм бил үү хэн мэдэх вэ? Энэ зэлүүд газар нь эрдэнэсийн сан булахад тохиромжтой байр яг мөн байлаа. Гэхдээ энэ илэрхий тэмдгүүд үүнийг авах учиргүй өөр хүмүүсийн нүдэнд өртөөгүй байгаа? Энэ арал өөрийн гайхамшигт нууцыг ариунаар хадгалж чадах болов уу?

Онгоц татсан газраас жараад алхмын зайтай, хүмүүсийн нүднээс далд байгаа газарт өнөөх тэмдгүүд алга болж орхисныг Эдмон мэдэв. Гэвч тэмдгүүд агуйд хүргэж ирсэнгүй. Хүчирхгээр суурилсан том дугараг хад өмнө нь байлаа. Тэгэхээр нь Дантес тавьсан тэмдгийн төгсгөлд ирж байгаа биш, харин эхэнд нь ирж байгаа юм биш биз гэж бодоод буцаж өнөөх замаараа явав.

Тэр завсар нөхөд нь хоол бэлтгэж, горхиос ус авч, онгоцон дээрээс талх, жимс зөөж янгираа шарж байлаа. Тэд өөрсдийн хийсэн шорноос шарсан махаа гаргаж байхдаа нэг хаднаас нөгөөг дамжин ямаа шиг шалмаг эрэмгий зоригтой дүүлэн харайж яваа Эдмоньг харав. Тэд бугаар буудан дохио өглөө. Эдмон тэр дороо эргэж тэдэн уруу яаравчиллаа. Тэд түүнийг харайж дүүлэн яварыг хараад болгоомжгүй аашилж байна гэж зэмлэж байтал тэдний хэлснийг батлах гэсэн юм шиг Эдмон хадны орой дээрээс хальтиран дуу алдсанаа олонд харагдахаа болилоо.

Эдмон өөрсдөөс нь давуутайг мэдэрдэг боловч цөмөөрөө түүнд хайртай болохоор түүн уруу гүйлдлээ. Гэхдээ Жакопо хамгийн түрүүн хүрэв.

Эдмон цус нөж болчихсон ухаангүй хэвтэж байв. Бодвол, арван хоёр, арван таван футын өндрөөс унасан бололтой. Аманд нь хэдэн дусал ром архи дусааж өглөө. Энэ эм урьд нэгэн удаа тус хүргэсэн шигээ мөн энэ удаа сайн нөлөө үзүүлэв.

Эдмон нүдээ харж, өвдгөөр нь хатгуулж толгой нь дүйрч, бүсэлхийгээр тэсвэрлэхийн аргагүй өвдөж байна гэж гомдоллов. Түүнийг эрэг өөд аваачихаар болж Жакопо удирдан босгох гэтэл дуу тавин орилж, хөдөлгөхөөр тэсэхийн аргагүй өвдөж байна гэж хэлэв.

Дантес янгирын мах идэхтэй мантай байгаа нь мэдээж байлаа. Харин өөр шигээ бацаг барих шалтгаангүй хүмүүсийг хоол уруу буцаж очихыг шаардав. Эдмоны хэлж байгаагаар, өөрт нь амрах л хэрэгтэй бөгөөд, тэднийг буцаад ирэхэд бие сайн болчихсон байх биз гэж итгүүлэв.

Далайчид удаан гуйлгаад байсангүй. Тэд өлссөн бөгөөд шарсан махны үнэр ханхална. Ер нь тэнгисийн чонууд өөр хоорондоо ёсорхож нэрлэхээд байдаггүй улс.

Тэд нэг цагийн дараа буцаж ирэв. Энэ хооронд Эдмоны хийж чадсан юм гэвэл хэдэн алхам мөлхөж, хөвд нэвсийн ургасан хад налж суусан байлаа.

Гэвч өвчин нь намдаагүйгээр барахгүй улам ч ихэссэн юм шиг байлаа. Пьемонт Францын хил дээр, Ницц, Фрежюс хоёрын хооронд бараагаа буулгахын тулд өглөөдөө хөдлөх ёстой байсан хөгшин ахмад Дантесыг босохыг шаардав. Дантес хүний хүчнээс хэтэрсэн их хүч гаргаж хүслийг нь биелүүлэх гэсэн боловч өндийх гэж оролдох бүрдээ царай нь зэвхийрэн зовиурлаж унана.

- Энүүний хавирга нь хугарчихаж гэж ахмад шивнэн хэлээд - Ялгаагүй, энэ бол сайн нөхөр орхиж болохгүй онгоцондоо ямарч байсан аваачихыг хичээцгээе гэв

Гэвч Дантес өчүүхэн төдий хөдлөхөд өвчинг тэсвэрлэж байхын оронд энэ байрандаа үхсэн дээр гэж хэлэв. Тэгэхэд ахмад,

- За яах вэ юу л болбол болог. Тан шиг ийм сайн хүнийг тусламж дэмжлэггүй хаяж явлаа гэж хүмүүс биднийг бүү муу хэлэг. Бид үдээс нааш зангууг өргөж замд гарахаа больё гэж хэлэв.

Энэ үгийг далайчдын нэг нь ч татгалзаагүй боловч ихэд гайхацгаав. Тэд ахмадынхаа нарийн чанд хүн болохыг мэдэх бөгөөд өөрийн бодол саналаас татгалзах буюу түүнийгээ гүйцэтгэх явдлыг хойшлуулж байсан удаагүй ажээ. Тийм учраас Дантес өөрөөс нь болж хөлөг онгоцон дээр тогтсон ёс журмыг урьд өмнө үзэгдээгүйгээр ингэж эвдэн зөрчихийг зөвшөөрсөнгүй.

- Үгүй, би өөрөө буруутай хэрэг хийсэн учир, авхаалж самбаагүй явдалдаа цээрлэл үзэх ёстой. Надад бага зэрэг хатаасан талх, буу, дарь, сум орхиорой. Янгир ямаа буудах ч юм уу эсвэл биеэ хамгаалахад ч хэрэг болж магадгүй. Бас та нарыг саатвал оромж барихад хэрэг болох зээтүү өгөөрэй гэж хэлэхэд, ахмад,

- Үгүй чи өлсөж үхнэ шүү дээ гэж хэлэв.

- Би тэсвэрлэшгүй өвдөж зовсноос үхсэн нь дэSp гэж үзэж байна гэж Эдмон хариулав.

Ахмад аян замд гарахаар бэлэн болсон «Амелии» давлагаан дээр дайвалзан байгаа тэнгисийн бяцхан зогсоол өөд харав. Тэгээд,

- Мальт хархүү чамайг бид явал дээр вэ? Бид чамайг хаяж явж чадахгүй, бас бид эндээ байгаад байж болохгүй гэж хэлэхэд Дантес,

- Явцгаа! Гэж хариулав.

- Бид долоо хоногоос доошгүй эзгүй байх болно. Бас тэгээд чамайг авах гэж замаасаа гажиж ирэх нь гэж ахмад хэлэв.

- Тэгвэл ингэе л дээ. Хэрвээ хоёр гурав хоногийн дараа наашаа чигтэй явж байгаа загасчны буюу өөр ямар нэг завь дайралдвал намайг авахыг захиж явуулаарай. Би хорин таван пиастр төлөөд Ливорнод хүрч очъё. Хэрвээ ямарч хүн дайралдахгүй бол өөрсдөө хүрээд ирээрэй гэв.

Ахмад толгойгоо сэгсрэв.

- Ахмад Бальдий та миний хэлэхийг сонсооч, бүхнийг зохицуулах арга байна гэж Жакопо хэлээд - Та нар явцгаа би шархадсан хүнтэй хоцорч сувилж байя гэв.

- Чи хоцроод олз хуваахад ногдох хувиа авахгүй татгалзах гэж үү? Гэж Эдмон асуухад,

- Тийм ээ, огт харамсахгүй байна гэж Жакопо хариулав.

- Жакопо чи сайн санаатай хүн юм, чиний энэ сайн сэтгэлийг бурхан шагнаг. Би чамд баярлалаа, надад хэн ч хэрэггүй. Нэг хоёр өдөр амраад зүгээр болчих байх. Энэ хадны хооронд шарх сорви эдгээх эмийн сайн өвс байдаг байх гэж бодох юм гэж Дантес хэлэв.

Тэгээд Дантесын уруул дээр эгзэгтэйхэн инээмсэглэл тодров. Тэр Жакопогийн гарыг чанга атгаж арал дээр үлдэх үлдэхдээ ганцаар а үлдэхийг буцалтгүй шийджээ.

Хориотой бараа зөөж худалдагчид Эдмонд хүссэн бүхнийг нь үлдээгээд, байн байн эргэн харж найрсгаар салах ёс гүйцэтгэхэд Эдмонд хөдөлж чадахгүй байгаа юм шиг зөвхөн өрөөсөн гараа өргөн хариулав.

Тэгээд тэдний бараа тасрахад Дантес инээд алдав.

- Хачин юм даа ийм хүмүүсийн дотроос үнэнч шударга нөхөрсөг явдал гарах гэж! Хэмээн шивнэв.

Дараа нь өөрийг нь тэнгисээс халхалсан хадны орой өөд болгоомжтой мөлхөж гараад бэлтгэлээ дуусгаад зангуугаа өргөн далавчаа дэлгэж байгаа цахлай шувуу шиг хөнгөнөөр ганхаж байснаа хөдлөн яваа бэсрэг онгоцоо үзлээ.

Цагийн дараа онгоц үзэгдэхээ болив. Үгүй дээ л шархтай хүний хэвтэж байгаа газраас харагдахгүй болжээ.

Тэгэхэд Дантес жанжуу гүйлс, голт борын сөөг дундуур энэ хоосон арал дээгүүр үсчин явдаг гөрөөснөөс илүү хөнгөн гавшгай ухасхийн босож нэг гартаа буугаа, нөгөө гартаа зээтүүгээ шүүрэн авч, өнөөх тэмдэг тавьсан хадныхаа төгсгөлд хүрч очив.

Тэгээд Фариагийн ярьж өгсөн арабын загасчны тухай үлгэрийг санаж,

- Аа, одоо, одоо Сезам, онгойгоорой! Гэж хэлэв.

3. Эрдэнэсийн туяа

Нар бараг замынхаа гуравны нэгийг туулж тавдугаар сарын амьдруулагч халуун илч нь цохио хадан дээр тусаж, тэдгээр нь халуун илч тусаж байгааг мэдэрч байх шиг санагдана. Хонин арцан доогуур нуугдан байсан мянга мянган дэвхрэг нэгэн янзын дуугаар зогсолтгүй шаагилдаж, жанжуу гүйлс, чидунгийн модны навчис бараг төмрийн дуу шиг шаржигнана. Наранд ээгдсэн боржин хадан дээгүүр яваа Эдмоны алхах бүрд оюу шиг ногоон гүрвэлүүд айн гүйлдэнэ. Алсад уулын энгэрээр анчдын дурыг татсан гөрөөс гүйлдэнэ. Энэ арал нь ан амьтантай амьдралаар дүүрэн боловч Эдмонд бурхны мутар дор орь ганцаараа байгаа юм шиг санагдаж байлаа.

Айж ч байгаа юм шиг хачин сэтгэгдэл түүнийг эзэмдэн авав. Хүн хойноос нь ажиглан хараад ч байгаа юм шиг санагдулдаг өдрийн хурц гэрэл энэхүү айдасын шалтгаан болжээ.

Энэ сэтгэгдэл нь, ажилдаа орохын өмнө зээтүүгээ хойш тавиад буугаа авч хадны орой өөд дахин авирч орчин тойрныг анхааралтай харахаар тийм хүчтэй байв.

Гэвч түүний анхаарал нь байшин нь ч харагдаж байгаа яруу сайхан Корсик, бараг мэдэж танихгүй Сардини их хэрэг явдлыг санагдуулсан Эльба, тэнгэрийн хаяанд үл мэдэг цэг мэт торойх авч далайчин хүний туршлагатай нүдээр харвал гайхамшигт сайхан Генуя ба худалдааны хот Ливорно болох нь танигдах тэдгээр хотуудад татагдсангүй. Харин түүний харц нь үүрээр хөдөлсөн хөлөг онгоц ба тун саяхан тэнгист гарсан бэсрэг онгоц хоёрыг хайж байлаа.

Түрүүчийнх нь Бонифациевын хоолойгоор орж харагдахгүй болсон байсан ба хоёр дахь нь нөгөө тийшээ Корсикийн эргийг дагаж тойроход ойртон явж байв.

Эдмон үүнийг хараад сэтгэл нь тайвшрав.

Тэгээд ойр байгаа зүйлүүдээ харав. Тэгэхэд шовх хадан арлын хамгийн өндөр орой дээр гарчихсан нь, бат бөх том суурин дээр байрлуулсан бяцхан хөшөө шиг өөрт нь санагдав. Доод талд нь нэг ч хүнгүй эргэн тойронд нь нэг ширхэг ч завь байхгүй, хадны хормой мөргөн долгиж эргийн боржин хадан дээр мөнгөлөг эмжээр үлдээж байгаа хөх цэнхэр тэнгис л харагдаж байлаа.

Тэгээд яаруу боловч болгоомжтойгоор хаднаас бууж эхлэв. Тэр өнөөх гайхамшигтай сайхнаар жүжиглэж үзүүлсэн шиг золгүй явдал үнэхээр тохиолдох вий гэж болгоомжилж байлаа.

Дантес, бидний дээр хэлсэнчлэн хадан дээр гаргасан тэмдгүүдийг дагаж буцаж явсан бөгөөд жижиг онгоц тэнд орж нуугдаж болохоор ажээ. Тэгэхээр нь ширээт лам Фариагийн ухаалгаар ээдрээг нь тайлсан утасны учгийг даган үзвэл, Спада хамба хүнд харагдахгүйн тулд жижиг онгоцоо энэ буланд нууж орхиод, хадан дээр тавьсан тэмдгийг дагаж яваад хүрэх тэр мухарт эрдэнэсийн сангаа нуусан байж таарав. Дантесын энэ санаа түүнийг нөгөөх дугараг чулуунд дахин хөтөлж ирэв.

Харин нэгэн зүйл түүний сэтгэлийг зовоож хүчтэй хөдалайчинөлийн тухай төсөөллийг нь бужигнуулаад хаячихав. Тав зургаан мянган фунт ийм хүнд булууг энэ суурин дээр их хүч гаргалгүйгээр яаж авчирч тавиа юм бол?

Гэтэл Дантест нэг ухаан төрж,

- Чулууг ерөөсөө өргөөгүй, зүгээр л дээрээс өнхрүүлж авчирсан байж болох юм гэж өөртөө хэлэв.

Тэгээд энэ чулууны анх байсан газрыг олохоор яаран дээш өгсөв.

Үнэхээр чулуу өнхөрсөн байж болохоор ташгай газрыг олж үзэв. Өөр нэг хэлтэрхий хад түүнийг тулан зогсоосон бололтой. Чулууны эргэн тойронд хайрга чулуу овоорч дээгээсээ үр шимтэй хөрсөөр даруулан түүн дээр нь өвс ногоо ургаж,

хөвдөөр хучигдан жанжуу гүйлс, арцны найлзуур нахиалан одоо энэ том чулуу ургаа хаднаас ялгагдахын аргагүй болжээ.

Дантес болгоомжтойгоор газрыг ухангаа энэхүү зальжин ажлыг тааварласан буюу ер нь ч таачихлаа хэмээн бодов.

Тэгээд цагийн эргэлтэд бэхэжсэн завсрын энэ ханыг зээтүүгээрээ ухаж гарав.

Арваад минут ухтал хана нь цоорч, гар шургуулж болохоор нүх гарч ирэв.

Дантес тэнд дайралдсан хамгийн бүдүүн чидун мод огтолж мөчрий нь цэвэрлэж хаяад түүнийгээ өнөөх нүхээрээ шургуулж хөшүүрэг болгон хэрэглэв.

Гэвч чулуу нь ганц хүн хэдий геракл лугаа адил хүчтэй байлаа ч гэсэн байрнаас нь хөдөлгөж чадахааргүй хүнд бөгөөд доод чулуундаа бат бэхээр суурилсан байлаа.

Тэгэхээр нь Дантес юуны өмнө тулгуур болгосон чулуугий нь авч хаяхаар шийдэв.

Гэвч түүнийг яаж авч хаях вэ?

Тэгээд гайхаш нь тасран ийш тийшээ харж байтал Жакопын орхисон дарьтай эвэр нүдэнд тусав.

Энэ адтай нээлт тус болно гэж бодохоос инээмсэглэв.

Дантес газар ухагчид урт удаан хүнд ажлаас зайлсхийж ухдаг шигээр хоёр чулууны хооронд мин суулгах зай гаргаж малтав. Энэ нүхэндээ дарь дүүртэл хийгээд алчуураа урж, догшин шүүнд дүрэн гол хийгээд дараа нь түүнийгээ шатаа, орхиод бушуухан зайлав.

Удаан хүлээлгэсэнгүй дэлбэрэлт боллоо.дээд чулуу нь д рины хэмжээлшгүй их хүчинд өргөгдөж доорд талын чулуу нь хэдэн хэсэг болон бутр в. Дантесын гаргасан жижигхэн нүхнээс хэдэн мянган хорхой шавьж хуйлран гарч, энэ нууц амны манаач том могой цагираглан хөхөвтөр биеэ задалж ум хумгүй алга боллоо.

Дантес ойртож ирэв. Түшиг тулгуургүй болсон дээд талын чулуу ангалын ирмэг дээр дэнжийж байлаа. Аймшиггүй эрүүлч манай хүн чулууг тойрон хараад хамгийн амархан ганхах газрыг олж хөшүүрэг дээрээ Сизиф лугаа адилаар хамаг хүчээрээ дарав.

Доргин хөдөлсөн чулуу ганхахад Дантес улам хүчтэй дарж бурхадтай тэмцэхийн тулд цохио хад авч хаяж байгаа аварга хүчтэнтэй адил байлаа. Тэгээд

эцсийн эцэст чулуу нь дийлдэж, эргэлдэн үсчиж, тэнгисийн эргүүлэгт орон далд оров.

Түүний доор дундаа төмөр гогцоотой дөрвөлжин чулуутай дугараг талбай ил гарчээ.

Дантес эхний оролдлого нь амжилттай болсонд баярлан хашхирлаа!

Цааш нь ухах гэсэн боловч өвдөг нь чичрэн, зүрх нь хүчтэй цохилж, нүдийг нь халуун манан бүрхсэн тул арга буюу ажлаа зогсоов.

Гэвч энэ зогсолт нь хором зуур л үргэлжлэв. Эдмон цагирагны нүхээр хөшиж өргөвөл дөрвөлжин чулуу нь өргөгдөж доор нь харанхуй агуй тийш эгц одсон шат маягийн юм харагдлаа.

Өөр хүн байсан бол баярлан хашхираад тэр уруу харайн орох байсан биз. Дантес царай нь зэвхийрэн, бодлого болон зогсов.

- Байз! Гэж өөр зуу^оаа хэлээд -Эр хүн шиг байх хэрэгтэй. Би золгүй явдалтай нүүр учирч сурсан хүн, арга тасрах явдал намайг мохоохгүй. Зовж зүдэрсэ минь намайг юунд ч сургаагүй гэж үү? Горьдол найдварын бүлээн үлээлтэд хэтэрхий хөөсөн зүрх жинхэнэ үнэн байдлын эвгүй хүйтнийг үзээд гэнэт агшин багасгадаг бус уу? Фариа дэмий солиорон, Спада хамба энэ агуй дотор юу ч булаагүй хэзээ ч энд ирж байгаагүй байж мэдэх юм. Ирсэн байлаа ч гэсэн аймшиггүй эзэрхэг, эцэж цуцахыг мэдэхгүй хар дээрэмчин Цезарь Боржиа мөрөөр нь над шиг л хаданд тавьсан тэмдгийг даган явж энэ чулууг өргөөд надаас өмнө энэ агуйд ороод надад юу ч үлдээгээгүй байж мэднэ гэв.

Гүнзгий хар нүх уруу харж, минут хэртэй хөдлөлгүй зогслоо.

Хувь заяагий нь алаг эрээн болгосон, ер бишийн хэрэг явдлууд хольцолдон нийлсэн хааны нэр зүүсэн тэр дээрэмчин ийм юм хийж элбэг чадна. Энэ үлгэрийн аялал нь түүний алдар гавьяаны нэгэн чухал мөчир нь байж болно. Боржиа нэгэн цагт нэг гартаа бамбар, нөгөө гартаа илд барьж энд ирэхэд, түүнээс хориод алхмын зайтай, магадгүй энэ хадны дэргэд омогт баргар царайтай хоёр манаач зогсож, газар тэнгэр, тэнгисийг соргоогоор ширтэн харж зогсоход тэдний эзэн нь одоо миний орох гэж байгаа шиг гал бадруулсан аймшигт гараараа харанхуйг зүсэн гэрэлтүүлж энэ агуйд орсон байх.

Үгүй, тэгээд өөрийнхөө нууцыг итгэж мэдэгдчихсэн хоёр манаачаа яагаа бол? Гэж Дантес өөрөөсөө асуугаад,

- «Яах вэ дээ, Аларихийн ясчингуудыг алаад хамт оршуулчихсантай л адил юм болоо байлгүй» гэж хариулав.

Тэгээд Дантес цааш нь үргэлжлүүлэн «Хэрвээ Боржиа энд ирсэн бол эрдэнэсийн санг олоод аваад явчихсан байх ёстой. Италийг алтарганатай адилтган түүнийг навчийг нь нэг нэгээр нь сугалан авч асан Боржиа цаг хугацаа ямар үнэтэй болохыг сайн мэдэх учир энэ чулууг хуучин байран дээр нь буцааж тавих гэж цаг алдахгүй байсан биз». Ингэхлээр агуйд ороод үзье» гэж хэлэв.

Тэгээд итгэлгүйхэн шиг инээмсэглэж, хүн төрөлхтний мэргэн цэцэн ухааны сүүлчийн үг болох «Магадгүй!...» гэдэг үгийг аман дотроо шивгэнэсээр шат уруу хөлөө тавив.

Гэвч түүний бодож байснаар энд бүтэж үхмээр агаартай, харанхуй нүх байсангүй, харин зөөлөн хөхөвтөр бүдэг газар байхыг Дантес олж үзэв. Энд зөвхөн түүний ухсан нүхээр агаар гэрэл орж ирж байсангүй, харин гадна талаас нь ажиглагдан харагдахгүй хад чулууны завсраар хөх тэнгэр, царс модны хээ татсан ногоон навчис, мөлхөө үүргэний өргөст мөчир харагдана.

Чийгтэй нойтон биш, харин гадны агаараас илүү зөөлөн агаартай, нарны хурц гэрлээс зөөлөн бүдэг хөхөвтөр гэгээтэй энэ агуйд харанхуйн дотор юм үздэг чадвартай Дантес хэдэн хором зогсохдоо хамгийн холын буланг нь ч харж амжив. Агуйн хана нь боржин чулуу бөгөөд, жижигхэн гялтгар хэсгүүд нь очир алмас мэт гялалзана.

- Ай хөөрхий! Гээд Эдмон инээмсэглэж хамбын үлдээсэн эрдэнэсийн сан гэдэг нь энэ юм байх даа зайлуул сайн санаатай ширээт лам зүүдэндээ энэ гялалзсан ханыг нь хараад горьдлогоор дүүрсэн юм байжээ гэж хэлэв.

Гэвч Дантес цээжээр мэдэж байсан өнөөх гэрээс бичгийн үгийг санаж «Хоёрдугаар нүхний хамгийн цаад талын буланд» гэж бодов.

Тэр зөвхөн эхний нь агуйд орсон бөгөөд, одоо хоёр дахь агуйд орох амыг нь олох хэрэгтэй байлаа.

Дантес эргэн тойрон харав. Хоёр дахь агуй нь арлынхаа төв уруу чиглэн явсан байх ёстой. Тэгээд тэр, ихэд болгоомжлон хаалга болгож хийсэн болов уу гэж бодсон том дөрвөлжин чулуу бүхнийг цохиж үзэв.

Зээтүү нь хатуу боржин чулуу цохих цул дуу хэдэн минутын туршид сонстоход Дантесын духанд хөлс чийхрав. Тэгж тэгж эцсийн эцэст эцэж цуцашгүй эрдэнэсийн уурхай ухагчид маань боржин чулуун хана арай хөндий бүгт дуугарах сонстов. Эдмон хана уруу ширтэн харж, хоригдол хүнээс өөр хэн ч ойлгохгүй байсан тэр зүйлийг ойлгов. Энд л өнөөх нүх байх ёстой.

Гэвч Цезарь Боржиагаас дутаагүйгээр цагийг хайрлан үздэг. Дантес дэмий хөдөлмөрлөхгүйн тулд бусад хануудыг нь зээтүүгээр цохиж туршин, бууныхаа

бөгсөөр газар тоншиж, сэжигтэй газрууддаа элсийг нь ухаж үзээд, юу ч мэдэгдэхгүй болохоор нь өнөөх горьдлоготой дуу гарсан газраа буцаж ирэв.

Тэр дахин их хүчтэйгээр цохив.

Гэтэл зээтүүний нь үзүүр хүрсэн газраас байшингийн ханын шавар шиг юм ховхрон ойчиж цаанаас нь барилгын ердийн чулуу шиг зөөлөн цагаан чулуу цухуйн гарахыг хараад гайхав. Хадны нүхийг энэ чулуугаар таглаж дээрээс нь шаваас тавиад боржин чулуу шиг өнгөлжээ.

Тэгэхээр нь Дантес зээтүүнийхээ хурц үзүүрээр цохиход хана уруу ямх хэртэй шигдэн оров.

Эрэх хэрэгтэй газар нь энэ ажээ.

Дантес, Фариаг эндүү ташаа юм яриагүй юм байна гэдгийг улам бүр нотлон мэдэх тусмаа хүнд байдаг хачин жигтэй араншингаар улам их эргэлзэн, арга нь барагдан гонсойход ойрхон байлаа. Түүнд эрэлхэг зориг өгөх ёстой мэт санагдах энэ нээлт нь харин түүний бүх хүч чадлыг шавхан авчав. Зээтүү нь ханан дээгүүр хальтирч гараас нь арай л мултарч ойчсонгүй. Тэгэхээр нь түүнээ газар тавиад духныхаа хөлсийг арчиж, хүн харж байгаа юм биш байгаа гэж аман дотроо хэлээд, үнэндээ бол цэвэр агаар амьсгалах гэж агуйгаас гарав. Түүний дотор нь муухай болж ухаан балартан унамаар санагджээ.

Арал дээр нэг ч хүн байсангүй, өндөр мандсан нар халуун илчээрээ төөнөнө. Алсад загасчны завинууд далбаагаа дэлгэн хөх цэнхэр тэнгис дээгүүр хөвнө.

Дантес өглөөнөөс хойш юм идээгүй боловч, юун юм идэхтэй мантай ром архинаас ганц балгаад агуйдаа буцаж ирэв.

Хачин хүнд юм шиг санагдаж байсан зээтүү нь хөнгөрсөн юм шиг санагдаж, өд шиг өргөж аваад шаламгай гэгчээр ажиллаж гарав.

Дантес хэд цохиод, чулуунууд нь хоорондоо юугаар ч бэхлэгдээгүй харин дээр дээрээс нь зүгээр тавиад бидний дээр хэлсэнчлэн шавраар шавардсан болохыг мэдэв. Тэгэхээр нь нэг завсраар нь зээтүүнийхээ үзүүрийг шургуулж ишин дээр нь гөнжин дарахад түүний хөлд чулуу унаж ирэв.

Ингэсний дараа Дантес чулуунуудыг нэл нэгээр нь зээтүүнийхээ үзүүрээ татаж, түрүүчийн унасан чулуун дээрээ унагав.

Дантес тэр гаргасан нүхээрээ орчхож болох байсан боловч итгэлээ холдуулж, горьдлогоо хадгалах гээд оролгүй удааширсаар байлаа.

Тэгээд Дантес эргэлзэхийн сүүлчийн минутыг давж хоёр дахь агуйд оров.

Орсон агуй нь эхнийхээсээ намхан, харанхуй бүдэг байлаа. Дөнгөж сая онгойлгосон нүхээр сад тавьж байгаа агаар нь эхний агуйнх шиг биш хүнд чийгтэй, муухай үнэртэй байлаа.

Энэ үхсэн чийгийг гаднын цэвэр агаар орж ирж цэвэрлэтэл Дантес хүлээж байгаад орж явчлав.

Орсон нүхний нь зүүн гар талд харанхуй гүн булан байна.

Гэвч Дантест харанхуй гэж байдаггүйг бид дээр хэлсэн билээ.

Эдмон тэр агуйг эргэн тойрон харахад, түрүүчийн агуй шигээ хөндий хоосон байлаа.

Хэрвээ өнөө эрдэнэсийн сан үнэхээр байгаа бол энэ харанхуй буланд л байх ёстой.

Дантес булан уруу очоод гэнэт шийдэмгий зориг гаргаж газар ухаж эхлэв.

Тав зургаан удаа цохисны дараа зээтүүнд нь төмөр дайралдав.

Гашуудал ба түгшүүрийн дуу хэзээ ч, хэнд ч ийм хачин сэтгэгдэл төрүүлж байгаагүй байх.

Хэрвээ Дантес юу ч олоогүй бол ингэж их царай нь зөвхийрэхгүй байх биз.

Тэр өөр газар уруу зээтүүгээрээ цохиход мөн ийм эсэргүүцэл тохиолдсон боловч дуу нь өөр байлаа.

- Төмөр бүслүүртэй модон авдар байх нь ээгэж дотроо хэлэв.

Яг энэ үед ямар нэгэн юм гэрлийг нь халхлан хурдан өнгөрөв.

Дантес зээтүүгээ тавиад, буугаа шүүрэн авч, агуйгаас гүйн гарав.

Янгир ямаа агуйн үүдний дэргэдүүр өнгөрч, өөрөөс нь хэдхэн алхмын зайтай газар идээшилж байв.

Энэ нь хоол бэлтгэж авах тохиромжтой тохиолдол байсан боловч Дантес буун дуу гаргаж хүний анхаарал татчихаж магадгүй гэж айв.

Эдмон бодож байснаа, дараа нь давирхайтай мод хугалж аваад хориотой бараа тээн худалдаачдын мах шарж байсан галаас асааж аваад бамбараа барьж агуйдаа буцаж ирэв.

Бүх зүйлийг нэгд нэггүй үзэх гэж боджээ. Тэгээд өнөөх бамбараа хамаа намбаагүй ухсан газраа авчирч эндүүрсэнгүй гэдгээ мэдэж авлаа. Зээтүү нь төмөр, мод хоёр дээр ээлжлэн тусаж байжээ.

Бамбараа газарт хатгаж орхиод ухаж гарав.

Хэдэн минутын дотор гурван фут урт, хоёр фут өргөн газар цэвэрлэж, төмөр бүслүүртэй царс модон авдар байхыг харав. Авдрын таган дээр Спадагийн удмын сүлд болох их хамбын овоодойгоор титэмлэсэн италийн зууван бамбай дээр үзүүрий нь доош хатгасан сэлмийг дүрсэлсэн газар доор ч өнгөө алдаагүй мөнгөн товч хадсан байв.

Дантес энэ сүлдийг дор нь танив. Ширээт лам Фариа хичнээн ч олон удаа зурдаг байлаа даа!

Одоо эргэлзэх юмгүй боллоо. Эрдэнэсийн сан энд байгаа ажээ. Хоосон авдрыг хэн ч ингэж нандигнан нуухгүй.

Дантес минутын дотор авдрыг тойруулан шороог цэвэрлэв. Эхлээд дээд талын цуурга, дараа нь зүүлттэй хоёр цоож, дараа нь хажуу талын сэнж гарч ирэв. Энэ бүхнийг гойд чадварлагаар урлаг хийжээ.

Дантес авдрын сэнжнээс барьж өөд нь татах гэсэн боловч бүтсэнгүй.

Тэгэхээр нь авдрыг онгойлгох гэсэн боловч түгжээ цоож нь маш их бат бэх байлаа. Эдгээр үнэнч хамгаалагчид, өөрсдөд нь хариуцуулсан эрдэнэсийн санг өгөхгүй гэсэн мэт байлаа.

Дантес зээтүүнийхээ хурц үзүүрийг авдрын хана, таг хоёрын завсраар шургуулж ишин дээр нь дарахад таг нь шажигнан дуугарав. Өргөн нүх гарч төмөр бүслүүр ч суларч байснаа эвдэрхий банзтай зууралдан зууралдсаар тасран авдар онгойв.

Дантес байдгаараа дагжин чичрэв. Тэгээд бугаа авч, гохыг нь сойгоод дэргэдээ тавив. Эхлээд бүдэг харанхуй дотор түрүүчийнхээ үзсэнээс улам олон од үзэх гэж хүүхэд нүдээ аньдаг шиг нүдээ хэсэг аниад дараа нь нээвэл нүд нь гялбасандаа нэг хэсэгтээ таг боллоо.

Авдар дотор гурван өрөө байлаа.

Эхний өрөөнд алтан зооснууд улбар туяа татуулан байна. Хоёр дахид нь засаж янзлаагүй, үнэ цэн, жингээ хадгалсан алтан цутгамлууд байна.

Сүүлчийн тэхий дундаа хүртэл дүүрсэн гурав дахь өрөөний бөөн очир алмас, сувд, бадмаараг, эрдэнэн дотор Дантес гараа дүрж, атган авч асгахад шилэн дээр шаагих мөндөр шиг чимээ гарна.

Дантес энэ зүйлийг ханатлаа харж алт үэт чулуунд чичирсэн гараа хэдэн удаа дүрснээ галзуурахад ганц хуруу дутуу хүн шиг ухасхийн агуйгаас гарав. Тэгээд нөгөө цохион дээр гарч тэнгис уруу харахад юу ч нүдэнд торсонгүй. Өөрөө эзэн нь болсон үзэгдэж дуулдаагүй, тоолж баршгүй их баялгаас өөр юмгүй ганцаараа байлаа. Үнэхээр ийм байна уу, эсвэл зүүдэлж байна уу? Энэ бүхэн нь түүний нүдэнд үзэгдсэн эгшин зуурын хий үзэгдэл үү, эсвэл үнэхээр ийм үнэт баялгийг гартаа барьж үзээ юу?

Алтаа үзье гэсэн сэтгэл нь тэмүүлэх боловч яг энэхэн үед үзэж чадах тэнхэл хүрэхгүй гэдгээ мэдэрч байв. Ухаан нь гараад арилчих гэж байгаа юм шиг хоёр гараараа толгойгоо бариад арал дээгүүр ухаан жолоогүй, зам харгуй ч гэж юм байхгүй янгир ямаа, тэнгисийн шувууг үргээн муухай хашхиран, хачин татганан савчиж гүйв. Монте Кристо арал дээр зам харгуй ч гэж байсангүй. Дараа нь тойруу замаар буцаж ирээд бас л өөртөө итгэлгүй хэвээр эхний агуйд орж, тэндээсээ дараачийн агуйд харайн ороход, алт очир алмасын уурхай нь өмнө нь байсаар байгааг харав.

Энэ удаад өвдөг дээрээ сөхрөн суугаад, хоёр гараа догдолсон зүрхэн дээрээ дарж, ганцхан бурхан л ойлгохоор мөргөлийн ном шивнэв.

Тэгээд жаахан байзнасныхаа дараа тайвширч, түүнийхээ хамт жаргалтай боллоо. Зөвхөн одоо л аз жаргалдаа итгэж эхлэв. Тэгээд баялгаа тоолж гарав. Авдар дотор тус бүр хоёроос гурван фунт хүнд мянган ширхэг цул алтан цутгам л байв. Дараа нь хутагт хамба лам VI Александр ба түүний өмнөх хамбуудын дүрстэй, одоогийн мөнгөөр нэг бүр нь наян франк хүрэх мурин таван мянган алтан зоос тоолоод зөвхөн өрөөнийхөө хагасыг нь хоослоод байгаагаа мэдэв. Тэгээд сүүлд нь сувд, очир алмас зэрэг бусад үнэт чулуунуудаасаа хоёр гараараа утган атга, атгаар нь жинлэж үзэв. Тэдний олонх нь тэр үеийн шилдэг дархчуул засаж урласан, мөнгөн үнээсээ илүү урлагийнхаа үнээр давамгайлсан эдлэлүүд байлаа.

Үдэш болох дөхөж, гэгээ бүдгэрч байв. Тэр агуй дотор байхаасаа айж, буугаа авч гадагшаа гарав. Хэсэг хатаасан талх, хэдэн балга дарс оройн хоол нь боллоо. Дараа нь хавтгай чулуугаа хуучин байран дээр нь тавиад дээр нь хэвтэж агуйн амыг биеэрээ таглан хэдэн цаг унтав.

Энэ шөнө бол энэхүү сэтгэлийн догдлолд автсан хүний хувьд тохиолдсон амттай боловч аймшигтай хоёр гурван шөнийн нэгэн байлаа.

Үл таних хүн

Өглөө боллоо. Дантес үүрээр сэрчихээд унтаагүй байлаа. Тэгээд нарны туяа тусмагц босож, урьдын адил арал дээрх хамгийн өндөр цохион дээр гарч орчин тойрныг эрэгцүүлэн харав. Хүн амьтан үзэгдэхгүй хэвээрээ байлаа.

Эдмон бууж ирээд, агуйнхаа амны чулууг зайлуулж дотор нь оров. Тэгээд хармаануудаа эрдэнэсийн чулуугаар дүүргэж аваад авдрынхаа тагийг аль болохуйц сайн таглаж, газрыг гишгэлэн, ухсан газраа мэдэгдэхгүйн тулд элс асгасныхаа дараа агуйнаас гарч аман дээр нь хавтгай чулуу тавьж, түүн дээрээ чулуу овоолоод хоорондох зайгийг нь шороогоор тэгшлэн булж дээр нь жанжуу гүйлс, хонин арцны бут суулгаад, аль хэдийнээс ургаж байгаа болгон усалж өгөөд хөлийнхөө ул мөрийг арилгаж орхиод нөхдөө буцаж ирэхийг тэсэж ядан хүлээв. Одоо тэрээр ашиг болохгүй их баялгийг хамгаалан сууж байдаг луу шиг алт, мөнгө, очир алмасаа харж нүд баясан арал дээр байх ямарч хэрэггүй болжээ. Одоо бол амьдралд, хүмүүсийн дунд эргэн орж, хүнд олдож болох хамгийн дээд зэргийн агуу их хүчин болох эд баялгаар олдох нэр хүнд, нөлөө, эрх дархыг олж авах хэрэгтэй боллоо.

Хориотой бараа тээж худалдагчид зургаа дахь хоног дээрээ эргэж ирэв. Дантес байдал ба явдлаар нь «Залуу Амелий» мөн болохыг танив. Тэгээд шархадсан Филоктет шиг онгоцны зогсоол уруу арай ядан очоод, нөхдийгөө эрэг дээр гарч ирэхэд тэдэнд бас л өвчтэй боловч нилээд сайжирсан гэж гомдоллон хэлэв. Дараа нь тэдний аялалд тохиолдсон сонин явдлуудыг сонсов. Тэд азтай явжээ. Тэд ачаагаа дөнгөж буулгаж дуусмагцаа Тулоноос харуулын хөлөг гарч тэдэн уруу ирж явна гэдгийг дуулжээ. Тэгэхээр нь «Амелий»-г тэгж их хурдан явуулж чаддаг Дантесыгаа байхгүйд харамсан яаран хөдөлсөн байв. Удалгүй хонйноосоо хөөж яваа онгоцыг хараад харанхуйг далимдуулан Корс хошууг тойрон, амар мэнд зайлж чадсан байна.

Аялал ерөнхийдөө амжилттай болж, тэд цөмөөрөө ялангуяа Жакопо Дантесыг энэ аялалд оролцон өөртөө ногдох хувь тавин пиастрыг авч чадсангүй гэж харамсаж байлаа.

Эдмон үүнд ажиг ч үгүй байлаа. Хэрвээ арлыг орхин явж чадсан бол авах байсан олзны хэмжээг хэлэхэд инээмсэглэсэн ч үгүй. «Залуу Амелий» зөвхөн өөрийг нь авах гэж Монте Кристо арал дээр ирсэн учир Дантес тэр үдэшдээ онгоцонд сууж, ахмадыг дагаж Ливорно орохоор явав.

Эдмон Ливорнод хүрч ирэнгээ наймаачин жүүд дээр очиж эрдэнэсийн чулуунаас хамгийн жижигхэн дөрвөн чулуу, тус бүрийг нь таван мянган франкаар худалдав. Тэр жүүд ийм үнэт чулуу далайчин хүнд хаанаас олдоо вэ гэж асууж болох байсан боловч чулуу бүрээс мянган франкын хожоо гарч байгаа болохоор асуусангүй дуугүй өнгөрөв.

Маргааш нь Дантес загасчны шинэ завь худалдан авч, Жакопод бэлэглээд, дээр нь далайчин хөлсөлж авах зуун пиастр нэмж өгөөд, түүнийг Марсель орж Мельяны тарималт гудамжинд суудаг Луи Дантес ба Каталаны гацаанд суудаг Мерседес гэдэг залуу бүсгүй хоёрын тухай мэдэж ирэх ганц болзол тавив.

Тэгэхэд нь Жакопо зүүдэлж байна гэж санасан боловч, Эдмон түүнд өөрийгөө эцэг эх мөнгө өгөхгүй болохоор нь зүггүйтэх дур нь хүрч далайчин болсон юм. Харин Ливорнод ирсэн чинь авга ах нь өөрийнхөө хөрөнгийг үе залгамжлуулан үлдээсэн байна гэж хэлжээ. Дантесын ихэд гэгээрэн боловсорсон байдал яриаг үнэн болохыг батлах тул, танилцаад удаагүй нөхөр нь үнэн юм ярьж байгаад Жакопо ганц минут ч эргэлзсэнгүй.

Дараа нь Дантес «Залуу Амелий» дээр ажиллах хугацаа нь дууссан тул эзэнтэй салах ёс гүйцэтгэв. Цаамаг нь түүнийг онгоцон дээрээ авч хоцрох гэсэн боловч өв хөрөнгө залгамжлан авсан гэж дуулаад хуучин далайчнаа онгоцон дээрээ үлдээч бариач гэсэнгүй.

Жакопо маргааш нь Марсель орохоор аялан одов.

Дантестай Монте Кристо арал дээр уулзахаар тохирчээ.

Мөн тэр өдрөө Дантес хаашаа явах гэж байгаагаа хэнд ч хэлэлгүй, «Залуу Амелий»-н далайчдад гомдолгүй шан хүртээгээд, хэзээ нэгэн цагт өөрийнхөө тухай мэдээ өгнө гэж ахмадад амлан хэлээд Генуя орохоор явлаа.

Эндэхийн онгоцны зогсоол дээр нэгэн англи хүн, Газрын дундад тэнгист генуэчүүд л хамгийн шилдэг онгоц баригчид хэмээн дуулаад, тийм сайн онгоцтой болох гэж захиж хийлгэсэн нэгэн бэсрэг хөлгийг шалгаж байлаа. Англи хүн хөлгийг дөчин мянган франкаар өгөөч гэлээ. Дантес тэгэхээр нь энэ хөлгийг өнөөдөр надад жаран мянган франкаар өгөөч гэлээ. Англи хүн хөлөг онгоцоо хийж гүйцэхийг хүлээнгээ Швейцарьт аялахаар явсан байв. Онгоц босгогч тэр завсар өөр нэгийг хийж амжина гэж шийдээд, энэ хөлгөө Дантест өгөхөөр боджээ. Дантес хөлөг онгоц барих газрын эзнийг жүүд наймаачны мухлагт дагуулан ирж, арын нь тасалгаанд ороход жүүд наймаачин онгоц баригчид жаран мянган франк тоолон өгөв.

Онгоц баригч Дантест онгоцон дээр нь ажиллах хүн олж өгье гэлээ. Гэвч Дантес ганцаар явдаг заншилтай гээд түүнд талархсанаа хэлээд харин орныхоо толгой дээр гурван тасалгаатай, тасалгаа тус бүр нь нууц цоожтой шүүгээ хийж өгөхийг хүсэв. Дантес шүүгээний тасалгаа бүрийн хэмжээг өөрөө хэлж өгсөн бөгөөд маргааё нь бэлхэн боллоо.

Хоёр цагийн дараа Дантес, ганцаараа аялан явж сурсан испанийн эрхэмсэг язгууртан хүнийг үзэхээр ирсэн олон хүний харсаар байтал генуегийн хөлөг онгоцны буудлаас гарч явав.

Дантес их л чадмаг жолоодно. Ганцхан жолооны хүчээр зайлшгүй чухал хөдөлгөөнийг гүйцэтгүүлэх тул дарвуулт онгоц нь өчүүхэн төдий шаардлагыг ч үг дуугүй биелүүлдэг амьд амьтан шиг байлаа. Генуэчүүд дэлхий дээр хамгийн шилдэг онгоц баригчид юм гэж алдаршсан нь шударга үнэн хэрэг байна гэж Дантес дотроо зөвшөөрч явав.

Цугласан улс тэрхүү хөлгийг далд орон ортол нь харж зогссоноо харагдахгүй болохоор нь чухам хаашаа явж байгаа тухай ярилцав. Нэг хэсэг нь Эльба уруу явсан гэх ба бас зарим нь Испани орохоор яваа хэмээн мөрий тавьж нөгөө зарим нь Африк орохоор явлаа гэлцэнэ. Хэний нь ч толгойд Монте Кристо арал гэж орж ирсэнгүй.

Гэтэл Дантес чухамхүү тийшээ явж байжээ.

Дантес хоёр дахь өдрийн үдэш арал дээр очив. Дарвуулт хөлөг нь маш хөнгөн хурдан явдаг учир гучин тавхан цаг яваад иржээ. Дантес эрэг орчмын газрыг сайн судалсан учир, онгоц зогсоолд оролгүй жижигхэн буланд орж, зангуугаа хаяв.

Арал хоосон, Дантесыг явснаас хойш хэн ч ирж буугаагүй бололтой. Агуй дотор орж, өнөөх эрдэнэсийнхээ санг байсан янзанд байхыг үзлээ.

Маргааш нь Дантес хэмжээгүй их баялгаа хөлөг онгоцон дээрээ нүүлгэн авчирч, нууц шүүгээнийхээ гурван өрөөнд хийв.

Дантес нэг долоо хоног хүлээв. Энэ долоо хонгийн турш морь шинжигч шиг арлыг тойрон явав. Энэ хугацаанд арлын бүх ашигтай, ашиггүй талуудыг мэдэж ашигтайг нь арвижуулан, дутагдалтайг нь засаж өөрчлөхөөр шийдвэрлэв.

Найм дахь хоног дээрээ Дантес бүх далбаагаа дэлгэн алар өөд ирж яваа завийг харж Жакопогийн завь мөн болохыг танив. Тэгээд дохио өгсөнд хариуд нь Жакопо дохио өгч, хоёр цагийн дараа завь хөлөг онгоцон дээр ирэв.

Эдмоны хоёр асуултанд хоёуланд нь гунигтай хариулт ирэв.

Өвгөн Дантес талийгаач болж Мерседес ор сураггүй болжээ.

Эдмон энэ мэдээг тайван сонссон боловч хойноосоо дагаж очихыг хориглоод тэр дороо эрэг дээр гарав.

Хоёр цаг болоод буцаж ирэв. Жакопогийн завинаас хоёр далайчин түүний онгоцон дээр дарвуул татаж буулгах ажлаар шилжин ирж, тэд Марселийг чиглэн явав. Эцгийгээ үхсэн байх гэж бодож байсан бөгөөд харин Мерседест ямар явдал тохиолдох нь энэ вэ?

Эдмон нууцаа илрүүлэхгүйгээр нэг ч төлөөлөгчид бүрэн заавар өгч чадахгүй ажээ. Түүнээс гадна өөр зарим мэдээ олж авах хэрэгтэй болохоор үүнийг ганцхан өөрөө л хийж чадах байлаа. Ливорнод үсчний толинд харахдаа танигдчих вий гэж болгоомжлох огт хэрэггүй юм гэдгийг мэдсэн ажээ. Түүний хамт зүсээ хувиргах бүх хэрэглүүр одоо түүний мэдэлд бий болжээ. Тэгээд нэгэн өглөө Дантесын дарвуулт хөлөг загасчны завь дагуулан Марселийн усан онгоцны буудалд шуудхан явж ооод, тэр нэгэн гайт өдөр Эдмоныг Иф цайзад аваачих гэж завинд суулгаж байсан яг тэр газар өөд харж зогсов.

Дантес өөдөөсөө ирж яваа цагдаагийн хорио хамгаалалтын завийг хараад хэнэг ч үгүй байж чадсангүй. Гэвч нэгэнт өөрийн болгосон тайван байдлаар Ливорноос худалдаж авсан Англи паспортоо ажигч үгүй гаргаж өгөв. Францад өөрийнх нь паспортоос илүү хүндэтгэдэг гадаадын энэ паспортын тусламжтайгаар эрэг дээр саадгүй гарав.

Каньебер гудамжинд хамгийн түрүүн дайралдсан хүн нь «Фараон» онгоцны далайчин байлаа. Энэ хүн, тээр жил Дантесын удирдлагад ажиллаж байсан бөгөөд Дантес өөртөө тохиолдсон өөрчлөлтийг үзэж мэдэг гэж зориуд ирж зогссон юм шиг тэнд байж байжээ. Дантес далайчин руу очоод хэдэн юм асуухад цаадах нь амьдралдаа анх үзэж байгаа огт танихгүй хүнтэй ярилцаж байгаа юм шиг хариулж байв.

Дантес түүний тайлбарт талархлаа илэрхийлэн нэг зоос авч өгөв. Минутын дараа, хөөрхий сайн сэтгэлт хүн хойноос нь гүйж ирж яваа дуулдав.

Дантес эргэж харахад,

- Уучлаарай эрхэм минь гэж далайчин хэлээд - Та андуурсан байж таарна, та надад хоёр франкын зоос өгөх гээд оронд нь давхар наполеондор өгчихсөн байна гэв.

- Чиний хэлдэг зөв, найз минь би андуурч гэж Дантес хэлээд, - Гэвч чиний үнэнч шударгыг шагнах ёстой, тэгэхээр надаас хоёр дахь алтан зоосоо авч нөхөдтэйгээ хамт миний эрүүл мэндийн төлөө уухыг хүсэж байна гэв.

- Далайчин ихэд гайхаж мэгдсэндээ баярлалаа ч гэж хэлэхэS мартчихжээ. Дантесын хойноос харж,

- Энэтхэгт л хагартлаа баяжсан хүн байх гэж хэлэв.

Дантес цааш явав. Алхам бүрд зүрх нь уяран бидний сэтгэлээс хэзээ ч арчигдан мартагддаггүй багын дуртгалууд гудамжны уулзвар, булан тохой бүрд дайралдана. Ноайль гудамжны адаг хүрч, Мельяний таримал гудамжийг харангуутаа хөл нь гуйвалж хажуугаараа явж байсан сүйх тэрэгний дугуйн доор золтой л орчихсонгүй. Тэгээд урьд нэгэн цагт эцэг нь сууж байсан байшинд хүрч

ирэв. Өвгөний хичээнгүйлэн арчилж байсан цонхон дээрх алтан лицэх цэцэг, чөдөр ороомог нь алга болжээ.

Дантес мод налж, хуучирсан байшингийн дээд давхрыг харж бодлого болон зогсов. Сүүлд нь хаалга уруу очиж, босго алхан ороод сул өрөө байна уу гэж асуув. Тавдугаар давхрын өрөөнүүд эзэнтэй байсан боловч, шалаад болохгүй болохоор нь байшингийн даамал дээш дагуулан гарч тасалгаануудыг гадаадын хүнд үзүүлэхийг суугчдаас нь гуйхад хүрэв. Хоёр тасалгаатай энэ байранд саяхан ханилж суугаад долоо хоноо ч үгүй байгаа залуу гэр бүл амьдран сууж байв. Аз жаргалтай хоёр залууг хараад Дантес гүнээ санаа алдав.

Эцэг нь сууж байсан үеийнхээс үлдсэн юм Дантест харагдсангүй. Туурганы цаасы нь солин, бага наснаас нь эхлэн сэтгэлд нь хадагдан хоцорсон эд агуурснаас юу ч үлдсэнгүй алга болжээ. Ганцхан хана нь л тэр хэвээрээ байлаа. Дантес ор уруу харахад тэр нь аавы нь ор байсан газраа байв. Эдмоны нүдэнд нулимс аяндаа бүрхэв! Энд өвгөн үхэхдээ хүүгээ дуудан амьсгаагаа хураасан ажээ.

Хөдөлгөөнгүй нүүрэн дээгүүр нь нулимс бөмбөрч байгаа энэ хүнийг хос залуу гайхан харна. Гэвч уй гашуу бүр ариун гэгээн байдаг учраас тэр хоёр үл таних хүнээс юу ч асуусангүй. Харин түүнд саад болохгүйн тулд холдсон бөгөөд түүнийг явах гэж ёс гүйцэтгэхэд тэр хоёр гаргаж өгөөд, дуртай цагтаа өчүүхэн муу гэрт минь ирж байгаарай, ирэх бүрд чинь бид таныг баярлан угтах болно гэж хэлэв.

Эдмон нэг давхраас доош буугаад нэгэн хаалганы дэргэд зогсож, Кадрусс сайван энд суудаг эсэхийг асуув. Даамал таны асууж байгаа тэр хүн үгүйрэн хоосроод одоо Белградаас Бокер орох зам дээр дэн буудал нээсэн байгаа гэж хариулав.

Дантес гадагшаа гарч, байшингийн эзний гэрийг заалган очоод лорд Уилмор (тэр тийм нэртэй паспорттой байжээ) ирлээ гэж хэлүүлэв. Тэгээд байшингийн эзнээс байшинг бүхлээр нь хорин таван мянган франкаар худалдаж авав. Хамгийн багаар бодоход арван мянган франк илүү төлжээ. Хэрвээ эзэн Дантест хагас саяар зарна гэсэн бол тэр нааш цааш ярилцахгүй өгөх байлаа.

Мөн тэр өдөртөө байшинг өгч авалцуулан нотариус ирж, залуу эр эм хоёрт, хэрвээ тэднийг одоогийнхоо сууж байгаа хоёр өрөөг суллаж өгвөл, энэ байшингаас дуртай өрөөгөө хуучин хөлсөөр хөлслөн сууж болно гэж шинэ эзэн мэдэгдэж байна гэдгийг хэлжээ.

Энэ хачин явдал бүтэн долоо хоногийн туршид Мельяны тарималт гудамжны суугчдын сонирхлыг татаж, хэдэн зуун янзаар тааварлан ярилцсан боловч нэгэнт үнэн байдалд нийцсэнгүй. Өглөө нь Мельяны тарималт гудамжны байшинд явж байсан өнөөх гадаадын хүн үдэш нь каталаны тосгонд очиж

загасчны муу ормонд орж, аль хэдийн арван таван жилийн өмнө алга болсон буюу үхэж үрэгдсэн хүмүүсийн тухай элдвийг асууж цаг гаруй суусан явдал олны бодлыг улам ч төөрөгдүүлжээ.

Маргааш нь, түүний очиж уулзсан загасчид хоёр тортой каталаны шинэ завь бэлгэнд хүлээн авчээ.

Энэ сайн сэтгэлт хүнд загасчид баяр талархлаа илэрхийлэх гэсэн боловч, урьд өдөр түүнийг нэгэн далайчинтай юм ярилцаад морь унаж Марселиас гарч Экскийн хаалгыг дамжин явчихжээ гэдгийг олж мэджээ

4. Үл таних хүн

Өглөө боллоо. Дантес үүрээр сэрчихээд унтаагүй байлаа. Тэгээд нарны туяа тусмагц босож, урьдын адил арал дээрх хамгийн өндөр цохион дээр гарч орчин тойрныг эрэгцүүлэн харав. Хүн амьтан үзэгдэхгүй хэвээрээ байлаа.

Эдмон бууж ирээд, агуйнхаа амны чулууг зайлуулж дотор нь оров. Тэгээд хармаануудаа эрдэнэсийн чулуугаар дүүргэж аваад авдрынхаа тагийг аль болохуйц сайн таглаж, газрыг гишгэлэн, ухсан газраа мэдэгдэхгүйн тулд элс асгасныхаа дараа агуйнаас гарч аман дээр нь хавтгай чулуу тавьж, түүн дээрээ чулуу овоолоод хоорондох зайгийг нь шороогоор тэгшлэн булж дээр нь жанжуу гүйлс, хонин арцны бут суулгаад, аль хэдийнээс ургаж байгаа болгон усалж өгөөд хөлийнхөө ул мөрийг арилгаж орхиод нөхдөө буцаж ирэхийг тэсэж ядан хүлээв. Одоо тэрээр ашиг болохгүй их баялгийг хамгаалан сууж байдаг луу шиг алт, мөнгө, очир алмасаа харж нүд баясан арал дээр байх ямарч хэрэггүй болжээ. Одоо бол амьдралд, хүмүүсийн дунд эргэн орж, хүнд олдож болох хамгийн дээд зэргийн агуу их хүчин болох эд баялгаар олдох нэр хүнд, нөлөө, эрх дархыг олж авах хэрэгтэй боллоо.

Хориотой бараа тээж худалдагчид зургаа дахь хоног дээрээ эргэж ирэв. Дантес байдал ба явдлаар нь «Залуу Амелий» мөн болохыг танив. Тэгээд шархадсан Филоктет шиг онгоцны зогсоол уруу арай ядан очоод, нөхдийгөө эрэг дээр гарч ирэхэд тэдэнд бас л өвчтэй боловч нилээд сайжирсан гэж гомдоллон хэлэв. Дараа нь тэдний аялалд тохиолдсон сонин явдлуудыг сонсов. Тэд азтай явжээ. Тэд ачаагаа дөнгөж буулгаж дуусмагцаа Тулоноос харуулын хөлөг гарч тэдэн уруу ирж явна гэдгийг дуулжээ. Тэгэхээр нь «Амелий»-г тэгж их хурдан явуулж чаддаг Дантесыгаа байхгүйд харамсан яаран хөдөлсөн байв. Удалгүй хонйноосоо хөөж яваа онгоцыг хараад харанхуйг далимдуулан Корс хошууг тойрон, амар мэнд зайлж чадсан байна.

Аялал ерөнхийдөө амжилттай болж, тэд цөмөөрөө ялангуяа Жакопо Дантесыг энэ аялалд оролцон өөртөө ногдох хувь тавин пиастрыг авч чадсангүй гэж харамсаж байлаа.

Эдмон үүнд ажиг ч үгүй байлаа. Хэрвээ арлыг орхин явж чачсан бол авах байсан олзны хэмжээг хэлэхэд инээмсэглэсэн ч үгүй. «Залуу Амелий» зөвхөн өөрийг нь авах гэж Монте Кристо арал дээр ирсэн учир Дантес тэр үдэшдээ онгоцонд сууж, ахмадыг дагаж Ливорно орохоор явав.

Эдмон Ливорнод хүрч ирэнгээ наймаачин жүүд дээр очиж эрдэнэсийн чулуунаас хамгийн жижигхэн дөрвөн чулуу, тус бүрийг нь таван мянган франкаар худалдав. Тэр жүүд

ийм үнэт чулуу далайчин хүнд хаанаас олдоо вэ гэж асууж болох байсан боловч чулуу бүрээс мянган франкын хожоо гарч байгаа болохоор асуусангүй дуугүй өнгөрөв.

Маргааш нь Дантес загасчны шинэ завь худалдан авч, Жакопод бэлэглээд, дээр нь далайчин хөлсөлж авах зуун пиастр нэмж өгөөд, түүнийг Марсель орж Мельяны тарималт гудамжинд суудаг Луи Дантес ба Каталаны гацаанд суудаг Мерседес гэдэг залуу бүсгүй хоёрын тухай мэдэж ирэх ганц болзол тавив.

Тэгэхэд нь Жакопо зүүдэлж байна гэж санасан боловч, Эдмон түүнд өөрийгөө эцэг эх мөнгө өгөхгүй болохоор нь зүггүйтэх дур нь хүрч далайчин болсон юм. Харин Ливорнод ирсэн чинь авга ах нь өөрийнхөө хөрөнгийг үе залгамжлуулан үлдээсэн байна гэж хэлжээ. Дантесын ихэд гэгээрэн боловсорсон байдал яриаг үнэн болохыг батлах тул, танилцаад удаагүй нөхөр нь үнэн юм ярьж байгаад Жакопо ганц минут ч эргэлзсэнгүй.

Дараа нь Дантес «Залуу Амелий» дээр ажиллах хугацаа нь дууссан тул эзэнтэй салах ёс гүйцэтгэв. Цаамах нь түүнийг онгоцон дээрээ авч хоцрох гэсэн боловч өв хөрөнгө залгамжлан авсан гэж дуулаад хуучин далайчнаа онгоцон дээрээ үлдээч бариач гэсэнгүй.

Жакопо маргааш нь Марсель орохоор аялан одов.

Дантестай Монте Кристо арал дээр уулзахаар тохирчээ.

Мөн тэр өдрөө Дантес хаашаа явах гэж байгаагаа хэнд ч хэлэлгүй, «Залуу Амелий»-н далайчдад гомдолгүй шан хүртээгээд, хэзээ нэгэн цагт өөрийнхөө тухай мэдээ өгнө гэж ахмадад амлан хэлээд Генуя орохоор явлаа.

Эндэхийн онгоцны зогсоол дээр нэгэн англи хүн, Газрын дундад тэнгист генуэчүүд л хамгийн шилдэг онгоц баригчид хэмээн дуулаад, тийм сайн онгоцтой болох гэж захиж хийлгэсэн нэгэн бэсрэг хөлгийг шалгаж байлаа. Англи хүн хөлгийг дөчин мянган франкаар өгөөч гэлээ. Дантес тэгэхээр нь энэ хөлгийг өнөөдөр надад жаран мянган франкаар өгөөч гэлээ. Англи хүн хөлөг онгоцоо хийж гүйцэхийг хүлээнгээ Швейцарьт аялахаар явсан байв. Онгоц босгогч тэр завсар өөр нэгийг хийж амжина гэж шийдээд, энэ хөлгөө Дантест өгөхөөр боджээ. Дантес хөлөг онгоц барих газрын эзнийг жүүд наймаачны мухлагт дагуулан ирж, арын нь тасалгаанд ороход жүүд наймаачин онгоц баригчид жаран мянган франк тоолон өгөв.

Онгоц баригч Дантест онгоцон дээр нь ажиллах хүн олж өгье гэлээ. Гэвч Дантес ганцаар явдаг заншилтай гээд түүнд талархсанаа хэлээд харин орныхоо толгой дээр гурван тасалгаатай, тасалгаа тус бүр нь нууц цоожтой шүүгээ хийж өгөхийг хүсэв. Дантес шүүгээний тасалгаа бүрийн хэмжээг өөрөө хэлж өгсөн бөгөөд маргааё нь бэлхэн боллоо.

Хоёр цагийн дараа Дантес, ганцаараа аялан явж сурсан испанийн эрхэмсэг язгууртан хүнийг үзэхээр ирсэн олон хүний харсаар байтал генуегийн хөлөг онгоцны буудлаас гарч явав.

Дантес их л чадмаг жолоодно. Ганцхан жолооны хүчээр зайлшгүй чухал хөдөлгөөнийг гүйцэтгүүлэх тул дарвуулт онгоц нь өчүүхэн төдий шаардлагыг ч үг дуугүй биелүүлдэг амьд амьтан шиг байлаа. Генуэчүүд дэлхий дээр хамгийн шилдэг онгоц баригчид юм гэж алдаршсан нь шударга үнэн хэрэг байна гэж Дантес дотроо зөвшөөрч явав.

Цугласан улс тэрхүү хөлгийг далд орон ортол нь харж зогссоноо харагдахгүй болохоор нь чухам хаашаа явж байгаа тухай ярилцав. Нэг хэсэг нь Эльба уруу явсан гэх ба бас зарим нь Испани орохоор яваа хэмээн мөрий тавьж нөгөө зарим нь Африк орохоор явлаа гэлцэнэ. Хэний нь ч толгойд Монте Кристо арал гэж орж ирсэнгүй.

Гэтэл Дантес чухамхүү тийшээ явж байжээ.

Дантес хоёр дахь өдрийн үдэш арал дээр очив. Дарвуулт хөлөг нь маш хөнгөн хурдан явдаг учир гучин тавхан цаг яваад иржээ. Дантес эрэг орчмын газрыг сайн судалсан учир, онгоц зогсоолд оролгүй жижигхэн буланд орж, зангуугаа хаяв.

Арал хоосон, Дантесыг явснаас хойш хэн ч ирж буюугагүй бололтой. Агуй дотор орж, өнөөх эрдэнэсийнхээ санг байсан янзанд байхыг үзлээ.

Маргааш нь Дантес хэмжээгүй их баялгаа хөлөг онгоцон дээрээ нүүлгэн авчирч, нууц шүүгээнийхээ гурван өрөөнд хийв.

Дантес нэг долоо хоног хүлээв. Энэ долоо хонгийн турш морь шинжигч шиг арлыг тойрон явав. Энэ хугацаанд арлын бүх ашигтай, ашиггүй талуудыг мэдэж ашигтайг нь арвижуулан, дутагдалтайг нь засаж өөрчлөхөөр шийдвэрлэв.

Найм дахь хоног дээрээ Дантес бүх далбаагаа дэлгэн алар өөд ирж яваа завийг харж Жакопогийн завь мөн болохыг танив. Тэгээд дохио өгсөнд хариуд нь Жакопо дохио өгч, хоёр цагийн дараа завь хөлөг онгоцон дээр ирэв.

Эдмоны хоёр асуултанд хоёуланд нь гунигтай хариулт ирэв.

Өвгөн Дантес талийгаач болж Мерседес ор сураггүй болжээ.

Эдмон энэ мэдээг тайван сонссон боловч хойноосоо дагаж очихыг хориглоод тэр дороо эрэг дээр гарав.

Хоёр цаг болоод буцаж ирэв. Жакопогийн завинаас хоёр далайчин түүний онгоцон дээр дарвуул татаж буулгах ажлаар шилжин ирж, тэд Марселийг чиглэн явав. Эцгийгээ үхсэн байх гэж бодож байсан бөгөөд харин Мерседест ямар явдал тохиолдох нь энэ вэ?

Эдмон нууцаа илрүүлэхгүйгээр нэг ч төлөөлөгчид бүрэн заавар өгч чадахгүй ажээ. Түүнээс гадна өөр зарим мэдээ олж авах хэрэгтэй болохоор үүнийг ганцхан өөрөө л хийж чадах байлаа. Ливорнод үсчний толинд харахдаа танигдчих вий гэж болгоомжлох огт хэрэггүй юм гэдгийг мэдсэн ажээ. Түүний хамт зүсээ хувиргах бүх хэрэглүүр одоо түүний мэдэлд бий болжээ. Тэгээд нэгэн өглөө Дантесын дарвуулт хөлөг загасчны завь дагуулан Марселийн усан онгоцны буудалд шуудхан явж о^оод, тэр нэгэн гайт өдөр Эдмоныг Иф цайзад аваачих гэж завинд суулгаж байсан яг тэр газар өөд харж зогсов.

Дантес өөдөөсөө ирж яваа цагдаагийн хорио хамгаалалтын завийг хараад хэнэг ч үгүй байж чадсангүй. Гэвч нэгэнт өөрийн болгосон тайван байдлаар Ливорноос худалдаж авсан Англи паспортоо ажигч үгүй гаргаж өгөв. Францад өөрийнх нь паспортоос илүү хүндэтгэдэг гадаадын энэ паспортын тусламжтайгаар эрэг дээр саадгүй гарав.

Каньебер гудамжинд хамгийн түрүүн дайралдсан хүн нь «Фараон» онгоцны далайчин байлаа. Энэ хүн, тээр жил Дантесын удирдлагад ажиллаж байсан бөгөөд Дантес өөртөө тохиолдсон өөрчлөлтийг үзэж мэдэг гэж зориуд ирж зогссон юм шиг тэнд байж байжээ. Дантес далайчин руу очоод хэдэн юм асуухад цаадах нь амьдралдаа анх үзэж байгаа огт танихгүй хүнтэй ярилцаж байгаа юм шиг хариулж байв.

Дантес түүний тайлбарт талархлаа илэрхийлэн нэг зоос авч өгөв. Минутын дараа, хөөрхий сайн сэтгэлт хүн хойноос нь гүйж ирж яваа дуулдав.

Дантес эргэж харахад,

- Уучлаарай эрхэм минь гэж далайчин хэлээд - Та андуурсан байж таарна, та надад хоёр франкын зоос өгөх гээд оронд нь давхар наполеондор₁ өгчихсөн байна гэв.

- Чиний хэлдэг зөв, найз минь би андуурч гэж Дантес хэлээд, - Гэвч чиний үнэнч шударгыг шагнах ёстой, тэгэхээр надаас хоёр дахь алтан зоосоо авч нөхөдтэйгээ хамт миний эрүүл мэндийн төлөө уухыг хүсэж байна гэв.

- Далайчин ихэд гайхаж мэгдсэндээ баярлалаа ч гэж хэлэхэS мартчихжээ. Дантесын хойноос харж,

- Энэтхэгт л хагартлаа баяжсан хүн байх гэж хэлэв.

Дантес цааш явав. Алхам бүрд зүрх нь уяран бидний сэтгэлээс хэзээ ч арчигдан мартагддаггүй багын дуртгалууд гудамжны уулзвар, булан тохой бүрд дайралдана. Ноайль гудамжны адаг хүрч, Мельяний таримал гудамжийг харангуутаа хөл нь гуйвалж хажуугаараа явж байсан сүйх тэрэгний дугуйн доор золтой л орчихсонгүй. Тэгээд урьд

нэгэн цагт эцэг нь сууж байсан байшинд хүрч ирэв. Өвгөний хичээнгүйлэн арчилж байсан цонхон дээрх алтан лицэх цэцэг, чөдөр ороомог нь алга болжээ.

Дантес мод налж, хуучирсан байшингийн дээд давхрыг харж бодлого болон зогсов. Сүүлд нь хаалга уруу очиж, босго алхан ороод сул өрөө байна уу гэж асуув. Тавдугаар давхрын өрөөнүүд эзэнтэй байсан боловч, шалаад болохгүй болохоор нь байшингийн даамал дээш дагуулан гарч тасалгаануудыг гадаадын хүнд үзүүлэхийг суугчдаас нь гуйхад хүрэв. Хоёр тасалгаатай энэ байранд саяхан ханилж суугаад долоо хоноо ч үгүй байгаа залуу гэр бүл амьдран сууж байв. Аз жаргалтай хоёр залууг хараад Дантес гүнээ санаа алдав.

Эцэг нь сууж байсан үеийнхээс үлдсэн юм Дантест харагдсангүй. Туурганы цаасы нь солин, бага наснаас нь эхлэн сэтгэлд нь хадагдан хоцорсон эд агуурснаас юу ч үлдсэнгүй алга болжээ. Ганцхан хана нь л тэр хэвээрээ байлаа. Дантес ор уруу харахад тэр нь аавы нь ор байсан газраа байв. Эдмоны нүдэнд нулимс аяндаа бүрхэв! Энд өвгөн үхэхдээ хүүгээ дуудан амьсгаагаа хураасан ажээ.

Хөдөлгөөнгүй нүүрэн дээгүүр нь нулимс бөмбөрч байгаа энэ хүнийг хос залуу гайхан харна. Гэвч уй гашуу бүр ариун гэгээн байдаг учраас тэр хоёр үл таних хүнээс юу ч асуусангүй. Харин түүнд саад болохгүйн тулд холдсон бөгөөд түүнийг явах гэж ёс гүйцэтгэхэд тэр хоёр гаргаж өгөөд, дуртай цагтаа өчүүхэн муу гэрт минь ирж байгаарай, ирэх бүрд чинь бид таныг баярлан угтах болно гэж хэлэв.

Эдмон нэг давхраас доош буугаад нэгэн хаалганы дэргэд зогсож, Кадрусс сайван энд суудаг эсэхийг асуув. Даамал таны асууж байгаа тэр хүн үгүйрэн хоосроод одоо Белградаас Бокер орох зам дээр дэн буудал нээсэн байгаа гэж хариулав.

Дантес гадагшаа гарч, байшингийн эзний гэрийг заалган очоод лорд Уилмор (тэр тийм нэртэй паспорттой байжээ) ирлээ гэж хэлүүлэв. Тэгээд байшингийн эзнээс байшинг бүхлээр нь хорин таван мянган франкаар худалдаж авав. Хамгийн багаар бодоход арван мянган франк илүү төлжээ. Хэрвээ эзэн Дантест хагас саяар зарна гэсэн бол тэр нааш цааш ярилцахгүй өгөх байлаа.

Мөн тэр өдөртөө байшинг өгч авалцуулан нотариус¹ ирж, залуу эр эм хоёрт, хэрвээ тэднийг одоогийнхоо сууж байгаа хоёр өрөөг суллаж өгвөл, энэ байшингаас дуртай өрөөгөө хуучин хөлсөөр хөлслөн сууж болно гэж шинэ эзэн мэдэгдэж байна гэдгийг хэлжээ.

Энэ хачин явдал бүтэн долоо хоногийн туршид Мельяны тарималт гудамжны суугчдын сонирхлыг татаж, хэдэн зуун янзаар тааварлан ярилцсан боловч нэгэнт үнэн байдалд нийцсэнгүй. Өглөө нь Мельяны тарималт гудамжны байшинд явж байсан өнөөх гадаадын хүн үдэш нь каталаны тосгонд очиж загасчны муу ормонд орж, аль хэдийн арван

таван жилийн өмнө алга болсон буюу үхэж үрэгдсэн хүмүүсийн тухай элдвийг асууж цаг гаруй суусан явдал олны бодлыг улам ч төөрөгдүүлжээ.

Маргааш нь, түүний очиж уулзсан загасчид хоёр тортой каталаны шинэ завь бэлгэнд хүлээн авчээ.

Энэ сайн сэтгэлт хүнд загасчид баяр талархлаа илэрхийлэх гэсэн боловч, урьд өдөр түүнийг нэгэн далайчинтай юм ярилцаад морь унаж Марселиас гарч Эксикийн хаалгыг дамжин явчихжээ гэдгийг олж мэджээ

5 «Гарийн гүүр» хэмээх дэн буудал

Над мэтийн өмнөд Францаар аялан жууулчилж явсан хүн бол Белград, Бокер хоёрын хооронд барагцаалбал хот тосгон хоёрын хооронд замын гол дунд, гэвч Белградаасаа Бокертээ арай ч ойр нэгэн бэсрэгхэн гуанз байдаг ба Гарийн гүүрийг хачин инээдтэйгээр дүрслэн зурсан зурагтай хаяг нь ялимгүй салхинд хяхнан дуугарч байдгийг нь үзсэн байх. Энэ буудал хэрвээ Рон голын урсгалыг дагаж явбал их замын зүүн талд ар талынхаа ханаар гол руу харж байдаг юм. Лангедокийнхон цэцэрлэг гэж нэрлэдэг хэдхэн намхан чидун жимсний модтой хашаалсан хэсэгхэн газар буудлын хаяанд байдаг бөгөөд тэдгээрийн завсар займхайгаар идэшний ногоо, гол төлөв сармис, улаан чинжүү, сонгино тарьсан байн. Эцэст нь буланд нь мартагдсан харуул шиг, италийн өндөр нарс тэнгэр өөд хурц оройгоо сүглийлгэн гучин градусын халуунд хатаж шарчигнах нь сонсогдоно.

Энэ бүх модод их бага алин боловч, төрөлхийн муруй тахир бөгөөд Провансын гурван хэцүүгийн нэг болох баруун хойд зүгийн салхины аясаар бөхийсөн байна. Нөгөө хоёр хэцүүг нь та мэдэх байж болно, үгүй ч байж болно. Дюранса улсын хурал хоёр юм.

Эргэн тойрон дахь том тоосгон нуур шиг талбай дээр нутгийн цэцэрлэгчид сонирхсоноосоо болоод энд тэнд тарьсан бололтой улаан буудайн түрүү энэ цөлөөр аялагчдын араас тарчигнан дуугарч байдаг царцаа дэвхэргийн суух байр л болж байдаг ажээ.

Энэ дэн буудал нь Тринетта гэдэг ганцхан зарц эмэгтэй, Пако гэдэг адуучинтай эр эм хоёрт харьяалагдаад долоон жил болж байна. Бокер ба Эг-Мортын хооронд усан суваг татаж шуудангийн морьдыг завь салаар, хөлөг өртөөний тэргийг хөлөг онгоцоор сольсон тул эд нарт хоёр зарц нь хангалттай хүрэлцэх ажээ.

Хөөрхий буудлын эзэнд гай болсон энэ суваг нь Роно ба зам хоёрын хоорондуур буудлаас зуугаадхан алхам газраар татагдан гарсан ажээ. Энэхүү буудлын тухай бид дээр товчхон боловч үнэнээр нь бичсэн билээ.

Энэ ядуу буудлын эзэн нь, дөчин тав орчим насны шөрмөслөг туранхай биетэй, гялтганасан хөнхөр нүдтэй, бүргэдийнх шиг хамартай, зэрлэг араатан шиг яралзса цагаан шүдтэй өмнөд нутгийн хүн байлаа. Хэдийгээр хөгшрөх төлөв орсон боловч, халимаг үсэнд нь өтгөн буржгар сахал шигээ энд тэнд ганц нэг цагаан үс ургасан ажээ. Түүний төрөлхийн бор царай нь морьтой явган аль нэгэн хүн ирж буух болов уу гэж өглөөний есөөс үдэш болтол үүдэндээ зогсож байдгийн улмаас бараг хар болжээ. Түүний энэ хүлээлт нь ямар ч үр ашиггүй өнгөрдөг бөгөөд испаний адуучид шиг толгойдоо зангидсан улаан алчуураас өөр юм төөнөх халуун нарнаас нүүрий нь хамгаалдаггүй байжээ. Энэ бол бидний хуучин танил Гаспар Кадрусс байлаа.

Залуудаа Мадлена Радель гэдэг нэртэй байсан түүний эхнэр нь цонхигор цагаан царайтай, өвчин эмгэгт баригдсан туранхай эмэгтэй байлаа. Энэ эмэгтэй Арль нутагт төрсөн бөгөөд нүүр царайд нь тэр нутгийн хүүхнийг алдаршуулдаг гоо үзэсгэлэнгийн төрх төлөв хадгалагдан үлджээ. Гэвч энэ царай нь Эг-мортын цөөрөм ба Камаргийн намгийн ойролцоо оршин суугчдын дунд өргөн дэлгэрсэн дотор халуун өвчнөөс болж эрт цонхийн цайжээ. Ийм учраас эмэгтэй хоёрдугаар давхарт байдаг тасалгаанаасаа бараг хэзээ ч гардаггүй бүхэл өдөржин халууран дагжин чичирч зөөлөн сандал ба орон дээр суух хэвтэх хоёрын хооронд өнгөрүүлдэг ажээ. Тэгэхэд нь нөхөр нь сурсан заншлаараа үүдэн дээрээ зогсож байдаг ажээ. Тэгээд байраа дуртай дургүй орхиж эхнэрийнхээ өрөөнд хүрч ирэхэд тэр нь хувь заяандаа үргэлжид гомдон үглэх бөгөөд тэгэхэд нь цаадах нь гүн ух антны маягаар,

- Дуугүй бай, Карконта! Бурхан ингэж таалсан юм байна гэж хариулдаг ажээ.

Мадлена Радель, Салоном Ламбеск хоёрын хоорондох Карконта гэдэг тосгонд төрсөн учир ийм өвчтэй болжээ. Тэр нутагт хүмүүс бие биеэ нэрнээс нь илүүгээр хочоор нь дууддаг учир нөхөр нь Мадлена гэдэг нэрийг хочоор нь сольж дуудах болжээ. Энэ нэр түүний бүдүүлэг ярианд дэндүү эелдэг зөөлөн санагдсан ч байж болох юм.

Хэдийгээр хувь тавиландаа захирагджээ ч гэлтэй ядуу даржин харагдавч, манай буудлын эзэн, хараал хүрсэн Бокерийн сувгаас болж ядуурсандаа гомдоллодоггүй эхнэр нь үргэлжид үглэж дуулахыг хайхардаггүй явсан гэж бодвол эндүүрэл юм. Тэр бол өмнөд нутгийн бүх хүний адил биеэ барьсан, бааздуухан хүн боловч гадна талынхаа байдлаар их л нэрэлхүү зантай хүн байв. Өнгөтэй өөдтэй явахдаа нэг ч зугаа цэнгэл баяр наадамд оролцолгүй өнгөрдөггүй, Карконттайгаа хамт ёсорхгоор хүрэлцэн ирдэг байв. Кадрусс каталан ба андалузын аль алинаас авсан гял цал болсон хувцас өмсөж, Карконта нь грег арабуудын дууриан хуулбарласан байж таарах арлын нутгийн хүүхний үзэмжит сайхан хувцас өмсдөг байлаа. Гэвч цагны оосор, хүзүүний сондор, олон өнгийн бүс, хилэн хантааз, гоёмсог сайхан торгон оймс, мөнгөн тоногтой шаахай нь алга болж, урьдынхаа гял цал байдлаар олонд харагдаж чадахаа больсон Гаспар Кадрусс эхнэртэйгээ баяр

цэнгэлд оролцохоо ч больж орлого олохоосоо илүү оргүйгээс охинтой нь дээр гэгчээр авч яваа ядмаг буудалд нь хөгжилдөн цэнгэлдэж бйгаа хүмүүсийн дуу хуур хүрч зү°хийг нь шимшрүүлнэ.

Кадрусс хуучин заншлаараа үд хүртэл гуанзныхаа үүдэн дээр зогсож, урагшаа хойшоо хоёр тийшээ явсан замын төгсгөлүүд, тахиа гүйлдэн яваа нугын зүг уйтгартайгаар харж байтал эхнэрийнхээ цангинах дууг сонсоод байраа орхин гэртээ орох хэрэгтэй боллоо. Аман дотроо үглэн буудалдаа орж хүн ирвэл манайд морилон орно уу гэсэн мэт хаалгаа дэлгэн орхиод хоёрдугаар давхрын шатаар дээш гарав.

Кадруссыг буудал руугаа орох үед харж зогссон их зам дээр өдөр тутмын хурц наранд говьд хүн амьтан харагддаггүйн адил амьд амьтны бараагүй хоосон байлаа. Энэ зам хоёр эгнээ ургасан тачирхан моддын хоорондуур хязгааргүй зурайн байх бөгөөд ийм үхмээр халуун цагаар цөл дундуур өөрийн дураар аялан явах аянчин хүн байхгүй нь тодорхой.

Хэрэв Кадрусс хуучин байран дээрээ зогсож байсан бол хэдийгээр байж боломгүй ч гэлээ Белградын зүгээс нэгэн морьтой хүн гарч ирж, морь хүн хоёрын хоорондын сайхан зохилдолгоог илэрхийлсэн жигд тайван алхаагаар галгиулан ирэхийг харах байв. Морь унасан хүн нь урт хар хувцастай үдийн халуун нар шарж байгаа боловч гурвалжин бүрх өмссөн лам хүн байв. Унасан жороо морь нь хөнгөхөнөөр хатирна.

Лам буудлын үүдэнд ирж зогсов. Дээр нь яваа хүнээ морь нь зогсоов уу, унаж яваа хүн нь зогсоов уу гэдгийн хэлэхэд бэрх байлаа. Аль нь ч байлаа гэсэн лам яаран бууж ганц нугасан дээр торж байгаа өмхөрсөн муу цохны хаалтны дэгээнээс морио цулбуураар нь уяж орхив. Дараа нь хаалга уруу очиж нүүр уруугаа урсаж байгаа хөлсийг улаан даавуу алчуураар арчаад, барьж явсан таягныхаа төмөр бөгжтэй үзүүрээр гурван удаа босгыг нь цохив.

Тэгтэл том хар нохой босож, хэд алхсанаа хуцан боргоож урт цагаан шүдээ ярзайлган архирав. Энэ бол буудалд хүн маш цөөн ирдгийн давхар баталгаа байлаа.

Ядуу оромжийн эзний хүнд нүсэр алхаан дор хана дагуулан гаргасан модон шат хяхнаж бөхийсөөр, үүдэнд зогсож байгаа лам руу нуруугаараа харж шатаар ормын эзэн бууж ирлээ.

- Очлоо очлоо, гэж маш их гайхсан Кадрусс хэлээд, - Марго чи дуугүй байна уу үгүй юу! Эрхэм минь битгий ай, давхидаг ч болсон урдаггүй юм. Та дарс уухыг хүсэж байна уу, тийм биз? Мөн золиг шиг халуун байна... гэснээ Кадрусс ямар хүнтэй ярьж байгаагаа харчихаад - Уучлаарай, чухам хэн ирснийг харсангүй. Танд юу хэрэгтэй вэ? Эрхэм ламтан танд юугаар тус болохсон бол? Гэж асуув.

Лам хэдэн хором Кадруссыг маш анхааралтай ширтэн харах нь тэрч байтугай түүний анхаарлыг өөр дээрээ татах гэсэн байлаа. Гэвч буудлын эзний царайд орж ирсэн хүнийгээ хариу дуугарахгүй байгааг гайхсанаас өөр ямарч юм мэдэгдэхгүй байгааг ажаад гайхсан байдлыг төгсгөл болгох хэрэгтэй гэж үзээд их л итали аялгуугаар

- Эрхэм Кадрусс гэдэг та юу? гэхэд дуугүй зогссоноос нь ингэж асуухыг нь илүү их гайхсан эзэн,

- Тийм ээ эрхэм ээ, би байна. Таны зарц Гаспар Кадрусс гэж хэлэв.

- Гаспар Кадрусс ий?.. Тийм ээ, тийм шиг санагдаж байна. Та урьд Мельяний тарималт гудамжинд дөрөвдүгээр давхарт сууж байсан уу?

- Яг тийм ээ.

- Та сайван байсан уу!

- Тийм ээ. Гэхдээ бүтэлтэй юм болсонгүй. Тэр хараал идмэр Марсельд удахгүй хүмүүс бүр хувцас өмсөхөө болих байх гэж бодож байна. Харин халуун гэснээс эрхэм ламтан та юм ууж сэрүүцэхгүй юү?

- Тэгнэ байгаа даа. Хамгийн шилдэг сайн дарснаас нэг лонх аваад ир л дээ. Тэгээд хоёулаа яриагаа үргэлжлүүлье.

- Эрхэм санваартан таны тушаалыг хэлсэнчлэн биелүүлье гэж Кадрусс хэлээд, үлдсэн хэдэн шилийг нь худалдах бололцоог алдахгүйн тулд яаран тасалгааныхаа шалан доор гал тогооны өрөө ба юм хадгалах газар болгон зассан зоорины тагийг яаран өргөв.

Таван минутын дараа дээш гарч ирэхэд лам тохойгоороо ширээгээ тулаад сандал дээр суусан байв. Тэр завсар Марго нохой хачин аялагч дарс ууя гэхийг сонсоод ярдглахаа болин шарвалзаж, өвдгөн дээр нь туранхай хүзүүгээ тавьж уриалагханаар харна.

Эзнийг лонх дарс, шилэн аягатай өмнө нь тавихад лам,

- Та энд ганцаараа суудаг юм уу? гэж асуув.

- Тийм ээ, ганцаараа, бараг л ганцаараа даа, эрхэм лам минь, миний энхэр надад тус болж чаддаггүй учраас тэр. Муу энхэр маань дандаа л өвдөж байдаг юм.

- Та тэгвэл эхнэртэй юм шив дээ? гэж лам санаа тавьсан өрөвдсөн байдалтай асуугаа ядуу эр эм хоёрын хогшил хөрөнгийг цэгнэх мэт эргэн тойрон харав.

- Эхрэм лам, т миний ядуу суудгийг харж байх шиг байна гэж Каэрусс асуугаад, санаа алдсанаа -Одоо яая гэх вэ дээ, энэ орчлонд сайн сайхан амьдрахад гагцхүү үнэнч хүн байх нь багадаад байдаг юм байна гэж хэлэв.

Лам түүнийг цоо ширтэн харав.

- Тийм ээ, үнэнч хүн, эрхэм лам минь би харин үүгээрээ л бахархдаг хүн дээ гэж эзэн хэлээд ламын нүд өөд эгцлэн харж, гараар элгээ дарж -Одоо үед дуртай хүн бүр ингэж хэлж чадахгүй шүү дээ гэхэд,

- Хэрвээ таны бахархаж байгаа тэр зүйл үнэн бол бүр сайн байна. Үнэнч хүн эрт орой алин боловч шагнагдаж, хорт санаатай шийтгэгддэг юм гэдэгт би хатуу итгэж байна гэв.

- Санваартан та ингэж ярих нь аргагүй, зүйтэй, лам минь гэж Каэрусс гунигтайгаар татгалзан хэлээд

- Харин хүн бүр таны үгэнд итгэсэн ч дур, итгээгүй ч дур гэхэд,

- Та дэмий тэгж ярьж байна, эрхмээ. Миний хэлсэн үг үнэн болохыг би танд нотлон харуулж л магадгүй дээ гэв. Тэгэхэд,

- Яаж тэр билээ? Гэж Каэрусс гайхан асуув.

- Тэгэхээр ийм байна. Юуны өмнө надад хэрэгтэй хүн чухам та мөн эсэхийг би мэдэх хэрэгтэй байна.

- Тэгвэл танд ямар баталгаа хэрэгтэй юм бэ?

- Та мянга найман зуун арван дөрөв, арван таван оны үед Дантес гэдэг нэртэй далайчин байсныг мэдэх үү?

- Дантес ий? Хөөрхий Эдмоныг мэдэх үү гэнэ ээ! Мэдэлгүй яах вэ? Миний сайн нөхөр байхгүй юу! гэж Каэрусс дуу алдаад царай нь час улайх д, ламын тунгалаг тайван нүд ярьж байгаа хүнээ нэгэн харцаар хамран авах мэт бүлтийв.

- Тийм байх аа, Эдмон гэсэн шиг санаж байна.

- Тэгэлгүй яах вэ, Түүнийг Эдмон гэдэг байсан юм! Тэгэхээр барах уу! Энэ бол намайг Гаспар Каэрусс гэдэгтэй адил үнэн юм байгаа юм: Харин тэр хөөрхий

Эдмон яасан бэ ламтан минь? Та түүнийг таньдаг байсан уу? Одоо тэр амьд уу? Суллагдсан уу? Жаргалтай яваа болов уу? гэж буудлын эзэн асуув.

- Тулоны цөллөгийн газар, хөлд нь дүүжилсэн цул төмрөө чирэн явдаг ялтангуудаас илүү дор, золгүй байдалд шоронд нас барсан.

Кадруссын улаан царай, үхээрийн цагаан өнгөөр солигдов. Цаашаа эргэж толгойгоо боосон улаан алчуурын булангаар нүднийхээ нулимсыг арчиж байгааг лам харав.

- Хөөрхий амьтан! Гэж Кадрусс аман дотроо бувтнаад, -Эрхэм лам минь, бурхан зөвхөн бүтэлгүй муу санаат хүмүүст хайр ивээлээ хүртээж байдаг юм гэж миний түрүүчийн хэлсэн үгийн бас нэг нотолгоо энэ байна шүү дээ. Ертөнц өдрөөс өдөрт муудаж байна. Тэнгэр бурхан, энэ дэлхий уруу эхлээд хүхрийн бороо, дараа нь галаар бороо оруулж, бүгдийг хиаруулчихаасай гэхэд,

- Та тэр залуу хүнд үнэн сэтгэлээсээ хайртай байсан бололтой гэж лам хэлэв. Тэгэхэд Кадрусс,

- Тийм ээ, Би түүнд үнэхээр хайртай байсан юм. Тэгэхдээ нэгэн удаа би түүнд атаархсандаа гэмших ёстой юм. Гэвч сүүлд нь түүний золгүй хувь зохиолд ихэд харамсан гашуудсан гэдгээ танд нэр төрөө барьж тангараглая гэж Кадрусс хэлэв.

Минутын туршид чимээ аниргүй болж лам дэн буудлын эзнийг нүд салгалгүй ширтэн харав.

- Та бас хөөрхий түүнийг таньдаг байсан юм уу? гэж Кадрусс асуув.

- Намайг үхэхийнх нь өмнөхөн наманчлуулах гэж аваачихад, би түүнд сүүлийн удаа бурхны тайвшруулах үг хэлсэн юм гэж лам хариулав.

- Аа, тэр юунаас болоод үхсэн бэ? Гэж Кадрусс намуухан дуугаар асуухад,

- Шоронд байгаа гучхан настай хүн шоронгоосоо биш өөр юунаас үхэх билээ дээ? гэж өөдөөс нь асуув.

Кадрусс нүүр уруугаа урсан гоожиж байгаа хөлсийг арчив.

Лам цааш нь үргэлжлүүлэн,

- Дантес үхэхийн өмнө, үнэсэн байсан загалмайгаар тангараглан өөрийгөө шоронд хорьсны үнэн учрыг мэдэхгүй байна гэж хэлсэн нь юм бүхнээс илүү гайхалтай байна гэхэд,

- Үнэн, үнэн юм Кадрусс шивнээд, -Тэр үүнийг мэдэж чадаагүй юм. Тийм шүү, эрхэм лам, хөөрхий хүүхэд үнэнээ хэлжээ гэв.

- Тийм учраас өөртөө тохиолдсон золгүй явдлын учир шалтгааныг олж хэрвээ нэр төр нь буртаглагдсан бол түүний нь дахин сэргээхийг надад даалгасан юм гэж хэлээд ламын гуниглангуй харц, Кадруссын барайж байгаа нүүрэнд улам ширтэн тусав.

- Нэгэн баян англи хүн гээд лам цааш үргэлжлүүлэн -Дахин сэргэлтийн үед шоронгоос гарсан түүний найз нөхөр нь их үнэтэй очир алмастай байжээ. Тэгээд шоронгоос гарахдаа энэ очир алмасыг өвчтэй байх үед нь төрсөн ах шигээ асран сувилж байсны нь хариуд талархал болгон Дантест өгсөн байна. Дантес очир эрдэний нь авчихаад өөрийг нь дараа нь барьж өгөх хуягуудыг хээл хахуулиар худалдан авах гэж бодсонгүй, харин шоронгоос гарах тохиолдлыг хүлээн нямбайлан хадгалж байжээ. Хэрэв шоронгоос гарсан бол очир эрдэнээ худалдаад тэр дороо л баяжих байж гэж ярихад Кадрусс нүд нь гялалзан,

- Их үнэтэй доржпалам байсан гэж та ярив уу? гэж асуухад,

- Орчлон дээрх юм бүхэн цөм харьцангүй байдаг. Эдмоний хувьд бол тэр эрдэнэ бүхэл бүтэн баялаг байсан юм. Тавин мянган франкаар үнэлэгдсэн эд гэж лам хариулав.

- Тавин мянга гэнэ ээ! гэж Кадрусс дуу алдаад -Тэр чинь хушга шиг том юм уу? гэж асуув.

- Үгүй, арай бага гэж лам хариулав. -Очир эрдэнэ надад байгаа болохоор та өөрөө үзэж болно гэхэд, Кадруссын харц ламын хормой доогуур очир эрдэнэ ирж байна уу гэлтэй болоод явчихав. Лам хар илгэн бүрээстэй жижиг хайрцаг халааснаасаа гарган онгойлгоод гайхан байгаа Кадрусст маш сайхан хийцтэй бөгжинд суулгасан гялалзсан доржпалам чулууг үзүүлэв.

- Энэ л тавин мянган франк болно гэж үү?

- Овоо үнэтэй. энэ хүрээгүйгээрээ тэр шүү гэж лам хариулав.

Лам хайрцгийг нь хаагаад очир эрдэнээ хармаандаа хийхэд Кадруссын бодолд тэр эрдэнийн чулуу гялалзсаар байлаа.

- Эрхэм лам таны гарт энэ чулуу яаж орж ирэв? Эдмон таныг залгамжлагчаар томилсон юм уу? гэж Кадрусс асуув.

- Өв өвлөгчөөр биш, гэрээсээ биелүүлэгчээр томилсон юм. Тэр хүн: «Надад гурван сайн найз, нэгэн болзоот хүүхэн байсан юм. Тэд дөрвүүлээ миний

хойноос гашуудаж суудаг байх гэж би итгэж байна, тэдний нэгийг Кадрусс гэдэг» гэж хэлсэн юм гэхэд Кадрисс цочив.

Лам Кадруссын сэтгэл хөдөлснийг анза раагүй юм шиг үргэлжлүүлэн, «Нөгөөдөхийг нь Данглар, гурав дахь нь » хэдийгээр надтай өрсөлдөгч боловч надад хайртай байсан гэсэн юм » гэж хэлэв.

Тэгэхэд Кадруссын уруул дээр хачин муухай инээмсэглэл тодрон ирээд ламын үгийг таслах гэхэд нь,

- Байзаарай гэж лам хэлээд - Би урьдаар яриад дуусчихъя, Хэрвээ танд надад хэлэх юм байвал сүүлд нь болоорой гээд «Гурав дахь нь хэдийгээр надтай өрсөлдөгч боловч надад хайртай байсан юм. Тэр нь Фернан гэдэг, аа миний болзоотой байсан хүүхнийг ...» гэснээ би болзоотой байсан хүүхнийх нь нэрийг мартчихаж гэж хэлэв.

- Мерседес гэж Кадрусс хэлэв.

- Тийм, тийм яг үнэн. Мерседес гэсэн гэж лам амьсгаагаа дарж батлан хэлэв.

- За тэгээд цааш нь юу болов? Гэж Кадрусс асуухад лам,

- Надад ус авчир өгөөч? Гэвэл Кадрусс түүний хүслийг яаран биелүүлбэл лам шилэн аяганд уснаас нь хийж хэд балгаад аягаа ширээн дээр тавьж,

- Бид юу ярьж байгаад зогслоо? Гэж асуув.

- Болзоот хүүхнийг нь Мерседес гэдэг байсан гэсэн,

- Тийм тийм, «Та Марсельд очиж...» гэснээ - Энэ бүгдийг Дантес хэлсэн гэдгийг та ойлгож байгаа биз? Гэв.

- Ойлгож байна.

- «Та энэ очир эрдэнийг худалдаад, авсан мөнгөө энэ орчлонд намайг хайрлаж байсан хүмүүс болох тэдгээр таван хүнд хувааж өгөөрэй» гэсэн

- Яагаад тав байдаг билээ? Гэж Кадрусс асуугаад -Та надад дөнгөж дөрөвхнийг нь нэрлэсэн шүү дээ гэв.

- Надад хэлснээр бол тав дахь нь үхчихсэн учраас тэр ... Тав дахь нь Дантесын аав байсан юм.

- Тийм ээ үнэн гэж зөрчилтэй сэтгэлдээ идэгдсэн Кадрусс хэлээд - Хөөрхий өвгөн үхчихсэн юм гэв.

- Би энэ тухай Марсельд очоод туулсан гэж лам хайнга байдалтай харагдах гэж хичээн хэлээд - Гэвч аль хэдийнээ өөд болсон учраас тэр тухай нарийн дуулж чадаагүй...Харин та өвгөний өөд болсон тухай юм мэдэхгүй биз? Гэж асуув.

- Би эс мэдвэл өөр хэн мэдэх вэ дээ? Би түүнтэй айл байсан. Ээ, бурхан минь! Хүүгээ алга болсноос хойш нэг жил ч бололгүй хөөрхий өвгөн нас барсан даа!

- Юунаас болж нас барсан юм бол?

- Эмч түүний өвчнийг ... ходоод нь хавдсан байна гэсэн шиг билээ, харин түүнийг мэддэг хүмүүс уйтгар гунигаас болж үхсэн гэгцгээдэг юм. Гэвч амьсгал хураахад нь дэргэд нь байсан би бол түүнийг ... гээд Кадрусс түгдрэхэд,

- Юунаас? Гэж лам сэтгэл түгшин асуув.

- Өлсөж үхсэн!

- Өлсөж үхсэн гэнэ ээ? гээд лам ухасхийн босож, - Өлсөж гэнэ ээ! хамгийн адгийн амьтан ч өлсөж үхдэггүй юм. Гудамжаар тэнэж явдаг нохойд хүртэл үмх талх хаяж өгдөг хүн олддог байтал, христосын шашинтан хүн, өөрсдийгөө мөн л христосын шүтлэгтэй гэж нэрлэдэг хүмүүсийн дунд байж байгаад өлсөж үхнэ гэнэ ээ! Тийм байж болохгүй! Энэ тийм байж болохгүй гэж хашхирах шахам хэлэв.

- Би танд үнэнийг нь хэлж байна шүү гэж Кадрусс хэлэхэд шатан дээрээс дуу га^оч,

- Дэмий битгий ярь. Чамд хамаагүй юманд хошуугаа яах гэж дүрээд байгаа юм бэ? Гэх сонстов.

Ярьж байсан хоёр хүн эргэж харахад, шатны хашлагын завсраар Карконтын цонхигор царай харагдав. Тэр өрөөнөөсөө гарч ирээд дээд талын шатан дээр гараараа толгойгоо тулан сууж, тэр хоёрын яриаг чагнаж байжээ.

- Эхнэр минь чи өөрөө юунд өөрт хамаагүй хэрэгт оролцоод байгаа юм бэ? Эрхэм лам намайг ярьж өгөөч гэсэн юм. Хүнийг хүндэтгэхийн үүднээс хэлэхгүй байхын аргагүй гэж Кадрусс хэлэв.

- Сайн бодвол дуугүй байсан нь дээр юм биш үү. Ямар санаатай асууж байгааг нь чи яаж мэдэх юм бэ тэнэг минь?

- Сайн санааны үүднээс, авгай минь. Би үүнийг батлан хэлье. Таны нөхөрт үнэн сэтгэлээсээ л ярьж байгаа бол айж болгоомжлох юм байхгүй гэж лам хэлэв.

- Бид энүүнийг чинь мэднэ. ... Эхлээд янз бүрийн юм амалж эхэлнэ, дараа нь айх зовох хэрэггүй гэнэ, тэгээд амласнаа биелүүлэлгүйгээр яваад өгнө, тэгээд адаг сүүлд нь нэг сайхан өглөө толгой дээрээс гай нөмрөөд ирнэ.

- Битгий зов. Надаас болж та нарт ямар ч муу юм болохгүй гэдгийг батлан хэлье гэж лам хариулав.

Карконта ойлгохын аргагүй юм аман дотроо бувтнаад, дахин гараараа толгойгоо түшиж, өвчиндөө автан, нөхөртөө цааш ярих бололцоо гаргаж дуугүй суусан боловч ярьснаас нэг ч үг алдахгүйг хичээн чагнав.

Тэр завсар лам бага зэрэг ус ууж тайвшрав. Тэгээд дахин,

- Үнэхээр тэр өлсөж үхэхээр тийм ганцаардмал хаягдмал хөөрхий өвгөн байсан юм уу? гэж асуув.

- Өө, үгүй шүү, каталан охин Мерседес, эрхэм Моррель хоёр түүнийг хаяагүй юм. Гэвч хөөрхий өвгөн гээд Кадрус± ёжтойгоор мушилзаад - Дантесын өнөөх найз нөхөр гээд байсан Фернаныг нь гэнэт үзэн ядах болсон юм гэж хэлэв.

- Аа, тэр түүний найз нь биш байсан юм гэж үү? Гэж лам асуув.

- Гаспар! Гаспар! Хэлэхээсээ өмнө сайн бодоорой! Гэж өвчтэй авгай шатан дээрээс орилов.

Кадрусс хор нь хөдөлсөн байдалтай, гараа саваад эхнэртээ хариу дуугарсангүй.

- Дурласан охиныг нь булааж авах гэсэн хүн найз нөхөр нь байж болдог юм уу? Дантес сайхан сэтгэлтэй хүн байсан болохоор тэд нарыг найз нөхдөө гэж байжээ... Хөөрхий Эдмон! Ерөөсөө ч тэдний тухай юу ч мэдээгүй байсан нь сайн болж, тэрнээс амьсгаа хураахдаа уучлахад хэцүү байх байсан байх... хэмээн их л урнаар урсгаж байгаа Кадрусс цааш нь үргэлжлүүлэн - Би амьдын үзэн ядахаас үхсэний хараалыг илүү дор гэж үзэж айдаг хүн гэж ярив.

- Чалчаа амьтан! Гэж Карконта хашхирав.

- Тэр Фернан гэдэг чухам яасныг нь та мэдэх үү? Гэж ширээт лам үргэлжлүүлэн асуухад,

- Мэдэх үү гэнэ ээ? Мэдэлгүй яах вэ! гэж буудлын эзэн хариулав.

- Тэгвэл ярьж өгнө үү?
- Өөрөө л мэд, Гаспар гэж эхнэр нь хэлээд - Дураараа бол, уг нь дуугүй байсан нь дээр дээ гэхэд Кадрусс,
- Энэ удаа чиний хэлдэг зөв шиг байна гэв.
- Тэгээд та ярих дургүй байна уу? гэж лам асуув.
- Юунд хэрэг болох билээ? Хэрвээ хөөрхий Эдмон амьд байгаад над дээр ирж, хэн нь нөхөр, хэн нь дайсан байсныг мэдэх гэж байгаа бол өөр хэрэг, Жэвч одоо булшинд орсон гэж та хэлсэн болохоор юу хийх вэ. Тэр одоо хэнийг ч үзэн ядаж, хэнээс ч өшөө хорслоо авч чадахгүй болсон болохоор энэ хэргийг орхиё гэж Кадрусс хэлэхэд,
- Тэгвэл та, тэр итгэлийг эвдэгч, хуурмаг найзууд нь үнэнч нөхөрлөлийн шагнал хүртэг гэж бодож байна уу? гэж лам асуув.
- Таны хэлдэг зөв, гэсэн ч хөөрхий Эдмоны үлдээсэн хөрөнгө тэдэнд юу болох вэ дээ? Далайд дусал гэсэн үг!
- Тэд чамайг ганц хуруугаараа няц дарчихна гэдгийг хэлэхгүйгээр тэр шүү гэж эхнэр нь дуугарав.
- Өө тийм үү? Тэр хүмүүс эрх мэдэлтэй, баян улс уу?
- Та тэдний тухай юу ч дуулаагүй юм уу?
- Үгүй надад ярьж өгнө үү?

Кадрусс бодлого боллоо.

- Үгүй дээ, ярихад дэндүү урт юм.
- Өөрөө л мэд дээ найз нөхөр минь, юу ч ярихгүй байж болно гэж лам огт хайхрамжгүйгээр хэлээд - Би таныг тээнэгэлзэж байгааг хүндэтгэж байна. Та сайн санаат хүний ёсоор ярьж байна. Энэ тухай дахин ярихаа больё. Надад даалгасан юм юу вэ гэвэл, талийгаачийн сүүлчийн хүслийг биелүүлэх явдал. Тэгэхээр би энэ очир алмасыг худалдана гэв.

Ингэж хэлээд хайрцагтай очир алмасыг хармаанаасаа гаргаж онгойлгоход, гайхан бахархсан Кадруссын нүдний өмнө өнөөх чулуу гялалзан гялтганана.

- Эхнээр, нааш ир, үүнийг хараач гэж сөөнгө паргиа хоолойгоор хэлэхэд Карконта,

- Очир алмас ий? Гэж асуугаад, босож нэлээд чийрэг алхаагаар шатнаас буун ирж - Юун очир алмас вэ? гэв.

- Чи дуулаагүй гэж үү? Гэж Кадрусс асуугаад - Энэ доржпаламыг Эямон бидэнд гэрээслэн үлдээжээ. Нэгдүгээрт өөрийнхөө эцэгт, дараа нь гурван найздаа, Фернанд, Дангларт, надад мөн болзоот хүүхэн Мерседест өгөөрэй гэжээ. Энэ эрдэнийн чулуу тавин мянган франк хүрэх гэнэ гэв.

- Ай юутай сайхан чулуу вэ? гэж Карконта хэлэхэд

- Тэгэхээр энэ мөнгөний тавны нэг нь бидэнд ногдох болж байна уу? гэж Кадрусс асуув.

- Тийм ээ, бас эцэгт нь ногдох хувийг би, та нарт хувааж өгөх эрхтэй учраас нэмэлт олдоно гэж лам хариулахад,

- Яагаад дөрвөн хүнд хуваагдах юм бэ? Гэж Карконта асуув.

- Яах юу байх вэ, та дөрвүүлээ цөм Эдмоны найз нөхөд болохоор тэр.

- Урвагчид болохоос биш найз, нөхөд биш! Гэж Карконта аман дотроо бувтнав.

- Би энийг чинь л хэлсэн юм шүү дээ гэж Кадрусс хэлээд, - Урвах явдлыг шагнана гэдэг бол гэмт хэрэг. Энэ бол нүгэл, бүр шүтээнээ доромжилсон хэрэг гэв.

- Та л өөрөө ингээсэй гэж хүсээд байна шүү дээ гэж лам тайван хариулаад, очир алмасаа хармаандаа буцаан хийгээд - Одоо надад Эдмоны найзуудынх нь хаягийг өгнө үү, би талийгаачийн сүүлчийн хүслийг нь биелүүлье гэв.

Кадруссын нүүр уруу хөлс зогсоо зайгүй цувна. Лам босож, морио харах гэж үүд уруу очоод эргэж ирэв. Кадрусс эхнэртэйгээ тайлбарлаж хэлэхийн аргагүй харцаар бие бие өөдөө харна.

- Энэ очир алмас ганцхан бидэнд оногдож болох юм гэж Кадрусс хэлэхэд эхнэр нь,

- Чи тэгж бодож байна уу? гэж асуув.

- Лам хүн биднийг хуурахгүй.

- Дураараа л бол, надад хамаагүй гэж Карконта хэлэв.

Тэгээд хэдий халуун байгаа боловч, халиун өвчнөөсөө болж чичрэн дагжиж, шүд нь тачигнасаар шат өөд дахин өгсөв.

Хамгийн дээд талын шатан дээр очиж зогсож,

- Гаспар минь, сайн л бодоорой гэж хэлэхэд,
- Би шийдсэн гэж Кадрусс хариулав.

Карконта амьсгаадсаар тасалгаанд орж алга болоход, хөл дор нь шал шажигнаж, дараа нь зөөлөн сандал нь хяхнах дуулдав.

- Та юу шийдчихээ вэ гэж ламыг асуухад, Кадрусс
- Танд бүгдийг нь ярих гэж шийдлээ хэмээн хариулав.
- Үнэнийг нь хэлэхэд тэгвэл дээр юм шиг надад санагдаж байна. Тэгэхдээ энэ бол надаас нуух гэсэн юмыг чинь мэдэхийн тулд биш, харин гэрээс үлдээсэн хүний хүслийн ёсоор тэр зүйлийг хуваахад та надад тусалбал сайн байна гэж лам хэлэхэд,
- Тийм байх гэж найдаж байна гэж горьдож, хомхойрсондоо хацар нь час улайсан Кадрусс хариулав.
- Би таны ярихыг хүлээж байна гэж лам хариулав.
- Байзаарай бидний яриаг зохимжгүй үеэр тасалчих вий, тэгвэл эвгүй юм болно. Тэгээд ч таныг энд ирсэн гэж өөр хүн мэдэхийн хэрэг юу байх вэ гэж Кадрусс хэлээд, хаалга уруу очиж хаагаад улам найдвартай байхын тулд шөнийнхөө түгжээг хийв. Тэр завсар лам тохиромжтой газар сонгон олж өөрөө сүүдэрт, цаад хүний нь нүүрэн дээр гэрэл тусаж байхаар тийм буланд орж суув. Тэрээр тонгойж, гараа атган юу ярихыг хүлээн суулаа.

Кадрусс дөрвөлжин мухар сандал авчирч, өөдөөс нь харж суув.

Гэтэл, Карконта доороо болж байгаа юмыг харж байгаа юм шиг чичирсэн дуугаар,

- Би чамайг заавал хэл гэж шахаагүй шүү гэж хэлэх сонстов.
- За, за боль, би бүх хариуцлагыг нь өөр дээрээ авна гэж Кадрусс хэлэв.

Тэгээд ярьж эхлэв.

6. Кадруссын яриа

- Юуны өмнө, эрхэм лам та, надад нэг зүйлийг амлаач гэж хүсэх байна гэж Кадрусс хэлэв.

- Юу вэ? гэж лам асуув.

- Хэрвээ миний одоогийн хэлэх зүйлийг та хожим хэзээ нэгэн цагт хэрэг болговол, үүнийг надаас дуулж мэдсэн юм гэдгийг хэн ч мэдэх ёсгүй. Миний энэ ярих гэж байгаа хүмүүс бол баян тарган, эрх мэдэлтэй хүчирхэг хүмүүс. Тэгэхээр надад чигчий хуруугаа л хүргэхэд хорхой шиг няц дарчихна шүү гэв.

- Битгий санаа зов найз минь. Би хувраг хүн болохоор таны энэ нууц миний цээжинд үүрд хадгалагдан үлдэнэ. Талийгаачийн сүүлчийн хүсэл зоригий нь аятай сайнаар биелүүлэхээс өөр зорилго надад байхгүй гэдгийг та санаж байгаа биз. Хэнийг ч хайрлалгүй, тэгэхдээ үзэн ядалгүйгээр, яг л үнэнийг нь яриарай. Таны надад ярих гээд байгаа хүмүүсийг би мэдэхгүй, ер нь ч тэгээд хэзээ ч танилцахгүй байх. Түүнээс гадна би франц хүн биш, итали хүн, хүмүүст бус бурханд хамаарагдах лам хүн. Талийгаачийн сүүлчийн хүслийг биелүүлэх гэж ганц удаа гарсан хийд уруугаа буцаж очно.

Ингэж итгэмээр нотлон ярихад Кадрусс бага зэрэг итгэл төрөв бололтой.

- Тийм бол, би тэр хөөрхий Эдмоны хичнээн үнэнч шударга гэж үзэж байсан нөхөрлө«д одоо таныг итгэхгүй болгох хэрэгтэй болж байна даа.

- Таныг эцлээс нь эхэлж яриач гэж гуйя. Эдмон өвгөний тухай их ч ярьсан, маш халуун хайрта© байсан бололтой гэж ламыг хэлэхэд Кадрусс толгой сэгсэрч,

- Энэ бол их гунигтай түүх байгаа юм. Та эхнийхий нь мэдэх байхаа гэв.

- Мэднэ ээ, Марселийн ойролцоох гуанзанд баригдах үе хүртэлх явдлаа Эдмон надад бүгдийг нь ярьсан гэж лам хариулав.

- «Нөөц»-өд! Би одоо түүнийг харж байгаа юм шиг л санаж байна.

- Энэ чинь арай гэрлэх ёс гүйцэтгэх гэсэн тэр өдөр биш шиг билээ?

- Тийм ээ, хөгжилтэй эхэлсэн цайллага, уйтгартай явдлаар төгсөж, Цагдаагийн комиссар дөрвөн цэрэгтэй орж ирээд Дантесыг аваад явчихсан юм.

- Би үүнээс хойшхий нь мэдэхгүй дээ. Дантес түүнээс хойш тэдний хэнтэй нь ч уулзаагүй, хэнийх нь ч тухай юу ч сонсоогүй учир зөвхөн өөртөө л холбогдох юмыг мэдэж байсан юм.

- За тэгвэл ийм байна. Дантесыг барьж аваад явсны дараа Моррель чухам юу болж байгааг мэдэхийн тулд Марсель ороод маш уйтгартай мэдээ авч

буцаж ирсэн юм. Өвгөн болсон эцэг нь гиншин уйлсаар гэртээ ирээд, гоёлынхоо хувцсыг тайлж өдрийн турш өрөөндөө хойш урагшаа холхиж байгаад нүд анилгүй хоносон юм. Тэгэхэд би тэдний доод давхарт сууж байсан болохоор, шөнийн турш тасалгаан дотуураа явж өнгөрсөн нь надад сонстож байсан юм. Үнэнээ хэлэхэд би ч тэр шөнө унтаагүй золгүй явдалд учирсан эцгийн нь уй гашуу намайг ихээр зовоож, хэрэг дээрээ өвгөн миний цээжин дээр гишгэлж байгаа юм шиг, алхам бүр нь зүрхий минь базлуулж байж билээ.

Маргааш нь Мерседес, Марсель орж ноён Вильфороос баривчлагдсан хүний тухай асуусан боловч юу ч олж мэдсэнгүй харин далимд нь өвгөнийг эргэж орж ирсэн. Тэгээд өвгөний ийм гутаж гуныхарч байгааг бүхэл шөнийн турш унтаагүй хонож өчигдрөөс хойш юу ч идээгүй байгааг нь мэдээд гэртээ аваачиж асарч сувилах гэж оролдсон юм. Гэвч өвгөн огт зөвшөөрсөнгүй.

- «Үгүй ээ, би орон гэрээ орхихгүй. Миний хөөрхий хүү, энэ орчлон дээр хэнээс ч илүү надад хайртай. Тэгэхээр шоронгоос суллагдмагцаа хамгийн түрүүн над дээр гүйж ирнэ. Тэгэхэд нь би байхгүй бол тэр минь яах вэ?» гэж өвгөн хэлэв.

Би Мерседесийг аргалж байгаад өвгөнийг аваад яваасай гэж бодож шатан дээр зогсож байсан болохоор энэ бүгдийг сонссон юм.

Өвгөний зовлонтой янзын алхаа миний толгой дээр дуулдаж намайг нэг ч минут амраахгүй байсан юм.

- Та өөрөө өвгөнийг тайвшруулах гэж түүн дээр ороогүй юу? гэж лам асуув. Тэгэхэд Кадрусс,

- Ай, эрхэм лам минь. Тайвшруулаасай гэж байгаа хүнийг л тайвшруулж болдог юм. Гэтэл тэр өвгөн тэгж хүсээгүй юм. Бас тэгээд яагаад ч юм бүү мэд, тэр надтай уулзах дургүй байсан юм. Нэг орой би цорхирон уйлахыг нь сонсоод тэсэж чадахгүй түүн дээр орох гэж дээшээ өгссөн боловч, намайг үүдэнд нь очиход уйлахаа больчлоод харин мөргөл хийж байлаа. Тэр ямар их уран гоё үг хэлж, учиргүй гомдсон гомдлоо илэрхийлж байсныг Үи танд хэлж чадахгүй эрхэм лам минь. Энэ бол мөргөл, уй гашуу хоёрын аль алинаас нь хүчтэй зүйл байлаа. Тэгээд би лам хувраг хү биш, шашин шүтэгчдэд дургүй учраас дотроо «Би өнчин ганцаараа, бурхан тэнгэр надад хүүхэд хайрлаагүй нь миний зол заяа, хэрвээ би эцэг хүн байгаад энэ золгүй өвгөн шиг ийм их уй гашууд учирсан бол энүүн шиг ийм гоё сайхан үг олж бурхан тэнгэрт залбиран мөргөж чадахгүй, харин зовлонгоосоо хагацахын тулд шулуухан л тэнгист живж үхэх байсан даа» гэж хэлж зогссон юм.

- Хөөрхий эцэг! Гэж лам дуу алдав.

- Өвгөн өдрөөс өдөрт хүн амьтнаас хөндийрч, эрхэм Моррель, Мерседес хоёр түүнийг эргэхээр ирэх боловч хаалга нь түгжээтэй байдаг байлаа. Түүнийг

гэртээ байгааг би мэддэг байсан юм. Гэвч тэдэнд хариу дуугардаггүй байлаа. Тэр нэгэн удаа өөрийнхөө заншлаас гадуур Мерседесийг гэртээ оруулсан. Тэгэхэд хөөрхий охин өөрөө арга нь барагдан гуньхарч явсан хэрнээ зориг оруулж сэтгэлийг нь засах гэхэд өвгөн өөдөөс нь:

«Охин минь тэр үхсэн гэдэгт итгэ, бид түүнийг хүлээх биш харин тэр биднийг хүлээж байгаа. Би чамаас олон ах, тийм учраас чамаас урьтаж түүнтэй уулзана тэгэхээр надад сайхан байна» гэж хэлсэн.

Хүн хэдий сайн санаатай боловч, харахад нүд хальтрам болсон хүнийг эргэж ирэхээ больдог юм. Тэгээд Дантес өвгөн орь ганцаараа болж хоцорсон. Түүнээс хойш ямар нэгэн үл таних хүн сэм ирээд боодолтой ваадантай юм аваад яваад өгөхөөс, өөр хүн ирэхээ больсныг би нүдээрээ үзсэн. Тэр боодолтой юмнууд нь чухам юу байсныг би удалгүй тааварлаж мэдсэн. Амь з@гоох гэж юмаа худалдаж байжээ. Тэгээд сүүлд нь хөөрхий өвгөн өөрийнхөө сүүлийн юмыг зарж дуусчээ. Байшингийнхаа хөлсийг төлөлгүй зээлээр сууж байсан тул, байрны эзэн түүнийг хөөж гаргана гэж айлгасан. Тэгэхэд нь өвгөн дахиад нэг долоо хоног хүлээгээч гэж гуйхад цаадах нь зөвшөөрсөн. Би байшингийн эзнийг тэднийхээс гараад манайд орж ирэхэд нь энэ тухай дуулж мэдсэн юм.

Түүнээс хойш өвгөн гурван өдрийн туршид хуучин янзаараа л тасалгаан дотуураа явж байхыг би дуулж байсан, харин дөрөв дэх өдөр нь юу ч дуулдахгүй болсон. Би түүн дээр орьё гээд очвол хаалга нь түгжээтэй байлаа. Тэгэхээр нь цоожны нь нүхээр шагайвал цонхийсон цав цагаан царайтай ядарч туйлдсан амьтан харагдлаа. Би түүнийг өвдөж гэж мэдээд, тэр дороо эрхэм Моррель гуайнд очиж хэлээд, Мерседес уруу гүйсэн. Тэр хоёр хоёулаа тэр дороо ирсэн. Моррель эмч дагуулж ирсэн. Эмч ходоод нь хавдаж өвдсөн байна гэж хэлээд, цагаан хоол идэж бай гэж зөвлөсөн. Тэгэхэд өвгөн хачин жигтэй инээмсэглэснийг би тэнд байсан болохоор харсан. Инээмсэглэсний нь одоо ч мартдаггүй юм, эрхэм лам аа. Түүнээс хойш хаалга үүдээ ч түгжихээ болилоо. Эмч түүнд цагаан хоол ид гэж зөвлөсөн болохоор юм идэхгүй байх үндэслэлтэй байлаа гэж ярихад ламын цээжнээс гинших дуу гарав.

- Миний яриа таны сэтгэлийг хөдөлгөж байна аа, эрхэм ламтан? Гэж Кадрусс асуухад лам,

- Тэгж байна, маш их сэтгэл хөдөлмөөр яриа байна гэж хариулав.

- Мерседес хоёр дахь удаагаа ирж, өвгөн их өөр байдалтай болсон байхыг үзээд, түрүүчийн адил аваачих гэж оролдсон. Эрхэм Моррель ч мөн тийм бодолтой байсан бөгөөд түүнийг хүчээр аваачих гэхэд өвгөн маш муухай хашхирсан тул тэр хоёр хоёулаа айж Мерседес өвгөний дэргэд сууж хоцроход, эрхэм Моррель зуухан дээр түрийвчтэй мөнгө орхисон гэж түүнд дохиогоор хэлээд гарч явсан. Гэвч эмчийн зөвлөсөн зүйлээр зэвсэглэсэн өвгөн юу ч идэхийг

зөвшөөрсөнгүй. Тэгээд эцэс сүүлд нь ес хоног тарчилсны дараа, өөрий нь ийм гунигт үхэлд хүргэсэн хүмүүсийг харааж зүхсээр нас барсан. Тэр Мерседест:

«Хэрвээ чи хэзээ нэгэн цагт Эдмонтой уулзвал намайг өөрий нь ерөөсөөр байгаад нас барсан гэж хэлээрэй» хэмээсэн гэхэд, лам босож, чичирсэн гараар хатсан хоолойгоо дарж, тасалгаан дотуур цааш наашаа хоёр удаа явав.

- Та түүнийг амьсгаа хураахдаа...

- Өлсөж үхсэн, эрхэм лам минь, өлсөж үхсэн гэж Кадрусс хариулаад - Би энүүнд та бид хоёр христос шашинтан гэдэгт итгэдэг шигээ итгэж байна гэхэд,

Лам тэхий дундуураа устай аяга шүүрэн авч, ганцхан амьсгаагаар уучхаад, нүд нь улайж, царай нь цонхийгоод дахин байрандаа сууж,

- Энэ бол их золгүй явдал гэдгийг та зөвшөөрөх байх гэж тэр бүдэгхэн дуугаар хариулав.

- Тэгэх тусмаа бурхан тэнгэр биш, харин хүн үүнд хамаатай нь бүр ч бэрх.

- Одоо нөгөө хүмүүсийн тухай ярья. Та надад бүгдийг нь хэлнэ гэснээ санаж байгаа биз гэж лам бараг туугасан байдалтай нэмж хэлээд - хүүгий нь цөхрөөж эцгий нь өлсгөлөнгөөр алдаг тэдгээр хүмүүс чинь ямар улс вэ? гэж асуув.

- Түүнд атаархсан хоёр хүн нэг нь дурлалаас, нөгөөх нь нэр төрд дуртайгаас. Энэ хоёр бол Фернан, Данглар хоёр юм.

- Тэр хоёрын атаархал юунд хүргэсэн бэ? Яриач!

- Тэд Эдмоныг бонапартын төлөөлөгч гэж гүтгэн ховлосон юм.

- Уухай хэн нь түүнийг гүтгэн ховлосон бэ? Жинхэнэ буруутан нь хэн бэ?

- Хоёулаа эрхэм лам минь, нэг нь гүтгэлгийн захидал бичиж, нөгөөх нь шууданд аваачиж өгсөн.

- Аа, тэр захидлыг хаана бичсэн бэ?

- Мөн тэр «Нөөц»-өд хуримын урьд өдөр.

- Тийм байх ёстой! Өө Фариа! Фариа! Чи хүмүүс, тэдний үйлд явдлыг яасан сайн мэднэм гэж лам шивнэвэл,

- Та юу гэнэ ээ? гэж Кадрусс асуув.

- Зүгээр, юу ч гээгүй, цааш нь ярь ярь гэж лам хариулав.
 - Данглар бичгийнхээ хэвийг танигдахгүйн тул солгой гараараа бичээд, түүний нь Фернан шуудан дээр хүргэж өгсөн.
 - Тэгэхэд та тэнд байсан уу? гэж лам гэнэт асуув. Кадрусс гайхаж,
 - Би юу? Намайг тэнд байсан гэж хэн танд хэлээ вэ? гэж асуув. Лам хэтэрч байгаагаа мэдээд,
 - Хэн ч хэлээгүй, харин ийм тодорхой мэдье гэвэл хамт байлцаж байсан байх ёстой гэж хэлэв.
 - Таны хэлдэг үнэн, би тэнд байсан гэж Кадрусс бүдэгхэн дуугаар хэлэхэд,
 - Та тэгээд тэр бузар явдлыг нь эсэргүүцээгүй юм уу? гэж лам асуугаад - Та тэгвэл тэдэнтэй хоршоо хуйвалдагч юм шив дээ гэв.
 - Эрхэм лам минь, тэд намайг бараг ухаан алдтал уулгасан юм. Би тэр явдлыг бүдэг бадаг мэдэж байсан. Би тэдэнд согтуу хүн хэлж чадах хэмжээгээр л хэлсэн боловч, тэд надад үүнийгээ зүгээр тоглоом тохуу хийж байгаа юм, ямар ч үр уршигт хүргэхгүй гэж хэлсэн.
 - Харин маргааш нь, эрхэм минь, маргааш нь ямар үр уршигт хүрснийг үзсэн биз дээ. Дантесыг барьж аваачих үед та тэнд байсан атлаа дуугүй байсан биз дээ?
 - Тийм ээ, эрхэм лам минь, би тэгэхэд тэнд байсан, тэгээд бүгдий нь хэлэх гэсэн боловч Данглар хориод байсан юм. Тэр надад: «Аа, хэрвээ тэр үнэхээр гэмтэн этгээд байгаад, Эльба арал дээр очиж, парист байгаа бонапартын хооронд өгөх захидал авсан нь үнэн болж тэр захиа түүнээс олдвол, түүнийг өмгөөлсөн хүнийг бас л хоршоо хуйвалдагч гэж үзнэ шүү дээ» гэж хэлсэн юм.
- Би тийм үед улс төрийн хэрэгт оролцохоос айгаад дуугүй өнгөрсөн юм. Энэ бол миний талаас туйлгүй аймхай явдал байснаас биш, харин ялт хэрэг байгаагүй гэдгийг хүлээе.
- Ойлголоо, та хариуцлагаас зайлж цэвэр өнгөрсөн юм байж.
 - Тийм ээ эрхэм лам минь гэж Кадрусс хариулаад - Тэр явдал өдөр шөнийн аль ч цагт миний сэтгэлийг зовоодог юм. Би тэгээд бурхан намайг өршөөгөөрэй гэж залбирч явдаг юм. Энэ бол энэ насандаа миний хийсэн ганц нүгэл бөгөөд надад тохиолдсон гай барцад бол ганцхан үүнээс л болсон гэж өөрийгөө буруушааж явдаг юм. Хар амиа бодсон тэр үеийн нүглээ наманчилж

Карконтыгаа хувь заяандаа гомдож элдвийн юм ярихаар «Дуугүй бай эхнэр минь, бурхан л ингэж таалж байгаа юм байлгүй» гэж хэлдэг юм.

Тэгээд Кадрусс үнэхээр гэмшсэн байртай доошоо тонгойв.

- Таны энэ чин зүрхнээсээ ярьж байгаа явдал сайшаалтай байна. Хэн ингэж буруугаа үнэхээр хүлээвэл тэр хүн уучлагдах ёстой гэхэд, Кадрусс үгий нь таслан,

- Гай болоход, Эдмон намайг уучлалгүй нас барчихсан гэж хэлэв.

- Тэр юу ч мэдээгүй... гэж лам хэлэхэд Кадрусс татгалзаж,

- Гэвч тэр одоо мэдэж байж магадгүй. Бурхан болоочид бүгдийг нь мэддэг гэж ярьцгаадаг шүү дээ гэж хэлэв.

Дуугүй болцгоов. Лам босож, бодлого бодон тасалгаан дотуураа явснаа дараа нь байрандаа ирж суугаад,

- Та Моррель гэдэг нэг хүний нэрийг хэдэн удаа хэлсэн, тэр юун хүн бэ? Гэж асуухад,

- Тэр бол «Фараон» хөлөг онгоцны эзэмшигч, Дантесын эзэн байсан юм.

- Аа тэр хүн чинь энэ гунигт явдалд ямар үүрэг гүйцэтгэсэн хүн бэ? Гэж лам асуухад,

- Үнэнч шударга, эрэлхэг зоригтой, хүнд тус боломтгой хүний үүргийг гүйцэтгэсэн юм. Дантесын төлөө хорь шахам удаа гуйж гувшиж гүйсэн. Эзэн хааныг эргэж ширээндээ ирэхэд гуйж гувшин занаж зүхэн захидал бичсэн дээ. Дахин тогтнолтын үед түүнийг өөрийг нь ч бонапартич хүн гэж гомдолгүй мөрдөн мөшгөж байсан юм. Арваад удаа Дантесын эцэг дээр гэртээ аваачих санаатай ирж сүүлд үхэхээс нь хоёр өдрийн өмнө, миний түрүүн ярьсанчлан зуухан дээр нь түрийвчтэй мөнгө орхиод явсан. Тэр мөнгөөр нь өвгөний өрийг төлж, оршуулах ёслолыг гүйцэтгэсэн юм. Ийнхүү хөөрхий талийгаач амьд байсан шигээ хэнд ч саад бололгүй нүд аньж чадсан юм. Одоо хүртэл тэр нэхмэл том улаан түрийвч нь надад байдаг юм гэж хэлэв.

- Ноён Моррель одоо амьд уу гэж лам асуухад,

- Амьдаа гэж Кадрусс хариулав.

- Түүнийг лав бурхан тэтгэж, одоо баян, аз жаргалтай яваа биз дээ.

Кадрусс гашуунаар инээмсэглэж,

- Над шиг л жаргалтай яваа даа гэв.
- Яалаа гэнэ ээ, эрхэм Моррель зол жаргалгүй яваа гэнэ ээ гэж лам дуу алдав.
- Тэр хоёр хоосролын туйлд хүрээд байгаа. Бас тэгээд хамгийн муухай нь нэр төрөө алдахад ойртон байна.
- Яагаад тэр вэ?
- Эрхэм Моррель хорин таван жил хөдөлмөрлөж Марселийн худалдаачдын дунд хамгийн хүндэт суурь эзэлж явснаа, одоо тартагтаа тултал хоосроод байгаа. Хоёр жилийн дотор таван онгоцоо алдаж, гурван дампууралд хохироод, одоо сүүлчийн найдвар нь болох хөөрхий Дантесын командалж байсан «Фараон» онгоцоо эргэж ирэхийг хүлээж байна. Онгоц нь Энэтхэгээс индига, кармин хэмээх үнэт улаан будаг ачиж удахгүй эргэж ирэх ёстой. Хэрвээ энэ онгоц нь бас живчихвэл эрхэм Моррель өнгөрөх нь тэр гэж Кадрусс ярив.
- Ингэхэд энэ золгүй хүнд эхнэр хүүхэд гэж би юу?
- Бий, эхнэр нь энэ бүхнийг сүсэгтэйгээр тэвчин өнгөрүүлж, охин нь бас дуртай хүнтэйгээ сууж чадахгүй болчихоод байгаа. Цаад хүнийх нь эцэг эх хүүгээ ядуурч хоосорч байгаа айлын охинтой суулгахыг дургүйцээд байгаа юм. Түүнээс гадна түүнд бас нэг офицер хүү бий, гэвч Энэ бүгд нь золгүй амьтны зовлонд ихэсгэхээс биш тайтгаруулахгүй байгаа нь ойлгомжтой. Хэрвээ ганц биесэн бол аль хэдийн духандаа буун сум зоочоод л төгсгөл болох байсан биз.
- Энэ чинь аймшигтай хэрэг байна даа! Гэж дам аман дотроо бувтнав.
- Буянтай хүмүүсийг бурхан ингэж л тэтгэж дэмждэг юм байна шүү дээ, эрхэм лам минь гэж Кадрусс хэлээд - Намайг хар л даа, би танд хэлснээс өөр ямар ч муу үйл хийгээгүй дээ. Тэгсэн хэр нь ийм ингэтлээ хоосорчихоод байна. Би ч хөөрхий эхнэрээ халуун хижиг өвчнөөр үхэхийг үзэж, өөрөө өвгөн Дантес шиг өлсөж үхэх хувьтай хүн байхаа. Тэгэхэд Фернан Данглар хоёр алтанд умбаж байна.
- Яалаа гэж тэр вэ?
- Яах вэ дээ үнэнч шударга хүмүүс хохирч, үл бүтэх нэг нь хожиж байдаг юм чинь.
- Гол гэмтэн Данглар яасан бэ? Тэр л хамаг хэргийг хийсэн биз дээ, тийм үү?

- Яасан бэ гэнэ ээ? Гэмт хэргийг нь мэдэхгүй Моррелийн зуучилснаар испанийн нэгэн банкны эзэнд хөлсөөр ажилд орсон. Испанийн дайны үеэр францын армид бэлтгэн нийлүүлэх ажил хийж баяжсан. Дараа нь бирж дээр тоглож ийм шиг байдалтайгаар хөрөнгөө гурав дахин нэмэгдүүлж, эхнэр болох банкны эзнийхээ охиныг үхсэний дараа одоогийн вангийн хиа бөгөөд эзнийхээ хайр хишгийг ихэд хүртсэн эрхэм Сальвьёгийн охин, бэлбэсэн Норгон хатагтайтай суусан даа. Тэрээр саяын хөрөнгөтэй болж, түшээ гүн хэргэмээр шагнуулан одоо түшээ гүн Данглар гэдэг болсон. Одоо Монблан гудамжинд тусгай ордтой, адууныхаа саравчинд арван морьтой, үүдэндээ зургаан зарцтай, харин вдран дотроо хичнээн саятайг нь мэдэхгүй.

- Өө тийм бий! Гэж лам хачин дуугаар хэлээд - Яа вэ дээ, аз жаргалтай яваа юмаа? Гэж асуув.

- Жаргалтай гэнэ ээ? Үүнийг хэн мэдэх вэ? Аз жаргал юм уу, биш юм уу ганцхан байшингийн хана л мэдэх байх. Хана туурга гэдэг чихтэй болохоос хэлгүй юм. Хэрвээ хөрөнгө хогшилтой хүн жаргалтай байдаг бол, Данглар жаргалтай л байгаа.

- Аа, Фернан?

- Өө, Фернанд улам ч илүү аз завшаан тохиолдсон.

- Үгүй ер, ямарч хөрөнгө хогшилгүй, боловсрол мэдлэггүй каталаны ядуу зүүдүү загасчин яаж баяжиж, хүмүүсийн дунд гарч яаж чаддаг сан билээ? Би түүнийг их сонирхож байна.

- Үүнийг ч хүн бүхэн сонирхож байгаа юм. Түүний амьдралд хэний ч мэдэхгүй нэгэн нууц зүйл байгаа байх.

- Гэвч харагдахуйц ямар замаар явж их хөрөнгө буюу эсвэл өндөр хэргэм зэрэгт хүрээ вэ?

- Тэр тэдгээрийн аль алинд нь хүрсэн эрхэм ламтан. Баялаг хөрөнгөтэй ч болсон өндөр хэргэм зэрэгт ч хүрсэн.

- Үлгэрт ийм юм гардаг сан даа.

- Нээрээ ч үлгэр домогтой адил юм, гэвч та миний ярихыг сонсоод бүгдийг мэдэх болно.

Эзэн хаан эргэж ирэхээс хэдхэн хоногийн өмнө Фернан цэрэгт оржээ. Бурбанчууд түүнд гар хүрсэнгүй. Гэвч Наполеон эргэн ирээд, онц татлага зарлаж Фернан армид явах боллоо. Би ч бас цэрэгт татагдсан боловч, Фернанаас ахмад, тэгээд ч бас саяхан энэ золгүй эхнэ^отэйгээ суучихсан байсан болохоор эрэг

орчмын хамгаалалтад үлдээсэн юм. Фернан давшиж байгаа армид орж, хороотой Жоо хамт хил дээр очиж Линийн дэргэдэх тулалдаанд оролцжээ.

Туллдааны дараах шөнө тэр, дайсантай нууц холбоотой байсан нэгэн генералын дагуулаар гарчээ. Тэр генерал англичууд уруу оргон очих ёстой байсан бөгөөд Фернаныг хамт явахгүй юу гэжээ. Фернан зөвшөөрч, генералыг дагаж явжээ.

Хэрвээ Наполеон ширээндээ хэвээрээ байсан бол урвагч гэж шийтгэгдэх байсан Фернаны тэр явдал Бурбончуудын үед гавьяатай хэрэг болжээ. Тэгээд Францад буцаж ирэхдээ бага даргын погонтой ирсэн бөгөөд тэр генерал нь ванд их л нэр хүндтэй хүн байсан учир Фернаныг хайр халамжгүй орхисонгүй. Дангларыг анхны хонжоотой дамын наймаагаа явуулж эхэлсэн яг тэр үе буюу испанийн дайн болж байсан мянга найман зуун хорин гурван онд ахмад цолоор шагнажээ. Фернан испани гаралтай хүн байсан учир хүмүүсийн зан сэтгэлийн байдал ямар байгааг тандуулахаар Мадрид уруу явуулжээ. Тэр тэнд Данглартай уулзаж ярилцан өөрийнхөө талаас зарим нэг үүрэг авч хороогоо өөрийнхөө сайн мэддэг бусдын үл мэдэх, роялистуудын хамгаалж байсан хавцлаар оруулж ер нь нэг үгээр хэлбэл, богино хугацааны энэ аяллын үед гавъяа байгуулж, Трокадерог эзлэн авсны дараа хурандаа цолоор дэвшиж Хүндэт легионы хэрээс одон ба гүн зэргээр шагнагджээ.

- Өө, хувь заяа, хувь заяа! Гэж лам шивнэв.

- Тийм ээ, гэвч та сонсож бай. Бас болоогүй байна. Испанийн дайн төгсөж, Европт урт удаан хугацаагаар энх тайван тогтвол Фернаны эрх тушаалд хор хүргэж болох байлаа. Зөвхөн грег л тургийн эсрэг босож тусгаар тогтнолын төлөө дайн эхэлж нийтийн анхаарал Афинд хандсан юм. Тэр үед грегүүдийг өрөвдөж дэмжих явдал заншил болоод байлаа. Францын засгийн газар тэднийг илэрхийгээр дэмжээгүй боловч амьхнаараа тусалж байсныг та мэдэх байх, Фернан тэр үеэр армид бүртгэлтэй хэвээрээ грег явах зөвшөөрөл гуйсан юм.

Тэгээд хэсэг хугацаа өнгөрсний дараа Морсер гүн (түүнийг тэгж нэрлэдэг байсан) Али-пашид албанд орж сургагч генерал тушаалтай болжээ гэдгийг мэдэж авцгаав. Али-паша алагдсаныг та мэднэ, гэвч үхэхийнхээ өмнө Фернаныг харамгүй шагнажээ. Фернан, Францдаа хүрч ирээд дэслэгч генерал цолтой болсон юм.

- Одоо ямар байгаа вэ?... гэж лам асуухад,

- Одоо тэр Парисын Эльдер гудамжинд хорин долоон номерын сайхан ордонд сууж байгаа гэж Кадрусс үргэлжлэн яриw.

Лам нэг юм хэлэх гэснээ, эргэлзэн зогссоноо их хүч гарган байж,

- Аа Мерседес? Түүнийг алга болчихсон гэж би дуулсан гэw.

- Алга болсон гэнэ ээ! гэж Кадрусс хэлээд - Тийм ээ нар өглөө улам ч сайхан гэрэлтэй болж мандахын тул орой шингэдэг юм гэв.

- Бас түүнд зол жаргал тохиолдсон юм биш биз дээ? гэж лам ёжтойхон асуухад,

- Мерседес парисын ямбатнуудын дотор тэргүүн зэргийн авгай нарын нэг нь болсон гэж Кадрусс хариулав.

- Цааш нь ярь ярь гэж лам хэлээд - Ямар нэгэн зүүд зэрэглСэний тухай яриа сонсож байгаа юу шиг санагдчихлаа. Гэвч өөрөө тЭйм ер бишийн хачин явдал үзсэн хүн болохоор таны ярианд онц гайхахгүй байна гэв.

- Мерседес анхандаа Эдмоноос хагацаасан тэр гэнэтийн цохилтод цөхрөн гунихарч байлаа. Эрхэм де Вильфорыг гуйж гувшин, Дантесын эцгийг асран сувилж байсан тухай би танд дээр ярьсан шүү дээ. Тэгж байтал Фернан цэрэгт явж Мерседесийн уйтгар гуниг улам нэмэгдсэн юм. Фернаны үйдсэн гэмт явдлыг мэдэхгүй байсан болохоор түүнд ах шигээ л хайртай байсан.

Фернан явж, Мерседес ганцаараа үлдлээ.

Уй гашуугаас болж үхэж байсан өвгөнөөс өөр юу ч үгүй үлдсэн хөөрхий бүсгүй гурван сарын турш уйлан унжиж байлаа. Эдмон, Фернан хоёрын алинаас нь ч сураг чимээ гарсангүй.

Мерседес нэгэн өдөр хуучин заншлаараа Марселаас Каталан уруу явсан хоёр замын салаан дээр өдөржингөө суугаад үдэш нь урьд урьдынхаасаа улам ч их гунигтайгаар гэртээ харьжээ. Энэ хоёр замын алинаар нь ч, түүний хайртай хүн ба найз нөхрийн хэн нь ч ирсэнгүй, тэдний нэгнийх нь ч тухай мэдээ чимээ сонстсонгүй.

Гэтэл таних хөлийн чимээ гарахад сэтгэл нь хөдлөн чагнатал үүд онгойж бага даргын хувцастай Фернан орж ирсэн байна.

Бүсгүй хэдийвээр түүнийг хүсэн мөрөөдөж уйтгарлаж байгаагүй ч, урьды нь амьдралын хагас хугас буцаж ирэх шиг санагджээ. Мерседес баярласандаа гараас нь шүүрч авахад цаадах нь үүний нь хайрын сэтгэл гэж боджээ. Гэвч энэ нь олон хоног ганцаардаж байснаа арай гэж ханьтай боллоо гэсэн бодлоос нь үүссэн жирийн нэг баяр хөөр байжээ. Тэгэхдээ Мерседес түүнийг жигшин үздэггүй, түүнд дурладаг ч үгүй зүгээр л байдаг юм санжээ. Мерседесийн зүрх өөр хүнд хамаарагдах бөгөөд тэр хүн нь алс хол... алга болж... магадгүй үхсэн ч байж мэдэх байлаа. Мерседес ингэж бодонгоо цорхирон уйлж арга нь тасран ихэд гуньдаг байсан. Гэвч урьд нь түүнд хүмүүс ийм санааг хэлэхэд Мерседес түүнээс зайлсхийдэг байсан бол, одоо ийм бодол түүнд аяндаа төрөх болжээ. Тэгээд ч бас

Дантес өвгөн: «Манай Эдмон нас барсан, хэрвээ амьд байгаа бол бидэн дээрээ ирчихсэн байлгүй яах вэ» гэж үргэлж үглэсээр байж.

Өвгөн талийгаач болсон гэдгийг би танд хэлсэн шүү дээ. Хэрвээ өвгөн амьд байсан бол Мерседес өөр хүнтэй хэзээ ч суухгүй байсан байж магадгүй. Өвгөн түүнийг үнэнч биш гэж зэмлэх байсан юм. Фернан ч үүнийг ойлгож байсан, тэгээд өвгөнийг үхсэн гэж дуулаад буцаж ирсэн, энэ удаа ирэхдээ бага даргын цолтой ирсэн. Фернан түрүүчийнхээ ирэлтэд Мерседест дурлалын тухай юу ч цухуйлгаагүй харин хоёр дахь удаагийнхаа ирэлтэд хайртай дуртай гэдгээ мэдэгджээ. Тэгэхэд нь Мерседес түүнийг Эдмоноо хүлээж цөхөртөл бас хагас жил хүлээ гэж хэлжээ.

- Нээрээ ч гээд лам гашуунаар инээмсэглэж - Нийтдээ бүтэн хагас жил болжээ! Хамгийн их тачаангуй дурласан хүн үүнээс илүү яаж ч шаардах билээ дээ? гэж хэлээд, английн нэг яруу найрагчийн шүлгийг «Frailty. The name is woman» хэмээн ама дотроо бувтнавал, Кадрусс цааш нь үргэлжлүүлэн,

- Тэгээд тэр хоёр хагас жилийн дараа Аккулийн сүмд гэрлэх ёс гүйцэтгэсэн гэж ярив.

- Энэ чинь Дантестай гэрлэх ёс гүйцэтгэх байсан сүм мөн биз гэж лам шивнээд - Зөвхөн болзоот эрээ сольсноос өөр юмгүй шив дээ гэв.

- Ингэж Мерседес хүнтэй суусан гэж Кадрусс үргэлжлүүлээд - Гэхдээ жил хагасын өмнө суух гэж байсан бөгөөд одоо хүртэл сэтгэлийнхээ гүнд дурласан хэвээр байгаа хүнтэйгээ гэрлэх ёс гүйцэтгэх гэж байсан «Нөөц»-ийн хажуугаар өнгөрөхдөө Мерседес хэдий тайван мэт байсан боловч муурч унасан.

Фернан зол жаргалтай болсон боловч амар тайван байж чадсангүй. Би түүнийг тэр үед нь харсан. Эдмоныг хүрээд ирчих вий гэж үргэлж айж байсан юм. Ийм учраас ч тэр эхнэрээ хол аваачих, өөрөө ч зайлан явах гэж яарсан хэрэг. Каталанд байхад дэндүү их аюултай, дэндүү олон юм дурсагдан санагдах байлаа.

Тэр хоёр хурим хийснийхээ дараа долоо хоноод яваад өгсөн.

- Аа, түүнээс хойш та Мерседестэй дахин уулзсан уу?

- Уулзсан, испанийн дайны үед Фернан түүнийг Перпиньянд орхиод явсан хойно нь уулзсан. Тэгэхэд хүүгээ хүмүүжүүлэх ажилтай байсан.

Ширээт лам татвасхийн,

- Хүүгээ гэнэ ээ? гэж асуув.

- Тийм ээ бяцхан Альбераа гэж Кадрусс хариулав.

- Тэр хүүхэн хүүгээ сургаж байсан гэхийг бодвол өөрөө эрдэм боловсролтой болжээ дээ? Эдмон түүнийг жирийн нэг загасчны охин, өнгө үзэсгэлэн боловч эрдэм номгүй хүн гэж надад ярьсан нь санагдаж байна гэхэд,

- Тэр өөрийнхө болзоот хүүхнийг тийм муу мэддэг байсан юм гэж үү? Хэрвээ хатан хааны титмийг хамгийн ухаантай хамгийн сайхан толгойд өмсгөдөг байсан бол Мерседес хатан хаан болчих байсан юм. Хувь заяа түүнийг өндөрт өргөж, өөрөө ч улам улам өөдөлсөн хүүхэн. Тэр эмэгтэй зураг зурж сураад, ер нь юм бүхэнд суралцаж амжсан, гэхдээ бид хоёр хоорондоо л гэж ярихад тэр хүүхэн мартагнах, сэтгэл санаагаа хуурах гэж энэ бүх зүйлээр оролдож байсан юм. Мерседес сэтгэлдээ дүүрэн байгаа тэр зүйлийг сонсохгүй байхын тулд өөр зүйлээр оролдож байлаа. Гэвч одоо энэ бүгдээр оролдохоо больсон байх ёстой. Эд хөрөнгө, нэр хүнд түүнийг тайтгаруулсан байх. Одоо баян, нэр төртэй, харин тэгэхдээ... гэснээ Кадрусс дуугүй болж зогсов. Тэгэхэд лам,

- Юу вэ? гэж асуув.

- Харин тэгэхдээ Мерседес жаргалтай биш гэдгийг би бүрэн итгэлтэй хэлнэ гэж Кадрусс хэлэхэд,

- Та яагаад тэгж бодож байна? гэж лам асуув.

- Яагаад гэвэл: би ядарч доройтоод, хуучин найз нөхөд минь туслах болов уу гэж горьдож байлаа. Тэгээд би Данглар дээр очлоо, тэгсэн чинь намайг хүлээж ч авсангүй. Дараа нь би Фернан дээр очлоо, тэгэхэд надад зарцаараа зуун франк өгүүлсэн.

- Тэгвэл та тэр хоёрын хэнтэй нь ч уулзсангүй хэрэг үү?

- Үгүй, харин гүнгийн хатан Морсер намайг харсан.

- Яаж?

- Намайг гарахад, миний хөлд түрийвч уналаа. Дотор нь хорин таван луйдар байсан. Би бушуухан дээшээ харахад, Мерседес цонхоо хааж б йлаа.

- Аа эрхэм де Вильфор? Гэж лам асуув.

- Тэр хэзээ ч миний найз байгаагүй, би түүнийг таних ч үгүй учраас юу ч гуйж чадаагүй.

- Тэр хүн одоо яасан бэ? Эдмонд гай тохиолдоход чухам яаж оролцсон юм бэ?

- Мэдэхгүй, харин Эдмоныг баривчилсан дараахан де Сен-Меран охинтой сууж Марселиас яваад өгсний нь л мэднэ. Бас л түүнд бусдын адил аз зохиол инээмсэглэсэн байлгүй. Тэр одоо Данглар шиг баян, Фернан шиг өндөр хэргэмтэй байгаа байх. Харин би л ганцаараа үгээгүй хоосон, ядуу зүдүү өчүүхэн амьтан, бурханд мартагдчихаад сууж байна.

- Та андуурч байна, найз нөхөр минь гэж ширээт лам хэлээд - Бурхны үнэн шударгын шүүх алгуур аажим ажиллаж байгаа болохоор нь л биднийг мартчихсан юм байх гэж санацгаадаг юм. Гэвч эрт орой алин боловч бурхан биднийг дурсан санах болно. Үүний баталгаа нь энэ мөн гээд лам хармаанаасаа өнөөх очир эрдэнийг гаргаж Кадрусст өгөөд - Май, найз минь. Энэ очир эрдэнийг ав, танд ногдох ёстой юм байна гэв.

- Юу! Надад ганцааранд минь өгч байгаа юм гэж үү? Гэж Кадрусс дуу алдаад - Юу гэсэн үг вэ? Та надаар доог хийж байна уу? гэж асуув.

- Энэ очир эрдэнийг Эдмоны найз нөхдүүдэд хувааж өгөх ёстой байсан юм. Гэвч Эдмонд ганцхан найз байсан болохоор энэ эрдэнийн чулууг хуваах явдалгүй. Энэ чулууг авч худалд. Энэ чулуу тавин мянган франк хүрнэ гэж би танд түрүүнд хэлсэн, энэ мөнгө таныг хоосролоос чинь аварна гэж би итгэж байна.

- Эрхэм ламтан гээд Кадрусс хулчигнан гараа сунгаж, нөгөө гараараа нүүрэн дээгүүрээ урсаж байгаа хөлсийг арчиж - Эрхэм лам аа, хүний жаргал, гомдлоор бүү тоглоом хийгээч дээ гэж хэлэв.

- Аз жаргал ба арга тасрах гэдгий чинь би сайн мэднэ, тэгэхээр би хүний ийм сэтгэлээр тоглоом хийхгүй хүн. Ав л даа, харин оронд нь... гэж ламыг хэлэхэд Кадрусс очир эрдэнэ уруу сарвайж байсан гараа татав.

Лам инээмсэглэж,

- ... Оронд нь, надад өвгөн Дантесын задгай зуухан дээр Моррелийн тавьж үлдээсэн түрүүвчийг аль. Тэр түрүүвч танд одоо хүртэл бий гэж та хэлсэн байх аа гэв.

Кадрусс улам гайхан, том царс модон шүүгээ уруу очиж, онгойлгоод хэзээ ч юм алтан шармал гуйлаар бүсэлсэн, гандсан улаан торгон түрийвчийг гаргаж өгөв.

Лам түрийвчий нь аваад доржпаламаа Кадрусст өгөв.

- Эрхэм та үнэхээр гэгээн хүн юм! Гэж Кадрусс дуу алдаад, - Эдмон танд энэ очир эрдэнийг орхисон гэж хэн ч мэдээгүй, тэгэхээр та үүнийг өөрөө авчихаж болох байсан гэв.

«Уухай! Чи бол тэгэх л байсан даа!» Гэж лам өөр зуураа хэлэв.

Лам босож, бүрх малгай, бээлий хоёроо аваад,

- Миний хэлэхийг сонсоорой! Таны ярьсан бүхэн чинь яг үнэн юм байгаа биз дээ? Би танд бүрэн итгэж болох уу? гэж асуухад,

- Эрхэм лам минь, тэр булад христосын дүртэй гэгээн загалмай байна. Энэ ширээн дээр эхнэрийн минь хөлгөн судар хэвтэж байгаа. Та тэр номыг нээ, би энэ судар болон христосын цовдлуулсан загалмайн өмнө танд болсон явдлыг яг үнэнээр нь хэлж байгаагаа, эрлэгийн өмнө шүүлгэх өдөр, эрлэгийн элч түүний чихэнд яг л миний хэлснийг давтана гэдгийг тангараглая гэж Кадрусс хэлэв.

- За тэгвэл сайн гэж лам Кадруссын дууны өнгөнөөс үзвэл үнэн хэлж байгаа нь лавтайг мэдэж хэлээд,

- За тэгвэл сайн, энэ мөнгө танд тус болоосой гэж хүсье! Баяртай, би одоо бие биедээ хорт муу үйл үйлддэг хүмүүсээс дахин хөндийрч сүмдээ буцаж очих минь гэв.

Тэгээд лам сэтгэлийнхээ үгийг урсган байгаа Кадруссаас арай хийн салж, өөрөө үүдний түгжээг тайлж гараад мориндоо мордоод баярласандаа олон үг хэлж байгаа буудлын эзэнд дахин мэхэсхийн ёслоод ирсэн замаараа буцаж явав.

Кадрусс эргэж харахад ар талд нь угийнхаасаа улам ч цонхийж, улам ч их чичрэн салганасан эхнэр нь зогсож байв.

- Миний дуулсан үнэн үү? Гэж хүүхэн асуухад, баярласандаа бараг ухаан алдах шахсан Кадрусс,

- Юу тэр вэ? Очир эрдэнийг ганц манайд өглөө гэдэг үү? Гэж асуув.

- Тийм ээ.

- Гарцаагүй үнэн, очир эрдэнэ надад байна.

Эхнэр нь түүн өөд харснаа сөөнгө дуугаар,

- Энэ чинь хэрвээ хуурамч эд байвал яана гэж асуув.

Кадруссын царай зэвхийрч хөл нь гуйвлаа.

- Хуурамч ий! Хуурамч ... Аа тэр надад яах гэж хуурамч очир алмас өгөх билээ? Гэж аман дотроо шивнэв.

- Яах вэ дээ, чалчаа минь, чиний нууцыг хуурч байгаад дуулах гээ биз.

Ийм таамаглалд цохиулсан Кадрусс байрандаа хөшсөн мэт хөдлөлгүй зогсов. Тэгээд минутын дараа Кадрусс малгайгаа шүүрэн авч, зангидсан улаан алчуур дээрээ өмсөөд,

- Одоохон мэдээдэхье гэв.

- Яаж?

- Бокерт яармаг нээгдсэн, тэнд Парисаас олон инжиан ирсэн, би тэдэн дээр очиж энэ чулуугаа үзүүлье. Эхнэр минь чи гэрээ мэдэж байгаарай, би хоёр цаг болоод ирнэ гэж хэлээд Кадрусс үл таних өнөөх хүний явсан зүгийн эсрэг тал уруу гүйв.

Карконта ганцаараа үлдээд,

- Тавин мянган франк! Энэ ч мөнгө... гэхдээ баялаг биш дээ гэж бувтнан зогсов.

7. Шоронгийн данс

Бельгард Бокер хоёрын хоорондох зам дээр бидний дээр өгүүлсэн яриа болсны маргааш нь хөх цамцтай шаргал өмдтэй цагаан хантаазтай, байдал төрх яриа хөөрөөгөөрөө цэвэр англи хүн Марсель хотын даргын ирэв.

- Өршөөлт эзэн минь, би бол ромын Томсон ба Френч гэдэг банкны төлөөлөгч хүн. Бид Марселийн «Моррель ба түүний хүү» гэдэг худалдааны газартай арав гаран жил холбоо харилцаатай байгаа юм. Энэ пүүсийн хөрөнгөнд манай зуун мянган франк эргэж байдаг болохоор бид түүнийг дампуурч байгаа гэж дуулаад сэтгэл зовж байна. Иймд энэ худалдааны газрын тухай та нараас асууж сураглах гэж Ром хотоос хэрэг болгож ирлээ гэж тэр хүнийг хэлэхэд, хотын дарга,

- Өршөөлт эзэн м'Энь, сүүлийн жилүүдэд эрхэм Моррелийг зол завшаангүй явдлууд дагаж, дөрөв таван хөлөг онгоцоо дараагаар алдаж, хэд хэдэн дампууралд орж хохирол үзсэн. Хэдийгээр надад арван мянга орчим франкын өртэй боловч, би танд түүний санхүүгийн байдлын тухай ямар нэгэн мэдээ өгөх боломж алга даа. Хэрвээ та намайг хотын даргын хувьд, эрхэм Моррелийн тухай бодлоо хэлнэ үү гэвэл, би танд түүнийг одоо хүртэл үүргээ цаг тухайд нь яг таг нарийвчлан биелүүлж байгаа маш үнэнч хүн гэж хариулах байна. Түүний тухай хэлж чадах бүх зүйл энэ байна даа. Хэрвээ энэ танд хангалтгүй байвал Ноайль гудамжны арван тавдугаар байшинд суудаг шоронгийн байцаагч эрхэм де Бовильтай уулз л даа. Хэрвээ андуураагүй бол, тэр хүн тэдний фирмд хоёр зуун франк буюу минийхээс үлэмж их мөнгө хийсэн болохоор илүү нухацтай мэдээ өгч чадах байх гэж хотын дарга хариулав.

Англи хүн хотын даргын эелдэг харьцааг үнэлсэн бололтой мэхийн ёслоод гарч, жинхэнэ британ хүний маягаар алхлан заасан гудамж уруу явав.

Эрхэм де Бовиль албаны өрөөндөө сууж байлаа. Англи хүн түүнийг харангаа байцаагчтай урьд нь уулзаж байсан хүн шиг хачин гайхсан янзтай хөдлөв. Гэвч эрхэм де Бовилийн ухаан санаа нь тэр чигээрээ шал өөр юманд хандаж, байдгаараа цөхөрсөн байсан болохоор өнгөрсөн баларсан үеийн тухай дурсан санах ч аргагүй болсон байжээ. Англи хүн гэм бус зан болсон ердийн хайнга байдлаараа Марсель хотын даргаас асуусан өнөөх асуултаа яг л өгүүлбэр алдалгүй давтан асуув.

- Ай эрхэм минь! Гэж эрхэм де Бовиль дуу алдааад - Таны болгоомжилж байг а тань харамсалтай нь бүрэн үндэстэй бөгөөд таны өмнө гайхаш нь тасарсан хүн сууж байна. Эрхэм Моррелийн хөрөнгөд миний хоёр зуун мянган франк эргэж байгаа юм. Энэ хоёр зуун мянган франк бол хоёр долоо хоногийн дараа хүнтэй суулгах гэж байгаа охины минь инж болох юм. Энэ хоёр зуун мянгыг минь, энэ сарын арван таван, дараа сарын арван таван хоёрт хоёр тасалж төлж дуусгах ёстой. Тэгээд тогтоосон хугацаанд мөнгийг минь өгөхийг эрхэм Моррельд мэдэгдсэн. Гэтэл хагас цагийн өмнө Моррель ирж, хэрвээ «Фараон» онгоцоо арван таванд багтаж ирэхгүй бол уг мөнгийг төлж өгөх боломжгүй болох нь гэж хэлээд явлаа гэв.

- Энэ чинь төлөх хугацааг хойшлуулж өгөөч гэсэнтэй үлэмж адилхан юм гэж англи хүн хэлэхэд, эрхэм де Бовиль толгойгоо барьж,

- Дампууралтай адилхан юм гэж хэлбэл дээр биш үү! гэв.

Англи хүн юм бодож байснаа дараа нь,

- Тэгэхээр энэ өрийн талаар хүлээсэн үүрэг таны сэтгэлийг зовоож байна аа даа? Гэж асуув.

- Би үүнийг найдваргүй болсон зүйл гэж үзэж байна.

- Тэгвэл би үүнийг чинь танаас худалдаж авъя.

- Та юу?

- Тиймээ би.

- Гэхдээ их бууруулж авна биз дээ?

- Үгүй, хоёр зуун мянган франкаар нь авна. Манай худалдааны газар гээд англи хүн инээж - Иймэрхүү юмаар оролддоггүй юм гэж нэмж хэлэв.

- Тэгэхээр та надад төлөхдөө...
 - Бэлэн мөнгөөр нь өгнө гэж хэлээд англи хүн эрхэм Бовилийн алдах гэж айж байсан хэмжээнээс хоёр дахин их боодолтой ца сан мөнгө хармаанаасаа гаргаж ирэв.
- Эрхэм де Бовилийн баярын магнай тэнийсэн боловч биеэ барьж чадаад,
- Өршөөлт эрхэм минь, та энэ мөнгөнийхөө зургаан хувийг нь ч олж авч чадахгүй гэдгийг урьдчилан сануулах хэрэгтэй байна гэв.
 - Энэ бол надад хамаагүй. Харин намайг явуулсан Томсон ба Френк банкны хэрэг. Өрсөлдөгч пүүсээ унагаж авах гэж л яарч байж магадгүй юм шүү дээ. Ямар ч байлаа гэсэн би энэ мөнгийг таны гарын үсэгтэйгээр тоолж өгөхөд бэлхэн байна. Тэгэхдээ танаас оронд нь шагнал авмаар байна гэж англи хүн хэлэв.
 - Тэгэлгүй яах вэ! Энэ бол маш шударга хүсэл гэж де Бовиль дуу алдаад - Шагнал бол уг нь бүтэн хагас хувь нь байгдаг юм, гэвч та хоёр, гурав, таван хувийг авах уу? Илүү авах уу? гэж асуув. Тэгэхэд англи хүн инээгээд,
 - Би бол пүүстэйгээ адил хүн. Ийм юм хийдэггүй хүн, харин шал өөр юмаар шагнал авах гэсэн юм гэхэд,
 - Хэл л дээ, би таны хэлэхийг дуулъя гэв.
 - Та шоронгуудын байцаагч байх аа?
 - Арван тав дахь жилдээ явж байна.
 - Танд шоронгийн данс бүртгэл байдаг уу?
 - Мэдээж хэрэг, байлгүй яахав.
 - Энэ дансанд чинь хоригдлуудын холбогдолтой баримт бичгүүд байдаг биз дээ?
 - Хоригдол бүрт тусгай хэрэг нээсэн байдаг.
 - Тэгэхээр ийм байна, өршөөлт эрхэм минь. Ромд намайг хүмүүжүүлсэн нэг лам байсан юм. Тэгтэл тэр маань гэнэт алга болчихсон. Сүүлд нь түүнийг Иф цайзад байсан гэж дуулсан юм. Тэгэхээр түүний үхсэн тухай зарим нэг чэдээ баримт дуулах гэсэн юм.
 - Түүнийг хэн гэдэг байсан бэ?

- Ширээ! лам Фариа.
 - Одоо би түүнийг сайн санаж байна гэж эрхэм де Бовиль дуу алдаад- Тэр чинь солиотой хүн байсан юм гэв.
 - Тийм ээ би тэгж дуулсан.
 - Солиотой байсан нь эргэлзэх юмгүй.
 - Тийм байж болох юм аа, гэвч яаж солиордог байсан бэ?
 - Нэгэн эрдэнэ булсан газрыг, хэмжээлшгүй ир эрдэнэсийн санг мэднэ гээд, өөрийгөө суллан тавибал засгийн газарт асар их мөнгө өгнө гэдэг байсан юм.
 - Хөөрхий амьтан! Тэгээд нас барчихсан уу?
 - Тэгсэн, хагас жилийн өмнө, хоёрдугаар сард.
 - Та юм мартдаггүй хүн юм аа.
 - Ширээт ламыг үхэх үед хачин жигтэй явдал болсон учраас би марталгүй санаж байгаа юм.
 - Ямар явдал болсон юм бол би мэдэж болох уу? гэж асуухад ажигч хүн бол түүний хайнга царайд сонирхсон шинж байхыг олж хараад гайхах байсан биз.
 - Болноо, бонапартын төлөөлөгч байсан бөгөөд түүнийг мянга найман зуун арван таван онд эргэн ширээндээ суухад нь ихэд тус хүргэсэн үлэмж шийдэмгий, аюултай хүн сууж байсан өрөөнөөс ширээт ламын сууж байсан өрөө таваас арван фут зайтай байсан юм.
 - Нээрээ юу? гэж англи хүн асуухад,
 - Нээрэн. Би түүнийг мянга найман зуун арван зургаа, мянга найман зуун арван долоон онд биеэрээ үзэх учрал тохиолдсон юм. Бид түүний хоригдож байсан өрөөнд салаа шахам цэрэгтэй орсон, тэгэхэд тэр хүн надад их хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн. Түүний царайг би хэзээ ч мартажгүй гэв.
- Англи хүний уруул дээр инээмсэглэл цухалзаж,
- Тэгэхээр та тэр хоёр өрөөг... гэхэд,
 - Тэр хоёр өрөө хоорондоо таван фут зайтай байсан юм. Гэвч, тэрхүү Эдмон Дантес гэгч...

- Тэр аюултай хүнийг...
- Эдмон Дантес гэдэг байсан юм, эрхэм минь. Бодвол тэр Эдмон Дантес багаж хэрэгсэл олсон ч юмуу өрөөнийхөө хооронд нүх гаргаад түүгээрээ хоёр биетэйгээ харьцаж байжээ.
- Тэр нүхийг оргох гэж ухсан юм байжээ дээ?
- Тэгэлгүй яах вэ, гэвч тэр хоёрын аз харихад ширээт ламд саа өвчин дайрч үхсэн.
- Ойлголоо, ийм учраас тэд оргож чадсангүй дээ.
- Үхсэн нь ч чадаагүй гэж эрхэм де Бовиль хариулаад - Гэвч амьд нь чадсан. Түүгээр ч барахгүй Дантес үүгээр өөрийнхөө оргох ажлыг түргэсгэсэн. Тэр бодвол, Иф цайзад үхсэн хүнийг жирийн нэг хүүр оршуулдаг газар аваачиж булдаг гэж бодсон байх. Тэгээд үхсэн хүнээ өөрийнхөө өрөөнд авчирч орхиод, өөрөө өвгөнийг хийж байсан шуудай дотор орж, оршуулах цагийг хүлээж хэвтжээ.
- Энэ бол түүний зүрхтэйг харуулсан хэрэг байна даа гэж англи хүн хэлэв.
- Түүнийг маш аюултай хүн байсан гэж би танд түрүүн хэлсэн. Харин аз болоход тэр өөрөө улсад тээр болохоо больсон юм.
- Яаж тэр билээ?
- Та ойлгохгүй байна гэж үү?
- Үгүй шүү.
- Иф цайзад хүүр оршуулах газар гэж байдаггүй, үхсэн хүмүүсийг хөлд нь гучин пүүгийн ширэм зүүгээд далайд хаячихдаг юм.
- Тэглээ гээд юу болох гэж? Хэмээн англи хүн дүйнгэ царай гарган асуув.
- Түүний хөлд гучин пүүгийн ширэм зүүгээд л далайд хаячихсан.
- Яалаа гэж дээ! гэж англи хүн дуу алдав.
- Тэгсээн, эрхэм минь. Оргох гэсэн хүн хадан дээрээс шидчихээр яасан их гайхаа бол. Тэр үед нь царайг нь харах сан гэж байцаагч үргэлжлүүлэн ярив.
- Энэ ч хэцүү хэрэг л дээ.

Хоёр зуун мянган франкаа алдалгүй олж авах итгэл төрсөн эрхэм де Бовилийн ухаан санаа нь улам ч тавиун болж,

- Ялгаагүй, ямар байсныг нь би төсөөлж байна! гээд учиргүй чанга инээхэд англи хүн,

- Би ч бас адил төсөөлж байна гээд англи хүмүүсийн инээдэг шиг ганцхан завжаараа инээв.

Хамгийн түрүүн хайнга байдалдаа орсон англи хүн,

- Тэгээд оргодол маань далайн ёроолд орчихоо шив дээ гэв.

- Усанд шидсэн түлхүүр шиг л...

- Тэгж Иф цайзын комендант солиотой, галзуу хоёроос нэг зэрэг салсан юм биз дээ?

- Чухамдаа тийм.

- Энэ явдлын тухай мэдээж баримт баталгаа гаргаа биз дээ? гэж англи хүн асуув.

- Тэгсэн тэгсэн, нас барсан тухай гэрчилгээ бий. Хэрвээ Дантест хамаатан садан гэж байдаг бол түүний үхсэн амьдыг мэдэж болно гэдгийг та ойлгож байгаа биз.

- Тэгэхээр одоо түүнээс өв хөрөнгө залгамжилж авах гэж хүлээж байгаа хүн бий бол санаа зовох юмгүй байж болох нь ээ. Тэр эргэлт буцалтгүй үхсэн үү?

- Тэгэхээр барах уу даа! Тэднийг баримт гэрчилгээ авна гээд ирвэл тэр дор нь л өгнө.

- Хөөрхий зайлуул тайван нойрсог доо гэж тэр англи хүн хэлээд - Одоо дансандаа эргэж оръё гэв.

- Таны хэлдэг зөв. Миний яриа таныг өөр тийш нь татчихлаа. Уучлахыг гуйу.

- Юу гэж тэр билээ? Ийм юм ярилаа гэж үү? Үгүй шүү таны яриа надад их сонин саагдлаа.

- Нээрээ ч сонин яриа шүү. Тэгэхээр та хөөрхий ламтай холбогдох зүйлийг үзье гэж хүсэж байна уу? Номхон ч амьтан байсан даа.

- Та надад их тус болж байна.
- Миний өрөөнд очъё. Би танд бүгдий нь үзүүлье.

Тэгээд тэр хоёр де Бовилийн өрөө уруу оров.

Байцаагч үнэн хэлжээ. Юм бүр нь үлгэр жишээ болохуйцаар эмх цэгцтэй байв. Хэрэг бүхэн өөрийн дугаартай, зохих байрандаа байна. Байцаагч англи хүнээ өөрийнхөө сандал дээр суулгаад Иф цайзад холбогдох хавтсыг авч өгөөд, чөлөөтэй үзэх бололцоо өгч өөрөө буланд суугаад, сонин уншиж гарав.

Ширээт лам Фариатай холбогдох баримт бичгүүдийг англи хүн зовлонгүй олов. Гэхдээ де Бовилийн ярьсан тохиолдлыг тэр ихэд сонирхсон бололтой. Англи хүн бичиг баримтыг уншин хуудас хуудсаар нь эргүүлсээр Эдмон Дантесын тухай бичиг баримт хүрэв. Бүх зүйл зүй ёсоороо байлаа. Ховын бичиг, байцаалтын тогтоол, Вильфорын цохолттой Моррелийн өргөдөл байв. Тэгэхээр нь ховын бичгийг сэмхэн авч хармаандаа нуугаад, байцаалтын тогтоолыг уншиж, Нуартъегийн нэр тэнд дурдагдаагүй байгааг харав. Моррель вангийн прокурорын туслахын зөвлөснөөр 1815 оны дөрөвдүгээр сарын арванд Наполеоны хаан ширээнд эргэж суусан үед, эзэнт улсын хэрэгт Дантесын оруулсан хувь нэмрийг хэтрүүлэн бичиж, дээр нь Вильфор батлан цохсон цохолттой өргөдөл бичсэн байсныг мөн гүйлгэн уншив. Тэгээд л бүх зүйлийг ойлгов. Наполеоны нэр эээр явуулсан боловч Вильфор цааш нь дамжуулалгүй авч хоцорсон энэ өргөдөл хоёр дахь удаагийн дахин сэргэлтийн үед вангийн прокурорын гарт аймшигт зэвсэг болжээ. Тийм учраас дараах хавсралт цохолтыг үзээд гайхсангүй.

-

Эдмон Дантес

Засаршгүй бонапартич, узурпаторыг Эльба арлаас эргэж ирэхэд идэвхтэй оролцсон. Маш нууцаар нарийн хяналтад байлга.

Эдгээр мөрнүүдийн доод талд өөр гараар:

«Яах ч аргагүй юм » гэж бичсэн байв.

Моррелийн өргөдөл дээр цохсон цохолтыг нэмж бичсэн зүйлтэй нь зэрэгцүүлэн үзээд, тэр уг цохолт нэмэлт хоёрыг нэг гар, өөрөөр хэлбэл Вильфорын гараар бичигдсэн болохыг мэдэв.

Цохолтын хажууд тэмдэглэсэн зүйл нь ахархан богинохон хугацаанд боловч Дантесын хувь заяаг шийдвэрлэхэд оролцож байсан шоронгийн байцаагчийн гарын үсэг мөн болохыг англи хүн танив. Гэвч энэхүү тэмдэглэсэн зүйлийг үзэхэд өөр ямраар ч оролцож болох бололцоогүй байсан ажээ.

Бидний дээр хэлсэнчлэн эрхэм де Бовиль ширээт лам Фариагийн шавьд саад болохгүйн тулд хүндэтгэл үзүүлэн буланд суугаад «Цагаан тугийг» уншиж байв.

Ийм учраас хоёрдугаар сарын хорин долооны зургаан цагт шуудангийн хайрцагнаас гаргаж авсныг тодорхойлсон Марселийн шуудангийн тэмдэгтэй, Данглар «Нөөц»-ийн сүүдрэвчинд сууж байгаад бичсэн ховын бичгийг англи хүн авч нугалаад хармаандаа хийхийг харсангүй.

Хэрвээ харсан байлаа ч гэсэн энэ өчүүхэн цаасыг юман төдий бодохгүй, харин өөрийнхөө хоёр зуун мянган франкыг чуха«члан үзэж, англи хүн бүх журмыг нь зөрчсөн ч түүнд саад болохгүй байсан биз ээ.

-Баярлалаа танд гэж англи хүн хэлээд хавтсаа чимээтэй хааснаа - Би хэрэгтэй бүх юмаа оллоо. Тэгэхлээр би одоо хэлсэн үгэндээ хүрэх үлдэж байна. Та надад зүгээр л авлаа гэсэн гарын үсэгтэй бичиг хийж аль, би бэлэн тоолоод өгье гэж хэлээд сууж байсан бичгийн ширээнийхээ цаанаас босож эрхэм ле Бовильд суудлаа тавьж өгөхөд, цаадах нь ёсорхолгүй суугаад гарын үсэгтэй бичгийг яаран хийв. Тэр завсар англи хүн ширээний буланд зогсож мөнгөн тэмдэгтүүдийг тоолж байв.

8. Моррелийн худалдааны пүүс

Моррелийн худалдааны пүүсийг мэддэг хүмүүсийн нэг нь, Марсель хотоос гарч хэдэн жил явж байгаад одоо бидний энэ тодорхойлон бичиж байгаа үед эргэж ирдэг юм гэхэд ир өөрчлөлт гарсан байхыг үзэх байлаа.

Буян нь дэлгэрсэн худалдааны пүүсний хөл хөгжөөнтэй, жаргалтай сэтгэл хангалуун байдлын оронд, цонхны хөшигний цаанаас цухалзах хөгжилтэй царай, хичээнгүйлэн ажиллаж суугаа буюу чихэндээ үзэг хавуулчихаад гудмаар гүйлдэж яваа албаны хүмүүсийн оронд, бараа таваар дүүрэн овоолж, хураасан хашаа, инээж хашхиралдаж байгаа ачаа бараа зөөгчдийн оронд, хаягдаж хүн амьтангүй зэлүүд болсон газрыг олж үзэх байлаа. Урьд тэднийд ажиллаж байсан олон ажилтны дотроос энэ хоосон гудам, хашаанд дөнгөж хоёрхон хүн үлджээ. Нэг нь Эмманюель Эрбо хэмээх хорин гурав орчим насны залуу хүн, энэ хүн эцэг эх нь дургүйцэх боловч эрхэм Моррелийн @хинд сэтгэлтэй учраас энд хоцорчээ. Нөгөөх нь сангийн няравын туслах байсан, өрөөсөн нүд нь сөлөр, Коклес гэдэг хочтой хүн. Урьд энд үүрлэн бужигналдаж байсан залуучууд түүнд ийм хоч өгсөн бөгөөд, тэр бүр үүндээ нэршчихсэн учраас хүн түүнийг ёстой нэрээр нь дуудвал лав эргэж харахгүй байсан биз.

Коклес эрхэм Моррелийн албанд хэвээр үлдсэн бөгөөд энэ үнэнч хүний байдалд өвөрмөц өөрчлөлт гарчээ. Тэр нэгэн зэрэг нярав хүртэл тушаал дэвшиж зарц хүртэл доошлон буурчээ.

Гэсэн хэдий боловч тэрээр сайн санаатай идэвхи зүтгэлтэй, үнэнч шударга хэвээрээ тоо бодлого гэдэг ганцхан асуудлаар бүхэл бүтэн ертөнцийн эсрэг, тэр ч байтугай Моррелийн өөрий нь өөдөөс ч гэсэн эсэргүүцэн босоход бэлэн, яаж ч элдэвлэж, будлиантуулж байсан, үржүүлэхийн хүрдэд л итгэлтэй байдаг Коклес хэвээрээ үлдэв.

Моррелийн пүүснийхэн цөмөөрөө гуниж гутарсан боловч ганцхан Коклес л огт ажигч үгүй байлаа. Үүнийг тэдэнд ижил дасал болоогүйгээс болсон юм гэж бодож болохгүй агаад харин ч тэдэнд гуйвшгүй итгэдгийн үр дүн байлаа. Сөнөх үйл нь ирсэн хөлөг онгоцыг зангуугаа авч хөдлөхөөс нь өмнө хулганууд зайлан оддог шигээр, элбэг дэлбэг загнах нь пүүсийн эзнээс шалтгаалж байсан албан хаагчид аажим аажмаар албан тасалгаа ба агуулах газруудыг дээр хэлсэнчлэн орхин зайлжээ. Гэвч Коклес тэдний орхин зайлахыг хараад, эд нар яагаад зугтааж байгаа юм бол ч гэж Үодсонгүй. Тэр бол юм бүхнийг тооны үүднээс үзэх бөгөөд, Моррелийн худалдааны пүүсэд хорин жил ажил хийхдээ төлбөрийг цаг тухайд нь төлж байснаас өөр юм үзээгүй тул их голд тавьсан усан тээрмийг хөдөлгөж байсан ус гэнэт зогсчихож яагаад ч болохгүйтэй адилаар энэ ажиллагаа гэнэт зогсчихно гэж огтхон ч санахгүй байв. Үнэндээ ч одоо хүртэл, Коклесийн итгэл гуйвж дайвхаар юм болоогүй байв. Сүүлчийн сарын төлбөр нь цагтаа төлөгдөв. Эрхэм Моррель андуурч далан сантим өөрөөсөө алдагдал болгосон байхаар нь илүү төлсөн тэр арван дөрвөн су-г тэр өдөрт нь эрхэм Моррельд эргүүлж өгөхөд цаадах нь уйтгартайгаар инээмсэглэн аваад бараг хоосорсон кассандаа хийгээд,

- Сайн байна Коклес минь, та энэ ертөнц дээр хамгийн сайн нярав юм гэж хэлэв.

Марсель хотын хамгийн үнэч хүн болох Моррельд магтуулах нь тавин экюгээр шагнуулахаас илүү сайхан байсан тул Коклес их л баяртай сэтгэл хангалуун явав.

Гэвч энэ хугацаандаа төлөгдсөн сүүлчийн төлбөрийн дараа, Моррельд хүнд бэрх өдрүүд тулгаран ирэв. Тэр, зээлдүүлэгчтэйгээ тооцоо хийхийн тулд сүүлчийнхээ аргыг хэрэглэж, Моррель хоосорчээ гэдэг цуу тараахгүйг бодож өөрөө Бокерийн яармаг дээр очиж эхнэр, охиныхоо үнэт эдлэл, алт мөнгөн чимэг, хоолны мөнгөн хэрэгсэлийнхээ хагасыг аваачиж зарах зэргээр мөнгө хуримтлуулав. Ингэж өөртөө хохирол учруулсны үрээр Моррелийн пүүс энэ удаа мэнд өнгөрөв. Гэсэн хэдий боловч касс нь бүүр хоосорчээ. Олны ціурхлаас айсан зээлдэгч хувиа бодоод зайлсхийдэг болов. Эрхэм де Бовильд энэ сарын арван таванд мөн дараа сарын арван таванд зуу, зуун мянган франк төлөхийн тулд «Фараон» онгоцоо хүлээхээсөөр аргагүй байв. Түүний гарсан тухай мэдээг хамт гараад Марсельд эсэн мэнд хүрч ирсэн нэг онгоц мэдэгдсэн байжээ. Гэвч «Фараон»-той хамт Калькутт хотоо гарсан энэ хөлөг хоёр долоо хоногийн өмнө ирсэн байтал харин «Фараон»-оос сураг чимээгүй байлаа.

Томсон ба Френчийн банкны итгэмжилсэн төлөөлөгч, эрхэм де Бовильтой уулзсанахаа маргааш, эрхэм Моррелинд ирэхэд байдал төлөв ийм байлаа.

Түүнийг Эмманюель хүлээн авав. Шинэ хүн ирэх бүрд, түүнийг элдэв хов жив сонсоод пүүсийн эзнээс чухам юу болоод байгааг лавлан асуух гэж ирж байгаа байх гэж боддог залуу, эзнийгээ эвгүй ярианд учруулахгүй байхыг хүсчээ. Тэгээд ирсэн хүнээс асууж шалгааж эхлэхэд, цаадах хүн нь эрхэм Эмманюельд хэлэх юм юу ч байхгүй, зөвхөн эрхэм Моррельтой биечлэн уулзана гэж хэлэв.

Эмманюель санаа алдаад Коклесийг дуудав. Коклес хүрч ирэхэд ирсэн хүнийг эрхэм Моррель дээр оруулж өг хэмээн тушаав.

Коклес түрүүнд нь, үл таних хүн хойноос нь дагаж явав. Шатан дээр арван зургаа арван долоо орчим насны үзэсгэлэн гоо охинтой дайралдвал охин үл таних хүн өөд сэтгэл зовсон шинжтэй харна.

Коклес түүний нь анзаараагүй боловч үл таних хүний харцаас зайлж чадсангүй.

- Эрхэм Моррелј өрөөндөө байна уу. Жюли авхай! Гэж нярав асуухад, залуу охин итгэлгүйхэн байдалтайгаар,

- Байх шиг л байна. Очоод хар л даа, хэрвээ аав байвал хүн ирлээ гэж хэлээч гэв.

- Миний тухай хэлээд ашиггүй гэж англи хүн хэлээд - Эрхэм Моррель миний нэрийг мэдэхгүй, харин танай аавын пүүстэй холбоо харилцаатай байдаг Томсон ба Френч пүүсийн ахлах төлөөлөгч иржээ гэж хэлбэл болно доо гэв.

Залуу охины царай нь зэвхийрээд шат уруу буухад Коклес үл таних хүн хоёр өөд өгсөв.

Жюли, Эмманюелийн ажил хийж байгаа өрөөнд ороход, Коклес эзнийхээ өрөөнд дуртай цагтаа ордгийн тэмдэг болсон түлхүүрээ гаргаж гуравдугаар давхрын буланд байгаа хаалга онгойлгож танихгүй хүнийг үүдний өрөөнд оруулаад, өөрөө цаад талын үүдээр орж хаалгы нь хаагаад Томсон ба Френчийн банкны төлөөлөгчийг хэсэг зуур ганцааранг нь орхиж явснаа, төдхөн буцаж ирээд түүнд орохыг зөвшөөрөн дохив.

Англи хүнийг ороход эрхэм Моррель бичгийн ширээний ард суугаад, сэтгэл нь хөдөлсөн бололтой царай нь зэвхийрэн, өмнөө байгаа өрийн дансыг ихэд айсан байдалтай харж байлаа.

Эрхэм Моррель танихгүй хүн орж ирэхийг хараад тооцооныхоо дэвтрийг хааж босож ирээд сандал тавьж өгөв. Тэгээд үл таних хүнийг суухаар нь, сандал дээрээ буцаж суув.

Энэ арван дөрвөн жилийн дотор том пүүсийн баян эзэн их л өөр болжээ. Бидний яриа эхлэх үед гучин зургаан наста© байсан бол одоо тавь шүргэж байв. Үс нь бууралтаж, санаа сэтгэл нь зовж явдгий уршгаар духан дээр нь үрчлээ сууж, урьд өмнө шийдэмгий байсан харц нь одоо зөөлөрч, нэг юмыг удаан бодохоос ч юм уу хүний өөдөөс эгцлэн харахаас айсан мэт итгэлгүй байдалтай болжээ.

Англи хүн түүнийг илэрхий өрөвдсөн байдалтай сонирхон харахад Моррелийн сэтгэл зовсон байдал нь энэ харцаас улам нэмэгдэж

- Эрхэм ээ та надтай ярих гэсэн байх аа? гэж асуув.
- Тийм ээ эрхэм ээ, хэний нэрийн өмнөөс явааг минь та мэдэж байгаа биз дээ?
- Томсон ба Френчийн банкны нэрийн өмнөө яваа, ингэж л надад нярав хэлсэн шүү дээ.
- Маш зөв. Томсон ба Френчийн банк ойрын хоёр сарын дотор Францад гурваас дөрвөн зуун мянган франк төлөх ёстой юм. Тэгэхээр манай банк таныг цаг хугацаанд нь төлбөрөө төлдөг болохыг мэдэх учраас, таны гарын үсэгтэй бүх үүргийг цуглуулж аваад, хугацааг нь болохоор танаас зохих мөнгийг авч зарцуулахыг надад даалгасан юм.

Моррель хүндээр санаа алдаад, хөлс чийхарсан нойтон духаа гараараа илбэв.

- Тэгэхээр, миний гарын үсэгтэй өр төлөх баталгаа танд байгаа юм биз дээ? гэж Моррель асуулаа.
- Байнаа, байхдаа нилээд их мөнгөнийх бий.
- Чухам хичнээн хэмжээний юм байна вэ? гэж Моррель дуугаа өөрчлөхгүй асуухыг хичээхэд англи хүн хармаанаасаа боодолтой цаас гаргаж ирээд,
- Нэгдүгээрт, шоронгийн байцааг эрхэм де Бовиль таны пүүсэнд оруулсан хоёр зуун мянган франкаа шилжүүлэн өгсний баталгаа энэ байна. Та эрхэм де Бовильд ийм өртэй гэдгээ хүлээж байна уу?
- Тийм ээ, тэр энэ мөнгийг таван жилийн өмнө дөрөв хагасын хүүтэйгээр манай дансанд оруулсан юм.

- Яг зөв байна. Дараа нь, энэ сарын эцэст хугацаа нь дуусаж байгаа гучин хоёр мянга таван зуун франкын өр төлөх баталгаа байна. Энэ бас л таны гарын үсэгтэй бөгөөд үүнийг эзэн нь бидэнд худалдсан юм.

- Би тэдгээрийг бас хүлээж байна гэж хэлээд Моррель анх удаа өрөө төлж чадахгүй болох нь энэ байжээ гэж бодоод ичиж царай нь улайгаад - Ингээд гүйцээ юу гэж асуув.

- Үгүй эрхэм ээ. Надад бас хугацаа нь дараа сарын эцсээр дуусах баталгаанууд бий. Эдгээр тавин таван мянган орчим франкын баталгааг бид Паскалийн болон Уайлд ба Тэркерийн худалдааны пүүснүүдээс авсан. Ингээд бүгд хоёр зуун наян долоон мянга таван зуун франк болж байна.

Золгүй болсон хөөрхий Моррель энэ бүгдийг тоочиж суух зуур тамд орж зовлон эдэлсэн мэт болжээ.

- Хоёр зуун наян долоон мянга таван зуун франк гэж өөрийн эрхгүй хар аяндаа дуугарав.

Тийм ээ эрхэм ээ, гэвч... гэснээ англи хүн хэсэг зуур дуугүй болоод - Эрхэм Моррель таны одоо хүртэл ямарч зэмлэл учирч яваагүй үнэнч шударгыг хэдийгээр хүндэтгэх боловч таныг хоосорч байна гэдэг чимээ Марсельд сонстож байгааг танаас нууж чадахгүй нь гэв.

Ийм, бараг бүдүүлэг шахуу үгэнд Моррелийн царай аймшигтай цонхийгоод,

-Өршөөлт эрхэм минь, эцэг маань гучин таван жилийн турш толгойлж байсан пүүсээ надад шилжүүлэн өгсөн тэр өдрөөс хойш хорин дөрвөн жил гаруй өнгөрөө. Энэ үеийг хүртэл «Моррель ба түүний хүү» гарын үсэгтэй өр төлбөрүүд нэг ч удаа хугацаандаа төлөгдөхгүй өнгөрч байгаагүй юм гэж хэлэхэд, англи хүн

- Тийм ээ, би үүнийг мэдэж байна. Гэвч үнэнч шударга хүмүүсийн ёсоор илэн далангүй ярь. Та энэ мөнгийг мөн цаг тухайд нь яг төлж чадах уу? гэж асуув.

- Тэгэхэд Моррель цочин дагжиснаа ярьж байгаа хүн өөдөө эгц харж,

- Ийм илэн далангүй асуултад мөн л илэн далангүй хариулах ёстой. Тэгнээ, эрхэм минь, хэрвээ миний хөлөг онгоц найдаж байгаагаар минь хүрч ирвэл би үүний тань төлж чадна, онгоц минь эргэж ирвэл надад гай тохиолдсноос болоод олдохгүй болж байгаа зээллэгийг эргүүлж олгох юм. Хэрэв миний сүүлчийн горьдлого болох «Фараон» аюулд учирвал...гээд хөлгийн эзний нүдэнд нулимс гүйлгэнээд ирэв.

- Ингээд энэ сүүлчийн горьдлого чинь таныг хуурчихвал яах вэ? гэж англи хүн асуув.

- Тэгвэл үүнийг хэлэхэд хэцүү боловч зол заяагүй явдалд дасчихаараа бас ичгүүр сонжуурт дасах болно... Тэгвэл би төлбөр төлж чадахгүй болно доо гэж Моррель үргэлжлэн ярив.

- Танд тус болох сайн нөхөд байхгүй гэж үү?

Моррель уйтгартайгаар инээмсэглэж

- Эрхэм минь, ажил албанд найз нөхөд байдаггүй гэдгийг та мэднэ. Зөвхөн харилцагчид л байдаг шүү дээ гэв.

- Энэ ч үнэн гэж англи хүн шивнээд - Тэгэхээр танд ганцхан л найдвар байх шив дээ? гэж хэлэв.

- Цорын ганцхан найдвар байна.

- Сүүлчийнх үү?

- Сүүлчийнх.

- Хэрвээ энэ г@рьдлого тань таныг хуурчихвал...

- Ёи өнгөрөх нь тэр, эргэлт буцалтгүй өнгөрөх нь тэр.

- Намайг танайх уруу ирж явахад нэг онгоц буудалд орж ирж яваа харагдсан.

- Мэднээ эрхэм ээ, надад золгүй явдал тохиолдсон боловч надад үнэнч хэвээр үлдсэн ажилчдын минь нэг хамгийн түрүүнд баяртай мэдээ авчирна гэж бүтэн өдрийн турш байшингийн дээвэр дээр өнгөрүүлдэг юм. Тэр надад хөлөг онгоц ирсэн тухай мэдэгдсэн.

- Тэгээд тэр чинь таны хөлөг бишүү?

- Бишээ, энэ бол Бордо хотын «Жиронда» гэдэг хөлөг. Бас л Энэтхэгээс ирсэн боловч, минийх биш.

- Энэ онгоцныхон «Фараон»-г хаана явааг мэдэж, ямар нэгэн мэдээ авчирсан юм биш биз дээ,

- Би танд үнэнээ хэлэх үү? Би түүнийг ор сураггүй байгаатай адилаар, сураг сонсохоосоо айж байна. Ор сураггүй байна гэдэг чинь бас л нэг горьдлого шүү дээ гэж хэлэв.

Эрхэм Моррель хэсэг зуур дуугүй байснаа сөөнгө хоолойгоор,

- Ингэж хожимдох явдал ойлгогдохгүй байна. Фараон Калькуттаас хоёр дугаар сарын таванд гарсан. Ирэх хугацаанаасаа сар илүү хожимдоод байна гэв.

- Юу вэ? гэж англи хүн юм чагнаснаа хэлээд - Юун шуугиан бэ гэж асуув.

- Бурхан минь! Бурхан минь! Гэж Моррель хэлээд үхээрийн юм шиг царай нь зэвхийрч - Бас юу болчихов доо? Гэв.

Үнэндээ ч шатан дээр шуугилдах чимээ тодхон дуулдав. Хүмүүс хойш урагшаа гүйлдэн, тэр бүү хэл нэг хүн гоморхон гинших ч сонстов.

Моррель хаалгаа онгойлгохоор боссон боловч, тамир нь алдарч суудалдаа дахин суучихав.

Тэр хоёр өөд өөдөөсөө харж суусан хэвээрээ боловч Моррелийн бүх бие чичирч, үл таних хүн түүнийг ихээр өрөвдсөн байдалтай харж байв. Чимээ намдсан боловч Моррель ямар нэгэн юм хүлээсэн бололтой. Чимээ гарснаас хойш учир нь олдох ёстой шалтгаантай ажээ.

Нэг хүн шатаар аяархан өгсөж, нэлээд хэдэн хүн тавцан дээр зогсох шиг үл таних хүнд санагдав.

Дараа нь эхний хаалганд түлхүүр шургуулж тэр хаалга чахран онгойхыг үл таних сонслоо.

- Энэ хаалганы түлхүүр зөвхөн Коклес, Жюли хоёрт л байдаг юм гэж Моррель шивнэв.

Тэр дороо наад үүд нээгдэж босгон дээр уйлж унжиж, царай нь зэвхийрсэн Жюли үзэгдлээ.

Моррель босож ойчихгүйн тулд зөөлөн сандлынхаа түшлэгээс тулж бүх бие нь чичрэн зогсов. Тэр юм ярих гэсэн боловч дуу нь гарч өгсөнгүй.

- Ааваа гэж охин царайчилсан янзтай гараа зөрүүлж бариад - Муухай мэдээ авчирсан охиноо өршөөгөөрэй? Гэж хэлэв.

Моррелийн царай аймшигтай зэвхийрч, Жюли ухасхийн тэврүүлэв.

- Ааваа ааваа зоригтой хэвээрээ байгаарай гэж охин хэлэхэд,

- «Фараон» сөнөчихөө юу? гэж Моррель бачимдсан дуугаар асуув.

Жюли хариу юу ч дуугараагүй боловч аавынхаа элгэнд наалдуулсан толгойгоо дохив.

- Аа, онгоцны багийнхан нь яасан? Гэж Моррель асуухад,
- Аврагджээ. Дөнгөж сая буудалд орж ирсэн Бордогийн хөлөг онгоц аварчээ гэж Жюли хариулав.

Моррель гараа дээш өргөн хүлцэнгүй бөгөөд баярласан янзаар залбиран,

- Баярлалаа, Бурхан минь! Чи ганцхан намайг л ниргэж! Гэж хэлэхэд, англи хүн хэдийгээр хайхрамжгүй мэт дүр үзүүлэн суусан боловч, нүдэнд нь нулимс гүйлгэнэв.
- Орж ир, орж ир, би та нарыг хаалганы цаана байна гэдгийг мэдэж байна гэж Моррель хэлж дуусмагц хатагтай Моррель эхэр татан уйлсаар орж ирэв.

Араас нь Эмманюель дагажээ. Үүдний өрөөний тэртээ цаад талд ядарч зүдэрч, хувцас хунаргүй шахам болсон далайчин зогсож байгаа харагдав. Англи хүн эдгээр хүмүүсийг хараад цочин агдасхийв. Тэгээд тэдэн уруу очмоор байна уу гэлтэй болсноо, биеэ барьж тасалгааны хамгийн бүдэг гэрэлтэй холын буланд очиж зогсов.

Моррель хатагтай зөөлөн сандал дээр суугаад нөхрийнхөө гарыг атгахад, Жюли мөн л эцгийнхээ элгэнд толгойгоо наасан хэвээр зогсож байв. Эмманюель, Моррелийн гэр бүл ба үүдэн дээр бөөгнөрөн байгаа далайчдын хоорондын холбоос болсон мэт тасалгааны дунд зогсоно.

- Яагаад ийм явдал болов? Гэж Моррель асуухад,
- Пенелон, ойртож очоод яриач гэж Эмманюель хэлэв.

Халуун орны хурц наранд харлатлаа түлэгдсэн өвгөн далайчин ойртож очоод, бүрх малгайныхаа хүрээнээс барьж эргэлдүүлэн,

- Сайн байна уу, эрхэм Моррель гэж дөнгөж өчигдөрхөн Марселиас гарч Экс буюу Тулонаар ороод өнөөдөр ирсэн юм шиг хэлэхэд, эзэн өөрийн эрхгүй нулимсныхаа хажуугаар инээмсэглээд,
- Сайн сайн байна уу найз нөхөр минь. Аа ахмад хаана байна гэж асуув.
- Ахмад өвдөөд Пальмд хоцорсон, эрхэм Моррель аа, гэвч тэнгэр бурхны ивээлээр удахгүй эдгэрч, хэд хоногийн дараа та бидэн шиг эрүүл энх ирSx болно.
- Сайн байна... Одоо ярь даа Пенелон! Гэж Моррель хэлэв.

Пенелон аман дахь бохио баруун завжнаасаа зүүн завжиндаа болгоод амаа гараараа таглаж цаашаа эргээд үүдний өрөө уруу харавтар шүлс унжиралдуулан нулимаад нэг хөлөө урагш нь тавьж биеэ найгуулан байж ярьсан нь:

- Тэгэхээр ийм байна, бид Бланко ба Боядор хоёр хошууны хооронд, баруун өмнөдийн салхинд туугдан нэг бүтэн долоо хоног явж байтал нэг өдөр ахмад Гомар над дээр гэнэт хүрч ирээд (би тэгэхэд жолоо барьж явсан)

- «Пенелон гуай, та тэр тэнгэрийн хаяанд гарч байгаа үүлийг юу гэж бодож байна?» гэж хэллээ.

-Тэр үед би ч бас тэр үүл уруу харж байсан.

-Намайг тэр үүлний тухай юу гэж бодож байна гэв үү, ахмад минь? Энэ үүл ердийнхөөсөө арай хурдан хөдөлж байгаа бөгөөд гэм хоргүй ердийн үүлийг бодвол илүү хар өнгөтэй байна даа»

-«Би бас тэгэж бодож байна, юу ч болсон урьдчилсан арга хэмжээ авъя. Бид одоогийн салхилж байгаа салхинд таараагүй арай олон дарвуултай явж байна... Эй, нөхөд минь! Бом-брамсель ба бомкливер дарвуулыг буулга» гэж ахмад хэлсэн.

-Яг цагаа олсон доо. Тушаалыг биелүүлж амжаагүй байтал, салхи ширүүсэж хөлөг хазайгаад ирсэн.

-«Дарвуул бас л олон байна даа. Гротыг буулга» гэж ахмад хэлсэн.

-Таван минутын дараа Гротаа буулгаж бид зөвхөн фок марсель брамселиар явлаа.

-«За үав Пенелон гуай, яагаад толгойгоо сэгсрээд байгаа юм бэ?» гэж ахмад надаас асуусан.

-Би л таны оронд байсан бол дарвуулаасаа баг буулга гэж тушаах байсан даа.

-«Өвгөн таны хэлдэг зөв бололтой, салхилах нь байна» гэж тэр хэлсэн.

-Салхилна гэдгийнхээ тухай мартчихвал таарна. Энэ чинь шуурга, хэрвээ л би энэ тухай бага зэрэг юм мэддэг бол ширүүн шуурга болно доо!» гэж би түүнд хариуллаа.

-Их зам дээрх тоос шиг салхи бидэн уруу шууд дайран ирсэн. Аз болоход манай ахмад ажлаа сайн мэддэг хүн байсан.

-Маарселийг хоёр рифээр буулга! Гэж ахмад хашхираад, гурвалжин дарвуулын амыг султга салхи уруу эргүүл, маарсель далбаагаа авч хая, шурагны тоноглолыг хумь гэж байлаа.

-Тэр өргөрөгт энэ багадна. Би л байсан бол дөрвөн рифээр буулгаж, фокуг авч хаях байсан даа гэж англи хүн гэнэт хэлэв.

Энэ эрс шулуун дууг сонсоод цөмөөрөө цочин харцгаав. Пенелон саравчлан байж ахмадын нь тушаалыг ингэж зоригтой шүүмжилсэн хүн өөд харав. Тэгээд өвгөн далайчин хүндэтгэсэн байдалтайгаар,

- Бид түүнээс ч илүү юм хийсэн дээ, эрхэм минь бид контрбизанийг авч салхины аяар явах гэж фордевинаар дамжуулан эргүүлж тавьсан. Арван минутын дараа бид маарселиа авч ганцхан олс дээс нь үлдсэн дээ гэв.

- Тэгж эрсдүүлж болохгүйгээр тийм хуучирсан онгоц байсан юм гэж англи хүн хэлэв.

- Харин тийм! Чухам энэ л биднийг алсан даа. Чөтгөр ч гэсэн бөөлжис нь цутгамаар арван хоёр цаг сэгсчисэний дараа онгоцонд нүх гарсан.

«Пенелон, бид живж байх шиг байна. Өвгөн минь насад жолоогоо өгөөд доошоо ор» гэж ахмад хэлсэн.

Би түүнд жолоогоо өгчихөөд доошоо орсон чинь гурван фут ус орчихсон байлаа. Би дээшээ гараад «Соруулаарай!» гэж хашхирсан. Тэгээд юу ч болсонгүй, хожимджээ! Бид соруулаад л байдаг. Ус ч улам нэмэгдээд л байдаг.

Тэгэхээр нь би дөрвөн цаг ноцолдож шал нойтон болоод «Та минь ээ, нэг үхэхээс хоёр үхэх биш, живбэл живнэ л биз» гэж хэллээ.

«Пенелон гуай та хүн уруу татаж байна. Хүлээж байгаарай!» гэж ахмад хэлээд өөрийнхөө өрөөнд очиж хоёр гар буу авчраад,

«Түрүүлж насос хаясан хүний гавлыг нь хага буудна!» гэж хэлдэг байна.

- Зүйтэй гэж англи хүн хэлэв.

- Ажил хэргийн чанартай үгнээс өөр зүрх зориг оруулдаг юм гэж байхгүй... Тэгээд ч тэнгэр цэлмэж, салхи намдаж байлаа. Гэвч ус нэмэгдсээр байв. Тэгэхдээ хурдан биш, цагт хоёр ямх хэртэй нэмэгдэж байсан. Цагт хоёр ямх гэдэг ялихгүй мэт боловч арван хоёр цагт хорин дөрвөн ямх болчихно. Хорин дөрвөн ямх гэдэг чинь хоёр фут гэсэн үг. Хоёр фут, бас түүн дээр урьд нь байсан гурван фут нийлээд бүгд таван фут. Аа, гүзээндээ таван фут устай хөлөг онгоц гэдэг чинь усны сав л гэсэн үг гэж далайчин үргэлжлүүлэн ярив.

«За одоо болно, эрхэм Моррель биднийг юу ч гэж зэмлэж чадахгүй. Бид онгоцыг аврах гэж чадах л бүхнээ хийлээ, одоо хүмүүсээ аврах хэрэгтэй. Завьнуудаа буулга, бушуулаарай нөхөд өө!» гэж ахмад хСлсэн дээ. Пенелон яриагаа үргэлжлүүлэн,

- Эрхэм Моррель, бид «Фараон»-д маш их хайртай байсан. Гэвч далайчин хүн гэдэг өөрийн онгоцонд хэдийгээр их хайртай байх боловч, аминдаа илүү хайртай юм. Тийм ч учраас бид хоёр дахин шаардуулсангүй, онгоц шажигнан дуугарч биднийг: «Бушуухан зайл!» гэх шиг болсон. Хөөрхий «Фараон» үнэнээ хэлжээ. Тэр хөлөг, бидний хөл доороос зайлж байх шиг болсныг бид мэдэрсэн. Бид эгшин зуурын дотор завиа буулгаж, наймуулаа түүндээ орж суусан.

Харин ахмад хамгийн сүүлд бууж ирсэн, үнэнийг нь хэлэхэд, онгоцноосоо хагацах дургүй байсан болохоор бууж ирээгүй, тэгэхээр нь тэвэрч аваад нөхдүүд уруугаа шидчихсэн. Дараа нь би өөрөө үсрэн буусан. Яг л амжсан. Би дөнгөж үсрэн буутал онгоцны тавцан задарч, дөчин найман их буутай хөлөг онгоц нэгэн зэрэг буудаж байгаа юм шиг тийм их чимээ гарсан.

Тэгээд арван минутын дараа хошуу нь ус уруу шааж дараа нь хитиг нь живж сүүлээ зуух гэж оролдож байгаа нохой шиг дороо эргэлдэн хөлбөрсөн. Тэгээд дараа нь бурхан минь, зүйл дуусч «Фараон» онгоц минь үгүй болсон.

Бидний тухайд гэвэл гурван өдөр хэлэндээ юм тавиагүй, юу ч уугаагүй, тэгээд хэн нь бусдыгаа тэжээхийг шодъё хэмээн ярилцаж байтал гэнэт «Жиронда» харагдсан. Бид ч дохио өгч, тэд ч биднийг ажиглаад бидэн уруу эргэн ирж завь буулгаж, бид бүгдийг татаж авсан. Ийм л явдал болсон юм даа эрхэм Моррель минь, далайчны үгэнд итгээрэй! Тийм биз дээ, нөхөд өө! Гэхэд цаадуул нь сайшаан шуугилдсан нь үнэн зөв, аятайхан дүрслэн яилаа гэдгийг бүгдээрээ зөвшөөрсний тэмдэг боллоо.

- Мэдлээ, найз нөхөд минь гэж эрхэм Моррель хэлээд - Та нар сайн улс. Надад тохиолдсон энэ золгүй явдалд миний өөдгүй хувь заяа л буруутай гэдгийг би өмнө нь мэддэг байсан юм. Энэ бол бурхны хүсэл таалал болохоос, хүний гэм буруу биш, бурхны таалалд захирагдъя. Одоо хэдий хэрийн цалин авах ёстойгоо надад хэлж өг дөө гэв.

- Болно болно, эрхэм Моррель, энэ тухай ярихгүй
- Үгүй, ярилгүй яахав гэж хөлгийн эзэн гунигтайгаар инээвхийлэн хэлэхэд,
- Бид гурван сарынхыг л... гэж Пенелон дуугартал Моррель тосон авч
- Коклес бидэнд хоёр, хоёр зуун франк өг. Өөр цагт сан бол бас хоёр хоёр зуун франкыг шагнаж өг гэх байсан юм. Одоо тийм цаг биш, цаана нь үлдсэн

өчүүхэн мөнгө минийх биш. Ийм болохоор та нар намайг бүү зэмлээрэй, уучилж үзнэ биз гэв.

Пенелон өрөвдсөн бололтой нүүрээ үрчийлгээд, нөхөд уруугаа эргэж нэгэн юмны тухай тэдэнтэй зөвлөснөө эргэж эзэндээ,

- Эрхэм Моррель энэ чинь гэж хэлснээ, нөгөө бохио нэг завжнаасаа нөгөө завжиндаа шилжүүлж, түрүүчийн адил шүлсээ үүдний өрөө уруу хаяад энэ чинь... гэхэд,

- Юу? гэж асуув.

- Мөнгө...

- Яагаа вэ тэгээд?

- Эрхэм Моррель, манай нөхөд одоохондоо тавь тавин франк аваад, бусдыг нь байзняя гэгцгээж байна гэж хэлэв.

- Баярлалаа, найзууд минь, баярлалаа гэж сэтгэл нь ихэд хөдөлсөн эрхэм Моррель хэлээд - Та нар цөм сайхан сэтгэлтэй улс, гэсэн ч тэр мөнгийг авцгаа. Тэгээд өөр ажил олдвол орцгоо. Та одоо чөлөөтэй гэв.

Энэ сүүлчийн үгс үнэнч далайчдын гайхшлыг төрүүлэв. Тэд сандран бие бие өөдөө харна. Пенелоны амьсгаа нь боогдож арай л бохио залгичихсангүй. Аз болоход, хоолойгоо амжиж атгаж авчээ.

- Яалаа гэж тэр вэ, эрхэм Моррель? Та биднийг ажлаас халж байгаа юм уу? Бид таны сэтгэлд таалагдсангүй юу? гэж бачимдсан дуугаар асуув.

- Үгүй дээ найз нөхөд минь гэж хөлгийн эзэн хариулаад - Үгүй, би та нарт харин ч сэтгэл хангалттай байна. Би та нарыг халж байгаа юм биш. Гэвч яая гэхэв? Надад хөлөг онгоц байхгүй, тэгэхээр далайчид ч хэрэггүй гэхэд,

- Яагаад хөлөг онгоц байхгүй гэж? Шинийг бариулахгүй юу? Бид хүлээж байя. Бурхан минь, бид нам гүм байж сурсан улс гэж Пенелон хэлэв.

- Пенелон минь, одоо надад хөлөг барих мөнгө байхгүй гэж хөлгийн эзэн гунигтайгаар инээмсэглээд, - Таны санал надад хичнээн сайхан санагдсан ч би хүлээж авч чадахгүй нь гэв.

- Аа, хэрвээ танд мөнгө байхгүй бол бидэнд хөлс төлөх хэрэггүй. Бид өөрсдийнхөө хөөрхий «Фараон» шиг зөвхөн олс дээсээрээ л явж байя. Тэгээд л гүйцээ!

- Боль, боль нөхөд минь! Гэж Моррель сэтгэл нь хөдөлж амьсгаадаж - Явцгаа даа, би та нарыг гуйя. Хожим сайн цагт уулзацгаая гэснээ - Эмманюель, эдэнтэй хамт явж миний шмйдвэр хэрхэн зөв биелэгдэж байгааг хар гэж хэлэв.

- Харин бид үүрд хагацахын ёс гүйцэтгэхгүй шүү, эрхэм Моррель, зөвхөн түр баяртай гэнэ, болно биз дээ гэж Пенелон мэлэв.

- Тийм ээ, найз нөхөд минь! Эр ёсоор болог гэж найдъя. Явцгаа даа.

Тэгээд Коклес өөд дохиод цаадах нь түрүүлэн явав. Далайчид няравыг дагалдан явахад, Эмманюель хамгийн сүүлд гарав. Хөлгийн эзэн эхнэр, охин хоёртоо,

- Одоо та нар түр гарч байгаач, би энэ эрхэмтэй ярих хэрэгтэй байна гэж хэлэв.

Тэгээд Моррель энэ бүх явдлын үед тасалгааны буланд хөдлөлгүй зогсож, дээр өгүүлсэн хэдхэн үгээр ярианд оролцсон, Томсон ба Френчийн банкны итгэмжлэгдсэн хүн өөл нүдээрээ дохив. Хоёр эмэгтэй огт мартчихсан байсан үл таних хүн өөд хараад гарч одов. Харин Жюли хаалган дээр очсоноо эргэж, түүн өөд сэтгэл хөдөлмөөр царайчилсан байдалтай харахад цаадах нь хариу инээвхийлэв. Энэ хүйтэн царай дээр ийм инээвхийлэл тодорсныг хажуугаас нь ажигласан хүн гайхах байсан биз. Эрэгтэйчүүд дангаараа үлдэв.

Моррель зөөлөн сандалдаа суух зуур,

- Та сая бүгдийг харлаа, бүгдий нь дууллаа, надад нэмж хэлэх юм юу ч алга гэж хэлэхэд,

- Би харлаа, танд урьдахын адил ямар ч учир шалтгаангүй нэгэн шинэ золгүй явдал тохиолдсон нь танд туслах хүслийг минь улам бататгаж өглөө гэж англи хүн хариу өгүүлэв.

- Ай эрхэм минь! Гэж Моррель хэлэхэд, үл таних хүн үргэлжлүүлэн,

- Би танд мөнгө зээлдүүлэгч гол хүмүүсийн нэг, тийм биз дээ? гэж асуув.

- Юу ч л гэсэн хамгийн түрүүнд хугацаа нь дуусах өрийн баталгаанууд танд байгаа.

- Та хугацаа сунгуулмаар байна уу?

- Хугацаа сунгавал миний нэр төр аврагдаж, түүгээрээ амь минь бас аврагдах бодно.

- Танд хэдий хугацаа хСрэгтэй вэ?

Моррель бодлого болсноо,

- Хоёр сарын хугацаа гэж хэлэв.
- Болно оо, би танд гурван сарын хугацаа сунгаж өгье гэж үл таних хүн хэлэв.
- Томсон ба Френчийн пүүс үүнийг...
- Сэтгэл бүү зов. Бүх хариуцлагыг би өөр дээрээ авна. Өнөөдөр зургаан сарын таван байх аа?
- Тийм ээ.
- Тэгвэл энэ өрийн баталгаануудыг есөн сарын таванд өглөөний арван нэгэн цагт болгож хуулж бичнэ үү (тэр үед цагийн зүү яг арван нэгийг зааж байв). Би яг хүрч ирнэ.
- Би таныг хүлээж байна. Та мөнгөө авах болно, эсвэл би амьд байхгүй болчихсон байна гэж Моррель хэлэв.

Сүүлчийн энэ үгийг маш аяархан хэлсэн тул үл таних хүн түүнийг дуулсангүй.

Өрийн баталгааг шинэчлэн бичээд, хуучнуудыг нь устгаж, хөөрхий эзэн сүүлчийнхээ хүч хөрөнгийг шавхах гурван сарын түр амьсгал олж авлаа.

Англи хүн Моррелийн баяр талархлын үгийн хариуд хайхрамжгүйхэн шиг инээмсэглээд, үүд хүртэл гаргаж өгсөн эзэнтэй салах ёс гүйцэтгэв.

Тэр шатан дээр Жюлитэй дайралдав.

Жюли шат уруу бууж яваа дүр үзүүлж байсан боловч үнэн хэрэг дээрээ түүнийг хүлээж байжээ.

- Ай эрхэм минь! Гэж тэр охин гуйсан царайтай арга нь барагдсан янзтай хэлэв.
- Авхай та гэж үл таних хүн хэлээд - Та... Синдбад - далайчин... гэдэг гарын үсэгтэй зурвас хэзээ ч юм хүлээн авах болно. Тэр бичиг танд ямарч хачин гайхалтай санагдсан түүн дотор дурдсан бүхнийг ширхэгчлэн биелүүлээрэй гэхэд,
- За гэж Жюли хариулав.

- Та ёс®ор нь гүйцэтгэнэ гэж ам өгөх үү?
- Танд тангараглая.
- Сайн байна баяртай, авхай минь. Дандаа ийм сайхан сэтгэлтэй, эцэгтээ хайртай охин байхыг ерөөе, бурхан таныг Эмманюельтай чинь суулгаг.

Жюли аяархан дуу алдаад, царай нь интоорын жимс шиг час улайж ойчихгүйн тулд шатны хашлагаас барьж авав. Үл таних хүн түүнд гараараа дохиж, салах ёс гүйцэтгэхчээд цаашаа явав.

Тэгээд хашаан дотор хоёр гартаа нэг нэг зуун франк барьчхаад яахаа мэдэхгүй байгаа янзтай зогсож байсан Пенелонтой дайралдав.

- Явъя найз минь гэж англи хүн түүнд хэлээд - Надад тантай ярих хэрэг байна гэв.

9. Есдүгээр сарын таван

Хүсэж хүлээгээгүй байхад нь Томсон ба Френчийн банкны төлөөлөгч тэгж санамсаргүй хугацаа хойшлуулсан нь тэрхэн үедээ, золгүй хувь заяа хөөрхий амьтныг даган зовоохоо больж байгаагаа мэдэгдэн хувь тавилан нь сайнаар эргэж байх шиг санагджээ. Моррель тэр өдөртөө үүнийг охин, эхнэр ба Эмманюель нарт ярьж, гэр оронд нь тайвшраагүй ч гэсэн бага зэрэг итгэл найдвар төржээ. Гэвч гай болоход Моррель өөрт нь урьдаас ийм нааштай хандсан Томсон ба Френчийн пүүсээс өөр олон газартай холбоо харьцаатай байжээ. Түүний хэлснээр худалдааны хэрэгт харилцагчид гэж байхаас, найз нөхөд гэж байдаггүй Моррель дотроо Томсон ба Френчийн пүүсийн энэрэнгүй санаачлагыг гайхан бодож учрыг олохгүй байлаа. Тэр энэ үлдлыг зөвхөн гурван зуун мянган франк авах хүнээ яаран хоосруулж, мөнгөнийхөө зиргаа буюу найман хувийг авснаас хугацааг нь сунжаад гурван сарын дараа зохих мөнгөө бүгдийг нь авсан нь дээр гэж шийдвэрлэн хувиа бодсон бодлого гэж дүгнэлт хийж байв.

Гэвч Моррелийн бусад зээлдүүлэгчид хорон санаа ч юм уу эсвэл бодлогогүйн гайгаар өөрөөр бодож байсан нь харамсалтай. Тийм учраас Моррелийн гарын үсэгтэй өрийн баталгаа тогтоосон хугацаандаа ирж байсан бөгөөд англи хүн өрийнхөө хугацааг сунгаж өгсний ачаар Коклес тэр дор нь төлж амжиж байв. Тийм учраас Коклес урьдын адил тайван байх ажээ. Харин ганцхан Моррель л, хэрвээ арван таванд эрхэм де Бовильд зуун мянган франк гучинд өөр нэг хүнд гучин хоёр мянга таван зуун франк төлсөн бол энэ сардаа л баларч дуусах байсан гэдгийгээ түгшин харж байлаа.

Марселийн баян худалдаачид Моррелийг энэ дарамтыг давж чадахгүй гэж бодож байв. Тийм учраас зургадугаар сарын төлбөрүүдийг ердийн байдлаараа яг төлчихийг үзээд олноороо их л гайхалдав. Хэдий тийм боловч хүмүүс түүнд

итгэхгүй болсон бөгөөд дараа сарын сүүлч болоход хөөрхий хөлгийн эзэн дампуурна гэж нэгэн дуугаар хугацаа тавьж байлаа.

Моррель хэрэгтэй хэмжээний мөнгө цуглуулах гэж бүх л долдугаар сарын туршид хүний хэрээс хэтэрсэн хүч гаргав. Урьд нь түүнд хүмүүс бүрэн итгэлтэйгээр мөнгө зээлдүүлдэг байсан бөгөөд өөрсдөө хүсэж ирэх нь ч олон байв. Моррель гурван сарын хугацаатай ерийн баталгаа гаргах гэсэн боловч түүний нь нэг ч банк авсангүй. Аз болоход Моррель өөрөө зарим нэг орлого олохыг хүлээж байсан бөгөөд эдгээр нь орж ирсэн учир сарын эцэст Моррель зээлдүүлэгчдийн сэтгэлийг хангав.

Томсон ба Френчийн фирмийн итгэмжлэгдсэн хүн Марсельд дахин үзэгдсэнгүй. Тэр хүн Моррельтой уулзсанахаа маргааш нөгөөдөр нь алга болжээ. Тэр Марсельд зөвхөн хотын дарга, шоронгийн байцаагч, хөлгийн эзэнтэй уулзсан учир түргэн зуур уулзсан тэр гурваас бусад хүн юу ч мэдсэнгүй.

«Фараон» онгоцны далайчдын тухай гэвэл өөр ажилд хөлслөгдсөн бололтой, бас алга болжээ.

Ахмад Гомар өвдөж Пальмд хоцорсон байснаа, эдгэрч Марсельдаа буцаж ирэв. Эрхэм Моррель дээр очихыг зүрхэлсэнгүй. Харин цаадах нь ирснийг нь дуулаад өөрөө түүн дээр очжээ. Үнэнч хөлгийн эзэн онгоц сүйдэх үед ахмадын гаргасан эрэлхэг явдлын тухай Пенелонгоос сонссон байсан тул, өөрөө түүний сэтгэлийг засахыг оролдлоо. Моррель түүний цалинг бүрэн авчирсан бөгөөд Гомар, түүний нь авах гэж өөрөө зүрхэлж ирэхгүй байсан биз ээ.

Моррель тэднийхээс гарч яваад, авсан цалингаа ашигтай зарцуулсан бололтой гоё сайхан хувцасласан Пенелонтой шатан дээр дайралдав. Хөлгийн эзнийг хараад үнэнч жолоо баригч их л зовох шиг боллоо. Тэр шатны тавцангийн хамгийн цаад талын буланд шигдэн зогсож, бохио эхлээд баруун завжнаасаа зүүн тийшээ, дараа нь зүүнээсээ баруун тийшээсээ, дараа нь зүүнээсээ баруун тийшээ хийж, айсан байдалтай нүдээ бүлтийлгээд, эрхэм Моррелийг ерийнхөөрөө нөхөрсөг ёсоор гар барихад гарыг нь хулчгардуухан атгав. Эрхэм Моррель түүний зовсон байдлыг нь гоё ганган хувцас өмссөнөөсөө болсон хэрэг гэж бодов. Өвгөн далайчин өөрийн мөнгөөр ингэж ганган хувцасласан биш бололтой. Өөр онгоцонд хөлслөгдөн орж «Фараоныхоо» гашуудлыг ийм хурдан авч хаясандаа эвгүйрхэж байгаа бололтой. Одоо ахмад Гомарт аз дайрснаа хэлж, өөрийн шинэ эзний нэрийн өмнөөс түүнийг ажилд оруулах гэж урьж ч байж ч магадгүй.

- Сайн хүмүүс! Гэж Моррель цааш явахдаа хэлээд - Та нарын эзэн чинь та нарт над шиг хайртай, надаас илүү азтай байх болтугай гэв.

Наймдугаар сарын туршид Моррель урьдын зээллэгээг дахин тогтоох эсвэл шинийг нээх гэж оролдож өнгөрөв.

Моррель шуудангийн сүйх тэргэнд суудал худалдан авчээ гэдэг нь наймдугаар сарын хоринд Марсельд илэрхий болж, хүмүүс түүнийг сарын эцэст хөрөнгө мөнгөгүй болсноо зарлана, харин энэ гунигт ёслолыг гүйцэтгэхийг ахлах захирагч Эмманюель нярав Коклес нарт даалгаад өөрөө яваад өгчихсөн байна гэж ярьцаав. Гэвч хүмүүсийн хүлээж байснаа ангид юм болж, наймдугаар сарын гучин нэгэнд касс урьдын адил нээгдэв. Коклес тортой цонхны цаана ажигч үгүй сууж, авчирч өгсөн өрийн баталгааг нарийвчлан хянаад эхнээс нь аваад эцэст нь хүртэл яг төлж дуусгав. Тэрч байтугай Моррелийн бодож байснаар гадны хоёр хүний өрийг хааж өгөхөд хүрсэн бөгөөд түүнийг нь Коклес хөлгийн эзний өрийн адилаар төлж өгчээ. Хэн ч юу ч ойлгохоо болиод, есдүгээр сарын эцэст өнөөх үгүйрлийн гунигт ёслол ёстой болно доо гэж урьдчилан хэлэв.

Моррель есдүгээр сарын нэгэнд буцаж ирэв. Гэрийнхэн нь сэтгэл түгшин хүлээж байв. Парис орсон нэн аяллаас тэдний аврагдах сүүлчийн бололцоо нь шалтгаалах байжээ. Моррель өөрийнх нь зуучилснаар испанийн нэгэн банкны эзэнд ажилд орж тэндээс эхлэн түргэн баяжсан саятан Дангларын тухай санажээ. Данглар зургаа буюу найман саяын хөрөнгөтэй хязгааргүй их авлагатай хүн гэж ярьцаана. Данглар сохор зоос ч хармаанаасаа гаргалгүйгээр Моррелийг аварч чадах юм. Тэр зөвхөн Моррелийг даана л гэж хэлчихвэл Моррель аврагдах байжээ. Иймд Моррель, аль хэдийнээс эхлэн Дангларын тухай бодох болжээ. Гэвч тодорхой биш шалтгаанаар Моррель дургүй нь хүрч, энэ эцсийнхээ аргыг хэрэглэхээс хойш суусаар байжээ. Түүний бодож байсан нь худал болсонгүй. Данглар түүнд гутамшигтайгаар татгалзсан хариу өгч, Моррель гар хоосон буцаж ирлээ. Гэвч Моррель босго алхангаа гомдож харааж зүхсэн нэг ч үг дуугарсангүй. Нүдэндээ нулимс гүйлгэнүүлэн байж эхнэр охин хоёроо тэврээд, Эмманюель өөд найрсгаар гараа сунгаж мэндлээд, гуравдугаар давхарт байгаа өрөөндөө орж Коклесийг дуудав.

- Энэ удаа ч бид өнгөрсөн шиг байна гэж хоёр эмэгтэй, Эмманюельд хэлэв. Тэд зөвлөн ярилцсаны дараа Жюли Нимад хороотойгоо байгаа ахдаа даруй ир гэж захидал бичихээр шийджээ.

Хөөрхий хүүхнүүд ойртож байгаа аюулыг тэсвэрлэн өнгөрүүлэхийн тулд бүх хүчээ дайчлан хуримтлуулах хэрэгтэйг зөнгөөрөө ойлгожээ.

Мөн Максимилиан Моррель дөнгөж хорин хоёрхон настай ч эцэгтээ их нөлөөтэй хүн байжээ.

Энэ бол шулуун шударга зантай залуу байлаа. Мэргэжлээ сонгон авах цаг болоход эцэг нь ямар мэргэжилтэй болохоо өөрийнхөө дур сонирхлоор шийд гэжээ. Тэгэхэд хүү цэрэгт орно гэжээ. Тэр ингэж шийдээд, элсэх уралдаант шалгалтыг сайн өгч, Политехникийн сургуульд орж, явган цэргийн тавин гуравдугаар хорооны бага дарга болжээ. Нэг жил хиртэй ийм цолтойгоор цэргийн алба хааж байгаа бөгөөд цол дэвшиж магадгүй байлаа. Максимилиан Моррель хороондоо зөвхөн цэргийн үүргийг ч биш бас хүний ёсны үүргийг хатуу чанд

биелүүлдэг хүнд тооцогддог байв. Түүнийг «шулуухан» гэж хочилдог байлаа. Олонх нь бусдыг дагаж ийнхүү хочоор нь дуудахдаа чухам юу гэсэн утгатай болохыг нь ч мэддэггүй нь ойлгомжтой.

Эх дүү хоёр нь ойртон ирж байгаа хүнд үеийг тэсвэрлэн өнгөрөхөд туслуулах гэж саях залуу офицерыг дуудуулсан нь тэр байжээ.

Байдал хүнд болсныг тэд эндэлгүй мэджээ. Моррель Коклестэй хамт өрөөндөө ороод, сүүлд нь Коклес зэвхий цагаан царайтай нүд нь гөлрөн салганан чичирсээр гарч ирэхийг Жюли харжээ.

Жюли түүнийг хажуугаараа өнгөрөхөд зогсоох гэсэн боловч хөөрхий амьтан өөрт нь зохиогүй яаруу байдлаар шат уруу буун, хоёр гараа дээш тэнгэр өөд өргөн дуу алдаж,

- Ай, Жюли авхай! Ямар гэж гаслан бэ! Хэн тэгж бодох билээ! Гэв.

Хэдэн минутын дараа тэрээр тооцооны зузаан дэвтэр, түрийвч, хүүдийтэй мөнгө зэргийг авч ирэв.

Моррель тооцооны дэвтрийг үзэж, түрийвчийг уудлан хүүдийтэй мөнгөө тоолов.

Бэлэн мөнгө нь наймхан мянган франктай тэнцэж байлаа.

Есдүгээр сарын таванд дөрөв таван мянган франк орж ирнэ гэж хүлээж болох байсан тул бүгд нийлээд сайн л бол, арван дөрвөн мянган франктай болох ажээ. Гэтэл хоёр зуун наян долоон мянга таван зуун франкын өр төлөх ёстой байв. Энэ мөнгийг төлөх ямарч боломжгүй байлаа.

Гэвч Моррель хоол идэхээр хүрч ирэхдээ нэлээд тайван байлаа. Энэ тайван байдал нь ямарч гунихралаас илүүгээр хоёр хүүхнийг айлгав.

Моррель хоол идсэнийхээ дараагаар гэрээсээ гарч «Фокейчуудын клубт» очиж «Дохиолуур» сонин уншиж аяга кофе уудаг заншилтай байсан боловч хашаан дотор чулуун дээр, толгой нүцгэн сууж өдрийн ихэнхийг өнгөрүүлэв.

Хатагтай Моррель ба Жюли хоёрыг Эмманюель зориг оруулж, сэтгэлийг нь сэргээх гэсэн боловч уран гоё ярих чадвар нь алга болчихжээ. Моррелийн гэр бүлд аймшигтай сүйрэл тохиолдоно гэдгийг мэдэхгүй байхын аргагүйгээр Эмманюель энэ пүүсийн ажил хэргийг дэндүү сайн мэдэж байжээ.

Шөнө боллоо. Хатагтай Моррель Жюли хоёр Моррелийг ажлын өрөөнөөсөө гарахдаа тэдэн дээгүүр орж ирнэ байх гэж Жорьдоод хэн нь ч унтсангүй. Гэтэл

тэднийг дуудаж магадгүй гэсэн бололтой үүдээр нь сэмхэн өнгөрөхийг цаадуул нь сонсчээ...

Тэр хоёрыг чагнасаар байтал Моррель өрөөндөө ороод хаалгаа түгжихэв.

Хатагтай Моррель охиноо явж унт гээд Жюлийг явсны дараа хагас цаг болоод босож шаахайгаа тайлж орхиод нөхрийгөө юу хийж байгааг цоожны нүхээр шагайж харах гэж гудмаар аяархан явав.

Гэтэл нэгэн сүүдэр цаашаа явчихыг ажиглажээ. Энэ бол сэтгэл нь зовоод эхээсээ түрүүлсэн Жюли байв.

Охин хатагтай Моррель дээр хүрч ирээд,

- Юм бичиж байна гэж хэлэв.

Хоёр хүүхэн үг дуугүйгээр бие биенийхээ санааг ойлгожээ.

Хатагтай Моррель цоожны нүхээр шагайхад Моррель юм бичиж байв. Гэвч хатагтай Моррель охиныхоо олж хараагүй юмыг ажиглажээ. Нөхөр нь сүлдтэй цагаан цаасан дээр юм бичиж байв.

Тэгэхэд нь нөхрийгөө гэрээслэл бичиж байгааг ойлголоо. Хамаг бие нь дагжин чичирсэн боловч Жюлид хэлэхгүй байх зориг гаргажээ.

Маргааш нь эрхэм Моррель огт тайван болчихсон байлаа. Тэр сурсан зангаараа ажлын өрөөндөө байж байгаад, өглөөнийхөө цайг уухаар хүрч ирэв. Харин үдийн хоолны дараа охиноо дэргэдээ суулгаад, хоёр гараараа толгойноос нь барьж цээжиндээ чанга тэврэв.

Үдэш нь Жюли эхдээ аав хэдийгээр тайван байсан боловч зүрх нь хүчтэй цохилж байсан гэж хэлжээ.

Дараагийн хоёр өдөр бас л иймэрхүү түгшүүртэй өнгөрөв. Есдүгээр сарын дөрөвний орой Моррель охиноо албан өрөөний түлхүүр өг гэж шаардав.

Энэ шаардлага Жюлид аймшигтай санагдсан учир цочин дагжив. Урьд хүүхэд байхад нь зөвхөн шийтгэл болгож хурааж авдаг байсан, Жюлийн дандаа авч явдаг энэ түлхүүрийг одоо эцэг нь яагаад авах болов.

Охин асуусан янзтай Моррель өөд харж,

- Би ямар буруу хэрэг хийгээ вэ аав аа, яагаад миний түлхүүрийг хурааж авах гэж байгаа юм бэ? Гэж асуув. Энэ сайхан сэтгэлийн асуултад нүдэнд нь нулимс гүйлгэнэсэн хөөрхий Моррель ,

- Ямар ч буруу хэрэг хийгээгүй охин минь, зүгээр л надад хэрэгтэй байна гэв.

Жюли түлхүүрээ эрж байгаа дүр үзүүлж,

- Би өрөөндөө орхичихсон юм шиг байна гэж хэлэв.

Тэгээд охин гарч өрөөндөө орохын оронд Эмманюельтэй зөвлөхөөр түүн уруу гүйж очив.

- Түлхүүрээ битгий өг, маргааш өглөө, болж өгвөл ааваасаа битгий холд гэж цаадах нь түүнд хэлэв.

Охин Эмманюелиэс учрыг нь асуух гэж оролдсон боловч цаадах нь юу ч мдэхгүй юм уу эсвэл хэлэх дургүй байв.

Есдүгээр сарын дөрөвний шөнө хатагтай Моррель, ханын цаанаас нөхрийнхөө хөлийн чимээг чагнаж өнгөрүүлэв. Өглөөний гурван цаг болтол нөхөр нь сэтгэл түгшүүртэйгээр тасалгаан дотуураа хойш урагшаа холхиж байснаа дөнгөж гурван цагт орондоо хэвтэх нь дуулдлаа.

Эх охин хоёр энэ шөнийг хамт өнгөрүүлэв. Тэд оройноос хойш Макмималианы ирэхийг хүлээж байлаа.

Өглөөний найман цагт эрхэм Моррель өрөөнд нь орж ирлээ. Тайван байдалтай байсан боловч нойргүй хоносны ул мөр цонхигор цагаан царайд ньхарагдаж байв.

Тэр хоёр сайн нойрссон эсэхийг нь ч асууж зүрхэлсэнгүй.

Моррель эхнэр охин хоёртойгоо урьд уьдынхаасаа улам ч их эелдэг зөөлөн байсан бөгөөд охиноо харж ханахгүй байн байн үнэсэв.

Жюли, Эмманюелийн зөвлөн хэлснийг санаж аавыгаа гаргаж өгье гэв. Гэвч эцэг нь түүнийг эелдгээр зогсоогоод,

- Ээжтэйгээ үлд дээ гэж хэлэхэд, Жюли заавал явна гэж зүтгэв.

- Би үлд гэж шаардаж байна! гэж Моррель хэлэв.

Моррель анх удаа охинтойгоо: «Би шаардаж байна» гэж ярьсан нь энэ бөгөөд, тэгэхдээ эцэг ёсны энэрэнгүй дуугаар хэлсэн учир Жюли байрнаасаа хөдөлж чадсангүй.

Охин дуу шуугүй, хөдлөхгүй зогсож үлдэв. Удалгүй хаалга дахин онгойж, нэг хүний гар түүнийг тэврэн авч, духан дэр нь үнэсэв.

Охин дээшээ хараад баярласандаа хашхирав.

- Максимилиан! Ах минь!

Энэ чимээгээр хатагтай Моррель гүйн ирж хүүгээ тэврэн авав. Максимилиан эхээсээ дүү уруугаа харцаа шилжүүлж,

- Ээж минь юу болов? Та нарын захидал намайг айлгаж би яаран ирлээ гэж хэлэхэд,

- Жюли чи ав дээрээ очиж Максимилианыг ирлээ гэж хэл гэж хатагтай хэлэв.

Жюли тасалгаанаас гүйн гартал гартаа захидал барьсан хүнтэй шатан дээр мөргөлдлөө.

- Та Жюли Моррель авхай мөн үү? Гэж ирсэн хүн их л итали аялгуугаар асуув.

- Тийм ээ, эрхэм ээ, би байна. Гэвч та ямар хэрэгтэй билээ? Би таныг танихгүй байна гэж Жюли аман дотроо бувтнав. Итали хүн барьж явсан захидлаа өгөөд,

- Үүнийг уншина уу гэхэд нь Жюли яадаг юм билээ гэсэн Үайдалтай боллоо.

- Аавыг тань аврах тухай л юм байгаа даа гэж хэлэхэд нь Жюли түүний гараас захидалыг шүүрэн авч задлан уншсан нь:

- «Одоохон Мельяний тарималт гудамжинд оч 15 дугаар байшинд орж байшин сахигч хүнээс тавдугаар давхрын тасалгааны түлхүүрийг аваад тасалгаанд ор, задгай зуухан дээр байгаа улаан торгон түрийвчийг авч, аавдаа аваачиж өг.

Тэр, энэ түрүүвчийг арван нэгэн цаг болохоос өмнө хүлээн авах нь чухал шүү.

Та миний хэлсэн үгийг сохроор биелүүлнэ гэсэн шүү дээ. Таны ингэж амласныг дахин сануулъя.

Синдбад - далайч.»

Залуу бүсгүй баяртайгаар дуу алдан хашхираад дээшээ болж захидал авчирч өгсөн хүнээс шалгаах санаатай хартал, цаадах нь алга болчихсон байлаа.

Тэгээд охин захидлыг дахин уншсанаа, нэмж бичсэн зүйл байхыг олж харав:

«Та энэ даалгаврыг ганц биеэрээ гүйцэтгэх нь чухал. Хэрвээ өөр хамт ирэх буюу эсвэл өөр хүн таны оронд ирвэл байшин сахигч юу ярьж байгааг тань мэдэхгүй гэж хариулах болно».

Энэ нэмж бичсэн зүйл бүсгүйн баярласан сэтгэлийг тэр дор нь хөргөв. Ямар нэг аюул заналхийлж байгаа юм биш биз? Занга тавьчихсан юм биш байгаа? Жюли ийм насны охин ямар аюулд учирч болохыг мэдэхээргүй тийм гэнэн хонгор нэгэн байлаа. Гэвч айхын тулд аюулыг үзэх хэрэгтэй биш. Чухамдаа үл мэдэгдэх аюул бол улам их айдас төрүүлдөг.

Жюли эргэлзэж, хүнээс зөвлөн асуухаар шийдлээ.

Тэгээд ямар нэгэн тайлбарлашгүй шалтгаанаар эхээсээ биш ахаас а биш, харин Эмманюелиэс тусламж эрэхээр явлаа.

Бүсгүй доошоо бууж, Томсон ба "ренчийн банкны төлөөлөгч ирсэн өдөр юу болсон, шатан дээр болсон явдал мөн ам өлсөн тухайгаа түүнд яриад захидлаа үзүүлэв.

- Та очих ёстой гэж Эмманюель хэлэхэд,
- Тийшээ очих гэж үү? Гэж Жюли шивнэв.
- Би тантай хамт очъё.
- Намайг ганцаараа ир гэж бичсэн байсныг уншаа биз дээ?
- Тэгээд яагаа вэ, та ганцаараа л очих болно гэж Эмманюель хариулаад - Би таныг гомдоосон хүнийг гомдолгүй болгоод өгөмц гэж хэлэв.
- Та тэгж бодож байна уу? Эмманюель, би энэ урилгаар очих ёстой болж байна уу? гэж охин шийдвэргүйхэн асуув.
- Тийм ээ оч. Ирсэн хүн таны эцгийг аврах тухай ярьж байна гэж хэлсэн биш бил үү?
- Юунаас аврах гэж тэр вэ, Эмманюель? Түүнд ямар аюул учраад байгаа юм бэ? Гэж Жюли асуув.

Эмманюель эргэлзсэн боловч, Жюлигийн зоригийг чангалах гэдэг бодол бүхнийг дийлж,

- Өнөөдөр чинь есдүгээр сарын таван шүү дээ гэж хэлэв.
- Тийм ээ.
- Өнөөдрийн арван нэгэн цагт танай аав гурван зуун мянга шахам франк төлөх ёстой.
- Тийм ээ, бид үүнийг мэднэ.
- Тэгтэл кассанд нь арван тавхан мянган франк ч алга байна шүү дээ гэж Эмманюель хэлэв.
- Тэгээд юу болох вэ?
- Хэрвээ өнөөдөр арван нэгэн цаг болтол аавд чинь туслах хүн гарч ирэхгүй бол, өдөр дунд дампуурснаа зарлах ёстой болно.
- Тэгвэл явъя, явъя бушуул! Гэж Жюли сандран дуу алдаад Эмманюелийг дагуулан явав.
- Тэр завсар хатагтай Моррель хүүдээ бүгдийг нь яржээ.

Максимилиан эцэгт нь удаа дараалан тохиолдсон золгүй явдлуудын дараа гэрийнх нь амьдралын байдалд ихээхэн өөрчлөлт гарсныг мэдэж байсан боловч хэрэг явдал ийм цөхөрсөн, аргаа барсан байдалд хүрснийг мэдээгүй байжээ.

Гэнэтийн энэ явдал түүнийг балмагтуулжээ.

Тэгээд тасалгаанаас гүйн гараад шатар өгсөж, аавыгаа байх болов уу гэж өрөөний нь хаалгыг цохив.

Энэ үед доор үүд онгойж, эргэн харвал эцэг нь байлаа. Моррель шууд ажлынхаа тасалгаа уруу явсангүй эхлээд өрөөгөөрөө ороод, гарч ирж байгаа нь энэ ажээ.

Эрхэм Моррель хүүгээ ирснийг мэдээгүй байсан учир түүнийг үзээд гайхан дуу алдав. Тэр зүүн сугандаа нэг юм нууж хавчуулаад, байран дээрээ хөдлөлгүй зогсоно.

Максимилиан шатаар түргэн бууж, аавыгаа хүзүүдэн авав. Тэгснээ гэнэт баруун гараараа эцгийнхээ элгэнд тулж гэдрэгээ ухрав. Тэгээд царай нь үхээрийн юм шиг хачин зэвхийрч,

- Аав аа та яагаад буу авч явна вэ? гэж асуухад Моррель,

- Би ингэнэ л гэж айж байсан юм... гэв.

- Аав аа! Бурхан минь! Энэ чинь юун зэвсэг вэ? гэж Максимилиан дуу алдахад, Моррель хүүгээ нүд салгалгүй ширтэн,

- Максимилиан чи бол эр хүн, нэр төрөө ч хамгаалж чадна, миний өрөөнд очъё, би бүгдийг ярья гэж хэлэв.

Тэгээд Моррель шийдэмгий алхаагаар өөдөө өгсөж өрөө уруугаа явахад, Максимилиан хойноос нь энд тэнд гишгэн дагажээ.

Моррель хаалгаа онгойлгон хүүгээ түрүүлж оруулаад хаалгаа түгжив. Үүднийхээ өрөөг өнгөрч бичгийнхээ ширээнд очиж буугаа гаргаж тавиад дэлгээтэй орхисон дансаа хүүдээ харуулав.

Данс хэрэг явдлыг яг үнэнээр нь ойлгуулжээ.

Хагас цагийн дараа Моррель хоёр зуун наян долоон мянга таван зуун франк төлөх ёстой байлаа.

Тэгэхэд кассанд нь дөнгөж арван таван мянга хоёр зуун тавин долоон франк байв.

- Унш! Гэж Моррель хэлэв.

Максимилиан уншив. Тэр аянганд ниргүүлсэн юм шиг зогсоно.

Эцэг нь нэг ч үг дуугарсангүй, энэ хаашаа ч гарахын аргагүй тоон дээр юугаа ч нэмэх юм билээ?

- Аав аа, та үүнээс зайлж гарах бололцоотой бүхнийг хийсэн үү? Гэж Максимилиан эцэст нь асуухад, Моррель

- Бүгдийг хийсээн гэж хариулав.

- Одоо орох орлого юу ч байхгүй юу?

- Юу ч байхгүй.

- Бүх хөрөнгөө барчихсан уу?

- Бүгдийг нь барчихсан.

- Тэгвэл хагас цагийн дараа... гээд Максимилианы царай барайж - Манай нэр төр нэгмөсөн хугарах нь ээ! гэж шивнэв.

- Нэр төрөө алдах явдлаас цус л авардаг юм гэж Моррель хэлэв.

- Таны зөв аав минь, таны хэлж байгааг ойлгож байна гээд буунууд уруу гараа сарвайж, - Нэг нь таных, нэг нь минийх. Баярлалаа гэхэд Моррель түүний гарыг зогсоож,

- Аа ээж?... Дүү?... Тэднийг хэн тэжээх вэ? гэхэд Максимилиан цочиж,

- Аав аа! Та намайг амьд бай гэж хэлж байгаа хэрэг үү? Гэж асуув.

- Тийм ээ, тэгж байгаа юм гэж Моррель хариулаад - Энэ бол чиний үүрэг. Максимилиан чи бол зориг тэнхээтэй, ухаантай хүн. Би чамд тушааж, тулгаж байгаа юм биш зүгээр л ярьж байгаа юм. «Чи өөрийгөө гадны хүн юм гэлээ гэж бодоод, байдлыг сайн эрэгцүүлж үз» гэв.

Максимилиан бодлого болсноо, нүд нь зоримгоор гялалзав. Гэвч энэ завсар тэр погоноо алгуур бөгөөд уйтгартайгаар хуулан авав.

- За яах вэ аав минь, сэтгэл тайван яв. Би амьд байя гэж хүү нь эцэгтээ гараа өгч хэлэв.

Моррель хүүгийнхээ хөлд сөхрөн унах гэсэн боловч хүү нь тэврэн авч сайхан сэтгэлийн хоёр зүрх нийлэн цохилон.

- Би буруутай биш гэдгийг чи мэднэ шүү дээ? гэж Моррель хэлэхэд Максимилиан инээмсэглэж,

- Таныг хамгийн үнэнч шударга хүн гэдгийг би мэднэ гэж хариулав.

- За сайн байна, бид хоёр ярьж гүйцлээ, одоо ээж, дүү хоёр дээрээ оч гэхэд залуу өвдөг дээрээ сөхрөн сууж,

- Аав аа та надад ерөөл тавьж адислаач гэв.

Моррель хоёр гараараа хүүгийнхээ толгойноос бариад, үнэсэж хэлсэн нь:

- Би өөрийн нэрийн өмнөөс болон, гэм зэмгүй гурван үеийнхнийхээ нэрийн өмнөөс адислан ерөөж байна. Тэд миний амаар дамжуулан чамд хэлэхийг сонс, золгүй явдлаар нурсан барилга тэнгэрийн бошгоор дахин босож мэднэ. Намайг яаж амь алдсан болохыг хараад хамгийн адармаатай хүмүүс ч гэсэн чамайг өрөвдөн үзэх болно. Надад бол хойшлуулж өгөхгүй байсан хугацааг чамд сунгаж өгч магадгүй. Тэгвэл тэрхүү гутамшигт үгийг хэлэхгүй болохын тулд чадах

бүхнээ хий. Ажлаа хийсэн шиг хийж зүрх зоригтой хөдөлж тэмцээрэй. Миний оронд өгөх хөрөнгийг өдрөөс өдөрт хуримтлуулахын тулд, аль болохуйц даруйхнаар амьдарч яваарай. Энэ тасалгаандаа чи: «Өнөөдөр миний хийж бүтээсэн зүйлийг миний эцэг хийж чадаагүй учир нас барсан юм, гэвч тэр намайг үүнийг хийж чадна гэж итгэж байсан учир тайван өөд болсон юм » гэж хэлж чадах тэр өдөр, миний нэр төр дахин сэргэн босгогдох тэр өдөр ямар сайхан, баяртай өдөр болно гэдгийг санаж яв гэхэд,

- Ай, аав аа, аав аа, та бидэнтэй үлдэж хоцордог ч болоосой! Гэж Максимилиан дуу алдав.

- Хэрвээ би амьд үлдэх юм бол бүх зүйл шал өөр болно .Хэрвээ би амьд үлдвэл хүмүүс өрөвдөхийн оронд үл итгэж, шахаж шаардсаар байх болно. Хэрвээ би амьд үлдвэл хэлсэн үгэндээ хүрдэггүй, өрөө төлөх чадваргүй, өрт амьтан болж хувирна. Хэрвээ би үхвэл Максимилиан минь энэ тухай бод, миний хүүр золгүй боловч үнэнч хүний хүүр байна. Би амьд байвал сайн нөхөд маань гэсэн ч надаас зайлсхийх болно. Хэрвээ би үхвэл Марселийнхан цөмөөрөө нүдэндээ нулимстайгаар намайг сүүлчийн минь замд үдэж гаргаж өгөх болно. Би амьд байвал, чи миний нэрээс ичиж зовох болно. Би үхвэл чи тэргүүнээ бардмаар өргөж «Би бол амьдралдаа анх удаа хэлсэн үгэндээ хүрч чадаагүй учраас амиа хорлож үхсэн хүний хүү шүү» гэж хэлж явах болно.

Максимилиан гунигтайгаар гиншсэн боловч хувь заяаны эрхийг дагасан бололтой. Энэ удаад зүрх сэтгэлээрээ биш боловч оюун ухаанаараа эцгийнхээ нотолгоог зөвшөөрч байлаа.

- Харин одоо ганцааранг минь орхи, эх дүү хоёроо эндээс холхон байлгахыг хичээгээрэй гэж Моррель хэлэв.

- Та Жюлитэй дахин уулзахгүй юу? гэж Максимилиан асуув.

Энэ уулзалтад сүүлчийн бүүр түүр горьдлого байсан боловч, Моррель толго© сэгсэрч,

- Би түүнтэй өглөө уулз ж салах ёс гүйцэтгэсэн гэж хэлэв.

- Аав аа танд надад захиж хэлэх өөр юм байхгүй юу? гэж Максимилиан бүдэгхэн дуугаар асуув.

- Байна аа хүү минь, нэг ариун сахиус байна.

- Хэл л дээ аав минь.

- Томсон ба Френчийн банк энэрэх сэтгэлээсээ ч юм уу хувиа бодсоноосоо ч тэр үү бүү мэд, би хүний бодол сэтгэлийг эрэгцүүлэн үзэх хэрэг

алга, юу боловч намайг өрөвдөж энэрсэн ганц газар байгаа юм. Одоо арван минутын дараа түүний итгэмжит төлөөлөгч хоёр зуун наян долоон мянга таван зуун франкын өрийн баталгаа авч ирнэ. Энэ хүн өөрөө гурван сарын хугацаа сунгаж өгсөн юм. Энэ пүүс хамгийн түрүүнд авах ёстой мөнгөө аваг, энэ хүн чамд ариун сайн хүн болог.

- За мэдлээ аав минь, гэж Максимилиан хэлэхэд

- Аа одоо, намайг дахин уучлаарай гэж Моррель хэлээд - Яв, яв би ганцаараа байх хэрэгтэй байна. Миний гэрээсийг унтлагын өрөөний ширээний нүднээс олж авах болно гэв.

Максимилиан хөдлөлгүй зогсоно. Тэр явах гэсэн боловч чадсангүй.

- Яв, Максимилиан гэж эцэг нь хэлээд - Би чам шиг цэрэг юм гэж бодъё, тэгээд бэхлэлт уруу дайрах тушаал авсан байг, намайг амь алдана гэдгийг чи мэдэж байгаа, тэгвэл чи одоогийнх шиг: «Аав минь яв, таны нэр төр хугарах болно, гутамшигт явдалд орсноос үхсэн дээр» гэж хэлэхгүй байсан гэж үү дээ? гэв.

- Тийм ээ, тэгж хэлнэ гэж Максимилиан хэлээд татвасхийн тэврэн авч,

- Яв даа аав минь, гэж хэлээд тасалгаанаас гүйн гарав.

Моррель ганцаараа үлдээд хүүгийнхэс гарсны дараа хаагдсан хаалга уруу харж хэдэн минут хөдлөлгүй зогссоноо, гараа сунгаж хонхны оосор олж татав.

Коклес орж ирэв. Энэ гурван хоногт тэр танигдашгүй болжээ. Моррелийн пүүс төлбөр төлөхөө болино гэдэг бодол түүнийг хорин жилээр хөгшрүүлжээ.

- Коклес найз минь чи үүдний өрөөнд байж бай. Гурван сарын өмнө энд ирсэн тэр эрхмийг хүрч ирэхээр тэр хүн Томсон ба Френчийн пүүсийн итгэмждэгдсэн төлөөлөгч гэдгийг чи мэднэ шүү дээ надад хэлээрэй.

Коклес хариу юу ч дуугаралгүйгээр толгойгоо дохичихоод гарч, үүдний өрөөнд сандал дээр суув.

Моррель зөөлөн сандал дээрээ лагхийн суув. Ханын цаг өөд харахад долоохон минут дутуу байлаа. Зүү нь хачин хурдан явах бөгөөд хөдлөх нь ч түүнд харагдах шиг болжээ.

Магадгүй хуурмаг ч байж болох боловч түүнд үнэн зөв мэт санагдах бодол итгэлдээ захирагдан насныхаа ид үед хайрлаж, дурлаж байсан бүх юмнаасаа хагацан салахаар бэлтгэж, гэр бүлийн жаргалыг бэлэглэн өгсөн амьдралаасаа хагацах гэж байгаа хүний сэтгэлд сүүлчийн энэ агшинд чухам юу болж байсныг үгээр хэлэхийн аргагүй. Үүнийг ойлгохын тулд, хувь зохиолоо дагасан байдлы нь

илэрхийлсэн боловч хөлс бурзайсан дух, нулимс дүүрэн мэлтэгнэсэн боловч өөдөө харсан нүдий нь харах хэрэгтэй байлаа.

Цагийн зүү гүйнэ. Гар буу цэнэгтэй бэлэн байх бөгөөд түүний нэгийг аваад, охиныхоо нэрийг шивнэн хэлэв.

Дараа нь үхлийн зэвсгээ буцааж тавиад, үзгээ авч хэдэн үг бичлээ. Хайртай охиноосоо салах ёсыг хангалттай сайн гүйцэтгэж чадаагүй мэт санагджээ.

Дараа нь цаг өөдөө дахин харав. Одоо цаг нь хувиар биш хормоор тоологдох боллоо.

Дахин буугаа аваад, амаа ангайсхийн цагийн зүү өөд ширтэн, замгий нь таттал хаалганы түгжээ дуугарахыг сонсоод цочин давхийв.

Энэхүү эгшин зуурын дотор нүүрий нь даган хөлс урсаж, үхлийн уйтгар гуниг зүрхий нь базална. Тэгтэл шатан доор хаалга чахрах дуу гарав.

Дараа нь тасалгааны үүд нээгдэв.

Цагийн зүү арван нэгд дөхөж байлаа.

Моррель эргэж харсангүй, одоо Коклесийг орж ирээд: «Томсон ба Френчийн пүүсийн итгэмжлэгдсэн төлөөлөгч» гэж хэлнэ гэж хүлээж байв.

Тэгээд буугаа ам өөдөө аваачив...

Ар талд нь чанга дуу гарлаа, Энэ бол охины нь дуу байлаа. Тэр эргэж Жюлийн орж ирснийг харав. Буу нь гараас нь унав.

- Аав аа! Та аврагдсан! Аврагдсан! Гэж оин баярласан ба ядарсандаа болж амьсгаадан хашхирав.

Тэгээд эцгийн өвөрт наалдаж улаан торгон түрүүвч гартаа өргөнө.

- Охин минь аврагдлаа гэнэ ээ? гэж Моррель дуу алдаад
- Хэнээс, юугаар? Гэж асуухад Жюли,
- Тийм ээ аврагдсан! Үүнийг хараач, хараач! Гэж хашхирна.

Моррель түрүүвчийг аваад цочин т твасхийв. Энэ түрүүвч нэгэн цагт өөрт нь байсныг бүүр түүр санажээ.

Түрүүвчний нэг талд нь хоёр зуун наян долоон мянга таван зуун франкын өрийн баталгаа байлаа.

Эдгээр баталгааг хүчингүй болгосон байв.

Нөгөө талд нь хушгийн хяраатай доржпалам хийж хэсэг илгэн цаасан дээр:

Жюлийн инж гэж бичсэн байлаа.

Моррель духаа илэв. Сэтгэл зүүдэндээ бодож байгаа юм шиг түүнд санагджээ.

Арван нэгэн цаг цохиж эхлэв.

Цагийн цохилт бүр түүний зүрхийг ган алхаар цохиж байгаа мэт санагдана.

- Байзаарай охин минь, яагаад ийм болов, надад тайлбарлаж өгөөч. Энэ түрийвчийг чи хаанаас олов? Гэж Моррель асуув.

- Мельяний тарималт гудамжны арван тавдугаар байшингийн тавдугаар давхрын нэг муу өрөөний задгай зуухан дээрээс авлаа.

- Тэгвэл энэ түрийвч чамд хамаагүй юм байна шүү дээ гэж Моррель дуу алдахад Жюли өглөө нь хүлээж авсан захидлаа аавдаа өгөв. Моррель захидлыг унших зуур,

- Тэгээд чи тэр уруу ганцаараа очив уу? гэж асуув.

- Эмманюель надтай хамт очсон. Тэр намайг Музейн гудамжны булан дээр хүлээнэ гэсэн. Харин гараад ирсэн чинь алга болчихсон байх юм.

- Эрхэм Моррель! Эрхэм Моррель! Гэх дуу шатан дээр гарав.

- Энэ чинь тэр байна шүү дээ! гэж Жюли хэлэв.

Тэгэнгүүт Эмманюель сэтгэл нь догдолж баярласандаа юугаа ч мэдэлгүй давхин оорж ирээд,

- «Фараон, Фараон» гэж хашхирав.

- Юу «Фараон» гэж Эмманюель та өөрийн ухаантай байна уу? Түүнийг сүйдэж үгүй болсон гэдгийг та мэднэ шүү дээ.

- «Фа^оон» эрхэм Моррель! Дохио өглөө «Фараон» буудалд орж ирж явна.

Моррель хүч тамир алдарч зөөлөн сандал дээрээ унав. Энэ дуулдаж сонстоогүй хачин зүйл ухаанд нь багтахгүй байлаа.

Гэтэл үүд онгойж Максимилиан орж ирэв.

- Аав аа гэж тэр хэлээд - Та «Фараон»-ыг сүйрчихсэн гээгүй бил үү? Манааны өндөрлөгөөс түүнийг буудалд орж ирж явна гэж дохио өгч байна гэв.

- Найз нхөд минь, хэрвээ энэ үнэн бол бурхны гайхамшиг! Гэвч үгүй байх аа, тийм байх ёсгүй! гэж Моррель хэлэв.

Гэвч түүний гартаа барьж байгаа хүчингүй болгосон баталгаатай, гялалзсан хар эрдэнэтэй түрийвч нь багагүй итгэгдмээр зүйл байлаа. Бас энэ завсар орж ирсэн Коклес,

- Эрхэм Моррель юу болж байна вэ! «Фараон» ирж явна! Гэж хэлэхэд Моррель,

- Явъя найз нөхөд минь, явж үзье, хэрвээ энэ худал мэдээ байвал бурхан биднийг энэрэг гэв.

Тэр шатан дээр хатагтай Моррельтой дайралдав. Хөөрхий эмэгтэй өөдөө гарч зүрхэлсэнгүй.

Хэдэн минутын дараа тэд Каннебьер гудамжинд гарсан байв.

Буудлын зогсоолд хүмүүс бөөгнөрөлдөнө.

Цугларсан олон Моррельд зам тавьж өгөв.

- «Фараон», «Фараон» гэж хашхиралдана.

Нээрээ ч олны нүдний өмнө дуулдаж сонстоогүй гайхамшигт явдал болж байлаа. Гэгээн Иоаннын цамхгийн нөгөө талд хошуун дээрээ «Фараон» (Моррель ба түүний хүү) гэж бичсэн урьдын «Фараон»-тай яг адил бас үнэт хөх будаг ачсан хөлөг онгоц зангуугаа хаяж, далбаануудаа буулгаж байлаа. Онгоцон дээр ахмад Гомар захирч, Пенелон гуай эрхэм Моррельд дохио өгч байв. Цааш эргэлзэх юмгүй. Моррель, түүний гэр бүл, үйлчлэгчид нь үүнийг нүдээрээ үзсэн бөгөөд бас үүнийг арван мянган хүний нүд харлаа.

Эцэг хүү Моррелийг хотынхны баяр хөөр болсон дуу чимээн дунд тэврэлдэж байхад, энэ гайхамшигт явдлын ажиглагдамгүй гэрч нүүрнийхээ тэн хагасыг хүртэл хар сахалтай хүн харуулын шовгорын цаанаас сэм ажиглаж байгаад,

- Сайхан сэтгэлт хүн минь аз жаргалтай бай, чиний хийсэн болоод хойшид хийх сайн сайхан үйл чинь улам дэлгэрэг. Миний хариу баяр чиний сайн үйл шиг нууц үлдэг гэж шивнэв.

Тэгээд сэтгэл ханамжтай баяртай инээмсэглээд, зогсож байсан газраасаа гарч, болж буй явдалд хүмүүсийн анхаарал татагдсан болохоор хэнд ч анзаарагдалгүй шатаар зогсоол уруу бууж, гурвантаа,

- Жакопо! Жакопо! Жакопо! Гэж дуудав.

Түүн уруу завь хүрэлцэн ирж суулгаж аваад, баян төхөөрөмжтэй дарвуулт онгоц уруу аваачхад, энэ хүн далайчин шиг хөнгөн шалмагаар түүн дээр үсрэн гарав. Эндээс тал бүхнээс нь сарвайсан гарыг нөхөрсгөөр атгаж, аврагчийгаа тэнгэрт байгаа мэт нулимс гүйлгэнэсэн нүдээр өөдөө харан хайж байгаа Моррелийг дахин харав.

- За, одоо гэж үл таних хүн хэлээд - Хүнийг энэрэн үзэгч... сайхан сэтгэл минь баяртай! Би сайн сэтгэлт хүмүүсийг баярлуулан бурхныг орлолоо. Одоо өшөө хорслын бурхан хортон санаатаас өшөөгөө авахад минь зай тавьж өгөг! гэв.

Энэ үгийг хэлээд, дохио өгөхөд зөвхөн үүнийг л хүлээж байсан бололтой дарвуулт онг@ц далайд гарч явлаа.

10. Итали Синдбад-далайчин

1838 оны эхээр Флоренцад Парисын шилдэгт хамаарагдах хоёр залуу сууж байлаа. Энэ хоёр бол бэйс Альбер де Морсер ба түшээ гүн Франц д Эпине хоёр ажээ. Тэр хоёр Ром хотод багт наадам хамт үзэхээр ярилцан тохирсон бөгөөд Франц нь Ром хотод дөрвөн жил суусан учир Альбертаа энэ хотыг тайлбарлан үйлчлэгчийн үүрэг гүйцэтгэх ёстой байлаа.

Ромд багт наадам үзэж өнгөрүүлнэ гэдэг хэрвээ Пьяцца дель Пополо ч юм уу эсвэл Кампо Ваччинод хоноё л гэхгүй бол Пьяццади Спанья гудамжинд байдаг «Лондон» хэмээх зочид буудлын эзэн эрхэм Пастринид нэг сайн байр тавьж байгаарай гэж захидал бичжээ.

Тэгэхэд нь эрхэм Пастрини, тэдэнд al secondo piano-д зөвхөн унтлагын хоёр өрөө ба зочдын ганц өрөөг, их ч үгүй бага ч үгүй үнэ болох өдрийн нэг луидороор хөлслүүлж болно хэмээн хариулжээ. Залуу хүмүүс зөвшөөрчээ. Альбер багт наадам хүртэлх хугацааг дэмий өнгөрүүлэхгүйн тул Неаполь хот уруу явж Франц нь Флоренцдоо үлдлээ.

Медичийн нэрд гарсан хотын амьдралд цэнгэн жаргаж, Кашина хэмээх диваажинд зугаацан, Флоренцын эзэд болох баяд ихсийн зочломтгойг үзэн мэдээд бонапартын өлгий нутаг болох Корсийг нэгэнт үзсэн болохоор одоо Наполеоны замын буудал болсон Эльба арлыг үзэхээр шийдлээ.

Ийнхүү нэгэн орой тэр ливорийн онгоц зогсоолын төмөр гогцооноос уяатай байгаа далбаат завийг тайлан явахыг тушаагаад, далайчдад зөвхөн Журван үг «Эльба арал уруу» гэж хэлээд цув нөмөрч завийн ёроолд орж хэвтэв. Завь нь үүрнээсээ нисэн гарч байгаа тэнгисийн шувуу шиг их тэнгис уруу давхин одож, маргааш нь Францыг Порто-Феррайод аваачиж буулгав.

Франц, эзэн хааны арал дээгүүр хөндлөн гулд яваад, Марчанд ирж дахин далайд гарч явав.

Тэгээд хоёр цагийн дараа улаан ятуу багшран нисэж байдаг гэж хэлсэн Пианоз арлын эрэг дээр буув. Ан амжилтгүй боллоо. Франц арай ядан байж хэдэн эцэнхий шувуу буудаж цаг, хүчээ дэмий барж гүйцсэн анчны адилаар нэлээд дурамжхан сэтгэлэгтэйгээр завиндаа суув.

- Хэрвээ эрхэмсэг та таалахсан бол, тийм ч муугүйгээр ан хийж болно доо гэж завины эзэн хэлэв.

- Хаана тэр вэ? гэж асуухад, эзэн өмнө зүгт, хар хөх өнгөтэй тэнгис дундаас сүндэрлэн боссон бараан зүйлийг зааж,

- Тэр арлыг харж байна уу? гэхэд Франц,

- Энэ юун арал вэ? гэж асуув.

- Монте-Кристо арал гэж эзэн хариулав.

- Үгүй, надад энэ арал дээр ан хийх зөвшөөрөл байхгүй.

- Зөвшөөрөл мөвшөөрөл хэрэггүй, хүн суудаггүй арал байгаа юм.

- Тэгвэл ч догь хэрэг ээ! Газрын дундадтэнгист хүн амьтан суудаггүй арал байна гэнэ ээ? Сонин хэрэг байна даа.

- Эрхэмсэг та гайхах юм байхгүй. Энэ арал туж хад чулуугаар бүрдсэн учир, тэндээс үр шимтэй өчүүхэн ч газар эрээд олохгүй.

- Тэгвэл энэ арал хэний харъяаных вэ?

- Тосканы харъяа

- Тэнд ямар ан байдаг юм бэ?

- Янгир ямаа л их байдаг юм гэхэд Франц үнэмшихгүй байгаа янзтай инээмсэглээд,

- Чулуу долоож амьдардаг амьтад байх нь ээ гэж хэлэв.
- Үгүй, тэд хад хавцлын завсар, ангалаар ургасан жанжуу гүйлс, хонин арц идэж амьдардаг юм.
- Тэгээд би хаана унтах вэ?
- Арал дээрх агуйд, эсвэл завин дотроо цуваа нөмрөөд унтаж болно. Эсвэл эрхэмсэг таныг хүсвэл ангаа хийж дуусмагц буцаж явж болно. Бид чинь өдөр ч тэр шөнө ч тэр дарвуул татан явдаг улс. Хэрвээ хэрэг тохиолдвол сэлүүрдээд ч явдаг юм даа.

Франц найз нөхөртэйгээ уулзахаар болзсон цаг хүртэл нэлээд хугацаа байсан ба Ромд очоод орох орон олчихсон болохоор саналыг хүлээн авч, урьд амжилтгүй өнгөрсөн ангийнхаа хариуг авахаар шийдлээ.

Тэгээд зөвшөөрлөө гэдгээ хэлбэл далайчид хоорондоо шивнэлдэв.

- Та нар юун тухай шивнэлдээд байна? Ямар нэгэн саад тотгор байгаа юм биш биз дээ? гэж Франц асуухад завины эзэн,

- Ямарч юм байхгүй. Гэвч энэ арал хяналтан дор байдаг юм гэдгийг эрхэмсэг танд бид урьдаас хэлж мэдэгдэх ёстой.

- Энэ юу гэсэн үг вэ?

- Энэ бол Монте-Кристо арал дээр хүн суудаггүй болохоор Корс, Сардин Африкийн хориотой юм тээж худалдагсад далайн дээрэмчид тэнд хааяа нуугдаж буудаллах нь тохиолддог. Тийм учраас хэрвээ биднийг энд ирж гэж мэдвэл Ливоронд зургаан хоног тусгаарлан хорих болно гэсэн үг.

- Чөтгөр ав! Энэ ч өөр хэрэг шүү. Зургаан хоног гэнэ ээ! Бурхан б гш орчлон ертөнцийг бүтээхэд хэргэлэсэнтэй адил зургаан хоног юм аа. Найз нөхөд минь энэ ч арай олон байна аа.

- За даа, хэн л эрхэмсэг таныг Монте-Кристо арал дээр оччихлоо гэж хэлнэ аж дээ?

- Юу боловч би хэлэхгүй шүү гэж Франц дуу гарахад далайчид,

- Бид ч бас үгүй гэгцгээв.

- За тэгвэл Монте-Кристо уруу явцгаая!

Энэ тушаал өгмөгц, завь Монте-Кристо арлыг чиглэн нисэх мэт одлоо.

Завь эргэж, шинэ чиглэлдээ орж, салхи дарвуулыг үлээн, дөрвөн далайчин өөр өөрсдийн суудлаа эзэлж, гурав нь өмнө, нэг нь жолоон дээр суухыг Франц хүлээж байгаад яриагаа дахин үргэлжлүүлж, завины эзэнд хандан,

- Найрсаг Гаэтано та, Монте-Кристо арал дээр далайн дээрэмчид үүрлэдэг гэж хэлсэн байх аа. Тэгэхээр эд чинь янгир ямаанаас шал өөр төлрийн ан шүү дээ гэж хэлэв.

- Тийм ээ яг тийм дээ эрхэм минь

- Би хориотой бараа тээн худалдагсад байдаг гэдгийг мэднэ. Харин Алжирыг эзэлж, берберийн өөртөө засах төр унаснаа хойш далайн дээрэмчид гэдгийг чинь зөвхөн Купер ба ахмад Марриэтын бичсэн зохиолуудад л байдаг юм гэж боддог юм.

- Эрхэмсэг та ташаарч байна. Хутагт хамба XII Лев их замын дээрэмчидтэй адилаар далайн дээрэмчдийг устгасан гэх боловч Ромын харуулын бүр дэргэд нь жуулчдыг өдөр бүр дээрэмдсээр байгаа юм. Жил хагасын өмнө гэгээн эзний дэргэд суулгасан францын итгэмжлэх төлөөлөгчийг Веллетрээс тавьхан алхмын зайтай газар дээрэмдсэнийг та дуулаагүй гэж үү?

- Би энэ тухай дуулсан.

- Хэрвээ эрхэмсэг та бидэн шиг Ливорнод суудагсан бол янз бүрийн бараатай хөлөг онгоц ч юм уу эсвэл Бастин, Порт®-Феррайо буюу Чивита-Виккийд ирэх ёстой байсан английн гоёмсог дарвуулт онгоц сураг чимээгүй алга болдог бөгөөд бодвол цохио хад мөргөн эвдэрсэн байлгүй дээ гэдгийг сонсох сон. Харин тэр цохио гээч нь зургаагаас найман хүнтэй ердийн нэг бэсрэг завь бөгөөд замын дээрэмчид шуудангийн сүйх тэргийг ойн захад зогсоон дээрэмддэгтэй яг адилаар ямар нэг хөлөг онгоцыг шуургатай харанхуй шөнө эзгүй арлын дэргэд эзлэн авч дээрэмддэг юм.

- Тэгвэл гээд Франц цувандаа шигдэн- дээрэмдүүлсэн улс яагаад гомдол гаргадаггүй юм бэ? Тэд энэ далйн дээрэмчдийн эсрэг Франц, Сардин эсвэл Тосканы засгийн газруудаас тусламж гуйхгүй яасан юм бэ? Гэж асуув.

- Яасан юм бэ гэнэ ээ? гэж Гаэтано инээвхийлэн асуув.

- Тийм ээ яагаад? Яагаад гэвэл, юуны өмнө онгоцноос хамаг хэрэгтэй бүхний нь завиндаа зөөж аваачдаг, дараа нь онгоцонд явсан хүмүүсийн гар хөлий нь хүлж, хөлнөөс нь хорин дөрвөн фунтын ширэм зүүгээд олзлогдсон онгоцныхоо доод талд ган хувингийн чинээ нүх гаргаад, онгоцны тавцангийн нүхнүүдийг таглаж орхиод өөрсдөө завиндаа үсрээд суучихдаг юм. Тэгээд арван минутын дараа хөлөг онгоц ус залгин хахаж цацан, гиншин дуугарч, бага багаар усанд живж эхлэх бөгөөд эхлээд нэг бөөрөөрөө хэлтийн хэлбэлзэнэ. Хөлөг онгоц өөдөө болсноо дахин доошилж усанд улам гүн живнэ. Тэгснээ гэнэт их буу дуугарах мэт чимээ гарах бөгөөд энэ нь шахагдсан хий онгоцны тавцанг

дэлбэ тавьж байгаа хэрэг. Хөлөг онгоц нь живж байгаа хүн шиг амь тэмцэн татвагнана. Хөлөг онгоцонд орсон ус дээшээ гарч чадахгүй шахагдахаараа, аварга том халим загас хамраараа усан оргилуур цацаргаж байгаа юм шиг аль тохиолдсон нүх сүвээр олгойдно. Эцсийн бүлэгт онгоц сөнөхийнхөө өмнө дуу гарган хяхатнаад далайн усанд бүрмөсөн живж, эхлээд усан дээр өрх гарган долгиуулж дараа нь намд намдсаар толийн тэгширнэ. Ингэж тэнд байсан юм бүхэн алга болж одох бөгөөд хэдэн минутын дараа гагцхүү бурхны мэлмий л далайн ёроолоос тэрхүү алга болсон онгоцыг олж харж чадах биз. Яагаад хөлөг онгоц буудалд эргэж ирдэггүйг далайчид нь гомдол гаргадаггүйн учрыг одоо та ойлгож аваа биз гэж завины эзэн хэлэв.

Хэрвээ Гаэтано энэ бүхнийг Монте-Кристо арал дээр очин ан хийе гэж шийдэхээс өмнө ярьсан бол Франц ийм зугаалга хийх эсэхээ лав бодох байсан байх. Гэвч тэд хэдийн замдаа орсон байсан бөгөөд хэлсэн үгнээсээ буцах нь аймхай хулчгараа харуулсан хэрэг болох байлаа. Франц бол аюул заналыг эрэлхийлж явдаггүй боловч, нэгэнт тулгарахад хүрвэл айдаггүй хүмүүсийн нэг байлаа. Аюул заналыг эрүүл тулаан хийхээр өмнө нь зогсож байгаа хүнээс өөрцгүй зүйл гэж үздэг тийм хүмүүсийн нэгэн юм. Ийм хүмүүс цаад хүнийхээ хөдөлгөөнийг урьдчилан тааварлаж, хүчий нь хэмжин, амьсгаагаа дарж, тэгэхийн хамт аймхай хулчгар хүн болж харагдахгүйн тулд хэрэглэгдэх хэмжээгээр алгуур удаан хөдөлж, нэг хараад л өөрийнхөө давуутай талыг мэдэж, ганц цохиод л алчихаг юм.

- Би Сицили, Калабри арлуудаар явж, бүлэг арлуудаар хоёр удаа жуулчилсан боловч их замын дээрэмчин ба далайн дээрэмчний сүүдэртэй нь ч дайралдаагүй гэж хэлэхэд,

- Би таныг ятгах гэж энэ бүхнийг яриагүй, зөвхөн таныг асууж хайрласан болохоор л хариулсан юм даа гэж Гаэтано хариулав.

- Тийм ээ хонгор Гаэтано, таны яриа надад их сонин байна. Би цааш нь юм дуулахыг хүсэж байна, тийм ч учраас Монте-Кристо арал уруу явж байгаа юм.

Тэр завсар зорьсон газартаа түргэн дөхөж байлаа. Сэнгэнэсэн салхи үлээж байсан тул завь цагт зургаа долоон бээрийн хурдтай урагшилж байв. Завь аралд ойртох тусам арал нь тэнгисээс урган босож байх шиг байлаа. Зэвсгийн агуулахад хураасан үхэр бууны бөөрөнхий ширмэн сум шиг бие биен дээрээ овоорсон хаднууд шингэж байгаа нарны туяанд тодхон дурайж, хад хавцлын завсраар жанжуу гүйлс, хонин арц улайрч ногоорон харагдана. Далайчид хэдийгээр илт түгшихгүй боловч, далайн долгион дээр хөвөлзөн байгаа цахлай шувуу мэт харагдах ганц нэг загасчдын завины цагаан дарвуул гялалзсан далайн мандал дээгүүр хянамгай болгоомжтойгоор харна.

Наран Корс арлын цаагуур далд орж эхэлж байх үед Монте-Кристо арал хүртэл арван таван бээр хүрэхгүй ойртсон байлаа. Арлын баруун талын улс баргар том өргөс мэт оройгоо сэрвийлгэн Адамастор шиг энэ аварга том чулуунууд завины өмнө аажмаар дээшлэн өндийж, нарыг халхлан өдрийн гэгээн гэрлийг өмнөө хөөн, үдшийн бүрэнхий,

тэнгис далай дээгүүр бүрхэв. Сүүлчийн туяа шовх өндөр хаданд тусаж түүн дээр эгшин зуур тогтносноо галт уулын гал утаа манарах мэт дүрсхийгээд алга болно. Тэг тэгсээр бэл нь харанхуйд сүүдэрлэгдэхийн адил орой нь сүүдэрлэгдээд арал бүхэл бүтнээрээ аварга том чулуун хана болж хувирав. Хагас цагийн дараа хав харанхуй боллоо.

Аз болоход сэлүүрчид Тосканы олтригийг хөндлөн гулд явж сурсан улс тул замаа сайн мэдэж байв. Хэрвээ ийм биш байсан бол Франц энэ харанхуйд сэтгэл түгшин нүдээ хөхөртөл ширтэх байсан биз. Корсик алга болж Монте-Кристо арал ч харагдахаа больсон боловч, далайчид харанхуйд шар шувуу шиг харж, завиа итгэлтэйгээр жолоодон явуулна.

Нар жаргаснаас хойш нэг цаг өнгөрсний дараа завинаас зүүн тийш дөрөвний нэгэн мод хэртэй газар нэгэн бөөн юм байх шиг харагдав. Гэвч маш бүдэгхэн харагдаж байсан тул Франц далайчдын элэг доог болох вий гэж болгоомжлоод, дуугүй байх нь дээр гэж боджээ. Гэнэт эрэг дээр хурц гэрэл гарав. Газар үүл шиг харагдаж болох боловч, гал нь ямарч байсан солир биш байлаа.

- Энэ юун гал вэ? гэж Франц асуухад,
- Чимээгүй! гэж завины эзэн шивнээд - Энэ чинь түүдэг гал байна гэв.
- Та чинь энэ арал дээр хүн суудаггүй гэсэн биш бил үү?
- Би танд арал дээр байнгын оршин суугчид байхгүй, харин хориотой бараа тээн худалдагчид үүрлэдэг гэж хэлсэн шүү дээ.
- Бас, далайн дээрсмчид!
- Тийм ээ, бас далайн дээрэмчид гэж Гаэтано давтан хэлээд - Тийм ч учраас би хажуугаар нь өнгөрөөд яв гэж тушаасан юм. Гэрэл бидний ард хоцорсныг харж байгаа биз дээ гэхэд Франц,
- Энэ гал биднийг түгшүүлэн сандаргахаасаа тайвшруулах ёстой юм биш үү. Хэрвээ тэд өөрсдийгөө харчихна гэж айдаг бол гал түлэхгүй баймаар шиг санагдах юм гэв.
- Энэ ямарч хамаагүй, харанхуй байгаа болохоор та арлын байдлыг харж чадахгүй байна. Харин тиймгүй бол та эрэг дээрээс ч, Пианоз арал дээрээс ч гал харагдахгүй, зөвхөн далайн дотроос л харж болох юм гэдгийг мэдэх байсан гэж Гаэтано хэлэв.
- Тэгвэл энэ түүдэг гал базаахгүй улстай уулзахын тэмдэг үү? Гэхэд Гаэтано энэхүү газар дээрх гэрлээс нүд салгалгүй ширтэн байж,
- Одоо л мэдье гэж хэлэв.

- Аа, та яаж мэдэх юм бэ?
- Одоохон харж л бай.

Гаэтано нөхөдтэйгээ шивнэлдэн таван хувь ингэж зөвлөсний дараа завь чиглэлээ өөрчилж, чимээгүйгээр буцаж явлаа. Хэдэн хормын дараа гал харагдахгүй боллоо. Бодвол ямар нэгэн өндөрлөгийн цаана далд орсон бололтой.

Жолоо баригч залуураа эргүүлэхэд жижиг онгоц аралд мэдэгдэлгүй ойртон, удалгүй тавиадхан алхмын ойр очив.

Гаэтано дарвуулаа буулгахад завь зогсов.

Энэ бүхнийг огт чимээ аниргүй гүйцэтгэв. Түүнээс гадна завь эргэж явсан үеэс хойш хэнч юу ч дуугарсангүй.

Зугаалах санал гаргасан Гаэтано бүх хариуцлгыг өөр дээрээ авав. Дөрвөн далайчин түүнээс нүд салгалгүй ширтэн, хэрэг болбол харанхуйгаар далимдуулан зайлж одоход бэлхнээр сэлүүрээ бэлэн барьж явна.

Францын тухайд гэвэл тэр бидний мэдэх хэнэггүй байдлаараа буунуудаа үзэж суув. Тэр хоёр амтай буу хоёртой ба нэг карбин буутай байв. Тэднийгээ цэнэглэж, замгий нь шалгаж үзэд юу болохыг хүлээлээ.

Тэр завсар Гаэтано хантааз, цамцаа тайлж, шалбуур өмдөө чангалав. Харин хөл нүцгэн байсан тул гутал тайлна гэх юмгүй байлаа. Тэр ийм гоёлтойгоор үнэний нь хэлбэл нүцгэнээр, уруулаа хуруугаараа дараад ус уруу орж, өчүүхэн ч чимээ гаргалгүй эрэг уруу болгоомжтойёо хөвөн одов. Зөвхөн түүний ард хоцорсон зургар цагаан судлаар хаана яваагий нь баримжаалахаар ажээ. Гэвч, энэ судал удалгүй алга боллоо. Бодвол Гаэтано эрэгт хүрсэн бололтой.

Хагас цагийн туршид завин дээр хэн ч хөдөлсөнгүй. Дараа нь эргийн зүгээс өнөөх цагаан судал дахин харагдаад ойртон ирэв. Нэгэн хувийн дараа Гаэтано завинд хүрч ирэв.

- За юу байна? гэж Франц ба далайчид нэгэн зэрэг асуув.
- Энд испанийн хориотой бараа тээж худалдагсад мөн корсийн хоёр дээрэмчин байна.
- Корсийн дээрэмчид яагаад испанийн хориотой бараа тээж худалдагсадтай нийлчихээ вэ?

- Эй, эрхэмсэг минь гэж Гаэтано үнэхээр христос шашинтны хонгор сэтгэлээр хэлээд - Тэд чинь бие биедээ туслах хэрэгтэй шүү дээ! Дээрэмчид заримдаа хуурай газар дээр цагдаа цэргүүдээс болоод ажил хэрэг нь муу болдог. Тэгэхээр эрэг дээр очиж завь олдог, тэр завинд нь бидэн шиг сайн санаат хүмүүс байж байдаг. Тэгээд тэд нараас толгой хоргодох газар гуйна. Мөрдөгдөн хөөгдөж яваа хөөрхий амьтанд туслахгүй байж болох уу даа? Бид тэднийг завиндаа аваад үнэнч шударга ёсыг бодож далайд гардаг юм. Үүнээс бидэнд ямарч гарз учирдаггүй, харин тэр хүний амь аврагдаж эсвэл үгүй ядахдаа л эрх чөлөөтэй хоцордог юм.

Тэр үүнийхээ хариуд бидэнд тус хүргэж сониучхан хүний нүднээс далд, бараа таваараа буулгах нууцгай газар зааж өгдөг юм.

- Тэгэхээр найз минь Гаэтано минь! Та чинь хориотой бараа тээх ажил хийдэг байх нь ээ? гэж Франыг хэлэхэд, Гаэтано тийм гэж хэлэхийн аргагүй хачин инээмсэглээд,

- Одоо яая гэх вэ дээ, эрхэм минь. Юм юмаар л бага зэрэг оролдох юм, ямар нэгэн аргаар амь зуух хэрэгтэй байна шүү дээ гэж хэлэв.

- Тэгвэл энэ Монте-Кристо арал дээр байгаа хүмүүс танд огт хамаагүй улс биш шив дээ?

- Тийм байх аа. Бид масоньхантай адил бие биенээ дохиогоор л таньдаг юм.

- Бид санаа зоволгүй эрэг дээр бууж болно гэж бодож байна уу?

- Тэгж бодож байна. хориотой бараа тээж худалдагсад бол хулгайч биш шүү дээ гэхэд Франц тохиолдож болох аюулыг урьдаас болгоомжлон,

- Харин тэр корсийн дээрэмчид... гэж асуув.

- Тэд өөрсдийн буруугаар дээрэмчин болоогүй, үүнд засгийн газар л буруутай гэж Гаэтано хэлэв.

- Яагаад тэр билээ?

- Өөрөөр яах юм бэ? Засгийн газар тэднийг Корс хүн өшөөгөө авахгүй байж болох юм шиг ердөө л хүний амь бусниулсан хэргээр бариад авдаг.

- Хүний амь бусниулах гэдэгтээ та юуг хэлж байна вэ? Хүн алах уу? гэж Франц асуув.

- Дайснаа устгах гэж эзэн хариулаад - Энэ бол шал өөр хэрэг шүү дээ гэв.

- За яах вэ, тэр дээрэмчин, хориотой бараа тээгсэд дээр очиж зочлохыг хүсье л дээ, тэд биднийг хүлээн авах болов уу? гэж Франц хэлэв.

- Тэгэлгүй яахав.

- Тэд хэдүүлээ байна?

- Дөрвүүлээ, эрхэмсэг минь, бас хоёр дээрэмчин бүгд зургаан хүн байна.

- Бид ч бас төдийчинээ. Хэрвээ эрхмүүд зан муутайхан байвал, бидний хүч тэнцүү болохоор бид тэднийг дөнгөчихөж болно. Тэгэхээр одоо асуудал шийдлээ. Монте-Кристо арал уруу явъя.

- Тэгье, харин эрхэмсэг та, биднийг урьдаас сэргийлсэн зарим нэг арга хэмжээ авахыг зөвшөөрнө үү?

- Мэдээж хэрэг, хайрт нөхөр минь! Нестор шиг цэцэн мэргэн, Улисс шиг сэргэлэн байхыг ерөөе. Би зөвхөн зөвшөөрөөд зогсохгүй, үүнийг танаас онцлон хүсэх байна.

- За сайн, хэрвээ тийм бол одоо дуугүй байцгаая! Гэж Гаэтано хэлэв.

- Ингээд цөм дуугаа хураав.

Франц шиг юмыг эрүүл ухаанаар хардаг хүнд, энэ байдал нь аюултай биш гэхэд нэлээд аз туршсан эрсхэн хэрэг байлаа. Тэр их далай дотор пад харанхуйн дунд өөрт нь үнэнч шударга байх ямарч шалтгаангүй далайчидтай хамт байлаа. Тэд түүний бүсэнд хэдэн мянган франк байгааг сайн мэдэх бөгөөд, сайхан зэвсгийг нь атаархаагүй ч гэсэн сонирхсон байдалтайгаар хэдэн арван удаа харж байлаа. Түүгээр ч зогсохгүй эдгээр хүмүүсийг дагуулан үлэмж сайхан нэртэй боловч, хориотой бараа тээгсэд, дээрэмчид үүрлэн байдаг болохоор христусыг Галгофад хүлээж байсан зочлолоос илүүг горьдохын аргагүй арал дээр очих болжээ. Хөлөг онгоцыг живүүлдэг тухай өдөр нь ярихад хэтрүүлж байна гэж бодож байсан бол, одоо шөнийн харанхуйд тэр нь улам ч үнэмшилтэй санагдана. Иймэрхүү байдлаар, магадгүй тэгж санагдаж байж ч болох, хоёр давхар аюулд орсон болохоор далайчдаа нүд салгалгүй ажиглан, гараасаа буугаа үл салгана.

Тэр завсар далайчид дарвуулаа дахин татаж, урьд хоёр удаа явсан замдаа оров. Францын нүд харанхуйд бага зэрэг дасаж амжсан тул завиа аварга том боржин чулуун хадны хажуугаар явж байгааг ялган танив. Тэгээд цохиог тойрч гарвал урьдахаасаа улам хурцаар асаж байгаа түүдэг гал, түүнийг тойрсон хэдэн хүнийг харлаа.

Галын туяа нь далайд зуугаад алхам хиртэй хол тусна. Гаэтано завиа гэрэлд оруулчихгүйг хичээн, гэрэлтүүлэгдсэн хэсгийг өнгөрөн гарав. Дараа нь түүдэг галыг яг эсрэг талд очоод гал уруу эгц явж гэрэлтүүлэгдсэн газарт ороод, загасчдын дууг чангаар аялан эхлэхэд далайчид ч тэр дор нь даган түрлээ.

Дууны ая сонсонгуут түүдэг гал тойрон суусан хүмүүс босож, эрэг уруу ойртон бодвол хэмжээ ба ямар зорилготой явааг нь мэдэх гэсэн бололтой завийг харна. Удалгүй харж ханасан бололтой эрэг дээр үлдсэн нэгээс бусад нь бүтэн янзага шарж байсан гал уруугаа буцав.

Завь эрэгт хориодхон алхам дөхөж очиход эрэг дээр зогсож байсан хүн, манаач эргүүлтэйгээ дайралдахаар тэгдэг шиг буугаа мөрнөөсөө авч сардин аялгуугаар

- Хэн бэ? Гэж асуув.

Франц сандралгүй хоёр бууныхаа замгийг хоёуланг нь татав.

Гаэтано тэр хүнтэй хэдэн үг солиход, Франц хэдийгээр өөрий нь тухай ярьж байсан боловч ганц ч үг ойлгосонгүй.

- Эрхэмсэг та нэрээ хэлэх үү, эсвэл нуух уу? гэж Гаэтано асуув.

- Миний нэрмийг хэлээд ямарч нэмэргүй. Тэгэхээр зүгээр л жуулчилж яваа франц хүн гэж хэл л дээ гэж Франц хариулав.

Гаэтано энэ хариуг дамжуулан хэлэхэд зогсож байсан манаач түүдэг галын дэргэд сууж байсан хүмүүсийн нэгэнд тушаал өгөхөд, цаадах нь босож хоёр цохио хадны хоорондуур орж алга болов.

Бүгд дуугүй байлаа. Хүн бүр л өөр өөрийнхөө ажил явдлаар оролдон байлаа. Франц арал дээр буухад бэлтгэн, далайчид дарвуулаа, хориотой бараа тээгсэд янзагаараа оролдон байв. Тэд ингэж гаднаа хайнга хайхрамжгүй байдалтай байсан мэт боловч бие биеэ сэм ажиглана.

Явсан хүн эргэж ирлээ. Харин тэгэхдээ явсан зүгээсээ биш, нөгөө талаас хүрч ирэв. Манаачид толгой доховол, цаадах нь завь уруу эргэж,

- S assomodi гэв.

Италийн энэ үг бол орчуулагддаггүй үг байгаа юм. Энэ үг бол «Морилон орно уу, орохыг хүсье, гэртээ байгаа юм шиг бай, та энд эзэн нь» гэсэн олон утгыг нэгэн доор илэрхийлнэ. Энэ бол язгууртны доторх бэртэгчиг олон утгатайгаар ихэд гайхуулсан Мольерын түрэг үг шиг юм.

Далайчид дахин гуйлгасангүй. Сэлүүрээ дөрвөнтөө татахад завь эрэгт тулав. Гаэтано эрэг дээр үсрэн буугаад манаачтай бас хэдэн үг шивнэн ярилцав. Далайчид нэг нэгээрээ цувран эрэг дээр бууж эцэс сүүлд нь Францын ээлж боллоо.

Тэр нэг буугаа мөрөвчилсэн бөгөөд нөгөө буу нь Гаэтанод байлаа. Нэг далайчин карабин бууг нь үүрч явав. Франц зураач хүн шиг хайнга боловч гангачуулын маягаар гоё хувцасласан байлаа. Энэ нь арлын эздэд ямарч сэжиг төрүүлээгүй бөгөөд тийм учраас ч айн болгоомжлох сэтгэл төрсөнгүй.

Завиа эргээс уяж орхиод,буудаллах тохитой газар эрэхээр явцгаав. Тэдний буудаллахыг ажиглан харж байсан хориотой бараа тээгчдийн санаанд явж байгаа чиг нь таараагүй бололтой Гаэтанод,

- Үгүй, тийшээ бүү яв! Гэж хашхирав.

Гаэтано аман дотороо бувтнан уучлалт гуйгаад, маргасан ч үгүй нөгөө тал уруу явав. Тэр завсар хоёр далайчин түүдэг галаас бамбар асаалаа.

Тэд гучаад алхам яваад, суугаагаараа харж манаж болохоор хады нь ухаж суудал гаргасан хавтгай талбайд хүрч очив. Эргэн тойронд нь байгаа үржил шимтэй нарийн зурвас газарт тарваган царс, жанжуу гүйлсийн бут ургажээ. Франц бамбараа доошлуулж бөөн үнс нурам байхыг хараад, энэ газрын тааламжтайг өөрөө анх үнэлэн үзэж байгаа биш Монте-Кристо арал дээр ирж очин байдаг улсын ердийн буудаллах газар болохыг мэдэв.

Ер бусын явдал болно гэж бодохоо больжээ. Эрэг дэSp хөл гишгэмэгц, эздийнх нь найрсаг биш ч гэсэн хайхрамжгүй байгаа байдлыг хараад, түгшсэн сэтгэл нь тайвширч, лүүдэг гал дээр шарж байгаа янзаганы үнэр өлсгөлөн байгаагий нь мэдүүлэв.

Үүнээ Гаэтанод хэлэхэд, цаадах нь завин дотор талх, дарс зургаан ятуу байгаа ба галтай болсон болохоор үдшийн хоол идэх гэдэг бол маш амархан хэрэг гэж хариулснаа, - Харин эрхэмсэг танд шарсан янзага сайхан санагдаад байвал, би хөршийнхөндөө хоёр ятуу өгөөд, хэсэг шарсан мах сольж авъя л даа гэж нэмж хэлэв.

- Маш сайхан хэрэг. Гаэтано маш сайн хэрэг гэж Франц хэлээд - Та чинь хэлэлцээ хийх авъяастай төрсөн хүн юм гэв.

Тэр завсар далайчид хонин арц, жанжуу, гүйлс, царсны мөчир хугалж дориун том түүдэг ноцоов.

Франц шарсан янзаганы үнэрийг үнэрлэн, Гаэтаног буцаж ирэхийг хүлээж ядан байтал цаадах нь үлэмж санааширсан байдалтай хүрч ирэхэд нь,

- За юу байна? Зөвшөөрөхгүй байна уу? гэж асуухад Гаэтаног,

- Үгүй, тэдний тэргүүн нь таныг франц хүн гэж дуулаад оройн зоогоо хамт зооглохыг урьж байна гэнэ гэж хариулав.

- Их найрсаг зантай хүн юм. Би өөрийн хувийг нэмэрлэх болохоор үүнээс татгалзах шалтгаангүй гэж үзэж байна гэж Франц хэлэв.

- Хэрэг явдал үүнд биш. Түүнд оройн хоолны юм бий, байхаар ч барахгүй хэтэрхий их бий. Харин таныг нэг хачин болзол тавьж байж гэртээ хүлээж авах гэнэ.

- Гэртээ хүлээж авах ий? Бүр өөртөө гэр бариад авчихсан хүн үү? Гэж Франц асуув.

- Үгүй дээ, Гэвч түүнд маш тохитой сууц бий гэнэ, үгүй дээ л тэгэж батлаад байдаг юм.

- Та тэр толгойлогчийг нь ланих уу?

- Түүний тухай дуулсан.

- Сайнаар уу, муугаар уу?

- Аль алинаар нь л

- Чөтгөр ав. Ямар болзол юм бол?

- Нүдээ боолгоод, ав гэхээр нь боолтоо авах юм гэнэ.

Франц энэ урилгын цаана чухам юу нуугдаж байгааг мэдэх гэж Гаэтаногийн нүд руу харав. Цаадах нь Францийн бодож байгааг тааварлаад,

- Тийм ээ, тийм би ч бас эргэцүүлэн бодох хэрэгтэй гэдгийг ойлгож л байна гэв.

- Та миний оронд байсан бол яах байсан бэ?

- Надаас ямар ч гарз гарахгүй болохоор би очно.

- Та тэр урилгыг хүлээж авах нь ээ.

- Тэгнэ, үгүй дээ л сонирхоод очно.

- Түүнд үзчихмээр сонин юм байгаа юм уу? гэхэд Гаэтано дуугаа нам болгож,

- Сонсож бай та. Үнэн худлыг бүү мэд, улсууд л ярилцах юм... гээд тэр тэдний яриаг хүн чагнаж байна уу гэсэн янзтай ийш тийшээ харахад Франц,

- Юу гэж ярицгааж байна? гэж асуув.

- Тэр дэргэд нь Питтийн ордон 1 ч юу ч биш, тийм газар доорх ордонд суудаг гэж ярилцах юм.

- Та зүүдэлж байна уу? гэж Франц суунгаа асуухад, Гаэтано,

- Үгүй, зүүдлээгүй. Энэ бол яг үнэн юм шүү. «Гэгээн Фердинандын» жолоо баригч Кама нэг удаа тэд ороод толгой нь эргэчихээд гарч ирсэн. Тийм их баялаг эрдэнэс зөвхөн үлгэрт л байдаг байх гэж хэлж байсан.

- Үгүй ер! Та ийм үг хэлж, намайг Али-Бабын агуй уруу оруулах гэж байгаагаа мэдэж байна уу?

- Эрхэмсэг танд би дуулсанаа л хэлж байгаа минь энэ.

- Тэгээд та намайг зөвшөөр гСж зөвлөж байна уу?

- Би тэгж хэлээгүй. Эрхэмсэг та дураараа л бол. Ийм явдалд зөвлөгөө өгч зүрхлэхгүй байна.

Франц бага зэрэг бодож байснаа, тийм баян хүн өөрийнх нь хэдхэн мянган франкийн хойноос хөөцөлдөхгүй байлгүй гэж шийдээд зөвхөн сайхан хоол идэхийг бодлоо. Гаэтано түүний хариуг дамжуулан хэлэхээр явав.

Бидний дээр хэлсэнчлэн Франц болгоомжтой хүн байсан болохоор хачин нууц эзний тухай их юм мэдэхийг хүсэж байв. Тэгээд өөрийг нь Гаэтантой ярьж байхад, үүрэгт ажлаараа бахархан байдаг хүний ёсоор ятууны өдийг их л додигор зулгааж суугаа далайчин уруу эргэж, энд ямар ч завь, онгоц байхгүй байхад эдгээр хүмүүс юугаар явж ирсэн юм болгэж асуухад,

- Би тэдний хөлөг онгоцыг мэддэг болохоор гайхахгүй байна гэж далайчин хариулав.

- Сайн онгоц уу?

- Эрхэмсэг та дэлхийг тойрвол тийм л онгоцоор явахыг хүсье.

- Тэгээд, том онгоц уу?

- Томоо, зуун тоннын онгоц, англичуудын хэлдгээр, даруулт онгоц гэдэг боловч агаар, тэнгэр ямар ч муухай байхад эвдрэхгүй бөх эд дээ.

- Хаана хийсэн юм бол?

- Мэдэхгүй, Генуяд хийсэн байлгүй дээ.

- Яахаараа хориотой бараа тээгсдийн тэргүүн Генуяд хөлөг онгоц захиж хийлгэхээсээ айхгүй байдаг билээ? Гэж Францыг асуухад,

- Онгоцны эзнийг хориотой бараа тээдэг гэж би хэлээгүйсэн билээ гэж далайчин хариулав.

- Үгүй, Гаэтано тэгэж хэлэх шиг болсон шүү дээ

- Гаэтано тэднийг холоос харсан болохоос биш, хэнтэй юу ч яриагүй юм шүү дээ.

- Тэгээд тэр хүн чинь хориотой бараа тээгсдийн толгойлогч биш юм бол өөр юу байдаг билээ?

- Жуулчлан цэнгэж яваа, баян язгууртан

«Хүн бүр өөр өөрөө ярьж байгаа болохоор маш битүүлэг хүн юм аа» гэж Франц бодлоо.

- Ингэхэд нэрийг нь хэн гэдэг юм бэ?

- Өөрөөс нь асуухаар, Синдбад-Далайчин гэдэг юм. Гэвч жинхэнэ нэр нь гэдэгт би эргэлзэж байна.

- Синдбад-далайчин гэнэ ээ?

- Тийм ээ

- Энэ эрхэмсэг дээдэс чинь хаана суудаг юм бэ?

- Далай дээр

- Хаанаас ирсэн хүн бэ?

- Мэдэхгүй

- Та түүнийг ер нь харсан уу?

- Харсан

- Ямаршуухан хүн байна?

- Эрхэмсэг та өөрөө үзнэ

- Намайг хаана хүлээж авах бол?

- Гаэтаногийн танд ярьсан газар доорх ордондоо хүлээж авна гэж бодож байх хэрэгтэй.

- Та тэр илбийн шидэт цайзад нь орох гэж хэзээ ч оролдоогүй юу?

- Эрхэмсэг минь, үзэхээр барах уу, нэг биш удаа оролдсон, гэвч ямар ч ашиг гараагүй. Бид бүх агуйг нэгжээд нэг ч нүх сүв олоогүй. Тэгээд ч үүд нь түлхүүрээр биш, илбийн үгээр онгойдог гэж ярьцгаах юм билээ.

- Би лав «мянга нэгэн шөнийн» үлгэртэй тохиодсон байх нь ээ гэж Франц хэлэв.

- Эрхэмсэг дээдэс таныг хүлээж байна гэж ар талд нь хүн дуугарахад манаачийг мөн байна гэж дуугаар нь танив.

Түүнийг дарвуулт онгоцны хоёр далайчин дагажээ.

Франц хариу хэлэхийг оронд хармаанаасаа нусныхаа алчуурыг гаргаж манаачид өгөв.

Түүний нүдийг үг дуу ч үгүй боож, залилж магадгүй гэж болгоомжлон нарийвлан шалгаж үзээд, боолтоо авах гэж хэрхэвч оролдохгүй гэж ам тангаргийг нь авав.

Франц ам өглөө.

Тэгэнгүүт далайчид түүнийг сугадан авч, манаач өмнө нь гарч явав.

Тэр гучаад алхам яваад, хорхой хөдөлгөсөн үнэрээр нь буудалласан газрын хажуугаар явж байгааг мэдэв. Дараа нь, өнөөх Гаэтаног явахыг хориглож байсан зүг уруу боллолтой тавь шахам алхам явлаа. Одоо тэгэж хориглосны нь учрыг ойлгов. Удалгүй агаар өөрчлөгдсөн учир газар доогуур оржээ гэдгийг Франц мэдлээ. Тэгээд хэдэн хором өнгөрсний дараа шаржигнах хөнгөн чимээ сонстоод сайхан зөөлөн агаар үлээв. Эцэст нь зөөлхөн хөвсгөр хивсэн дээгүүр явж байхыг мэдрэв. Замчилж явсан хүмүүс түүний гарыг тавив. Чимээ аниргүй болж байснаа, нэгэн хүн мадаггүй сайхан боловч гадаадын аялгуутай франц хэлээр

- Өршөөн соёрхоно уу, та одоо боолтоо авч болно гэв.

Франц хоёр дахиа гуйлгаагүй нь мэдээж хэрэг. Нүд боосон алчуураа авч, тунисс маягаар өөрөө хэлбэл хөх өдтэй улаан малгайтай, энд тэндгүй алтан саа хадсан цэмбэн хантаазтай, хурц улаан өнгийн шалбуур өмдтэй, мөн тийм өнгийн алтан саа хадсан шилбэ барьсан саланги түрийтэй шар шаахай өмссөн дөч орчим насны хүн зогсож байхыг харав. Өргөн кашмир ороолт бүсэлж, жижигхэн махир чинжаал хавчуулжээ.

Царай нь үхээрийн юм шиг цонхигор боловч гоо үзэсгэлэнтэй ажээ. Нүд нь хурц сэргэлэн бараг духтайгаа тэгшхэн хамрын нь хянга нь цэвэр грег маягийг санагдуулна. Давирхай шиг гялтганасан хар сахлаар эмжигдсэн дун цагаан шүд ь нүд гялбан гялалзна.

Энэ хүний цонхигор царай нь угийн биш бөгөөд олон жил булшинд байсан юм шиг амьдралын улаа бутарсан өнгөө дахин хэзээ ч олохгүй гэлтэй харагдана. Тийм ч өндөр биш авч, чийрэг сайхан биетэй өмнөд нутгийн хүмүүсийнх шиг жижигхэн гар хөлтэй ажээ.

Гаэтаногийн ярьсныг үлгэр домог гэж үзэж байсан Францад эндхийн тавилгын гоё сайхан нь бүхнээс илүү гайхах сэтгэл төрүүлэв.

Бүх тасалгааг алтан цэцэг шаглаж оёсон түргийн улаан торгоор бүржээ. Мухарт нь өргөн буйдан байх бөгөөд дээр нь алтан хуйтай үнэт чулуу шигтгэсэн бариултай араб зэвсэг өлгөөтэй байлаа. Венецийн шилээр хийсэн гоёмсог дэнлүү таазнаас өлгөөтэй, хөл түргийн зөөлөн хивсэн дээр гишгэлнэ. Францын орсон хаалга нь хөшгөөр хаалттай бөгөөд мөн хурц гэрэлтэй зэргэлдээ өрөөнд ордог хаалга ч гэсэн хөшигтэй байв.

Францын гайхан сонирхоход гэрийн эзэн саад бололгүй, харцыг нь харцаар хариулж түүнээс нүд үл салгана. Тэгснээ,

- Өршөөлт эрхэм минь, таныг тэгж болгоомжлон над дээр авчирсан явдалд уучлахыг хүсье. Энэ арал ихэнх дээ хүн амьтангүй байдаг болохоор, хэрвээ ямар нэг хүн оромжийн минь нууцыг мэдчихвэл би буцаж ирэхдээ өөрийнхөө сууцыг нэлээд эвгүй байдалтай болчихсон байхыг үзэхэд хүрвэл надад үлэмж зэвүүн санагдана. Тэгэхдээ гарсан газрын тухай бодож гунихрахгүй, харин ганцаараа байх бололцоогүй болчихсондоо л гунихрах болно. Харин одоо би энэ өчүүхэн эвгүй явдлыг мартагдуулахын тулд, танд эндээс олдоно гэж бодоогүй сайхан оройн хоол, тааламжтай ор дэр өгье гэв.

- Өршөөгөөрөй, Юун уучлал билээ? Илбэт цайзуудын босго алхаж байгаа хүн бүрийн нүдийг боодог гэдгийг бүхэн мэднэ. Гугенотын Раулийг сана л даа. Үнэндээ, би танд гомдол гаргах ёсгүй. Таны надад үзүүлж байгаа бүх зүйл чинь «Мянга нэгэн шөнийн» үлгэрийн гайхамшигтай адил юм.

- Үгүй ер! Би танд Лукулл шиг хэлье. Таныг над дээр морилон ирэхийг мэдсэн сэн бол би бэлтгэх байсан юмсан. Гэвч миний энэ өчүүхэн байр таны мэдэлд байна. Миний тавьж байгаа оройн зууш хэдий тааруухан боловч амсаж хайрлаыг хүсье. Али ширээ зассан уу?

Тэр дороо хаалганы хөшиг нээгдэж, эбеновын мод шиг тас хар, биеэ барьсан цагаан дээл өмссөн нуби хүн эзнээ зоогийн өрөөнд орохыг урьж дохив.

- Та надтай санал нийлэх эсэхийг мэдэхгүй байна гэж үл таних хүн Францад хэлээд -Бүтэн цагаар бие биеэ харж, ширээний хоёр талд суучихаад ярилцаж суугаа хүнээ

хэн гэж өргөмжлөн дуудахыг мэдэхгүй байхаас өөр тэсвэрлэшгүй юм байдаггүй юм шиг надад санагддаг юм. Харин хүндэтгэл зочлолын ёсыг бодож би таны нэр ус, алдар цолыг асуухгүй ганцхан тантай, хэн гэж харьцвал зохихыг мэдмээр байна. Намайг бол Синдбад-далайчин гэж дууддаг юм гэдгийг би танд асуулгалгүй хэлчихье гэв.

- Би өнөөдөр Аладин болоход, гайхамшигт дэнлүү л дутаж байна. Тийм болохоор Аладин гэж нэрлүүлэхэд саад тотгор болох ямарч зүйл алга гэж үзэж байна. Тэгэхээр намайг ямар нэгэн үл үзэгдэх ариун сүнс нааш нь авчирсан, дорнодын энэ хаант улсдаа үлдье гэж Франц хариулав.

- За тэгвэл, найрсаг Аладин гэж нөгөө жигтэй эзэн хэлээд - Оройн зоог бэлэн гэж хэлснийг та дуулсан, иймээс таныг зоогийн өрөөнд орохыг гуйя. Таны дуулгаварт зарц, танд зам зааж өгөхийн тулд өмнө тань явъя гэв.

Тэгээд Синдбад хөшгөө өргөж, зочныхоо урд орж явав.

Францын гайхаж шагсрах нь улам нэмэгджээ. Хоолны ширээ нь тун гоц сайхан засагджээ. Энэ чухал нөхцөл байдлыг үзэж үнэмшээд, эргэн тойрныг харж эхлэв. Зоогийн өрөө нь дөнгөж сая гарч ирсэн зочны өрөөнөөс дутах юмгүй хээнцэр сайхан байлаа. Эрт цагийн үнэт барималтай гантиг чулуугаар хийгджээ. Гонзгойвтор өрөөний хоёр талын буланд толгой дээрээ сагс тавьсан хоёр сайхан баримал байлаа. Сагсан дотор нь хамгийн ховор нандин үр жимс болох, сицилийн хан боргоцой, малагийн анир, балеарын жүрж, францын тоор, туниссын нанжин чавгыг шовойлгон өржээ.

Оройн зоог нь корсийн хөндийг тойруулан тавьсан шарсан гургуул, шүүстэй зэрлэг гахайн хирс, татарын сүмстэй шарсан янзага, амтлаг сайхан хальпин загас аварга том далайн хавч байв. Том тавгуудын хоорондуур зууштай дийзнүүд тавьжээ. Дийзнүүд нь мөнгө бөгөөд тавагнууд нь япон шаазан байлаа.

Франц нүдээ арчив. Энэ бүхэн зүүд зэрэглээ шиг санагджээ.

Али ганцаараа үйлчлэх бөгөөд өөрийн үүргийг маш сайн гүйцэтгэнэ. Зочин түүнийг магтав.

Тэгэхэд эзэн нь Францыг зочлох зуураа дээдсийн хайнга байдлаар,

Тийм ээ, энэ хөөрхий амьтан надад маш үнэнч, маш хичээнгүй байдаг юм. Амиа аварсныг санаж явдаг юм. Толгойдоо хайртай байсан болоод, түүнийг нь үлдээж өгсний ачийг хариулж байгаа бололтой гэж хариулав.

Тэгэхэд Али эзэн уруугаа дөхөж очоод гарыг нь авч үнэсэв.

- Та энэ буянт үйлээ ямар нөхцөл байдлын дунд хийснийг тань асуувал миний зүгээс даруу биш зан гаргасан хэрэг болох биз? Гэж Франц асуухад,

- Энэ амархан хэрэг. Энэ зальтай гайхал Туниссийн ноёны ордны ойролцоо, хар арьстан хүн явж болохгүй газраар явчихаж л дээ. Тэгэхээр нь ноён түүнийг барьж аваад хэл, гар, толгойг нь ав гэж тушаажээ. Анхны өдөр хэлийг нь, маргааш нь гарыг нь, нөгөөдөр нь толгойгийг нь авах байлаа. Би хэлгүй зарцтай байх юмсан гэж боддог болохоор хэлийг нь огтолж авахыг хүлээж байгаад, ноёнд очиж хоёр амтай буугаар сольж авъя гэж хэлэв. Тэр буу эзэн дээдэст таалагдаж байхыг би урьд өдөр нь мэдсэн юм. Тэр энэ муу золгүй амьтныг тонилгох гэж ихэд хүсэж байсан учир нэлээд түдгэлзсэн юм. Гэвч би эзэн дээдсийн түрэг махир хутгыг нь тас огтолсон англи анчны хутга дээр нь нэмлээ. Тэгэхэд ноён энэ хөөрхий амьтныг гар толгойтой үлдэхийг нь зөвшөөрч, тэгэхдээ туниссийн нутаг дээр дахин гишгүүлэхгүй гэж болзоо тавьж тохирсон юм. Ингэж захих нь илүү ажил байжээ. Энэ золгүй амьтан Африкийн эргийг холоос ч гэсэн харвал онгоцны хамгийн холын булад очиж нуугдан ертөнцийн гурав дахь тивийг өнгөрөн явахаас цааш тэндээсээ яагаад ч гарч ирдэггүй юм.

Эзний ярьсан энэ хатуу ширүүн энэрэлт сэтгэлийг юу гэж тайлбарлахаа Франц мэдэхгүй бодлого боллоо. Тэгээд яриагаа өөрчлөхийн тулд,

- Та нэрийг нь хэрэглэж яваа тэрхүү сайн санаат далайчин шиг амьдралаа жуулчлалаар өнгөрүүлж яваа хүн юм аа даа? Гэхэд,

- Тийм ээ, энэ бол урьд нэгэн цагт, үүнийг биелүүлж хэрэгжүүлж чадах бололцоо гарна гэж бодоогүй явсан үедээ андгайлсан тангараг байгаа юм гэж үл таних хүн инээмсэглэн хариулаад - Би бас хэдэн тангараг тавьсан хүн, цагийг нь ирэхээр тэднийгээ ч гүйцэтгэнэ гэж горьддог юм.

Синдбад эдгээр үгийг маш их хайхрамжгүй хэлсэн боловч хатуу ширүүнээр үзэн ядах явдал харцанд нь илэрнэ.

- Та их зовсон хүн юмаа даа? Гэж Франц асуучихлаа.

Синдбад татвас хийж түүн өөд ширтэн харснаа,

- Та юунаас болж ингэж бодов гэж асуув.

- Юм бүхнээс гэж Франц хариулаад - Таны дуу, харц, цонхигор царай, таны байгаа амьдрал тань цөмөөрөө гэв.

- Би юу? Би орчлон дээр байж болох хамгийн жаргалтай сайхан амьдрал, пашийн амьдралаар л амьдарч байгаа хүн. Би бол энэ ертөнцийн эзэн. Ямар нэгэн газар сайхан санагдвал, би тэндээ байдаг. Хэрвээ тэндээсээ уйдчихвал яваад л өгдөг. Би шувуу шиг л эрх чөлөөтэй хүн дээ. Би шувуу шиг далавчтай. Намайг хүрээлэн байгаа хүмүүс анхны дохиогоор л миний захирсныг гүйцэтгэдэг. Би заримдаа хүмүүсийн үнэн шударгыг шүүхээр, даажигнан тэдний эрж байг а дээрэмчин, мөрдөж байгаа хэрэгтэнг нь булаан авч

зугаацдаг юм. Түүнээс гадна надад өөрт минь үнэн шударгын шүүх бий. Үүнд бүх зүйл анги бий, зэмлэх хэлтрүүлэх явдлыг элдэв ёс, журам гэлгүй гүйцэтгэдэг юм. Түүнд хэн ч оролцох эрхгүй. Хэрвээ та миний амьдралаас амсаж үзсэн сэн бол өөрөөр байхыг хүсэх ч үгүй энэ ертөнцөд дахин ямар нэг нандин бодлоо биелүүлэх гэж л биш бол хэзээ ч буцаж ирэхгүй сэн.

- Жишээлбэл өшөө авах уу? гэж Франц хэлэв.

Тэгэхэд танихгүй хүн, хүний оюун санаа, зүрх сэтгэлд нэвтрэн ордог тэрхүү харцаар Францыг харав.

- Яагаад заавал өшөө авах байдаг билээ? Гэж асуув.

- Яагаад гэвэл, та нийгэмд хөөгдөн шахагдаж, тэдэнтэй аймшигт тооцоо хийх гэж бэлтгэж байгаа хүн шиг надад санагдлаа гэж Франц өөдөөс нь хэлэхэд Синдбад,

- Та эндүүрч байна гэж хэлээд цагаан шүдээ яралзуулан хачин инээдээр инээгээд - Би бол нэг ёсны нигүүлсэн тэтгэгч хүн, хожим нэгэн цагт Парист очиж эрхэм Аппер болон Хөх цувтай хүнтэй өрсөлдөж магадгүй шүү гэв.

- Энэ таны Парист очих анхны аялал болох уу?

- Тийм ээ! Би тийм их сониуч биш байгаа биз. Би түүнд буруутай биш гэдгийг хэлье. Цаг нь болохоор аялна.

- Тэгэд та Парис уруу удахгүй явах уу?

- Би өөрөө мэдэхгүй байна, цаг үеийн байдлаас л болно.

- Би таныг очиход тэнд байж Монте-Кристо арал дээр таны ийнхүү элбэг дэлбэгээр зочилсны хариуд чадах чинээгээрээ үйлчлэхийг хүсэж байна.

- Би таны урилгыг их л баяртай хүлээн авах байсан сан. Гэвч би Парис орвол хэнд ч мэдэгдэхгүйгээр очих минь харамсалтай байна.

Тэр завсар зоог үргэлжлэн байв. Үл таних хүн санаандгүй ирсэн зочинд тавьсан энэ сайхан хоолонд хуруу хүрэх төдий болсон тул, энэ хоол ганцхан л Францад зориулж тавьсан мэт байлаа.

Эцэст нь Али амттан буюу өөрөөр хэлбэл баримал дээр байсан сагстай жимсийг буулгаж ирэв.

Сагснуудын хооронд тагтай алтан аяга авчирч тавив.

Али энэ аягатай юмыг хүндэтгэн авчирч тавьсан нь Францын сониуч занг хөдөлгөжээ. Тагийг нь авч харвал, урьд нь огт үзээгүй харахад шербет хэмээх сэрүүцүүлэх ундаатай төсөөтэй, ногоовтор өнгийн зунгааралдсан юм байлаа.

Франц учрыг ололгүй гайхан буцааж таглаад, эзэн өөд харвал цаадах нь дооглосон маягтай инээвхийлж байв.

- Та энэ аяган дотор байгаа юмыг юу болохыг нь тааварлаж чадахгүй, мэдэх юмсан гэж хорхой тань хүрч байна уу?

- Тийм ээ, үнэн шүү.

- Энэ ногоон шербет бол Геба, Юпитерийн ширээн дээр тавьж өгсөн амврози байгаа юм.

Гэхдээ энэ амврози хүний гарт орж ирээд тэнгэрийнхээ нэрийг орхиж газрын нэртэй болоогүй юм уу? Миний төдийлөн таалахгүй байгаа энэ зүйлийг, хүний хэлээр юу гэж нэрлэдэг юм бол?

- Манай материализмын маргашгүй нотолгоо гэдэг ёстой энэ байна даа! Гэж Синдбад дуу алдаад - Бид аз жаргалаа ажиглан мэдэхгүй, түүнийг харахгүйгээр хажуугаар нь хэчнээн олон удаа өнгөрнө вэ? Түүн өөд харлаа ч гэсэн олж танихгүй байна. Хэрэв та томоотой, тэгээд шүтээн тань алт байдаг бол энэ шербетээс амс л даа таны өмнө Перугийн, Гузертийн, Голкондын алтны уурхай нээгдэнэ. Хэрвээ та дүрслэн бодогч, яруу найрагч хүн бол үүнээс амсмагц бололцоогүй юм гэж байхгүй болж, таны өмнө хязгааргүй өргөн тал нээгдэж, таны зүрх сэтгэл, хүсэл мөрөөдөл чөлөөтэй болж мөрөөдлийн эцэс төгсгөлгүй хязгаарт халин нисэх болно. Хэрвээ та нэр төрд дуртай, огрчлонгийн сүр хүчний төлөө хөөцөлддөг хүн бол үүнээс идээд, нэг цаг болмогц л та европ тивийн өчүүхэн жижиг Англи, Франц, Испани мэтийн эзэн бус харин орчлонгийн эзэн, хорвоо ертөнцийн эзэн болчихно. Таны хаан суудал Сатана Иисусийг аваачиж өргөсөн тэр өндөрлөг дээр байж, түүнд сөхрөлгүйгээр түүний хумсыг үнэсэлгүйгээр бүх дэлхий дээрх хаант улсуудыг захиран суух болно. Энэ маш сонин тэгээд ч бас үүнд хүрэлцэхүйц байна... хараач гэв.

Энэ үгийг хэлээд алтан шаргал аяганы тагийг авч кофе цайны халбагаар шидэт шербетээс хутган авч амандаа хийгээд, нүдээ дутуу аньж толгойгоо гэдийлгэн байгаад алгуурхан залгив.

Франц өөрийн эзнийг дуртай амттанаа амтархахад нь саад болсонгүй. Тэгээд түүнийг бага зэрэг ухаан ороход нь,

- Энэ шидэт зүйл тань юу гээч вэ? гэж асуув.

- Та Уулын өвгөн гэдгийн тухай дуулсан уу? гэж эзэн асуугаад - Филипп Августыг алах гэсэн тэр хүний тухай дуулсан уу? Гэв.

- Дуулалгүй яахав.

- Уулынхаа хормойд үзэсгэлэнт сайхан хөндийлэй байсан бөгөөд тэндээ Хасан-Иби-Сабб сайхан цэцэрлэг ургуулж тэнд нь зэлүүд сэрүүн асартай байсныг та мэднэ шүү дээ. Тэр сэрүүн асартаа онцолж авсан хүмүүсээ урьж авчран, тэднийг Марко Пологийн хэлснээр бол үргэлж цэцэглэж байдаг ургамал, үргэлж болсон жимс, мөнх залуугаараа байдаг охидуудтай газарт хүргэж аваачдаг тийм өвсөөр зочилдог байжээ. Эдгээр зол жаргалтай хөвгүүд үнэн гэж бодож байсан зүйл нь зөвхөн хүсэл мөрөөдөл байсан юм. Тэгэхдээ энэ хүсэл мөрөөдөл нь түүнийг бэлэглэн өгсөн хүнд сэтгэл оюун, бие цогцсоо худалдахаар тийм амттай тайвшруулагч тийм их шуналтай хүсэл мөрөөдөл бөгөөд тэд түүнд, бурханд захирагдаж байгаа юм шиг захирагдаж зааж өгсөн хүний нь алахаар ертөнцийн хязгаарт ч хүртэл явж, үхлийг зөвхөн тэр сайхан амьдралд шилжиж байгаа шилжилт төдийхнөөр үзэж, сэтгэл зоволгүй аймшигтайгаар үздэг байжээ.

- Тэгвэл энэ чинь гашиш уу? гэж Франц дуу алдан асуугаад - Би үүний тухай сонссон юм байна гэв.

- Тийм ээ найрсаг Аладин, энэ бол хамгийн сайхан, хамгийн цэвэр александрийн гашиш байгаа юм. «Хүн төрөлхтөнд аз жаргалыг худалдагчид» гэж бичсэн бичигтэй ордон барьж өгвөл зохилтой зүйрлэшгүй их хүн Аbugораас авсан юм.

- Би таны магтаж байгаа зүйлийг биеэрээ амсаж итгэхийг хүсэж байна гэж Франц хэлэв.

- Өөрөө л мэд хүндэт зочин минь өөрөө л мэд, харин эхний туршлага дээрээ бүү зогсоорой. Сэрлийг зөөлөн, ширүүн, уйтгартай, баяртай гэх зэргийн шинэ сэтгэгдэл бүрт дасгаж байх хэрэгтэй. Энэ тэнгэрлэг өвс аз жаргалын төлөө бүтээгдсэн биш, зовлон зүдүүрээс зууралдан байх учир байгаль энэхүү ургамалтай тэмцэж байдаг юм. Энэ тулалдаанд байгаль ялагдан унаж, хүсэл мөрөөдлийн хойноос үнэн бодит зүйл дагалдан ирдэг болох хэрэгтэй юм. Тэгэхэд л хүсэл мөрөөдөл дийлж, хүсэл мөрөөдөл нь амьдрал болон, амьдрал нь хүсэл мөрөөдөл болно. Энэ өөрчлөлт хэчнээн олон янз гээч! Жинхэнэ амьдралын уйтгар гунигийг хүсэл мөрөөдлийн амьдралын баясалтай зэрэгцүүлэн, та амьдралаас нүүр буруулан үүрдийн хүсэл мөрөөдөлд автах болно. Тэгээд та өөрийн ертөнцийг, бусдын ертөнцийн тулд орхих үед неаполитаны хаврыг лапландын өвлөөр сольж, диваажингаас газарт бууж, тэнгэрээс тамд орсон мэт санагдах болно. Амсаад үз, хүндэт зочин минь гашиш амсаад үз.

Франц хариу хэлэхийн оронд халбагаа авч гайхамшигт шербетээс эзний л авсан хэмжээгэр хутгаж амандаа хийгээд, бурхны идээг залгисны дараа,

- Чөтгөр ав! Дараа нь ямар сайхан болохыг бүү мэд, таны хэлсэн шиг тийм амттай юм биш байна гэж хэлэв.

- Таны тагнай ер бишийн амьтанд дасаагүй болоод тэгж байгаа юм. Таны сүүлд нь учиргүй шуналтай болсон хавч, цай, дарс, шоколад эхлээд л амсахад тань сайхан санагдсан гэж үү? Та гургуул дээр ассафетида хольж иддэг ромчууд, алтан хараацайн үүр иддэг хятадуудыг та ойлгоно гэж үү? Мэдээж үгүй. Тэгвэл гашиш ч адилхан. Энэ өнөөдөр танд ямарч амтгүй муухай санагдавч долоо хоног тэвчээд үз, тэгвэл үүнтэй зэрэгцүүлэх сайхан юм Энэ орчлонд үгүй болно. Харин одоо тийшээ таны өрөөнд оръё. Али бидэнд ганс тамхи, кофе цай авчирч өгнө үү.

Тэгээд босож байх зуур өөрийгөө Синдбад-далайчин гэж нэрлэж бид ч тийнхүү нэрлэж буй хүн зарцдаа тушаал өгч, Франц зэргэлдээ өрөөнд орлоо.

Өрөөний засал чимэг нь энгийн боловч бусдаасаа дутахгүй баян чинээлэг ажээ. Өрөө дув дугараг бөгөөд эргэн тойрон буйдан тавьжээ. Харин буйдан хана, тааз, шал нь хөвсгөр хивс шиг үнэт сахлаг зөөлөн үсээр бүрхэгджээ. Сахлаг дэлтэй африкийн арслан, бенгалийн судалт барс, Дантегийн үзсэн шиг алаг цоохор капийн ирвэс, сибирийн баавгай, норвегийн үнэгний арьс байлаа. Дээр дээрээс нь овоолон тавьсан байх тул өтгөн өвсөн дээр явж байгаа ч юм уу эсвэл зөөлөн дэвсгэрт хэвтэж байгаа юм шиг санагдана.

Зочин эзэн хоёр буйдан дээр хажуулав. Хуван соруултай мэлрэгийн модон ганснууд дахин дахин нэрэх гэж ажил удахгүйн тулд тамхи нэрээстэй бэлэн байлаа. Тэр хоёрыг ганс авахад, Али гал өгөөд кофе цай авчрахаар явлаа.

Нам гүм болов. Синдбад ярианы үед ч гэсэн сэтгэлээс нь гараагүй бодолдоо автан, Франц сайн тамхи татаж байгаа хүний ёсоор хамаг гунигтай санаа нь нисэн алга болж, оронд нь шидэт зүүд шахан түрнэ.

Али кофе цай авчрав.

- Та франц маягаар уу эсвэл түрэг маягаар уу, шингэн үү, өтгөн үү, чихэртэй буюу чихэргүй юү, хандалсныг уу эсвэл буцалгасныг уух уу? гэж үл таних хүн асуув.

- Би түрэг маягаар бэлтгэснийг ууя гэж Франц хариулахад,

- Таных маш зөв. Энэ чинь таныг дорнодын амьдралд дуртайг харуулж байна. Ээ хөөрхий! Зөвхөн Дорнодод л амьдарч чадаж байна. Харин миний тухайд гэвэл гээд хачин инээдээ Францаас нуулгүй инээмсэглээд - Би Парис дахь хэргээ дуусгачхаад Дорнодод насаа дуустал сууна. Хэрвээ та манайхаар очъё гэвэл намайг Каир, Багдад эсвэл Исфаген хотоос эрж сураглах хэрэг гарна байх гэв.

- Энэ тун амархан хэрэг, надад бүргэдийн далавч ургаж байх шиг байна. Би түүгээр нэг хоногийн дотор ертөнцийг тойрон ниснэ гэж Франц хэлэв.

- Ай даа. Гашиш нөлөөлж байна! Тэгвэл далавчаа дэлгэж газар дэлхий дээрх уудам зайд нисэн од доо. Битгий айгаарай, таныг хамгаалж байгаа хэрвээ таны далавч Икарын далавч шиг нарны халуун илчинд шатвал бид таныг тосож тэврэн авна.

Тэгээд Алид араб хэлээр хэдэн үг хэлэхэд цаадах нь бөхийн ёслоод гарч одов.

Өөрт нь хачин өөрчлөлт болж байхыг Франц мэдэв. Өдрийн турш хуримтлагдсан ядрал, үдшийн явдалд хөдөлсөн түгшүүр нь унтахын өмнөх мэт алга болон арилж, цовоо сэргэлэн боллоо. Бие нь хөнгөрч ухаан нь хэлэхийн аргагүй саруул болж, сэрэл нь хоёр дахин хурцдав. Тэнгэрийн хаяа улам өргөжиж ямар нэгэн бүдэг бүрий аюул заналхийллийг төрүүлсэн баргар бараан байхаа больж, харавч хараа цуцам тунгалаг хөх далай цэлийж нарны хурц гэрэл гийгүүлж ариун салхин үлээнэ. Дараа нь хэрвээ бичиж авч амжвал тэнгэрлэг аялгуу байхаар, далайчдых нь дууны нарийн цэвэр аялгуун дор, Монте-Кристо арал өмнө нь босож ирэхийг харав. Тэгэхдээ арал долгион дээрх аймшигт цохио хад биш харин цөл говьд байдаг баян бүрд шиг харагдав. Арлаас тэнгэр өөд битүүлэг шидэт аялгуу цацран нисэж байгаа мэт учир завь дөхөх тусам дуулах нь улам тархан цуурайтна: Энд Лорелея загасчныг уруу татах ч юм уу Амфион хот босгох гэж байгаа адил болно.

Эцэст нь завь эрэгт тулав. Тэгэхдээ нийлж байгаа хоёр уруул шиг ямарч доргилт түлхэлтгүй алгуур зөөлөн хүрч, өөрөө бууж агуй уруу ороход гайхамшигт хөгжим намдахгүй байлаа. Тэр шатаар доошоо бууж байгаа юм шиг өөрт нь санагдан, цэвэр ариун агаар амьсгалж, түүнээс болон оюун ухаан нь хүсэл мөрөөдөлд уусан замхарч хачин эзэн Синдбад, хэлгүй зарц Алиг хүртэл үзэв. Дараа нь хамаг юм сүүдэрлэгдэх мэт алга болон одож, эрт цагт нойр болон жаргал зугаацлаа хамгаалах гэж шөнө асаадаг бүдэг гэрлээр гэрэлтүүлсэн баримал хөшөөтэй өрөөнд орлоо

Тэдгээр нь шохоорхмоор гоё сайхан хэлбэртэй, соронзон мэт харцтай, дур сэтгэлийг татам инээмсэглэсэн зөөлөн бужгар үстэй уран найраг дүүрэн баримал байлаа. Эдгээр бол агуу их айлгүй гурван хүүхэн Фрина, Клеопатра, Месалина байлаа. Ичгүүр сонжуургүй энэ үзэгдлийн дунд, гуалиг хонгор залуу биеэ энэ гурван гантиг чулуун завхайчуулаас ичингүйрэн нуусан мэт далдалсан гэгээн сайхан тэнгэрийн дагина үзэгдэн гарч ирэв.

Тэгээд тэр гурван баримал нэгэн хүнд тачаадан дурлаж тэр дурласан хүн нь өөрөө байх юм. Тэд хөлөө хүртэл унжсан цагаан нөмрөг нөмөрч задлан тавьсан үсээ долгилуулан, цээжээ ил гарган түүн лүү ойртож ирэв. Тэд бурхдын сэтгэлийг татаж чадах боловч, ариун гэгээнтнүүд өмнө нь тэсвэрлэн зогсож чаддаг тийм царайгаа гарган ирэв. Түүн уруу шувуу харсан могой харц шиг шуналтай гал дөл бадарсан харцаар харахад тэврэх мэт зовлонтой, үнэсэн таалах мэт амттай тэр бүхний нь өмнө тэсвэрлэн зогсох хүч хүрсэнгүй.

Франц нүдээ аньснаа эргэн тойрныг сүүлчийн удаа харахад өнөөх нөмрөгтэй ичингүйрсэн баримал бүүр түүр харагдав. Тэгээд нүд нь үнэн бодит байдлыг харахаа байж, ухаан нь бодож ухаарахын аргагүй сэрэлд зориулагдан нээгдэв.

Тэгэхэд холыг харагч мэргэн хүн амлан хэлсэн тэр эцэж цуцашгүй шунал тачаалын барагдашгүй сайхан үе эхлэв. Гантиг чулуун уруул амь орж, цээжин бие нь халуу дүүгэн гашишийн эрхшээлд анх удаагаа орсон Францад шунал тачаал нь зовлон болж сэтгэл бахдам жаргаж байсан нь тамлал мэт санагдлаа. Тэгтэл халуу оргисон уруул дээр атирсан могой шиг хүйтэн уруул наалдан ирэхийг мэдэрч тэр дороо энэ хачин гайхалтай шунал тачаалыг гараараа түлхэн зайлуулахыг оролдов Сэрэл мэдрэл нь далд нойрны эрхэнд автагдан сэтгэл оюунаа ч өгөхөд харамсахгүй тэмцлийн дараа тэр хүн жаргал цэнгэлдээ ядран сульдаж гантиг чулуун хонгоруудын үнэсэлт ба нойронд дарагдан ухаангүй унаж ойчив.

11. Сэрсэн нь

Франц сэрэхэд эргэн тойрон байгаа зүйлүүд нь зүүд нойрны нь үргэлжлэл мэт байлаа. Гунигт харц шиг нарны цацраг дөнгөн данган нэвтэрч байгаа булшийн ёроолд байгаа юм шиг түүнд санагдав. Гараа сунгавал нүцгэн чулуу баригдав. Тэгээд өндийж харвал маш зөөлөн анхилам үнэртэй хонин арцан дээр цуваа нөмрөөд хэвтэж байлаа.

Зүүдлэн үзэж байсан юм алга болж булшин дотроос гарч ирсэн мэт баримал унтаж байх хооронд нь алга болоод сэрэхэд нь байхгүй байлаа.

Гэрлийн туяа өөд хэд алхав. Оргилон байгаа зүүд нь энгийн тайван үнэн байдлаар солигдов. Агуй дотор байгаагаа ойлгож хагас дугараг үүд рүү очиж цэнхэр тэнгэр, хөхөмдөг далайг олж харлаа. Өглөөний нарны илч далайн долгио, агаарыг гийгүүлнэ. Эрэг дээр далайчид суугаад, юм ярьж инээлдэж байна. Эргээс арваадхан алхмын зайтай газар завь зангуун дээрээ найган дайвалзана.

Дух өөд нь сэнгэнэн үлээх ариун салхийг амьсгалан хэдэн минут зогсов. Цохио хадан дээр мөнгө мэт цагаан хөөс үлдсэн байгаа долгионы чимээ чагнан, ялангуяа зүүд нойрын дараа гоц сайхан санагдах өглөөний гоо үзэсгэлэнд алмайран зогсов Агуу сайхан, тайван цэвэр байгалийн амьдралыг хараад, өөрийн зүүдний хуурамч худал болохыг мэдрэн, үнэн байдал ухаан санаанд нь орж ирэв.

Франц арал дээр хүрч ирснээ, хориотой бараа тээгчдийн толгойлогчтой уулзсанаа газар доорх ордны баялаг чимгийг сайхан зууш, халбага гашишийг дурсан санав. ,

Гэвч өдрийн хурц гэрэлд гараад ирэхэд, энэ учрал наана хаяад л жилийн өмнө болж өнгөрсөн юм шиг санагдав. Зүүдэлсэн зүүд нь ухаан санаанд нь тод байх бөгөөд бодол сэтгэлийг нь эзэлнэ. Шөнийн турш энхрийлэн байсан тэр хий

үзэгдэл заримдаа далайчдын дунд, заримдаа гялалзан байгаа хад чулуун дунд заримдаа ганхан байгаа завин дээр харагдах шиг болно. Тэгэхдээ толгой сэргэлэн, бие нь амарсан байв. Бие нь хөнгөн бөгөөд цэвэр агаар дүүрэн амьсгалж, мандаж байгаа нарны дулаан илчинд нүүрээ тосон ээнэ.

Цовоолог алхлан далайчид уруу очив.

Цаадуул нь түүнийг хараад босож завины эзэн өөдөөс нь хүрч ирэв.

- Эрхэмсэг дээдэс, Синдбад-далайчин таны өмнө бөхийн ёслоод салах ёс гүйцэтгэж чадаагүй явсандаа хязгааргүй их харамсаж байна гэж хэлээрэй гэсэн. Маш яаруу хэргээр Малага явах болсон учрыг мэдээд таныг уучлах байх гэж найдаж байгаагаа хэлүүлсэн шүү гэхэд,

- Тэгэхээр энэ бүгд цөм үнэн гэж үү, найз Гаэтано минь! гэж Франц асуугаад - Энэ арал дээр намайг хаан хүний ёсоор хүлээж аваад, унтаж байхад минь яваад өгсөн хүн үнэхээр байна уу? гэв

- Байгаа юм. Бүх дарвуулаа дэлгэсэн хөлөг нь тэр явна. Хэрвээ та дуран байгаар харвал онгоцон дээрх хүмүүсийн дотор нөгөө эзнийг олно доо гээд Гаэтано, корсикийн өмнөд үзүүрийг чиглэн яваа бяцхан хөлгийн зүг заав.

Франц дуран байгаа авч нүдэндээ тохируулан тавиад заасан зүг уруу нь харав.

Гаэтано андуурсангүй. Онгоцны тавцан дээр өнөөх хачин хүн өөрийнх нь адил дура бай барин арал өөд харж зогсоно. Урьд өдөр нь зочноо хүлээж авахад өмсөж байсан хувцастайгаа, салах ёс гүйцэтгэхийн дохио болгон алчуураараа даллан байв.

Франц алчуураа гаргаад хариу даллав.

Хормын дараа хөлөг онгоцон дээр цагаан утаа гарч онгоцны хитигнээс гоёхноор тасран тэнгэр өөд алгуурхан дэгдэхэд Франц бууны сулхан дуу сонсов.

- Сонсож байна уу? тантай салах ёс гүйцэтгэж байна гэж Гаэтано хэлэв.

Франц буугаа авч тэдний хоорондох зайг буун дуу давж хүрч чадна гэдэгт найдахгүй ч гэлээ буудав.

- Эрхэм та одоо юу гэж тушаахсан бол? Гэж Гаэтано асуухад,

- Юуны өмнө бамбар асаа гэв.

- Өө, ойлголоо гэж эзэн хэлээд - Та шидэт ордонд ордог хаалга эрэх гэж байна уу. Хэрвээ энэ ажил зугаатай санагдаж байгаа бол эрхэмсэг танд амжилт хүсье. Би танд одоохон бамбар олж өгье. Энэ санаа намайг тайван суулгахгүй байгаа юм. Би гурав дөрвөн удаа эрж үзсэн боловч эцэст нь больчихсон гэснээ Жованни, бамбар асааж эрхэмсэг хүнд өг гэв.

Жованни тушаалыг гүйцэтгэхэд Франц бамбарыг нь авч газар доор орлоо. Хойноос нь Гаэтано дагалдан оров.

Тэр арцан дээр унтаж байсан газраа мэднэ. Гэвч агуйн ханыг гэрэлтүүлээд юу ч олсонгүй. Утаа тортог болсныг нь харж, үүнээс өмнө олон хүн ингэж эрж байсан болохыг мэдэв.

Гэвч ирээдүй шиг нэвтрэхийн аргагүй боржин чулуун ханыг нарийвчлан үзэв. Өчүүхэн төдий завсар дайралдах бүрд ангийнхаа хутгыг шааж үзэн овгор товгор бүрийг онгойх болов уу гэж дарна. Ямарч үр ашиггүй хоёр цагаа дэмий өнгөрүүлэв.

Эцэс сүүлд нь өөрийн бодлоос ухарч, Гаэтано дийлэв.

Францыг эрэг дээр буцаж ирэхэд хөлөг онгоц алсад өчүүхэн цэг төдий юм харагдаж байлаа. Дуран бай авч харсан боловч юу ч ялган таньж чадсангүй.

Гаэтано түүнд зэрлэг ямаа агнах гэж ийшээ ирснийг нь сануулав. Франц үүнийг огт мартчихсан байжээ. Тэгээд буугаа авч, зугаацан цэнгэх гэж яваа биш харин алба гүйцэтгэх гэж яваа хүн шиг арал дээгүүр хэсэн яваад арван таван минутын дотор нэг янгир, хоёр ишиг агнав. Гэвч эдгээр нь эрэмгий догшноороо зээртэй төсөөтэй, гадна талаасаа тэжээвэр гэрийн ямаатай ижил байсан учир Франц тэдгээрийг ан гэж үзсэнгүй.

Түүнээс гадна санаанд нь огт өөр юм бодогдож байлаа. Өчигдөр үдээс хойш «Мянга нэгэн шөнийн» үлгэрийн баатар болсон бөгөөд санаа бодол нь агуй уруу байн байн эргэж буцна.

Хэдийгээр эхний удаа амжилтгүй эрсэн боловч эрлээ дахин үргэлжлүүлж, энэ завсар нэг ишгээ шарж бай гэж Гаэтанод тушаав. Энэ удаагийн эрэлт нь маш удаан үргэлжилж, Францыг буцаж ирэхэд нь ишгий нь аль хэдийн шарчихаад өглөөний зоог бэлэн болчихсон байлаа.

Урьд өдөр нь хачин жигтэй эзэн хамт хоол идэхгүй юу гэж урьж ирэхэд сууж байсан байран дээрээ сууж, корсикийн зүг явж байгаа, цахлай шувуу шиг цагаан онгоцыг дахин харав.

- Энэ юу болж байна. Эрхэм Синдбад Малага орохоор явлаа гэж та надад хэлсэн байхаа, гэтэл миний бодоход Iэр Порто-Веккио уруу шууд явчих шиг боллоо гэж хэлэхэд, хөлгийн эзэн өөдөөс минь

- Энэ хөлөг дээр корсийн хоёр дээрэмчин явааг та мартчихаа юу? гэж асуув.

- Нээрээ тийм! Тэгээд тэднийг эрэг дээр буулгах гэж яваа байх нь ээ? гэж Франц асуув.

- Чухамхүү тийм! Энэ хүн бурхнаас ч тэр, чөтгөрөөс ч айдаггүй, хөөрхий болсон хүнд тус хүргэхийн тул замаасаа тавин бээр хазайх нь ч бэлхэн хүн гэж ярьцгаадаг.

- Харин тийм тусна, тэр хүнийг буянт үйлээ үйлдсэн улсын засгийн газартай маргалдахад хүргэх юм биш үү гэж Францыг хэлэхэд,

- Тэглээ гээд юу болох вэ дээ! гэж Гаэтано инээмсэглэн хариулаад - Засаг захиргаа түүнд ямар хамаа байна? Сохор зоосын төдий ч бодохгүй хойноос нь хөөгөөд үз л дээ, нэгдүгээрт онгоц нь хөлөг онгоц биш шувуу л гэсэн үг. Ямар ч сайн хөлөг онгоцноос гурван зангилаагаар түрүүлнэ. Хоёрдугаарт: тэр зөвхөн эрэг дээр гарвал л болоо, түүнд энд тэндгүй найз нөхөд бий гэв.

Энэ бүхнээс үзэхэд Францыг дайлсан Синдбад бол газрын дундад тэнгисийн эргийн дагуух хориотой бараа тээгсэд, дээрэмчидтэй холбоо хамааралтай байдаг хачин янзын хүн болох нь тодорхой байлаа. Одоо Францыг Монте-Кристо арал дээр тогтоох юу ч байсангүй. Агуйн нууцыг тайлах бүх л найдвараа алдаад, явахаар завдаж завиа бэлтгэж бай гэж далайчдад тушаагаад өглөөнийхөө зуушийг зооглов. Хагас цагийн дараа завиндаа суусан байв.

Франц сүүлийн уд а өнөөх хөлөг онгоц өөд харахад, Порто-Веккио буланд орж нүдэнд харагдахгүй боллоо.

Франц хөдлөх дохио өглөө.

Завь хөдлөх яг тэрхэн үед хөлөг онгоц харагдахгүй болжээ.

Хөлөг онгоцны хамтаар өнгөрсөн шөнийн явдлын сүүлчийн ул мөр: оройн зууш, Синдбад, гашиш ба баримлууд алга болж одлоо.

Завь нь бүтэн өдөр шөнө яваад маргааш өглөө нь нар мандах үед Монте-Кристо арлын бараа тасарлаа.

Франц эрэг дээр буумагц адал явдлынхаа тухай түр мартаж, Альбер де Морсерын хүлээж байгаа Ром хот орохын тул, дээдсийн хүрээлэнгийн ёс журмуудыг түргэн гүйцэтгэхээр яаравчлав.

Дараа нь замд гарч, хагас сайн өдрийн үдэш шуудангийн сүйх тэргээр гаалийн талбайд хүрч ирэв.

Бидний дээр хэлсэнчлэн тэдэнд тасалгаа бэлэнэ байлаа. Зөвхөн л эрхэм Пастринийн зочид буудал хүрэх үлдсэн бөгөөд гэвч, Ром хот их хэрэг явдлын дуулианд автан, гудамж зээлээр хүмүүс багталцахгүй дүүрсэн байх учир тийм ч амархан хэрэг биш байлаа. Ромд жил бүр дөрвөн их хэрэг явдал болдог: багт наадам, улаан өндөгний баярын өмнөх долоо хоног, бурхны хутгийг олсон баяр ба гэгээн Петрийн дүйцэн өдөр болно.

Жилийн бусад цагт нь Ром хот амьдрал үхэл хоёрын хоорондох ичээний байдалтай энэ ертөнц нөгөө ертөнц хоёрын хоорондох буудал, нэг ёсны яруу найраг, уран гайхамшиг өвөрмөц байдалтай үдлэх газар болдог байлаа. Франц ийм үед нь зургаа долоон удаа ирсэн агаад жилээс жилд улам ±айхан улам ч ид шидийн юм шиг санагддаг ажээ.

Франц улам улам олшрон миегнэж байгаа олны дундуур чихэлдэн явж зочид буудал хүрСв. Эхний асуултад нь хүн олонтой зайгүй зочид буудлын үйлчлэгчдийн ердийн заншлаар «Лондон» буудалд түүнд байр алга даа гэж их л ширүүн хариу дуугарав. Тэгэхэд нь нэрийн хуудсаа эрхэм Пастринид явуулж, Альбер де Морсерийн нэрийг ч дурдаад авав. Энэ нь тус болжээ. Эрхэм Пастринийн өөрөө гүйн гарч ирээд, эрхэм хүний биеийг хүлээлгэн чилээлгэсэндээ уучлал гуйж, газарчилж явсан хүний гараас лааны нь суурийг булаан авч өөрөө Альбер де Морсер дээр оруулж өгөхөөр дагуулж явтал цаадах нь өөдөөс нь гарч ирэв.

Захиалсан байр нь хоёр жижигхэн унтлагын өрөө, нэг хүлээн авах өрөөтэй ажээ. Унтлагын өрөөний цонх нь гудамж уруу харжээ. Энэ нь буудлын эзний хэлснээр үнэлж баршгүй давуутай зүйл байв. Энэ давхрын бусад бүх тасалгааг сицил ч юм уу мальти ч юм уу нэгэн баян хүн хөлслөн авчээ. Хаанахын хүний нь буудлын эзэн яг таг мэдэхгүй гэнэ.

- Энэ бүгд маш сайн, эрхэм Пастрини гэж Франц хэлээд - Одоо бид хоол идмээр байна. Харин маргаашаас эхлээд сүйх тэрэг хэрэгтэй дээ гэхэд зочид буудлын эзэн,

- Оройн хоолны тухайд гэвэл одоохон авчирч өгнө. Харин сүйх тэрэг гэдэг чинь... гэхэд,

- Юу гэж? Гэж Альбер дуугараад - Байзаарай, байзаарай, эрхэм Пастрини минь, энэ чинь юу гэсэн үг болж байна? Бидэнд сүйх тэрэг хэрэгтэй гэв.

- Эрхэм минь, бид түүнийг бүтээхийн тул чадах бүхнээ хийнэ. Танд амалж чадах юм энэ л байна гэж буудлын эзэн хариулав.

- Тэгээд бид хэзээ хариуг нь авах вэ? гэж Франц асуухад,

- Маргааш өглөө гэж эзэн хариулав.

- Тэр юу байх вэ дээ! Илүү хөлс өгнө, тэгээд л болоо биз. Мэдээж хэрэг шүү дээ. Дрек Арон хоёроос жирийн өдөр хорин таван франкаар, бүтэн сайн өдөр баяраар гуч, гучин таваар авдаг. Дээр нь тавыг нэмчих, тэгвэл дөч болно. Ингээд л гүйцээ гэж Альбер хэллээ.

- Эрхэм минь хоёр дахин илүү үнэ төлөөд ч юм олж чадахгүй байх гэж би эргэлзэж байна.

- Тэгвэл миний замын сүйх тэргэнд морь хөллөчих дөө. Замдаа л жаахан муудчихсан байх, тэглээ гээд муу юм алга.

- Морьд олдохгүй ээ.

Альбер чухам юу ярьж байгааг ойлгохгүй байгаа хүний харцаар Франц өөд хараад,

- Франц танд энэ ямар шүү санагдаж байна? Морьд олдохгүй гэнэ. Үгүй ядахдаа шуудангийн морьд ч олж болохгүй гэж үү? Гэв.

- Аль хэдийнэ хоёр долоо хоногийн өмнө тараагаад авчихсан. Одоо зөвхөн шууданд хэрэгтэй нь л үлдсэн.

- Та үүнийг юу гэж хэлэх вэ? гэж Франц асуухад Альбер,

- Би ямар нэг зүйл ухаанаас хэтрээд ойлгогдохгүй болчихвол түүн дээрээ зогсоод байдаггүй, өөр сэдвийг ярьдаг заншилтай хүн дээ. Эрхэм Пастрин гуай, оройн хоол юу болж байна? гэв.

- Оройн хоол бэлэн.

- За тэгвэл хоол идэхээсээ л эхэлье.

- Сүйх тэрэг, морь яах вэ? гэж Франц асуув.

- Найз минь бүү санаа зов. Олдоно, харин мөнгөө нарийлж л болохгүй.

Тэгээд дүүрэн мөнгөтэй түрийв-тэй цагт болохгүй бүтэхгүй юм гэж байдаггүй хэмээн үздэг үзэл баримталдаг Морсер оройн хоолыг зооглочихоод тарвага шиг унтаж зургаан морь хөллөсөн сүйх тэргээр багт наадам үзэж байна гэж зүүдлэв.

12. Ромын дээрэмчид

Маргааш өглөө нь Франц түрүүлж сэрээд хонхоо дуугаргав.

Хонхны дуу намдаж амжаагүй байтал Пастрини өөрөө орж ирэв. Тэгээд францын асуухыг ч хүлээлгүйгээр,

- Харж байна уу, би өчигдөр сүйх тэрэг олж өгнө гэж ам алдаагүй нь сайн болж. Та нар дэндүү орой хөөцөлдөж дээ. Ромд одоо нэг ч сүйх тэрэг байхгүй, өөрөөр хэлбэл сүүлийн гурван өдөрт нэг ч сүйх тэрэг олдохгүй нь гэж хэлэв.

- Тэгэлгүй яах вэ! Чухам хамгийн хэрэгтэй өдрүүдэд тэр шүү дээ.! гэж Франц хэлэхэд, Альбер орж ирээд

- Юу гэнээ? Сүйх тэрэг байхгүй гэнэ үү? Гэж асуув.

- Найз минь та таачихлаа гэж Франц хариулав.

- Хэлэх ч юм алга даа, танай мөнхийн хот чинь! Гэхэд Пастрини христос ертөнцийн нийслэлийн нэр хүндийг ирсэн гадны хүмүүсийн өмнө өндөр байлгахыг оролдон,

- Ням гаригийн өглөөнөөс мягмарын орой хүртэл л сүйх тэрэг олдохгүй байх нь гэж хэлэх гэсэн юм. Харин бүтэн сайн өдөр болтол, та минь хүсвэл тавин сүйх тэрэг ч олж өгч болно гэв.

- Энэ бол арай дээр хэргээ! Өнөөдөр чинь пүрэв гариг. Ням гариг юу болохыг хэн мэдэх вэ? гэж Альбер хэллээ.

- Арав, арван хоёр мянган хүн нэмж ирээд байдал улам л хүнд болно доо гэж Франц хариулахад,

- Найрсаг нөхөр минь, маргаашийг бодолгүйгээр өнөөдөртөө л сэтгэл хангалуун явъя гэж Моррес хэлэв.

- Үгүй ядахдаа бидэнд цонх олдоно байгаа? Гэж Франц асуув.

- Цонх ий? Хаашаа харсан юм?

- Мэдээж хэрэг, Корсо уруу!

- Та тохуурхаж байна! Цонх! Гэж эрхэм Пастрини дуу алдаад, - Боллоцоогүй хэрэг! Огт боллоцоо байхгүй! Палацио Пориагийн зургадугаар давхарт ганц сул цонх байсан. Оросын нэгэн тайжид өдрийн хорин цехинээр өгчихсөн гэж хэлэв.

Тэгэхэд залуу хүмүүс гайхан бие биеэ харав.

- Найз минь одоо яах хэрэгтэй болж байна? гэж Франц Альбердаа хэлээд,
- Венецид л багт наадам өнгөрөөх үү дээ. Тэнд сүйх тэрэг олддоггүй юмаа гэхэд завь олдоно доо гэв.

- Хэрхэвч үгүй! гэж Альбер хариу дуугараад - Би ромын багт наадмыг үзэх гэсэн болохоор модон хөл хийж байгаад ч болох нь оо үзнэ дээ гэхэд, Франц хажуугаас нь орж

- Сайхан санаа байна, ялангуяа мокколетти□ бөхөөхийн тул полишинел□, вампири□ исланд нутгийн дээрэмчид шиг хувцаслая. Тэгвэл толгой эргэм их амжилт олно доо гэв.

- Эрхэмсэг та нар, ямар ч байсан ням гариг хүртэл тэрэг авахыг хүсэхсэн болов уу?

- Мэдээж хэрэг! Та биднийг ямар нэг бичээч шиг ромын гудамжаар явган явах юм гэж бодоогүй биз дээ? гэж Альбер хэллээ.

- Эрхмүүдийн зарлиг ёсоор гүйцэтгэе гэж Пастрини хариулаад - харин сүйх тэрэг зургаан пиастрын хөлстэй гэдгийг урьдчилан хэлье гэхэд,

- Ай, найрсаг Пастрини гэж Франц үгийг нь тосон аваад - Бид манай хөрш саятан биш болохоор танд урьдчилан хэлье. Би дөрөв дэх удаагаа Ромд ирж байгаа учир сүйх тэрэг жирийн өдөр, баяр ёслолын өдөр, бүтэн сайн өдрүүдэд ямар хөлстэй байдгийг мэднэ. Танд гурван өдрийн хөлс болгож арван хоёр пиастр өгнө. Өнөөдрийнх, маргаашийнх, нөгөөдрийнх, тэгэхээр та тийм ч муугүй хожоо олох болно гэв.

- Юу л даа... эрхэм минь!.. хэмээн Пастрини тайлбар тавихыг завдтал,

- Хүндэт эзэн та өөрөө л мэд, дураараа л бол. Эсвэл би таны тэрэг хөлслөгчтэй өөрөө ярих уу. Би түүнийг сайн танина, хуучин танил маань байгаа юм. Надаас багагүй юм тоншсон юм. Тэгэхээр хойшдынхыгоо бодоод миний хэлж байгаагаас ч бага үнээр надад хөлслүүлэх байх. Тэгвэл та өөрийн буруугаар хоорондох зөрүүг олж авч чадахгүй хоцорно гэж хэлэхэд эрхэм Пастрини дийлдсэнээ хүлээсэн итали хүний инээдээр инээмсэглэж,

- Та өөртөө яршиг учруулж яах нь вэ? Танд үйлчлэхийг хичээе. Та сэтгэл хангалуун байх болно гэж найдаж байна гэв.

- За тэр, сайн байна! Түрүүний л ингэх байсан юм.

- Сүйх тэрэг хэзээ хэрэгтэй вэ?

- Цагийн дараа

- Цагийн дараа үүдэн дээр ирсэн байх болно.

Нээрээ ч цагийн дараа сүйх тэрэг ирж залуу хүмүүсийг хүлээн зогсож байлаа. Энэ нь ердийн өртөөний тэрэг байсан бөгөөд баяр наадмын үеэр сүйх тэрэг гэж өргөмжлөн нэрлэжээ. Гэвч залуу хүмүүс энэ тэрэгний энгийн байрлыг харгалзахгүйгээр багт наадм»н гурван өдөр мэдэлдээ хэрэглэвэл азтай улс гэж үзэх байлаа.

- Эрхэм дээдэс! Гэж газарч цонхоор шагайн хашхираад - сүйх тэргийг ордны үүдэнд аваачих уу? гэж асуув.

Италичуудын өргөмжлөн ярих дуртайг Франц мэдэх боловч ийш тийшээ харав. Газарч өөрт нь л хэлсэн бололтой.

Эрхэм дээдэс гэдэг нь Франц өөрөө, сүйх тэрэг гэдэг нь өртөөний тэрэг, ордон гэдэг нь «Лондон» зочид буудал байжээ.

Италичуудын хэтрүүлэн өргөмжлөх авьяас энэ өгүүлбэрт бүрэн багтжээ.

Франц Альбер хоёр доошоо буулаа. Сүйх тэрэг ордны үүдэнд хүрч ирэв. Эрхэм дээдсүүд тэргэнд сууж газарч байрандаа үсрэн гарав.

- Эрхэм дээдсүүд, хаашаа явах сан бол?

- Эхлээд гэгээн Петрийн сүмд, дараа нь Колизейд очъё гэж Альбер жинхэнэ парисийн хүний ёсоор хэлэв.

Гэвч Альбер, гэгээн Петрийн сүмийг бүтэн өдөр үзэж бүтэн сар харж судлах хэрэгтэй гэдгийг нь мэдэхгүй байлаа. Гэгээн Петрийн сүмийг бүтэн өдөр үзэж өнгөрүүлэв.

Гэнэт хоёр найз орой болж байхыг мэдлээ.

Франц цагаа харвал дөрөв хагас болж байлаа.

Гэртээ харих хэрэгтэй боллоо. Франц тэрэгнээс буухдаа орой найман цагт ирээрэй гэж хөтөчдөө хэлэв. Тэр Альберт, Петрийн сүмийг нарны гэрэлд үзүүлсэн шигээ Колизейг сарны гэрэлд үзүүлэхийг хүсчээ. Найз нөхөртөө урьд нь үзсэн хотоо үзүүлж танилцуулж байхад дээр цагт явж байсан хүүхэнтэйгээ найзыгаа танилцуулж байгаа юм шиг их хөхүүн байдаг билээ.

Ийм учраас Франц өөрөө хөтчөд явах замаа зааж өглөө. Дель-Попологийн хаалгыг өнгөрч, Сан-Жованийн гадаа ханыг дагаж явж хаалгаар нь орох ёстой байлаа. Ингэж явбал Колизей өмнө нь шууд гарч ирэх бөгөөд түүний үзэсгэлэнт

сайхан нь замд дайралдах Капитолид ч, Форумд ч, Умард Септимийн дааман хаалганд ч, виа -Сакра дахь Антонни ба Фаустины сүмд ч дарагдахгүй байх болно.

Хоолоо идэхээр суув. Пастрини сайхан хоол өгнө гэж амласан байжээ. Нээрээ ч хоол нь боломжийн ёжиж өгөх юмгүй байлаа.

Хоолны дараа эзэн ирэв. Франц түүнийг магтуулах гэж байна гэж бодоод, сайшаах үг бэлтгэн хэлтэл Пастрини үгийг нь хэлүүлсэнгүй таслан,

- Эрхэмсэг танд би их баярлалаа, гэвч би ийм үг дуулах гэж ирээгүй гэв.
- Тэгвэл та бидэнд сүйх тэрэг оллоо гэж хэлэх гэж ирсэн юм биш биз дээ? гэж Альбер ороомол навчин тамхиа татангаа асуув.
- Тэр ч бага хэрэг. Эрхэмсэг таныг энэ тухай бодохоо болиоч гэж би зөвлөх байна. Ромд чинь, болох болохгүй юм гэж байдаг. Танд бололцоогүй л гэж хэлсэн бол өнгөрсөн хэрэг.
- Парист бол хичнээн таатай гээч. Хэрвээ танд ямар нэгэн юмыг байхгүй гэж хэлбэл хоёр дахин өндөр үнэ өгчих. Тэгвэл хэрэгтэй юмаа дор нь авах болно.
- Франц хүн бүхэн тэгж ярьдаг юм гэж шар нь хөдөлсөн Пастрини хэлээд - Тэгвэл тэд яах гэж ингэж жуулчилж явдаг юм бол би ойлгохгүй юм гэв. Тэгэхэд Альберт тамхиныхаа утааг дутуухан үлээнгээ дайвалзан,
- Тийм учраас л бидэн шиг тэнэгүүд, ухаангүй амьтад ингэж жуулчилж явдаг юм. Ухаантай хүмүүс бол Эльдерийн гудамж Гантын цэцэрлэг, Кофе де Парис дахь шилтгээндээ тайван сууж байхыг дээд үздэг юм даа гэж хэллээ.

Альбер дээр дурдсан гудамжинд сууж, өдөр бүр дэгжин цэцэрлэгт гудамжаар зугаалан, хоол зөөгчтэй нь сайн харьцаатай байвал л хоол олж идэж болдог ганц кафед хоол иддэг гэдгийг тайлбарлах хэрэг байсангүй.

Альберийн хариултыг бүүрэн ойлгоогүй эрхэм Пастрини юу ч хариулсангүй дуугүй зогсов. Тэгэхэд Франц, дэлхийн байдлын тухай бодож байсан эзний бодлогыг тасалж,

- Гэсэн ч та бидэнд ямар нэгэн юм хэлэх гэж ирсэн. Чухам юу юм бол? Гэж асуув.
- Таны хэлдэг зөв. Тэгэхээр ийм байна. Та найман цагт сүйх тэрэг өг гэж тушаасан юм аа?
- Тийм ээ

- Та Колосео үзэх гээ юу?
- Та Колизейг хэлж байна уу?
- Энэ хоёр ялгаагүй
- Тийм байж
- Та хөтчид дель - Попологийн хаалгаар гарч Сан-Жованнийн гадаа ханыг даган явж, хаалгаар нь орох юм хэлсэн үү?
- Яг үнэн.
- Ингэж явж болохгүй
- Болохгүй ий?
- Үгүй дээ л маш аюултай
- Аюултай гэнэ ээ? Яагаад тэр билээ?
- Алдарт Луижи Вампаас болоод тэр.
- Найрсаг эзэн минь, эхлээд танай тэр алдарт Луижи Вампа гэж хэн гээч вэ гэдгийг хэлээд аль? Тэр Ромд их алдартай хүн байж болноо, харин Парист бол огт дуулдаагүй юм байх чинь гэв.
- Яалаа гэнээ та түүнийг дуулаагүй юу?
- Тийм аз тохиолдсонгүй.
- Та түүний нэрийг хэзээ ч сонсоогүй гэж үү дээ?
- Хэзээ ч сонсоогүй.
- Тэгвэл мэдэж ав л даа. Энэ бол Дечезарис, Гаспароне хоёр ч дэргэд нь зүгээр банди нар болох тийм сүрхий дээрэмчин хүн.
- Анхаараарай! Альбер гэж Франц дуу алдаад - одоо л дээрэмчин гээч гарч ирэх нь гэж хэлэв.
- Найрсаг эзэн минь, би таны нэг ч үгийг итгэхгүй гэдгээ хэлье. Тэгэхээр та хичнээн л ярьвал ярь. Би сонсож байя. За «Урьд нэг хүн байж гэнэ...» За алив, яриарай! Гэв.

Пастрини гуай хоёр найзын арай ухаалаг нь гэж санагдсан Франц уруу эргэж харав. Хөөрхий амьтанд зөвийг өгөх хэрэгтэй. Түүний амьдралын туршид зочид буудалд нь цөөн биш франц хүн ирсэн авч тэдний ухааны зарим чанар түүнд ойлгогдохгүй хэвээр хоцорчээ. Тэгээд Франц өөд их л ноцтой царайгаар хараад,

- Эрхэм та хэрвээ намайг худалч гэж байвал би танд хэлэх гэж бодсон юмаа хэлэхийн ч хэрэг алга. Гэвч таны тусын тулд л хэлсэн гэдгээ тангараглая гэхэд Франц үгийг нь тасалж,

- Хүндэт Пастрини таныг Альбер худалч гэж хэлээгүй, зөвхөн таны хэлсэнд үнэмшихгүй гэдгээ л хэлсэн, тэгээд л тэр. Харин би таны хэлсэнд үнэмшиж байна. Та ярь л даа гэв.

- Гэсэн ч та миний ярьж байгаад эргэлзээд байвал... гэхэд Франц бас л үгийг тасалж,

- Та ч Кассандраас ч илүү их гомдомтгой хүн юмаа. Тэр, холыг харагч хүн байсан. Хэдий тийм боловч, хэн ч тэр хүүхний үгийг сонсдоггүй байсан шүү дээ. Гэтэл таны хувьд бол ярилцаж байсан хүмүүсийн тал хувь нь анхааран чагнаж байна. Та суугаад эрхэм Вампа гэдэг чинь хэн болохыг ярь л даа гэв.

- Энэ бол алдарт Мастрильигаас хойш үзэгдэж дуулдаагүй дээрэмчин гэдгийг би танд айлтгасан.

- За тэгвэл би хөтчөд дель Полологийн хаалгаар ороод, Сан Жованнийн хаалгаар гарч ирнэ гэж хэлсэнтэй, таны энэ дээрэмчин ямар холбоотой болж байна вэ?

- Та нэг хаалгаар нь амар тайван ороод явчихна харин нөгөөхөөр нь гарч ирэх эсэх дээр би эргэлзэж байна.

- Яагаад тэр вэ? гэж Франц асуув.

- Яагаад гэвэл харанхуй болмогц л хаалганаас цааш тавьхан алхамд ч аюултай.

- Бүр тийм үү? гэж Альбер асуув.

Итгэхгүй байгаад нь сэтгэлдээ гүн гомдсон хэвээр байсан Пастрини гуай,

- Эрхэм бэйс, би үүнийг танд биш, тантай хамт яваа хүнд хэлж байна. Энэ хүн Ромд ирж байсан болохоороо энд ийм юмаар тоглоом наадам болгодоггүйг мэдэж байгаа байх гэж хэлэв.

- Найз минь гэж Альбер Францад хэлээд - Сонин гайхалтай учрал тохиолдол бидний гарт аяндаа орж ирэх нь. Бид сүйх тэргээ гар буу, урт буу, хоёр амтай буугаар зэвсэглээд явъя. Луижи Вампа яваад ирэг. Харин тэр барьж авахгүй, бид түүнийг барьж авна. Тэгээд бид Ромд орж, тэр алдарт дээрэмчнийг гэгээн хутагт хамба ламд аваачиж өгнө. Хутагт лам биднээс шанд нь юу авах вэ? гэж асууна. Тэгэхээр нь нэрэлхэлгүй, хутагт хамбын сангаас сүйх тэрэг, хоёр морьтой авч, багт наадмыг сүйх тэргэн дотроос үзнэ. Ромын ардууд бидэнд баяр хүргэж, эх орноо аварсан Курций Гораций хоёр шиг өргөмжлөн мандуулахын тухай яриад ч яах вэ гэв.

Альберийг ингэж сүр бадруулан ярьж байх хооронд Пастрини гуайн царайг зураач хүн зурчихмаар л байлаа.

- Нэгдүгээрт гээд Франц татгалзан - Та тэр гарбуу, урт буу, хоёр амтай буунуудаа хаанаас олж сүйх тэргээ зэвсэглэх вэ? гэж асуув.

- Миний зэвсгийн сангаас л биш. Перрачинд миний чинжаалыг хүртэл хурааж авсан, таныхыг яасан бэ?

- Аква-Пентэд намайг бас л тэгсэн.

- Найрсаг эзэн минь, гээд Альбер хоёр дахь тамхиа түрүүчийнхээсээ асааж аваад - Ийм арга хэмжээ л дээрэмчдэд үлэмж тохирно доо, ингэж хураадаг явдал тэдэнтэй хуйвалдсан хэрэг шиг надад санагдах юм гэж хэлэв.

Үг хэлээ ололцож болох ганцхан ухаантай хүн нь болсон Франц өөд харж, ямар нэгэн үл ойлгогдох юм амандаа бувтнасан нь ийм зоримог тоглоом шоглоом эзэнд аюултай санагдсанаас тэгсэн бололтой.

- Эрхэмсэг та, дээрэмчин довтлоход эсэргүүцэж болдоггүй гэдгийг мэдэх байх аа?

- Яагаад? «Болдоггүй гэдэг» чинь юү гэсэн үг вэ? гэж дуу алдав.

- Тийм л дээ, ямар ч эсэргүүцэл ашиг болохгүй. Гуу жалга эсвэл модны цаанаас гэнэт гараад ирэх хэдэн арван хүний өөдөөс та юу хийж чадах вэ? Тэд цөмөөрөө л тан өөд буугаа чиглүүлнэ шүү дээ.

- Чөтгөр ав! Намайг ална л биз! Гэж Альбер дуугарав.

Тэгэхэд Пастрини гуай Франц өөд «Таны найз нөхөр солиотой байх аа» гэсэн бололтой харцаар харав.

- Хүндэт Альбер, Таны хариулт сайхан бөгөөд корнелийн «*gu il mourut*» гэсэн үгтэй тэнцэхүйц байна. Гэвч тэнд Ромыг аврах тухай яриа байс н, Ром ч

аврагдах учиртай байсан юм. Харин бидний тухайд гэвэл §угаацаж л яваа улс, зугаацан цэнгэхээс болж амиа өгнө гэдэг бол инээдэмтэй хэрэг гэж Франц сөргөн хэлэв.

- Per Вассо гэж Пастрини гуай дуу алдаад - Ёстой алт шиг үг байна! гэв.

Альбер дарснаас аяганд хийж аваад, бага багаар балгангаа үл ойлгогдох юм аман дотроо бувтнана.

- За Пастрини гуай гээд Франц үгээ үргэлжлүүлэн - Одоо найз минь тайвширч, миний шөргөөцөхгүй байгаад та итгэсэн болохоор эрхэм Вампа гэдэг хэн болохыг бидэнд ярьж өгнө үү? Тэр чинь ямар хүн бэ, малчин уу, эсвэл ихэс дээдэс үү? Залуу хүн үү, хөгшин хүн үү? Өндөр үү, намхан уу? Бид хожим түүнтэй, олны дунд, ямар нэгэн газар дайралдвал таньж чадахаар дүрслэн хэлж өгөөч гэв.

- Эрхэмсэг минь би түүнийг хүүхэд байхаас нь эхлээд мэдэх болохоор, түүний тухай хэн ч надаас илүү хэлж өгч чадахгүй. Бас тэгээд би нэгэн удаа Фарентиноос Алатри орох замаар явж байгаад түүний гарт орсон юм. Тэгтэл миний аз болоход, хуучин танил болохоо санаж. Намайг суллан тавьсан бөгөөд оронд нь надаас юу ч аваагүйгээр барахгүй надад сайхан цаг бэлэглэж, өөрийнхөө түүхийг ярьж өгсөн юм гэв.

- Цагаа харуулаач гэж Альбер хэлэхэд, Пастрини хантаазныхаа хармааг уудалж хийсэн хүний нэр гүнгийн титмийн зурагтай туйлын сайхан цаг гаргаж ирэв.

- Энэ байна.

- Чөтгөр ав! Танд баяр хүргэе! Надад ч бас бараг энүүн шиг цаг бий гээд хантаазныхаа хармаанаас цагаа гаргаж - Гурван мянган франкаар авсан юм гэв.

Франц сандлаа ойртуулаад, Пастрини гуайг суухыг уриад,

- Тэр түүхээ ярьж өгөөч гэв.

- Та зөвшөөрөх үү? Гэж эзэн асуухад,

- Хүндэт хүн та дураараа бол гэж Альбер хариулаад - Та чинь зогсож ярьдаг лам биш шүү дээ гэж хэлэв.

Тэгэхэд эзэн тэр хоёрт мэхийн бөхөсхийв. Энэ нь Луижи Вампын тухай мэдэх бүхнээ ярьж өгөхөд бэлхэн байгааг нь харуулжээ.

- Байзаарай гээд Франц ярьж эхлэхээр ам нээсэн Пастрини гуайг зогсоогоод - Та Вампыг хүүхэд байхаас нь мэднэ гэл үү. Тэгэхээр тэр чинь, одоо ив идэрхэн хүн байх нь ээ? гэж хэлэв.

- Залуу юу гэнэ ээ? Тэгэлгүй яах вэ. Одоо дөнгөж хорин хоёртой, энэ жаал хол явна даа, зоволтгүй.
- Альбер та үүнийг юу гэж үзэж байна? Хорин хоёртойдоо алдарших гэнэ ээ. Энэ ч тоглоом биш ээ гэж Франц хэлэв.
- Тиймээ, үүний насан дээр Александр, Цезарь ба Наполеон дараа нь алдаршсан хэдий ч бага л амжилттай явсан юм.
- Тэгэхээр таны ярианы баатар чинь дөнгөж хорин хоёр настай юм аа? гэж Франц эзэнд хандан үргэлжлүүлэн хэлэв.
- Миний танд хэлсэнчлэн дөнгөж хорин хоёр хүрч байгаа юм.
- Ямар нуруутай вэ, өндөр үү, намхан уу?
- Дунд зэрэг барагцаалбал, энэ эрхэмсэг хүн шиг гээд Альбер өөд заав. Тэгэхэд Альбер мэхийн ёслоод,
- Зүйрлэж ярьсанд тань баярлалаа гэж хэлэхэд Франц нөхрийнхөө гоморхуу занд инээд нь хүрч,
- Ярь л даа Пастрини гуай, тэр чинь нийгмийн ямар ангид хамаарагддаг хүн бэ? Гэж асуув.
- Палестрин Габри нуурын хооронд байдаг Сан-Феличе гүнгийн эдлэн газарт жирийн малчин байсан юм. Пампинарт төрөөд таван наснаасаа эхлэн гүнгийн ажил хийсэн юм. Эцэг нь мөн малчин бөгөөд Ананийд бяцхан сүрэгтэй, хонины ноос, хонины бяслаг Ром хотод авчирч худалддаг байсан юм.

Бяцхан Вампа багаасаа их хачин зантай хүүхэд байсан юм. Нэгэн удаа, долоон настай байхдаа палестриний ламд очиж ном уншихыг зааж өгөөч гэж гуйжээ. Бяцхан малчин сүргээсээ салж болохгүй учраас тийм ч амар хэрэг биш байжээ. Харин сайн сэтгэлт лам нэр ус ч байхгүй «Борго» гэж нэрлэдэг жижигхэн сууринд өдөр бүр очиж ном уншдаг байж. Тэгээд ламбагуай Лиужийг зам дээр хүлээж байгаад тэр дороо замын хажууд ном зааж өгнө. Харин хичээл нь маш богино болохоор шавийгаа маш анхааралтай хичээнгүй байх хэрэгтэй болно гэж урьдчилан хэлжээ.

Жаалхүү баярлан зөвшөөрсөн байж.

Луижи малаа өдөр бүр Палестринаас Борго орох зам уруу тууж аваачна. Өдөр бүрийн өглөөний есөн цагт лам үүгээр явж өнгөрнө. Лам жаал хүүтэй сувгийн эрэг дээр сууж, бяцхан малчин хүү мөргөлийн номоор үсэг заалгана.

Гурван сарын дотор хүү уншиж сурсан юм.

Гэвч энэ нь түүнд бага санагдаж бичиж сурахыг хүслээ.

Лам Ром хотод цэвэр бичгийн багшид том үсгийн, дунд зргийн үсгийн, жижиг үсгийн гурванг загварыг захиж авчруулаад түүнийгээ үзүүртэй төмрөөр занар дээр яаж бичихийг жаал хүүд зааж өгчээ.

Вампа малаа хашчихаад, тэр оройгоо палестрины дархан дээр о-иж том хадаас аваад, түүнийгээ улайсгаж давтаад эрт цагийн үзгэрхүү маягийн юм хийж авсан байна.

Тэгээд тэр ма^огаашаас хэдэн занарын ялтас олж аваад ажилдаа оржээ.

Гурван сарын дотор хүү бичиг бичдэг болжээ.

Лам жаал хүүгийн идэвх зүтгэлийг хараад сэтгэл нь хөдөлж түүнд хэдэн дэвтэр бөөн өд, үзүүрлэдэг тонгорогтой нь бэлэглэжээ.

Жаал хүүгийн суралцах ёстой шинэ шинжлэх ухаан нь түрүүчийнхээс нь хөнгөн байлаа. Хүү долоо хоногийн дараа өдөн үзгээ өнөөх муу төмөр үзэг шигээ сайн хэрэглэж чаддаг боллоо.

Лам хүүгийн тухай Сен-Феличе гүнд ярьжээ. Цаадах нь малчин хүүтэй уулзахыг хүсэж, түүгээр өөрийнхөө дэргэд юм бичүүлж уншуулж үзээд захирагчдаа түүнийг барлагуудтай хамт хооллож сард хоёр пиастрийн цалин өгч бай гэж тушаасан байна.

Луижи энэ мөнгөөрөө ном, харандаа худалдан авдаг байлаа.

Хүү юм дууриалгах ер бишийн авъяастай болохоор Жотто шиг занар самбар дээр өөрийн хонь, байшин, модыг зурна.

Дараа нь тонгоргоороо мод зорж янз бүрийн хэлбэртэй юм хийх боллоо. Алдарт уран барималч Пинелли бас ингэж өөрийн үйл ажлыг эхэлсэн юм.

Луижиас бага зэрэг дүү, зургаан настай жаал охин бас л Палестрины ойролцоо мал хариулдаг байлаа. Охин Вальмонтод төрсөн, өнчин ганцаар бөгөөд Тереза гэдэг нэртэй байжээ.

Тэр хоёр хүүхэд мал нь нийлж хамт бэлчтэл нь бие биеийнхээ дэргэд сууж, дэмий ярин, инээлдэн тоглоно. Тэгээд үдэш болоход Сан-Феличе гүнгийн малыг, түшээ гүн Черветрийн малаас салгаж маргааш өглөө нь дахин уулзахаар болзоо тавиад т л тал тийшээ явна. Тэр хоёр энэ болзоогоо хэзээ ч зөрчиж байгаагүй бөгөөд иймэрхүүгээр хамт өсөж торнив.

Луизи арван хоёр хүрч, Тереза арван нэгтэй боллоо.

Түүний хамт тэр хоёрын төрөлхийн авъяас билэг хөгжсөөр байлаа.

Ганцаардлын дунд, болох л хэвээрээ Луизи урлагаар оролдсон хэвээр байлаа. Олон зантай заримдаа ямарч шалтгаангүйгээр уйтгарлана. Заримдаа хөгжүүн хөөргөн, түргэн зантай байх ба үргэлж ёжилж байдаг байсан юм. Пампинар, Палестрины ба Вальмонтоны нэг ч хүүхэд түүнд нөлөө үзүүлж чадаагүй бөгөөд тэр ч байтугай түүний найз нөхөр нь ч болж чадсангүй. Түүний дур зоргоороо, шаардлагатай, юунд ч бууж өгдөггүй зан нь нөхөрлөл бүү хэл талтай байхыг ч няцаана. Ганцхан Тереза л түүнийн хачин занг нэг харц, ганц үг, ганц дохиогоор номхотгоно. Хүү эмэгтэй хүний гарын шидэнд бууж өгөх бөгөөд харин эрэгтэй хүний гар бол түүнийг зөвхөн хугалж чадахаас биш, нугалж чадахгүй юм.

Тереза бол хөгжилтэй цовоо сэргэлэн боловч хэтэрхий амиа бодсон охин байв. Сан-Феличе гүнгийн захирагчаас Луижид өгдөг хоёр пиастр ба түүний хийж Ромд аваачиж тэндхийн тоглоомын худалдаачдад худалддаг тоглоом болон бусад хэрэгтэй хэрэггүй зүйлээс орсон бүх мөнгө нь хуурамч сувд, хүзүүний шилэн зүүлт чимэг, алтан зүү авахад зарцуулагдана. Залуу найзын өгөөмөр өглөгчийн ачаар Тереза Ром хавийн хамгийн хөөрхөн, хамгийн гоё хувцастай тариачин авхай байлаа.

Хүүхдүүд бүтэн өдрийг тоглож биесээ зугаацуулан өнгөрүүлсээр өсөж л байн. Тэдний яриа хүсэл, мөрөөдөл дотор Вампа өөрийгөө дандаа л хөлөг онгоцны ахмад цэргийн жанжин эсвэл ямар нэг мужийн амбан сайдаар дүрслэх ба Тереза өөрийгөө үзэсгэлэнт сайхан хувцастай олон зарц дагуулсан баян хүүхэн болсон байхыг хүснэ. Тэр хоёр ингэж хүсэн мөрөөдөж тоглож байгаад хонь малаа хашаанд нь аваачихаар салан явж, хүсэл мөрөөдлийн өндөрлөг дээрээс гашуун зовлонт үнэн байдалдаа бууж ирдэг байжээ.

Нэгэн өдөр залуу малчин, гүнгийн захирагчид Сабинын уулнаас чоно гарч ирээд, сүргийн хажуугаар шогшин явсныг үзсэнээ хэлэв. Захирагч түүнд буу өглөө. Вампа зөвхөн үүнийг л хүссэн хэрэг байжээ.

Энэ бууг Брешийн сайн дархан хүн хийсэн бөгөөд англи карабин буунаас дутахгүй тусаж байжээ. Гэвч гүн шархадсан үнэг цохиж байгаад бөгсий нь эвдэж, түүнээс хойш хэрэглэхээ байсан байжээ.

Вампа шиг модоор юм зордог хүнд энэ нь ямарч төвөгтэй ажил биш билээ. Тэр хуучны нь хэмжиж үзээд мөрөндөө тааруулан чухам юугий нь өөрчлөхийг бодож гаргаад маш гайхамшигт сайхан сийлбэртэй бөгс хийж залгав. Зөвхөн энэ модон бөгсий нь хотод аваачиж худалдвал арван тав хорин пиастр дажгүй хүрэх байв.

Гэвч тэр худалдах тухай бодсонгүй. Буутай болох гэдэг түүний нандин мөрөөдөл байжээ. Хараат биш байдал эрх чөлөөг сольсон орон бүхэнд, эрэлхэг хүн бүрийн хүчирхэг нөхөрлөлийн хамгийн анхны хэрэгцээ шаардлага бол өөрийн эзнийг буцаад хүмүүс тоон үзэх болгодог аймшигт хүчтэй довтлох ба хамгаалахын алинд ч үйлчилж чадах зэвсэгтэй байх явдал юм.

Энэ үеэс эхлээд Вампа завтай цаг бүхнээ буудлагын дасгалд зориулав. Тэр дарь сум худалдан авч юм бүхэн түүнд бай боллоо. Сабины уулын хажуу дээр ургадаг нарийхан чидун модны гол, олз хайж оройхон үүрнээсээ гарсан үнэг, агаарт халин нисэгч бүргэд эд бүгд цөм бай боллоо. Удалгүй мэргэн буудах болж, анхандаа буу дуугарах бүрд айдаг байсан Тереза, залуу найз нь дуртай газартаа гараараа хатгачихаж байгаа юм шиг тийм цэцнээр сум шигтгэж чадах болсонд нь бахархан баярлах боллоо.

Нэгэн орой нээрээ ч тэр хоёрын сууж тоглодог газрын дэргэдэх төглөөс чоно гарч ирэв. Чоно арав ч алхсангүй, үхэтхийн ойчив.

Вампа амжилтандаа бахархан, алсан чоноо үүрээд эдлэн газартаа авчрав.

Энэ бүхэн нь Луижи Вампыг зарим нэг талаар нэртэй болголоо. Хаана ч байсан бусдаас илүүтэй хүн өөрийгөө хүндэтгэх хүмүүсийг олж авдаг юм. Залуу малчныг тойрог даяар эргэн тойрны арван модын газартаа л хамгийн шалмаг хүч чадалтай, аймшиггүй хүү гэж ярьцгаах болов. Тереза, Сабины охидуудын дотор бараг тэргүүн зэргийн гоо сайхан хүүхэн гэж тооцогдож байсан боловч Вампа түүнд дуртай болохыг бараг бүгдээр мэддэг учир хэн ч түүнтэй дурлалын тухай ярьж зүрхэлдэггүй ажээ.

Луижи Тереза хоёр ч мөн дурлалын тухай огт ярьдаггүй байлаа. Тэр хоёр газар доогуур үндсээрээ холбоотой газар дээр мөчрөөрөө, агаар тэнгэрт анхилам үнэрээрээ хо«боотой хоёр мод шиг бие биеийнхээ дэргэд өсөв. Тэр хоёр үргэлж хамт байх юмсан гэсэн ганцхан хүсэлтэй. Энэ хүсэл нь зайлшгүй хэрэгцээт шаардлага болон хувирч тэр хоёр нэг өдөр саланги байснаас үхэхийг дээрд үзэхээр байлаа.

Тереза арван зургаатай, Луижи арван долоотой боллоо.

Энэ үед Лепиний уланд хурсан дээрэмчдийн бүлгийн тухай ярилцах болов. Ромын ойролцоох дээрэмчдийг үндсээр нь устгаж хэзээ ч чадаагүй юм. Заримдаа толгойлогчгүй болчихно. Тэгээд толгойлогч гараад ирэнгүүт тэр дороо л бүлэг дээрэмчид цугларчихдаг байв.

Абруццын ууланд мөрдөгдөж, неаполитаны эдлэнгээс хөөгдсөн алдарт Кукуметто тэнд дайн зарлаад Манфред шиг Гарильяног давж Соннино Пиперно хоёрын хоорондох Амазеногийн эрэг дээр хоргодох газар олжээ.

Одоо тэр Дечезарис ба Гаспароны замаар явж, бүлэг цуглуулаад, тэднээс ч илүү гарахыг хүсчээ. Палестрина, Фраскат, Памон нараас хэдэн залуу алга болчихов. Анхандаа тэдний тухай санаа зовж байсан боловч, сүүлд нь Кукуметтогийн бүлэгт орчихжээ гэж дуулав.

Кукуметто удалгүй олны анхаарал татсан зүйл боллоо. Түүний ер бишийн зориг, зэвүү хүрэм хатуу сэтгэлий нь тухай ярьцгаана.

Нэгэн удаа Фрозины газар хэмжигчийн охиныг хулгайлан авчээ. Дээрэмчдийн хууль бол хатуу бөгөөд олзлогдсон охиныг эхлээд олзолсон хүн нь хэрэглэнэ, дараа нь бусад нь сугалагаар дэс дараалан уйдталаа буюу эсвэл охиныг үхтэл нь зугаагаа хийнэ.

Хэрвээ эцэг эх нь баян б᠙л золиос төлөөд охиноо ав гэж элч явуулна. Элчийн амь насанд аюулгүй байхыг олзлогдсон хүүхэн толгойгоороо хариуцна. Хэрвээ золиосны мөнгө ирэхгүй бол охины хувь заяа шийдэгдэх нь тэр.

Кукуметтогийн бүлгийнхэн дотор тэрхүү олзлогдсон хүүхний дурласан хархүү Карлини гэгч байжээ.

Охин түүнийг хараад, гараа сарвайн, одоо аврагдлаа гэж боджээ. Харин хөөрхий Карлини түүнийг таниад, ямар хувь зохиол тохиолдох гэж байгааг нь мэдэх учир зүрх нь базлан шимшрэв.

Гэхдээ залуу, Кукуметтогийн хайртай хүн нь байсан бөгөөд гурван жилийн туршид түүнтэй бүх аюулыг хуваалцан, нэг удаа мөрдөж ирсэн цэрэг түүний толгой дээр сэлмээ далайж байхад нь аварсан болохоор, одоо намайг өрөвдөн өршөөх байх гэж найджээ.

Тэгээд толгойлогчоо хажуу тийш нь аваачхад, нөгөө хүүхэн дээрэмчдийн шохоорхсон харцаас буруулах гэж ромын тариачин бүсгүйчүүлийн хэрэглэдэг өнгөт алчуураар нүүрээ бүтээгээд өндөр нарсан доор суув.

Карлини толгойлогчдоо бүгдийг, дурлалцсанаа, бие биедээ үнэнч байна гэж тангарагласан тангаргаа дээрэмчдийн бүлэг энд байрласнаас хойш шөнө бүхэн балгасан дотор уулздаг байснаа хэлэв.

Яг тэр орой Карлинийг зэргэлдээ тосгон уруу явуулсан байсан учир уулзаж чадсангүй. Тэгтэл Кукуметто тэрүүгээр дэмий явж байгаад охинтой дайралдаж хулгайлан авчирсан нь тэр байжээ.

Карлини өөрийгөө бодож Ритаг зүгээр өнгөрөөгөөч, эцэг нь баян хүн болохоор сайн золиос төлнө гэж гуйж гувшжээ.

Тэгэхэд нь Кукуметто найзын гуйлтыг хүлээн авч байгаа дүр үзүүлэн, Фродикон уруу Ритагийн эцэгт элч болгон явуулах малчин ол гэж хэлэв.

Карлини баярлан охин дээр гүйж очоод аврагдсаны нь хэлж одоо эцэгтээ болсон явдлын тухай мэдэгдэж, гурван зуун пиастр төлбөл суллагдана гэж бич гэв.

Эцэгт нь маргааш өглөөний есөн цаг хүртэл арван хоёр цагийн хугацаа өгөв.

Карлини захидлы нь аваад явах элч олохоор хөндий уруу гүйв.

Тэгээд малаа хашиж байсан нэгэн залуу малчин олжээ. Хот ба уул хоёрын хооронд, зэрлэг ба соёлтой амьдралын зааг дээр оршин суудаг малчид гол төлөв дээрэмчдийн элч болдог ажээ.

Малчин нэг цагийн дараа Фрозинонд хүрсэн байна гэж амлаад даруй замд орж явав.

Карлини энэ мэдээгээ дурлалт хүүхэндээ хэлж тайвшруулах гэж яаран эргэв.

Түүнийг ирэхэд дээрэмчид ойн цоорхойд хоолоо идэн хөгжилдөж байв. Тэд нутгийнхнаас өргөл болгож авсан хүнс тэжээлээр хоол хийнэ. Гэтэл найрлаж суугаа улсын дунд Кукуметто Рита хоёр алга байлаа.

Тэр хоёрыг хаачсан бэ гэж асуув. Хариуд нь дээрэмчид чанга инээлдэн өнгөрөв. Карлиний духан дээр хүйтэн хөлс чийхарч оройны нь үс орвойн бослоо.

Тэр дахин асуув. Найрлагчдын нэг нь орвиетын дарс аяганд хийж, Карлинад өгч,

«Зоригт Кукуметто ба гоо үзэсгэлэнт Рита нарын төлөө» гэж хэлэв.

Яг энэ үеэр эмэгтэй хүн хашхирахыг Карлини сонсов. Тэр бүх учрыг ойлголоо. Карлини аягыг шүүрэн авч, дайлах гэсэн хүний нүүр өөд шидчихээд хашхирах дуу гарсан зүг уруу гүйв.

Тэр зуугаад алхам хэртэй гүйгээд ухаангүй болсон Ритаг тэврэн байгаа Кукуметтог харав.

Кукуметто Карлинийг хараад босож, түүн уруу хоёр гар буу чиглүүлэв.

Хоёр дээрэмчин бие бие өөдөө нэг нь тохуурхсан маягтай инээмсэглэж, нөгөөх нь үхээрийн цагаан царай гарган харж байлаа.

Энэ хоёрын хооронд одоохон хатуу ширүүн тулалдаан болох нь ээ гэж бодмоор байв. Гэтэл Карлиний царай өөр болж бүсэндээ хавчуулаастай байсан буюу атгасан гар нь доош унжив.

Рита тэр хоёрын хооронд газар хэвтэнэ.

Энэ явдлыг сарны гэрэл гийгүүлж байв.

«За яав? Чи даалгаврыг биелүүлэв үү?» гэж Кукуметто асуув. Тэгэхэд Карлини,

«Тэгсэн, атаман аа гэж хариулаад - Маргааш есөн цагт Ритагийн эцэг мөнгө авч ирнэ» гэв.

«Маш сайн хэрэг. Одоохондоо бид шөнийг хөгжилдөн өнгөрөөе. Гайхмаар сайхан охин юм. Карлини чи хүүхэн муугүй таньдаг юм байна шүү. Харин би ганц амиа бодсон амьтан биш болохоор, одоо нөхөд дээрээ буцаж, хэнд нь энэ охин ноогдох вэ гэдгийг сугалж үзье.»

«Тэгвэл та энэ охиныг ердийнхөөрөө өнгөрүүлэх гэж бодоо шив дээ» гэж Карлини асуув.

«Яагаад үүнийг онцгойлж үзэх билээ?»

Би таныг миний хүсэлтийг анхаарч...»

«Чи бусдаасаа юугаараа илүү юм бэ?»

«Таны хэлдэг үнэн» гэхэд Кукуметто инээгээд,

«Чи битгий зөв, эрт орой алин боловч чиний ээлж ирнэ» гэж хэлэв.

Карлини шүдээ зуухад хавиран тачигнав.

«За алив явъя» гэж Кукуметто хэлээд нөхдийнхөө зүг алхав.

«Би таны хойноос очноо»

Кукуметто түүнийг араасаа довтолж магадгүй гэж эргэн эргэн харсаар цааш явав. Гэвч залуу дээрэмчин ямарч сэжигтэй байдал үзүүлсэнгүй.

Тэр одоо болтол ухаангүй байгаа Ритагийн дээр гараа зөрүүлэн зогссоор байв.

Карлини охиныг тэврэн авч зугтаах магадгүй гэдэг бодол Кукуметтогийн санаанд орж ирэв. Гэсэн ч тэр Ритатай хэрэгтэй бүхнээ хийсэн тул үүнд сэтгэл зовсонгүй. Бас дээрэмчдийн дунд хуваах гурван зуун пиастр нь өчүүхэн мөнгө байсан тул тэд ч үүнийг бас бага сонирхож таарна.

Тэгээд дээрэмчид уруугаа явсаар байв. Харин Карлини өөртэй нь бараг зэрэг хүрч ирэхэд тэр гайхав.

Дээрэмчид толгойлогчоо хараад «Сугалаа! Сугалаа!» гэж хашхиралдав.

Эдгээр хүмүүсийн нүд нь шуналаар гялалзаж, түүдэг галын дэргэд тэдний царай шуламын царай шиг харагдана.

Шаардлага зүй ёсны байсан учир толгойлогч зөвшөөрөн толгой дохив. Тэдний болон Карлиний нэрийг бичээд, бүрх малгай дотор хийгээд, хамгийн бага нь нэгийг сугалж гаргав.

Энэ сугалаан дээр Дьяволаччогийн нэр бичээстэй байв.

Энэ бол Карлинид аягатай дарс өгөөд нүүр өөдөө цацуулсан хүн байлаа.

Чамархайгаас нь эрүүгий нь хүртэл зүссэн өргөн шархнаас цус дусалж байв.

Түүний нэрийг дуудахад чанга инээж,

«Толгойлогчоо Карлини сая намайг таны төлөө уу гэхэд уугаагүй шүү, та миний төлөө уу гэж өгөөрэй, таны мусэлтийг минийхээс дээрд үзэж м гадгүй» гэж хэлэв.

Хүн бүхэн Карлинийг уурлан дүрсхийх байх гэж бодож байлаа. Гэтэл тэр нэг гараараа аяга, нөгөө гараараа савтай дарс авч өөртөө хийж авав.

«Дьяволаччо, чиний эрүүл мэндийн төлөө ууя» гэж тайван дуугаар хэлэхэд хүмүүс их л гайхав.

Тэгээд аягатай дарсаа хоослон уухад гар нь ч чичирсэнгүй. Дараа нь галд ойртон суугаад «Миний хувийг өгөөч! Би явсаар байгаад өлсөж орхижээ!» гэж хэлэв.

«Карлини мандтугай!» гэж дээрэмчид хашхиралдан, ийм л байх хэрэгтэй Үүнийг ч ёстой нөхөрсөг ёс гэж хэлнэ дээ!» гэцгээв.

Тэгээд цөм галаа тойрон сууцгаахад Дьяволаччо явав.

Карлини юу ч болоогүй юм шиг идэж ууж байв.

Карлини ингэж санаанд ч орохгүй сууж байгааг дээрэмчид хараад гайхаж байтал, ард талд нь хүнд хөлийн чимээ гарав...

Цөм эргэж харахад: Дьяволаччо олзлогдсон залуу хүүхнийг гар дээрээ өргөчихсөн ирж явав. Охины толгой нь гэдийж урт гэзэг нь газар шүргэж байв.

Түүнийг ойртон ирэх тусам түүдэг галын гэрэлд дээрэмчин охин хоёрын царай улам ч зэвхий харагдана.

Энэ нь ч хачин зэвүүн, сүрлэг байсан учир Карлиниас бусад нь цөм боссон бөгөөд ганцхан Карлини л юу ч болоогүй юм шиг тайвнаар идэж ууж байв.

Дьяволаччо чимээгүй зогсож байгаа хүмүүс уруу ойртон ирж, толгойлогчийнхоо хөлийн дэргэд Ритаг тавив.

Тэгэхэд хүмүүс дээрэмчин ба охины царай яагаад ийм зэвхий байгаагийн урыг ойлгов. Охины зүүн хөхнөөс хутганы иш цухуйж байв.

Цөм Карлини өөд харахад бүсэн дэх хутганы нь хуй хоосон байв.

«Карлини яах гэж хоцорсныг би одоо ойлголоо» гэж толгойлогч хэлэв.

Зэрлэг зантай хүмүүс зоримог явдлыг үнэлдэг. Карлиний хийсэн энэ зүйлийг нэг ч дээрэмчин хийж чадахгүй болох боловч цөм түүнийг ойлгожээ.

Карлини бас байрнаасаа босоод хүүр уруу очиж, бууныхаа бариул дээр гараа тавьж,

«Одоо энэ хүүхнийг надтай булаацалдах хүн байна уу?» гэж асуухад толгойлогч,

«Үгүй, одоо чинийх!» гэж хариулав.

Карлини түүнийг өргөж, түүдэг галын гэрэл туссан дугараг хүрээнээс гаргав.

Кукуметто харуул манаагаа тавиад, дээрэмчид цуваа нөмрөн галын дэргэд унтацгаав.

Шөнө дунд түгшүүр зарлахад толгойлогч дээрэмчид тэр дороо бослоо.

Энэ бол Ритагийн эцэг нь золиосны мөнгө аваад ирсэн хэрэг байжээ. Тэр толгойлогчид хүүдийтэй мөнгөн зоос өгч,

«Май ав. Гурван зуун пиастр. Охины минь аль» гэж хэлэв. Толгойлогч мөнгий нь авсангүй, харин хойноосоо дагаад яв гэж дохижээ. Өвгөн үгэнд нь орж,

сарны гэрэл завсраар нь туссан моддын дунд оров. Кукуметто зогсож байсан модон доор байгаа хоёр дүрсийг өвгөнд зааж,

- Тэр байна. Энэ хүнээс охиноо нэхэж ав, түүний тухай тодорхой ярьж чадна » гэж хэлээд нөхөд дээрээ эргэж ирэв.

Өвгөн байрандаа алмайран зогсоно. Засаж залруулж болшгүй их гай түүний толгой дээр нөмрөн ирэхийг мэдэрчээ. Тэгээд модон дотор чухам юу болж байгааг ялгах гэж урагшаа хэд алхав.

Хөлийн чимээ сонсоод Карлини толгойгоо өндийлгөхөд, хоёр хүний дүрс өвгөнд тодхон харагдав.

Газар дээр нэгэн эмэгтэй хүн хэвтэх бөгөөд дээрээс нь тонгойсон эрэгтэй толгойгий нь өвдөг дээрээ тавьжээ. Залуу толгойгоо өндийлгөж, цээжиндээ тэвэрсэн хүүхний царайг ил гаргав.

Өвгөн охиноо танив. Карлини ч өвгөнийг танив.

«Би таныг хүлээж байлаа» гэж дээрэмчин Ритагийн эцэгт хэлэхэд,

«Бузар амьтан, чи яаж байгаа чинь энэ вэ?» гэж өвгөн дуун алдав.

Тэгээд цээжиндээ хутга шаалттай, цус нөж болчихсон хэвтэж байгаа Ритаг харав. Сарны гэрэл түүн дээр тусаж бүдэгхэн гэрэлтүүлнэ.

« Кукуметто охины чинь бузарлачихсан. Би хайртай байсан болохоороо алчихлаа. Бүр дээрэмчдийн тоглоом болох байсан юм» гэж Карлини хэлэв.

Өвгөн нэг ч үг дуугарсангүй боловч, царай нь буг чөтгөр шиг зэвхийрэв.

«Хэрвээ би буруутай байвал, охиныхоо өшөөг надаас ав» гэж Карлини хэлээд залуу охины цээжинд шаалттай байсан хутгыг суга татан авч нэг гараараа өвгөнд өгөөд, нөгөө гараараа энгэрээ ярав.

«Чиний ингэсэн чинь сайн болж» гэж өвгөн бүдэгхэн дуугаар хэлээд, «Хүү минь намайг тэвэр» гэв.

Карлини эхэр татан уйлж, дурлалт хүүхнийхээ эцэг тэврүүлэв. Энэ нь энэхүү цусаар бузарлагдсан хүний амьдралд анх удаа гарсан нулимс байжээ.

«Одоо, охиноо оршуулахад минь туслаач» гэж өвгөн хэлэв.

Карлиний өвгөн хоёр зуун наст царс модны саглагар мөчир доор булш ухав.

Булш бэлхэн болоход алагдсан охиныг эцэг нь түрүүлэн үнэсээд, дараа нь дурлаж байсан хархүү нь үнэсэв. Дараа нь тэр хоёрын нэг нь хөлөөс нь нөгөөх нь мөрнөөс нь өргөж булшинд тавив.

Тэр хоёр булшны дэргэд сөхрөн сууж маань уншив. Өвгөн залууд гараа өгөөд,

«Хүү минь чамд баярлалаа, одоо намайг ганцааранг минь орхи» гэж хэлэв.

Карлини өвгөний үгэнд орж, нөхөд дээрээ очоод цуваа нөмрөн бас л тэдэн шиг бөх унтав.

Урьд өдөр нь байраа солихоор шийдсэн байжээ.

Үүр цайхаас цагийн өмнө Кукуметто бүлгийг босгож, замд гарах тушаал өгөв.

Гэвч Карлини охины эцгийг юу болсныг мэдэхээс нааш явахгүй гэлээ.

Тэгээд салсан газартаа очтол өвгөн охины булшны дэргэдэх царс модны мөчрөөс дүүжилж үхсэн байв.

Эцэг охин хоёрын булшин дээр Карлини хоёулангийнх нь өшөөг авна гэж тангараглав.

Гэвч тангаргийг хэрэгжүүлж чадсангүй, Хоёр хоногийн дараа ромын цагдаа нартай тулалдаж яваад алагджээ.

Тэр дайсны өөдөөс харж явсан боловч араас нь сум орсон байхыг хараад хүмүүс гайхжээ.

Карлинийг ухан үед түүний ард арваад алхмын зайтай Кукуметто явж байсан гэдгийг нэгэн дээрэмчин санаж байгаагаа хэлснээс хойш гайхахаа больцгоожээ.

Дээрэмчидийн бүлэг Фрозиноны ойг орхиж явах үед Кукуметто, Карлинийг харанхуй дотор сэм дагаж яваад тангараг тавьж байхы нь дуулжээ. Болгоомжтой хүн болохоор түүнээс урьдсан нь тэр байжээ.

Энэ аймшигт толгойлогчийн тухай өөр багагүй га©халтай түүх олон бий юм.

Фондигос Перужи хүртэл, ганцхан Кукуметто гэдэг нэрийг хэлэхэд чичрэн дагждаг байв.

Энэ нь Луизи Тереза хоёрын хоорондын ярианы сэдэв болох нь олонт тохиолдоно.

Тереза айн чичрэхэд Вампа алдалгүй мэргэн тусдаг буугаа алгадан байж инээмсэглэн түүнийг тайвшруулна. Хэрвээ бүсгүй тайвширч өгөхгүй бол өөрсдөөсөө зуун алхмын зайтай газар модны мөчир дээр сууж байгаа хэрээг заагаад, буугаа шагайж, гохоо дарахад нь шувуу үхэтхийн унана.

Тэр завсар цаг хугацаа өнгөрсөөр байв. Луизи хорин нас хүрч, Тереза арван ес хүрч хоёр залуу ханилан суухаар шийдэв.

Хоёулаа өнчин учраас гэр бүл болох тхай зөвхөн өөрсдийнхөө эздээс зөвшөөрөл гуйх хэрэгтэй боллоо. Тэгээд ч тэднээс гуйж цаадуул нь зөвшөөрөв.

Нэг өдөр тэр хоёр ирээдүйнхээ тухай мөрөөдөн сууж байтал гэнэт буун дуу сонстов. Тэдний хонио хариулдаг газрын дэргэдэх төгөл дотроос нэг хүн ухасхийн гарч ирээд шууд тэдний зүг гүйв.

Ойртон гүйж ирээд

«Хойноос минь хөөж явна! Намайг нуугаач!» гэж хашхирав

Залуу хүмүүс дээрэмчин гэдгийг дор нь танив. Ромын тариачин ба Ромын дээрэмчин хоёрын хооронд төрөлхийн сайн харьцаатай байдаг болохоор нэг нь нөгөөдөө дандаа тус хүргэдэг байв.

Вампа нэг ч үг дуугаралгүй агуй уруугаа гүйж очоод хэн ч мэддэггүй оромжныхоо үүдийг тагласан чулууг зайлуулж, түүнийг оруулаад дахин таглаж орхиод Терезагийн дэргэд хуучин байрандаа ирж суув.

Төдхөн дөрвөн морьтой цагдаа төглийн захад давхилдан гарч ирэв. Гурав нь зугатсан хүнийг эрж дөрөв дэх нь баригдсан дээрэмчинг хүзүүнээс нь хөтөлж явав.

Цагдаа нар орчин тойрноо хараад залуу хүмүүсийг харж давхилдан ирээд, асууж сураглаж эхлэв.

Тэд хэнийг ч харсангүй.

«Ай халаг, бидний эрж яваа хүн толгойлогч нь байгаа юм» гэж эргүүлийн дарга хэлэв. Тэгэхэд Луизи, Тереза хоёр нэгэн зэрэг,

Кукуметто юу?» гэж өөрийн эрхгүй асуув.

«Тийм ээ, түүний толгойг авчирсан хүнд ромын мянган скудо шагнах юм. Та хоёр түүнийг барихад бидэнд тусалсан бол таван зуу нь та нарт очих байлаа» гэж дарга хариулав.

Залуу хүмүүс өөд өөдөөсөө харав. Цагдаа нарт горьдлого төржээ. Ромын таван зуун скудо бол францын гурван мянган франк болно. Гурван мянган франк гэдэг бол сүй тавих гэж байгаа хоёр өнчин хүнд бүхэл бүтэн хөрөнгө гэсэн үг.

«Тийм ээ халагламаар юм болж. Гэвч бид түүнийг даанч харсангүй дээ» гэж Вампа хариулав.

Цагдаа нар тал тал тийшээ давхилдсан боловч хэнийг ч олсонгүй.

Дараа нь цувралдан далд орлоо.

Тэгэхэд Вампа чулууг нь зайлуулж, Кукуметто агуй дотроос гарч ирэв.

Боржин чулуун хаалганы завсраар тэр хоёрыг цэргүүдтэй ярилцаж байхы нь харжээ. Юун тухай ярицлсаны нь ч тааварлан мэджээ. Луижи Тереза хоёр өөрий нь илчлэн барьж өгөхгүйг тэдний царай дээрээс харав. Тэгээд дүүрэн алт чихсэн түрийвч гаргаж тэр хоёрт сарвайв.

Вампа бардмаар толгойгоо дээш өргөхөд, харин Тереза энэ алтаар хичнээн их үнэт эдлэл гоёл чимэг авч болохыг бодоод нүд нь гялалзав.

Кукуметто бол дээрэмчний дүрийг олсон чөтгөр, хорт могой ажээ. Сайхь харцыг хараад Тереза Евагийн жинхэнэ охин болохыг таньж, төгөл уруу далд ортлоо аврагчидтайгаа салах ёс гүйцэтгэж байгаа дүр үзүүлэн хэдэн удаа эргэж харав.

Хэдэн өдөр өнгөрлөө. Кукуметто дахин үзэгдээгүй бөгөөд түүний тухай юу ч дуулдсангүй.

Багт наадмын үе дөхөж ирлээ. Сен-Феличе гүн, гоё хувцастай багт наадам зохиохоор шийдэж, ромын язгууртан дээдсийг урив.

Тереза баяр үзэх гэж ихэд хүсэв. Луижи Терезатай хамт зарц нарын дунд холилдон орж баяр наадам үзье гэж захирагчаас гуйв.

Гүн амин сүнс нь болсон ганц охиноо зугаацуулах гэж багт наадам санаачилсан байжээ.

Гүнгийн охин Кармела Терезатай нас чацуу, нуруу адил, Тереза ч хөөрхнөөрөө гүнгийн охиноос дутахгүй ажээ.

Тереза баярын орой, цайны хувцсаа өмсөж, үсэндээ хамгийн үнэтэй зүү хатгаж, хүзүүндээ хамгийн гоё гялалзсан чимэг зүүгээд Фраскатийн тариачин авгайн ёсоор хувцаслав.

Луижи тоскан нутгийн хүний баяр ёслолын гоё хувцас өмсөв.

Тэр хоёр ярилцсан ёсоороо зарц тариачдын дунд орж алга боллоо.

Энэ баяр баян тансгаараа гоц болсон байлаа. Зөвхөн гүнгийн байшин дээр гэрэл ассан төдий биш, бас цэцэрлэгийн мод бүр дээр өнгө өнгийн гэрэлт дэнлүү асаасан байв. Ийм учраас зочид гийчид элбэг арвин зоогт тасалгаануудаас дэвсэг дээр гарч тэндээсээс цэцэрлэгт орцгоов.

Уулзвар бүхэн дээр хөгжим тоглож, амттан дарс өрөөстэй ширээнүүд тавилж, зугаацан яваа хүмүүс зогсон хэсэг хэсэг Сэрээ дуртай газартаа бүжиглэнэ.

Кармела, Сонино нутгийн хүүхний хувцас өмсөж, сувдан эмжээрт тоорцог тавьж, алтан зүү, очир алмас гялтагнуулан зүүж, түрэг торгоор хийсэн бүсэн дээрээ том цэцэг хатгаж, бүслэхийг нь бачуухан барьсан цамц банзал хоёроо кашмир даавуугаар хийжээ.

Найз хоёр охины нэг нь Неттуно, нөгөөх нь Риччия нутгийнхны хувцас өмсжээ.

Ромын хамгийн баян гэр бүлийн дөрвөн залуу эр тэднийг дагаж ямарч оронтой зэрэгцүүлшгүй италийн чөлөөтэй байлдлаар харьцан явна. Тэд бас л Альбано, Веллетри, Чичита-Кастеллана нутгийнхны хувцсаар хувцаслажээ.

Эрэгтэйчүүдийн хувцас ч эмэгтэйчүүдийн хувцас шиг алт, үнэт чулуугаар чимэглэн гялалзуулсныг хэлэх юун.

Кармела ижилхэн хувцастай хүүхнүүдээр кадрил бүжиг хийхийг хүссэн боловч дөрөв дэх авгай олдохгүй байв.

Кармела цугларсан олныг харвал тохирох хувцастай нэг ч зочин байсангүй.

Сан-Феличе гүн, тэртээ тэнд Луиджийн гарыг түшээд тариачдын дунд зогсож байгаа Терезаг заав.

«Аав та зөвшөөрөх үү?» гэж Кармела асуухад,

«Тэгэлгүй яахав, өнөөдөр чинь багт наадмын өдөр шүү дээ!» гэж гүн хариулав.

Кармела дагалдан яваа залуугийн чихэнд тонгойж хэдэн үг аяархан хэлээд, залуу охиныг заав. Залуу хүн хөөрхөн гарын заасан зүг хараад, гүйцэтгэхийн тэмдэг болгож мэхийн ёслоод гүнгийн охины бүрдүүлсэн бүжигт Терезаг урихаар явав.

Терезагийн хацар нь улайв. Тэгээд Луизи өөд яах вэ гэсэн маягтай харав. Татгалз х бололцоогүй байв. Луизи түүний гарыг аяархан тавихад, бүх биеэрээ чичрэн энэхүү урьж ирсэн ганган хүнийг дагаж дээдсийн бүжигт байраа эзлэн зогсов.

Уран зураач хүний нүдэнд бол яг тохируулан өмссөн Терезагийн хувцас Кармела түүний найз охидын хувцаснаас илүү сайхан санагдах нь мэдээж хэрэг. Гэвч Тереза бол хөнгөн хийсвэр, нэр төрд дуртай охин байлаа. Энэтхэгийн нимгэн кисея, түрэг, угалзтай хатгамал бүс, сайхан кашемир энэ бүгд түүний нүдийг гялбуулж, индринал, очир эрдэнэд ухаан алдана.

Луижид урьд өмнө байгаагүй хачин сэтгэгдэл төрнө. Энэ өвчин анхандаа зүрхийг нь базлан, дараагаар нь судас шөрмөсөөр нь дамжиж, бүх биеийг нь эзлэн авав. Тереза хамт бүжиглэж байгаа хүн хоёрын өчүүхэн хөдлөх бүрийг ширтэн харна. Гар гараасаа барилцахад нь толгой нь эргэж, судсанд нь цус долгион, чихэнд нь хонхны дуу жингэнэх шиг болно. Тэр хоёр ярилцаж Тереза гоёмсог залуугийн яриаг даруу байдлаар чагнан нүдээ доош болгоход, Луизи залуугийн нүд очтон Терезаг магтаж хөөргөж байгааг ойлгов. Тэгэнгүүт хөл дорх газар нь зайлан, тамын бүх дуу хоолой түүнд өшөө авах, алахын тухай шивнээд байх шиг болов. Биеэ барьж чадахгүй болчих вий гээд, нэг гараараа дэргэд нь байсан ногооны хайснаас бариад нөгөө гараараа бүсэндээ хавчуулсан чинжаал хутганыхаа сийлбэртэй ишийг аяндаа маажиж, өөрөө анзааралгүй хуйнаас нь сугалах шахна.

Луизи хардаж байлаа! Нэр төрд дуртай, биеэ т@осон Терезаг алдаж болох юм гэж мэдрэв.

Тэр завсар анхандаа айж хулчийж байсан Тереза удалгүй зовохоо болилоо. Охины гоо үзэсгэлэнтэй гэдгийг бид дээр хэлсэн билээ. Энэ бол манай хуурамч, хиймэл гунхсан, сайхан байдлаас мянга дахин илүүгээр сэтгэлийг татах, угийн гунхсан туялзуур үзэсгэлэн ажээ.

Бүсгүй бүжгийн охь манлай нь боллоо. Хэрвээ охин Сан-Феличе гүнгийн охинд атаархаж байсан бол, Кармела түүнийг огтхон ч хар хоргүй харж байсан гэж бид батлан хэлж чадахгүй байна.

Бүжиг төгсөхөд гоёмсог хархүү тал зассан манж үг урсган Терезаг хуучин зогсож байсан газарт нь хүргэж өгөв. Луизи энд хүлээж байв.

Бүжиг хийж байх зуураа Тереза хэдэн удаа түүн уруу эргэж зовж зүдрэн, царай нь зэвхийрэн байхыг харжээ. Тэр бүү хэл нэг удаа түүний нүдний өмнө аймшигт хутганы ир гялалзах шиг болжээ.

Охин дурласан хар хүүгийнхээ гараас сэтгэл хөдлөн барьж авав.

Бүжиг нь амжилттай болсон учир зочид дахин бүжиглэж өгөхийг хүсэв. Кармела ганцаараа татгалзав. Гэвч Сан-Феличе гүн гуйж шалсаар Кармелаг арай гэж зөвшөөрүүлэв.

Тэгмэгц бүжиглэгч залуусын нэг нь Терезагүйгээр энэ бүжгийг бүжиглэж болохгүй учир урихаар гуйж ирэхэд Тереза алга болчихсон байв.

Луижи хоёр дахь шалгалтыг давж чадахгүйгээ мэдээд, нэг талаар ятгаж, нөгөө талаар хүчлэн байж Терезаг цэцэрлэгийн нөгөө талд аваачсан байжээ. Тереза түүний үгийг дургүйхэн дагасан боловч Луижийн царай хачин болж дуу шуугүй гар нь салганан чичирч байгаагаар дотор нь юу болж байгааг тааварлан мэдэв. Охины сэтгэл ч бас хөдөлжээ. Тэр өөрөө ямарч муу юм хийгээгүй боловч ингэж зэмлэх нь зөв гэж ухамсарлан мэдэрч байв.

Гэвч Луижи бүхэл оройн турш юу ч дуугарахгүй байгаад Тереза багагүй гайхав. Зөвхөн үдшийн сэрүүн орж зочид цэцэрлэгээ орхиж, дотор орж бүжиглэхээр явцгаахад Луижи Терезаг гэрт нь хүргэж өгөөд,

«Тереза чи гүнгийн охины өөдөөс харан бүжиглэж байхдаа юу бодож байв?» гэж асуув. Тэгэхэд охин илэн далангүйгээр,

- Ийм хувцсанд би амьдралынхаа хагасыг өгчихнө дөө гэж бодож байсан гэж хэлэв.

«Ингэхэд чамтай бүжиглэж явсан хүн юу гэж байна»

«Ийм хувцастай болох нь надаас шалтгаална. Үүний тулд ганц л үг хэлбэл болох нь тэр» гэсэн.

«Түүний хэлдэг үнэн. Тэгээд чи ийм хувцастай болохыг хүсэж байна уу»

«Хүсэж байна»

«Чи тийм хувцастай болно!»

Тереза гайхан толгойгоо дээш болгоод юм асуух гэтэл Луижийн царай хачин баргар, аймшигтай байсан учир үг нь уруул дээр нь тээглэн зогсчихлоо.

Тэгээд Луижи тэр дороо яваад өглөө.

Тереза хойноос нь харж зогсож байснаа түүнийг харанхуйд далд орчхоор нь санаа алдаад гэртээ оров.

Тэр шөнө гайтай явдал боллоо. Зарц гал унтраахаа мартаж, Сан-Феличийн ордонд түймэр гарч үзэсгэлэнт Кармелагийн өрөө байдаг жигүүр шатжээ. Охин шөнө дунд сэрээд гал дүрэлзэн байхыг харж, ухасхийн босоод халаатаа нөмрөн үүд уруу гүйв. Гэвч гарах гэсэн гудам нь галд автсан байв. Тэгэхээр нь өрөөндөө буцаж орж ирээд чанга хашхирч тусламж гуйжээ. Гэтэл газраас хорин фут байдаг цонх нь гэнэт нээгдэж, нэгэн тариачин хүү тасалгаанд харайн орж ирээд, түүнийг гар дээрээ өргөн хүнээс гарамгүй хүч самбаатайгаар гадаа зүлгэн дээр аваачив. Кармела ухаан алдчихжээ. Түүнийг ухаан ороход эцэг нь дэргэд нь байж байв. Эргэн тойронд нь зарц нар нь цугларч түүнд тус болохыг хичээнэ. Ордны тэр жигүүр бүрэн шатчихав. Кармела л амьд мэнд байсан хойно тэр тухай хэн юу бодох билээ?

Түүнийг аварсан хүнийг энд тэндгүй эрсэн боловч огт олдсонгүй. Хүн бүрээс асуусан боловч хэн ч түүнийг үзсэнгүй. Кармела маш их сандарчихсан байсан тул царайг нь харж амжаагүй байжээ.

Гүн маш их баян хүн байсан болохоор охинд нь тохиолдсон аюулыг л тооцохгүй бол ямарч мэдэгдэхээр гарз учраагүй бөгөөд охин нь ингэж гайхамшигтайгаар аврагдсан явдлыг бурхны шинэ лүндэн лугаа адилаар санажээ.

Маргааш нь Тереза Луижи хоёр болзоотой цагтаа ойн захад уулзав. Луижи түрүүлж ирээд Терезаг баяртай угтан мэндлэв. Тэр өчигдрийн явдлыг огт мартчихсан мэт байлаа. Тереза бодлогошрон байх боловч Луижийг эелдэг зөөлөн, хөгжилтэй байхыг хараад бас хөгжилтэй цовоо боллоо. Ер нь ч түүнийг ямар нэгэн шунал хүсэл зовоохгүй бол үргэлж хөгжилтэй цовоо сэргэлэн байдаг байлаа.

Луижи гараас нь хөтөлж, агуйнхаа аман дээр авчрав. Охин ер бусын явдал бо«ж байгааг ойлгоод түүнийг ширтэн харна.

«Чи өчигдөр, гүнгийн охиных шиг хувцастай болбол энэ ертөнц дээр байгаа юм бүхнийг өгнө гэж хэлсэн, байх аа?» гэж Луижи хэлэв.

«Тийм ээ, гэвч энэ бол хөнгөн хийсвэр хүсэл байсан юм» гэж Тереза гайхан хариулав.

«Харин би чамд «Тийм хувцастай болно» гэж хариулсан гэхэд улам их гайхсан Тереза,

«Тийм ээ. Чи надад аятайхан санагдаг гэсэндээ л тэгж хариулсан биз» гэж хэлэхэд Луижи бардмаар,

«Би чамд хэзээ ч хоосон ам хэлж байгаагүй Агуйд ороод хувцал» гэж хэлэв.

Энэ үгийг хэлээд чулууг зайлуулж гоёмсог толины хоёр талд асаасан лааны гэрлээр гийгүүлсэн агуйг Терезад заав. Луижийн гараар хийсэн бүдүлэг ширээн дээр хүзүүний сувдан чимэг, алмаз чулуун зүү хэвтэж байв. Хажуугийн сандал дээр хувцас нь харагдав.

Тереза баярлан хашхираад, энэ гоёлыг хаанаас авав гэж ч асуулгүй, тэр ч байтугай Луижид баярласнаа ч хэлэлгүй агуй уруу үсрэн оров.

Палестриныг халхалсан гүвээн дээр нэгэн морьтой хүн зогсоод аль замаар явахаа мэдэхгүй гайхаж байгаа бололтой байхыг Луижид хараад агуйнхаа амыг чулуугаар нь таглачихав. Өмнөд нутгийн цэнхэр огторгуйн мандалд л харагддагаар морьтой хүн тов тодхон харагдлаа.

Морьтой хүн Луижийг хараад түүн уруу хатируулан ирэв.

Луижид андуурсангүй, Палестринаас Тиволи орох замаар явж байсан тэр хүн төөрсөн байжээ.

Луижид түүнд зам зааж өссөн боловч өмнөм зам нь бас л салж хэдэн тийш яах тул морьтой хүн дахин төөрөхгүйг бодож Луижийг газарчилж өгөөч гэж гуйв.

Луижид цуваа тайлж чулуун дээр тавиад, карабин буугаа үүрч, мориноос ч хоцордоггүй уулын хүний алхаагаар зэрэгцэн явав.

Арван минутын дараа Луижид морьтой хүн хоёр замын уулзварт хүрэв.

Тэгэхэд залуу хүү хаан хүний явах ёстойг нь зааж,

- Энэ таны явах зам. Эрхэмсэг та одоо төөрөхгүй гэж хэлэв.

«Харин энэ чиний шагнал» гэж морьтой хүн хэлээд, хэдэн жижиг зоос сарвайв. Тэгэхэд Луижид түүний гарыг хойшлуулж,

- Баярлалаа, би хүнд тус хүргэхээс биш худалддаггүй юм гэж хэлэв. Тэгэхэд хот газрын хүний долигонуур зан, хөдөөний хүний эрс шууд зан хоёрын ялгааг мэддэг байж таарах өнөөх морьтой хүн

«Хэрвээ чи хөлс авахаасаа татгалзаж байвал, бэлэг өгөхөд авах биз дээ?» гэж асуув.

- Энэ бол өөр хэрэг?»

Тэгвэл энэ Венецийн хоёр цехинийг авч болзоот охиндоо ээмэг хийлгэж өг

«Аа та энэ чинжаалыг ав. Альбаноос Чивита Кастеллана хүртэлх газраас та ийм сийлбэртэй хутга олохгүй» гэж малчин хариулав.

«Би чиний бэлгийг хүлээн авъя. Тэгэхээр би чамд өртэй хоцорлоо. Энэ хутга хоёр цехинээс илүү үнэтэй шүү дээ» гэж морьтой хүн хэлэв.

«Хэрвээ худалдвал ч тийм л дээ Гэхдээ үүнийг би өөрөө хийсэн болохоор нэг пиастраас илүү үнэ ороогүй юм.»

«Чамайг хэн гэдэг вэ?» гэж морьтой хүн асуухад малчин хүү, Македоны Александр хэлж байгаа юм шиг,

«Луижи Вампа гэдэг, таныг хэн гэдэг вэ?» гэж хариулав.

«Намайг Синдбад-далайчин гэдэг» гэж морьтой хүн хариулжээ.

Франц д Эпине гайхан дуугарч,

- Синдбад-далайчин гэнэ ээ? гэж лавлан асуув.
- Тийм ээ, гэж буудлын эзэн хариулаад -Тэр өөрийгөө тэгэж нэрлэсэн гэнэ билээ гэв.
- За яав? Энэ нэр яагаад эвгүй санагдчихав? Гэж Альбер завсраас нь орж хэлээд - Их сайхан нэр шүү, жинхэнэ Синдбадад тохилдсон учрал явдлыг би нэгэн үе их сонирхдог байсан юм гэв.

Франц дуугүй боллоо. Синдбад-далайчийн нэр түүнд маш ойлгомжтой шалтгаанаар бөөн дуртгал төрүүлсэн билээ.

- Цааш нь ярь гэж эзэнд хэлэв.
- Вампа хоёр цехинийг хармаандаа хайнга хийгээд эргэж аажуухан явсан байна. Тэгээд агуйгаас гурван зуухан алхмын зайтай явахад хүний хашхирах дуу сонстов.

Вампа зог тусан чагнажээ.

Хормын дараа нэрээр нь дуудаж байхыг тодхон сонсов.

Энэ дуу агуйн зүгээс сонстож байлаа.

Гөрөөс мэт хурдлан гүйж, явдал дундаа бугаа цэнэглэн, хоёрхон харайгаад гүвээний орой дээр гарав.

Хашхирах дуу улам тодхон боллоо.

Доошоо хартал нэг эрэгтэй хүн Терезаг Несс кентавр Деянирийг хулгайлан авч яваа юм шиг өргөн яваа нь харагдав.

Хулгайч ой уруу гүйж агуй ой хоёрыг заагласан замын дөрөвний гурвыг туулчихсан явж байлаа.

Вампа нүдээрээ газрыг хэмжиж үзэв. Тэр хоёрын хооронд хоёр зуугаас багагүй алхам газар байлаа. Терезаг авч яваа хүнийг гүйцэхээс өмнө далд орчихоор байлаа.

Залуу малчин зог тусан ургаа мод шиг зогсов. Буугаа авч, аажуухан шагайгаад гохоо дарчлаа.

Хулгайлагч гэнэт дороо зог тусав. Өвдөг нь нуга тусаж Терезатай хамт ойчжээ.

Харин Тереза ухас хийх хөл дээрээ босов. Хулгайлагч боссонгүй хэвтсэн хэвээр бөгөөд амьсгаа тавихынхаа өмнө татваганаж байлаа.

Вампа Тереза өөд ухасхийн очив. Тереза үхэж байгаа хүнээс арваад алхам холдоод сөхрөн унав. Хулгайчийг алсан сум болзоот охиныг нь дайрчихав уу гэдэг аймшигт сэтгэл төрөв.

Аз болоход ийм явдал болсонгүй. Зөвхөн айснаасаа болоод Терезагийн тамир алдарчээ. Охиныг эсэн мэнд байгааг мэдээд, шархадсан хүн уруу очив.

Гэтэл цаадах нь хэдийн амьсгаа хураачихсан байв. Нударга нь зангидаатай, ам нь мурийчихсан, үс нь өрвийчихсэн, үхэхийн өмнө хөлс нь чийхраад дух нь нойтон байв.

Нүд нь хараастай, айдас төрүүлэм хэвээр байв.

Вампа, үхсэн хүн нь Кукуметто болохыг танив. Хоёр залуу өөрийг нь аварсан өдрөөс хойш тэрээр Терезад дурлаж, охиныг өөрийн болгоно гэж андгайлсан байжээ. Тэгээд цуцалтгүй харуулдан отож байжээ. Ийнхүү Луижийг морьтой хүнд зам зааж өгөхөөр явахад охиныг хулгайлан авч, одоо минийх боллоо гэж явтал, Вампын мэргэн сум зүрхэнд нь тусжээ.

Вампа түүнийг өчүүхэн ч сэтгэл догдлосон царайгүй харж зогсоход Тереза бас л айсан хэвээр хүүрэнд хүрч чадахгүй, чичрэн дагжсаар хайрт хүнийхээ мөрөн дээгүүр эмээн харна.

Вампа түүн уруу эргэж,

«Чи хувцаслачихсан байх шив гэж хэлээд, одоо миний ээлж боллоо» гэв.

Тереза үнэхээр л хөлөөсөө толгойг@о хүртэл Сан-Феличе гүнгийн охиы хувцасыг өмсчихсэн байв.

Вампа Кукуметтогийн хүүрийг өргөн агуйд авч оров. Харин энэ удаа Тереза тийшээ орсонгүй.

Хэрвээ энэ үеэр өөр нэг морьтой хүн гарч ирсэн бол хачин юм үзэх байлаа. Кашимер даашинзтай, сувдан ээмэг хүзүүн чимэг зүүж, очир эрдэнэ зүү гээгэндээ хатгасан, бадмаараг чулуун товчтой цээживч өмссөн охин хонь хариулж явлаа.

Флорианы үед ирж гэж бодоод Парист очсон хойноо Альпийн малчин охиныг Сабины уулын хормойд үзсэн гэж итгүүлэн ярих байсан байх.

Нэгэн мөчийн дараа Вампа агуйгаас гарч ирэв. Терезагаас дутахгүй дэгжин хувцаслажээ. Вампа цутгамал алтан товчтой ногоон хилэн цамц, утас ороосон торгон хантааз өмсөж, ром маягийн хүзүүний ороолт ороон, алтан тээглүүртэй улаан ногоон алаг бүс бүслэж, алмас эрдэнэн горхитой өвдөгцөө хүрсэн цэнхэр хилэн өмд, хээ тавьж өнгийн саа сүлжсэн түрий өмсөж, өнгө өнгийн туузтай бүрх малгай тавьжээ. Бүсэнд нь хоёр цаг, маш сайхан чинжаал хутга зүүсэн байв.

Тереза гайхан шагширсандаа хашхирав. Кукуметтогийн хувцас өмссөн Вампа, Леопольд Робер, Шпецийн зурагтай адилхан байв.

Болзоот охиндоо ямар сэтгэгдэл төрүүлснийг хараад бардмаар инээмсэглэж,

«Миний хувь заяа ямраар ч эргэсэн ч чи надтай хуваалцах уу?» гэж охиноос асуув.

«Тэгнэ ээ» гэж Тереза дуугар в.

«Чи хаана ч гэсэн намайг дагаж явах уу?»

«Ертөнцийн хязгаарт ч хүрсэн хамаагүй»

«Тэгвэл гараа өг, явцгаая, цаг алдасны хэрэггүй»

Хүүхэн дйрлалт хар хүүдээ чухам хаашаа явахыг нь ч асуулгүйгээр гараа өгөв. Энэ үед Вампа, охинд бурхан тэнгэр шиг гоо сайхан, бардам, бяр чадалтай харагдана.

Тэр хоёр ой уруу орж хэдэн минутын дараа модны цаагуур орж далд оров.

Вампа уулын зөрөг бүрийг мэддэг байсныг хэлэх юун. Мод уруу улам гүн орж, хэдийгээр хүний мөр гарсан нэг ч зөрөг байхгүй боловч, хормын төдий ч эргэлзэхгүй явна. Мод бутаар зам чигээ олох ажээ. Ийнхүү цаг хагас явав.

Яван явсаар ойн хамгийн гүнд хүрчээ. Хатсан голын гулдрал харанхуй хавцалд аваачив. Вампа энэхүү хоёр эргийн хооронд гүн ухагдсан, дээгүүрээ нарсны мөчрөөр далдлагдсан хүн яваагүй замаар явав. Хэрвээ налуу уруу байгаагүй бол Виргилийн ярьдаг Аверны зөрөг гэж хэлж болох байлаа.

Тереза анхандаа энэ зэрлэг, хүн амьтангүй газраар явахдаа айж, дагуулж яваа хүндээ наалдаж явсан бол тайван жигд алхаж яваагийн нь хараад, түгшүүрээ нуухтайгаа боллоо.

Гэнэт тэднээс арван алхмын зайд байгаа модны цаанаас хүн гарч ирээд Луижи өөд буу зангаж,

«Нэг ч алхаж болохгүй, алхвал ална» гэж хашхирав.

«Боль доо, чоно чоноо мэрдэг гэж үү» гэж Вампа гараа өргөж тайван хайхрамжгүй хэлэхэд, Тереза айснаа нууж чадалгүй бүх бие нь чичрэн хайрт хүндээ наалдна.

«Чи хэн гээч вэ?» гэж манаач асуув.

«Би Сан-Феличийн эдлэнгийн хоньчин Луижи Вампа байна.»

«Чамд юу хэрэгтэй юм бэ? »

«Би Рокка-Бианкад байгаа танай нөхөдтэй ярих хэ°эгтэй байна»

«Тэгвэл намайг даJaад яв, үгүй, очих газраа мэдэх хойно түрүүлээд яв» гэж манаач хэлэв.

Вампа зэвүүрхсэн байртай ярвайн инээмсэглээд Терезатайгаа хамт урьд нь гарч энэ хүртэл явж ирсэн шигээ итгэлтэй тайван алхлав.

Таван минутын дараа дээрэмчин тэднийг зогс хэмээн тушаалаа.

Дээрэмчин хэрээ шиг гурван удаа гуагалав.

Хариуд нь бас л тэгж гуагалах сонстов.

«За одоо цаашаа явж болно» гэж дээрэмчин хэлэхэд Луижи Тереза хоёр цааш явав.

Цаашлах тусам Тереза дурлалт хархүүдээ улам наалдана. Үнэндээ модны завсраар бууны ам цухуйж байх харагджээ.

Рокка-Бианка хэмээх ойн цагаалж нь нэгэн багавтар уулын орой дээр байдаг ажээ. Энэ нь Ромул Рем хоёр Альбийг орхиж Ром хотыг барихаас өмнө галт уул байсан бололтой газар юм.

Тереза Луизи хоёр орой дээр нь гараад хориод дээрэмчинтэй нүүр учран уулзав.

«Энэ залуу та нарыг эрж, та нартай уулзах хэрэгтэй гэнэ» гэж манаач хэлэв. Тэгэхэд толгойлогчийг эзгүй хооронд орлож байсан дээрэмчин,

«Энэ хүн бидэнд юу хэлэх гээ юм бол?» гэж асуув.

«Би малчин байхаас уйдчихлаа» гэж Вампа хариулжээ.

«За ойлголоо. Чи бидний бүлэгт элсье гэж ирээ юү?» гэж толгойлогчийн туслах хэлэхэд,

«Дуртай зөвшөөрнө!» гэж Луижийг таньдаг байсан Феррузино, Пампинар Ананьийн дээрэмчид зэрэг зэрэг хашхиралдав.

«Тэгэхдээ би та нарын зөвхөн найз нөхөр байхыг хүсэхгүй»

«Тэгээд чи юу болох гэсэн юм бэ?» гэж дээрэмчин гайхан асуухад,

«Би та нарын толгойлогч болохыг хүсэж байна» гэж Луизи Вампа хариулав.

Дээрэмчид учиргүй хөхрөлдөв.

«Чи ийм хүндтэй байхаар ямар гавьяа байгуулсан хүн бэ? Гэж толгойлогчийн туслах асуухад,»

«Би Кукуметтог алсан, худлаа гэвэл хувцас нь энэ байна. Бас өөрийнхөө болзоот охинд хуримын хувцас бэлтгэх гэж Сан-Феличегийн ордныг шатаасан» гэж Луизи хариулжээ.

Цагийн дараа Кукуметтогийн оронд Луизи Вампыг толгойлогчоор сонгосон байна гэж ярихад Франц найздаа,

- Хонгор Альбер минь та одоо эрхэм Луизи Вампын тухай ямар сэтгэгдэлтэй байна? гэж асуухад,

- Домог үлгэр шиг л байна. Тийм хүн хэзээ ч байгаагүй гэж Альбер хариулав.

- Домог үлгэр гэдэг чинь юу юм бэ? Гэж Пастринийг асуухад,

- Найрсаг эзэн минь тайлбарлахад дэндүү удаан цаг хэрэгтэй гэж Франц хариулаад - Тэгэхээр эрхэм Вампа одоо Ромын орчноор ажил явдлаа хийж байна гэж ярив уу? гэж асуув.

- Урьд өмнө нэг ч дээрэмчин тэгж байгаагүйгээр омогтой төрхгүйгээр хийж байна.

- Цагдаа нар барих гэж оролдоод чадахгүй байна уу?

- Яах ч арга алга! Хөдөө хээрийн малчид, тибрийн загасчид, эрэг орчмын хориотой бараа тээж худалдагсадтай нөхөрлөдөг юм. Түүнийг ууланд эрж явахад, гол дээр байж байдаг. Тэгээд гол дээр ирэхээр их далайд гараад явчихдаг, эцэст нь Жильо, Жанутри эсвэл Монте-Кристо арал дээр гараад явчлаа гэж бодоход буцаад ирчихсэн Альбано, Тиволи эсвэл Риччинд байж байдаг юм.

- Жуулчидтай ямраар харьцдаг хүн юм бол?

- Маш ердийн. Хотоос хэр хол байгааг харгалзан золиос төлөх найм, арван хоёр, хорин дөрвөн цагийн хугацаа өгдөг юм. Дараа нь хугацаа дуусахаар бас нэг цагийн хугацаа сунгаж өгдөг. Энэ цагийн жар дахь хувьд мөнгө төлөгдөөгүй байвал баривчлагдсан хүний духанд сум зоож эсвэл цээжинд нь хутга шаана. Тэгээд л гүйцээ!

- За Альбер, ямар байна гэж Франц хэлээд - Та Колизей руу, гаднах цэцэрлэг дундуур нь явах хүсэлтэй хэвээрээ л байна уу? гэж асуув.

- Хэрвээ энэ зам үзэсгэлэнтэй сайхан бол мэдээж хэрэг шүү дээ гэж Альбер хариулав.

Энэ үед есөн цаг дуугарлаа. Хаалга онгойж хөтөч орж ирэв.

- Сүйх тэрэг ирсэн гэж хэлэхэд,

- За тэгвэл Колизей уруу явах уу гэж Франц хэлэв.

- Дель-Попологийн хаалгаар уу, эсвэл гудамжаар явах уу?

- Гудамжаар, гудамжаар, чөтгөр ав! Гэж Франц дуу алдав.

Альбер гурав дахь тамхиа асаагаад,

- Найз минь, би таныг арай ч зоригтой гэж бодож байсан юм гэж Альбер хэлэв.

Залуу хүмүүс шатаар бууж сүйх тэргэнд суув.

13. Хий үзэгдэл

Франц эртний дурсгалуудын дэргэдүүр өнгөрч, аварга том баганыг харснаас дутаалгүйгээр Альберийг Колизей өөд аваачих арга ямар ч байсан олжээ. Ингэхийн тулд виа Систинаар явж, Санта Мариа Мажорын урдуур эгц эргэж, виа Урбана ба Сан-Пьетроин -Винколигоор явж, виа дель Колосод хүрэх хэрэгтэй байв.

Энэ зам бас нэг давуу талтай нь гэвэл Монте-Кристо арлын нууц эзнийг дурдсан Пастрини гуайн ярианаас Францын с наа бодлыг салгах юм юу ч байсагүй. Тэр суудлаа налж тухлан суугаад, өөртөө тавин тохирох хариулт олж чадахгүй байгаа олон түгшүүрт асуудалдаа гүнзгийрэн орж бодлогошров.

Дашрамд дурдахад, энэ ярианы өөр нэгэн зүйл Синдбад далайчны бодуулахад хүргэжээ. Тухайлбал дээрэмчид ба далайчдын хоорондын нууцлаг харьцаа юм. Пастрини гуайг, Вампа загасчид ба хориотой бараа тээн худалдагсдаас амь хоргодох газар олдог гэж ярихад, бяцхан хөлгийнхөнтэй хамт оройн хоол идэж суусан корсийн хоёр дээрэмчинг хүргэх гэж замаасаа хазайж Порто-Веккиод орсон дарвуулт онгоц санаанд нь оров. Монте-Кристо арлын эзэн хэмээн өөрийгөө нэрлэсэн тэр хүн бас «Лондон» зочид буудлын эзний ярианд дурдсан тэр хүн бол корс, тоскан, испаний эргээр буянт үйл үйлдэж явдаг шигээ Пьомбино, Чивта-Веккий, Остин ба Гаэтагийн эргээр бас л буян үйлдэж явдаг хүн байх нь. Мөн Тунис, Палермогийн тухай ярьсан байсан нь Францад санагдаж, бодвоос зэгсэн өргөн танил талтай хүн бололтой байлаа.

Энэ бүхэн Францын ухаан бодлыг хэдийчинээ эзэлж байсан ч буг чөтгөрийн нүднээс тусах гэрэл мэт урт цагаан гэрэл орой дээрх нурсан хэсгээр нь гэрэлтсэн Колизейн асар том баргар дүрс өмнө нь босож ирэхэд эд бүхэн тэр дороо мартагдав. Сүйх тэрэг Мета Седан-аас хэдэн алхмын зайтай зогсож хөтөч хаалга огойлгож өгөв. Залуу хүмүүс гарч, газраас гарч ирсэн мэт өмнө нь бий болсон тайлбарлагчтай нүүр тулан уулзав.

Тэднийг зочид буудлаас тайлбарлагч дагаж явсан болохоор хоёр үйлчлэх хүнтэй болжээ.

Ер нь Ромд газарчдаас зайлахын аргагүй байдаг. Зочид буудлын босго алхаж ормогц угтан аваад хотоос гарч явтал чинь дагалдан үйлчлэх гол үйлчлэгчээс гадна хөшөө дурсгал бүрд тусгай тайлбарлагч байдаг юм. Ер нь хөшөө дурсгалын хэсэг бүрт ч тусгай тайлбарлагч бий гэж хэлж болох байх. Ийм учраас энэ дурсгалын тухай Марциал□,

«Мемфис пирамидуудынхаа онгон сайхнаар бидний өмнө гайхуулахгүй. Бас вавилоны гайхамшгууд ч магтагдахгүй, харин Цезарийн амфитеатрын хэмжээлшгүй их барилгын өмнө хүн бүхэн бөхийх ёстой, энэ дурсгалыг магтан дуулахын тулд бүх л дуу хоолойг нийлүүлэх ёстой» гэж хэлсэн байхад дагалдан явж тайлбарлах хүн хичнээн байх нь мэдээж хэрэг.

Франц Альбер хоёр Колизей дундуур бамбар барьж явах эрхтэй, ромын гол тайлбарлагчдаас зайлсхийх гэж оролдсонгүй. Ийм учраас татгалзсангүй, тэдний бүрэн мэдэлд оров.

Франц арваад удаа энд ирсэн болохоор энэ зугаалгыг сайн мэдэх билээ. Харин хамт яваа хүн нь Флавие Веспасианы босгосон энэ барилгад анх орж байгаа болохоор тайлбарлагчид дэмий чалчих боловч Колизей түүнд асар их сэтгэгдэл төрүүлэв. Үнэндээ ч энэ зүйлийг өөрөө нүдээрээ үзээгүй байж эрт цагийн аварга их барилгуудын аугаа ихийг яахан тааварлаж болох билээ. Ялангуяа өмнө зүгийн сарны билүүлэг гэрэлд үзэгдэхдээ өрнөдийн үдшийн гэгээнд харагдахын адил улам ч сүрлэг бөхлөхыг нь яана.

Франц дотор талын баганат гудамлагаар зуу шахам алхаад Альберийг арслангийн нүх, гладиаторуудын байр, цезарийн суудал зэргийг нэгд нэгэнгүй харуулахыг хүссэн дагуулууды нь мэдэлд орхив. Тэгээд эвдэрхий шатаар өгсөн дээр гарснаа боржин чулуун аваргыг бүх л агуу сайхнаар нь харж болох том баганын сүүдэрт нөгөө эвдэрхийн эсрэг талд очиж суув.

Франц, Колизейн нөгөө үзүүрт байгаа жижиг дуганаас гарч, гал даган сажлах сүүдрүүд шиг гишгүүр дамжсаар голомтын шүтээн тавьсан газар уруу яваа Альбер түүний бамбар баригчдыг харан нэгэн мөч хэртэй суув. Гэтэл түүний өгсөж ирсэн шатны хажуугийн эвдэрхий шатнаас чулуу өнхрөн доош унах нь сонстов.

Олон он жилийн цагийн эрхэнд чулуу ойчих нь ховор биш тохиолдол боловч энэ удаа саях чулуу хүний хөлөөр хөндөгдөн унав уу даа гэлтэй санагджээ. Бас аяархан алхах хөлийн чимээ ч сонстох шиг болов. Энэ хүн аль болохуйц сэмээрхэн гишгэхийг эрмэлзэн, шатаар яваа бололтой.

Нээрээ ч минутын дараа хүний дүрс харагдаж, шатаар өгсөх тутам нь улам тодорно. Шатны дээд талыг сар гийгүүлж доошлох тусам улам бүрдэгхэн харанхуй ажээ.

Тэр хүн бас л өөр шиг нь тайлбарлагчийн тэнэг ярианаас зайлхсхийж, ганцаараа байхыг илүүд үзсэн хүн байж болох юм. Иймээс ч хүн гарч ирсэнд гайхсангүй. Гэвч шатны дээд гишгүүр дээр шийдвэргүйхэн гарч тавцан дээр зогсоод юм чагнаж байхыг нь хараад Франц түүнийг ямар нэгэн хэрэгтэй ирж, хүн хүлээж байна гэдгийг нь ойлгов.

Франц хар аяндаа баганын цаана орж нуугдав.

Газраас арван алхмын өндөрт том дугараг цоорхой байх бөгөөд түүгээр од түгсэн тэнгэр харагдана.

Хэдэн зуун жил сарны гэрэл гийгүүлсэн байж мэдэх энэ нүхний хажуу талаар бут ургаж ногоон навчис нь хөх цэнхэр тэнгэрт тодрон зурайн харагдана. Дээд талаас нь аварга том ороонго өвс ургамлууд салхинд хийссэн аргамж мэт унжин байна.

Битүүлгээр хүрч ирж Францын анхаарлыг татсан хүн, нүүрийг нь харанхуйлсан сүүдэрт зогссон боловч хувцсыг нь ялган таньж болох байв. Өргөн бараан цув нөмөрч, зүүн мөрөн дээгүүрээ давуулан хаясан өрөөсөн хормойгоороо нүүрээ таглажээ. Дух ба нүдийг нь бүрх майлгайны нь өргөн хүрээ халхална. Чийдсэн шаахай уруу нь дэгжин унжсан хар өмд нь цоорхойгоор орж ирсэн ташуу гэрэлд харагдана.

Энэ хүн язгууртны хүрээнийх биш гэхэд лав л дээдсийн хүрээлэнд багтдаг нь эргэлзээгүй байв.

Хэдэн минут зогсоод хүлээж ядан байгаа нь илэрхий болж иртэл дээд талын хэрдэг дээгүүр сулхан чимээ гарав.

Тэгтэл ч сүүдэр сарны гэрлийг халхалж, нэгэн хүн гарч ирээд харанхуй уруу ширтэн харснаа үл таних цувтай хүнийг олж үзэх шиг болов. Тэгээд унжиж байгаа бүдүүн чөдөр өвснөөс дүүжлэн доош буугаад газраас гурван фут хэртэй өндөрт ирмэгц сурмаг байдлаар үсрэв. Тэр хүн транстиверен бүрэн хувцас өмсжээ.

- Эрхэмсэг таныг хүлээлгэсний минь уучлахыг гуйя гэж ром аялгуугаар хэлээд - Гэвч би хэдэн минут хожигдлоо. Сан-Жованни Латераногийн цамхаг дээрх цаг саяхан арав болсныг зааж цохилоо гэв.

- Та хожигдоогүй би түрүүлж ирсэн юм. Тийм болохоор бүү зов. Хэрвээ та хожигдсон ч байлаа гэсэн, таны буруугаар биш гэдгийг би мэдэж байна гэж танихгүй хүн цэвэр тоскан аялгуугаар хэлэв.

- Та андуурсангүй, би гэгээн Ангелийн цайзаас ирлээ. Би арай гэж Беппотой хэдэн үг сольж амжлаа.

- Беппо гэдэг чинь хэн билээ?

- Шорногийн хуяг. Би түүнд жаахан мөнгө өгсөн юм. Тэр надад гэгээнтний шоронд юу болж байгааг хэлж байх болно.

- Та их болгоомжтой хүн юм аа!

- Өөрөөр яах билээ, дээдэс минь. Юу болохыг яаж мэдэх вэ? Намайг хожим Пеппино шиг бариад авахыг хэн байг гэх вэ, тэгвэл надад олс мэрэх үхэр хулгана хэрэгтэй шүү дээ.
- Товчоор хэлбэл, та юу мэдэж ирэв дээ?
- Ромд их баяр болохын өмнө хүн цаазалдаг заншил ёсоор энэ мягмар гаригийн хоёр цагт хоёр хүн цаазаар авах гэнэ. Нэг нь mazzolato болно. Энэ бол хүмүүжүүлсэн багш ламаа алсан бузар амьтан. Би үүнийг анхаарсангүй. Нөгөөдөх нь de caritato болно. Энэ нь манай муу Пеппино юм байна.
- За, хайрт нөхөр минь яадаг билээ? Та нар зөвхөн папа ламын засгийн газар байтугай зэргэлдээ улсыг ч хүртэл айлгаж байгаа учраас эрх баригчид заавал нийтэд үлгэр жишээ болгохоор цаазална гээд байна.
- Гэхдээ Пеппино чинь манай бүлгийн хүн ч биш шүү дээ. Тэр бол зүгээр л нэг ядуу малчин хүн, бидэнд хүнс залгуулсан нь л буруу болж байгаа юм.
- Энэ л түүнийг та нарын хань хамсаатан болгож байгаа хэрэг. Гэвч түүнд хөнгөлөлт үзүүлж байгаа шүү дээ. Хэрвээ таныг хэзээ нэгэн цагт барьж авбал толгойг чинь бяц цохиж ална даа. Тэгвэл түүнийхийг гильотиноор авах юм. Түүнээс гадна, ийм зугаатай юманд нэг шинэ юм нэмж хүн бүхний сонирхолд тохирно доо.
- Гэвч хүн зоны огт бодоогүй миний бэлдэж байгаа үзвэр улам ч илүү сонирхолтой болно доо гэж цаадах хүн зөрж хэлэв.
- Найрсаг нөхөр минь, та ямар нэгэн тэнэг явдал бэлтгэж байна гэж хэлэхийг зөвшөөрнө үү гэж цувтай хүн хэлэв.
- Надад тус болж яваад гайд учирсан Пеппиног аврахын тулд юу ч хийсэн бэлхэн байна. Хэрвээ энэ үнэнч хүний төлөө ямарч юм хийж чадахгүй бол өөрийгөө аймхай хулчгар гэж үзнэ.
- Та тэгээд юу бодож олсон юм бэ дээ?
- Би цаазын индрийн дэргэд хориод хүн зогсооно. Тэгээд Пеппиног тууж авчрахаар намайг дохио өгөнгүүт цөмөөрөө хутга барьж дайран орж булаан авна.
- Энэ чинь маш эгзэгтэй ажил байна. Миний арга арай дээр байх гэж бодогдож байна.
- Эрхэмсэг танд ямар төлөвлөгөө байна вэ?

- Би нэг хүнд хоёр мянган пиастр өгч Пеппиногийн цаазыг ирэх жил хүртэл хойшлуулж өгөхийг гуйлгана. Харин энэ завсар бас нэг өөр хүнд мянган пиастр өгч Пеппиног шоронгоос оргуулна.

- Та үүнийг амжилттай болно гэж итгэлтэй байна уу?

- Pardieu гэж цувтай хүн хэлэхэд,

- Та юу гэж хэлэв ээ? гэж нөгөө хүн өөдөөс нь асуув.

- Найз минь би, өөрийнхөө а«тны тусламжаар хутга, гар буу, урт буугаар зэвсэглэсэн танай хүмүүсээс илүү их юм хийж чадна гэж хэлсэн юм. Ийм учраас энэ хэргийг надад даатга.

- Дуртай зөвшөөрнө. Харин таны ажил амжилтгүй болбол бид юу ч гэсэн бэлхэн байж байя.

- Хэрвээ тэгж хүсээд байвал бэлхэн л байж бай даа. Би өршөөл гуйж чадна гэдэгтээ эргэлзэхгүй байна.

- Мягмар гаригт гэдгийг бүү мартаарай, нөгөөдөр шүү дээ. Танд ганцхан өдөр л үлдэж байна.

- Тэгээд яагаа вэ? Өдөр бол хорин дөрвөн цагаас, цаг бол жаран хувиас, хувь бол жаран хормоос бүрдэнэ. Тэгэхээр наян зургаан мянга дөрвөн зуун хоромд их юм хийж болжо шүү дээ.

- Хэрвээ эрхэмсэг та бүгдийг амжуулж орхивол бид түүнийг тань яаж мэдэх билээ?

- Маш амархан. Би Ролсполи гуанзны захын гурван цонхыг хөлсөлж авсан. Тэгэхээр өршөөл гуйж чадвал захын хоёр цонх нь шар торгон хөшиг татаатай, дундах цонх нь дундаа улаан хэрээстэй цагаан хөшиг татаатай байна.

- Маш сайн. Харин өршөөл үзүүлсэн бичгийг нь надад яаж дамжуулж өгөх вэ?

- Та нэг хүнээ мөргөлчний хувцас өмсүүлж над дээр ирүүлээрэй. Тэр хүн чинь хувцасныхаа ачаар цаазын индэр дээр очиж алуурчид нь тэрхүү өршөөлийн бичгийг өгөх болно. Харин тэр завсар Пеппинод мэдэгдээрэй тэгэхгүй бол цаадах чинь айснаасаа болоод үхчих ч юм уу, солирчихвол түүний төлөө дэмий мөнгөө үрсэн хэрэг болно.

- Эрхэмсэг та сонсож бай, Үи танд бүх зүрх сэтгэлээрээ үнэнч шударга гэдгийг та мэднэ шүү дээ.

- Тийм байх гэж найдаж байна.
- Тэгэхээр ийм байна, та Пеппин@г аварчих юм бол үнэнч шударга байгаад зогсохгүй шууд захирагдах болно.
- Найз минь бодолгүй юм бүү ярь. Чи надад хожим нэгэн цагт хэрэг болж болох учраас хэлсэн үгийг чинь сануулан хэлж магадгүй шүү.
- Тэгвэл би өнөөдөр таны ирсэн шиг хэрэгтэй цагт чинь хүрч ирнэ. Та ертөнцийн хязгаарт байсан ч гэсэн «Тийм тийм юм хий» гэж бичвэл л болох нь тэр. Би түүниг чинь өөрийнхөө... нэр шиг л яг биелүүлнэ.
- Чш! Хүн явж байх шиг байна гэж цувтай хүн хэлэв.
- Энэ бол жуулчид бамбарын гэрэлд Колизейг үзэж явна.
- Хамт байгаагаа эдэнд харагдах хэрэггүй. Энэ тайлбарлагчид цөм тандуулууд, тэгэхээр таныг таньчихаж магадгүй. Таны нөхөрлөл надад хэчнээн сайхан боловч бид хоёрын танил талыг хүмүүс мэдчихвэл миний нэр хүндэд хор болж магадгүй.
- Хэрвээ та цаазыг хойшлуулж чадвал...
- Дунд талын цонх улаан хэрээстэй, цагаан хөшигтэй байна.
- Хэрвээ амжихгүй бол?
- Гурван цонх цөмөөрөө шар хөшигтэй байна.
- Тэгвэл...
- Тэгвэл найрсаг нөхөр минь хутгаа ажилд оруулаарай, би өөрөө хүртэл сонирхохоор очно.
- Баяртай дээдэс минь. Би танд найдаж байна, та надад найдаарай.

Транстеврийн хүн ийм үг хэлээд шатан дээрээс алга болж, цувтай хүн бүрх малгайгаа дух уруугаа улам дараад Францын хажуугаар хоёрхон алхмын зайтай өнгөрч, талбай уруу тайван явав.

Хормын дараа харанхуй дундаас Францыг дуудах сонстов. Энэ нь Альбер дуудаж байжээ.

Франц царайгий нь үзээгүй боловч, хэлсэн үг болгоны нь сонсож авах хүний дэргэд ярьсан гэдгийг нөгөө хоёр хүнд мэдэгдэхгүйн тулд нэлээд хол очтол нь хариу дуугарч зүрхэлсэнгүй.

Франц арван минутын дараа сүйх тэргэнд сууж, замдаа Альберийн, Плиния ба Канурния хоёрт түшиглэн зэрлэг амьтдыг үзэгчид уруу довтлуулахгүйн тулд хурц ирмэгтэй тор хийх тухай эрдмийн зэрэг горилсон номоо тайлбарлан ярихыг нь арай ядан сонсож, буудал хүртэл явлаа.

Франц найзынхаа үгнээс зөрсөнгүй. Тэр бушуухан ганцаараа үлдэж, өөр юу ч анхааралгүй, дөнгөж сая сонссон зүйлээ эрэгцүүлэн бодохыг хүсэв.

Түүний харсан хоёр хүний нэг нь огтын танихгүй хүн бөгөөд нөгөө нь арай л ондоо санагдана. Франц харанхуйд далдлагдан, цуваар халхалсан тул царайг нь харж чадаагүй боловч урьд нь анх сонсохдоо ихэд гайхаж байсан хоолойны нь өнгийг дор нь таньжээ. Ялангуяа энэ ёжтой маягийн өнгөнд нь ямар нэгэн огцом ширүүн, төмөр мэт хатуу аялга сонсож, Монте-Кристо арлын агуйд цочин дагжсан шиг нь Колизей дотор бас цочиход хүргэжээ.

Энэ хүн бол Синдбад-далайчнаас зайлахгүй гэдэгт Франц огтхон ч эргэлзсэнгүй.

Франц үүнээс өөр ямарч үед сонирхлыг нь ихэд татсан тэр хүнд өөрийн байгааг мэдэгдэх байсан ажээ. Гэвч нэгэнт сонссон зүйл нь үлэмж нууц зүйл байсан учир түүнийг гараад очвол тэд огтхон ч баярлахгүй байсан болохоор болгоомжилсон нь зөв болжээ. Тийм учраас Синдбад-далайчинг зогсоолгүй зүгээр явуулж орхисон боловч, дараа дайралдвал зүгээр өнгөрүүлэхгүй гэж хатуу шийдэв.

Франц бодолдоо гүн автсан учир унтаж чадахгүй байв. Бүхэл шөнийн туршид агуйн эзэн ба Колизейд байсан үл таних хүн хоёр нэг л хүн гэдгийг нотлох баримтуудыг ухаан дотроо эрэгцүүлэн бодов. Хэчнээн их бодох тусам, өөрийнхөө бодолд улам их итгэнэ.

Тэгээд үүрээр унтсан учир орой болгов. Альбер чухамхүү парис хүний заншлаар үдшийнхээ ажлын тухай бодож, Аржентинын театрт лож олуулахаар хүн явуулжээ.

Франц нутаг уруугаа захидал бичих ёстой байсан учир сүйх тэрэг бүтэн өдөр Альберийн мэдэлд байв.

Альбер таван цагт буцаж ирэв. Тэр баталгаа болгон явуулсан захидлуудыг тараан өгч, бүх л үдэшлэгүүдэд урилга хүлээн авч, Ром хотын сайн сайхантай танилцав.

Энэ бүхнийг хийхэд Альберт ганцхан өдөр хүрэлцэв.

Тэр ч байтугай ямар ший гарах, ямар ямар жүжигчид тоглохыг нь хүртэл мэдэж амжжээ.

«Паризина» гэдэг шийнд Козеллий, Морианн ба хатагтай Шпех нар тоглох байв.

Залуу хүмүүсийн аз болж «Лючин Ламмермурыг зохиогчийн шилдэг дуурьт Италийн шилдэг гурван жүжигчин тоглох ажээ.»

Буффед өөрийн сандалтай, Оперийн ложинд өөрийн суудалтай Альбер задгай лож ч байхгүй, давхар асарч байхгүй италийн театруудтай эвлэрч чадахгүй байв.

Гэлээ ч Францтай хамт театрт очих бүрдээ гялалзсан сайхан хувцсаа өмсөхөд нь энэ саад болохгүй байв. Гэвч энэ бүхэн нь үр ашиггүй хоосон өнгөрнө. Парисын дээд хэсгийн шилдэг сайхан залуугийн нэг болох Альбер итали орноор дөрвөн сар тэнүүчлэхдээ нэг ч адал явдал хийж чадаагүй нь ичгэвтэр ажээ.

Альбер энэ талаар тоглоом болгоод үзэв. Гэвч хор шар нь үлэмж их хөдөлжээ. Гялалзсан залуусын нэг болох Альбер де Морсер хүсэж хүлээсэн хэвээр байна гэдэг чинь юу гэсэн үг вэ. Манай нутгийн хонгоруудад зохицох даруу байдлаараа Альбер Италид их амжилт олж, гэртээ харьсан хойноо Гаткийн цэцэрлэг хавийнхандаа ялалтаа гайхуулан ярина гэж бодож байсан учраас энэ амжилтгүй явдал нь улам ч хурцаар мэдрэгдэнэ.

Гэтэл тэр ихэд андуурчээ. Генуэ, Флоренц ба Ромын гоо үзэсгэлэнт хатагтай нар нөхөртөө биш гэхнээ, явдаг харчуулдаа үнэнчээ бат хадгалан байх учир Альбер итали хүүхнүүд өөрийн үнэнч бишдээ үнэнчээрээ франц хүүхнүүдээс давуутай юм гэдэгт итгэх болов.

Италид бусад орнуудтай адил жичдээ явдал байдаггүйг нотлоход хэцүү л дээ.

Альбер бол зөвхөн гоёмсог сайхан залуу төдий биш, бас хурц ухаантай хүн байв. Бас тэгээд бэйс, тэгэхдээ шинэхэн үеийн бэйс л дээ. Баатар зоригоо нотлон харуулах явдал шаардагдахгүй болсон манай үед өөрийнхөө удмыг 1399 оноос эсвэл 1815 оноос тоолоход ямар ялгаа байх вэ? Түүнээс гадна жилд тавин мянган ливрийн @рлоготой. Ийм маягаар манай хүнд парисын дээд зЭндааныхны дунд дураараа явахад хэрэгтэй бүхэн байлаа. Гэвч очсон хотуудад нь түүнийг зохих ёсоор анхааран үзээгүй хот үгүйг бодохоос түүнд ичгүүртэй байжээ.

Альбер өөрийгөө Ромд шагнах юм бодож байжээ. Орон бүхэнд заншсан энэ баярын үеэр ямарч хатуу чанга журамтай хүмүүс өөрсдийгөө сул тавьдаг юм.

Тэгэхээр маргааш багт наадам эхлэх гэж байгаа болохоор Альбер өөрийгөө гял цалаар үзүүлэх хэрэгтэй боллоо. Энэ зорилгоор нэгдүгээр давхрын хамгийн гоц ложид суудал авч, маш нямбай сайхан хувцаслаж очив. Ташрамд хэлэхэд нэгдүгээр давхар нь бенуар, бельэтаж шиг язгууртнуудын суудал юм.

Арван хоёр хүн уужуухан багтах энэ лож Амбигюгийн театрын дөрвөн суудалтай ложноос хямд туссаныг хэлэх хэрэгтэй.

Альбер өөр нэг юманд горьдож байв. Хэрвээ гоо үзэсгэлэнт ром хүүхний зүрхийг эзэлж чадвал сүйх тэргэнд нь уригдаж, язгууртны сүйх тэрэг эсвэл тайжийн тагтан дээрээс багт наадам үзэх юуны магад хэмээн бодож байжээ.

Альбер энэ хий бодлынхоо ачаар тэр орой их л хөгжилтэй байв. Тайз уруу нуруугаа харуулж суугаад ложноосоо цээжээ гарган зургаан ямхын дурангаар сайхан авгайчуулыг дурандаж гарав.

Ингэж хичнээн их хүч гаргавч, нэг ч хүүхэн түүнийг ядахдаа шохоорхож ч болов харсангүй.

Үзэгчид ажил явдал, дурлал, зочлуулсан тухаага маргааш болох багт наадмын тухай ярилцаж, дуучид ба жүжгийг анхаарахгүй суцгаах бөгөөд хааяа зарим үед цөм эргэн харж Козеллийн дуулахыг чагнаж, Морианид баяр хүргэн алга ташиж, эсвэл дуучин Шпехт «сайхан байна» гэж хашхирнаа. Тэгээд л цөм таслагдсан яриагаа дахин үргэлжлүүлнэ.

Нэгдүгээр үзэгдэл төгсөх үед одоо хүртэл хоосон байсан ложийн үүд нээгдэж нэгэн хатагтай орж ирэхэд, Франц өөрийн таних хүн мөн болохыг танив. Франц түүнтэй Парист танилцсан бөгөөд түүнийг тэндээ л байгаа юм бодож байжээ. Альбер найзыгаа өөрийн эрхгүй хөдлөхийг хараад түүн уруу эргэж:

- Та энэ хүүхнийг таних уу? гэж асуув.
- Танина, танд таалагдаж байна уу?
- Сайхан хүүхэн байна найз минь, бас тэгээд хонгор шар үстэй юм. Ямар сайхан үс вэ! Франц хүүхэн үү?
- Үгүй, Венецийн хүүхэн.
- Хэн гэдэг юм бэ?
- Гүнгийн хатан Г гэдэг юм.

- Би энэ хүүхний нэрийг нь мэднэ. Гоо сайхнаасаа гадна ухаалаг гэж ярьцгаадаг юм. Би Вильфор хатагтайн сүүлчийн үдэшлэг дээр энэ хүүхэнтэй танилцаж болох байсан юм, гэвч тэгээгүй! Ямар тэнэг юм хийгээ вэ?

- Хэрвээ таныг хүсвэл энэ алдааг чинь засаж өгье? Гэж Франц асуув.

- Та энэ хүүхэнтэй, намайг ложинд нь аваачихаар тийм сайн танил юм уу?

- Би түүнтэй гурван удаа ярилцах завшаан тохиолдсон юм. Тэгэхээр биднийг очиход бүдүүлэг зан гаргалаа гэхгүй байхаа.

Энэ үеэр хатагтай Францыг харж, гараараа даллан мэндлэв. Хариуд нь Франц хүндэтгэн мэхийв.

- Та энэ хүүхэнтэй зүгээргүй харьцаатай юм аа даа? Гэж Альбер хэлэв.

- Та эндүүрч байна. Франц хүмүүс хилийн цаана явахдаа юм бүхнийг Парисийнхаараа хэмждэг учраас мянган тэнэг явдал гаргадаг юм. Испани ялангуяа Италид байхдаа хүний чөлөөтэй харьцааг ойр дотно харьцаа гэж бүү үзэж байгаарай. Гүнгийн хатан бид хоёр зүгээр л бие биедээ талтай байдаг юм.

- Зүрхээрээ талтай юу? гэж Альбер инээмсэглэн асуухад,

- Үгүй, зөвхөн ухаанаараа гэж Франц нухацтай хариулав.

- Үүнийгээ яаж мэдээ вэ?

- Та бид хоёрын явсан шиг Колизейгээр зугаалж явах үед мэдсэн юм.

- Сарны гэрэлд үү?

- Тийм ээ.

- Хоёулхнаа юу?

- Бараг л тийм дээ.

- Тэгээд та нар юу... ярив даа?

- Үхэгсдийн тухай ярилцсан.

- Энэ ч мэдээж маш сонин л доо гэж Альбер хэлээд - Гэхдээ би тийм зугаалгын үед ийм сайхан авхайг дагаж явсан сан бол түүнтэй зөвхөн амьдын тухай л ярих байсан даа гэв.

- Магадгүй, алдаа болсон ч юм билүү.
- Харин одоохондоо та амласан ёсоороо намайг түүнтэйгээ танилцуулж өгнө биз дээ?
- Хөшиг буумагц л танилцуулъя.
- Энэ золигийн нэгдүгээр үзэгдэл хэзээ дуусах бол?
- Төгсгөл ойртож байна, чагнаач. Их сайхан Козелли мөн ч сайхан дуулна шүү.
- Тийм ээ, ямар сайхан бие вэ!
- Зүрх сэтгэл догдлуулахы нь яана...
- Зонтаг, Малибран хоёрын дуулахыг сонссоны дараа...
- Мориани сайхан сургуулиар сурсныг олж харахгүй байна гэж үү?
- Бор хүүхнүүд, цагаан хүүхнүүд шиг дуулахад би дургүй.

Гүнгийн хатны сууж байгаа ложноос дурангаа салгахгүй байгаа Альбераас эргэж Франц,

- Таны сэтгэлд тааруулахад хэцүү юм байна даа, хонгор минь гэв.

Арай гэж хөшиг буусан нь бэйс де Морсерын сэтгэлийг ихэд тавтай болгов. Альбер бүрхээ авч, үсээ янзлаад, зангиа ханцуйгаа засаад явахад бэлэн гэж Францад хэлэв.

Франц асуусан маягтай харвал гүнгийн хатан түүнийг хүлээж байна гэж дохисон болохоор тэсэж ядан байгаа Альберын хүслийг хангахаар явав. Франц хувцсаа илж засаж яваа найзыгаа дагуулан гудмаар тойрч хатны сууж байгаа ложны үүдийг тогшив.

Гүнгийн хатны хажууд сууж байсан залуу тэр дороо хаалга онгойлгон өгч, италийн заншил ёсоор ирсэн зочинд суудлаа тавьж өгөв. Хэрвээ өөр хүн орж ирвэл саяын суусан хүн бас л суудлаа тавьж өгөх ёстой ажээ.

Франц, Альберыг нийгмийн байдал ба ухаанаараа хамгийн гялалзсан залуу хүмүүсийн нэг гэж танилцуулав. Энэ нь ч үнэн. Альбер, Паристаа байсан бол дээдсийн хүрээлэнгийн алдартнуудын нэг нь билээ. Альбер Францад байхдаа танилцаж чадаагүйдээ хармсаж одоо тохиолдол гарсан дээр намайг тантай

танилцуулж өгөөч гэж гуйсан юм. Тэгэхдээ ингэж зориглосныг уучлаарай гэснийг хэлэв.

Хариуд нь хатан Альбер өөд мэхийгээд Францын гарыг атгаж, Альберыг хажуудаа байсан сул сандал дээр суухыг урьж, Франц хатны ард хоёр дахь эгнээнд суув.

Альбер яриа дэлгэх сайхан сэдэв олж, Парисын тухай, танил хүмүүсийнхээ тухай ярив. Франц өөрийн найзыг зөв зам дээрээ гарсныг мэдээд хүчит дурангий нь гараас нь авч үзэгчдийн танхимыг дурандаж эхлэв.

Нэгдүгээр давхрын нэгэн ложид дорнодын хувцастай ер Үишийн гоо сайхан хүүхэн сууж ба©в. Бүсгүй хувцсаа ердийн өмсдөг хувцас шигээ чөлөөтэй өмссөн байв. Бүдэг харанхуйн дунд ард нь сууж байгаа хүний нүүр нь харагдахгүй байв.

Франц, гүнгийн хатан Альбер хоёрын яриаг тасалж, зөвхөн эрэгтэйчүүдийг ч биш, бас эмэгтэйчүүдийн анхаарлыг татах энэ гоо сайхан албани хүүхнийг таних уу гэж хатнаас асуув.

- Үгүй, энэ улирлын эхнээс л Ромд байх болсон юм. Театрын нээлтээр энэ хүүхэн энэ ложид сууж байсан. Тэрнээс хойш бүтэн сарын туршид нэг ч жүжиг алгасалгүй үзсэн. Заримдаа ард талд нь сууж байгаа хүн, заримдаа зөвхөн негр зарц нь дагаж явдаг.

- Хатагтай танд энэ хүүхэн хэр зэрэг таалагдаж байна?

- Хачин их таалагдаж байна. Медора л ийм байсан байх.

Франц, гүнгийн хатан хоёр бие биеэ харж инээмсэглээд, дараа нь хатан Альбертай яриагаа үргэлжлүүлэхэд, Франц гоо сайхан албани хүүхнийг дурандаж гарав.

Алдарт Анрийн тавьсан, италийн алдарт бүжгийн жүжиг эхлэв. Энэ бол эхнээсээ аваад эцсээ хүртэл бүх бүжигчид цөм үйлчлэн оролцож, зуун тавин хүн нэг зэрэг адил хөдөлгөөн хийж гараа өргөвөл, гараа өргөж, хөлөө өргөвөл нэгэн зэрэг хөлөө өргөдөг тийм бүжиг юм. Энэ бүжгийн нэр нь «Полиска»!

Энэ бүжгийг жүжиг хэчнээн сайхан байлаа ч Франц үл таних гоо үзэсгэлэнт бүсгүйг хараад жүжгийг анхаарсангүй. Бүсгүйн тухайд гэвэл, жүжгийг харваас ихэд дуртайя харж суусан бөгөөд харин хамт яваа хүн нь бүжгийн энэ сайхан жүжгийн үед огтхон ч хөдөлсөнгүй, бүрээ, янчир түрэг хонхны галзуирсан мэт их дууг үл хайхран сууж, тэнгэрийн тайван сайхан нойрыг эдэлж байгаа юм шиг байв.

Эцэст нь бүжгийн жүжиг дуусч, хөшиг хаагдан, сэтгэл нь хөгжсөн үзэгчид нижигнэтэл алга ташив.

Дуурийн жүжигт, бүжгийн жүжгийг орулан тавьдаг магтууштай заншлын ачаар, жүжгийн завсарлагаа маш богинохон байдаг. Бүжигчид бүжиглэж байхад, дуучид амарч, хувцсаа сольж амждаг ажээ. Хоёрдугаар үзэгдлийн эхлэл хөгжим эгшиглэв. Удирдаач эхлэн дохимогц, албани хүүхний хамт яваа хүн аяархан өндийж түүн уруу бөхийхөд, өнөөх хүүхэн гэдрэгээ эргэж хэдэн үг хэлчихээд дахин ложоо түшин суув.

Ярилцаж байгаа хүний царай бас л сүүдэрт байсан учир Франц ялгаж харж чадсангүй.

Хөшиг нээгдэж, Францын анхаарал өөрийн эрхгүй жүжигчид уруу татагдаж, танихгүй хүүхний ложноос нүд нь салж, тайз өөд харав.

Хоёрдугаар үзэгдэл нь Паризина зүүдэн дотроо Аццотай Угод сэтгэлтэй болсон тухайгаа ярьж байгаа хослол дуугаар эхэлдэг. Хууртагдсан нөхөр нь хардан сэрдэх гээчийг үзэж эцэст нь эхнэрээ урвасныг мэдээд, унтаж байхад нь сэрээж өшөөгөө авах тухайгаа илэрхийлэн хэлнэ.

Энэ бол Доницеттийн үр бүтээлт үзгээр бичсэн хамгийн сайхан хамгийн тодорхой, хамгийн урамтай хослол дуунуудын нэг юм. Франц үүнийг гурав дахь удаагаа сонсож байгаа хэдий ч энэ хослол дуу түүнд гүн сэтгэгдэл төрүүлдэг ажээ. Ийм ч учраас хөгжин хөхиж байгаа үзэгчидтэй ая нийлүүлэн алга таших гэснээ өргөсөн гар нь зогсож «сайхан байна» гэж хэлэх гэсэн үг нь хоолойд нь тээглээд гарч өгсөнгүй.

Ложид сууж байсан хүн бүх биеэрээ босож, урьд өдөр нь Колизейн эвдэрхий балгасан дотор бараагий нь харж, дуугий нь сонссон өнөөх Монте-Кристо арлын оршин суугч битүүлэг хүн мөн байхыг Франц танив.

Эргэлзэх юм алга хачин жуулчин Ромд байгаа юм байж.

Үл таних хүнээс болж аягүйрхсэн нь Францын царайд илэрсэн бололтой, гүнгийн хатан түүн өөд харж инээгээд, юу болов гэж асуухад,

- Хатагтай би танаас дөнгөж саяхан тэр албани хүүхнийг таних уу гэж асуусан. Одоо би нөхрийг нь таних уу гэж асуух гэсэн юм гэж Франц хариулав.

- Хүүхний нь дайтай л мэднэ гэж гүнгийн хатан хариулав.

- Та үүнийг анзаарч хараагүй юу?

- Ёстой франц хүний асуулт байна даа! Бидний, итали хүүхнүүдийн хувьд хайрлаж дурладаг хүнээс маань өөр юм байдаггүй юм шүү дээ.

- Энэ үнэн гэж Франц хариулахад гүнгийн хатан Альберын дуранг нөгөө талынхаа лож өөд чиглүүлэн,

- Ямарч байдаг байсан лав л түүнийг саяхан булшнаас гарсан хүүр гэлтэй юм. Хараач, ямар цонхигор цагаан юм бэ гэж хэлэв.

- Ерөөсөө ийм царайтай хүн байгаа юм гэж Франц хариулахад,

- Тэгвэл та түүнийг таньдаг юм уу? Хэн гээч болохыг нь надад хэлж өгөөч, гуйя хэмээн гүнгийн хатан хэлэв.

- Би үүнийг нэг л газар үзсэн шиг санагдаж байна гэмэд хатан жихүүцсэн юм шиг гоо сайхан мөрөө хөдөлгөөд,

- Би ойлгож байна. Энэ хүнийг нэг л үзвэл хэзээ ч мартагдахгүй юм байна гэв.

Энэ үл таних бүдүүлэг хүн зөвхөн өөрт нь л жигтэй хачин сэтгэгдэл төрүүлээд байдаггүй юм байна гэж Франц бодов. Тэгээд гүнгийн хатныг дахин тэр хүн уруу дурандах гэтэл Франц,

- Та юу гэж бодож байна? гэж асуув.

- Мах цусанд төрсөн Лорд Рутвен ирсэн нь энэ байх гэж бодож байна.

Үүнийг дурдсан нь Францад гайхал төрүүлэв. Хэрвээ хэн нэг хүн вампирууд бий гэдэгт итгүүлж чадвал, тэр нь ёстой энэ хүн мөнөөс мөн.

- Энэ хүн хэн болохыг би мэдэх ёстой гэж хэлээд Франц босов.

- Үгүй, үгүй, битгий яв, би танаар хүргүүлэх гэж бодсон юм, таныг явуулахгүй гэж гүнгийн хатан дуугарав.

Франц бөхийж түүний чихэнд,

- Та нээрээ айж байна уу? гэж асуув.

- Сонсож бай! Байрон намайг вампир бийд итгэ гэсэн юм. Өөрөө тэднийг үзсэн гэдэг юм. Надад тэдний царай зүсийг тодорхойлон бичсэн... Энэ төрх нь яг л ийм хар үс, хурц нүд, үхээрийн цонхигор цагаан царай байдаг гэнэ билээ. Хамт яваа авгай нь ч бас бусадтай адилгүй... энэ лав ямар нэг грег хүүхэн буюу эсвэл... лав нөхөр шигээ шидэт эм байгаа байх... Би таныг гуйя, тийшээ бүү яваач, хэрэгтэй л юм бол маргааш эрж сур, өнөөдөр л явуулахгүй гэж хатагтайг хэлэхэд Франц зүтгэснээрээ л байв. Тэгэхэд хүүхэн босож,

- Үгүй, үгүй би явлаа. Жүжиг дуустал энд байж болохгүй. Манайд зочид ирнэ. Та надтай хамт байхгүй гэж Ийм бүдүүлэг зан гаргах гэж үү? Гэв.

Тэгэхэд Франц бүрхээ авч, ложны хаалга онгойлгоод гүнгийн хатанд гараа өгөхөөс өөр арга багцсангүй. Тэгээд ч гараа өглөө.

Гүнгийн хатан үнэхээр маш их сэтгэл нь хөдөлж, Франц ч бас мухар сүсгээсээ болон эвгүйрхэж хатныг учир зүггүй айж эхлэхэд нь түүний бодол санаа өмнөх дурсамжаараа улам ч бэхжин байв. Франц, хүүхнийг тэргэнд суулгаж өгөхдөө бүх бие нь дагжиж байгааг мэдлээ.

Франц гүнгийн хатныг гэрт нь хүргэж өгөхөд ямарч зочин байхгүй, хэн ч түүнийг хүлээгээгүй байв. Франц түүнийг ийнхүү хуурсанд нь зэмлэв.

- Миний бие үнэхээр муу байна. Би ганцаараа байхыг хүсэж байна. Тэр хүнийг харсандаа сэтгэл бүр эвгүй болчихлоо гэж хатанг хэлэхэд Франц инээх гэж оролдов.

- Битгий инээ, энэ танд бол бүр ч инээдтэй хэрэг биш гэж хатагтай хэлээд - Та надад нэг юм амлаж чадах уу? гэв.

- Юу тэр вэ?

- Та юуны өмнө андгайл.

- Тэр хүний хэн болох мэдэх оролдлогоос няцах л биш юм бол таны хэлсэн бүхнийг гүйцэтгэнэ. Би танд хэлж болохгүй зарим шалтгаанаар тэр хүн хэн болох, хаанаас ирсэн, хаашаа явж байгааг мэдэх ёстой юм.

- Хаанаас ирснийг нь би мэдэхгүй, харин хаашаа явж байгааг нь танд хэлж болно. Тэр бол там уруу шууд явж байгаа хүн.

- Таны надаас авах гэсэн андгайд эргэж оръё, хатагтай.

- Өө тийм, одоо шууд зочид буудал уруугаа яв, өнөөдөр тэр хүнтэй уулзах хэрэггүй. Салж байгаа болон уулзаж байгаа хүмүүсийн хооронд ямар нэгэн холбоо байдаг юм. Энэ хүн бид хоёрын хооронд зуучлагч бүү болоорой. Маргааш л тэр хүнийхээ хойноос хэчнээн л бол хэчнээн хөөцөлд. Харин намайг айлгаж аах л гэж бодоогүй бол тэр хүнийг хэзээ ч надтай бүү танилцуулаарай. Одоо баяртай! Унтахыг бод. Харин миний нойр хүрэхгүй гэдгийг би мэдэж байна.

Гүнгийн хатан ингэж хэлээд Францаас салж хоцорсон бөгөөд Франц түүний үнэхээр айж байгаа эсвэл тоглоом тохуу хийж байгаа алин болохыг нь ойлгосонгүй.

Франц зочид буудалдаа эргэж ирэхэд Альбер халаад гэрийн өмдийг өмсөж, амандаа ороомол навчин тамхи зуугаад зөөлөн сандал дээр тавтайхан налайн хэвтэж байв.

- Өө, та хүрээд ирэв үү, би тантай маргааш өглөөнөөс нааш уузлахгүй юм байх гэж бодож байлаа шүү гэж хэлэхэд,

- Альбер та сонсож бай, итали хүүхнүүдийн тухай хамгийн буруу бодолтой байгааг тань нэгмөсөн нотлох аз тохиолдсонд би их баярлаж байна. Тэгээд ч бас таны дурлалын амжилтгүй явдлууд таныг ухаан оруулмаар юм санаа гэж Франц хэлэв.

- Та юу гэж айлтгах гэж байна? Энэ хүүхнүүдийн учрыг чөтгөр ч олохгүй байх! Гараас чинь бариад л атгаад л таатай шивгэнэлдээд л, хүргэж өгөхийг шаардаад л байсан. Парисын хүүхэн сайн нэрээ алдахад ийм байдлын аравны нэг нь л хүрэлцэнэ!

- Хамаг учир үүнд л байгаа юм. Тэд юу ч нуудаггүй улс. Эд Дантегийн хэлснээр «si» цуурайтдаг сайхан орондоо, нуугдалгүй нарны туяан дор амьдардаг улс. Ийм учраас тэд цэмцэгнэж маяглах гэдгийг мэддэггүй юм. Тэгээд ч та гүнгийн хатныг үнэхээр айж байгаагийг нь харсан шүү дээ.

- Хэнээс? Бидний нөгөө талд хөөрхөн грег хүүхэнтэй сууж Үайсан эрхмээс үү? Би өөрөө тэдний хэн болохыг мэдэх гэж гудамд зориуд түүнтэй тулгарсан. Та нар яагаад ийм дэмий юм ярьж байгаа юм бэ? Цэвэрхэн царайтай, сайхан хувцасласан эр байх чинь билээ. Лав манай Блее эсвэл Юмани хувцсыг нь оёж өгдөг байхаа. Баахан цонхигор царайтай нь үнэн. Цагаан царай гэдэг чинь язгууртанд хамаарахын тэмдэг гэдгийг та мэднэ шүү дээ.

Альбер өөрийгөө цагаан царайтай гэдгийг нь санаад Францын инээд хүрэв.

- Гүнгийн хатан тэр хүнээс айсан нь хий бодлоос нь л болсон гэдгийг би мэдэж байна л даа. Тэгээд ямар нэг юм яриу?

- Ярьсан, харин тэгэхдээ шинэ грегийн хэлээр ярьсан. Би үүнийг нь хазгай дуудсан хэдэн үгээр нь мэдлээ. Эрхэм нөхөр минь, би сургуульд байхдаа грег хэлэнд гарамгай байсан юм шүү.

- Тэгэхээр шинэ грег хэлээр яриа юу?

- Тэгэх шиг болно билээ.

- Тэгвэл эргэлзэх юм алга, тэр хүн мөн гэж Франц шивнэв.

- Та юу гэнэ ээ?

- Зүгээр. Та тэгээд энд юу хийж байв даа?
 - Би танд нэг сонин юм хэлэхээр бэлдсэн.
 - Ямар?
 - Сүйх тэрэг олдохгүй гэдгийг та мэднэ байх аа?
 - Мэдэлгүй яах вэ. Бид хүний л хүч хүрэх бүхнийг хийсэн боловч юу ч олоогүй шүү дээ.
 - Надад нэг сайхан санаа төрлөө.
- Франц Альбер өөд итгэлгүйхэн шиг харав.
- Хүндэт нөхөр минь, та намайг итгэн харж байна. Би таны энэ харцыг хангах хэрэглэй болно гэв.
 - Бодож олсон зүйл чи нь таны хэлж байгаагаар үнэхээр сайхан санаа бол би тэгж л таарна.
 - За тэгвэл чагнаж бай даа.
 - Сонсож байна.
 - Сүйх тэрэг олж болохгүй, тийм ээ?
 - Болохгүй.
 - Морь ч бас олдохгүй тийм ээ?
 - Олдохгүй ээ.
 - Харин үхэр тэрэг олж болох уу?
 - Магадгүй ээ.
 - Бас хоёр шар олдох уу?
 - Олдох байлгүй.
 - За тэгвэл ийм байна найз минь! Энэ л бидэнд хэрэгтэй болох нь. Би тэргээ эрээлж мяраалж буд гэж тушаая, тэгээд хоёулаа неаполитаны тариачдын хувцас өмсөж, Леонольд Роберын алдарт зургийг нь амьдаар нь үзүүлье. Хэрвээ гүнгийн хатан Попуоли эсвэл Серренто нутгийн тариачин хүүхэн болж хувцаслахыг

зөвшөөрвөл зурагтай улам ч адилхан болж, их амжилт олно. Гүнгийн хатан сайхан хүүхэн болохоор, түүнийг хүмүүс ёстой «Хүүхэд тэвэрсэн эмэгтэй» дүрээрээ байна гэж бодно.

- Бурхан минь гэж Франц дуу алдаад - Энэ удаа таных зөв. Үнэхээр сайхан санаа байна гэв. Энэ бол манай сэлгүүцэгч вангуудын үеийг сэргээж байгаа юм. Ромын эрхэм хүмүүс та нар, бид хоёрыг сүйх тэрэг морь олдохгүй учраас лаццарониуд шиг гудамжаар явган явцгаана гэж бодоо биз? Тэгвэл бид олдохгүй байсан уналга хөсгийг чинь зохиож оллоо.

- Та энэ суут бүтээлээ хэн нэгэн хүнд хэлсэн үү?

- Манай эзэнд хэлсэн. Би театраас хүрч ирээд түүнийг дуудаж энэ саналаа хэлсэн. Тэгэхэд тэр үүнээс хялбархан юм гэж байхгүй гэж байна билээ. Шарныхаа эврийг алтлуулах гэсэн чинь гурав хоног хэрэгтэй гэнэ. Тэгэхээр энэ чимэглэлээс татгалзахаас Үйш яах вэ?

- Тэр чинь хаана байна?

- Хэн?

- Эзэн.

- Тэрэг олох гээд явчихсан. Маргааш болбол хожигдчихож магадгүй.

- Тэгвэл тэр өнөөдөр бидэнд хариу өгөх үү?

- Тэгнээ, би хүлээж байна.

Энэ үед үүд онгойж Патсрини гуайн толгой цухуйж

- Permesso гэж асуув.

- Боллогүй яах эв, ор! Гэж Франц хариу дуугарав.

- За яав? Тэрэг шар олов уу? гэж Альберийн асуухад, эзэн их л хангалуун байдалтайгаар,

- Арай ч дээр юм олсон гэж хаиулав.

- Болгоомжлоорой, хүндэт эзэн минь, сайн юманд садаа мундахгүй шүү гэж Альбер хэлэхэд,

- Эрхэмсэг та надад найдаж болно гэж эзэн их л бардмаар хэлэв.

- Чухам тэгээд юу вэ дээ? гэж Франц асуувал,
- Монте-Кристо гүн та нартай нэг давхарт байгааг мэдэж байна уу? гэв.
- Бид үүнийг яалаа гэж мэдэхгүй байх вэ. Түүний хайр энэрлээр л бид ингэж латины хорооллын □ оюутнууд шиг энд шахцалдаж сууна гэж Альбер хэлэв.
- Та хоёрын амжилтгүй явдлыг сонсоод өөрийн сүйх тэргэнд хоёр байр, бас палаццо Росполид хөлслөн авсан цонхон дээрээ хоёр суудал өгч байна.

Альбер Франц хоёр бие бие өөдөө харав.

- Бид энэ огт танихгүй хүний найр тавьж өгсөн юмыг авч болох уу, үгүй юу гэж Альберыг хэлэхэд,
- Энэ Монте-Кристо гүн гэдэг чинь ямар хүн бэ? Гэж Франц асуув.
- Сицил эсвэл мальтийн язгууртан дээдэс, чухам сайн мэдэхгүй байна. Боргезе е шиг нэр алдартай, ундармал булаг шиг баян хүн юм.
- Пастрини гуайн хэлж байгаад үнэмшвэл, энэ гүн шиг ийм хүн арай өөрөөр урьж болохсон... гэж Франц Альберт хэлэв.

Яг энэ үед үүд тогшив.

- Ор, ор Лэж Франц хэлэхэд, ганган хувцастай зарц босгон «ээр гарч ирээд,
- Монте-Кристо гүн, түшээ гүн Франц л Эпине ба бэйс Альбер де Морсер хоёрт нэрийн хуудас өгөхөд цаадах нь авч, залуу хүмүүст тэрэг дамжуулан өгөв. Тэгэхэд зарц цааш нь үргэлжлүүлэн,
- Монте-Кристо гүн айл хөршийн хувьд маргааш өглөө зочлон орж ирэх зөвшөөрөл гуйж байна. Хэдэн цагт эрхэмсэг залуу хүмүүс түүний биеийг хүлээж авч болохыг мэдэх юмсан гэж хүсэж байна гэв.
- Хэлэх юм алга, бүх юм ёсоор бүтэж байна гэж Альбер хэлээд - Пастрини гуай, таны Монте-Кристо гүн чинь их хүмүүжилтэй хүн юмаа гэхэд,
- Тэгвэл та нар түүний хэлснийг хүлээн авч байх шив? Гэж эзэн асуув.
- Мэдээж хэрэг, гэхдээ тэргээ харамсаж байна. Хэрвээ Росполи палаццогийн цонхны дэргэд хоёр суудал өгсөн явдал Колизей дотор үл таних хүн ба транстенерийн хүн хоёрын яриаг Францад санагдууллаа. Францын бодож байгаагаар, тэрхүү цувтай хүн Аржентинын театрт юм үзэж байсан тэр хүн мөн

бол, одоо түүнтэй уулзаж сонирхсон сэтгэлээ тайвшруулахад юу ч саад болохгүй боллоо.

- Франц орой унтав. Үл таних хүний тухай бодол маргаашийг хүлээсэн сэтгэл хоёр түүнийг түгшүүлнэ. Үнэндээ ч маргааш өглөө нь хамаг юм тодорхой болно. Энэ удаад Монте-Кристо арлын нууц эзэн хэрвээ зүүх дээр харагдахгүй болчихдог Гечесийн нууц бөгжгүй л бол түүнээс зайлж чадахгүй.

Францыг сэрэхэд найман цаг ч болоогүй байв. Өглөө болохыг яаран хүлээх ямарч шалтгангүй Альбер бөх бат нойрсож байв.

Франц эзэнг дуудуулахаар хүн явуулсад цаадах нь ердийн заншлаараа мэхэлзэн бөхөлзсөөр хүрч ирэв.

- Пастрини гуай, би эндүүрээгүй бол өнөөдөр ямар нэг хүнийг цаазаар аваачих биз дээ? гэж Франц асуув.

- Тийм ээ, эрхэм дээдэс хэрвээ түүнийг харах цонх ол гэж байгаа бол одоо хэдийнэ хожимдчихсон.

- Үгүй, би энэ явдлыг үзье гэж тэгтлээ хүссэн бол Монте пинчод суудал олоод авчих байсан гэж Франц татгалзан хэлэв.

- Өө, би эрхэм таныг Монте Пинчогоор дүүрэн байдаг борчуултай хутгалдахгүй байх гэж итгэж байна.

- Үнэнээ хэлэхэд би тийшээ очихгүй. Харин зарим нэг зүйлийг танаас асуумаар байна гэж Франц хэлэв.

- Ямар?

- Цаазлагдах хүмүүсийн тоо, тэдний нэр алдар яаж цаазлагдах тухай.

- Энүүнээс хялбархан юм байхгүй. Дөнгөж сая надад Tavolette авчирч өгсөн.

- Tavolette гэж юү вэ?

- Энэ бол цаазаар авахын өмнө гудамжинд дүүжилдэг модон самбар. Самбар дээр хэрэгтнүүдийн нэр, тэдний хийсэн хэрэг, цаазаар авах арга зэргийг бичсэн байдаг юм. Энэ бол цаазлагдах хүмүүсийг мөргөг гэж тараадаг нэг ёсны гуйлт байгаа юм.

- Таныг сүсэгтэнгүүдтэй нийлэн мөргөг гэж энэ самбарыг авчирч өгөө юү? хэмээн Франц итгээгүй өнгөөр асуувал,

- Үгүй ээ, эрхэм дээдэс. Би зарлал наадаг хүмүүстэй тохирсон учир тэд манай зочдоос цаазыг үзэх дуртай хүн байвал үзэг гэж театрын зарлал авчирч өгдөг шигээ авчирсан юм.

- Та юмыг их урьдаас хардаг хүн юм гэж Франц хэлэв.

- Надад итгэн найддаг сайн төрөлт гадаадын хүмүүсийг тохитой сайхан байлгахын тулд би хүч хүрэх бүхнээ хийдэг гэж хэлж чадна хэмээн Пастрини гуай инээмсэглэн хэлэв.

- Таны иймийг бид харж байна, хүн бүхэнд ярина, санаа бүү зов. Одоо би таны самбарыг уншмаар байна.

- Одоохон гэж хэлснээ эзэн хаалга онгойлгоод - Би нэгий нь шатны талбар дээр хадаарай гэж тушаасан гэж хэлэв.

Тэгээд тасалгаанаас гарч, өлгөөстэй байсан «самбарыг» авчирч Францад өгөв.

Энэ цаазлах зарлалыг үгчлэн орчуулбал:

«Багт наадмын анхны өдөр хоёрдугаар сарын 22-ны мягмар гаригт дээд шүүхийн тогтоолоор Пьяцца-дель Попологийн талбайд доорх хүмүүсийг цаазаар авахыг нийтийн анхааралд мэдэгдэх нь: гэгээн Ианна Латераны сүмийн гэсгүй өндөр дээд, хүндэт хүн Чезаре Торнинийг алсан Андре Рондоло, бас жигшүүрт дээрэмчин Луижи Вампа ба түүний бүлгийн гишүүдтэй хамссан хэрэгт холбогдсон Рокка Приори хэмээх хочтой Пипино болно. Нэгдүгээр нь mazzolato болно.

Хоёрдугаар нь decapitato болно.

Энэ хорон санаат хоёр хэрэгтнийг үнэн зүрхнээсээ наманчлан мөргөх эрхмүүдийг урьж байна.» гэжээ.

Хоёр хоногийн өмнө Колизейн балгасан дотор Францын дуулсан зүйл яг мөн байв. Программд нь ямарч өөрчлөлт гарсангүй. Яллагдсан хүмүүсийн нэр, хийсэн хэрэг, цаазлах арга нь тэр хэвээрээ байжээ.

Ийм болохоор, тэр транстевериний хүн нь Луижи Вампаас өөр хүн биш, нөгөөх цувтай хүн нь Порто-Веккио, Тунист хийдэг шигээ Ромд ч бас буянт үйлээ хийсээр яваа Синдбад-далайчнаас өөр хэн ч биш болжээ.

ТэгтСл есөн цаг цохиж Франц Альберийг сэрээх гэтэл, цаадах нь бүрэн хувцаслачихсан гарч ирэхэд нь гайхав. Багт наадам түүнийг тайван унтуулсангүй, Францын бодсоноос эрт босжээ.

- Эрхэм Пастрини та юу гэж бодож байна, бид хоёр бэлхэн болчихсон болохоор, Монте-Кристо гүн дээр орох уу, яах вэ? гэж Франц эзнээс асуухад,

- Мэдээж хэрэг, Монте-Кристо гүн их эртэч хүн байгаа юм. Одоо лав сэрээд хоёр цаг болж байгаа байх гэж цаадах нь хариулав.

- Бид түүнд төвөг болох юм биш байгаа?

- Огт үгүй.

- Тэгвэл Альбер та бэлхэн бол...

- Би яг бэлхэн байна.

- За тэгвэл очиж хөршийнхөө хүнд анхаарч үзсэний нь хариу баярыг хүргэе.

- Явцгаая!

Франц Альбер хоёр дөнгөж шатны талбайг өнгөрч гарах хэрэгтэй байв. Эзэн тэндээс түрүүлж хонх дарахад зарц хаалга онгойлгож өгөв.

- I signori Francesi ! гэж Пастрини хэлэхэд зарц ёслоод тэднийг орохыг урив.

Тэр хоёр Пастрини зочид буудалд байна гэж бодохооргүй гоё сайхнаар зассан хоёр өрөө өнгөрч, асар сайхнаар чимсэн зочдын өрөөнд оров. Шалан дээр нь түрэг хивс дэвсэж, зөөлөн тохилог сандал тавьсан нь орж ирсэн хүмүүсийг өөрийнхөө уян хатан суудал дээр сууж амар гэж урих адил байв. Ханан дээр нь нэрт зураачдын зурсан зургуудыг гоёмсог зэвсгүүдтэй хослон хаджээ. Хаалганд нь зөөлөн сайхан хөшиг намирна.

- Эрхмүүд сууж ажаам уу, би гүнд айлтгаад ирье гэж зарц хэлэв.

Тэгээд өөр нэг хаалга уруу орчихов.

Хаалга онгойход цаанаас нь хөгжмийн дуу гарснаа тэр дороо таг болчхов. Зочдын өрөөнд хүлээн суугаа залуу хүмүүс хөгжмийн дуу халти сонстоно.

Франц Альбер хоёр бие биеэ харчихаад, дахиад л гэрийн хэрэглэл, зураг зэвсгүүдийг үзэж гарав.

Тэд энэхүү баян тансагийг харах тусам улам ч аугаа сайхан болох мэт санагдана. Франц найзаасаа,

- За, та юу гэж бодож байна? гэж асуув.
- Хүндэт нөхөр минь, хөрш маань нэг бол испанийн фондыг багасгах гэж яваа биржийн зууч, эсвэл хуурамч нэрээр жуулчлан яваа ноён байх.
- Чимээгүй! Одоохон бид үүнийг мэдчихнэ. Ирж явах шиг байна гэж Франц хэлэв.

Хаалга онгойх сонстож, хөшиг нээгдэн, энэ бүх баялгийн эзэн босгон дээр гарч ирэв. Альбер түүн уруу дөхөж очиход, Франц дороо хадчихсан юм шиг зогсож хоцров.

Орж ирсэн хүн бол нөгөө цувтай хүн, ложинд сууж байсан танихгүй хүн, Монте-Кристо арлын нууцат эзэн биеэрээ байлаа.

14. Mazzolato

- Эрхмүүд ээ, та нар дээр түрүүлж очоогүйг минь уучлахыг гуйя. Дэндүү эрт очиж төвөг удахаасаа айсан юм. Тэгээд ч бас та нар өөрсдөө морилон ирнэ гэж надад мэдэгдсэн болохоор тань би та нарын хүслийг харгалзан үзсэн юм гэж Монте-Кристо гүн хэлэв.

- Бид танд мянгатаа баярлаж байна, гүн гуай. Та биднийг үнэхээр золгүй явдлаас аварлаа. Таны найрсаг урилгыг бидэнд дамжуулах үед бид хамгийн үл гүйцэлдэх юм сүвэгчилж байсан юм гэж Альбер хэлэв.

Гүн залуу хүмүүсийг зөөлөн сандал дээр суухыг уриад,

- Пастрини гэдэг энэ балай амьтан л буруутай. Та нарт төвөгтэй явдал тохиолдож байгааг надад хэлсэнгүй л дээ. Тэгтэл би гэдэг хүн энд цор ганцаардаж, хөрштэйгөө танилцахын л хүслэн болж байсан юм. Тэгээд та нарт ямар нэгэн юмаар тус хүргэж болох бололцоо гармагц даруй ашигласан нь энэ дээ гэв.

Залуу хүмүүс гүнээ мэхийн ёслов. Франц ганц ч үг дуугаралгүй, тээнэгэлзсэн хэвээрээ байв. Гүн түүнийг таньсан буюу өөрийгөө танигдсан гэдэг ямар ч царай үзүүлэхгүй байгаа болохоор Франц түрүүн уулзсанаа хэлэх үү эсвэл шинэ нотолгоо олж байж болох уу гэдгээ мэдэхгүй байв. Франц энэ хүнийг урьд өдөр нь театрын ложинд сууж байсныг нь нотлон хэлж чадах боловч харин уржигдар Колизейд байж байсан гэж батлах ямар ч юмгүй байв. Тийм учраас дэндүү урагш гүйлгүй, юу ч хэлэлгүй байхаар шийдэв. Нэмж хэлэхэд гүн, нууж далдлах юмгүй яваа Францын тухай юу ч мэдэхгүй байхад, харин Франц гүнгийн нууцыг мэдэж байгаагаараа давуутай байв.

Юу боловч зарим нэг эргэлзээг шийдвэрлэхээр юм яриад үзье гэж шийдээд,

- Та бидэнд сүйх тэргэндээ хоёр байр, Росполийн палаццод цонх өгсөн болохоор Пьяцца-дель Пополод италиудын ярьдагчлан «Манааны байр» яаж олох аргыг зааж өгөх юм биш биз дээ? гэж асуув.

Өө тийм гэж гүн Морсер өөд ширтэнгээ хайнгад хэлээд - өнөөдөр Пьяцца дель Пополод цаазаар аваачих юм байна шүү гэж хэлэв. Ийнхүү хүссэн сэдвийг нь хөндөж ярьсанд баярласан Франц,

- Тийм эS гэж хариулав.

- Би өчигдөр даам лдаа энэ талаар хөөцөлдөөрэй гэж хэлсэн юм сан. Та нарт жаахан тусламж үзүүлж ч магадгүй гэж хэлээд гүн гараа сунгаж нэгэн оосор чангааж гурав дуугаргав.

- Та ер нь цагаа зөв хуваарилж, зарц нараа хойш урагш нь явуулах явдлыг багасгах гэж бодож байв уу? гэж гүн Францад хэлээд - Би энэ асуудлыг судалж, одоо хиаг дуудахад нэг удаа, бойдааг дуудахад хоёр удаа, гэрийн даамлыг дуудахад гурван удаа хонх дуугаргана. Ингээд би нэг ч илүү хувь нэг ч илүү үг зарцуулдаггүй юм. За тэр миний даамал ороод ирлээ гэв.

Дөчин тав орчим насны бөгөөд Францыг синдбадын агуйд оруулж өгсөнтэй усны хоёр дусал мэт адилхан хүн тасалгаанд орж ирэв. Гэвч түүнийг таньж байгаа шинж ч үзүүлсэнгүй. Гүн ингэж тушаасан гэдгийг Франц ойлгов.

- Эрхэм Бертуччо, би танд өчигдөр Пьяцца дель Пополод цонх олж аваарай гэж хэлснийг санаж байгаа биз гэж гүн асуув.

- Тийм ээ, гэгээн ноёнтон минь, тэр дэндүү оройтсон байсан тул... гэж даамал хэлтэл, гүн хөмсгөө зангидаж,

- Яалаа гэнээ? Надад цонх хэрэгтэй гэж би танд хэлсэн биз дээ? гэж өөдөөс нь асуув.

- Гэгээн эзэн минь та цонхтой болно. Харин цонхыг оросын ноён Лобаньевт өгчихсөн байсан болохоор би түүнд зуун...гэхэд нь

- За за сайн байна, эрхэм Бертуччо, миний зочдыг аж ахуйн нарийн ширийн юмнаас хол байлгаарай. Та цонх олсон л бол бүх хэрэг бүтлээ. Хөтчөд хаягийг нь хэлээд бидэнд газарчилахаар гадаа шатан дээр хүлээж бай. Одоо явж болно. Гэрийн даамал мэхийн ёслоод үүд уруу эргэтэл,

- Өө, өөр нэг юм байна. Пастрини «таволетта» олж авч уу, үгүй юу, надад ирүүлж болох эсэхийг нь мэдээд ирнэ үү гэв. Тэгэхэд Франц хармаанаасаа тэмдэглэлийн дэвтэр гаргаж ирээд,

- Санаа бүү зов. Би тэр самбарыг өөрөө үзэж хуулж авсан юм, энэ байна гэв.

- Маш сайн хэрэг. Тэгвэл Бертуччо та явж болно, надад одоо хэрэггүй. Харин өглөөний зоог бэлэн болохоор бидэнд хэлээрэй гэснээ тэр зочид өөдөө эргэж - Би та хоёрыг надтай хамт өглөөний цай уух байх гэж найдаж байна гэв.

- Гэхдээ гүнтэн, таны энэ зочломтгой занг ингэж хэтрүүлэн хэрэглэж болохгүй гэж Альбер хэлэв.

- Үгүй, үгүй, та хоёртой байх надад их зугаатай сайхан байна. Та хоёрын аль нэг магадгүй хоёулаа ч байж мэднэ, Парис очсон хойно надад хариу тус болно биз. Эрхэм Бертуччо, гурван хүний ширээ засуулаарай.

Тэгээд Францын гараас тэмдэглэлийн нь дэвтрийг авч,

- За тэгэхээр гээд театрын зарлал уншиж байгаа юм шиг хайхрамжгүй байдлаар «... хоёрдугаар сарын хорин хоёрт...цаазаар аваачих хүмүүс: гэгээн Иоанна Латернанскийн сүмийн гэсгүй, өндөр дээд, хүндэт Чезаре Торлинийг алсан Андреа Рондоло, бас жигшүүрт дээрэмчин Луизи Вампа, түүний бүлгийн гишүүдтэй хамссан хэрэгт холбогдсон Ронка Приори хэмээх хочтой Пеппино...«Үгүй ер!»... нэгдүгээр нь «мазолатта» болно. Хоёрдугаар нь «декапитато» болно гэж уншаад - Тийм ээ, ийм юм болох байсан юм, гэвч өнөөдөр энэ ёслолын явцад өөрчлөлт орсон байх ёстой гэж гүн нэмж хэлэв.»

- Өө тийм үү! Гэж Франц дуугарав.

- Тийм ээ, би өчигдөр цорж Роспильозийнд байхдаа, нэг хэрэгтнийх нь цаазыг хойшлуулсан гэж дуулсан юм байна.

- Алиныг нь, Андреа Рондолог уу? гэж Франц асуухад,

- Үгүй, нөгөөдөхийг нь... гэснээ нэрийг нь санахгүй байгаа юм шиг тэмдэглэлийн дэвтэр уруу харж - Рокка Приори гэдэг хочтой Пеппиног. Энэ таныг гильотино үзэж чадахгүй болгож байгаа юм. Гэвч та нарт мазолато үлдэж байна. Үүнийг нэг үзэхэд, тэр ч байтугай хоёр дахиа ч үзэхэд сонирхолтой цааз шүү. Тэгэхэд та нарын сайн мэдэх гильотино нэг л хэвийн байдалтай, дэндүү энгийн, хүн цочмоор ямар ч гэнэтийн юмгүй цааз байдаг юм. Хутга нь халтирахгүй, чичрэхгүй хажуугаар нь хальт хатгачихгүй, гүн де Шалены толгойг авсан тэр цэрэг шиг гуч дахин хатгачихгүй юм. Гэвч Ришелье хэрэгтнийг онцгой анхаар гэж алуурчдаа тушаасан ч байж магадгүй л дээ. Үгүй шүү гээд гүн жигшсэн байдалтайгаар - Тамлах талаар Европчуудын тухай надад бүү ярь. Тэр хатуу догшин байх талаар юу ч мэдэхгүй балчир бага хүүхэд ч юм уу эсвэл зөнөг өвгөд л гэсэн үг гэж хэлэв.

- Гүн таныг газрын бөмбөрцөг дээр хэрэглэгдэн байдаг цааз бүрийг хооронд нь харьцуулан судалсан юм байна гэж бодож болох нээ гэж Франц хэлэхэд,

- Юу ч л гэсэн миний үзээгүй тийм цааз цөөхөн л байх гэж гүн ажиг ч үгү© хариулав.

- Ийм аймаар юм танд сайхан санагддаг гэж үү дээ?

- Би анхандаа жигшин үздэг байсан, дараа нь хайхрахгүй байдаг болсон, тэгснээ эцэст нэ сонирхох боллоо.

- Сонирхох ий? Ямар аймшигтай үг вэ?

- Яагаад? Амьдралд хамгийн чухал нь үхэл шүү дээ. Сүнс нь биеэсээ яаж салж, хүмүүс ахуйгаас хий хоосон уруу яаж очих сүүлчийн энэ шилжилтийг зан байдал, ааш авираараа тус бүр хэрхэн давж өнгөрүүлдэгийг харах нь сонин байдаг юм. Үхэж байгаа хүн олныг харвал, сүүлд өөрөө зовохгүй үхэх болно. Тийм учраас үхэл бол цааз болохоос биш, өршөөл энэрэл биш.

- Би таны хэлж байгааг бүрэн ойлгохгүй байна. Таны ярьж байгаа зүйлийг хэр зэрэг сонирхож байгааг минь та мэддэг ч болоосой. Та санаагаа тайлбарлаж өгнө үү гэхэд гүнгийн царай бусад хүнийх шиг цусаар уйлахгүй харин цөсөөр шаргалтан,

- Та аан гэж бай. Хэрвээ ямар нэгэн хүн таны эцэг юм уу эхийг, хайртай хүүхнийг чинь ер нь л хамгийн дотно хүмүүсийн нэгийг хязгааргүй зовлон зүдгүүрт оруулан тарчилгаж байгаад, зүрхнээс чинь суга татан авч, үүрд мөнхийн хоосон хөндий зай үлдээж, эдгэршгүй цуст шарх тогтоосон бол та тэр алуурчныг аман хүзүү хатан хүзүү хоёрын нь хоорондуур заазуураар цаазлан, таныг олон он жилээр сэтгэлийн зовлонд учруулсан тэр хүн хэдхэн хором зовоод өнгөрчихвөл нийгэм надад хангалттай хариу авч өглөө гэж үзнэ гэж үү гэж хэлэхэд

- Тийм ээ, хүмүүсийн шударга үнэний шүүх гэдэг бол муу тайтгаруулагч гэдгийг би мэднэ. Зөвхөн цусны төлөө цус урсгана. Тэгэхээр хэмжээнээс нь хэтэрсэн юм түүнээс шаардаж болохгүй гэж Франц хариулав. Тэгэхэд гүн цааш үргэлжлүүлэн,

- Би бол нийгмийн нэг гишүүн үхсэн явдалд цочин түгшиж, цусыг цусаар нь хариулдаг тийм тохиолдлын тухай ярьлаа. Гэтэл нийгмийн хайхран үздэггүй, хүний сэтгэл зүрхийг шимшрүүлсэн сая сая зовлон зүдүүр байдаг. Нийгэм түүний төлөө бидний саяын ярьсан төдийний сэтгэл тэгтлээ ханамгүй тэр аргаар ч гэсэн өшөөг авч өгдөггүй юм. Хэдийвээр хайхрамжгүй олон нийт огт шийтгэлгүйгээр орхидог боловч түрэг шиг гадсан дээр суулгаж, ирокезууд! шиг судсын нь сугалахаас илүү аймшигтай шийтгэл ногдуулан тийм гэмт хэрэг байдаггүй гэж үү?

- Бий, тийм учраас ч халз тулалддаг юм гэж Франц хариулав.

- Халз тулалдах ий! Хэлэх юм алга, бай болон зогсох зорилгод хүрэх хамгийн сайн хэрэглүүр! Хүн танаас дуртай хүүхнийг чинь хулгайлан авч, эхнэрийн чинь толгойг эргүүлж, охиныг чинь бузарлан бурхан өөрийн бүтээсэн хүн бүхэнд өгөхөөр амалсан аз жаргалыг хүртэх эрхтэй амьдралыг чинь тэр хүн зовлон зүдгүүр, гутамшиг болгож хувиргавал яана! Тэгэхээр ухаан санаагий чинь солируулж, зүрх сэтгэлийг чинь тарчилган зовоосон тэр хүнийг сэлмээр хатгачин духанд нь сум зоох төдийгөөр та өшөөгөө авсан болж сэтгэл ханана гэж үү? Боль доо! Тэгээд бас тийм хүн тэмцэл дундаас ялагч болон гарч олны өмнө зөвтгөгдөн бурханд уучлагдах нь цөөнгүй байдгийг яриад яах вэ. Үгүй, хэрвээ хэзээ нэгэн цагт өшөөгөө авах тавилантай төрсөн бол ийм маягаар өшөө авахгүй! гэж гүн ярив.

- Тэгвэл та халз тулааныг үгүйсгэж байх шив дээ? Та тулалдахаас татгалзах нээ? Гэж гүнгийн хачин онолд гайхсан Альбер асуухад гүн татгалзаж,

- Үгүй, яалаа гэж? Та миний хэлэхийг ойлго л доо: би бол ялихгүй юмны төлөө, намайг доромжилсон худлаа хэллээ гэсэн эсвэл, намайг алгадчихсаны төлөө сэтгэл зовохгүй тулалдана. Тэгээд өөрийн олж авсан чадвар, олон жил аюул заналын дор байж дассан заншлын ачаар дайснаа ялж гарна гэхэд эргэлзэхгүй байдаг. Энэ бүхний төлөө би тулалдана. Харин гүн гүнзгий, олон жил яалт ч үгүй цөхрөн зовж зүдэрсний хариуг мөн түүн шиг нь удаан хугацаагаар дорнодын хүмүүсийн ярьдагчлан хорыг хороор нь өсийг өсөөр нь алгуурхан авна. Дорнодын хүмүүс бол бидний багш, амьдралыг зүүд нойр болгож, үнэн бодит зүйлийг диваажин болгож чаддаг хүмүүс юм шүү гэж гүн хэлэв.

- Гэхдээ та өөрийн хэргийн шүүгч, алуурч нь болчих болохоор хуулийн хэмжээ хязгаарт баригдалгүй өөрөө эрхэнд нь орчихгүй байх нь бэрх байх. Үзэн ядах гэдэг бол сохор, уур хилэн гэдэг бол ухаангүй тэнэг явдал, хэн өшөө авах сэтгэлд автана тэр хүн гашуун зовлон амсдаг гэж Франц татгалзан хэлэв.

- Хэрвээ ядуу хоосон, тэнэг хүн бол тийм болно. Хэрвээ сая саяын хөрөнгөтэй ухаантан хүн бол тийм биш гэсэн үг, хамгийн муугаар бодоход л бидний саяын ярьдгаар л цаазлагдана. Харин энэ цаазыг хүнийг энэрэн үзэгч Францын хувьсгал мөч мөчөөр нь салгахгүй болгосон юм. Хэрвээ өшөөгөө авчихсан бол түүд цааз юу болдог юм бэ? Хөөрхий тэр Пеппино надад өрөвдөлтэй санагдаж байна. Эдний ярьдаг «декапитато» болохгүй байх. Хичнээн их цаг авах байсныг яриад яахав. Үгүй ингэхэд эрхмүүд ээ, багт наадмын эхний өдөр бид ямар муухай юм ярьж байнаа! Энэ юунаас эхэлчих вэ? Өө, тийм саналаа! Та хоёр миний цонхон дээр суудал авах хүсэлтэй байл уу, за яахав болноо. Харин одоо, юуны өмнө ширээнд сууцгаая. Өглөөний зоог болсон бололтой гэв.

Үнэхээр ч зочдын өрөөнд ордог дөрвөн хаалганы нэг нь онгойж, зарц орж ирээд хүндэтгэлийн үг хэлж,

- Al suo commodo Гэв.

Залуу хүмүүс босож, хоолны өрөөнд оров.

Дээд зэргийн сайхан бэлтгэсэн зууш идэж, нэн гоёор зассан ширээнд сууж байх зуур эзний хэлсэн үг Альберт ямар сэтгэгдэл төрүүлж байгааг харах гэж Франц хичээнэ. Тэр төрөлхийн хайхрамжгүй зангаараа гүнгийн ярьсан юмыг төдий л анхаараагүй, эсвэл халз тулааны талаар Монте-Кристо гүн бууж өгсөн нь Альберийг түүнтэй эвлэрүүлсэн буюу эсвэл Францын мэддэг тэдгээр зүйлүүд нь гүнгийн хэлсэн үзэл санааг зөвхөн Францад л улам гүнзгийрүүлж байгаагаас болсон хэрэг үү, юу боловч найз нөхөр нь юманд санаа тавьсан шинжгүй байв. Харин бараг таван сарын туршид ертөнц дээр хамгийн муу гэгддэг итали хоолоор сэтгэл ханаж явсан хүн шиг л амтархан зооглож байв. Гүнгийн тухай гэвэл хоолноосоо амсахын төдий байв. 'эр зөвхөн ёсыг бодож зочидтойго® сууж байгаагаас биш тэднийг гараад явмагц өөртөө ямар нэгэн хачин, онцгой хоол авчирч өгөхийг тушаах гэж байгаа хүн шиг санагдана.

Энэ нь гүнгийн хатан Г-г айлгаж, тэр хүүхэн гүнг буюу нөгөө талын нь лоожинд сууж байсан хүнийг ороолон гэж хэлснийг аяндаа Францад санагдуулав.

Франц зооглож дууссаны дараа цагаа харав.

- Та яав? Гэж гүн асуув.
- Бидэнд одоо мянга түмэн ажил байна, эрхэм гүн уучлаарай гэж Франц хариулав.
- Ямар?
- Бидэнд хувцас байхгүй байгаа, өнөөдөр заавал хувцас хэрэгтэй
- Энэ талаар бүү санаа зов. Пьяцца дель Пополод бидэнд тусгай өрөө гаргаж өгөх байх. Тэгэхээр та нарт хэрэгтэй ямар л бол ямар хувцас авчирч өг гэж тушаая. Тэгээд тэндээ хувцсаа сольж өмсөмз.
- Цаазны дараа юу? гэж Франц дуугарав.
- Цаазны өмнө сүүлд, эсвэл яг дундуур нь аль дуртай цагтаа л хувцаслана биз.
- Хэзээ цаазлахаас нь болох уу?
- Баярын программд цааз орж байгаа.

- Гүнтэн би болилоо гэж Франц хэлээд - Би танд их баярлалаа, надад таны сүйх тэрэг ба Росполи палаццогийн цонхны дэргэдэх суудал хангалттай болно. Харин та Пьяцца дель Пополод байгаа миний суудлыг эзэмшихийг гуйя гэв.

- Та маш сонин юмнаас хоцрох гэж байгааг хэлэх ёстой гэж гүн хариулав.

- Яахав та үзсэн тухайгаа надад ярьж өгөөрэй. Таны яриа надад тэр зүйлийг биеэрээ үзсэнээс дутуугүй сэтгэгдэл төрүүлнэ. Би хэдэн удаа цаазаар авахыг үзэх гэсэн Уоловч зүрх хүрээгүй юм, харин Альберт та яах вэ? гэж асуухад,

- Би Кастеныг цаазаар авахыг үзсэн юм байна гэж бэйс хариулаад - Харин тэгэхдээ их л хөгжилтэй болчихсон цагтаа үзсэн юм. Бид дунд сургууль төгсөөд нэг гуанзанд бүх л шөнийг өнгөрүүлсэн байсан юм гэж хэлэв.

- Парист байхдаа ямар нэгэн юм хийгээгүй гэдэг бол харийн оронд очоод түүнээ хийхгүй байхын шалтгаан биш гэж гүн хэлээд - Юм мэдэх гэж жуулчилдаг, шинийг үзэх гэж байраа сольдог. Та бод л доо: «Ромд яаж цаазаар авдаг юм бэ?» гэж асуухад «Мэдэхгүй» гэж байвал танд ичгүүртэй шүү дээ. Тэгээд бас цаазлагдаж байгаа хүн засаршгүй бузар амьтан, хүү шигээ хүмүүжүүлсэн хүндэт ламыг чулуун тулгаар цохиж алсан, үл бүтэх хүн гэж байгаа юм. Чөтгөр ав, ер нь лам хүнийг тэр дандаа эцгээсээ ялгаагүй хүнийг алахад хүрвэл тулганаас арай аятайхан зэвсгээр цохих хэрэгтэй байсан юм. Хэрвээ та нар Испаниар жуулчилж яваа бол зэрлэг бухын тулалдаан үзэх байсан даа, тийм ээ? Тэгвэл бухын тулаан үзэхээр яваа гэж бод. Эртний Ромчуудын циркийн тухай, гурван зуун арслан, зуугаад хүн хохирлог агнуурын тухай сана л даа. Наян мянган үзэгчид нэгэн зэрэг алга ташдаг тухай, эрд гарах болсон охиноо дагуулан ирдэг авгайчуулын тухай, хөөрхөн хуруугаараа: «Алив бүү залхуурцгаа, наадхаа дуусгаадхаач бараг үхчихсэн байх шив» гэж дохин зогсдог хонгор шар үстэй тайлгач хүүхнүүдийн тухай бод л доо.

- Альберт та явах уу? Гэж Франц асуув.

- Би тан шиг эргэлзэх байсан боловч гүнгийн ярьж байгаа зүйл намайг итгүүлчихлээ.

- За тэгвэ« та нарын таалалд нийцүүлж явцгаая гэж Франц хэлээд - Пьяцца дель Пополо орох замдаа Корсогоор орох хэрэгтэй байна. Ингэж явж болох болов уу?

- Явган бол болно, сүйх тэрэгтэй бол болохгүй.

- Тэгвэл би явган явна.

- Та заавал Корсод очих ёстой юм уу?

- Тийм ээ, юухан хээхэн үзэх хэрэгтэй байна.

- Болноо, тэгвэл Корсо уруу явган явцгаая. Сүйх тэрэг маань виа-дель-Бабуионогоор явж, Пьяцца дель Пополод очоод биднийг хүлээж байг. Би ч бас Корсогоор явган явж, зарим нэг тушаал биелэгдсэн эсэхийг үзэхээс зөрөх юм алга гэж хэлтэл хаалга онгойж,

- Гэгээн эзэнтэн минь, мөргөлчийн хувцастай хүн хүрч ирээд тантай уулзах зөвшөөрөл гуйж байна гэж зарц хэлэв.

- Тиймээ, мэдэж байна гэж гүн хэлээд - Эрхмүүдээ та нар зочдын өрөөнд орохыг зөвшөөрөх сөн болов уу? Тэнд ширээн дээр гаваний дээд зэргийн ороомол навчин тамхи бий... минутын дараа та нар дээр очно гэв.

Залуу хүмүүс босож нэгэн хаалгаар гарахад, гүн тэднээс дахин уучлал гуйгаад нөгөө хаалгаар гарав. Кафе-де-Парид янжуургүйгээр хооллох юм бол том гарз гаргана гэж боддог. Тамхинд их дуртай Альбер ширээн дээр ёстой «пурос» байхыг хараад баярлан дуу алдав.

- За, Монте-Кристо гүнгийн тухай юу гэж бодож байна? гэж Франц түүнээс асуув. Нөхрийгөө ингэж асуусанд илтэд гайхсан Альбер,

- Би түүний тухай юу бодож байна гэнээ? Энэ бол олон юм үзэж, судалсан, их юм боддог Брут шиг туйлбартай хүмүүсийн тоонд орох маш хонгор сайхан, зочломтгой эзэн гэснээ тамхиныхаа утааг дээш нь цагираглуулан гаргаж - Тэгээд маш сайхан тамхитай хүн юм гэж хэлэв.

Альбер гүнгийн тухай ийм бодолтой байв. Альбер аль нэгэн хүн юмны тухай санал бодлоо гаргахдаа дандаа саруул ухаанаар эргэцүүлэн бодсоны дараа хэлдэг гэж сайрхдаг учраас Франц түүнээс зөрөхийг оролдсонгүй.

- Гэвч та маш хачин нэгэн зүйлийг анзаарав уу гэж Франц асуув.

- Ямар?

- Таныг хачин их ширтээд байсныг анзаарав уу?

- Намайг уу?

- Тийм ээ, таныг

Альбер бодлого боллоо. Тэгээд санаа алдаж,

- Яая гэх вэ, үүнд гайхалтай юм ер алга. Би Парисаас гараад нэг жил болж байгаа болохоор мануухай шиг л юм болчихсон байх. Гүн намайг хөдөөгийн

хүн гэж бодож байгаа байх. Найз минь тийм биш гэдгийг хэлэх шалтаг гармагц л хэлж, итгүүлж өгөөрэй гэж хэлэв.

Франц инээмсэглэв. Тэгтэл минутын дараа гүн орж ирэв.

- За одоо эрхмүүдээ, юм та бүхний мэдэлд бүрэн шилжлээ. Тушаал өгчихсөн. Сүйх тэрэг өөрийнхөө замаар Пьяцца дель Пополо орохоор явсан. Бид тийшээгээ Корсогоор дайрч явган явна. Эрхэм де Морсер та хэдэн ороомол тамхи ав л даа гэж гүн хэлэхэд,

- Дуртайяа авъя, гүнтэн, баярлалаа танд гэж Альбер хэлээд, - Италийн ороомол навчин тамхи Францынхаас долоон дор юм. Таныг Парист очвол би тантай данс бодолцомц гэв.

- Татгалзахгүй шүү, хэзээ ч юм Парис орно гэ! найдаж байгаа. Тэгээд таны зөвшөөрөлтэйгээр танайд очно. За эрхмүүд ээ, биднийг цаг хүлээхгүй, хэдийн арван хоёо цаг хагас болжээ. Явцгаая!

Тэд гурвуулаа доош буув. Хөтөч эзнийхээ тушаалыг сонсоод виадель-Бабуниагаар явахад, гүн залуу хүмүүстэй хамт палаццио Фиано ба палаццо Росполийн хоорондуур Корсо уруу хүргэх Пьяцца ди Спанийг чиглэн виа-Фраттинаар дайран явав.

Франц ордны цонхыг ширтэн харав. Колизей дотор транстеверийн хүн цувтай хүн хоёрын хооронд тохирсон дохиог мартаагүй байв.

- Эдний аль нь таных вэ? гэж гүнгээс аль болох ердийн байдлар асуухад,

- Захын гурав нь гэж цаадах нь энэ асуултын үнэн учрыг мэдэлгүй, хайнга байдлаар хариулав.

Франц цонх өөд түргэн харав. Хоёр захынх нь шар хөшигтэй дундах нь улаан хэрээстэй цагаан хөшигтэй байв.

Цувтай хүн хэлсэн үгэндээ хүрчээ. Тэр цувтай хүн бол Монте-Кристо гүн байсан нь эргэлзээгүй боллоо.

Гурван цонхон дээр хэн ч байхгүй байв.

Энд тэндгүй багт наадамд бэлтгэж, сандал ширээ тавилж, модон индэр босгон цонхонд хөшиг татна. Хонх дуугарахаас нааш багаа ил гаргаж болохгүй, сүйх тэргүүд ийш тийшээ явж болохгүй ёстой. Гэвч цонх бүрийн цаана баг байгаа нь мэдэгдэж, хаалга бүрийн ард сүйх тэрэг бэлэн байгаа нь илэрхий байв.

Франц, Альбер, гүн гурав Корсогоор явсаар байв. Тэд Пьяцца дель Пополод ойртох тусам хүн улам олон болно. Талбайн дунд хирээс сүндэрлэн байгаа нь хүмүүсийн дээгүүр харагдах бөгөөд Бабуниа, Корсо Рипетта гурван гудамжны уулзвар дээр цаазны индрийн хоёр шон ёрдойж тэдгээрийн хооронд цаазын хагас дугараJ заазуур гялалзана.

Гудамжны буланд гүнгийн гэрийн даамал эзнээ хүлээн зогсож байхыг харав.

Харвал жигтэйхэн үнэтэйгээр хөлслөн авсан цонх нь виа-дель-Бабунио ба Монте Пинчо хоёрын хоорондох том ордны гуравдугаар давхарт байлаа. Гүн хэр зэргийн үнэ төлснөө зочдод мэдэгдэхийг хүссэнгүй. Энэ тасалгаа нь унтлагын өрөөтэй залгасан хүлээн авах өрөө мэт ажээ. Унтлагын өрөөний үүдийг нь хаачихвал гэртээ л байгаа юм шиг болно. Цэнхэр цагаан атлас даавуугаар хийсэн алиалагчийн зэгсэн дэгжин хувцсыг сандал дээгүүр тавилжээ.

- Та нар намайг, өөрсөддөө хувцас сонгож авахыг зөвшөөрсөн болохоор та нарт үүнийг бэлтгүүллээ. Нэгдүгээрт энэ жил ийм костюм шинэ маягт орж байгаа, хоёрдугаарт, гурил болсон ч мэдэгдэхгүй өнгийн цаасан ширхэгт маш тохиромжтой байдаг гэв.

Франц гүнгийн хэлсэн үгийг бараг сонссонгүй, тэр бүү хэл найрсаг зан гаргахыг нь дутуу үнэлсэн байж ч магадгүй. Бүх анхаарал нь Пьяцца дель Пополод, энэ үеэр гол гоёо нь болж байгаа аймшигт зэвсэг дээр татагдсан байв.

Франц амьдралдаа анх удаа гильотинийг үзэж байгаа нь энэ бөгөөд ромын *mandaia* нь Францын цаазны заазууртай маш төсөөтэй болохоор гильотин гэж ярьж байгаа юм. Энэ бол тал сар шиг, цүлхгэр талаараа огтолдог, харин тэгэхдээ багахан өндрөөс буудаг, ийм л ялгаатай хутга байгаа юм.

Яллагдагчийг хэвтүүлэн сунгадаг банзан дээр хоёр хүн суугаад ца зыг хүлээн юм идэж байв. Идэж байгаа юм нь Францын харснаар талх, хиам байв. Тэдний нэг нь доошоо тонгойж банзан дороосоо дашмагтай дарс гаргаж ирээд, даруулан нэг балгаад нөхөртөө өгөв. Энэ хоёр бол алуурчны туслахууд ажээ.

Франц тэднийг хараад, хуйх нь хөлрөх шиг боллоо.

Яллагдагчийг урьд өдөр нь шинэ шоронгоос Санта Мария дель Попологийн жижиг сүмд шилжүүлэн авчирч, тэнд тус бүр хойдхы нь унших хоёр ламтай өмнүүр нь, цаг тутам солигдогч манаач нартай олон лаа асааж гэрэлтүүлсэн жижиг сүмд шөнийг өнгөрүүлжээ.

Сүмийн үүднээс, цаазын индэр хүртэл хоёр эгнээ морьтой цагдаа жагсаж, голдоо арван фут орчим зай гаргаж цаазын заазуурын эргэн тойрон зуун алхам газарт сул зай үлдээн зааглажээ. Бусад бүх талбай нь хүн дүүрэн байв. Олон

хүүхэн хүүхдээ мөрөн дээрээ суулгасан байх бөгөөд эндээс балчир иргэд цаазны индрийг тодхон харна.

Монте Пинчогийн дэвсэг бүрт хүн дүүрч, асар том хагас дугараг театр шиг байв. Виа-дель-Бабуино ба виа-ди-Рипеттын булан дахь хоёр сүмийн тагт дээгүүр ямбатан хүмүүс дүүрчээ. Шатнууд нь цувран гүйж байгаа далайн долгион мэт байв. Хүн л зогсож болохоор хананаас ёрдойсон юм бүр нь амьд хөшөөний суурь болсон байв.

Гүнгийн хэлсэн үнэн болж, амьдралд үхлээс илүү сонирхолтой зүйл байхгүй бололтой.

Одоогийн болох гэж байгаа ёслолын байдлаар бол нам гүм, чимээ аниргүй баймаар байтал, цугларсан олны дундаас чанга чанга инээлдэх, гуугчих баярлан хашхиралдах дуу гарна. Цааз бол багт наадмын эхлэлт болно гэж гүнгийн хэлдэг ч зөв боллоо.

Гэв гэнэт шидэт бэрээгээр дохисон адил намгүм болж сүмийн хаалганууд нээгдэв.

Өмнө талд нь нүдэндээ нүх гаргасан шуудай нөмөрсөн мөргөлчид нүглийг нь наманчилж асаалттай лаа барьж явна. Манлайд нь бүлгийн тэргүүн явав.

Араас нь богино зотон өмдийг нь эс тооцвол нүцгэн өндөр хүн явна. Зүүн хажуудаа том хуйтай хутга зүүж, баруун мөрөн дээрээ том төмөр муна үүрчээ. Энэ бол алуурчин ажээ.

Хөлдөө, шагайгаараа шидмэсээр тогтоосон шаахай углажээ.

Алуурчийн хойноос цаазлагдах дэс дараагаараа Пеппино, Андреа хоёр явна.

Тэр хоёрыг тус бүрийг нь хоёр лам дагажээ.

Тэр хоёрын алины нь ч нүдийг боосонгүй.

Пеппино овоо алхалж байна, бодвол юу болохыг түүнд хэлж амжсан бололтой.

Андреаг нь хоёр лам сугадан явна.

Ялтан уруулд нь байн байн нааж байгаа загалмайг үнэснэ.

Франц зөвхөн хараад л хөл нь гуйвлах шиг болов. Тэгээд Альбер өөд харав. Цаадах нь захнаасаа илүү цагаан болчихоод, тамхиа татаж дуусаагүй атлаа амнаасаа аваад хаяж харагдана.

Ганцхан гүн л хэнэг ч үгүй зогсоно. Бас ч гэж үхээрийн цагаан царай нь үл мэдэг улайсан байлаа.

Хамар нь цус үнэртсэн араатан шиг сартайн, хагас ангайсан амнаас нь цөөвөр чонынх шиг хурц цагаан шүд цухуйна.

Хэдий ийм царайтай ч Францад урьд нь ажиглагдаагүй баяртай байрын зөөлөн байдал илэрч байв. Ялангуяа зөөлөн хилэн шиг нүд нь гайхмаар ажээ.

Тэр завсар ялтангүйд цаазны индэрт ойртон ирж, нүүр царайг нь ялган таньж болох болов. Пеппино нь хурц догшин нүдтэй, хорин тав орчим насны сайхан хархүү байлаа. Тэр, аль зүгээс аврал ирэх бол гэсэн шиг толгойгоо өргөн явна.

Андреа нь намхан тарган эр байв. Түүний ширүүн бузар царайгаар хэдэн настай болохыг хэлэхэд хэцүү. Гучин настай гэж хэлж болмоор байв. Шоронд байхдаа сахлаа тавьчихжээ, толгой нь гудайн унжиж, хөл нь гуйвалзан аяндаа дуулгавартай явна.

- Ганцханыг нь цаазална гэж та ярьсан байх аа гэж Францын хэлэхэд,
- Би танд худлаа хэлээгүйсэн билээ гэж гүн хүйтнээр хариулав.
- Гэтэл хоёр хүн байна шүү дээ.
- Тийм ээ, гэвч нэг нь үхлийн аман дээр байгаа, нөгөөх нь олон жил амьд явна.
- Одоо л өршөөвөл цаг нь болоод байгаа юм шиг санагдах юм.
- Тийм шүү хар л даа гэж гүн хэлэв.

Нээрээ ч Пеппиног цаазны индэрт тулж ирэх үед нэгэн мөргөлчин бүсэлсэн цэргүүдийн дундуур гарч, ёслол гүйцэтгэгчийн тэргүүнд дөрөв нугалсан бичиг барив.

Пеппиногийн хурц харц энэ явдлыг цөмийг харж байлаа. Тэргүүн уг цаасыг задалж уншаад гараа өргөв.

- Бурхан өршөөг, өндөр төрөлт гэгээн хутагт хамбыг магтан сайшаая, ялтнуудын нэгийг өршөөсөн байна гэж чанга тодхон хэлэв.

- Өршөөж ий! Гэж цугларсан олон зэрэг хэлээд - Нэг нь өршөөгджээ!
Гэцгээв.

«Өршөөл» гэдэг үгийг дуулаад Андреа цочин давхийж толгойгоо өргөв.

- Хэнийг өршөөгөө вэ? гэж орилов.

Пеппино хүндээр амьсгалан, хөшсөн мэт дороо зогсов.

Рокка Приори гэдэг хочтой Пеппиног өршөөжээ гэж тэргүүн хэлэв. Тэгээд морьт цагдаа нарын даргад бичгийг өгөхөд цаадах нь авч уншаад буцааж өгөв.

- Пеппино өршөөгдсөн гэнээ гэж нөгөө доожоогүй байдлаа таягдан хаясан Андреа орилоод - Яагаад намайг өршөөхгүй түүнийг өршөөдөг билээ? Бид хоёлуаа үхэх ёстой байсан, энүүнийг надаас түрүүнд үхнэ гэж амласан. Та нар намайг ганцааранг минь алах эрх байхгүй. Би ганцаараа үхэхгүй, би ганцаараа үхэхийг хүсэхгүй байна! гэж хашхичив.

Тэгээд лам нарын гараас мултран гараа хүлсэн олсыг таслах гэж оролдон тонгочин сүйд боллоо.

Алуурчин туслахууд өөдөө дохиход цаадуул нь цаазны индрээс үсрэн бууж ялтанг барьж авав.

- Тэнд юу болж байна вэ? гэж Франц гүнгээс асуув.

Цөм ром аялгуугаар ярилцаж байсан болохоор юу болж байгааг нь муу ойлгожээ.

- Тэнд юу болж байна вэ? гэж гүн давтан асуугаад - Та тааварлахгүй байна гэж үү? Одоо үхэх гэж байгаа энэ хүн нөгөө хүнээ өөртэйгөө хамт үхэхгүй болохоор галзуурч байгаа нь тэр. Хэрвээ түүнийг дураар нь тавибал өөрт заяагаагүй цаадхынхаа амийг таслахын тулд хумс, шүдээрээ тасчин хаяна. Өө, хүмүүс, хүмүүс! Карл Моорын хэлснээр гүмбэраа матрын зулбадсууд! Гэж хэлээд гүн олны дээгүүр, гараараа зангаж - Би та нарыг мэдэж байна, та нар хэзээ өөр өөрсөндөө хүн юм! Гэв.

Андреа, алуурчийн туслагчидтай шорон дээгүүр чиргүүцэлдэж, «Тэр заавал үхэх ёстой! Би түүнийг үхээсэй гэж хүсэж байна! Та нар намаг ганцааранг минь алах эрх байхгүй!» гэж хашхирна.

- Хараач гээд гүн залуу хүмүүсийн гараас барьж, - Хараач, үүнийг харах хэрэгтэй гэдгийг андгайлъя. Хувь заяандаа захирагдаж, айж хулчийсандаа ямар ч эсэргүүцэл гомдолгүй, үхэхэд бэлхэн болчихоод байсан хүн энэ байна. Юу гээч нь түүнд ийм их хүч өгөв өө? Ямар юм түүнийг тайвшруулж байв? Тэр яагаад

толгойгоо авахуулахыг хүлцэн хүлээж байв? Яагаад гэвэл, өөр хүн бас тэгж зовж, бас тэгж үхэх ёстой байснаас, яагаад гэвэл, өөр хүн өөрөөс нь өмнө үхэх ёстой байснаас тэр! Хоёр хонь, хоёр шарыг алах гээд нядалгааны газар аваад ир л дээ, тэгээд нэгэнд нь өөрийн нөхөр үхэхгүй амьд мэнд үлдэнэ гэж мэдэгдчих тэгвэл хонь баярлан майлж, үхэр нөхрийгөө азтайд нь мөөрнө. Гэтэл бурхантай адил түүний дүрээр бүтээгдсэн хүн, ойр дотныхныгоо хайрлахыг хамгийн дээд хууль хэмээн бурхнаас номлосон хүн, өөрийн санаа бодлыг ярьж байг гэж хэл яриа заяасан хүн, өөрийнхөө нөхрийг аврагдлаа гэдгийг мэдмэгц юу гэж орилов. Хараал зүхэл. Түмэн бодисын охь, бүтээлийн эзэн гэгч ийм л байна!

Тэгээд гүн ихэд зовж зүдэрсэн хүн л инээж чадах тийм аймшигт инээдээр инээв.

Тэр завсар цаазны индрийн дэргэдэх тэмцэл үргэлжилж, харахад нүд халтирам байлаа. Алуурчийн туслахууд Андреаг цаазны индэр дээр чирч гаргав. Цугларсан олон цөм Андреагийн эсрэг болж хорин мянган хүн нэгэн зэрэг: «Цаазал! Түүнийг цаазал!» гэж хашхирав.

Францын нүд далдирч гуйвав. Гэвч гүн түүний гараас барьж цонхны дэргэд байлган,

- Та яаж байна? гэж асуугаад - Та түүнийг өрөвдөж байна уу? хэлэх юм алга, болох л өрөвдөлт! Зөвхөн галзуу нохойнд уруулснаараа буруутан болж галзуурсан нохой хашаан дотор цонхны доогуур чинь гүйж явбал, та ухасхийж буугаа шүүрч аваад ямар ч хайр энэрэлгүйгээр хөөрхий амьтныг буудаад алчихна шүү дээ. Аа, тэгэхэд та, хэнд ч уруулаагүй боловч өөртөө буян бүтээсэн хүнийг алж орхиод, одоо гар нь хүлээтэй болохоор нөхрийгөө алж чадахгүй байгаа хамт хоригдож, зовж зүдэрч байсан нөхрөө алаад аль гэж хорсон шаардаж байгаа хүнийг өрөвдөж байна гэнээ? Үгүй шүү, хараач, хараач! Гэв.

Гүнгийн энэ шаардлага бараг илүү хэрэг байлаа. Франц аймшигт үзэгдлээс нүдээ салгаж чадахгүй байв. Алуурчийн туслахууд ялтанг орилон хашхирч, хазаж зулгааж, нүдэж балбаж байвч үл хайхран цаазны индэр дээр татан гаргаж, өвдөг дээр нь хүчээр сөхрүүлэв. Алуурч түүний хажуу талд очоод мунаа бэлхэн барьж туслагчиддаа дохио өгөхөд цаадуул нь зайлав. Ялтан өндийх гэсэн боловч амжсангүй. Шийдэм зүүн чамархайд нь цохиж бүгд дуугарахад Андреа тонгосхийн унаад, дараа нь гэдрэгээ харан тэрийв. Тэгэхэд алуурч мунаа хаяж, хутгаа сугалан ганц цавчиж хоолойг нь огтлоод гэдсэн дээр нь гарч хөлөөрөө гишиглэв. Гишиглэх бүрд ялтны хоолой гүрээнээс нь цус олгойдно.

Франц цааш тэсвэрлэж чадснгүй, тасалгааны булан уруу очиж зөөлөн сандал эээр бараг ухаангүй уналаа.

Альбер нүдээ онийлгож, цонхны хөшигнөөс зууран зогсоно.

Гүн толгойгоо дээгүүр өргөж, хорт явдлын ялгуусан бурхан мэт зогсож байв.

15. Ромын багт наадам

Франц ухаан ороход, Альбер үхсэн хүн шиг зэвхий царайтай болчихоод ус ууж, гүн алиалагчийн хувцас өмсөж байгаа үзэгдэв. Франц талбай өөд өөрийн эрхгүй харвал цаазын заазуур, алуурчид, цаазаар авахуулсан хүн цөм алга болчихсон, хөгжилдөж бужигнан шуугилдсан олон хүмүүс үлдсэн байв. Хутагт хамба ламын таалал болох, багт наадам нээх хоёрт л дуугардаг Монте Читориогийн хонх дүнгэнэн дуугарав.

- Юу болж байна вэ? гэж Франц гүнгээс асуухад цаадах нь,
 - Юу ч болоогүй, харж байгаа биз дээ. Багт наадам л нээгдлээ. Бушуухан хувцаслаарай гэв.
 - Энэ аймшигт явдал зүүд шиг арилчихдаг мөн хачин юм даа гэж Францын хэлэхэд,
 - Тийм ээ, энэ бол таны хар дарж үзсэн зүүд гэв.
 - Надад ч тийм, харин цаазаар авагдсан хүнд?
 - Түүнд ч бас адилхан, харин тэр үүрд нойрсож, та сэрсэн. Та хоёрын хэн нь жаргалтайг хэн мэдэх вэ?
 - Харин Пеппино хаачсан бэ? Тэр юу болоо бол? Гэж Франц асуув.
 - Пеппино бол ямар ч биеэ тоосон илүү зангүй ухаалаг хүү. Өөрийн нь мартчихлаа гэж гомдож гонсойхын оронд энэ завшааныг ашиглан олны дунд шурган орж, цаазны индэр хүртэл дагаж ирсэн лам нартаа ч баярлалаа гэж хэлэлгүй алга болж одсон. Үнэнийг хэлэхэд хүн гэдэг бол баяр талархалгүй, хувиа хичээсэн амьтан... За, эрхмээ та хувцасла, таны найз тань танд үлгэр дуурайл үзүүлж байгааг хараач.
- Үнэхээр ч Альбер хар өмд, гялалзсан хар шаахайн дээгүүрээ атласан өмд өмсөж байв.
- За Альбер ямар байна, марзганамаар байна уу? гэж Франц асуугаад - Зөвхөн үнэнээ л хэлээрэй гэв.
 - Үгүй шүү гэж Альбер хариулаад - Гэхдээ үүнийг үзсэндээ баяртай байна. Би гүнгийн хэлдгийг зөвшөөрч байна, хэрвээ ийм үзэгдлийг нэг л үзэж давбал энэ нь эцэс сүүлдээ хүчтэй сэрэл өгч чадах ор ганц зүйл болох юм гэв.

- Ийм үед л хүнийг судалж болно гэдгийг ярилгүйгээр шүү гэж гүн хэлээд - Цаазын индрийн эхний гишгүүр дээр л хүний бүх амьдралынхаа турш өмсөж явсан баг нь ховхрон ойчиж үнэн царай нь гардаг. Андреагийн царай бол нүдэнд дулаахан царай биш гэж хэлэх хэрэгтэй байна... ямар бузар амьтан гээч! ... хувцаслацгаа, эрхмүүдээ, хувцаслацгаа! Гэв.

Франц нөхдөө дуурайхгүй бол инээдэмтэй хэрэг болох байв. Тэгээд өөрийнхөө нүүрээс өчүүхэн ч цагаан биш баг зүүж, костюм өмсөв.

Тэд хувцаслаж гүйцээд доошоо буув. Үүдний дэргэд олон өнгийн цаасан ширхэг, цэцгийн баглаа дүүрэн ачсан сүйх тэрэг зогсож байв.

Тэд сүйх тэрэгнүүдийн цуваан дотор байраа эзлэв.

Ер нь үүнээс өөр огцом өөрчлөлт байдаг гэж бодоход хэцүү байв. Пьяцца дель Попологийн анир чимээгүй баргар хар үзэгдлийн дараа наадам зугаа, хөөр дэлгэрэв. Багнууд энд тэндгүй гарч, хаалга үүд, цонхоос цухалзана. Гудамж бүрээс арлекин, алия жүжигчин, баатар э°, хөдөөний хүн болж хувцасласан хүмүүсээр дүүрэн сүйх тэрэгнүүд гарч ирнэ. Бүгд хашхиралдаж, өндөг гурилд хийсэн эрээн цаас цэцгээр бие биеэ шидэн, өөрийн хүний таних, танихгүй хамаагүй чулуудалцан хэн нь ч гомдохгүй, харин ганцхан инээдээр хариулна.

Франц, Альбер хоёрыг уйтгары нь сэргээх гэж мухлагт авчрахад, архи ууж согтоод өнгөрсөн явдлаа мартаж мансууран байгаа хүмүүстэй адилхан байв. Тэр хоёр дөнгөж саяхан болсон явдалдаа автагдсан хэвээр байсан авч нийтийн хөгжөөнд бага багаар автан ухаан санаа нь мартагнахад бэлхэн болж, энэ шуугиан бужигнаанд толгойгоор нь шумбуулан оруулахаар татаж байгаа юм шиг санагдав. Зэргэлдээ яваа сүйх тэрэгнээс Морсер уруу чулуудсан цаас Альбер түүний хамт яваа нөхөд дээр асгарч хүзүү ба багаар халхлагдаагүй нүцгэн газруудыг нь хэдэн зуун зүүгээр хатгах мэт болов. Энэ нь бүх багуудыг оролцож буй нийгмийн тулалдаанд ороход хүргэв: бусдын адил сүйх тэргэн дотроо босож зогсоод өөрийн бүх л чадал хүч, самбаа залиг гарган өндөг, өнгийн цаасаар хариу тулалдаж эхлэв.

Хатуу ширүүн тулаан эхлэв. Хагас цагийн өмнө болсон явдал хоёр найзын санаанаас бүрэн арчигдан алга болжээ. Тэдний өмнө болж байгаа эрээн мяраан, толгой эргэм үзэгдэл тэр хоёрыг тэр чигээр нь залгин авав. Монте-К°исто гүнгийн тухайд гэвэл, цаазын үед тайван байдлаа нэг ч хором алдаагүй гэдгиг дээр өгүүлсэн билээ.

Тагт, цонх нь бүгд хивс, хөшгөөр бүрэгдсэн ордуудаар эмжээрлэгдэж, тагт цонхнууд дээр нь ром, итали, дэлхийн улс бүхнээс ирсэн гадаадын хүмүүс зэрэг цус, мөнгө, авьяас билгийн сурвалтнууд болох гурван зуун мянган хүн зогсож, сайхан юманд саатаж хөгжсөн хүүхнүүд тагт, цонхноос бөхийлцөж доогуураа зөрөлдөн яваа хүмүүсийг цаасан ширхэгээр шидэхэд, хариуд нь цэцгийн

баглаагаар чулуудаж буй Корсогийн урт гудамжийг төсөөл л дөө. Агаарт бүх өнгийн цаас, цэцэг эргэлдэж, газарт хамгийн хачин жигтэй хувцас өмссөн хүмүүс бужигналдана. Асар том байцаа, үхэр толгойтой хүн бөгстэй мөөрсөн амьтан, хойд хөл дээрээ босон нохой шиг явж байгаа нь харагдах бөгөөд, гэнэт энэ бужигналдан үймэлдсэн олны дотор Каллогийн зүүдэнд үзэгдсэн гэгээн Антонийн алдаст байдаг шиг байгаа өргөн гайхам сайхан царайгаа гаргасан Астарта гарч ирэхэд хүмүүс шохоорхон хойноос дагахад, шөнө зүүдэнд ордог чөтгөр шиг ороолонгууд замы нь хааж саад хийгээд явуулж өгөхгүй байна гээд дотроо дүрслэн бодоод үз, тэгвэл Ромын багт наадам гэж юу байдаг нь муухан төсөөлөгдөнө.

Гүн Корсогоор хоёр дахин нааш цааш явсны дараа, гүн сүйх тэрэгнүүд зогсохыг ашиглан тэдний мэдэлд тэргээ орхиод явах зөвшөөрөл гуйв. Франц толгойгоо дээш болгож, палаццо Росполиин нүүрэн талыг харав. Улаан хэрээстэй цагаан хөшиг татсан дунд талын цонхон дээр багт наадмын хөх дээл үзэгдэв. Арджентинын театрт харсан өнөөх үл таних, гоо хүүхэн Францын бодолд дорхноо буугаад ирлээ.

Гүн сүйх тэрэгнээс гарах зуураа,

- Эрхмүүд ээ, та нар жүжиглэж ханаад үзэгч болцгооё гэж хүсвэл цонхны дэргэдэх суудал хүлээж байгаа гэдгийг бүү мартаарай. Тэр хүртлээ миний хөтөч, сүйх тэрэг, зарцыг хэрэглэж байгаарай гэж хэлэв.

Гүнгийн хөтөч «Баавгай ба Их сайдад» гардаг Одриатай яг адилхан хар баавгай шиг хувцаслаж, ар талд нь зогсож яваа зарц нар нь ногоон сармагчин шиг хувцасласан бөгөөд нүүрний баг нь пүрштэй болохоор дайралдсан хүмүүс өөд зүс царайгаа янз янз болгож явааг өгүүлэхээ бид мартчихаж шүү.

Франц, гүнгийн найрсаг занд хариу талархав. Харин Альберын тухайд гэвэл эгдүүтэй хувцасласан хөдөөгийн хүүхнүүд суусан сүйх тэрэг уруу цэцэг шидээд завгүй байв.

Гай болоход сүйх тэрэгнүүд хөдөлж, Альберыг Пьяцца-дель-Пополо уруу авч явахад анхаарлыг нь татсан сүйх тэрэг Венецийн ордон өөд чиглэв.

- Та харав уу? гэж Францаас асуухад
- Юу тэр вэ? гэж Франц хэлэв.
- Тариачин хүүхнүүд суулгасан тэр сүйх тэргийг?
- Үгүй шүү.
- Харамсалтай хэрэг! Гайхалтай хөөрхөн хүүхнүүд шиг байна.

- Та баг өмсчихсөн байсан нь юутай харамсалтай уг нь, одоо л амжилтгүй явж байгаагийнхаа хариуг авч болох цаг санж гэж Франц хэлэв. Тэгэхэд цаадах нь тоглоом, тохуу хоёрын хооронд,

- Багт наадам намайг нэгэн юмаар шагнах байх гэж маш их Жорьдож байна гэж хариулав.

Альберийн горьдлого талаар болж, энэ өдөр өнөөх сүйх тэрэгтэй хэд дахин дайралдсанаас өөр гойд юу ч Уолсонгүй. Ингэж дайралдаж байх үед нэг удаа Альберын баг зориуд юм уу, үгүй юм уу бүү мэд нүүрээсээ ойчив.

Тэгэхээр нь үлдсэн бүх цэцгээ тэврэн авч нөгөө сүйх уруу чулуудав.

Тариачин хүүхний хувцас өмссөн ч гоо сайхан хүүхнүүд гэдгий нь Альбер таагаад байгаа бүсгүйчүүдийн нэг нь түүний анхаарал тавьсанд уярав бололтой залуу хүмүүсийн сууж явсан сүйх тэрэг дахин зэрэгцэж ирэхэд өнөө хүүхэн нил цэцгийн багцыг тэдэн уруу шидлээ. Альбер түүнийг нь шүүрэн авав. Франц цэцгийн баглааг өөртөө ирүүлсэн гэж бодох ямар ч үндэс байхгүй тул Альберийг авахад нь саад болсонгүй. Альбер цэцгийг авч энгэртээ хатгаад их л хангалуунаар цааш явав.

-За тэр дурлалын аяны чинь эхлэлт болж байх шив дээ! гэж Франц хэлэхэд,

- Хэчнээн л бол хэчнээн доог хий гэж Альбер хариулаад - Үнэн хэрэг дээрээ тийм болж байна гэж би бодож байна. Одоо энэ цэцгийг биеэсээ салгахгүй гэж хэлэв.

- Тэгэлгүй яах вэ! Үүнгүйгээр яаж бие биеэ таних вэ? гэж Франц хэлээд инээв.

Гэтэл тоглоом тохуу нь үнэн байдал болж Франц, Альбер хоёрыг өнөөх сүйх тэрэгтэй дахин дайралдахад нөгөө цэцг шидсэн баг цэцгийг нь Альбер энгэртээ хатгасан байхыг хараад алга ташиж байлаа.

- Догь, догь! Санасан хэрэг сэтгэлчлэн бүтэж байна. Та ганцаараа хоцроно гэж хүсэж байгаа юм биш байгаа? Гэж Францын асуухад,

-Үгүй, үгүй, яарах хэрэггүй! Тэр хүүхэн намайг амархан т тчихлаа гэж бодохгүй байг. Хэрвээ хөдөөгийн гоо хүүхэн тоглоомоо үргэлжлүүлэе гэж таалж байгаа бол бид түүнийг маргааш олно, чухамдаа тэр хүүхэн биднийг олно. Тэгээд өөрийгөө мэдэгдэг. Тэр үед нь л яахыгаа шийдье гэв.

-Зүйтэй Альбер, та Нестор шиг мэргэн, Улисс шиг ухаантай хүн юм. Хэрвээ таны Цирцея таныг ямар нэгэн адгуус болгож хувиргаж чадвал, тэр хүүхэн эсвэл маш уран чадварлаг эсвэл маш их хүчирхэг хүн байх ёстой.

-Альберийн хэлсэн зөв байжээ. Үл таних гоо хүүхэн энэ өдөр тоглоомоо үргэлжлүүлэхгүйгээр шийдсэн бололтой. Залуу хүмүүс дахин хэдэн удаа тойрсон боловч тариачин хүүхнүүдийн суусан тэрэг ер үзэгдсэнгүй. Бодвол хажуугийн нэгэн гудамж уруу эргээд явчихсан бололтой.

Тэгээд тэр хоёр палаццо Росполид эргэж ирвэл тэнд гүн ч, юүдэнтэй цэнхэр цув ч алга байлаа. Шар хөшигтэй цонхон дээр зогсож байгаа хүмүүс бодвол гүнгийн урьсан хүмүүс байж таарав.

Энэ үед багт наадам эхэлснийг зарлан дуугарсан хонх одоо түүний төгсөж байгааг нь мэдэгдэн цохив. Тэгэхэд гинж мэт цувралдан явсан сүйх тэрэгнүүд тасран тал тал тийшээ тархаж хажуугийн гудамжуудаар оров.

Франц, Альбер хоёр яг виа делла Мараттегийн эсрэг талд явж байсан болохоор хөтөч юу ч дуугаралгүй шууд хажуу тийш эргэж палаццио Полиг өнгөрөн, Пьяцца-де-Спапья уруу гарч зочид буудал өөд явав.

Пастрини гуай зочдоо угтахаар гарч ирэв.

Франц юуны өмнө гүнг сураглаж, цагт нь араас нь очиж чадсангүйгээ харамсаж байгааг илэрхийлэхийг урьдал болгов. Гэвч Пастрини түүнд гүнг өөр сүйх тэрэг захиалж, палаццио Росполи уруу явсан гэж хэлж сэтгэлийг нь амраалаа. Түүнээс гадна гүн Аржентины театр дахь лоожныхоо түлхүүрийг залуу хүмүүст өгөөрэй гэж түүнд орхижээ.

Франц, Альбераас орой юу хийх төлөвлөгөөтэй байна гэж асуухад Альбер театрын тухай бодох байтугай өөр нэгэн юм бодоод завгүй байв. Тэгээд Францад хариу хэлэхийн оронд Пастрини гуайгаас сайван олдох болов уу гэж асуув.

- Сайван ий? Яах нь вэ? гэж эзэн хэлэхэд,
- Маргааш хэрэглэх тариачин хүний хоёр хувцас оёулья гэж Альбер хариулав.

Пастрини гуай толгой сэгсэрч,

- Танд маргааш хэрэглэх хоёр костюм оёх гэнээ? Гэж дуу алдаад - Бүү гомдоорой, таны энэ чинь ёстой л франц хүмүүсийн хүсэл байна даа. Хоёр костюм шүү! Та багт наадмын долоо хоногт хантаазандаа нэг бүрий нь нэг скудоор хадуулах ч гэсэн зургаахан ширхэг товч хадаад өгөх хүн олохгүй! гэв.

- Тэгвэл ийм хувцас олох боломжгүй юм шив дээ.

- Яалаа гэж тэр вэ? Бэлэн хувцас олж болно. Энэ ажлыг надад даалгаад л орхи, маргааш өглөө ээрэхэд тань бүрх малгай, цамц, өмд овоолгоотой л байж байх бий. Бүү санаа зов, сэтгэлд тань таалагдах байх.

- Найз минь гээд Франц Альбер өөд хандаж - Эзэнд найдъя. Зайтай хүн гэдгээ харуулсан шүү дээ. Алив одоо хоолоо идье, дараа нь «Итали хүүхэн Алжирт»-ыг очиж үзье гэж хэлэв.

- Тэгэх юм байна. «Итали хүүхэн Алжирт» -г үзье гэж Альбер зөвшөөрөөд, - Харин Пастрини гуай битгий мартаарай, надад бас миний найзад гээд Франц өөд зааж - Маргааш л түрүүчийн хэлсэн хувцас хэрэгтэй гэдгийг бүү мартаарай гэж хэлэв.

Эзэн, хүндэт тэр хоёрыг санаа зовох явдалгүй, хүссэн ёсоор бүтнэ гэж дахин батлан хэлэхэд Франц, Альбер хоёр багт наадмынхаа хувцсыг тайлахаар өрөө уруугаа явав.

Альбер нил цэцгээ нямбайлан далд хийв. Энэ бол өнөөх гоо сайхан тариачин хүүхэн түүнийг таних тэмдэг нь байлаа.

Найз хоёр хоолоо идэхээр суув. Эрхэм Пастрини ба Монте-Кристо гүн хоёрын хоолны хоорондох ялгааг Альбер ажиглахгүй өнгөрч чадсангүй. Франц гүнд жаахан сэжигтэй ханддаг боловч үнэндээ зэрэгцүүлэлт нь зочид буудлын тогоочид даанч ашиггүй байлаа.

Амттан авчирч өгсний дараа зарц тэднээс хэдэн цагт сүйх тэрэг хэрэгтэй болохыг лавлав. Альбер, Франц хоёр шийдэж чадахгүй бие биеэ харав. Зарц тэдний бодлыг тааж,

- Эрхэмсэг дээдэс Монте-Кристо гүн сүйх тэргийг бүтэн өдөр та нарын мэдэлд байлга гэсэн. Тэгэхээр эрхмүүд зоволтгүй хэрэглэж болно гэж хэлэв.

Залуу хүмүүс гүнгийн найрсгаар анхаарал тавьсныг аёиглахаар шийдэв. Тэргээ хөллөж байхыг тушаагаад олон олон тулааны үеэр үрчийсэн хувцсаа солихоор явав.

Залуу хүмүүс хувцсаа сольж өмсөөд театрт очиж, гүнгийн лоожид суулаа.

Нэгдүгээр үзэгдлийн дундуур гүнгийн хатан Г лоожиндоо орж ирэв. Тэгээд юуны өмнө урьд өдөр нь гүнгийн сууж байсан тэр зүг хартал, түрүүнд нь Францад хачин санагдсанаа хэлж байсан хүний лоожид Франц, Альбер хоёр сууж байхыг харлаа.

Түүний дуран өөр дээр нь махруу чиглэж байгааг мэдээд хүүхний сонирхсон зүйлд хариу өгөхгүй байх нь эвгүй хэрэг гэдгийг Франц ойлгов. Иймээс италийн

дээдэс үзэгчдийн танхимыг зочдын өрөө болгон хувиргадаг эрх ямбатай байдгийг ашиглан, хоёр найз хатагтайг хүндэтгэж байгаагаа үзүүлэх гэж лоожноосоо гарч түүн уруу явав.

Тэр хоёрыг бараг орж амжаагүй байтал хатагтай Францад өөрийнхөө дэргэдэх хүндэтгэлийн суудлыг заав.

Альбер ар талд нь суув.

- За тэгээд гэж хатан Францыг сууж амжаагүй шахам байтал хэлээд, - Та шинэ гарч ирсэн лорд Рутвентэй цаг алдалгүй танилцаж, тэр ч байтугай найзалж амжсан байх шив? Гэв.

- Таны бодож байгаа шиг тийм дотносог биш л дээ. Гэхдээ бид хоёр өнөөдөр бүтэн өдөржингөө найрсаг зочлолыг нь хүлээж өнгөрсөн гэдгийг үгүйсгэх зүрх хүрэхгүй байна гэж Франц хариулав.

- Бүтэн өдөр ий?

- Тийм ээ бүтэн өдөр, өглөө нь бид тэднийд өглөөний зууш идсэн, өдөр нь сүйх тэргээр нь Корсогоор зугаалсан, ингээд орой нь лоожинд нь сууж байна.

- Та тэгэхээр түүнтэй т нил байх нь ээ?

- Тийм ч биш, үгүй ч биш.

- Яагаад тэр вэ?

- Энэ бол урт түүх байгаа см.

- Та түүнийгээ надад ярьж өгөх үү?

- Ай, энэ түүх таныг айлгачихна.

- Тэр тусмаа л сайн.

- Тэгвэл адаглаад энэ явдал тайлагдтал хүлээж бай.

- За тэгвэл сайн, би бүрэн бүтэн өгүүлэл сонсох дуртай. Гэхдээ та яаж уулзсанаа ч болсон ярьж өгөөч? Хэн та нарыг танилцуулсан бэ?

- Хэн ч үгүй. Тэр өөрөө бидэнтэй танилцсан.

- Хэзээ?

- Өчигдөр орой, та бид хоёрын салж явсны дараа
- Ямаршуухан маягаар танилцав?
- Манай зочид буудлын эзнээр зуучлуулан жирийн л нэг танилцсан.
- Тэгвэл тэр хүн бас «Лондон» зочид буудалд байрлаж байгаа юм уу?
- Тийм ээ, тэр ч байтугай бидэнтэй зэргэлдээ шүү.
- Нэрийн нь хэн гэдэг юм бэ? Та нэрийг нь мэдэх ёстой доо.
- Мэдээж хэрэг. Монте-Кристо гүн гэдэг.
- Юу гэсэн үг вэ? Энэ чинь үе уламжилсан нэр биш байна.
- Бишээ, энэ бол түүний худалдаж авсан арлын нэр.
- Тэгээд тэр чинь гүн хүн юм уу?
- Тосканы гүн.
- За яах вэ, энүүнийг нь ч бас залгиж орхиё гэж венецийн эртний удамт хатагтай хэлээд - Тэр тэгээд ямар хүн юм бэ дээ? гэв.
- Де Морсер бэйсээс асуу л даа.
- Дуулж байгаа биз дээ, бэйс. Намайг тан уруу зааж байна гэж хатагтайг хэлэхэд,
- Хатагтай минь бид түүнийг сэтгэл татмаар хүн гэж үзэхгүй бол хэтэрхий гоочломтгой хүмүүс болно гэж Альбер хариулаад - арван жил найзалсан хүн ч гэсэн бидний төлөө түүний хийсэн зүйлийг хийхгүй байсан даа. Тэгэхээр ямар их анхаарал санаачлагатай, найрсаг гээч! Язгууртан дээдсийн хүрээлэнгийн хүн гэдэгт эргэлзэх юм алга гэв.
- •арж байгаа биз дээ гээд хатагта© инээмсэглэснээ - Миний ороолон гээд байгаа хүн олон сая мөнгий нь уучилж үзээсэй гэж хүссэн ямар нэг зайгуул этгээд, ийм учраас эрхэм Рочильдтой өөрийгөө андуурахгүй байгаасай гэж Лара болж харагдах гэсэн амьтан байна. Харин та нөгөөдөхий нь харсан уу? гэв.
- Нөгөөдөх нь гэж хэн бэ? хэмээн Франц инээмсэглэн асуухад,
- Өчигдрийн гоо сайхан грег хүүхнийг? Гэв.

- Үгүй бид зөвхөн хөгжимдөхийг нь сонсох шиг болсон, харин өөрийг нь харж чадаагүй,

- Эрхэм Франц та битгий битүүлэг юм болгоод бай. Тэгвэл цагаан хөшигтэй цонхны дэргэд сууж байсан юүдэнтэй цэнхэр цувтай хүн хэн байх вэ гэж Альбер хэлэхэд,

- Тэр цонх чинь хаана байсан юм бэ? Гэж хатагтай асуув.

- Палаццио Росполид

- Тэгвэл палаццио Росполид гүн цонхтой байсан байх нь ээ?

- Тийм ээ, та Корсод байв уу?

- Байлгүй яах вэ, байсан.

- Тэгвэл шар хөшигтэй хоёр цонх, улаан хэрээстэй цагаан хөшигтэй нэг цонх байсныг ажигласан уу? Энэ гурван цонх гүнгийнх байсан юм.

- Тэгвэл энэ чинь ёстой энэтхэгийн баян хүн байна! Багт наадмын үеэр тэгээд бас Корсогийн хамгийн сайхан баяр болох палаццио Росполид ийм гурван цонх ямар үнэтэй байдгийг та мэдэх үү?

- Ромын хоёр буюу гурван зуун скудо л биз.

- Үгүй хоёр гурван мянга л гэж хэлбэл дээр.

- Ай, чөтгөр ав.

- Түүний арал ийм их орлого өгдөг юм уу?

- Арал нь ий? Тэр арал сохор зоосны ч орлого өгдөггүй.

- Тэгвэл арлыг яах гэж худалдаж авсан юм бол?

- Саваагүйтэж л авсан байх.

- Тийм хачин хүн үү?

- Тийм ээ, надад баахан өвөрмөц хачин хүн шиг санагдсан шүү гэж Альбер хэлээд - Хэрвээ Парист сууж ихэс дээдсийн дотор гарч ирвэл, би түүнийг инээдэм ханиадам болгож явдаг илбэч эсвэл утга зохиол уншсаар байгаад ухаан нь эвдэрчихсэн хүн гэж хэлэх байна. Өнөөдөр тэрээр Дидье! буюу Антони! хэлж баймаар номлол хэлсэн шүү гэв.

Лоожид нь өөр хүн орж ирсэн учир Франц ёсыг сахин сандлаа тавьж өгөөд, яриа ч өөр чиглэлтэй боллоо.

Цагийн дараа найз хоёр зочид буудалдаа буцаж ирэв. Пастрини гуай тэдний хувцасны тухай хэдийнэ санаа тавьж, олж ирсэнд нь сэтгэл хангагдана гэж итгүүлж байв.

Нээрээ ч маргааш өглөө нь Пастрини гуай, арван цагт ромын тариачдын хувцас үүрсэн сайван дагуулсаар Францын өрөөнд орж ирэв. Хоёр найз биедээ таарах адилхан хувцас шилж аваад, бүрх малгайд нь хорь хорин метр тууз хад гэж тушаагаад, тариачид баярын өдрүүдэд бүсэлдэг хөндлөн судалтай торгон бүс нэг нэгийг олж ир гэв.

Шинэ хувцас нь зохиж байгаа эсэхийг харах гэж Альбер тэсэж ядна. Энэ хувцас нь богино дээл, хөх цэнхэр өнгийн хилэн өмд, судалтай оймс, тоногтой шаахай, торгон хантааз байв. Энэ гоё хувцас Альберийн биед зохиж, бүсээ бүсэлж, бүрх малгайгаа духдуулан тавихад Франц түүнийг хараад зарим нэг ард түмэн биеийн байдлаар гоц сайхан байдаг нь хувцаснаасаа их шалтгаалдаг юм байна гэж бодов. Урьд цагт хурц өнгийн урт дээл өмсөж байсан түргүүд одоо бариухан товчилдог сюртук болон улаан лацан бөглөөтэй, дарсны лонх шиг болгосон грег малгай өмсдөг болсон нь ямар зохимжгүй муухай вэ дээ.

Толины өмнө чухам яагаад инээмсэглэж байгаад нь эргэлзэхийн аргагүйгээр зогсож буй Альберт Франц хэдэн үг хэлэв.

Тэднийг ийнхүү байтал Монте-Кристо гүн орж ирэв.

- Эрхмүүд ээ, хэн нэгэн хүнтэй баяр цэнгэлийг хуваалцах нь таатай сайхан боловч дураараа байх нь түүнээс ч илүү таатай байдаг. Иймээс би, өнөөдөр болоод дараах бүх өдөр өчигдрийн чинь хэрэглэсэн сүйх тэргийг та нарын бүрэн мэдэлд өгье гэж хэлэхээр ирлээ. Намайг гурав дөрвөн сүйх тэрэг хэрэглэж байгаа гэж буудлын эзэн та нарт хэлсэн байх, ийм учраас та хоёр надад садаа болохгүй. Энэ сүйх тэргийг зугаа цэнгэл ба ажил хэрэгтээ бүрэн чөлөөтэй ашигла. Та нар надтай уулзмаар байвал би дандаа л палаццо Росполид байна гэж хэлэв.

Залуу хүмүүс эхлээд нэрэлхсэн боловч тэдэнд тэгтлээ татгалзах ноцтой шалтгаан байхгүй учир ийм ашигтай энэ саналыг эцэстээ хүлээн авав.

Монте-Кристо гүн элдвийг чөлөөтэй ярьж арван таван минут хэртэй суув. Бидний дээр тэмдэглэсэнчлэн тэр хүн, орон бүрийн ард түмний утга зохиолтой танилцсан хүн байв. Түүний зочдын өрөөний хана өөд ганц харахад л уран зураг мэддэг гэдэг нь Альбер Франц хоёрт ойлгогдсон билээ. Бас хайнгууд хэлсэн ганц хоёр үг нь шинжлэх ухаанд ойр дотно болохы нь нотлох бөгөөд гол төлөв хувилахуй ухааныг сонирхдог бололтой.

Залуу хүмүүс гүнгийн айрсаг занг мөн тийм маягаар нь хариу барих гэж оролдсонгүй. Түүний амтат сайхан өглөөний зуушны хариуд Пастрини гуайн баазхан хоолыг өгвөл тэдний зүгээс тэнэг хэрэг болно. Тэд үүнийгээ нуулгүй хэлбэл гүн ч тэдний энэ бодлыг дүүрэн үнэлэв.

Альбер гүнгийн зан байдлыг шагшин магтах бөгөөд хэрвээ цаадах нь эрдэмтэн хүн байгаагүйсэн бол гүнг ёстой жентельмен гэх байсан биз ээ. Сүйх тэрэг дураараа хэрэглэх болсон нь түүнийг юунаас ч илүү баярлуулав. Нөгөө гоо сайхан тариачин хүүхнүүдийг л бодсон бөгөөд тэр урьд өдөр нь үлэмж сайхан сүйх тэрэгтэй байсан болохоор тэднээс доор юманд суух хүсэлгүй байв.

Нэг цаг хагаст залуу хүмүүс шатан дээр гарч ирэв. Хөтөч, зарц хоёр араатны арьсан хувцсан дээгүүрээ ёслолын хувцас өмссөн тул өчигдрийнхөөсөө ч инээдтэй болж Альбер Франц хоёрт магтагдав.

Өнгө алдаж муудаж байгаа цэцгийн баглаа Альберын энгэр дээр донжтой унжина.

Хонхны анхны дуугаар виа Витториагийн замаар орж Корсо орохоор чиглэн явав.

Хоёр дахь удаагаа тойрч явтал алиалагчийн хувцас өмссөн хүүхнүүд суусан сүйх тэрэгнээс тэдэн уруу шинэхэн нил цэцгийн баглаа шидэв. Альбер тэднийг хараад өчигдрийн тариачин хүүхнүүд хувцсаа сольсныг ойлгов. Магадгүй санамсаргүй ч юм уу эсвэл дэгжирхэн алиалагчийн хувцас өмсжээ.

Альбер муудаж байгаа цэцгээ шинс цэцгээр сольж хатгаад, хуучин цэцгээ гартаа барьж дахин нөгөө сүйх тэрэгтэй дайралдахдаа түүнийгээ уруулдаа хүгэсэн нь цэцэг шидсэн авхайд төдийгүй хамт явж байсан хөгжилтэй найз авхайчуулд нь ч их л таалагджээ.

Корсо дахь хөл хөдөлгөөн өчигдрийнхөөсөө дутахгүй байлаа. Нарийн ажигламтгай хүн бол хөгжил хөдөлгөөн, шуугиан нэмэгдсэнийг ажиглахаар байлаа. Гүн цонхон дээр хэсэгхэн зуур харагдсан боловч, сүйх тэрэг дахин эргэж ирэхэд алга болчихсон байв.

Альбер ба нил цэцгийн эзэн авхай хоёрын харилцан тоглоом бүтэн өдөр үргэлжилсэн нь мэдээж хэрэг.

Орой нь Франц гэртээ харьж ирээд, элчин сайдын яамнаас нь захидал ирсэн байхыг олж үзэв. Захидалд маргааш түүнийг гэгээн дээдэс хүлээж авч уулзахыг зөвшөөрснийг мэдэгджээ. Тэр Ром хотод ирэх бүрдээ энэ хайр ивээлийг хүсэн гуйдаг ажээ. Франц зөвхөн буян санасандаа төдийгүй баярлаж талархсандаа буянт үйлтнүүдийн дотроос ховорхон тохиох гэгээн Петрийн үе залгамжлагчийн

өлмийд сөгдөн хүндэтгэн ёслохгүйгээр христосын ертөнцийн нийслэлийг орхиж явах дургүй байжээ.

Ийм болохоор маргааш нь багт наадамд оролцоно гэж ярих ч хэрэггүй болжээ. XVI Григорий хэмээх буянт буурлын сүр хүчинд нь тохирох сэтгэлийнх нь сайхныг нь хайхралгүй, түүний өмнө өвдөг сөгдөхөөр догдолж бэлтгэхгүй хүн гэж нэг ч байхгүй.

Франц Ватиканаас гараад Корсогоор дайрахыг ч бодолгүй шууд зочид буудалдаа хүрч ирэв. Сайхан баялоор дүүрэн явсан тул түүнийгээ багт наадмын ухаан жолоогүй үймээнээр үймүүлчихээсээ айжээ.

Таван цагаас арван минут өнгөрч байхад Альбер хүрч ирэв. Тэр ихэд байярлан байсан нөгөө авхай нь тариачин хувцастайгаа дахин гарч ирээд, Альбертай дайралдахдаа багаа өргөжээ.

Тэр нь гайхалтай сайхан хүүхэн байжээ.

Франц Альберт үнэн сэтгэлээсээ баяр хүргэхэд цаадах нь түүнийг тэгэх ёстой юм шиг хүлээн авав. Байгаа байдлыг нь харваас үл таних гоо сайхан хүүхэн язгууртны ангид хамаарагдах нь эргэлзээгүй гэж Альбер баталж байв.

Тэгээд маргааш нь захидал бичихээр хатуу шийджээ.

Франц энэ үгийг сонсоод Альбер түүнээс нэг юм гуйх гэсэн боловч зовоод чадахгүй байна гэдгийг тааварлав. Франц нөхрийнхөө эрх ашиг, аз жаргалын төлөө юугаа ч хайрлахгүй гэдгээ хэлээд асууж шалгааж гарав. Альбер эелдэг ёсонд шаардагдах хэмжээнд хүртэл шалуулж байгаад, сүүлд нь сүйх тэргээ маргааш надад ганцааранд минь хэрэглүүлбэл туйлын их тус болох байна гэж Францад үнэнээ хэлэв.

Тариачин хувцастай гоо сайхан хүүхэн өөрийг нь ганцаараа явсан болохоор багаа авсан байх гэж Альбер бодсон ажээ.

Франц бол тийм сайхан учрал тохиолдол болох гэж ид оргилж байгаа үед нь Альберт саад болохоор хувиа бодсон хүн биш нь мэдээж. Франц хөнгөмсөг найзынхаа нэрэлхдэггүй чалчаа яриаг сайн мэдэх тул тохиолдсон явдлаа нэгд нэггүй ярина гэдэгт эргэлзэхгүй байсан бөгөөд өөрөө гурван жилийн турш бүх Италиар хэрэн хэсэн явсан боловч нэг ч удаа жог ургуулж яваагүй тул, энэ явдал хэрхэн болдгийг мэдэхээс буцахгүй байв.

Тэгээд зөвхөн үзэгчийн маягаар багт наадмыг палаццо Росполиин цонхоор сонирхъё гэж ам өгөв.

Маргааш нь Франц хэлсэн үгэндээ хүрч, цонхон дээр зогсоод Альберийг Корсогоор хойш урагш зугаацан явж байгааг харж байв. Альберын гартаа барьсан цэцгийн том баглаанд дурлалын зурвас лавтай хавчуулсан байгаа нь эргэлзээгүй. Алиалагчийн хувцас өмссөн үзэсгэлэнт авхайн гарт өнөөх боодолтой цэцэг нь байхыг хараад түрүүчийн тааварласан нь үнэн болохыг Франц мэдэв.

Альбер гэртээ эргэж ирэхдээ сэтгэл хөдлөөд зогссонгүй бүр ухаан алдталаа баярлажээ. Гоо сайхан хүүхэн түүнд дээрхийн адил хариу илгээнэ гэдэгт Альбер огтхон ч эргэлзэхгүй байлаа. Франц хүслий нь дагуулан, энэ шуугиан үймээнээс залхуу хүрч байна, маргааш бүтэн өдөр альбом, тэмдэглэлээрээ оролдож өнгөрнө гэж хэлэв.

Альберын урьдаас зөгнөсөн нь андуу болсонгүй.

Маргааш орой нь дөрвөлжин эвхсэн цаас барьчихсан Францын өрөөнд гүйхээрээ орж ирээд,

- Юу болсон гээч! Би юу гэж хэллээ! Гэж дуу алдав.
- Хүүхэн хариу ирүүлээ юү? Гэж Франц мөн адил дуу алдаж асуув.
- Уншаач гэхдээ хэлэхийн аргагүй хөөр баяр дүүрэн өнгөөр хэлэв.

Франц зурвасыг авч уншсан нь:

«Мягмар гаригийн орой, долоон цагт виа дель Понтефичийн урьд очоод сүйх тэрэгнээсээ гарч, таны гараас мокколеттогийн тань булаан авах хүүхнийг дагаж яваарай. Тэгээд та Сан Жакомо сүмийн эхний шатан дээр гармагц хувцсандаа ягаан тууз уяхаа битгий мартаарай.

Хоёр дахь өдөр болтол та надтай уулзахгүй.

Үнэнчийг сахиж, нууцыг хадгал.»

Францыг уншиж дуусмагц Альбер,

- За, сайн нөхөр минь үүнийг та юу гэж үзэж байна? гэж асуув.
- Ажил явдал чинь бүтэмжтэй тал уруугаа эргэж байна гэж хэлэх байна хэмээн Франц хариулав.
- Би ч бас тэгж бодож байна. Таныг Браччано бэйлийн наадамд ганцаараа очиж болох бий гэж айж байна гэв.

Франц Альбер хоёрыг өглөө нь ромын нэрт банкны эзэн багт наадамдаа урьсан юм байжээ.

- Альбер минь, бэйлийнд эндхийн бүх нэр алдартан цуглана гэдгийг бодоорой. Хэрвээ тэр үл таних бүсгүй чинь нээрээ л язгууртан хүн бол тэнд заавал ирэх ёстой доо гэж Франц хэлэхэд Альбер,

- Тэр ирсэн ирээгүй хамаагүй, түүний тухай өөрийн бодлоо би өөрчлөхгүй. Та захидлы нь уншсан биз дээ? гэж асуув.

- Тэгсээн.

- Италид дунд давхаргын бүсгүйчүүл ямар боловсрол олж авдгийг мэдэх үү?

- Мэднэ ээ гэж Франц хариулав.

- Тэгвэл энэ зурвасыг уншаад, үг үсэг, утга найруулгын алдаа ол л доо.

Нээрээ ч цэвэр сайхан, алдаа мадаггүй бичиг байв.

- Та ч азтай хүн юм аа! гээд Франц зурвасы нь эгүүлэн өгөв.

- Та хичнээн л тоглоом тохуу хийвэл хий, харин би дурлачихаад байна гэж Альбер өөдөөс нь хэллээ.

- Бурхан минь айдас хүрэх шиг боллоо. Би зөвхөн бэйл Браччаногийг наадамд ганцаараа очоод зогсохгүй, Флоренц уруугаа ч ганцаараа буцах болох нь шиг байна гэж Франц хэлэв.

- Юу ч л гэсэн, миний үл таних бүсгүй гоо сайхан шигээ найрсаг зантай байвал би Ромд дор хаяж зургаан долоо хоног байна гэдгээ эрс шийдвэртэй хэлж чадах байна. Би Ром хотыг эрхэмлэж явдгаас гадна бас хуучны судлалд сүсэлдэг хүн.

- Дахиад хоёр гурван ийм явдал гарвал, би таныг бичээс, уран үг дүрслэлийн академийн гишүүн болчихсон байхыг тань үзэх юм байна даа.

Альбер академийн ширээнд суух эрхтэй болох тухайгаа их л тухтайгаар тайлбарлан ярьж эхлэх гэтэл зарц орж ирээд хоол бэлэн болсныг мэдэгдэв. Альбер дурлалаас болж хоолонд муудаж байсан удаа ер үгүй билээ. Тийм учраас хоол идсэний дараа яриагаа үргэлжлүүлэхээр яаран хоолны ширээнд очиж суув.

Гэтэл хоолны дараа Монте-Кристо гүн ирснийг мэдэгдэв. Залуу хүмүүс хоёр өдөр түүнтэй уулзаагүй байсан ажээ. Ажил хэргээр Чивита-Векки орохоор явсан

гэдгийг Пастриниас дуулсан байжээ. Гүн урьд орой нь явсан бөгөөд эргэж ирсээр дөнгөж ганц цаг болоод байгаа ажээ. Гүн маш найрсаг сайхан зантай байв. Эсвэл биеэ барьж байсан, эсвэл эгдүүтэй гашуун үг хэлэх шалтаг олноогүй юм уу, ямар боловч энэ орой бусад бүх хүмүүсийн адил байлаа. Энэ бол францад тайлбарлаж болшгүй таавар мэт санагдана. Монте-Кристо арал дээр өөрийнд нь зочлон ирсэн энэ хүн, өөрийг нь таньж байна гэж гүн мэдэж байлаа. Гэсэн хэдий боловч гүн дахин уулзсанаасаа хойш өмнө нь үзсэн юм байна гэж ганц ч үг дуугарсангүй. Франц ч гэсэн түүнд урьд дайралдсанаа хэлэх гэж маш их хүсэм боловч өөрсөдтэй нь тийм их бо«гоомжтой харьцаж байгаа хүний сэтгэлд эвгүй юм санагдуулчих вий хэмээн цэгнэх учир гүнгийн адилаар тоглоомоо үргэлжлүүлсээр байв.

Франц Альбер хоёр Аржентины театрт лоож худалдан авах гэсэн боловч бүх лоожийг эзлэн авсан учир суудал олж чадаагүй гэж дуулаад Монте-Кристо лоожныхоо түлхүүрийг авчирлаа гэж энэ удаа орж ирсэн хэргээ тайлбарлав.

Альбер, Франц хоёр түүний тохийг алдуулчих байх гээд татгалзах гэсэн боловч, гүн өөрөө Паллийн театрт юм үзнэ. Тэгэхээр та хоёр миний лоожийг хэрэглэхгүй бол Аржентины театрт байгаа лоож минь хоосон байх болно гэж хэлэв.

Ингэж хэлэхээр нь Альбер, Франц хоёр зөвшөөрчээ.

Франц анх уулзахдаа ихэд гайхсан гүнгийн цагаан царайд бага багаар дасаж байв. Гол дутагдал нь буюу гол ололт нь болсон цав цагаан өнгөтэй царайных нь цэвэрхэн сайхныг хүлээн зөвшөөрөхгүй байж чадсангүй. Гүн бол ёстой Байроны зохиолын баатар шиг бөгөөд Франц түүнийг үзэхийн төдий ч биш харин санаандаа дүрслэн бодоход л түүний баргар толгойг Манфедрын мөрөн дээр буюу эсвэл Ларын бүрх малгай доор байгаа шигээр бодно. Гашуун бодолд автагдсаныг нь духны нь үрчлээс илтгэнэ. Хурц нүд нь хүний сэтгэлийн гүнд ортол нэвт шувт харна. Эгдүүтэйхэн бардам уруул нь түүний ярьж байгаа бүх зүйлд онцгой өнгө шинж байдлыг өгч, үүний ачаар ярьж байгаа зүйл нь сонсогч хүний тархинд арилшгүйгээр шингэн орно.

Гүн дөчөөд нас хүрсэн бололтой боловч өрсөлдөгч ямар ч залууг дийлж чада гэдэгт хэн ч эргэлзэхгүй биз. Английн яруу найрагчийн урнаар сэтгэн гаргасан баатруудтай адилаар сайхан зантай хүн ажээ.

Энэхүү үнэлж баршгүй хүнтэй танилцуулсан азтай учралын тухай Альбер байн байн батлан ярина. Франц нэлээд биеэ барих боловч өнөөх хачирхалтай хүний орчиндоо нөлөөлөх нөлөөлөлд бас л автжээ.

Франц, гүнг Парис орно гэж хэдэн удаа ярьсныг санаад зан ааш, гадаад байдал хэмжээ хязгааргүй баялгаараа үнэхээр тэнд шуугиан дэгдээнэ гэдэгт эргэлзсэнгүй.

Хэдий тийм боловч түүнтэй нэг зэрэг Парист байхыг хүсэхгүй байлаа.

Үдэшлэг бол италийн театруудын ердийн заншлаар болж, үзэгчид дуучдын дуулахыг чагнахын оронд бие биеийнхээ лоожуудаар зочлоно. Хатагтай Г гүнгийн тухай яримаар байсан авч Франц илүү сонин зүйл байна гэж Альберыг эсэргүүцсээр байтал, өнөөх гурван өдрийн турш хоёр найзын санаа бодлыг эзэлж байгаа хэргийнхээ тухай хатанд ярьж өгөв.

Италиар жуулчлан яваа хүмүүст ийм явдал тохиолдох нь ховор биш байдаг тул хатагтай огтхон ч гайхсангүй, аятай сайхнаар төгсөх төлөвтэй эхэлж байгаа Альберын дурлалын явдалд баяр хүргэв.

Хоёр залуу, хатагтайтай Ромынхон бараг цөм уригдсан бэйл Браччаногийн наадам дээр уулзана гэж ярилцан тохиров. Өнөөх гоо хүүхэн хэлсэн үгэндээ хүрч маргааш нь ч, нөгөөдөр нь ч гэсэн эснэ мэнд байгаагаа Альберт мэдэгдсэнгүй.

Тэгтэл арай гэж багт наадмын хамгийн хөл хөдөлгөөнтэй сүүлчийн өдөр мягмар гариг боллоо. Оройн найман цагаас мацаг эхлэх тул энэ өдөр театрууд өглөөний арван цагаас онгойв. Мөнгө хүрээгүй, зав байгаагүй, эсвэл дур нь хүрээгүй учир баярт оролцож чадаагүй хүмүүс энэ өдөр баяртай оролцож нийтийн хөл хөдөлгөөн шуугиан үймээнд өөрсдийн хувь нэмрийг оруулна.

Франц Альбер хоёр өдрийн хоёр цагаас таван цаг хүртэл сүйх тэрэгтэй хүмүүс мөн тэрэгний хоорондуур, морьдын хөлд орчих шахан яваа явган хүмүүстэй өнгийн сүлжмэл цаасаар шидэлцэн явж өнгөрөв. Тоо томшгүй олон хүн шахцалдан явах боловч нэг ч аюул осол, хэрүүл маргаан, зодоон цохион гарсангүй. Италичууд бол энэ талаар гайхалтай ардууд. Эдэнд баяр наадам гэдэг бол үнэхээрийн жинхэнэ наадам байдаг. Энэ туужийг зохиогч Италид зургаан жил шахам суухдаа манайхны багт наадмын үед алба шиг тохиолдож байдаг явдлаар багт наадам нь үймүүлэгдэж байсан тохиолдлыг нэг ч үзсэнгүй билээ.

Альбер алиалагчийнхаа хувцсыг өмсөж гоёод мөрнөөс нь өвдгийг нь хүртэл намирсан ягаан тууз унжуулжээ. Андуурагдахгүйн тулд Франц тариачин хүний хувцас өмсжээ.

Үдэш ойртох тутам улам ч чимээ шуугиантай боллоо. Явган зам, сүйх тэргүүд, цонхны дэргэд дув дуугүй байгаа ам, хөдөлж даллаагүй гар гэж огт байсангүй. Энэ бол хашхиралдаан шуугилдаан, өнгөт эрээн цаас, чихэр, гурилтай өндөг, жүрж, өнгө өнгийн цэцгүүдийн бөөгнөрсөн их хөлтэй, үнэхээр хүн зоны амьд шуурган мэт байлаа.

Гурван цагт их бууны дуу энэ галзуурсан мэт шуугианыг арай гСж дарав. Пьяцца дель Пополо ба Венецийн ордны дэргэд нэгэн зэрэг дуугарч морин уралдаан эхэлснийг зарлав. Морин уралдаан бол мокколийн адил багт наадмын сүүлчийн өдөр заавал болдог байв. Буун дуугаар сүйх тэргүүд цуваанаасаа гарч,

хажуугийн гудамжаар асгаран оров. Энэ бүхэн нь цагдаа зам чигийг нь заахгүй байхад гайхалтай түргэн шалмаг гүйцэтгэгдэнэ.

Явган хүмүүс байшинд шахаж наалдахад, морьдын төвөргөөн, сэлмийн харшилдах дуу сонстов.

Морьт цагдаа нар арван тав таван хүнээр эгнэн жагсаж, уралдааны зам цэвэрлэн Корсо гудамжаар давхилдав. Энэ отряд Венецийн ордныг хүрэхэд их буудахин буудаж гудамж чөлөөтэй болсныг зарлан мэдэгдэв.

Тэр үед чих дүлийрэм их чимээн дунд, гурван зуун мянган хүний хашхиралдах дууны дундуур найман морь сүүдэр мэт хурдлан давхив. Хэсэг болсны дараа гэгээн Ангелын шигтгээнээс гурван удаа их буугаар буудах чимээ сонстож энэ нь гурав дахь морь түрүүлснийг мэдэгдсэн хэрэг байв.

Тэр дороо л сүйх тэргүүд ямар ч дохиогүйгээр эгшин зуур саатагдсан голын усанд тавигдах адил зэргэлдээх гудамжуудаас багшран гарч ирж, аварга гол түрүүчийнхээсээ ч илүү хурднаар боржин чулуу эргийн хоорондуур урсаж эхлэв.

Харин одоо энэ урсгалд шуугиан үймээний шинэ эх булаг нэмэгдсэн нь янз бүрийн лаа худалдагчид хүрэлцэн ирсэн явдал байлаа.

Мокколи буюу моколетти гэдэг бол улаан өндөгний баярын үеийн лаанаас эхлэсд, хамгийн нарийхан лааг хүртэл хэлдэг ажээ. Ромын багт наадмын төгсгөлийн үзэгдэлд оролцогч хүмүүст хоёр чухал зүйл гарч ирнэ.

1. Өөрийнхөө лааг унтраалгахгүй байх

2. Бусдын лааг унтраах

Энэ утгаараа моколетто амьдралтай адилхан: хүн бол амьдрах ганцхан арга олсон бөгөөд түүнийгээ бурхнаас олж авчээ.

Харин тэгэхдээ амьдралыг үгүй хийх мянган арга олсон юм. Үнэндээ энүүнд чөтгөр баахан тусалчихсан нь үнэн.

Лаагаа асаахын тулд зөвхөн гал дээр барьчихвал боллоо.

Арьсны тулам, гайхалтай бөхөөгүүр, аварга том дэвүүр гээд л моколеттог унтраах мянга мянган аргыг яахан бичиж барах билээ.

Лаануудыг тэр доор нь худалдан авчхав. Франц Альбер хоёр ч бусдыг дуурайв.

Үдшийн бүрий болж «Мокколи» гэж хашхиралдах хэдэн мянган худалдаачны чих дөжрөм дуун доор цугларсан олны дээгүүр анхны одод асан гэрэлтэв. Энэ нь нийтэд дохио болж, арваад минут ч өнгөрөөгүй байтал Венецийн ордноос Пьяцца дель Пополо хүртэл тавин мянган оч гэрэлтэн асав.

Энэ нь ёстой чөтгөрийн галын баяр гэлтэй байлаа.

Ийм үзэгдлийг сэтгэлдээ багтаан бодоход хэцүү.

Тэнгэрийн одон мичид газарт бууж дуу шуугиант бүжиг хийж байна л гэж бод. Харин агаар тэнгэрт газрын бөмбөрцгийн бусад хэсэг дэх ямар ч хүний чихэнд сонстоогүй тийм их чимээ шуугиан гарна.

Энэ үед, давхарга, зиндааны бүх ялгаа арилан үгүй болно. Тариачин хүн ноёнг хөөж транстeverийн хүн худалдаачинг хөөцөлдөн лаагийн нь унтраан, дахин асаан наадна. Хэрэв энэ үед эртний Эол гарч ирсэн бол, энэ наадмын хаан болох байсан бөгөөд Аквилон нь үе залгамжлах хаан хүү болох байсан биз.

Энэ ач тач үзэлцсэн галт тулалдаан хоёр цаг үргэлжлэв. Корсод өдөр адил саруул, дөрөв тав дахь давхрын цонхон дээр зогсож байсан хүний царайг ялган таньж болохоор байв.

Альбер таван минут болоод л цагаа харна. Цаг нь арай гэж долоо болсныг заав.

Энэ үед хоёр найз виа-де-Понтефичийн дэргэдүүр явж байлаа. Альбер лаагаа гартаа барьсаар сүйх тэрэгнээсээ үсрэн буув.

Хэдэн багтай хүн түүнийг хүрээлэн ирж лаагий нь үлээсэн боловч самбаатай нударган зодоонч мэт тэднийг өөрөөсөө арваад алхам түлхэж холдуулаад Сан-Жакомо сүм уруу харайлгав.

Хүн бүр бие биеийнхээ лааг унтраахыг оролдон үзэлцэж Франц Альберынхаа хойноос ажиглан, сүмийн нэгдүгээр шатан дээр гарахыг нь харав. Бараг тэр дор нь өнөөх сайн таних тариачин хүүхний хувцастай баг гарч ирээд гараа сарвайхад Альбер энэ удаа эсэргүүцэлгүйгээр лаагаа өгөв.

Франц, тэр хоёрын яриаг дуулахын аргагүй хол байв. Гэвч харваас яриа таарав бололтой. Альбер тариачин хүүхэнтэй гар гараасаа хөтөлцөн цааш явлаа. Франц тэднийг бас нэг минут хэртэй харж байгаад хараанаасаа алдчихлаа.

Тэгтэл баг наадам төгссөнийг зарласан хонхны дуу гарч, мөн тэр хоромд шидэт дохиураар дохисон мэт бүх лаа нэгэн зэрэг хүчит салхинд цохигдох лугаа адил унтрав.

Франц пад харанхуйн дунд хоёрров.

Гэрэл гэгээний хамт нөгөө Ёх шуугиан чимээ саяын салхинд туугдан явсан мэт нам болов. Зөвхөн л багт хүмүүсээ байдаг газарт нь хүргэхээр яваа сүйх тэргүүдийн дугуйн чимээ дуулдана. Цонхнуудад хаана нэг гэрэл ёлтолзож харагдана.

Ингэж багт наадам төгслөө.

16. Сан-Себастиано хэмээх сүлжээсэн агуй

Франц амьдралынхаа ингэж хөгжил цэнгэлээс гэнэт уйтгар гунигт шилжин орохыг үзээгүй байж мэдэх юм. Ямар нэгэн шөнийн буг бүх Ром хотыг аварга том булш болгон хувиргасан мэт байлаа. Сар гараагүй учир улам ч түнэр харанхуй юм шиг. Иймээс Францын явж байгаа гудамж тас харанхуй байв. Гэвч явах зам урт биш, аравхан минутын дараа түүний буюу өөрөөр хэлбэл гүнгийн сүйх тэрэг зочид буудлын үүдэнд очиж зогсов.

Хоол бэлэн болсон байжээ. Альбер мөд ирэхгүй байх гэж хэлсэн учир Франц хоолоо идэхээр ганцаараа суулаа.

Тэр хоёрыг дандаа хамт байдгийг мэдэх Пастрини гуай, Альбер хаачсаныг лавлан асуув. Альбер айлд уригдсан гэж Франц хариулав. Гэтэл гэгээ гэнэт үгүй болж, хурц тод гэрлийн оронд харанхуй шөнө болж, шуугиан үймээн, чимээ аниргүй нам гүмээр солигдсон нь Францын сэтгэлд гунит төрүүлж цаанаа л нэг түгшүүртэй болгочихов. Зочломтгой эзэн олонтоо орж ирэн зочны сэтгэл хангалуун байгааг лавлах боловч, хоол дуу чимээгүй өнгөрөв. Франц Альберыгаа чадах ядахынхаа хэрээр хүлээрээх шийдэв. Ийм учраас франц арван нэгэн цагт сүйх тэрэг өгөөрэй гэж Пастринд тушаагаад Альберыг зочид буудалд орлоод ирвэл надад даруй мэдэгдээрэй гэж гуйв. Арван нэгэн цаг болтол Альбер ирсэнгүй, франц шөнийг бэйл Браччанргийн цэнгэлд өнгөрөөнө гэж хэлээд хувцсаа өмсөж гарч явлаа.

Бэйс Браччаногийн байшин бол Ромын хамгийн сайхан байшингуудын нэгэн юм. Эхнэр нь эртний Колоний удамд хамаарах маш сайхан авгай бөгөөд тэдний хүлээн авалт еврап тивд нэртэй гарчээ. Франц, Альбер хоёулаа бэйлд итгэмжлэх захидалтай иржээ. Ийм учраас бэйл Францаас хамгийн түрүүнд хамт яваа нөхөр нь яасныг асуув. Тэгэхэд нь Франц гэрлийн наадам зогсох үед түүнээс салсан виа-Мачеллогийн дэргэл бараагийг нь алдчихлаа гэж хариулав.

-Тэгээд одоо болтол ирээгүй байна уу? гэж бэйл асуухад,

-Би түүнийг арван нэг хүртэл хүлээж байгаад ирлээ гэж Франц хариулав.

-Та түүний хаашаа явсныг мэдэх үү?

-Сайн мэдэхгүй хүнтэй уулзах гээд явсан байх

-Чөтгөр ав! Өнөөдөр чинь орой болтол зугаалахад муу өдөр, Өөрөөр хэлбэл муу шөнө байгаа юм. Тийм биз дээ, гүнгийн хатан аа? гэж бэйл хэлэв.

Энэ сүүлийн үг нь дөнгөж сая бэйлийн ах ноён Торлониатай сугадалцан орж ирсэн гүнгийн хатан Г-д хамаарагджээ.

- Үгүй, би өнөө шөнийг маш сайхан шөнө гэж бодож байна шүү. Энд цугларсан хүмүүс өнөө шөнийг яасан хурдан өнгөрчихөв гэж харамсах байх гэж хэлэхэд бэйл инээмсэглэн,

- Бид энд цугларсан хүмүүсийн тухай яриагүй. Харин энд цугларсан хүмүүст ганцхан аюултай зүйл бол хэрэв эрэгтэй хүн байвал танд дурлачих, аа эмэгтэй хүн байвал таы гоо үзэсгэлэнд атаархах явдал л юм. Би Ромын гудамжаар зугаалан яваа зарим хүмүүсийн тухай ярьж байна гэв.

- Найранд л очих гээгүй бол ийм үеэр гудамжаар тэнэх хүн хаа байх билээ? гэж хатанг хэлэхэд, Франц, Долоон цагт бид хоёр салсан. Танихгүй хүүхнээ дагаад явчихсан. Түүнээс хойш бид хоёр уулзсангүй гэв.

- Яалаа гэнэ ээ? Тэгээд та түүний хаа байгааг мэдэхгүй гэж үү?

- Юу ч мэдэхгүй.

- Зэвсэгтэй яваа юу?

- Алиалагчийн хувцаснаас өөр юмгүй яваа.

- Та түүнийг явуулах хэрэггүй байсан юм. Та чинь Ром хотыг түүнээс илүү сайн мэднэ шүү дээ гэж бэйлийг хэлэхэд,

- Тэгэхийн арга алга. Тэрэнд орохноо өнөөдрийн уралдаанд түрүүлсэн морийг барьж зогсоох нь хялбар байсан биз. Үгүй тэгээд юу л болно аж даа? Гэж Франц хариу өгүүлэв.

- Хэн мэдэх вэ? Шөнө маш харанхуй, тэгээд ч виа-Мачеллогоос Тибр хүртэл гараа сарвайгаад хүрэх газар байхгүй юу.

Бэйл гүнгийн хатах хоёр өөртэй нь адил сэтгэл зовж байгааг хараад Францын бие нь хүйт даав.

-Би танай руу явлаа гэдгээ зочид буудлынханд хэлсэн. Альберыг ирвэл надад мэдэгдэх ёстой гэж Франц хэлэхэд,

- За тэр, таныг миний зарц эрж байх шиг байна гэж бэйл хэлэв. Бэйл андуурсангүй, зарц Францыг хараад түүн уруу хүрч ирээд,

- Дээдэс танд «Лондон» зочид буудлын эзэн хүн илгээж, Морсер бэйсээс захирагч авчирсан хүн буудалд хүлээж байна гэж хэлүүлсэн байна гэж хэлэхд Франц,

- Бэйсээс захидал авчирсан гэнэ ээ! гэ! дуу алдав.

- Тийм ээ.

- Ямаршуухан хүн байна?

- Мэдэхгүй.

- Тэр яагаад захидлаа нааш нь аваад ирсэнгүй вэ?

- Ирсэн хүн надад юу ч хэлсэнгүй.

- Тэр хүн чинь хаана байна.

- Танд айлтгахаар наашаа ирэхий минь харчихаад яваад өгнө билээ.

- Бурхан минь! Гэж гүнгийн хатан дуугараад -Бушуухан яваач. Хөөрхий амьтан! Түүнд золгүй явдал тохиолдсон байж мэднэ гэхэд,

- Одоохон явлаа гэж Франц хариулав.

- Та эргэж ирж бүгдий нь ярих уу? гэж хатанг асуухад, Франц

- Гойд юм болоогүй бол тэгнээ, харин хэрэг явдал өөрөөр эргэвэл чадахгүй байх. Юу болохыг бүү мэд гэж хэлэв.

- Юу ч болсон болгоомжтой яваарай гэж захихад

- Өө, энүүнд сэтгэл зовох хэрэггүй гэв.

Франц бүрхээ аваад яаран гарав. Франц найранд хүрч ирээд хөтчөө шөнийн хоёр цагт ирээрэй гээд явуулчихсан байсан боловч, аз болоход бэйлийн ордон нэг талаараа Корсо өөд, нөгөө талаараа гэгээн Апостолуудын талбай уруу харсан тул «Лондон» зочид буудал хүртэл аравхан минут алхаад хүрчих газар байв. Франц хаалган дээр хүч ирээд гудамжны дунд хүн зогсож байхыг харж, Альберын явуулсан хүн гэж дорхноо бодов. Халхгар цув өмсжээ. Франц тэр хүн уруу ойртон очоод шуудхан ярихад цаадах нь багагүй гайхлаа. Тэгээд хойшоо алхам ухраад,

- Эрхэм та надаас юу хүсээ вэ? гэж асуув.
- Та надад бэйс де Морсероос захидал авчраа юу гэж Франц асуухад,
- Эрхэм та Пастриний зочид буудалд суудаг уу? гэж өөдөөс нь асуув.
- Тийм ээ.
- Эрхэм та бэйстэй хамт жуулчлан яваа юу?
- Тийм ээ.
- Эрхэм таны алдар нэр хэн бэ?
- Түшээ гүн Франц д Эпине гэдэг.
- Тэгвэл энэ захидал эрхэм танд хаягласан нь мөн болох нь ээ.

Франц захидлыг авах зуураа,

- Хариу хэрэгтэй юу? гэж асуув.
- Тийм ээ, таны нөхөр хариу хүлээн горьдож суугаа байх.
- Тэгвэл дээшээ гаръя.
- Үгүй, би эндээ хүлээж байсан нь дээр гэж ирсэн хүн нь инээвхийлэн хэлэв.

- Яагаад тэр вэ?
- Эрхэм та захидлыг уншаад учрыг ойлгох биз.
- Та тэгвэл энд байх уу?
- Заавал байна.

Франц зочид буудалд орж, шатан дээр Пастрини гуайтай дайралдав.

- За юу болов? гэж цаадах нь түүнээс асуухад, Франц
- Та чухам юу асууж байна? гэж хэлэв.
- Та найзынхаа ирүүлсэн хүнтэй уулзав уу? гэж эзэн асуухад,

- Тэгсээн уулзсан. Надад захидал авчирч өгсөн. Алив гал өг гэж хэлээч гэж Франц хариулав.

Эзэн зарцдаа лаа авчирч өг гэж тушаав. Эзэн их л сандран тэвдсэн юм шиг Францад санагдсан учир Альберын захидлыг унших хүсэл нь улам оргиллоо. Зарц гэрэл асаамагц Франц нугалсан хуудсыг тэнийлгэв. Энэ захилдыг Альбер бичиж, доор нь гарынхаа үсгийг зурсан байлаа. Франц захидлыг хоёр дахин уншив. Огт санаанд ормооргүй юм бичсэн байжээ.

Уг захидлын утгыг үгчлэн сийрүүлбэл:

«Хайрт нөхөр минь, энэ захидлыг хүлээн авмагц бичгийн ширээний шүүгээн дотроос миний түрүүвчинд байгаа мөнгөний итгэмжлэх бичгийн авч, хэрэв миний мөнгө хүрэхгүй бол өөрийнхийгөө нийлүүлж, Торлонна уруу гүйж очоод түүнээс дөрвөн мянган пиастр авч энэ заридлыг хүргэж очсон хүнд өг. Энэ мөнгийг яаравчлан өгөх нь чухал байна.

Та надад найдаж болохын адил би танд найдаж байгаа тул үүгээр хязгаарлая.

Жич: I believe now in Italie bandits

Таны найз

Альбер де Морсер

гэжээ.

Мөрнүүдийн дор италиар бичсэн өөр хүний гарын үсэг байв. «Se alle sei della mattina le quatro mila plastre non sono nelle mie mani alle sette in conte Alberto avra ossato di vivere»

Luigi Vampa»

Хоёр дахь гарын үсэг Францад бүх зүйлийг тодорхой болгож, ирсэн хүн дээшээ гарч тасалгаанд орохыг дургүйцсэний учрыг ойлгов. Тэр хүн гадна хоцорвол илүү аюулгүй гэж үзжээ. Альбер өнөөх байдаг гэдэгт нь огтхон ч итгэхгүй байсан цуут дээрэмчний гарт оржээ.

Нэг ч минут алдаж болохгүй байлаа. Франц бичгийн ширээг онгойлгож шүүгээн дотроос нь түрүүвчий нь авч үзвэл дотор нь мөнгөний баримт байлаа. Энэ нь зургаан мянган пиастрийн баримт байсан боловч гурван мянгыг нь зарцуулчихсан байв. Францын тухайд гэвэл түүнд ерөөсөө ч мөнгөний баримт бичиг байсангүй. Тэр Флоренцад сууж байгаад Ромд зөвхөн долоо хоногийн хугацаатай ирсэн учир зөвхөн зуун лиодар авч гарсныхаа талтай нь үлдээд

байжээ. Ийм маягаар Альберт хэрэгтэй мөнгөнөөс долоо найман зуун пиастр дутаад байлаа. Ийм чухал явдал тохиолдоход Франц ноён Торлониад найдаж болох байлаа.

Тэгээд нэг ч минут алдалгүй Браччаногийн ордонд буцаж очихоор завдтал гэнэт нэгэн сайхан санаа түүнд төрөв. Монте-Кристо гүнг санажээ. Франц Пастринийг дуудуулахаар хүн явуулах гэж хонх дуугаргах гэтэл, хаалга онгойж Пастрини өөрөө орж ирэв.

- Синьор Пастрини, та юу гэж бодож байна, гүн гэртээ байгаа болов уу? гэж Франц яаран асуув.

- Тийм ээ, эрхмээ гүн дөнгөж сая ирсэн.
- Арай унтчихаагүй байгаа
- Үгүй байх аа.
- Тэгвэл та түүн уруу ороод намайг уулзмаар байна гэж хэлээдхээч.

Пастрини гуай даалгаврыг биелүүлэхээр яаран гараад, таван минут болсны дараа эргэн ирээд,

- Гүн таныг хүлээж байна гэж хэлэв.

Франц талбай өнгөрөхөд зарц нь түүнийг гүн дээр оруулав. Гүн Францын үзээгүй ханыг дагуулан зөөлөн сандлууд тавилсан нэгэн жижиг тасалгаанд байлаа. Гүн түүнийг угтан босож ирэв.

- Ямар сайхан явдал таныг над дээр ирэх болгов? Та надтай хамт оройн зоог барихгүй юу? Хэрэв ингэвэл надад их л сайхан байх байна гэв.

- Үгүй, би чухал хэрэгтэй байна.

- Хэргээр ий? гээд гүн өнөөх нэвт шувт хардаг харцаараа Франц өөд хараад - Ямар хэргээр ирээ вэ? гэж асуув.

- Биднээс өөр хүн байхгүй биз?

Гүн хаалга уруу очоод эргэн ирж,

- Зөвхөн хоёулхнаа л байна гэлээ.

Тэгэхээр нь Франц түүнд Альберын захидлыг сарвайж,

- Та уншина уу? гэхэд

Гүн захидлыг уншаад:

- За гэж дуугарав.
- Та нэмж бичсэний нь уншив уу?
- Уншсан.

«Хэрвээ өглөөний зургаан цагт дөрвөн мянган пиастр миний гарт орохгүй бол, долоон цагт бэйс Альбер амьд байхгүй болно» гэсэн байна хэмээн италиар уншив.

- Та үүнийг юу гэж үзэж байна вэ? гэж Франц асуув.
- Та нарт энэ хэмжээний мөнгө бий юу?
- Бий, тэгэхдээ зөвхөн найман зуун пиастр дутаад байна.

Гүн ширээ өөдөө очиж нүдий нь татахад дүүрэн алт байв.

- Би таныг намайг гомдоохгүй, өөр хэнээс ч хүсэхгүй байх гэж найдаж байна гэж Францад хэлэхэд,

- Би шууд л тан дээр ирж байгааг харж байгаа биз дээ гэж Франц хариулав.

- Би энүүнд чинь баярлаж байна. Ав, ав гээд Францад авдраа заав.

- Үгүй ингэхэд Луизи Вампад энэ мөнгийг заавал явуулах хэрэгтэй юм гэж үү? Гэж Франц гүнг тас ширтэн асуухад цаадах нь,

- Өөрөөр яах вэ! Хангалттай тодорхой бичсэн байгаа юм биш үү гэж хариулав.

- Хэрвээ та хүсвэл илүү хялбархан арга олж болох мэт надад санагдах юм гэж Франц хэлэхэд гүн гайхан,

- Ямар? Гэж асуув.

- Жишээлбэл, хэрэв та бид хоёр Луизи Вампа дээр хамт очвол тэр танд Альберыг суллаж өгөхөөсөө татгалзахгүй гэдэгт итгэж байна.

- Надад уу? Би тэр дээрэмчинд ямар нөлөө үзүүлж чадах билээ?

- Та түүнд огт мартагдашгүй нэгэн тус хүргээгүй гэж үү?
- Ямар тус?
- Та Пеппиногийн амийг аварсан биш үү?
- Өө! Гэж гүн дуугараад - танд хэн хэлээ вэ? гэж асуув.
- Хэн хэлсэн нь хамаагүй юм биш үү? Би л үүнийг мэдэж байна. Гүн дуугүй болж хөмсгөө атируулав.
- Хэрвээ намайг Луизи уруу явбал та надтай хамт явах уу?
- Хэрвээ надтай хамт явах нь танд эвгүй биш бол явна.
- За яах вэ тэгвэл тэгье. Тэнгэр зайхан байна. Ромын орчмоор зугаацах нь зөвхөн тааламжтай явдал болно биз.
- Зэвсэг авах хэрэгтэй юу?
- Яах юм бэ?
- Мөнгө авах хэрэг байна уу?
- Хэрэггүй. Захидал авчирсан хүн хаана байна?
- Гадаа бий.
- Хариу хүлээж байгаа нь тэр үү?
- Тийм ээ.
- Юу ч гэсэн хаашаа явахаа мэдэх хэрэгтэй байна. Би түүнийг дуудъя.
- Тэр орж ирэх дургүй байна лээ.
- Тан дээр бол магадгүй, харин над дээр орж ирнээ.

Тэгээд гүн гудамж уруу харсан цонхон дээрээ очиж, тун этгээд маягаар исгэрэв. Цувтай хүн хананаас хөндийрч гудамжны гол дунд гарч ирэв. Тэгэхэд гүн зарцдаа тушаал өгч байгаа юм шиг дуугаар Salite!! Гэж хэлэв.

Ирсэн хүн огтхон ч эргэлзээгүйгээр үл барам тушаалыг яаран дагаж шатаар өгсөн зочид буудалд ороод таван секунд болоход гүнгийн үүдэнд ирчихсэн байжээ.

- Аа, Пеппино чи байсан юм уу? гэж гүн хэлэв.

Пеппино хариу хэлэхийн оронд өвдөг дээрээ сөхрөн гүнгийн гарыг шүүрэн авч хэдэнтээ үнэсэв.

- Үгүй ер! Чиний амийг аварсныг минь мартаагүй л байгаа юм уу? хачин юм даа, одоо бүтэн долоо хоног өнгөрчихөөд байхад гэж гүн хэлэхэд,

- Үгүй, гэгээнтэн минь, би үүнийг хэзээ ч мартахагүй гэж Пеппино ихэд хүндэтгэн баярласан дуугаар хариу өгүүлэв.

- Хэзээ ч гэнээ? Мөн ч их удаан хэрэг байна даа. За яах вэ, ингэж бодож байгаа чинь сайн байна. Бос асуусныг хариулаадах гэв. Пеппино Франц өөд их л сэтгэл түгшсэн байдалтай харав.

- Чи энэ эрхэм хүний дэргэд ярьж болно гэж гүн хэлээд - Энэ бол миний найз гэснээ Франц өөд харж франц хэлээр - Та ингэж нэрлэхийг зөвшөөрөх болов уу? Энүүнд итгүүлэх явдал чухал байна гэж хэлжээ.

- Миний дэргэд ярьж болно. Би гүнгийн найз нь байгаа юм гэж Франц хэллээ.

- За гэж Пеппино хариулаад, гүн уруу хандаж - Гэгээнтэн та асууж хайрлагтун, би хариульъя гэж хэлэв.

- Альбер бэйс яагаад Лиужийн гарт орчхов?

- Гэгээнтэн минь, тэр франц хүний сууж явсан сүйх тэрэг Терезагийн сууж явсан сүйх тэрэгтэй хэдэн удаа дайралдсан юм.

- Толгойлогчийн найз хүүхэн үү?

- Тийм ээ. Тэр хүн сээтэгнэж эхэлсэн юм. Тереза ч тоглоом болгож хариулжээ. Франц хүн баглаа цэцэг шидсэн, тэгэхэд нь Тереза бас цэцэг шидэж, тэгэхдээ сайхь сүйх тэргэнд сууж явсан толгойлогчийн зөвшөөрөлтэйгөөр шидэлгүй яах вэ?

- Яалаа гэнээ? Гэж Франц дуу алдаад - Луижи Вампа тариачны хувцастай хүүхнүүд сууж явсан сүйх тэргэн дээр байсан гэж үү? Гэж асуулаа.

- Бүр хөтчийн хувцас өмсөөд, жолоо барьж явсан юм гэж Пеппино хариуллаа.

- Цааш нь? Гэж гүн хэлэв.

- Аа, цааш нь франц хүн багаа авахад Тереза ч атаманы зөвшөөрөлтэйгөөр бас л нүүрээ ил гаргажээ. Франц хүн уулзъя гэж гуйхад нь Тереза уулзах газар цаг тогтоож өгч л дээ. Харин Сан-Жакомо сүмийн дэргэд Тереза биш Беппо хүлээж байсан юм.

- Яалаа гэнээ? Гээд Франц түүний яриаг таслан - Түүний лааг булааж авсан нөгөө тариачин хүүхэн үү? Гэж асуухад,

- Энэ бол арван таван настай жаал хүү байсан юм. Гэвч таны найз түүний гарт орсондоо ичих явдал байхгүй. Тэр чинь Беппогийн мэхэлсэн анхны хүн биш ээ гэж Пеппино хариулав.

- Тэгээд Беппо түүнийг хотоос авч гарсан уу? гэж гүн асуулаа.

- Тийм ээ. Виа-Мачеллогийн үзүүрт сүйх тэрэг хүлээж байсан. Беппо суугаад нөгөө франц хүнээ урьж суулгахад цаадах нь ч гуйлгасан ч үгүй. Тэр хүн Беппод баруун талынхаа суудлыг найрсгаар тавьж өгөөд өөрөө зэрэгцэн суужээ. Тэгэхлээр нь Беппо түүнд Ромоос нэгэн бээр газар байгаа зусландаа аваачна гэж хэлжээ. Франц хүн газрын мухар ч очсон хамаагүй гэж түүнд хэлжээ. Хөтөч нь виади-Рипеттыг чиглэн явж, гэгээн Павлын хаалгыг өнгөрөн гарч хээр гарахад франц эр дэндүү дураараа аашлах гэж оролдож эхлэхээр нь Беппо хоёр буу гаргаж цээжинд нь тулгажээ. Хөтөч морио зогсоогоод эргэж мөн адил зүйлийг үзүүлжээ. Тэр үед Альмо голын эрэг дээр нуугдаж байсан манайхны дөрвөн хүн гүйж иржээ. Франц хүн биеэ хамгаалах гэж бодож, тэр ч байтугай Беппогийн хоолойг бага зэрэг шахаад авсан ч бололтой. Тэгэвч таван зэвсэглэсэн хүний өөдөөс юу хийж чадах билээ? Бууж өгөхөөс өөр арга байсангүй. Тэгээд түүнийг сүйх тэрэгнээс гаргаад голын эрэг дээр Сан-Себастьяногийн газар доогуурх агуйд хүлээж байсан Тереза, Луизи хоёр дээр хүргэж өгсөн юм.

- За яах вэ энэ явдал бусад бүх явдлынхаа адил л юм биз. Та юу хэлмээр байна? Та чинь ийм хэргийг сайн мэддэг шүү дээ? гэж гүн Францад хэлэхэд,

- Хэрвээ энэ явдал хөөрхий Альбераас өөр хүнд тохиолдсон бол үнэн голоосоо инээх байсан юм гэж Франц хариулав.

- Тиймээ та надтай уулзаагүй бол таны нөхрийн энэ дурлалын паян овоо үнэтэй өнгөрөх байсан даа. Одоо тайвшир, аюулаас аврамц.

- Тэгвэл түүний хойноос явах уу? гэж Франц асуув.

- Одоохон! Тэгээд ч их сайхан газар байгаа юм байна. Та Сан-Себастьяногийн агуйг мэдэх үү?

- Үгүй би тийшээ орж үзээгүй, харин явах юм сан гэж л бодоод байдаг юм.

- Ёстой тохиромжтой учрал тохиолдлоо. Үүнээс илүү юм гэж хаана байх вэ. Сүйх тэрэг тань гадаа бий юу?

- Байхгүй.

- За яах вэ. Минийх бол өдөр шөнөгүй бэлэн байдаг юм.

- Морьд нь хөллөөтэй юу?

- Тийм ээ. Би ер нь суугаад байдаггүй хүн гэдгээ хэлэх хэрэгтэй юм байна. Заримдаа ширээний араас босоод юм уу эсвэл шөнө дунд ч гэсэн газрын мухар орохоор явъя л гэвэл яваад өгдөг юм.

Гүн хонхоо нэг удаа дарахад, тасалгаанд гэрийн даамал орж ирэв.

- Саравчнаас сүйх тэрэг гаргаж ир гэж тушаа, тэгээд тэргэн дотроос гар буунуудыг гаргаж ав. Хөтчийг бүү сэрээ, биднийг Али авч явна гэж гүн хэлэв.

Минутын дараа сүйх тэрэгний дуу гарч үүдэнд ирэв. Гүн цагаа харж,

- Арван хоёр цаг хагас болж байна. Бид өглөө таван цагт гарсан ч цагаасаа өмнө амжих юм. Удаашрах нь таны нөхрийг тайван хажуулахгүйд хүргэх болохоор бушуухан л түүнийг буруу номтны гараас гаргаж авах нь дээр юм. Та надтай явах хэвээрээ л байна уу? гэж хэлэв.

- Хэзээ хэзээнийхээс илүү.

- За тэгвэл явъя.

Франц гүн хоёр тасалгаанаас гарахад Пеппино дагаж гарав.

Шатны дэргэд сүйх тэрэг зогсож хөтчий суудал дээр Али сууж байв. Монте-Кристогийн аркын агуйд байсан хэлгүй боол мөн болохыг Франц танив.

Франц гүнгийн хамт хоёр хүний суудалтай сүйх тэргэнд сууж, Пеппино Алитай зэрэгцэн суухад морьд давхилдан одов.

Али урьдаас шийдвэр авсан бололтой шууд Корсогоор орж, Камно Ваччиног хөндлөн гарч, Сан Грегориог өгсөн, Сан-Себастьяногийн хаалганд хүрч ирэв. Манаач нь тэднийг гаргахыг дургүйцсэн боловч гүн Ром хотын даргаас өгсөн шөнө өдөр хэзээ боловч саадгүй гарч орж байх зөвшөөрлийн бичгийг үзүүлэв. Хаалт төмөр тэр дороо өргөгдөж манаач нь хөдөлмөрийнхөө хөлсөнд алтан зоос авч, сүйх тэрэг цааш явлаа.

Тэд хоёр эгнээ бунхны хоорондох эртний Аппиевын замаар явлаа. Эвдэрхий балгасны суурин дундаас байн байн манааны хүн гарч ирэх боловч Пеппиногийн дохиогоор тэр дорхноо алга болж байх нь мандаж байгаа сарны бүдгэвтэр гэрэлд Францад харагдах шиг болов.

Каракалд арай хүрэлгүй сүйх тэрэг зогсож, Пеппино хаалга онгойлогод гүн Франц хоёр гарав. Гүн хамт яваа хүндээ

- Бид арван минутын дараа очих газартаа хүрнэ гэж хэлэв.

Дараа нь Пеппиног хажуу тийш нь дуудаж, нэг зүйлийг шивнэн тушаахад, Пеппино сүйх тэрэгний хайрцагнаас бамбар аваад яваад өгчээ.

Таван минут өнгөрөхөд Пеппино дов толгодтой Ромын тэгш тал дундуур гарсан нарийхан зөргөөр явж дараа нь аварга том арслангийн дэл шиг өндөр улаан өвсөн дотор орж алга болох нь Францад харагдав.

- За, үүнийг дагаад явъя гэж гүн хэлэв.

Тэд цөм зөргөөр явж, зүг шахам алхам газар өгсөөд нэгэн бяцхан хөндийд гарч ирэв. Удалгүй харанхуйн дунд ярилцаж байгаа хоёр хүнийг олж харав.

- Цаашаа явах уу, эсвэл хүлээж байх хэрэгтэй юм болов уу? гэж Франц асуухад,

- Явъя, явъя Пеппино. Манаач нарт урьдчилан мэдэгдсэн байх гэв.

Нээрээ ч ярьж байсан хоёр хүний нэг нь Пеппино нөгөө нь манайд зогсож байсан дээрэмчин байлаа.

Гүн Франц хоёр тэдэн дээр очиход нөгөө дээрэмчин мэхийн ёслов.

- Гэгээнтэн минь, та миний хойноос явах сан болов уу? Агуйн үүд эндээс хоёрхон алхмын тэнд байна.

- За түрүүлээд яв гэж гүн хэлэв.

Удалгүй бутны цаана, чулуун дотор хүн арай гэж багтмаар нүх байгаа харагдав.

Пеппино түрүүлж нүх уруу оров. Хэд алхмагц газар доорх хаалга өргөн боллоо. Тэнд Пеппино зогсож бамбараа асаагаад эргэж харав.

Уур татах нүх шиг энэ юм уруу гүн түрүүлж ороход Франц түүнийг дагаж оров.

Зам уруудан явж, аяндаа өргөжинө. Хэдий тийм боловч Франц, гүн хоёр бас л бөгтийсөн хэвээр явах бөгөөд маш төвөгтэйгөөр зэрэгцэн явж болох байлаа. Тэд ингэж зуун тавь орчим алхам явж байтал «Хэн бэ?» гэж хашхирах чимээгээр зогсов.

Карбин бууны ам бамбарын гэрэлд гялс хийхийг тэр хоёр харав.

- Найз гэж Пеппино хариу дуугарав.

Пеппино урагш гарч манаачид хэдэн үг хэлэхэд, түрүүчийн нэгэн адил мэхийн ёсолж, цааш явж болохыг мэдэгдэн дохив.

Манаач хориод гишгүүртэй шатны дээд талд зогсож байлаа. Франц гүн хоёр түүгээр бууж нэгэн газар бунхан шЁг юманд оров. Эндээс таван тийшээ салбарлаж явсан нүх харагдана. Хананд нь авс шиг нүх зэрэгцүүлэн ухжээ. Тэр хоёр ёстой өнөөх сүлжсэн агуйдаа хүрч иржээ гэдгийг ойлголоо.

Эдгээр салбарласан нүхний нэгэн дотор гэрэл тусах бөгөөд урт богиныг нь тааж мэдэх аргагүй байлаа.

Гүн Францын мөрөн дээр гараа тавьж,

- Дээрэмчдийн лагерь яаж амарч байгааг үзэхийг хүсч байна уу? гэж асуухад,

- Туйлгүй хүсч байна гэж Франц хариу өгүүлэв.

- Тэгвэл намайг дагаад яв... Пеппино чи бамбараа унтраа.

Пеппино тушаалыг биелүүлэхэд, Франц гүн хоёр тас харанхуй дотор хоцров. Зөвхөн өмнө талд нь тавиад алхмын зайтай газар улаавтар гэрэл гарч байснаа Пеппиног бамбар унтраахаар улам ч тод болжээ.

Тэд урагш дув дуугай алхах бөгөөд гүн харанхуйд юм үздэг юм шиг Францыг итгэлтэйгээр дагуулан явна. Тэд өөрсдөд нь зам заагч одон болж байгаа гэрэлд ойртох тутам Франц ч замаа улам сайн ялган таних болж явлаа.

Тэдний өмнө гурван гулдан байх бөгөөд тэдгээрийн дунд тлынх нь ордог хаалга ажээ. Энэ хаалганууд нь бидний дээр өгүүлсэн шиг ханандаа хүнхэр нүхтэй том дөрвөлжин тасалгааг гүн, Франц хоёроос тусгаарлаж байлаа. Тасалгааны дунд талд урьд шүтээн болж байсан дөрвөн чулуу байх бөгөөд үүнийг нь одоо хүртэл тэнд байгаа загалмай тэмдэг гэрчилнэ.

Баганын суурин дээр тавьсан өнчин ганц дэнлүүний сүүтэгнэсэн гэрэлд хачин сонирхолтой зүйл хар нхуйд нуугдсан хүмүүсийн нүдэнд тусав.

Баганын суурин дээр тохойлдсон нэгэн хүн цаашаа хараад юм уншиж байв.

Энэ бол дээрэмчний бүлгийн толгойлогч Луизи Вампа байлаа.

Түүний дэргэдүүр цув өмссөн хориод дээрэмчин хэвтэх нь хэвтэж хана дагуу байгаа чулуун сандал шиг юи түших нь түшиж дур дураараа унтацгааж байв. Хүн бүхний гарын дэргэд карабин буу байлаа. Тасалгааны гүн доторх дөнгөж ажиглагдах төдий сүүтэгнэж байгаа манаачийн сүүдэр ханан дахь ямар нэг нүх шиг юмны өмнүүр чимээ аниргүй хойш урагш хөдөлнө. Энд нүх байгаа гэдэг нь бараан харанхуйн дунд улам түнэр харанхуй харагдаж байгаагаар мэдэгдэж байв.

Гүн Францад энэ байдлыг харах бүрэн бололцоо олгов. Дараа нь хуруугаа аман дээрээ нааж, гурван гишгүүр дээш алхаад дунд талын хаалгаар орж, уншиж байгаа юмандаа автан түүний хөлийн чимээг ч сонсохгүй байгаа Луижид ойртон очив.

- Хэн бэ? Гэж манаач толгойлогчийн араас хүн гарч ирэхийг дэнгийн гэрэлд хараар хашхирав.

Энэ дууг сонсмогц Вампа ухасхийн босож, бүснээсээ гар бугаа суга татан авав. Эгшин зуурын дотор хорин дээрэмчин босон харайж хорин бууны ам гүн өөд чиглэв. Тэгэхэд нь гүн тайван дуугаар, түүгээр ч барахгүй нүүрнийх нь нэг ч булчин хөдлөхгүй,

- Ингэхэд эрхэм Вампа та найзыгаа угтаж авахын тулд дэндүү их ёс гүйцэтгэж байгаа юм биш үү? гэж хэлэв. Толгойлогч нэг гараа өргөж,

- Зэвсгээ хураа! Гэж захирангуй командлаад, нөгөө гараараа бүрх малгайгаа авч хүндэлгэв.

Дараа нь энэ үзэгдэлд оролцогч бүхнийг удирдан хөтлөх мэт байгаа гүнд хандаж,

- Би таныг наашаа заларна гэж мэдээгүй байсан тул таныг таньсангүй, уучлаарай гүн минь гэв.

- Та ер нь мартамхай хүн бололтой. Вампа та зөвхөн хүн таньдаггүйгээр барахгүй, хийсэн тохироогоо ч мартчихдаг хүн юмаа.

- Гүн минь, би ямар тохиролцоо мартчихаа вэ? гэж дээрэмчин өөрийн алдааг даруй засахад бэлэн байгаа хүний дуугаар асуухад гүн,

- Та бид хоёр, зөвхөн би ч биш, миний бүх найз цөм таны хувьд гар хүршгүй хүмүүс байхаар ярьж тохирсон биш бил үү? Гэж хэлэв.

- Би хэлсэн үгнээсээ юугаараа гажаа вэ, дээдэс минь?

- Та өнөөдөр бэйс Алвбер де Морсерийг хулгайлан авчирчээ. Энэ залуу бол гээд гүн Францыг өөрийн эрхгүй татвасхийхээр эвгүй дуугаар үргэлжлүүлэн - Миний найз нөхдийн нэг байгаа юм. Надтай нэг зочид буудалд суудаг, түүгээр ч барахгүй бүтэн долоо хоногийн турш миний сүйх тэргээр Корсогоор зугаалсан. Тэгэхэд та түүнийг хулгайлан авч энд авчирсан байна гэснээ гүн хармаанаасаа захидал гаргаж ирээд нэмж - Бас тэгээд анх уулзсан хүн шиг золиосны мөнгө нэхсэн байна гэв.

Тэгэхэд толгойлогч өөрийнхөө өмнө хулчигнан зогсож байгаа нөхөд уруугаа хандаж,

- Энэ тухай надад яагаад хэлээгүй вэ? Та нар намайг яагаад гүн шиг, бид бүхний амийг гартаа барьж байгаа хүнд хэлсэн үгээ зөрчихөд хүргэв? Христосын цусаар тангараглая! Хэрвээ би та нарын хэн нэгэн чинь энэ залууг эрхэмсэг гүнгийн найз нөхөр нь гэж мэдэж байсан гэдгийг мэдвэл өөрийнхөө гараар буудаж алах байсан! Гэж хэлэв.

Тэгэхэд гүн Францын зогсож байгаа зүг уруу хандаж,

- Андуураад тэгсэн байх гэж би танд хэлсэн шүү дээ. Харж байгаа биз гэж хэлэхэд Вампа сандарсан байдалтайгаар,

- Та ганцаараа ирээгүй юм уу? гэж асуув.

- Надтай хамт энэ захидлыг хаягласан хүн ирсэн. Би түүнд Луизи Вампа хэлсэн үгэндээ хэзээд хүрдэг хүн гэдгийг үзүүлэх гэсэн юм гэснээ Франц уруу хандан - Түшээ гүн, та наашаа ирнэ үү. Луизи алдаа гаргасандаа сэтгэл зовж байгаагаа өөрөө танд хэлэг гэв.

Франц ойртож ирэхэд толгойлогч түүнийг угтан хэд алхаж,

- Эрхэм ээ таныг миний зочин болохыг хүсье. Та гүнгийн асууж, миний хариулсныг сонссон байх. Үүн дээр миний нэмж хэлэх юм бол ийм юм тохиолдохгүй байлгахын тулд золиосны дөрвөн мянган пиастрыг ч дуртай өгөхөд бэлэн байна гэхэд Франц,

- Олзлогдсон хүн хаана байна? Тэр надад харагдахгүй байх чинь гэж ийш тийш сэтгэл зовонгуй харж хэлэв.

- Түүнд элдэв явдал тохиолдоогүй гэж найдаж байна гэж гүн хөмсгөө зангидан асуухад Вампа,

- Олзлогдсон хүн тэнд байгаа гэж хариулаад өнөөх цааш орсон гүнзгий нүхний аман дээр зогсож байсан манаач өөд зааж, - Түүнийг суллагдсан гэж би өөрөө очиж хэлье гэв.

Толгойлогч Альберийн байгаа жовгон өөд явахад Франц гүн хоёр хойноос нь дагалдан явав.

- Олзлогдсон хүн юу хийж байна? гэж Вампа манаачаас асуухад, цаадах нь,

- Мэдэхгүй байна дарга аа. Огтхон ч чимээ гаргахгүй б@лсоор цаг гаруй болж байна гэж хариуллаа.

- Орж ажаам уу гэж Вампа хэлэв.

Гүн, Франц хоёр толгойлогчийг дагаж гишгүүрээр өгсөв. Вампа түгжээг мулталж хаалга онгойлгов.

Тэгээд бунханд байсан шиг дэнгийн гэрэлд Альбер харагдав. Альбер дээрэмчдийн өгсөн нэг цув нөмрөөд тайван нойрсож байв. Гүн зөвхөн өөрт нь зохисон инээмсэглэлээр инээмсэглэж,

- Өглөө долоон цагт алуулах гэж байгаа хүнд муугүй л хэрэг байна даа гэж хэлэв.

Вампа унтаж байгаа Альберийг хараад гайхахгүй байж чадсангүй. Залуу эрийн цөс ихтэй түүнд сэтгэгдэл төрүүлсэн нь илэрхий харагдаж байв.

- Гүн та үнэн хэлжээ. Энэ хүн таны найз гэхэд эргэлзэх юм алга гэж Вампа хэлэв.

Тэгээд Вампа, Альбер уруу очиж мөрөөс нь татаад,

- Эрхэм та, сэрэхгүй юмсан болов уу? гэв.

Альбер суниалгаж, нүдээ арчаад харав.

- Өө, толгойлогч та юу? Чөтгөр ав, та намайг яах гэж сэрээчихэв ээ, би сайхан зүүд зүүдэлж байсан юмсан. Би Торлониагийн найранд очоод гүнгийн хатан Г-тэй бүжиглэж байна гэж зүүдэлж байсан юм сан гэв.

Тэр өөрөө цаг мөчийг мэдэж байя гэж үлдээсэн цагаа хармаанаасаа гаргаж,

- Нэг цаг хагас болж байна. Та намайг өдийд яах гэж сэрээв? Гэж асуув.

- Эрхэм таныг суллагдсан гэж хэлэх гэсэн юм гэхэд Альбер хайхрамжгүй байдлаар,

- Эрхэм минь, хожим та агуу их Наполеоны хэлсэн «Зөвхөн түү мэдээ ирвэл сэрээж бай» гэж хэлснийг санаж байгаарай. Хэрвээ та намайг сэрээ-ихээгүй бол бүжиг дуустал нь шогшоо хийчихээд энэ насаараа танд баярлаж явахсан... Тэгээд золиосны мөнгө ирээ юу? гэв.

- Үгүй эрхэмсэг минь.
- Тэгвэл би яагаад чөлөөтэй болов?
- Би юухан ч татгалзаж болохгүй хүн таны араас ирсэн.
- Наашаа юу?
- Наашаа.
- Тэгвэл тэр чинь их найрсаг хүн байх нь ээ.

Альбер эргэн тойрноо хараад, Францыг олж харав.

- Үгүй ер! Хонгор Франц та ингэж амь хайргүй зүтгээ юу? гэж Альбер асуухад,

- Үгүй, би биш манай хөрш, Монте-Кристо гүн гэж Франц хариулав.

- Өө, гүн гээд Альбер зангиа, захаа засаж - Та үнэхээр үнэлж баршгүй хүн юм. Би танд үүрд өртэй хүн. Нэгдүгээрт та надад сүйх тэргээ өгч байсан, хоёрдугаарт одоо намайг чөлөөлж байна гэж хэлээд гүн гараа өгөхөд цаадах нь цочин давхийсэн боловч гараа өгч барив.

- Луижи Вампа болж байгаа явдлыг гайхан харна. Олзлогдсон хүмүүс өөрийн нь өмнө дагжин чичирч байхыг харж сурчихсан байжээ. Харин шогч зан ааш нь огтхон ч өөрчлөгдөхгүй байгаа хүн ганцыг энэ удаа үзжээ. Францын тухайд гэвэл Альбер дээрэмчдийн өмнө үндэснийхээ нэр төрийг алдахгүй байгаад нь бахархаж байлаа.

- Эрхэм Альбер, хэрвээ та түргэлбэл бид Торлониагийн үдэшлэг тарахаас өмнө очиж амжина. Та тасарсан бүжгээ хийж дуусгах болно. Бас энэ хэрэгт сайн санаа гаргасан Луижийг уучилж үз гэж Франц хэлэхэд,

- Таны хэлдэг зөв, бид хоёр цагт тэнд очиж амжина гэж хэлээд - Эрхэм Луижи, би тантай салах ёс гүйцэтгэхий өмнө өөр ямар ёс гүйцэтгэвэл зөвхөн вэ? гэж асуув.

- Ямар ч ёс хэрэггүй. Би салхин мэт чөлөөтэй боллоо гэж дээрэмчин хариулав.

- Тэгвэл та бүхэнд зол жаргал, хөгжилтэй сайхан амьдрахыг хүсье. За, явцгаая эрхмүүд ээ!

Тэгээд Альбер, Франц гүн хоёрыг дагуулан том дөрвөлжин тасалгааг туулан өнгөрөв. Бүх дээрэмчин толгой нүцгэн зогсож байлаа.

- Пеппино! Алив бамбар өгөөдөх гэж толгойлогч хэлэхэд гүн,

- Та яах гээ вэ? асуув.

- Би та нарыг гаргаж өгье. Энэ бол би танд үзүүлж чадах өчүүхэн боловч хүндлэл болно гэж толгойлогч хариулав.

Тэгээд тэр Пеппиногийн гараас асаасан бамбар авч зочдынхоо түрүүнд орж, үүргээ гүйцэтгэж яваа зарц шиг биш, харин элчин сайдууд дагуулан яваа ван шиг алхлав.

Гарах хаалганы тэнд хүрээд мэхийн ёсолж,

- Гүн минь, би танаас дахин уучлал гуйя. Энэ болсон явдлын төлөө дахин намайг зэмлэхгүй биз гэж найдаж байна гэж хэлэв.

- Үгүй, хүндэт Вампа! Та өөрийн алдааг найрсгаар засаж чадах юм. Харин би танд энэ алдаа гаргасан явдалд чи нь баяр хүргэмээр байна гэв.

- Эрхмүүд ээ гээд дээрэмчин залуу хүмүүст хандаж - Би та нарыг урих нь та нарт сонирхолгүй байж мэднэ, тэхдээ та нар хэзээ нэгэн цагт над дээр ирэх юм бол би хаана ч байсан баяртай угтах болно гэж хэлэв.

Франц Альбер хоёр мэхийн ёслов. Гүн түрүүлэн гарч Альбер хойноос нь дагаж гарав. Франц гарахыг яарсангүй.

- Эрхэмсэг та надаас юм хум асуух гээгүй биз? Гэж Вампа инээвхийлэн хэлэхэд,

- Тийм ээ үнэн. Та биднийг орж очиход ямар номыг тэгтлээ шимтэн уншиж байсан бэ? Гэж Франц асуулаа.

- «Цезарийн тэмдэглэл» миний хамгийн дуртай ном байгаа юм гэж дээрэмчин хариулав.

- Франц та яачихав аа гэж Альбер асуухад,

- Очлоо, очлоо гэж Франц хариулав.

Тэгээд тэр нүхний амнаас гарав.

Тэд хэдэн алхам явав.

- Уучлаарай гэснээ Альбер буцаж яваад та зөвшөөрөх үү? Хэмээн Луижийн бамбараас ороомол навчин тамхиа асааж авав.

- Аа, одоо гүн минь, цаг алдаад яах вэ. Шөнийхөө үлдсэн хэсгийг бэйл Браччаногийнд өнгөрөөхийг хүсэж байна гэж хэлэв.

Сүйх тэрэг тэдний орхисон газар л хүлээж байв. Гүн араб хэлээр Алид юм хэлэхэд, морьд хар хурдаараа давхилдаж одов.

Яг хоёр цагт найз нөхөд бүжгийн тасалгаанд орж очжээ.

Тэд орж ирсэн нь шуугиан дэгдээв. Гэвч хоёулаа ирсэн учир Альберын төлөө сэтгэл түгшиж байсан нь тэр дороо үгүй болов.

Де Морсер бэйс хатагтай Г-нийг дэргэд очоод

- Хатагтай та өчигдөр надтай бүжиг хийнэ гэж сайхан сэтгэлээсээ амласан. Гэвч би таны энэ сайхан амлалтын тухай танд бага зэрэг оройтож сануулж байна. Харин энэ бол миний буруугаас болсон хэрэг биш гэдгийг миний нөхөр танд үнэнээр нь хэлэх байх гэж бодож байна гэв.

Энэ үед хөгжим эгшиглэж эхэлсэн тул Альбер хатагтай бүсэлхийгээр тэвэрч бүжиглэгч хосуудын дундуур эргэлдэн оров.

Тэр завсар Франц, Монте-Кристо гүн Альберт дуртай дургүй гараа өгч барих үедээ хачин жигтэй цочин давхийсныг нь гайхан эргэцүүлэн бодож байлаа.

17. Болзсон нь

Маргааш нь Альбер орноосоо босоод юуны өмнө гүнгийн орьё гэж Францад хэлэв. Альбер урьд нь талархлаа илэрхийлсэн боловч, гүнгийн үзүүлсэн ач тус нь дахин баяр талархал илэрхийлэхэд илүүдэхгүйг ойлгожээ.

Гүнд сэтгэл татагдахын хажуугаар айдаг болсон Франц түүнтэй хамт явав. Тэднийг зочдын өрөөнд оруулж, таван минут болсны дараа гүн гарч ирэв.

- Ноёнтон минь, өчигдөр төдий л хангалттай хэлж чадаагүй зүйлээ өнөөдөр давтан хэлэхийг зөвшөөрнө үү. Та намайг ямар байдалд байхад ирж тусалсныг би хэзээ ч мартахагүй. Үүрд танд амь биеэрээ ачийг чинь хариулах үүрэгтэй гэдгээ үргэлжид санаж явна гэж Альбер түүнд ойртонгоо хэлэхэд, гүн инээд алдан,

- Хүндэт хөрш минь та миний үзүүлсэн тусыг дэндүү хэтрүүлж байна. Би таны хорин мянган франкыг л хэмнэж өгснөөс өөр юм алга. Энэ тухай ярих хэрэггүйг харж байгаа биз дээ. Харин та миний гайхан шагшрахыг зөвшөөрнө үү. Та гайхмаар тайван байдаг шүү гэж хэлэв.

- Гүн минь, би өөрөөр яах ч юм билээ дээ? Би маргалдан хэрэлдээд халз тулаанд хүрчээ гэж дотроо бодлоо. Тэгээд орон бүхэнд халз тулалдаан хийдэг боловч, зөвхөн францууд л инээж байгаад үзэлцдэгийг тэдгээр дээрэмчдэд харуулах гэсэн юм. Гэвч энэ нь миний талархлыг өчүүхэн ч багасгахгүй би өөрөө буюу өөрийн танил нөхдөөр дамжуулан танд ямар нэгэн зүйлээр тус хүргэж болох эсэхийг асуух гэж ирлээ. Миний эцэг де Морсер гүн испани гаралтай. Францад ч, Испанид ч их нэр нөлөөтэй хүн. Би болоод надад хайртай хүн бүхэн таны бүрэн мэдэлд байна гэдэгт та итгэлтэй байж болно гэж Альбер хэлэхэд,

- Эрхэм де Морсер үнэнээ хэлэхэд таныг ингэнэ ч байх гэж бодож байсан юм. Тэгээд ч чин зүрхнээсээ хүлээн авч байна. Би өөрөө танаас нэг том зүйлийг хүсэх гэж байсан юм хэмээн гүн хэлэв.

- Ямар?

- Би Парист очиж ер үзээгүй. Парисыг огтхон ч мэдэхгүй...

- Нээрээ гэж үү? Та Парисыг үзэлгүйгээр яаж амьдарч чадаж байсан юм бэ? Энэ чинь үнэмшмээргүй хэрэг байна! гэж Альбер гайхав.

- Тийм л болчихоод байгаа юм. Гэвч би соёлт ертөнцийн нийслэлийг үзэх хэрэгтэй болсон гэж таны адил үзэж байна. Би танд цааш нь ярья. Намайг Парисын дээдсийн хүрээлэнд оруулж, танилгүй байгаа газарт минь танилтай болгож өгөх хүн байсан бол би энэ аяллыг аль хэдийн хийчих байсан юм.

- Тан шиг ийм хүн! Гэж Альбер дуу алдав.

- Та их найрсаг хүн юм. Би өөрийгөө сая сая мөнгөнийхөө тоогоор ноён Агуадо эсвэл ноён Рочильдтой өрсөлдөж чадахаас өөр гойд юмгүй хүн гэж боддог болохоор, би Парист бирж дээр тоглох гэж явж байгаа биш болохоор энэ шалтгаан л намайг саатуулаад байсан юм. Харин таны хэлсэн зүйл хэрэг явдлыг өөр болгож байна. Хүндэт ноён де Морсер та (энэ үгийг хэлэхдээ гүнгийн уруул дээр хачин инээвхийлэл тодров) намайг Парист очиход огтхон ч тал танил байхгүй надад ихэс дээдсийн хүрээлэнгийн үүдийг онгойлгож өгөх үүргийг өөртөө авах уу? гэв.

- Өө, гүн минь маш их баяртайгаар, чин зүрхнээсээ хүлээн авна! Гэж Альбер хариуаад - Өнөөдөр өглөө хүлээж авсан захидалд намайг Парист ир гэсэн байна. Захидалд Парисын нэр цуутангуудтай тун сүрхий холбоотой нэг сайн айлд надтай тохирох нэгэн хүүхэн байгаа тухай бичсэн байна гэв.

- Тэгвэл та гэрлэх нь үү? Гэж Франц инээмсэглэн асуув.

- Тийм л бололтой. Та Парист буцаж очихдоо намайг эхнэр авчихсан бас магадгүй хүүхэдтэй болж гэр бүлийн эцэг болсон байхыг үзэж мэднэ. Би төрөлхийн төлөв хүн болохоор энэ байдал надад улам ч зохих байх. Ямар ч байсан гүн минь, миний ойр дотны хүмүүс танд бие мах бод сэтгэл санаагаараа үйлчлэхэд бэлэн байгаа гэдгийг давтан хэлье.

- Би зөвшөөрч байна. Би аль хэдийнээс бодсон төлөвлөгөөгөө биелүүлэхэд зөвхөн энэ учрал л дутаад байсан юм гэдгийг танд батлан хэлье гэж гүн ярьжээ.

Энэ бол Монте-Кристо арлын агуйд байхдаа гүнгийн цухуйлгаж байсан өнөөх төлөвлөгөө мөн гэдэгт Франц огтхон ч эргэлзсэнгүй, тэгээд гүнг Парис явах болгосон энэхүү төлөвлөгөөнд холбогдох өчүүхэн боловч зүйлийг түүний царайнаас олж харах хэмээн гүн өөд анхааралтай ширтэнэ. Гэвч энэ хүний санаа бодол, ялангуяа ёсорхог инээмсэглэлийн цаана нуугдсан чухамхүү санааг нь нэвт шувт харахад туйлын хэцүү болой.

Монте-Кристо гүн шиг ийм хачин өвөрмөц хүнийг Парисын дээдсийн хүрээлэд оруулан танилцуулах болсондоо баярлаж хөөрсөн Альбер,

- Үгүй инJэхэд гүн таны энэ төлөвлөгөө жулчлан явахад санаанд орж ирээд, сүүлд нь элсэн дэр барьсан юм шиг анхны салхи дайрахад замхран алга болчихдог бодол шиг алга болих юм биш биз? Гэж хэлэхэд,

- Үгүй ээ, энэ тийм биш гэдгийг баталъя. Би үнэхээр Парист очихыг хүсэж байна, тэр ч байтугай тэнд очих чухал хэрэгтэй гэж гүн хэлэв.

- Тэгвэл хэзээ очих вэ?

- Та өөрөө тэнд хэзээ байх вэ?

- Би юу? гээд Альбер - Хоёр долоо хоног, хамгийн ихдээ л гурван долоо хоногийн дараа, өөрөөр хэлбэл замд явах хугацаа л байна гэв.

- За яах вэ, тэгвэл би танд гурван сарын хугацаа өгье. Би нарийлахгүй байгааг та харж байгаа биздээ гэж гүн хэлэхэд Альбер баярлан дуу алдаж,

- Тэгвэл та гурван сарын дараа манайд очих нь шив дээ? гэв.

- Уулзах өдөр, цагаа яг болзох уу? Харин би яг л болзсон болзоогоо хатуу баримталдаг хүн шүү гэдгийг танд урьдчилан хэлье гэж гүн хэлэхэд,

- Өдөр цаг ий? Бүр ч сайн хэрэг! Гэж Альбер хэлэв.

- Одоо үзье л дээ гэж гүн хэлээд толины дэргэд өлгөөтэй байсан хуанли өөд гараа сарвайж - Өнөөдөр чинь хоёрдугаар сарын хорин нэгэн гээд цагаа харж - одоо арван цаг хагас болж байна. Тэгэхээр та намайг тавдугаар сарын хорин нэгний арван цаг хагаст хүлээн авахыг зөвшөөрөх үү? Гэж хэлэхэд Альбер,

- Тохирлоо. Өглөөний зууш ширээн дээр бэлэн байна гэж хариу дуугарав.

- Та хаана суудаг вэ?
- Эльдер гудамжны хорин долдугаар байшинд:
- Та ганцаараа суудаг уу? Би танд дараа болох юм биш биз?
- Би эцгийнхээ байшинд тэгэхдээ жигүүрийн байшинд суудаг.
- Тэгвэл сайн хэрэг.

Гүн тэмдэглэлийнхэс дэвтрийг авч «Эльдер гудамж 27, тавдугаар сарын 21, өглөөний арван цаг хагас» гэж тэмдэглэв. Тэгээд тэмдэглэлийнхээ дэвтрийг хармаандаа хийж,

-За одоо зовох юмгүй, би таны зүүж яваа цагийн зүү шиг л яг очно гэж хэлэв.

-Би явахаасаа өмнө тантай уулзах болов уу? гэж Альбер асуув.

-Энэ таны хэзээ явахаас л шалтгаална даа.

- Би маргааш орой таван цагт явна.
- Тэгвэл би тантай салах ёс гүйцэтгэчихье. Би Неаполь орох ёстой, тэгээд бямба гаригийн орой буюу ням гаригийн өглөөнөөс нааш ирэхгүй гэсэнээ Францад хандаж, - Аа, та бас явах уу, түшээ гүн? гэж асуув.

- Явна аа
- Франц уруу юу?
- Үгүй Венеци явна. Би Италид дахиад нэг хоёр жил болно.
- Тэгвэл та бид хоёр Парист дайралдахгүй байх нь ээ?
- Ийм аз тохиолдохгүй байх гэж айж байна.

- За тэгвэл эрхмүүд ээ, сайн явцгаагаарай гэж хэлээд гүн, Франц Альбер хоёрт хоёр гараа зэрэг өгөв.

Франц анх удаа энэ хүний гарт хүрч байгаа ажээ. Өөрийн эрхгүй цочин агдасхийв. Энэ хүний гар үхдэлийн гар шиг хүйтэн байлаа.

- За тохирох шив дээ. Та ирнэ гэж амласан. Эльдер гудамж, хорин долоо, тавдугаар сарын хорин нэгэн, өглөөний арван цаг хагас гэж Альбер хэлэхэд гүн,

- Тавдугаар сарын хорин нэгэн, өглөөний арван цаг хагас, Эльдер гудамж, хорин долоо гэж давтан хэлэв.

Ингээд залуу хүмүүс мэхийн ёслоод гарч одов.

Альбер тасалгаандаа хүрч ирээд Францаас,

- Та яав? Та их санааширсан царайтай байх чинь Жэж асуухад,

- Тийм ээ, гүн хачин гайхалтай хүн. Парист тантай уулзана гэж болзож байгаа энэ уулзалт сэтгэлийг минь зовоож байна гэдгээ хэлэх хэрэгтэй байна гэж Франц хэллээ.

- Таны сэтгэлийг зовоож байна гэнэ ээ! Энэ уулзалт уу? .. Үгүй та чинь солиорчээ! гэж Альбер дуу алдав.

- Одоо яая гэх вэ? Би солиорсон байж болох юм. Гэсэн ч энэ үнэндээ гэж Франц хэлэхэд, Альбер үргэлжлүүлэн,

- Би танд өөрийнхөө бодлыг хэлэх бололцоо олдсонд баярлаж байна. Та гүнд нэг л дотно биш байгааг чинь би аль хэдийнэ ажигласан, гэтэл гүн та бидэнтэй тун ч найрсаг байсан. Та түүнд дургүйцэх ямар нэгэн юм байна уу? гэж асуув.

- Магадгүй.

- Та урьд нь түүнтэй уулзсан уу?

- Тэгсэн болоод л тэр.

- Хаана?

- Миний ярих юмыг хэнд ч хэлэхгүй гэж ам өгөх үү?

- Өгнө.

- Үнэн үү?
- Үнэн.
- За сайн байна тэгвэл сонсож бай.

Тэгээд Франц Альберт, Монте-Кристо арал дээр очсоноо, тэнд бүлэг хил давуулан наймаа хийдэг хүнтэй дайралдсанаа, тэдний дотор Корсийн хоёр дээрэмчин байсныг ярив. Цааш нь, гүн өөрийн «Мянга нэгэн шөнө»-н үлгэрийнх шиг агуй дотроо үлгэрт гардаг шиг хэрхэн зочилсон, оройн зоог, гашиш, баримал хөшөөний тухай, мөн зүүдэндээ үзсэн зүйлийг ярьж, тэгээд өглөө нь энэ бүхнээс Порто-Ветекино уруу явж байгаа бяцхан хөлөг онгоц тэнгэрийн хаяанд харагдахаас өөр юу ч үлдээгүй зэргийг бүгдийн нь ярив. Дараа нь Ромын тухай шөнө Колизейн тэнд гүн, Луизи хоёрын хоородоо ярьсан яриаг сонсож, гүн Пеппинод өршөөл үзүүлэх тухай хөөцөлдөх гэж ам өгч, уншигчдын дээр үзсэнээр хэлсэн үгэндээ хүрсэн зэргийг нэгд нэггүй ярив.

Эцэст нь урьд шөнийн явдлыг ярьж, мөнгөнөөс долоон зуун пиастр дутахад хичнээн хүнд байдалд орсноо, тэгээд гүнд очъё гэдэг санаа төрснөө, энэ нь завшаантайгаар учраа олон төгссөнийг ярив. Альбер, Францын яриаг чих тавин сонсож суув. Тэгээд түүнийг яриагаа төгсгөхөд,

- Тэгээд яагаа вэ? Энүүнд болгоомжлоод байх юу байгаа юм бэ? Гүн аялан явах дуртай, баян болохоороо өөрийн хөлөг онгоцтой байхыг хүсээ л биз. Та Портсмут эсвэл Саутгемптонд очвол тийм чамин дэгжин юмыг хэрэглэх дуртай англичуудын дарвуулт онгоцоор буудлууд нь дүүрэн байхыг үзнэ дээ. Би дөрвөн сар, та дөрвөн жил хордож байгаа энэ муухай хорт агаараар хордохгүйн тул нойр хүрэхгүй муухай чийгтэй хонгил хэвтэхгүйн тулд Монте-Кристо арал дээр байртай болсон юм байгаа биз. Тэгээд түүнийгээ засаж төвхнүүлж орхиод Токсаны засгийн газар хураагаад авчихвал зарцуулсан хөрөнгө нь дэмий үрэгдчихэж магадгүй гэж болгоомжлоод уг арлыг худалдан авч, түүнийхээ нэрээр өөрийгөө нэрлээ л биз. Хүндэт нөхөр минь, ухаан санаандаа бодоод үз, таны танилуудын дотор огт эзэмшиж байгаагүй газрынхаа нэрээр өөрийгөө нэрлэхихдэг хүн цөөхөнгүй шүү дээ? гэв.

- Аа, тэгвэл түүнд хамаарагдан байгаа Корсийн дээрэмчид юу вэ? гэж Франц хэлэв.

- Тэнд гайхаад байх юм юу байгаа юм бэ? Корсийн дээрэмчид бол тонуулчид биш, зөвхөн үе залгамжилсан өшөөнөөс болоод төрөлх хот тосгоноосоо хөөгдсөн улс гэдгийг та сайн мэднэ шүү дээ. Тэдний дунд нэр төрөө алдалгүй байж болно. Миний тухайд гэвэл, хэрвээ хэзээ нэгэн цагт Корс ордог юм бол амбан сайдад нь очихоосоо өмнө, намайг Коломбын дээрэмчидтэйгээ танилцуулж аль гэж гуйна. Харин тэд нар нь олдохгүй байх даа. Би тэднийг бахадмаар улс гэж боддог.

- Аа, тэгвэл Вампа түүний бүлгийг юу гэх вэ? Эд чинь зүгээр л тоноод байдаг ёстой дээрэмчид шүү дээ. Та үүнийг үгүйсгэхгүй байх аа. Ийм хүмүүс, гүн чөлөөтэй байдгийг та юу гэх вэ? гэж Франц зөрж асуув.

- Эрхэм нөхөр минь, энэ нөлөөний ачийг би амь насаараа хариулах ёстой болохоор гүнг элдвээр өөлж чадахгүй байгаага танд хэлье. Ийм учраас би гүнг тан шиг гэмт хэрэгтэн мэт үзэж чадахгүй, харин манай хөрш миний амийг эс боловч, дөрвөн мянган пиастрыг минь хэмнэж өгсний тул гүнг уучлахыг зөвшөөрнө үү? Энэ бол манай мөнгөөр хорин дөрвөн мянган франк болно. Францад бол намайг ийм үнээр үнэлэх нь юу л бол гэснээ Альбер инээж Энэ бол хүн эх орондоо байхдаа холыг харж чаддаггүй гэдгийг нотолж байна гэж нэмж хэлэв.

- Үгүй ингэхэд эх орон гэснээс гүнгийн эх орон хаана юм бол? Түүний төрөлх хэл нь ямар хэл юм бол? Ямар хөрөнгөөр амьдарч байдаг юм бол? Тэр их баялгийг хаанаас авсан юм бол? Амьдралын нь хоёрдугаар хагаст бараан сүүдэр тусгасан эхэн үеийн үл мэдэгдэх амьдрал нь ямар байсан юм бол? Би л таны оронд байсан бол энэ бүгдийг мэдэхийг хичээнэ дээ.

- Эрхэм Франц, та миний захидлыг хүлээн авч уншаад гүн бидэнд хэрэг болж байгааг хараад түүнд очиж «Миний найз Альбер аюулд учраад байна. Түүнийг аврахад минь надад туслаач» гэж хэлсэн биз дээ? Тийм үү?

- Тийм ээ

- Аа, тэгэхэд өөдөөс чинь Альбер де Морсер гэдэг чинь юун хүн бэ гэж асуусан уу? Хаанаас ийм нэртэй болсон юм бэ? Хаанаас ийм хөрөнгөтэй болсон юм бэ? Ямар хөрөнгөөр амьдарч байдаг юм бэ? Эх орон нь хаана байна вэ? Хаана төрсөн юм бэ? Ингэж танаас асуусан уу, хэлж өгөөч?

- Үгүй, асуугаагүй.

- Олон таван үггүй яваа биз дээ. Тэр намайг, хэдийгээр таны хэлснээр маш чөлөөтэй байсан боловч үнэнээ хэлэхэд булай санагдаж байсан тэр газраас Луижийн гараас намайг салгаж авсан. Ийм тус хүргэснийхээ хариуд, бид өдөр бүр л Оросын эсвэл Италийн вангуудыг Парист ирэхэд хийж байдаг ажил, өөрөөр хэлбэл Парисын дээдсийн хүрээлэнд оруулж танилцуулж өгөхийг гуйж байхад намайг татгалз гээ юу? Одоо больё, Франц та солиорчээ.

Энэ удаа учир зүй Альберын талд байгааг зөвшөөрөхгүй байх арга байсангүй. Франц санаа алдан,

- Эрхэм бэйс минь, дураараа л бол. Таны ярьж байгаа бүхэн маш итгэмээр юм. Гэвч Монте-Кристо гүн их л хачин хүн дээ гэж хэлэв.

- Монте-Кристо гүн бол нигүүлсэн ивээгч хүн юм. Тэр ямар хэргээр Парис орох гэж байгаага танд хэлээгүй. За тэгэхлээр, Монтионовын шагналыг горилогч болохын тулд гээ. Хэрвээ түүнийг авахад нь миний санал мөн өөр нэг хүний оролцоо хэрэгтэй юм бол би саналаа өгнө, харин нөгөө хүнийхийг дааж чадахгүй. За найз минь, үүгээр яриагаа төгсгөж, хоолоо идээд, гэгээн Петрийн сүмийг сүүлийн удаа харахаар явъя.

Альберын төлөвлөгөө биелэгдэж маргааш нь оройн таван цагт хоёр найз салав. Альбер де Морсер Парисдаа буцаж, Франц д Эпине Венеци уруу хоёр долоо хоногийн хугацаагаар явав.

Харин Альбер, зочин нь очихоо мартчих бий гэж айхдаа сүйх тэргэнд суугаад, Монте-Кристо гүнд өгүүлэхээр нэрийн хуудсан дээрх «Бэйс Альбер де Морсер» гэдэг үгийн доод талд харандаагаар:

Тавдугаар сарын 21. Өглөөний арван цаг хагас, Эльдер гудамж 27 гэж бичээд явуулжээ.

Эх сурвалж:

www.e-pada.com

Формат, фонт зэргийг бага зэрэг янзалж pdf хэлбэр уруу хөрвүүлсэн:

mongolnom.blogspot.com